

САЙШААЛ ЗОХИОВ



**ЧИНГИС ХААНЫ
ТОВЧООН**

II


Чингис хааны товчоон II
Зохиолч: Б.Сайшаал

ISBN: 978-99929-4-662-8


© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn


Долдугаар бүлэг



Чингис хаан дайснаа дарж бүхий зураг



Чингис хаан Алтан улсад байлдаж байгаа зураг



Алтан улсын үеэс одоо болтол ургаж байгаа нарс мод



Тангуд улсын үсэг - Хятан бага үсгийн хөшөө

Чингис хаан өмнөш дайлсан нь

Чингис хааны өмнөш дайлсан гол харалт бол Алтан улс болно. Гэвч жигүүрийн түгшүүрийг үгүй болгох байлдах бодлогоос үүсч, урьдаар Тангуд улс (баруун Ся улс)-ыг хэдэн удаа дайлсан байна. Алтан улс лугаа дайралдсаны хамт буюу дараа, Хятан үндэстнийг оруулан авахаар зүүн хойд оронд цэрэг хэрэглэжээ. Энэ бол Чингис хааны өмнөш дайлсан ерөнхий явц болно, бас ч өөрийн улс орныхоо хэмжээнээс давж гадагш халдсаны эхлэлт болох бөгөөд Дундад орныг дайлж, Дундад улсыг нэгтгэн, Юань улсын төрийг байгуулахын эхлэлт болно.

52. Тангуд улсыг дөрвөн удаа дайлсан нь

Тангуд улс гэдэг бол Монголчуудын дуудлага (анхандаа Хашин орон гэдэг) болно. Сүн улс, Алтан улсынхан “Ся улс” гэж дууддаг бөгөөд Төвдчүүд “Минаг” гэж дууддаг байна. Тангудчууд өөрөө “Их Ся улс” буюу “Бомбеле” (Mbo-mbe-le) гэдэг гэлээ. Тэр бол Сяньби угсаатны Найман аймгийн нэг болох Дан-сян Цян үндэстний нэгэн салбарынхны байгуулсан их Ся улс гэгч феодалын төр болно. “Баруун Ся улс” гэдэг нь Тангуд улс мөхөхийн үед “Алтан улсын түүх”-д тэмдэглэгджээ. Учир нь Пусянь Ваньну Алтан улсаасаа урваж, зүүн хойд оронд “Их Жүрчин” гэсэн тусгаар төр байгуулжээ. Түүнийг “Зүүн Ся улс” гэдэг байна. Үүнээс ялгахын төлөө “Баруун Ся улс” гэдэг нэр буй болжээ.

Дан-сян Цян үндэстэн бол эртний нэгэн үндэстэн болно. Тэр нь Дундад улсын өмнө умар төрийн үед одоогийн Хөхнуурын зүүн өмнөд хэсгийн Хэчуй ба Сычуань мужийн Сунфангаас барууншихи уулархаг газраар тархан нутаглаж байжээ. Тан улсын эхний үед Төвдчүүд Хөх нуурын өндөрлөг дэхи аймаг угсаатныг байлдан эзэлсэн тэр үед ихэнх Дан-сян үндэстэн нь арга бус Ганьсу, Нинся, Шаньбэй орчмоор нүүн нутагшжээ. Умард Сүн улсын үед Дан-сян Цян үндэстнээр гол болгон байгуулсан Ся улс гэдэг нь энэ билээ.

оршиж, Яргай хот (хятадаар “Чжун-шин Фу” гэдэг, хуучин хот нь одоохи Нинся-гийн Хотон Үндэстний Өөртөө Засах Орны Иньчуань хотоос зүүн өмнөхөн байв)-д нийслэж, өрнөн бадарч байх үедээ одоогийн Нинся, Шаньбэй, Ганьсу-гийн баруун хойд хэсэг ба Өвөр Монголын нэг хэсэг орон (Ордос, Алшаа, Эзнээ)-ыг багтаасан хорин хоёр чжоу-г захирч байсан билээ. Эдгээр газрын олонхи нь Хатан голоос баруунш байдаг болохоор хятадаар Хэ Си буюу Хэ Си-гийн хонгил гэдэг. Тиймээс “Нууц товчоон”-д заримдаа Хашин иргэн гэж нэрлэдэг нь “Хэ Си”-гийн халгуу дуудлага болно. Тангуд улсын суугуул ард нь Дан-сян Цян, Хятад, Төвд, Уйгур зэрэг үндэстнээр бүрэлджээ. Хааны угсаа нь Ли овогтой (Сүн улсаас бас Чжао овог өгчээ) билээ. Нийтийн он тооллын 1038 онд Тангудын Ли Юань Хао гэгч биеэ хаан өргөмжлөснөөс хойш, 1205 онд Чингис хаан анх удаа дайталхи 166 жилийн хооронд Тангуд улс нь нийт таван хааныг өнгөрөөж, зургадугаар хаан Ли Цунь Ю гэгч сууринаа байв. “Нууц товчоон”-д Тангудын хааныг нь “Бурхан”¹ гэж тэмдэглэдэг юм. Тангуд улс нь мал (ялангуяа тэмээ) тариалангийн аж ахуйг эрхэлдэг бөгөөд эртнээсээ гуу суваг малтаж ус ашиглалтыг сайтар эрхэлсэн болохоор газар нутаг нь явцуу боловч амуу будаагаар баялаг байсан гэдэг. Хөх, цагаан давсны гаралт элбэг, хивсэн нэхмэлээр алдартай юм. Сүн улстай ч аж ахуй, соёлын талын харьцаа нягт бөгөөд цай, төмөр, морь, давсны арилжааг ихээр хийж байв. Тангудчууд өөрөө үсэг бичигтэй (зураг 67-г лавлаарай). Сүн улс, Ляо улс ба Алтан улс лугаа олон удаа дайн байлдаан хийж байсан бөгөөд ард иргэд нь их хохирлыг амсчээ.

Нэгдүгээр удаа Тангуд улсыг дайлсан нь

Чингис хаан нэгдүгээр удаа Тангудыг дайлсан цаг бол хөхөгчин үхэр жил (1205 он) болно. Тэр үед Тангудын зургадугаар хаан (Д’Оссоны номд долдугаар гэжээ, энд Дундад улсын тооллыг баримтлав) Ли Цунь Ю гэгч төр барьж байв.

Энэ удаа Тангудыг дайлсан шууд шалтгаан бол Чингис хаан Монголын эл аймгийг нэгтгэсний дараа, үлдэгдэл дайснаа цэвэрлэн устгаж байсан лугаа холбогдох болно. Энэ үед Нилха Сэнгүм Тангуд өөд дутаасан тул Тангуд түүнийг далдлав гэсэн шалтгаар цэрэг хөдөлгөжээ². Хэн бүхний мэдэж байхаар, энэ Нилха Сэнгүм бол Хэрэйдийн Ван ханы хайрт хөвгүүн нь болно. Тэр 1203 онд Чингисийн цэрэгт бут цохигдоод ганц биеэрээ (дагаж байсан нэгэн агтач Хөхэчү гэдэг нь эзнээ орхиж Чингис хаанд бууж өгөөд алагдсан билээ - “Нууц товчоон”-ы 188 дугаар зүйл) зугтаж явахдаа Тангуд улсын Чал хот (энэ бол Эзнээ буюу Хар хотын тангуд нэр болно)-ыг дайрч гарлаа гэдэг тул бодоход энэ жилийн намрын барагаар Тангудад хүрсэн бололтой.

Энэ бол Тангудад цэрэг хэрэглэсний гадаад шалтгаан юм. Хэрэг дээрээ Тангудыг дайлсны чухам зорилго бол Алтан улсад хандуулж байсан билээ. Алтан улс болон Тангуд улсын харьцаа бол уруул шүд мэт нягт тул Тангудад цохилт өгөх нь Алтан улсын баруун гарыг нь хугалсантай адил ач холбогдолтойгоор үл барам, хот балгасыг байлдах үнэн бодтой сургуулил болох юм. Тиймээс Тангудыг дайлсан хэдэн удаагийн байлдаан нь Алтан улс лугаа удалгүй хийх дайны хөшиг болж нээгджээ.

Чингис хаан Тангуд улсыг дайлах хэрэгцээтэй байснаар барахгүй, түүнд ийм бололцоо ч их байжээ. Юуны урьд Тангудын байдлыг нь сайн мэдэж байв. “Хэрэйд, Найман ба Монголын зарим аймгууд урт хугацаанаа Тангудчуудтай тасраагүй харьцаж байсан болохоор, энэ улсын тухай маш оновчтой мэдээг эзэмшиж байв. Уйгур хүн, ялангуяа уйгур худалдаачид үргэлж

Тангудаар очдог тул Тангуд ба Тангудын эл талын байдлыг нарийн ойлгодог билээ. Тиймээс эд нар маш их үйлдлийг гаргав” гэж Б.Я.Владимирцовын тэмдэглэсэн нь зүйтэй юм. Чингис хаан Найманыг нэгтгэн авснаас Монголын хил нь Тангуд улс лугаа залгалдсан бөгөөд 1205 онд Чингис хааны их цэрэг нь их Алтайн өмнүүр байсан тул нэгэн говийг гэтэлбэл даруй Хашинд хүрэх юм. Ингээд, Монголын цэрэг анх удаа Тангуд улсыг дайлах эл талын нөхцөлийг бүрэлдүүлжээ.



Зураг – 68. Чингис хаан нэгдүгээр удаа Тангудыг дайлсан зураг

Елюй Ахай-гаар жолоодуулсан Чингис хааны их цэрэг Тангудад хүрмэгц “Маш бэхлэг хот”

Лигири цайзыг хэдэн хоног бүсэлж, эзлэн аваад үнсэн товрог болгов гэдэг. Дараа нь Лос хот (үүнийг Рашидын номонд “Клин-Лоши” гэжээ)-ыг дайрч, ард иргэдийг нь их л уулгалан, эд ашгийг арвин олзолж, ялангуяа маш олон тэмээ олзолж буцсан тул Монголчууд тэмээг өргөн хэмжээгээр хэрэглэсэн явдал үүнээс үүсэлтэй гэж олонхи түүхчид үзэцгээдэг болно.

Энэ удаагийн байлдааны үр дүнд, Тангуд улсаас Монголд өргөл өргөх гэрээ тогтоосон гэдгийг бид хоёрдугаар удаа дайлсныхи нь шалтгаанаас мэдэж болно. Гэвч энэ учрыг түүх шастирт тодорхой тэмдэглээгүй юм.

Хоёрдугаар удаа Тангуд улсыг дайлсан нь

Чингис хаан хоёрдугаар удаа Тангуд улсыг дайлсан цаг бол улаагчин туулай жил (1207 он)-ийн намар болно. Чингис хаан дөчин зургаан настай байжээ. Энэ үед Тангуд улсын хаан орыг Ли Ань Цюань гэгч булаан эзлээд, өөрийгөө долдугаар үеийн хаан (Сянцзун хаан гэдэг) өргөмжлөөд нэг жил болж байжээ.

Энэ удаа Тангуд улсыг довтолсон шууд шалтгаан бол Тангудын шинэ ноёрхогч нь сэтгэл урваж өргөл барихаа больсоноос болсон гэж Рашид-ад-Дин, Д’Оссон, Ту Цзи нар тэмдэглэжээ. Энэ удаагийн байлдаанд Чингис хаан биеэр морилсон бөгөөд 1207 оны өвөл Урахай хотыг³ эзэлж, 1208 оны хавар цэрэг буцжээ. Энэ удаагийн дайлалт нь урьд хожид хагас жил шахам болсон байна.

Гуравдугаар удаа Тангуд улсыг дайлсан нь

Чингис хаан Тангуд улсыг гуравдугаар удаа дайлсан цаг бол цагаан морин жил (1209 он)-ийн намар⁴ болно. Чингис хаан дөчин найман настай байв. Энэ удаагийн байлдааны үүссэн бодтой шалтгааныг “Цэрэг элсүүлж дайнд туслуулах гэсэн байж магадгүй” гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ. Гэтэл “Ли Ань Цюань Алтан улсаар өргөмжлөгдсөн ба Монголд түрүү хааныхаа гашуудлыг мэдэгдсэнгүйгээс буюу ялангуяа Чингис хаан хот довтлох сорилт хийхийн төлөө” дайн үүссэн магадгүй гэж Ли Цзэ Фэнь авгай тэмдэглэжээ.

Чингис хааны цэрэг Тангудын умардахи Чал хотын зүгээс шувгалж, Урахайн боомтод хүрсэнд Тангудын эзэн (“Нууц товчоон”-д “Бурхан” гэдэг) Ли Ань Ци-юань түүний ширах хөвгүүн Ли Цзунь Сюй-гээр цэрэг захируулан хориглуулжээ. Энэ Ли Цзунь Сюй бол Ань Цюань-ий төрсөн хөвгүүн нь биш, төрлийнх нь хөвгүүн юм. “Юань улсын түүх”-д “ширах хөвгүүн” гэснээс үзэхүл, энэ үед түүнийг нэгэнтээ залгамжлагчаар тогтоосон бололтой. Ли Цзунь Сюй дийлэгдэж, түүний дэд юаньшоай Гао Лин Гун⁵ гэгч монгол цэрэгт баригдав. Дараа нь монгол цэрэг Урахай хотыг бас нэгэн удаа эзэлж, тайфу түшмэл⁶ Сяньби үндэстэн Э Да гэгчийг олзолжээ. Цааш урагшлан Яргай хотын зах болох Кэ И Мэнь боомтод хүрч, Тангудын цэргийг бас нэгэн удаа дийлээд алдарт жанжин Вэй Мин⁷ гэгч түшмэлийг нь уран аргаар барьж авчээ. Ингээд Хатан голын баруун хөвөөн дэхи Тангудын нийслэл Яргай хотод⁸ нь шахан хүрч, Хатан голын усыг таслан хот өөд нь цутгав. Энэ үед Тангуд нь Алтан улсаас тусламж гуйгаад олсонгүй байв. Голын хашилга сэтэрч, ус нь гадагш тэлсэнд монгол цэрэг ч тэсч чадсангүй сая бүслэлтээ хурааж, урьд барьж авсан тайфу түшмэл Э Да-г тавин, Яргай хотод очуулж, оруулан авах зарлиг буулгасанд, Тангудын эзэн Ли Ань Цюань “Дагаар орж, баруун гар чинь болж, хүчээ өгье хэмээн Чагаа нэртэй охиноо⁹ Чингис хаанд авчирч өгөв”

“Нууц товчоон”-ы 249 дүгээр зүйл) гэдэг билээ. Ингээд “Боомийн гэрээ” тогтож цэрэг буцжээ.

Дөрөвдүгээр удаа Тангуд улсыг дайлсан нь

Чингис хаан дөрөвдүгээр удаа Тангуд улсыг дайлсан цаг бол шар барс жил (1218 он, “Ши Ся Шу Ши”-гийн 41 дүгээр ботид 1217 он гэжээ)-ийн хаврын тэргүүн сар болно. Чингис хаан тавин долоон настай байв. Энэ удаагийн дайлалт нь Чингис хаан Алтан улсыг хэдэнтээ дайлсны дараа явагджээ. Тиймээс Чингисийн морьт цэрэг нь хот сууринг байлдах туршлагатай болсноор барахгүй, цэргийнх нь хүч сүр ч ихээр бадарч байсан үе болно. Энэ удаагийн дайлалтыг цагийн дэс дараагаар Алтан улсыг дайлсны дараа тэмдэглэвэл зохих билээ. Гэвч бид төвлөрөнгүйгээр илтгэхийн тулд энд шилжүүлэн тэмдэглэснээ тусгайлан тодорхойлье.

Энэ үед Ли Цзунь Сюй нэгэнтээ Ли Ань Цюань-ий орыг залгамжилж, Тангудын наймдугаар эзэн нь болоод байв. Чингис хааны их цэрэг хүрмэгц Тангудын нийслэл Яргай хотыг нь бүслэв. Тангудын эзэн Ли Цзунь Сюй, хөвгүүн Ли Дэ Ван гэгчээр хотоо сахиулж, өөрийн Си Лянь (“Нууц товчоон”-д Эрижэү гэж, Чин улсын үед Лян Чжоу Фу гэдэг, төв нь одоогийн У Вэй болно) өөд дутаажээ. Тиймээс Монголын цэрэг буцав гэдэг. Чжан Чжэнь Пэй-н зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир”-т: Баруун Ляо улс элчийг алсан (Баруун Ляо улс гэсэн нь таарахгүй юм. Чингисийн элчийг алсан нь Хорезм болно - эшлэгч) тул баруунш дайлахаар шийдсэн ташрамд Тангуд улс ч цэрэг гарган туслая гэж хуурмагаар найрамдахыг гуйчлав, ингээд цэрэг буцав гэж тэмдэглэж буй.

Энд бас тэмдэглүүштэй зүйл гэвэл, энэ удаагийн дайлсан шалтгааныг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д:

Хаан Тангудаас цэрэг элсэж, Монголын цэргийн хамт Сартуулыг байлдаж гэсэнд Тангуд хүлээсэнгүй учраас Тангудыг байлдаж гэж тэмдэглэж байдаг. Гэвч “Нууц товчоон”-д:

Чингис хаан (баруун зүг) байлдаанд мордоод, Тангуд улсын Бурханд элч явуулж хэлүүлсэн нь: “Баруун гар чинь больё гэж чи хэлсэн биш үү? Сартуул улсад алтан аргамжаа тасдуулаад би хариу авахаар мордов. Баруун гар болж морил!” гэж илгээвээс... Аша хамбу өгүүлрүүн: “Хүч хүрэхгүй болбоос хаан юунд болов?” хэмээгээд туслах цэрэг өгсөнгүй омогтой их үгийг хэлж элчийг буцаажээ. Тэнд Чингис хаан өгүүлрүүн: “Аша хамбуд яаж ингэж хэлэгдэх билээ? Урьдаар тэдэнтэй очиж байлдвал зохилтой бишүү? Гэвч өөр хүнд зорьж байгаа цаг тул энэ удаа больё. Мөнх тэнгэрт ивээгдэж, алтан жолоогоо баг татаж ирвэл, тэр цагт магад болтугай!” гэжээ (Ц.Дамдинсүрэнгийн одоочилго 256 дугаар зүйл) гэж тэмдэглэж байхаас үзэхүл, энэ удаа Тангудад зөвхөн элч илгээснээс биш, цэргээр дайлсангүй мэт. Энэ нь бусад тэмдэглэлд байдаггүй. “Алтан улсын түүх, Сюаньцзун хааны шастир” Син Дин-ий хоёрдугаар он (1218 он)-ы цагаан сарын хөхөгчин тахиа өдрийн тэмдэглэлд: “Их Юань улс (энэ бол сүүлчийн нэр болно – эшлэгч)-ын цэрэг, Тангудын вангийн хотыг бүсэлсэн тул Ли Цзунь Сюй хөвгүүнээрээ сахиулж, өөрөө Си Лян өөд дутаав” гэж, “Юань улсын түүх, Тайцзугийн шастир”-т:

Тэр жил (Чингис хааны арван гуравдугаар он, шар барс жил), баруун Ся улсыг дайлж,

вангийн хотыг бүслэв, Сян улсын эзэн Ли Цзунь Сюй Си Лян өөд дутаав гэж, “Д’Оссоны Монголын түүх”-д: 1218 онд Чингис хаан баруун Ся улсыг дөрөвдэх удаагаа дайлж, нийслэл хотыг нь бүслэв, Ся улсын эзэн Ли Цзунь Сюй Си Лян өөд дутаажээ. Си Лян бол одоохи Ганьсу-гийн Лян Чжоу Фу болно гэж тус тус тэмдэглэж байдаг.

Эдгээр тэмдэглэлүүдээс үзэхүл, Чингис хаан энэ удаа охор нэгэн хугацаанд Тангуд улсыг дайлсан нь үнэн явдал болох бөгөөд энэ удаагийн дайлсан зорилго нь баруун орны дайнд цэрэг туслуулах гэсэнд оршино. Гэвч Ли Цзунь Сюй дутаан зайлаад, түүний хөвгүүн Ли Дэ Ван “Цэрэг гарган туслая гэж хуурмагаар найрамдах”-ыг гуйчилсан боловч, түүний түшмэл Аша Гомбу харин цэрэг өгөхгүй гэсэн бололтой. Үүнд “Урьдаар тэдэнтэй очиж байлдваас зохилтой биш үү?” гэж Чингис хаан хэлсэн нь Ли Цзунь Сюй-г нэхэн байлдахыг хэлсэн мэт. Тиймээс “Нууц товчоон”-ы тэмдэглэл нэлээд балархай болгосон байна.

Багцлаад хэлбэл, Чингис хаан 1205 оноос 1218 оны хооронд Тангуд улсыг дөрвөн удаа дайлсан тойм байдал бол ийм л байна. Гурван удаа нь 1211 онд Алтан улсыг дайлахаас өмнө явагджээ. Дөрөвдүгээр удаа нь 1219 онд Хорезм (Сартуул)-ыг дайлахаас өмнө 1218 онд явагджээ. Бас хамаг эцсийн нэгэн удаагийн дайралт буй, түүнийг есдүгээр бүлэгт тусгай сэдвээр танилцуулна. Энэ хэдэн удаагийн дайралтыг дамжиж, Тангуд улсын хүчийг нь ихээр хохируулж, Алтан улсад тусалж эс чадах болгосон бөгөөд тэр хоёр улсын хоорондохи зөрчлийг нь ч ихэтгэж (1212 онд Тангудын цэрэг бас Алтан улс өөд довтолж байв), тус тусаар нь устгахад ашигтай нөхцөлийг буй болгожээ. Энэ бол Чингис хааны байлдах бодлогын зорилго юм.

Ингээд Чингис хааны дараачийн харалт бол түүний гол дайсан Алтан улс болов.

53. Алтан улс ба Монгол

Алтан улс бол Жүрчин үндэстний Ваньгинь аймгийн ахлагч Агуда гэгчийн үүдэн байгуулсан улс мөн. Жүрчин үгээр “Айсин гүрүн” гэдэг. Ингэж нэрлэсэн учир гэвэл, Хятан үндэстний байгуулсан Ляо улсын “ляо” гэсэн нь “төмөр” гэсэн утгатай тул, төмөр хэдийгээр хатуу боловч зэврэн эвдэрдэг, ганц алт бол өнөд хувиршгүй гэж улсаа “Алтан улс” гэлээ гэдэг юм. Жүрчин үндэстэн бол эртний үндэстэн болно. Тан улсын үед Хар усны Мөхэ (mòhè) гэдэг. Аравдугаар зууны түрүүчээр Жүрчин нар Сунгари мөрөн, Хар мөрөний доод урсгал дагуу зүүнш далай хүртэлх орноор нутаглаж байжээ. Тэд нар загас шүүх, гахай тэжээх зэрэг аж ахуйг эрхэлдэг бөгөөд буурцаг, буудай зэргийг тарьдаг байна.

Умард Сүн улсын үед Ваньгинь аймаг нь Жүрчидийн гол аймаг болж ихээр хөгжжээ. Үгүнай ахлагчийн үед төмөр багажийг оруулж, нийгмийн үйлдвэрлэлийн хүчээ дээшлүүлжээ. Арван хоёрдугаар зууны эхэнд Агуда гэгч аймгийн ахлагч болж, Жүрчиний эл аймгийг нэгтгэж, 1115 онд Алтан улсын төрийг байгуулсан байна. Алтан улс нь анхандаа Хуйнин хот (одоогийн Хар мөрөн мужийн А-чэн хотын өмнө буй)-д нийслэж байв. Тянь Хуй-гийн гуравдугаар он (1125 он)-д Ляо улсыг мөхөөж, дараа жилд нь умард Сүн улсыг мөхөөв. Ингээд нийслэлээ Чжунду хот (одоогийн Бээжин)10-д нүүлгэсэн (1214 онд бас Кайфэн хотод нүүлгэжээ) билээ. Түүнчлэн Алтан улсын нутаг дэвсгэр нь зүүнш одоогийн Япон тэнгис, Агнуурын тэнгис ба гадаад Хянган нуруу хүрч, баруун хойш одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улс хүрч, баруунш Бортохой, Шаньси, Хэншань уул, Ганьсу-гийн зүүн хэсэг Тангуд улс лугаа зах нийлж

өмнөш Чиньлин нуруу, Хуанхэ гол хүрч, өмнөд Сүн улс лугаа зах нийлж байв. Тэр үедээ Алтан улс бол өмнөд Сүн улстай дайсагнаж, Дундад улсын умард орныг эзэлж байсан нэгэн феодалын хаант төр болно. Сүүлдээ Өгөөдэй хааны үед, 1234 онд Монгол улс ба өмнөд Сүн улсын хамтарсан дайлалтад мөхжээ. Алтан улс мөхтлөө нийт есөн хаан ор сууж, зуун хорин жил ноёрхож байв.

Алтан улсын ноёрхогчид нь бүх Дундад улсыг эзлэх зорилгоо биелүүлэхийн тулд, анхны үедээ бүх хүчээ өмнөш төвлөрүүлж, өмнөд Сүн улс лугаа байлдаж байжээ. Умардын эл угсаатанд бол хатган завсардуулж, харилцан алж хядуулах “харийг хариар захирах” тэрслүү төрийн бодлогыг хэрэгжүүлж байсан бөгөөд өөрөө “гурван жилд нэгэн удаа дайлж, таван жилд нэгэн удаа шүүрдэж, шарилж эрхий-гийн аргыг хэрэглэн, төвлөрсөн хүчийг нь хохироовоос, Чжань Хань Чжу-ци мэтсийг эрхшээн эс чадах хэмээн зовох явдал хэрхэн байх ажгуу? “Шарилж” хэмээгч, үлгэрлэвээс шарилжийг хадах мэт, “эрхий” хэмээгч, эрхий хурууг нь огтлон авах мэт атал хуяг цэргийг хэрэглэх хэрэггүй болжээ” (Чжэн Со Нань-ий зохиосон “Сэтгэлийн түүх”, доод боть) гэж үзэж, “Гурван жил нэг удаа дайлах, таван жилд нэг удаа шүүрдэх” аргыг хэрэгжүүлж байжээ. Гэвч Алтан улсын энэхүү хямд өртгийн “наймаа” нь дэмий удаан явагдаж чадсангүй, түүний тавдугаар хаан Ваньгинь Юн-гийн үе (1161 - 1189 он) болоход, дотоодынхи нь зөрчил хурцадсан ба Хятад үндэстний ард түмний эсэргүүцэл ширүүдсэн учраас арга бус Сүн улс лугаа дайн зогсох гэрээ тогтож, цэргийн хүчээ өмнөд фронтоос ухруулж, дотооддоо буюу умард хил өдөө төвлөрүүлэн харуулсан билээ. Тэр үед “Татар дахин дахин ирж, хаан эзнийг орох газаргүй болгожээ” гэсэн цуурхал байсныг Алтан улсын Шицзун хаан Ваньгинь Юн олж сонсоод: “Энэ лав Татар хүн манай улсад зовлон болохын бэлгэ” гэж хэлсэн бөгөөд умард хилийн “алс бөглүү газар хүртэл цэрэг илгээн дуустал хядав” (“Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”).

байсан юм. Алтан улсын ноёрхогчид нь нэгэнт талаар олон тооны их цэргийг “гурван жил бүрд” (хэрэг дээрээ жил бүр) Монгол оронд томилон явуулж, алан хядах, талхин дээрэмдэх зэрэг зусар харгис ажиллагаагаа Монголын ард түмэнд тулгажээ. Үүнээ хүн амын тоог хомсотгох гэдэг, одоо болтол Дундад орны хүн бүр умартаагүй, ярих бүр: хорин оны өмнө Шаньдун, Хэбэй-н газарт хэний гэрт татар хүнийг худалдан авчраж боол шивэгчин болгож байсангүй буй? Энэ бүр олон цэргийн булаан авчирсан юм хэмээн хэлэлдмүй, одоохи Татарын их түшмэд олонхи нь тэр үес булаагдаж Алтан улсад сууж байсан хүмүүс юм. Бас тэдний улс жил бүр алба хүргэж ирэхэд хязгаарын гаднаас алба бэлгийг нь хураан авч буцуулаад, хилийг давуулан оруулдаггүй юм (“Монгол Татарын бүрэн тэмдэглэл”, 74 нүүр). Нөгөө талаар, “харийг хариар захирах” тэрслүү бодлогоо идэвхтэй хэрэгжүүлж, Монголын эл аймгуудыг хутган завсардуулж, харилцан алан хядуулж байв. Ялангуяа Монголын эл аймгаас Татарыг ашиглан, бусад аймгийн ард түмнийг талхидаж байснаар барахгүй, Чингис хааны дээдэс Амбагай хаан, Охин Бархаг болон Хэрэйдийн Ван ханы өвөг Хурчахус Буйруг хан нарыг барьж Алтан улсад хүргэн, харгис балмадаар тамлан алсан юм.

Амбагай хааныг алсан цаг бол Алтан улсын Сицзун хааны үе (1135-1148 он) болно. Тэр үед Буйр, Хөлөн хоёр нуурын хоорондохи Оршун голоор нутаглаж байсан Айригуд, Буйругуд овгийн Татар аймагт Амбагай хаан охиноо өгч, охиноо өөрөө хүргэж очоод, өшөөтөн Жүйн Татарт баригдаж Алтан улсад хүргэгджээ. Алтан улсын Сицзун хаан өөрийн үүдэн бүтээсэн харгис эрүү модон элжгэндээ унуулж хадаасаар хадаж тамлан алсан байна. Амбагай хаан Хамгийн хаан, улсын эзэн байтал, охиноо өөрөө үдэж хүргэхийг надаар цээрлэл болгогтун! Би Татар аймагт баригдав. Таван хурууны хумсыг тамтартал, арван хуруугаа барагдтал миний өшөөг авахыг оролдогтун (“Нууц товчоон”-ы 53 дугаар зүйл) гэж гэрээс үлдээж үхжээ. Бусад барьж авагсдыг ч мөн ингэж тамлан алдаг байжээ. Чингис хааны эцэг Есүхэй баатар ч мөн Алтан улсын “харийг хариар захирах” тэрслүү бодлогын тахилга болж амиа өгсөн билээ. Эдгээр бол зөвхөн түүхэнд тэмдэглэгдсэн монгол үндэстний нэр алдартай язгууртны төлөөлөгч хүмүүс төдий билээ. Тэмдэглэгдсэнгүй хорлогдсон хүмүүс хэчнээн байх, ялангуяа их довтолгоон байлдаанд дайрагдан хядагдсан монгол үндэстний жирийн ард түмэн хэчнээн байсныг хэрхэн тодорхойлох аж?!

Алтан улс ба Монголын хоорондохи гүн зузаан өшөө хорсол бол ингэж үүсч, улам улмаар гүнзгийрчээ. Үүнийг дайн үүссэний чухал нэгэн шалтгаан биш гэж хэлэхийн аргагүй юм. Ямар нэгэн улс үндэстэн боловч, хэзээ ч болтугай харийн дарлал доромжлолыг хүлээн тэсч ядах үед эсэргүүцэн тэмцэх буюу эсрэг этгээддээ сэтгэлийн чанартай цохилт өгдөг байна. Энэ бол дээрмийн дайн лугаа мөн чанарын ялгаатай юм. Тиймээс Монголоос Алтан улсыг эсэргүүцсэн явдал нь эхлэхийн үедээ үндэстний дарлалыг эсэргүүцсэн ариун шударга чанартай байв (Цю Шу Сэнь-ий зохиосон “Юань улсын түүхийн тухай яриа”, 29 нүүр). Чингис хаан өвөг дээдсийнхээ энэхүү өшөө хорслыг авахыг хэзээнээс бодолхийлж байсан юм. Ялангуяа 1206 оноо улс байгуулсны дараа, Алтан улсын хааны удаа дараагийн халдлагыг цээрлүүлэн залхаахаар тогтсон билээ. Гэвч тэр үед дотоодоо бүрэн төвшитгөж чадаагүй байсан болохоор, тэр даруй хөдөлсөнгүй байна.

54. Чингис хаан Алтан улсыг биеэр дайлсан нь

1206 онд Хаант Монгол Улсыг тунхаглан байгуулснаас нааш, Ойн иргэдийг хураан нэгтгэсэн,

үлдэгдэл дайсныг устгасан, дотоодын зөрчил ба эсрэг этгээдээ шийдвэрлэсэн зэрэг шинэ төрөө бэхжүүлэх ажлыг хийж, Алтан улсыг дайлах дотоодын нөхцөлийг бүрэлдүүлсэн байна. Үүний хамт Алтан улсын харьяат улс, түүний жигүүрийн халхавч хүч бологч Тангуд улсыг гурвантаа дайлж, Тангудын хүчийг нь ихээр бууруулж, Алтан улсыг дэмжих хүч болгосонгүйгээр барахгүй, Тангуд улс ба Алтан улсын хоорондохи зөрчлийг нь ихэтгэж нэг нэгээр нь устгахад ашигтай болгожээ. Жишээлбэл, “Алтан улс ба Тангуд хоёр наян жил найрамдлаар зэрэгцэн оршсон атал, Чингис хаан гутгаар удаа Тангудыг довтлоход Тангудын эзэн нь Алтан улсаас тусламж гуйгаад олсонгүй гэлээ. Ингээд 1210 онд Тангуд нь Алтан улс лугаа харьцаагаа тасалж Монголтой эвссэн бөгөөд 1213 оны эцсээр Тангуд улсаас Алтан улсын Цзинчжоу-г булаан эзэлжээ” (“Д’Оссоны түүх”, дээд дэвтэр, 73 нүүр).

Алтан улсыг дайлахад заавал бүрэлдүүлэх хэрэгтэй бас нэгэн чухал нөхцөл гэвэл, Алтан улсын дотоод байдлыг нь ойлгох явдал болно. Өөрөөр хэлбэл, цэрэг дайны тагнуулын ажлыг сайтар хийх хэрэгтэй. Энэхүү бэлтгэлийг Чингис хаан мөн нэгэн гарамгай удирдагчийн хувиар амжилттай биелүүлжээ. Энэхүү мэдээний ирэл нь голдуу гурван талаар бүрэлджээ. Нэгд, Алтан улсын хилийг сахиж байсан Онгуд аймгаас ойлгодог, Хоёрт, дотор газраар удаан явсан, олон зүйлийг үзэж мэдсэн соёл боловсролтой Сартуул худалдаачдаас ойлгодог, Гуравт, Алтан улсын ноёрхлыг эсрэгүүцэн Монголд дагаар ирэгсэдээс ойлгодог байна. Эдгээр талын хүмүүсийг дэмжиж, Алтан улсын дотоодхи эл үндэстний зөрчил, ард түмнээс Жүрчидийн ноёрхлыг эсэргүүцэж байх байдал ба жич эрх баригчдын хоорондхи зөрчил зэрэг улс төрийн мэдээ, эд гаралт ба хураамж бэлтгэл зэрэг аж ахуйн мэдээ, цэргийн тоо, зэвсэг тоног, байрлуулалт жич зам нэвтрэлгэ, хот балгас, бэхлэлт цайзын байр байдал болон цэргийн хэрэгцээний байдал зэрэг цэрэг дайны оновчтой мэдээнүүдийг ойлгон мэджээ. Ингээд Чингис хаан өшөөтөн Алтан улсыг дайлж аливаа дотоод гадаадын нөхцөл ба бэлтгэлийг бүрэлдүүлэн дуусгав.

Монгол улс ба Алтан улсын хооронд явагдсан дайн нь 1211 онд Чингис хааны үеэс эхэлж, 1234 онд Өгөөдэй хааны үед дууссан тул хэрэг дээрээ урьд хожид хорин дөрвөн жил явагдсан билээ. Энэ хорин дөрвөн жилийг их төлөв гурван шат үе хувааж болно. Нэгдүгээр шат үе нь 1211 оноос 1217 он болтол Чингис хаан өөрийн биеэр дайлсан үе болно. Хоёрдугаар шат үе нь 1217 оноос 1223 он болтол Го ван Мухулай эрхлэн дайлсан үе болно. Гуравдугаар шат үе нь 1229 оноос 1234 он болтол Чингис хааны их орыг залгамжласан Өгөөдэй хаан эрхлэн дайлсан бөгөөд Алтан улсыг хамаг эцэс мөхөөсөн үе болно. Тус товчоонд нэгдүгээр шат үеийнх нь явдлыг тэмдэглэнэ. Чингис хаан биеэр дайлсан шат үедээ Чжунду хотоор гол харалт болгосон гурван удаагийн их дайлалдааныг хийжээ.

Нэгдүгээр удаа Чжунду хотыг дайлсан нь

Анхандаа Монгол үндэстэн өөрийн улсаа байгуулахаас өмнө, Алтан улсад харьяалагдаж, жил бүр алба өргөл барьж байсан гэлээ. Гэтэл Монголчууд сүүлдээ алба тушаахыг эсэргүүцсэн болохоор Алтан улсын зургадугаар хаан - Чжанцзун хааны үед Вэй Шао Ван Юн Цзий гэгчийг Монголын зах дахи Цзинчжоу (одоогийн Өвөр Монголын Дөрвөн хошууны нутагт байжээ) оронд томилж алба нэхүүлж байсан билээ. Түүний энэ удаа (Березиний тэмдэглэлд 1206 он гэжээ. Энэ тэмдэглэл бодот байдалтай таарахгүй мэт)-гийн алба нэхэлтийг Чингис хаан эс ойшоосон тул Юн Цзий хариад, Монголыг цэргээр дайल्या гэж Чжанцзун хаандаа

сануулж байсан гэдэг. Энэ тухай Ли Цзэ Фэнь-авгайн номд баахан зөрөөтэй тэмдэглэж буй. Тэр тэмдэглэхдээ: Чжанцзун хааны эцсийн жил (1208 он), Чингис хаан Алтан улсын байдлыг нь ойлгохын тулд өргөл барих нэрээр, биеэрээ Алтан улсад хүрсэн гэнэ. Алтан улс сэрэмжтэй байсан учраас түүнийг улстаа оруулсангүй, харин Вэй ванг Чжунду өөд томилж Чингис хаан лугаа учруулсан гэлээ. Энэ үед Чингис хаан Вэй Шао ванг ойшоосон тул Вэй Шао ван ихэд уурлан, төрдөө хариад, Монголыг дайлах сануулгыг дурдсан боловч, Чжанцзун хаан нь дэмий удсангүй үхсэн учир болив гэжээ. Гэтэл Чингис хаан Алтан улсын байдлыг тагнахаар биеэрээ очлоо гэдэг явдал нь энгийн байдал дор байж болшгүй хэрэг юм. Учир нь Чингис хаан энэ үед нэгэнтээ бүх Монголыг нэгтгэж, Хаант Монгол Улсын их хаан суусан байдал дор, ийм гэнэн ажиллагааг арай хийхгүй байх аа.

Вэй Шао ван Юн Цзий хэдийгээр Монголыг дайлах сануулгыг дурдсан боловч, тэр үед Чжанцзун хаанд ийм тэнхээгүй байсан бөгөөд дэмий удсангүй 1208 онд нь дөчин нэгэн настайдаа үхсэн байв. Ингээд 1209 онд Алтан улсын долдугаар хаан орыг Вэй Шао ван Ваньгинь Юн Цзий (энэ Юн Цзий бол Чжанцзун хааны ач хөвгүүн нь болно) залгамжлаад, даяарт зарлиг тархааж, сөгдөн хүлээтүгэй гэжээ. Энэ үед Чингис хаан Тангуд улсыг гуравдахи удаагаа дайлж дуусаад, Онон мөрөн өөдөө буцаж ахуйд, түүний түргэн улаа дорно дахинаас нисэх мэт давхиулан ирж: “Алтан хааны элч нэгэнтээ Цагаан хэрэмийг гэтлэн айсуй” гэж мэдүүлжээ. Чингис хаан тэр даруй зарлиг буулган цэргээ зогсоож, Алтан улсын элчийг дуудун ирүүлж, аяны ордондоо уулзсан байна (Березиний ном). Ингээд “Шинэ эзэн чинь хэн буй?” гэж Чингис хаан Алтан улсын элчээс асуухуйд, “Вэй Шао ван болой” гэж элч хариулсанд, Чингис хаан өмнөш хандан нулимаад Дундад орны хаан нь тэнгэрээс заяасан хүн хэмээн би боддог бөлгөө, харин ийм хөдхи амьтан бас байх ажгуу, түүнд хэрхэн сөгдөх аж! (“Юань улсын түүх”) гэж хэлээд мордож умарш явсан гэлээ. Алтан улсын элч буцаж хариад хариу айлтгасанд Юн Цзий ихэд уурлан, дахин өргөл барих үед нь барьж аван хорлоё гэж тогтжээ. Үүнийг нь Чингис хаан сонсоод Алтан улс лугаа аливаа харьцааг зогсоож, их цэргийг засан өмнөш дайлахаар бэлтгэв. Энэ бол дайн үүссэн шууд шалтгаан нь болно.

Чингис хаан Алтан улсыг анх удаа дайлсан цаг бол Чингис хааны зургадугаар он (1211 он)-ы 2 сар11 болно. Энэ үед Чингис хаан тавин нас сүүдэртэй байв.

Их цэрэг мордохын өмнө, Чингис хаан нэгэн бөө мөргөлийн сүсэгтний хувиар, өндөр дов дээр гарч, бүсээ тайлан хүзүүн дээрээ тавин, малгайгаа авч: “Мөнх тэнгэр ивээтүгэй! Амбагай хаан тэргүүтэн миний өвөг дээдсийг Алтан улсын хаан хар харгисаар тамлан алжээ. Энэхүү цусан өшөөг авахыг мөнх тэнгэр ивээх аваас надад нэгэн мөрийн хүч соёрхохын хамт нөгчигсөдийн ариун сүнс ба эл сахиулснаар намайг дэмжүүлэх болов уу”¹² гэж даатган наминчилж дуусаад цэрэг мордов.

Чингис хаан дөрвөн хөвгүүн (Жочи, Чагаадай, Өгөөдэй, Тулуй)-ийхээ хамт, хошууч жанжин Зэв, зүүн гарын түмний ноён Мухулай нарыг удирдан их цэргийг дайчилж, Хэрлэнгийн их ордоосоо хөдөлж, Монголын их говь нутгийг шургуу бушуу туулж, Алтан улсын зах болох Онгуд аймагт хүрэв. Чингис хаан Цагаан хэрэм хүртэл бараг 180 уналгын газар (нэг уналгын газрыг нь дөрвөн км гэдэг)-ын Монголын говь нутгийг туулан өнгөрөөжээ. Энэхүү говь нутагт нь харин шорвог нуур л байхаас биш ус бэлчээргүй, ой шугуй нэнгүй” гэж “Д`Оссоны Монголын түүх”-д тэмдэглэж байв. Үүнээс үзэхүл, Монголын их цэрэг нь Онгуд аймаг

хүртэл бараг мянга таван зуун газрын бэрхшээлтэй замыг туулж хүрчээ.

Юуны урьд Чингисийн хошууч жанжин Зэв ноёны удирдсан цэрэг, Онгуд хүнээр замчуулж Цзинчжоу13-гийн газраар дайран зүүнш шувталж, тус оны 4 сард Да-суй-луань, Фэн-ли (одоогийн Хэбэй мужийн Чжанбэй сянь-аас баруунш байжээ) зэрэг сянь-ийг эзлэн авсан байна. Энэ зун Чингис хаан Онгудын нутагт зусаж, цэрэг агтаа амруулан, намрын довтлолтоо бэлтгэжээ. Энэ үед Онгуд аймгийн ахлагч Алахуши Дигит Хури харьяат нараа дагуулан ирж Чингис хаанд бараадсан бөгөөд энэ удаагийн дайралдаанд нь замчлан явав.

Үүний урьд, Чингис хаан Алтан улсыг дайлах бэлтгэлийг бүх талаар хийж байх үед, Алтан улсын умард хилийн сэргийлэгч жанжин Нахамайжу гэгч ажиг мэдэж, “Монголчууд говийн умард аймгуудыг цөм нэгтгэн авсан бөгөөд зэргэлдээ улс орнууд нь даган, Тангуд улс охиноо өгч, Монголчууд бас зэр зэвсгийг үйлдэн, одоо өмнөш шилжин байхаар үзэхүл, Алтан улсыг халдах бололтой” гэж Ваньгинь Юн Цзий хаан (Ту Цзи харин Чжанцзун хаан гэжээ. Гэтэл Чжаньцзун энэ үед үхсэн байлаа)-даа мэдүүлжээ. Гэвч Алтан улсын хаан байдлыг буруугаар ойлгож, Алтан улс ба Монголын хооронд зуураангүй гэсэн бөгөөд гэдрэгээ Нахамайжу-г хилийн өдөөнөөс айв гэж барьж аваад гянданд хорьсон гэдэг билээ. Ингээд Алтан улс нь Чингис хааны дайралтад ямар ч бэлтгэлгүй байв.

Чингис хааны жолоодсон Монголын их цэрэг элс говийг туулж, өмнөш довтолж байх үед, Алтан улсын хаан бас эсэргүүцэх зориггүй болохоор баруун хойд замын Чжао Тао Ши түшмэл Чжань-ха Хада гэгчийг томилон, найрамдахаар гуйчилжээ. Гэвч Чингис хаан эс хүлээсэн тул Юн Цзий ихэд айж, Нахамайжу-г тавьсан бөгөөд 1211 оны 3 сараас эхэлж сая хориглолтын бэлтгэлийг бачим сандруу хийж, Алтан улсын баруун нийслэл Сянь хот (одоогийн Шаньси мужийн Датун хот)-оос Чжанчжоу (одоогийн Хэбэй мужийн Сюаньхуа сянь-ий харьяа), Фучжоу (одоогийн Чжанбэй сянь болно. Гэтэл зарим бичигт Синхэ Чэн буюу Хар балгас гэдэг) хүртэлх нэгэн шугамаар монгол цэргийг хориглохоор горьдож, Чжанчжоу, Фучжоу фронтын жолоодлогыг Пин-чжан ноён Дуги Цянцзяну, Ваньгинь Чэн Юй-гээр хариуцуулж, төрийн зөвлөгч Ваньгинь Хуша-гаар Сюань Дэ (одоогийн Хэбэй мужийн Сюань Хуа) мужийн хэргийг захируулсан бөгөөд баруун нийслэлийн сэргийлэгч Шу Ми Юань-ий орлогч Хишли Хушаху (дорогш Хушаху гэж товчлов)-гаар баруун фронтын хориглолтыг хариуцуулжээ.

Алтан улсын хааны энэхүү бодлого бол цэргээ салгаж, хот боомтыг нэг нэгээр нь сахих бодлого болно. Алтан улс энэ мэт хот боомтыг нэг нэгээр нь сахиж, цэргийн хүчээ салгасан тул Монголын их цэргийн довтлолт доор “саланги цэрэг төвлөрөнгүй дайралтад садран ялагдах нь зайлшгүй” гэдгийг дайны эхний үед дээд нийслэлийн сахигч Тугдани гэгч үзэж мэдээд Чжанчжоу, Хуаньчжоу (Д’Оссон “Кутун балгас coutoun-balgassou” гэжээ. Одоогийн Өвөр Монголын Долон нуур орчим байжээ), Фучжоу зэрэг газрын хүний хүч ба бодосын хүчийг Цагаан хэрэмээс дотогш шилжүүлж, голдлоготой хориглолт хийхийг Алтан хаанд сануулга тавьсан байв. Гэтэл Алтан хаан Чжанчжоу, Хуанчжоу, Фучжоу-гийн газрыг тавих дургүй тул түүний сануулгыг нь хүлээн авсангүй гэлээ. Тэр үед бас Алтан улсын төрийн Циши түшмэл Чжао Бин Вэнь гэгч “Монголын бүх цэрэг өмнөш довтлон, ар тал нь хоосорсон завшааныг далимдуулан, Линь Хуан-д бүхий нэгэн хэсэг цэргийг хойш томилон, Монголын цэргийн чухал ар талыг нь дайрвал, баруун нийслэлийг Монголын цэргийн сүрдүүллээс

хөнгөлж болно” гэж Алтан хаандаа сануулсан боловч, Алтан хаан нь бас хүлээн авсангүй бөгөөд Сюандэ, Фучжоу зэрэг хотыг үхэн сахиж, Ушабуу цайзыг15 бэхлэн буулгажхориглон хийв.

баруун нийслэлийн халхавч бологч Ушабуу, У-юай-ин (одоогийн Өвөр Монголын Улаанцав аймгийн Синхэ сянь-ий харьяанд байжээ) зэрэг газрыг эзлэн авсан тул Алтан улсын сахиул цэргийн түрүү Цяньцзяну, Ваньгинь Хуша нар Фучжоу-гийн газраа орхиж, Сюань Пин (одоогийн Хэбэй мужийн Ваньчжун сянь)-д дутаан очин хориглолт хийжээ. Энэ үед Алтан улсын түшмэл Го Бао Юй¹⁶ зэрэг монгол цэрэгт бууж өгсөн бөгөөд монгол цэрэг нь Бай Дэн (одоогийн Шаньси мужийн Датун хотоос зүүн хойш байжээ)-г хялбархан эзлэн авч, Алтан улсын баруун нийслэлд шахан хүрчээ. Энэ үед баруун нийслэлийн сэргийлэгч жанжин Хушаху¹⁷ хотоо долоохон өдөр сахиад, зуугаад морьт цэргийг авч бүслэлтийг шувтлан гарч зүүнш Цзицзингуань боомт өөд дутаасан тул, Чингис хаан гурван мянган морьт цэргээр Хушаху-г нэхүүлсэнд, Хушаху Юйчжоу (одоогийн Хэбэй мужийн Юй сянь)-г дайрч, нийслэл Чжунду хотдоо дутаан харьсан байна. Монгол цэрэг баруун нийслэлийг нь эзлэн авав. Ингээд Чингис хаан гол цэргээ өөрөө дайчилж, Чжанчжоу, Фучжоу хоёр чжоуг довтолсонд Алтан улсын цэргийн сэргийлэгч жанжин Ваньгинь Чэнь Юй цэргээ дагуулан ухарсан байв. Энэ үед Монголын цэрэг нэхэн, Цуй Бин Шань (одоогийн Чуулалт хаалгын ар дахи Вань Цюань сянь-аас баруун хойш буй), Хуй Хэ Бао (Вань Цюань сянь-аас өмнөш байжээ) зэрэг газар гүйцэж эцээд Ваньгинь Чэн Юй-гийн цэргийн гол хүчийг нь дараа дараагаар сөнөөж, ялалтын эрчээрээ Сюань Дэ, Дэ Син (одоогийн Хэбэй мужийн Чжо Лу сянь) зэрэг хот балгасыг эзлэн авсан байлаа.

Тус оны 9 сард нь Монголын цэрэг Дэ Син-ийг эзлэн авч, Зэв болон Хүйхүнэг баатар хоёрыг манлай болгож, Цавчаал боомтыг довглохуйд, хуурмагаар ухран, Алтан улсын сахиул цэргийг бэхлэлтээс нь өдөн гаргаж, гэдрэг довтолж нэхэн сөнөөсөн бөгөөд Монголын цэрэг Цавчаал боомтыг эзлэн авав. Дараагаар нь Чингис хаан гол цэргээ дагуулан хүрч ирээд Шар Дэгтэрт¹⁸ буув. Ингээд Монголын цэрэг Алтан улсын нийслэл Чжунду хотын дүүрэгт шахан хүрчээ. Энэ үед Алтан улсын хаан нь өмнөд нийслэл (одоогийн Хэнань мужийн Кайфэн хот) өөдөө дутаахыг оролдож, доорхи ноёд түшмэддээ эсэргүүцэгдлээ гэдэг билээ. Ингээд Алтан улсын цэрэг нийслэл хотоо чанга сэргийлсэн тул монгол цэрэг хэдэн удаа довтолсон боловч эзэлж чадсангүй мөртөө цэргийн хүчээ нэлээд хохируулж, арга бус ухран гаргажээ. Монгол цэрэг ухран буцах үед “Елюй Ахай Алтан улсын Юньнэй дэх адууны талбайг нь довтолсон бөгөөд 10 сард адуун талбайн элч Онгу Дангун гэгч адуугаа хөөж орж өгөөд, Чингис хаан лугаа аяны газар бараадав”¹⁹.

Монголын цэргийн гол хүч нь Алтан улсын нийслэл Чжундуг довглохын хамт, Чингис хаан өөрийн гурван хөвгүүн Жочи, Чагаадай, Өгөөдэйгээр баруун гарын цэргийг захируулж, баруун замаар довглуулжээ. Тэдний удирдсан цэрэг нь Юньнэй (одоогийн Өвөр Монголын Урад хошуу – иргэн улсын үед Саальчин тинхимийн харьяат газар), Дуншэн (одоогийн Өвөр Монголын Тогтох сянь), У чжоу (одоогийн Шаньси мужийн У-чжай сянь), Су чжоу (одоогийн Шаньси мужийн сянь) зэрэг газрыг эзлэн авсан байна. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” ба “Елюй Люгэ-гийн намтар”, “Алтан улсын түүх, Вэй Шао вангийн шастир” зэрэг тэмдэглэлээс үзэхүл, Чингис хаан анх удаа Алтан улсын нийслэл Чжунду-г биеэр дайлахын зэрэгцээгээр, Алчи ноён, Сүбээдэй нараар жолоодуулсан нэгэн салаа цэргийг Ляодун орон өөд томилжээ. Энэ нэгэн салаа цэрэг нь 1211 оны 12 сарын баргаар Луухын голын дээд урсгал оронд хүрч Елюй Люгэ лүгээ уулзав гэдэг билээ.

Энэ удаагийн дайралдаанд Монголын цэрэг нь Алтан улсын Дэсин, Хунчжоу (одоогийн

Хэбэй мужийн Янюань сянь-ий орчим), Чанпин, Хуайлай, Цзиньшань (одоогийн Бээжин хотын Янцин сянь), Цзинин (одоогийн Хэбэй мужийн Чжанбэй сянь-ий харьяанд байжээ), Мюнь, Фуинь зэрэг олон хот балгасыг дайран талхижээ. Энд тэмдэглүүштэй нэгэн зүйл гэвэл, тэр үед монгол цэрэг нь хот балгасыг байлдан цохиж, дайсан этгээдийнхээ амьд хүчийг хохируулаад явдгаас биш, орон газрыг эзлэн суудаггүй байлаа. Тиймээс монгол цэрэг явсан хойно олонхи газрыг нь Алтан улсын цэрэг дахиад эзэлдэг тул нэг л газрыг монгол цэрэг гэнэт байлдаж, хэдэнтээ эзэлсэн явдал ч гарч байв.

Монгол цэрэг нь олон удаагийн байлдааныг өнгөрөөж, 1211 оны өвөл хойш ухарч, Алтан улсын умард хил дагуу газраар цэргээ цэгцлэн амруулжээ. Түүнчлэн Чингис хааны анх удаа Алтан улсын нийслэл Чжунду хотыг дайлсан дайралдаан нь мөн ч түр завсарласан билээ.

Хоёрдугаар удаа Чжунду хотыг дайлсан нь

Монголын цэрэг охор хугацааны амралтыг өнгөрөөж, Чингис хааны долдугаар он (1212 он)-ы хаврын тэргүүн сар²⁰, хаан тавин нэгэн нас сүүдэртэйдээ Алтан улсын нийслэл Чжунду хот руу хоёрдугаар удаагийн дайралт явуулав. Энэ удаагийн дайралдаан нь хэрэг дээрээ анх удаагийн дайралдааныхинь үргэлжлэл болно. Дайралдаан эхэлмэгц монгол цэрэг Юньчжун (Шаньси мужийн Датун сянь-ий харьяанд байжээ), Цзю-юань (Өвөр Монголын У-юань орчим)-ыг эзлэн авч, залгаад Фучжоу уруу дахин довтолсон байна.

Энэ үед Алтан улсын хаан нь баруун нийслэлийн сэргийлэгч Шу Ми Юань-ий орлогч Хушаху-г ерөнхий захирагч болгож, зүүн гарын түшмэл Ваньгинь Уну-гаар дэдлүүлж, Дин Сюай гэгчээр хошуучлуулж, Сюандэ-гийн мужийн орлогч Ваньгинь Хуша-гаар гээг болгон гучин түмэн их цэрэг (энэ тоо нь хол ихэсгэсэн тоо бөгөөд “Юань улсын түүх”-ийн тэмдэглэл баримтгүй гэж Ли Цзэ үзжээ. Би мөн “Юань улсын түүх”-ийн тэмдэглэлээр баримтлав)-ээр Үнэгэн даваа²¹ дээр хориглолт хийжээ. Тэр үед Ваньгинь Хуша²²: “Монголын цэрэг Фучжоу-г саяхан эзэлж аваад, агт морио хээр адуулан, цэргээ дураар тавьж, ихээр олзолж буй хэмээн сонслоо. Бид хэрвээ түүний сэрэмжгүйг нь далимдуулан, гавшгай морьт цэргээр дайрваас хялбар ялж болмуй” гэж Хушаху-д арга заасан гэлээ. Гэтэл Хушаху хүлээн авсангүй бөгөөд “Энэ болбоос аюултай арга буй за, харин явган, морьт хоёр цэргээр хамт довтолбоос дээд бодлого буюу” гэж хэлээд дараа өглөө нь их цэргээр довтолсон байв.

Чингис хаан энэхүү бачим мэдээг сонсоход яг цэргийн хүрээндээ зоог барьж байсан тул аяга савхаа тавьж, голын цэрэг ба зүүн гарын цэргээ авч Доргын хошуу²³ гэдэг газар дайсныг угтаж байлдав. Алтан улсын цэргийн ерөнхий захирагч Хушаху, Шимо Мянган²⁴ гэгчийг томилж, монгол цэрэг юуны учир довтлов? гэж асуулгахаар явуулсан байв. Гэтэл Шимо Мянган хүрмэгцээ цэрэгт буун өгсөн бөгөөд Алтан улсын цэргийн бүх байдлыг Чингис хаанд хэлж өгчээ. Энэхүү байдлыг нь олж мэдээд, “Алтан улсын цэрэг олон, Монголын цэрэг цөөн тул хэрвээ үхэн үл байлдаас Алтан улсын цэргийг ялахуйяа бэрх” гэж Чингисийн зүүн гарын түмний ноён Мухулай хэлж, шаргуу байлдах ангийг биеэрээ дагуулан Алтан улсын цэргийн байранд дайран орсон бөгөөд Чингис хаан гол цэргээ жолоодож, хойноос нь довтлон оржээ. Алтан улсын “Хар хятад (Хятан – эшлэгч)”, Жүрчин, Жүйний²⁵ шилдэг баатар цэргүүдийг дарж, Цавчаалыг хүртэл Хятад (Алтан улс – эшлэгч)-ын цэргийг хиартал хядав” (“Нууц товчоон”-ы 247 дугаар зүйл). Энэ үед Алтан улсын жанжин Ваньгинь Хуша монгол цэрэг лүгээ учралдмагц өчүүхэн ч эсэргүүцэж чадсангүй өмнөш дутааж, Хуй Хэ Бао цайзад²⁶

туйлбартай ялагджээ. Ингээд Алтан улсын гучин түмэн цэргийг бүрмөсөн устгасан юм. Энэ үед Елюй Тохуа-гийн цэрэг Хушаху-г Дин Ань-ий умараа нэхэн хүрч ялсан бөгөөд Хушаху нарийн замыг барин Цзицзингуань боомтод дутаан оржээ. Дараа нь монгол цэрэг Сюаньдэ-г эзлэн авч, хотыг нь эвдлэв.

1212 оны 8 сард, Чингис хаан өөрөө Алтан улсын баруун нийслэл Сицзин хотыг бүслэн довтлов. Энэ үед Алтан улсын юаньшуай, зүүн гарын цэргийн захирагч Уудунсянь гэгч цэргээ дагуулан ирж баруун нийслэлийнхээ цэргийг тусласанд, Чингис хаан цэрэг томилон, түүнийг Ми Гу коу (“Алтан улсын түүх, Сянь-ий намтар”-т “Мо Гу коу” гэдэг) өөд өөдөө дагуулж, эсрэгээс нь байлдан сөнөөсөн тул Уудунсянь ганц биеэрээ дутаан гарлаа гэдэг билээ. Залгаад Чингис хаан баруун нийслэлийг довтолж зэрлэг суманд шархдаад цэрэг ухарчээ²⁷.

Тус оны 9 сард, монгол цэрэг бас Дэ Син балгасыг довтлоод авч чадсангүй ухарчээ. Дэ Син балгас бол тухайн үедээ жимс цэцгийн хүрээлэнтэй бөгөөд архи арвин нэрдэг тул Алтан улс нь хурц цэргээр сахиж байжээ. Дараа нь Чингисийн дөрөвдүгээр хөвгүүн Тулуй болон Чихү хүргэнээр дайчлуулж, Дэ Син балгасыг дахин довтлуулжээ. Энэ байлдаанд Чихү хүргэн урьдаар байлдах тагтыг нь даван гарч, хотыг нь эзлэн авсан бөгөөд тус хотын харьяан дахи цайз бэхлэлтийг нь бүр эзлэн авсан байв. Гэвч удалгүй Алтан улсын цэрэг бас буцаан эзэлсэн гэдэг билээ.

Мөн 1212 онд Хятаны үрс “Зүүн Ляо Улс” гэж байгуулаад, Монголд орж өгсөн юм. Үүнийг дараа тусгай сэдвээр бичих тул энд товчлов.

Залгаад, 1213 оны 7 сард, Монголын цэрэг гол хүчээ Алтан улсын нийслэл Чжунду хотоос араархи орнуудад шилжүүлэн байлджээ. 7 сард нь Чингис хаан биеэрээ Дэ Син балгасыг дахин эвдэж, 8 сард нь Гуйчуань гол (одоогийн Хэбэй мужийн Гуйсуй гол)-д хүрч, Алтан улсын мужийн төлөөлөгч Ваньгинь Ган, Чжэнчжоу-гийн юаньшуай, баруун мөрийн нийтлэн захирагч Жүхү Гуучи нартай байлдаж ялав. Ингээд Цавчаал боомтын умард ам хүртэл нэхэн байлдаад, боомтыг шахан хүрэв.

Гэвч, Алтан улсын цэрэг Цавчаал боомтыг дахин эзэлж аваад, үүд хаалгыг нь төмрөөр гагнан бэхэлж, бас төмөр зараан саадыг зуун газрын шугамаар тавьж, хүнд цэргээр сахиулж байсан тул Монголын цэрэг ойртож эс чадав. Энэ үед, “Цзицзингуань боомтоор тойрч, шөнө өдрийн дотор Цавчаал боомтод хүрч чадах нэгэн нарийн зам байдаг” гэж Жабар Чингис хаанд сануулга айлтгасан гэлээ. Ингээд Чингис хаан, Хэтэй (Уругудын Жүрчидэй-н хөвгүүн, тавин долдугаар гавьяатан), Бочэ²⁸ хоёрт, Цавчаал боомтын умард хаалганд цэргээ байрлуулж, Алтан улсын цэргийн анхаарлыг тэд тэнцэлдэж байтугай гэж Арачан (үүнийг Жабар Халжа мөн гэж Ту Ци тэмдэглэжээ)-гаар зарлиг уламжлуулж, өөрөө Зэвийн шаламгай цэргийг дагуулан, Цавчаал боомтын баруун дахи нарийн замаар тойрон, Фэй Ху Дао-гийн хавцлыг сэмээр авч, өмнөш Цзицзингуань боомтын хаалгад хүрчээ. Үүнийг Алтан улсын хаан сонсч, боомтыг эрхшээн сахиулахаар Жүхү Гуучи-г²⁹ бачим томилсон боловч, Чингис хааны цэрэг нэгэнт Цзицзингуань боомтыг гэтлэн гарч, Жүхү Гуучи-гийн цэрэг лүгээ Ухуйлин даваанаа ширүүн байлдаж сөнөөв. Түүнчлэн У чжоу (одоогийн Хэбэй мужийн У сянь)-г эзлэн авсан бөгөөд Зэв ноёны хөнгөн морьт цэргийг нисгэн довтолгож, Цавчаал боомтын ар тал болох энэ коу-г гэнэт дайран авч, дайсныг хөндлөн гулдгүй алсан байна. Үүний хамт Цавчаалын умар

хаалгыг сахиж байсан Хятан жанжин Элүбүр зэрэг ч умар хаалгаа тавин орж өгөв. Ингээд Зэвийн цэрэг энэ коу-гийн хавцлаар хойш явж, Хэтэй, Бочэ-гийн цэрэг лүгээ нийлэн Цавчаал боомтыг дахин эзлэн авав.

Тус оны 8 сард, Алтан улсын баруун нийслэлийн сэргийлэгч байсан Хушаху “Ордны хувьсал” гаргаж, Ваньгинь Юн Цзий хаанаа хор идүүлэн алж, Фэн ван Ваньгинь Сюань-ийг Алтан улсын наймдугаар хаанаар өргөмжилжээ. Чингис хаан, Алтан улсын энэхүү дотоодын хямралдааныг нь ашиглан, Чжунду хотын довтлох ажиллагаагаа эрчимжүүлсэн байв. Ингээд Чингис хаан Цавчаал боомтыг эзлэн авсан хойно, Хэтэй, Хадай30 жанжнаар таван мянган шилдэг морьт цэргийг удирдуулж, Чжунду хотын нэвтрэх зам бүхнийг нь эрхшээлгэж, өөрөө их цэргээ авч Чжочжоу-г довтолжээ. Өвлийн 10 сарын 5-д Алтан хааныг бууж өгтүгэй гэж Арачан-ыг Чжунду хотод элчээр явуулсан бөгөөд тус сарын 16-д нь Монголын их цэрэг Чжунду хотын умараа ирж, Жүхү Гуучи лугаа нэгэн өдөр байлдаж устгаад, Чжочжоу хотыг эзлэн авав.

Гэвч, Чжунду хотын сэргийлэл хамгаалалт нь бат бэх тул олонтоо довтолсон боловч хотыг нь ер эзэлж чадсангүй билээ. Ингээд Чингис хаан Чжунду хотыг довтолох төлөвлөгөөгөө түр өөрчилж, бүх цэргээ гурван замаар хуваан, Алтан улсын ар талын гүн тийш довтолов.

Баруун зам нь Жочи, Чагаадай, Өгөөдэйн удирдсан баруун гарын цэрэг болно. Тэр нь Тайханшань уулыг даган өмнөш довтолж, Баочжоу (одоогийн Баодин), Суйчжоу (Хэбэй мужийн Сюйсуй сянь-аас баруунш буй), Вэйчжоу (Хэбэй мужийн Вэй сянь), Синчжоу (Хэбэй мужийн Синтай), Лочжоу (Хэбэй мужийн Юнняян-аас зүүн өмнөш буй), Чжандэ (Хэнань мужийн Ань Янь), Хуайчжоу (одоогийн Циньян), Мэнчжоу (одоогийн Мэн сянь) зэрэг газрыг байлдан аваад, шууд Хатан голын умард эрэг хүрч, дахин баруун хойш Тайханшань уулыг мушгин ороож, Шаньси мужид оров. Ингээд бас Лу-ань (Шаньси мужийн Чанхи), Пинян (Шаньси мужийн Линьфэнь), Тайюань зэрэг газрыг байлдан талхижээ.

бага хөвгүүн гэжээ. Энэ нь таарахгүй юм), Алчи ноён³¹, Толун чэрби нарын удирдсан зүүн гарын цэрэг болно. Тэр нь далай дагуу зүүнш довтолж, Цзичжоу (Хэбэй мужийн Цзи сянь), Люаньжоу (Хэбэй мужийн Люань сянь) ба Ляоси-гийн эл газрыг байлдан авчээ. Дунд зам нь Чингис хаан болон түүний дөрөвдүгээр хөвгүүн Тулуйн удирдсан гол замын цэрэг болно. Тэр нь өмнөш довтлон Хэцзянь, Цзийнань, Иду зэрэг олон хот балгасыг байлдан авч, хошууч цэрэг нь И Мэн Шань уулыг гэтэлж Пэ сянь-д хүрсэн байв.

Энэ үед Алтан улсын төр нь бүх цэргийн хүчээ төвлөрүүлэн нийслэл Чжунду мэтийн чухал хотуудаа сэргийлж байсан тул Дундад орны өргөн уудам орон нутаг нь цэргийн хүчгүй хоосорч, эл хотод нь байлдах чадваргүй хөдөөгийн ардыг барьж ирээд хотоо сахиулж байв. Тиймээс Монголын их цэрэг нь хандсан зүг дайсангүй байж, дайрсан газар бүхнийг дагуулж, Тунсунь (одоогийн Сунь-и сянь), Чжэньдин (одоогийн Джендин), Дамин, Дунпин зэрэг арван нэгэн хот балгасаас бусад Шаньдун, Шаньси, Хэбэй, Ляоси зэрэг газрын ерээд хот балгасыг байлдан авчээ.

Тус оны сүүлчээр Чингис хаан Чжунду хотын баруун хойд дүүргийн Шар хээр³² гэдэг газар ирж, буусан бөгөөд Мухулай бас энд ирж хаан лугаа учирчээ.

1214 он (хөх нохой жил)-ы хаврын тэргүүн сард Чингис хаан Шар хээрт байх үед, Алтан улс эвсэхийг гуйчлахаар зөвлөж байна гэсэн чимээг сонсч, довтлолтоо зогсоож, ямар болохыг хүлээн авай. Энэ үед олон жанжин нар нь, ялалтын эрчин дээрээ Чжунду хотыг эзлэн авахаар дурдаж байв. Гэвч Чингис хаан зөвшөөрсөнгүй бөгөөд “Өнчин хотыг дайсанд үлдээн сахиулбаас хүч нь өөртөө буурах болой” гэж хэлжээ.

Тус оны 2 сард, Арачан (“Алтан улсын түүх, Сюаньцзун хааны шастир”-т: “элч Зэв” гэжээ. Энэ “Зэв” гэсэн нь “Жабар”-ын хувирал болох нь илт бөгөөд Жабар, Арачан нэг хүн болохыг бас гэрчилж болно)-г Алтан хааны дэргэд хоёр удаа элчлүүлж: Шаньдун, Хэбэй-н олон фу, чжоу-гийн газар чинь цөм минийх болов, чи өдгөө ганц Чжунду хотоо сахих болов. Дээд тэнгэр чамайг буруу үзэж, би бас түгшүүрт тулгуурлав. Мөнх тэнгэр өршөөтүгэй, би өдгөө умарш буцсугай хэмээн амуй, чи харин цэргийг тохинуулж, жанжин нарын хилэн чилээг үл тайтгаруулах буюу? гэж хэлүүлсэн гэлээ.

Алтан улсын эзэн нь олон түшмэд ноёдоо цуглуулж, дайн зогсох бодлогын тухай зөвлөгөөн хийжээ. Энэ зөвлөгөөн дээр нь хоёр зүйлийн адилгүй санал дурдлаа гэдэг билээ. Нэг нь байлдах гэсэн санал, нөгөө нь эвсэх гэсэн санал болно. Байлдах гэсэн саналыг Пинчуань ноён Жүхү Гуучи дурджээ. Түүний үзэхээр, Монголын агт морьд эцэнхий, хүч буурсан тул энэ завшааныг далимдуулж байгаад ялсан ялагдсан ч болтугай эцсийн шийдвэрт байлдааныг хийе гэж зорьжээ.

Эвсэх гэсэн саналыг нийтлэн захирагч юаньшуай Ваньгинь Чэнхуй (бас Фусин гэдэг) дурджээ. Тэр хэлсэн нь, Чжунду-д бүхий цэрэг бол эл газраас бачим элсэн эчсэн тул бие нь хэдийгээр энд байвч, гэр бүл нь эл орон газарт байх тул сэтгэл нь хаа байхыг бүү мэд, ийм цэргээр байлдваас, тороос мултарсан шувуу мэт нисэн бутарч, ялагдахгүй байж чадахгүй, завшаанаар ялавч, тэд гэр нутаг гэргий хүүхдээ санаж, хэн нэгэн сэтгэлээр сахих буй? Тиймээс өвөг дээдсийн үйл өв лүгээ холбогдох их явдлыг хэрхэн эцсийн ганцхан мөрийцөөнд найдах аж? гэжээ. Алтан хаан энэ саналыг нь зөвшөөрсөн байв. Ингээд 3 сарын цагагчин

хонин өдөр, Алтан улсын хаан нь Ваньгинь Чэнхуй-г Монголын цэргийн хүрээнд элчлүүлж, дайн зогсож, эвсэхийг гуйчлуулсанд Чингис хаан зөвшөөрч, бас Арачан-ыг Чжунду-д элчлүүлэн, эвсэх нөхцөлийг хэлэлцүүлсэн байна.

Хэлэлцээний дүнд, Алтан улсаас Вэй Шао вангийн охин Чиху гүнжийг инж дагалт хөвгүүд охид тус бүр таван зуун нэр, агт морь гурван мянга, алт мөнгө, агуурс таваарыг даан ядтал Чингис хаанд хүргэжээ. Энэ Чиху гүнжийг бол Чингисийн татвар гүнж хатан гэдэг билээ.

Түүнчлэн эвсэл биелэгдэх, Ваньгинь Чэнхуй Чингис хааныг Цавчаал боомтоос үдэн мордуулж Фучжоу-гийн Доругу-гийн хошуу хүртэл хүргэсэн гэлээ. Монголын цэрэг Чжунду хотыг хоёрдугаар удаа дайлсан дайлалдаан ч ингээд түр цаг дууссан юм.

Гуравдугаар удаа Чжунду хотыг дайлсан нь

Чингис хаан Алтан улсын нийслэл Чжунду-гаар гол харалт болгож, Алтан улсын өргөн уудам дотор газрыг нь хоёр удаа байлдан сүйтгээд, 1214 оны хавар байлдааныг зогсоож, Алтан улс лугаа түр эвсэн, Цагаан хэрэмээс хойш ухарч, энэ зун Загасан нуурт³³ зусав.

Алтан улс нь Монголын цэргийн хоёр удаагийн өргөн хэмжээний довтлолтод дайрагдаж, барсаас айсан тугал, нумнаас үргэсэн шувуу, нуураас салсан галуу шиг болсон байна. Ингээд Алтан хаан нь 1214 оны 4 сард өмнөд нийслэл Бяньляндаа шилжин нийслэхээр тогтжээ. Энэ үед Алтан хааны сайд Түгдэни: Одоо нэгэнт Монгол улс лугаа эвссэн тул энэхүү завшааныг ашиглан, цэргийн хүчийг сэргээн төвлөрүүлж, амуу хүнсийг хураан цуглуулж Чжунду хотыг алдалгүй сахивал зохих бөгөөд Ляодун бол газрын байцын талаар сахихад ашигтай байлдах бодлогын чухал орон болох тул Ляодун-гийн хориглолтыг чангатгавал зохино. Ялангуяа өмнө нийслэл бол дөрвөн талаасаа дайсны сүрдүүллийг олж байх хот тул яасан ч тэнд нийсэлж болохгүй гэж хаандаа айлтган мэдүүлсэн гэлээ. Гэвч мунхуурч доройтсон Алтан хаан түүний зөв сайн саналыг сонссонгүй, бас л нийслэлээ нүүлгэхээр шийдэж, баруун мөрийн түшмэл Ваньгинь Чэнхуй, зүүн мөрийн түшмэл эрхин сайд Моняньцзиньчун³⁴ хоёроор хааны тайцзи Шуцзун-ыг туслуулан Чжунду хотыг сахиулаад, тус оны 5 сард нь, Алтан хаан Ваньгинь Сюнь зургаан ордны хатад татвараа авч, өмнөш Хэнань өөд нүүн явсан бөгөөд Лянсян (Бээжингээс баруун өмнө Фаншань сянь-ий харьяанд буй)-д хүрсэнд Алтан хааны хамгаалагч цэрэг дэх Хятан үндэстний хүмүүс нь урван гарч Чингис хаанд орж өгсөн байлаа³⁵.


1214 оны 6 сард, Чингис хаан Загасан нуурын зуслангийн газар байхдаа, Алтан хааны өмнөш нүүснийг сонсч, “эвссэн бөгөөтөл нийслэлээ нүүлгэж байх нь өөр сэтгэл өвөрлөж, эвслийн гэрээгээр намайг мэхэлсэн буй за” гэж машид хилигнэсэн бөгөөд бас Арачанг томилон донгодон зэмлэв.

Тус оны 7 сард, Алтан хаан монгол цэргийн дахин довтлохыг сонсч тайцзи Шучжунаа бас Чжунду хотоос дуудун өмнөд нийслэл Бяньлян өөдөө аваачжээ. Ийм байдал доор, Чингис хаан дахин өмнөш дайлахаар шийдэж, Салжигудын Самуха баатарт зарлиг өгч, Хятаны жанжин Шимо мянган болон Елюй Ахай, Елюй Тохуа ах дүү хоёроор хошуучлуулан, Каньда зэрэг шинэхэн орж өгсөн Хятан цэрэг лүгээ хүч хамтран Чжунду хот өөд довтлов. Тэдний цэрэг Мулташи-гийн хаалгаар дайрч, Цзинчжоу (Хэбэй мужийн Цзуньхуа сянь), Цзичжоу,

Таньчжоу (одоогийн Бээжин хотын Мичин сүм), Шуньчжоу (Бээжин хотын Шунь-и сянь) зэрэг газрыг дараа дараагаар байлдан авч шууд Чжунду хотод шахан хүрэв.

Чжунду болон Ляоси-гийн 36 харилцааг нь таслахын тулд, тус оны 10 сард Чингис хаан Мухулай ноёныг томилон Ляоси орныг дайлуулжээ. Ингээд Мухулайн удирдсан их цэрэг зүүнш довтолж, Гаочжоу (Хэбэй мужийн Пинчуань сянь), Чэнчжоу (Ляонин мужийн И сянь-аас хойно байжээ) зэрэг газрыг байлдан авав. Алтан улсын Чэнчжоу хотын сэргийлэгч жанжин Чжан Цзин гэгч түүний захирагч түшмэлээ алж, биеэ Линь-хай ван гэж өргөмжлөөд, Монголд буун өгчээ. 12 сард нь, Мухулайн удирдсан монгол цэрэг У чжоу (Ляонин мужийн Хэй Шан сянь)-г эзлэн авав. Энэ үед (1215 оны хавар) Алтан улсын цэрэг нь, Алтан улсаас урван Монголд орж өгсөн Хятаны жанжин Елюй Люгэ лүгээ байлдаж байв. Алтан улсын цэрэг нь Хятан улсын цэрэг болон монгол цэргийн шахалт дунд туйлбартай ялагдаж, монгол цэрэг Ляоси-гийн газрыг бүрмөсөн эрхшээж авсан байна.

1215 оны хаврын тэргүүн сард, Алтан улсын баруун мөрийн дэд юаньшуай Пуча Чигин гэгч Тунчжоу (Бээжин хотын Тун сянь)-д монгол цэрэгт бууж өгсөн тул монгол цэрэг Чжунду хотоос өмнүүрх айл тосгоныг бүр эзлэв. Үүний хамт, Мухулай ноён цэрэг томилж, Алтан улсын хойд нийслэл (хуучны Данин хот, одоогийн Хэбэй мужийн Пинчуань сянь)-ийг довтолсонд тэндэхийн сахиул цэрэг нь зэвсэг хөдөлгөсөнгүйгээр монгол цэрэгт буун өгчээ.



Зураг – 72. Чингис хаан гуравдугаар удаа Чжунду хотыг дайлсан зураг

Алтан улсын Чжунду хотын байдал улам түгшүүртэй болсон тул, өмнө нийслэл Бяньлянд

бүхий Алтан хаандаа бачим мэдээ хүргэжээ. Тиймээс тус оны 3 сард (“Алтан улсын түүх”-д 2 сар гэжээ. Энэ нь цэрэг томилсон цагаар тэмдэглэсэн мэт) Алтан хаан нь төрийн түшмэл Ли Ин-гээр амуу будаа хүргүүлж Чжунду хотыг туслуулахаар томилсон бөгөөд баруун мөрийн цэргийн захирагч юаньшуай Ваньгинь Юнси болон зүүн мөрийн нийтлэн захирагч Үгүлүн Циншоу-гаар хоёр түм есөн мянган цэрэг захируулж, хоёр зам хуваан Ли Ин-г хамгаалан умарш амуу будаа хүргүүлжээ. Тэд хүн бүр гурван дүү амуу үүрч явж байлаа гэдэг билээ. Энэхүү чимээг нь Чингис хаан сонсч, баруун гарын дэд юаньшуай Шэнь Са-гаар дөрвөн зуун морьт цэрэг, Шимо мянганаар таван зуун морьт цэрэг тус тус захируулж урьд хожид томилон тосон байлдуулав. Монголын цэрэг Бачжоу-гийн орчим Ли Ин-гийн цэрэг лүгээ дайралджээ. Энэ үед Ли Ин архи ууж согтуу байсан бөгөөд цэрэг нь сахилгагүй байсан тул Монголын цэрэг хүрмэгц бүх цэргийг нь бут цохиж, Ли Ин-г амьдаар барьж аваад мянган тэрэг амуу будааг нь олзолжээ. Бас Ваньгинь Юнси, Үгүлүн Циншоу нарын цэргийг нь Чжочжоу-гийн ар дахи Сюань Фэн Цзай гэдэг газар устгасан байна. Энэ мэт Алтан улсын хоёр замын туслах цэргийн элчид туслаж чадсангүй олон Чжунду хотын газар тусламж бүрмөсөн тасарч ганцаардав. 4 сард нь, монгол цэрэг Гу Ань зэрэг хот балгасыг эзлэн авсан бөгөөд энэ үед Чжунду хотын амуу хүнс бүрмөсөн хоосорч, “үлдсэн цэрэг нь өлбөрч үхэцгээсэн ба өөр зуураа алалцаж, хүний махыг идэлцжээ” (“Нууц товчоон”-ы 251 дүгээр зүйл). Энэхүү туйлын түгшүүртэй байдал доор, Чжунду-гийн ерөнхий захирагч баруун мөрийн түшмэл Ваньгинь Чэнхуй хор идэн үхэж, нийтлэн захирагч юаньшуай Моняньцзиньчжун-г хотоо орхиод өмнөш дугаажээ. Шимо мянганы жолоодсон монгол цэрэг Чжунду хотод орж бүх хотыг эзлэн авсан бөгөөд ордон харшийг нь галдаж, ихээр алж талхисан хэрэг юм. Ингээд олон удаа бүслэгдэж довглогдсон Алтан улсын нийслэл Чжунду хот эцэстээ Хаант Монгол Улсын цэрэгт эзлэгдсэн байна. Шимо мянган нар тэр даруй элч томилж Чингис хаанд ялалтын мэдээ хүргэв.

Чингис хаан энэ үед Лянцзин (Хуаньчжоу-гийн харьяан дахи Үхэр чулуун амнаас гадна буй) гэдэг газар бууж байв. “Чингис хаан, Чжунду балгасны алтан, мөнгөн, эд агуурс, юмыг тоолуулахаар Өнгүр буурч, Архай Хасар, Шигихутуху гурвыг илгээв. Энэ гурвыг очиход Хада ноён угтаж, алттай, хээтэй эд агуурсыг барьж хот дотроос харьж уулзав. Хада-д Шигихутуху өгүүлрүүн: Урьд энэ Чжунду хот ба Чжундугийн эд юм алт хааныхи байв. Одоо Чжунду Чингис хааныхи болов. Чингис хааны эд агуурсыг нь чи яагаад далдуур хулгайлан авчирч өгч байна? Үүнийг би авахгүй гэж Шигихутуху эс авав (“Нууц товчоон”-ы 252 дугаар зүйл). Энэ удаагийн байлдааны дараа, Чингис хаан Хятаны бичгийн хүн Елюй Чусай-г Чжунду хотоос элсэн хэрэглэжээ. Энэ нь Монголын төрийн байгуулалтад чухал үйлдлийг үзүүлсэн юм. Чингис хаан Чжунду хотыг гуравдугаар удаа дайлсан дайлалдаан ч ингээд дууссан билээ.

1215 оны 6 сард, Чингис хаан мөн Загасан нуурт зогсож, цэргээ гурав хуваан, Салжигудын Самуха баатараар баруун замын монгол цэргийг захируулж Гуаньчжун өөд, Хонхотаны Толун чэрби-гээр дунд замын монгол, хятан цэргийг захируулж Чжэньдин өөд, Ши-тянь-нин-д дэд юаньшуай цол өгч, барс толгойт алтан пайз шагнан зүүн замын хятад цэргийг захируулан Пинчжоу өөд томилж, Алтан улсыг залгалдаагаар дайлав. Тус оны намар нь Чингис хаан Хэрлэнгийн их ордондоо буцав. Энэ удаагийн буцсан шалтгаан нь, нэгд Чжунду хотыг эзэлж гол харалтаа биелүүлсэн бөгөөд Алтан улсын хүчийг хохируулжээ;

Хоёрт, ар талд нь гарсан урвалгааныг дарангуйлах (бодтой учрыг зургадугаар бүлэгт лавлаарай)-ын төлөө юм. Үүнээс хойш Чингис хаан дахиж Алтан улсын гол фронтод биеэр

хүрсэнгүй. 1217 оны 8 сард Мухулай ноёд Гован цол ба мужийн нийтлэн захирагч тайш зэрэг өргөмжлөн, алтан тамга, есөн хөхөлт цагаан туг шагнаж, Онгудын Жинхүйн түмэн морьт цэрэг, Горлосын Сэчэгүрийн мянган морьт цэрэг, Уругудын Гэтэйн дөрвөн мянган морьт цэрэг, мянгатын Мөнх, Халжа-гийн мянган морьт цэрэг, Хонгирадын Алчи ноёны гурван мянган морьт цэрэг, Ихирэсийн Буту хүргэний мянган морьт цэрэг, Жалайрын Дайсун Жүн вангийн хоёр мянган морьт цэрэг, Салжигудын Үерээр захируулсан умард нийслэлийн Жүрчин, Хятан, Хятад цэрэг, Елюй Тохуа-гийн захирсан уулын арын хятад цэрэг болон Жаларын захирсан Хятан цэргийг Мухулайгаар ерөнхийлүүлэн дайчлуулж, Алтан улсыг цаашид дайлах үүргийг хариуцуулжээ.

55. Хятан ба түүнийг оруулан авсан нь

Хятан үндэстнийг түнгүс гарлын үндэстэн гэдэг юм. Тэр нь умар Вэй улсаас нааш одоогийн Шар мөрөний дээд урсгал хавиар нүүдэллэн нутаглаж байжээ. Тан улсын сүүлчийн үед Хятаны нэгэн аймгийн ахлагч Абаожи гэгч Хятаны эл аймгуудыг нэгтгэж, нийтийн он тооллын 916 онд Ляо улс гэсэн феодалын хаант төрийг байгуулж, таван төр ба умард Сүн улс лугаа зэрэгцэн оршиж байв. Ляо улс нь мандан бадарч бүхий үедээ мал аж ахуй, тариалан аж ахуй ба гар үйлдвэр нэлээд хөгжиж, өөрөө үсэг бичигтэй үндэстэн байсан билээ (зураг 73-ыг лавлаарай). Одоо цөөн бус судалгааны дүнд Хятаныг монгол хэлтэн үндэстэн бололтой гэж үзэцгээж байна.

Хятан үндэстний байгуулсан Ляо улс нь 1125 онд Алтан улсад мөхөөгдөж, эх нутаг ба олон харьяат иргэд нь цөм Алтан улсад харьяалагджээ. Гагцхүү Хятан хааны угсааны Елюй Даши гэгч баруунш нүүж Хар Хятан (баруун Ляо) улсыг байгуулсан билээ (бодтой учрыг тус товчооны зургадугаар бүлэгт лавлаарай).

Жүрчиний язгууртны байгуулагдсан Алтан улс нь Ляо улсыг мөхөөсний хойно, нэг талаар Хятаны язгууртадыг нь ашиглаж төрдөө үйлчлүүлж байсны хамт, нөгөө талаар Хятан үндэстний ард түмэнд хүнд сүрхий үндэстний дарлалыг учруулжээ. Ингээд Хятан үндэстэн ба Жүрчин үндэстний хоорондохи үндэстний зөрчил, Хятаны ард түмэн ба Жүрчин, Хятаны язгууртны хоорондхи ангийн зөрчил ерөөс шийдвэрлэгдсэнгүй бөгөөд өдрөөс өдөр хурцдаж байсан юм. Ялангуяа Алтан улсын сүүлчийн үед феодал язгууртны ноёрхол нь улам тэрслүүжихийг дагалдан, энэхүү зөрчил нь улам ширүүсч, Хятан хүмүүс (үүнд зарим язгууртан ч багтаж буй)-ээс Алтан улсын ноёрхлыг эсэргүүцсэн босолго урвалга тасраагүй гарч байсан юм.

Энэхүү улс төрийн байдал нь, Чингис хааны Алтан улсыг дайлахад нь ашигтай нөхцөлийг бусдач талаас бүрэлдүүлж өгсөн бөгөөд Чингис хаан ч Алтан улсын өрцөөс нь дэлбэрсэн энэхүү хүчийг гарамгайгаар ашиглажээ.

Алтан улсын Чжанцзун хаан (1191 он)-аас нааш, Ляодун-гийн газрыг Алтан улсын Ай ван эцэг хөвгүүнээрээ эзэлж байсан бөгөөд жилдээ цэрэг морь, дайн дажинаар давжаарч байв. Хятан хааны угсааны Елюй Люгэ гэгч нэгэн язгууртан Алтан улсад алба хааж, умард хилийн мянганы ноён сууж байв. Сүүлд нь Чингис хаан умардад цэрэг байгуулж, улс үндэстнээ нэгтгэж байх үед, Хятан хүмүүс сэтгэл урвах болуузай гэж Алтан улсын ноёрхогчид сэжиглэж байсан бөгөөд нэгэн Хятан өрхийг хоёр Жүрчин өрхөөр сахин суулгах зарлиг буулгажээ. Ийм

байдал доор, Алтан улсын төрд үйлчилж байсан Елюй Люгэ хүртэл дургүйцэн эсэргүүцсэн байна. Тэр 1211 оноос эхлэн, Лунань (Гирин мужийн Нунань сянь), Ханьжоу (Ляонин мужийн Чанту сянь-ий ба Мянчэн орчим) зэрэг газар цэрэг морь элсэж, ойр орчмын газраа булаан талхиж байсан тул Алтан улсаас цэргээр дайлсан боловч бүр ялагджээ. Хэдхэн сарын дотор, Люгэ нар арваад түмэн хүнийг цуглуулж, байр хуаран зуу гаруй газар залгалдаж, 1212 оны хаврын тэргүүн сард Лунань-д их чуулган хийж, Елюй Ахай өөрийн биедээ нийтлэн захирагч юаньшуай цол өргөмжлөөд Ляодун-гийн газарт их түргээн болж байсан бөгөөд Чингис хаанд дагаар элч томилжээ. 1211 оны сүүлчээр буюу 1212 оны хавар, урьд Чингис хааны томилсон Алчи ноёны цэрэг Ляодун-д Елюй Люгэ-тэй хамтаар Алтан улсыг эсэргүүцжээ. Алчи ноён Цзиньшан уулнаа (Мүгдэнгээс хойш дөч, тавин уналга газар байдаг гэлээ) Люгэ-тэй учирч, саарал морь, цагаан үхэр алан умарш хандаж сум хугалан тангараг хийсэн гэдэг билээ.

Хятан нар Ляодун-гийн газар Алтан улсыг эсэргүүцэн, Монголд дагаж өгсөн явдал нь Алтан улст авч хэлбэл амин чухал цохилт болсон юм. Тийнхүү Алтан хаан Си-ань-ий тохинуулагч түшмэл Ваньгинь Хуша-гаар жаран түм (энэ тоо бол “Юань улсын түүх, Люгэ-гийн намтар”-ын тэмдэглэл болно. Үүнийг шал дэмий гэж Ли Цзэ Фэнь тэмдэглэжээ) цэрэг захируулж, Елюй Люгэ-г дайлаар томилсон бөгөөд Люгэ-гийн толгойг хүргэн ирэгсдэд хүнд шагнал өгөх зар тараасан байв. Энэ үед Люгэ Монголоос тусламж гуйсанд Чингис хаан гурван мянган шилдэг морьт цэрэг томилж, Люгэ-г хавсран Ваньгинь Хуша-гийн цэргийг сөнөөж, олз ашиг, ачаа хөсгийг нь Монголын хаанд өргөв гэдэг билээ.

1213 оны хаврын тэргүүн сард, Чингис хаан Алтан улсын зүүн нийслэл Ляо Ян37-ыг эзлүүлэхээр зүүн гарын өрлөг жанжин Зэвийг томилжээ. Зэв ноён тэнд очоод, хот балгас нь бэхлэг болохоор хэдэн өдрийн газар ухран явж, Алтан улсын цэргийн сэрэмжийг нь алдуулсан бөгөөд хүнд ачаа хөсгөө хол орхиж, дахин сайн морьтныг сонгон бушуу түргэн дайрч, хотыг нь уран аргаар эзлэн авсан байна. Ингээд Хятаны эх газар ч бараг Люгэ-гийн эрхшээлд оров. 3 сард нь Люгэ биеэрээ Ляо ван өргөмжилж (“Д`Оссоны Монголын түүх”-д Чингис хаанаас өргөмжлөв гэж тэмдэглэжээ), оны нэрээ Юаньтун гэж нэрлээд, Гуаннинд нийслэжээ.

1214 оны хавар Алтан хаан элч томилж, Люгэ-г бууж өг гэсэнд Люгэ хүлээсэнгүй гэлээ. Ингээд шинээн томилсон Алтан улсын Ляодун-ы тохинуулагч зарлигийн элч Пусянь Ваньну-гаар38 дөчин түмэн цэрэг дайчлуулж, Елюй Люгэ-г дайлуулжээ. Энэ удаагийн байлдаан нь Гуй Жэнь (одоогийн Кай Юань сянь) гэгч газар ширүүн явагдаж, Ваньну-гийн цэрэг ихээр дийлэгдсэн бөгөөд Люгэ Ляодун-гийн газрыг эрхшээн авч Сянь Пин Фу (Ляонин мужийн Тялин-гээс хойш байжээ)-д нийслэжээ. Ваньну дийлэгдсэн цэргээ авч Алтан улсын зүүн нийслэл Ляо Ян хотыг эзлэн авчээ.

Ваньну энэ удаагийн дийлэгдсэн ялаасаа айн, Алтан улсаас урваж, өөртөө Тянь ван цол өргөмжилж, “улс”-ын нэрээ “Да Чжэнь” гэж, оны нэрээ “Тяньтай” гэж нэрлэжээ.

Ваньну Алтан улсаас урваж өөртөө “улс” байгуулсан явдлыг “Алтан улсын түүх”-д 1215 оны 10 сараар тэмдэглэж буй. Энэ нь Бяньлянд мэдээ хүргэсэн цагаар тэмдэглэсэн бололтой. Ту Ци авгай 1215 оны цагаан сараар тэмдэглэсэн нь нэлээд зүйтэй мэт.

Энэхүү “Да Чжэнь” гэдэг нэр бол “Их Жүрчин” гэсэн утгатай гэж олонхи түүхчид үздэг байна. Учир нь “Жүрчин”-ийг хятадаар “Нюй Чжэнь” гэдэг. Энэ үг товчлогдоод “Да Чжэнь” болжээ. Ваньну энэхүү түр цагийн төрөө байгуулж, их төлөв Жүрчин үндэстний их газрыг дахин эзлэн авсан байна. Дараа нь удсангүй “улс”-ын нэрээ “Зүүн Ся улс” гэж өөрчилжээ. Гэвч Ваньну-гийн энэхүү “төр” нь 1215-1223 оны хооронд түр зуур тогтносон болохоор эл түүх шастирт түүнийг жинхэнэ төрөөр тооцдоггүй. Ялангуяа Солонгосын түүхэнд зөвхөн “Зүүн Жүрчин” гэж тэмдэглэдэг гэлээ. Сүүлчийн үед Накамичиё авгай “Зүүн Ся” гэдэг бол “Зүүн Жүрчин” гэснийг ташаарал гэж үзэж байжээ. Энэ нь Дундад улсын түүхэн тэмдэглэлтэй таарахгүй юм.

Гэвч дэмий удсангүй Елюй Люгэ-гийн цэрэг гэдрэг довлолт хийж, Мухулайн удирдсан монгол цэрэгтэй хавсран Пусянь Ваньну-гийн цэргийг сөнөөж, Ляодун-гийн эл чжоу, чжунь-ийг дахин эзлэн аваад, Ся Фин Фу-гаар төв болгон, Чжунцзун гэгч цолыг өргөмжиллөө гэдэг билээ. Дахин Алтан улсын зүүн мөрийн юаньшуай Елюй Ду-гийн цэргийг сөнөөж, Алтан улсын зүүн нийслэлийг нь эзлэн авчээ. Энэ үед түүнийг “Дорнодын хаан” өргөмжилсүгэй гэж Хятаны олон түмэн нь дурдсан боловч Люгэ өөрөө зөвшөөрсөнгүй бөгөөд хөвгүүнээ дагуулж Чингис хаанд бараалхахаар очжээ. Тэр очихдоо алтан зоос ерэн тэрэг тээж, Алтан улсын зүүн нийслэлээс хөдөлж, Хэрлэн мөрний Алтан ботухан гэсэн газар Чингис хаантай бараадаж, дахин буцсангүй гэдэг билээ. Ингээд Хятаны эх газрыг нь түүний харьяат нь эзэлж байсан бөгөөд таван жилийн дотор дөрвөн эзэн солилоо гэдэг юм. Дараа нь Чингис хаан Люгэ-гийн хөвгүүн нь захдаа барьцаа үлдээж, Люгэ-гийн цэрэг захируулан томилж Хятаны эх газрыг төвшитгөжээ. Гэвч Хуньгунцзян мөрнөөс 39 өмнөх Пусянь Ваньну эзэлж, Люгэ зөвхөн мөрний умардахи орныг эзэлж байв.

Чингис хаан биеэрээ Алтан улсыг дайлах үед Хятаныг оруулж авсан байдал их төлөв ийм байна.

1220 онд Елюй Люгэ үхсэн билээ. Тэр үед түүний хатан Ёли овогт Чингис хаанд бараалхахаар Монголын төрд очсон байна. Гэтэл энэ үед Чингис хаан баруунш дайлахаар яваад байсан тул хааны дүү Отчигин ноён төрийн хэргийг орлон захирч байжээ. Ингээд Ёли хатнаар Хятаны хэргийг захируулж долоон жил болов. 1226 онд Ёли хатан гурван хөвгүүнээ дагуулж, Тангудын Алчур хот (“Нууц товчоон” дахи Эрижэү, Ганьсу мужийн У Вэй хот)-д Чингис хаанд бараалхжээ. Энэ үед Чингис хаан тавдугаар удаа – хамгийн сүүлчийн удаа Тангудыг дайлж байсан юм. Хаан Ёли хатантай уулзаад: “Элээ шувуу эргэж нисээд хүрэхгүй газар, эхнэр та яахин хүрч ирэв?” гэж хэлсэн бөгөөд архи шагнаж, дотноор тохинуулсан гэнэ. Ингээд Ёли хатан ирсэн учраа Чингис хаанд: “Люгэ бие бараад хэдэн жил болж, ард иргэд эзэнгүй бөгөөд ахмад хөвгүүн Саду хааны бараанд бас хэдэн жил боллоо, одоо дуртайяа хоёрдугаар хөвгүүн Шангаа-г хааны босгонд бараа болгож, ахмад хөвгүүнийг буцааж эцгийнх орыг залгамжлуулах болов уу!” гэж айлтгажээ. Энэ үед Чингис хаан, баруун орны байлдаанд, Саду-гийн гаргасан гавьяа зүтгэлийг нь магтаж сайшаасан бөгөөд одоо Саду нэгэнтээ монгол хүн болчихсон тул буцаан явуулахуйд зохихгүй гэжээ. Гэтэл Ёли хатан бас сөгдөн уйлж: “Саду бол Люгэ-гийн авааль гэргийгээс төрсөн эзмэд (эз суух – хө.) хөвгүүн нь болох тул түүнээр Люгэ-гийн орыг залгамжлуулах нь зүйтэй, харин Шангаа бол доорд надаас төрсөн хөвгүүн юм, хэрвээ түүнээр залгамжлуулбаас, хувь биеийг өргөж тэнгэрийн ёсыг эвдэх болмуй. Доорд миний бие чингэж болохгүй” гэж айлтгав. Хаан сонсч, түүний журамт сэтгэлийг нь

биширч, Саду-гаар Люгэ-гийн орыг ширах (siraqu - залгамжлах - хө.)-ыг зөвшөөрсөн бөгөөд хоёр бага хөвгүүнийг нь үлдээж, Саду-г Ёли хатны хамт буцаасан байна. Тэднийг буцахад Хашин орноос олзолсон хүн ес, агт морь ес, цагаан алт есөн дөрвөлж жич бус эдлэл хэрэгслийг ес есийн тоогоор бэлэглэсний дараа: Урьд хаан миний бие Жүрчидэд цэрэглэж бүхийд, чиний эцэг цэргээ авч Ляодун-гийн газраас хаан миний цэрэг лүгээ нийлсэн бөгөөд үнэнчээр үйлчилсэн нь үнэхээр эрхэм дээд болой. Гэтэл Жалайр хүмүүс урван тэрсэлж, ард иргэд чинь сарнин бутарч, өдгөө бас таныг занан хорсогчид хэрхэн эс байх аж? Хаан би эцгийг чинь ах дүү мэт үзэж байсан тул чи болбоос миний хөвгүүн лүгээ адил бөлгөө, өдгөө чиний эцэг нэгэнтээ өнгөрсөн тул, чи миний дүү Бэлгүтэй лүгээ хамт цэрэг захирч, гутгаар мянга болтугай (Чжан Чжэнь Пэй: “Чингис хааны шүүмжлэл шастир”) гэж Саду-д зарлиг болжээ. Ингээд Саду-гийн үр ач ч Ляодун-гийн газрыг эзэлж үеийн үеээрээ Юань улсын төрийн зүтгэлтэн болж байсан юм.

Сүүлдээ Хятан үндэстэн бүр хайлагдсан байна. Энэ тухай зарим тэмдэглэл (“Үгсийн далай”, 1979 оны хэвлэл)-д “Хятаны нутагт хятад хүмүүсийг бүлэг бүлгээр олон нүүлгэн очуулсан тул хятад хүний давшсан аж ахуй, утга соёлын нөлөөнөөр Хятаны тариалан, гар үйлдвэр нь нийтэмдээ дээшилжээ. ... Хятан хүний олонхи нь хятад, монгол, жүрчин хүмүүст хайлагджээ” гэж тэмдэглэж байна.

56. Гуули улс ба Хаант Монгол Улсын харьцаа

Одоогийн Солонгос улсыг түүхэнд Гуули улс гэж тэмдэглэж байсан юм. Ван Цзянь гэгчийн байгуулсан эртний Гуули улс нь 918 оноос 1392 он болтол оршиж байжээ. Монголчууд Өгөөдэй хааны үед “Солонгос” гэж нэрлэж байсан тэмдэглэл буй. Харин арван наймдугаар зууны үеийн зарим монгол түүх бичигт: (Чингис хаан) гучин нэгэн насандаа Солонгосын Буха Цагаан хааныг гурван жил аялж оруулж авав (“Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж оршив”, Зөвлөлт улсын Шастина-гийн хэвлүүлсэн 1957 оны Москва-Ленинградын хэвлэл, 22-23 нүүр) гэдэг. Бас “Аргасун хуурчийн домог” гэдэгт “Чингис хаан Солонгосын Хулан саран гүнжийг хатан болгож аваад тэнд гурван жил түдэж суусан...” гэдэг тэмдэглэл ч байдаг. Эдгээр нь бүр түүхийн баримтгүй тэмдэглэл юм. Хулан хатан бол Увас Мэргидийн ноён Дайр усуны охин болохыг “Нууц товчоон” зэрэг тулгар бичигт баттай тэмдэглэж байдаг. Түүнийг Саган сэцэн “Солонгос Мэргидийн Дайр усун” гэж тэмдэглэжээ. Энэ “Солонгос бол одоогийн Солонгос улс биш, солон баргын Солонгос мөн” гэж Ц.Дамдинсүрэн авгай ч тэмдэглэсэн юм. Энэ нь бүр зүйтэй юм. Чингис хаан Солонгост биеэрээ дайлсангүй нь лавтай юм.

Чингэвэл Монгол Солонгосын харьцаа хэдийнээс эхлэв гэвэл, Чингис хааны үеэс эхэлжээ. Уул нь Гуули улсаас Алтан улсад жил бүр өргөл барьдаг харьцаатай байсан бөгөөд Хятан, Жүрчин үндэстэнтэй зах зэрэглэн сууж байжээ. Чингис хаан 1211 оноос 1217 он болтол Алтан улсыг биеэр дайлж, Ляодун-гийн газрыг эзлэн авсан хойно, нэгэн бүлэг Хятаны үлдэгдэл Цзиньшань түрүүтэй есөн түмэн хүн Ялу мөрнийг гэтэлж, Гуули улсад дутаан орсон бөгөөд 1217 онд Гуули улсын Цзянтун хотыг эзлэн суужээ. Ингээд Цзиньшань биеэ Ляодун-гийн ван өргөмжилж, дотор зуураа хувьсал гарган, Тунгу гэгч Цзиньшань-ийг алж, бас Ханьша гэгч Тунгу-г алжээ. Энэ мэт Гуули орныг түйвээж байхад, 1218 оны 12 сард Чингис хаан Хажин (“Нууц товчоон”-д дурдагддаг Жалайрын Хачигун Тухурагуд бараг энэ

хүн бололтой гэж Ту Цзи тэмдэглэжээ)-аар манлайлуулж, Жалайрдай Хорчи-гоор дэдлүүлж монгол цэргийг захируулан, Люгэ-гийн Хятан цэрэг, зүүн Ся улсын юаньшуай Ваньгинь Цзыюань-ий Жүрчин цэрэг нийт арван түмэн хүнийг томилж, Хятаны оргодлыг дайлуулжээ. Монголын их цэрэг тэнд хүрээд Гуули улсын жанжин Чжао Чун гэгчтэй хамтран байлдав. 1219 оны хавар Ханьша биеэ хорлож, Хятаны оргодол цөм дарагджээ. Ингээд Хажинь их цэрэг ч Гуули улсын нутаг дэвсгэрээс бүр ухран буцав. Тэр үед Гуули улсын эзэн Ван Чэ гэгч монгол цэрэгт ихэд талархан, үхэр ба архи хүргэж тохинуулсан бөгөөд Гуули улсын Шу-ми түшмэл (Батлан хамгаалах сайд) Чжао Чун болон монгол цэргийн дэд захирагч Жалайрдай лугаа журмын ах дүү бололцож, Гуули улс нь монгол улсад жил бүр өргөл барихаар тогтжээ.

Монгол ба Гуули улсын харьцаа бол ингэж эхэлсэн бөгөөд Чингис хааны үе дэх байдал ч их төлөв ийм байна.

Багцлаад хэлбэл, Чингис хааны өмнөш дайлсан гол харалт бол өвөг дээдсийн өстөн Алтан улс болох юм. Тэр гол дайснаа сөнөөхийн тулд түүний жигүүрийн халхавч Тангуд улсыг урьдаар хэдэнтэй дайж, Хятан үндэстэн ба Алтан улсын хоорондохи үндэстний зөрчлийг ашиглаж, Хятаныг татан аваад Алтан улсын туслах хүчийг нь бүрмөсөн тасалжээ. Чингис хааны биеэрээ удирдсан Монголын их цэрэг нь 1211 оноос 1217 болтол Алтан улсад хүнд цохилт өгч, амьд хүчийг нь ноцтой хохируулсан бөгөөд түүнийг Хятан голоос өмнөших цухалхан газарт шахан оруулж, өмнөд Сүн улсын хамт байлдах бодлогын бүслэлтийн үүргийг гүйцэтгэжээ. Ингээд Алтан улсыг дайлах дараачийн үүргийг Го ван Мухулай ноёноор хариуцуулсан юм.

Дагалдвар

1 “Нууц товчоон”-д Тангуд улсын эзнийг “Хашин хаан”, “Бурхан”, “Илаху бурхан”, “Шударга хаан” мэтээр нэрлэдэг билээ. Энэхүү “Хашин хаан” гэсэн нь яриангүй “Хэси-гийн хаан” гэсэн үг болно. “Бурхан” гэдэг бол Тангудчууд “Улсын эзэн”-ээ хүндэтгэн өргөмжилсөн дуудлага гэдэг билээ. Энэ бол Буддын шашныг шүтэгчдийн дээд цол нь болох юм. “Илаху” гэдгийн чухам ирэл, утгынхи нь талаар хангамжтай мэдээгүй байсаар. “Шударга” гэсэн нэр бол Тангудын эцсийн нэгэн эзэн Ли Сянь нөхцөлгүйгээр бууж өгсөн учраас Чингис хаан түүнд “шударга” гэсэн цол өгсөн нь тодорхой тэмдэглэлтэй юм.

2 Чингис хаан энэ удаа Тангуд улсыг дайлсан шууд шалтгааны тухай эл түүх шастирт ер тодорхой мэдээ байдаггүй, “Өшөөтөн Нилха Сэнгүмийг далдлав” гэсэн бодот дурдлага бол Ту Цзи авгайн тайлбар болно (түүний ирлийг “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-ийн шинэ хэвлэлийн 1 дүгээр ботийн 23 нүүрт үз). Нилха Сэнгүм Тангудын Чал хотоор дайрч гарсан цаг бол 1203 он буюу 1204 оны явдал болно. Чингис хааны хорин нэгэн (1226 он) он болоход, учир явдал нэгэнтээ өнгөрөөд хорин хоёр, гурван жил болсон бөгөөд Чингис хаан үүнээс өмнө Тангудыг дөрвөн удаа дайлаад энэ учрыг дурдсангүй, хорин хэдэн жил болоод сая дурдах гэдэг бол сэтгэгдэшгүй хэрэг юм. Дахиад, Чингис хаан 1226 онд хамаг эцэс Тангудыг дайлсан шууд шалтгаан бол, баруун орныг дайлахад цэрэг элсээд өгсөнгүй ба Аша Гомбу-гаас доромжлогдсон хариуг авсан явдал болно. Тиймээс “Юань улсын түүх”-ийн энэ нэгэн тэмдэглэл нь нэгдүгээр удаа Тангудыг дайлсан шалтгааны цагийг нь эндүүрэн тэмдэглэсэн нь илт байна.

3 Урахай хотын эртний ор нь одоохи Өвөр Монголын Алшаа баруун хошуунаас баруун өмнөх Луншоушань уул (Ту Цзи авгай Лунгушань уул, монгол нэр нь Алаг уул гэдэг гэжээ) болон Ганьсу мужийн Шаньдань сянь-ий заагт байдаг гэлээ. “Юань улсын түүх, газар зүйн тэмдэглэл”-д “Урахай Лу” гэж тэмдэглэжээ.

4 Чингис хаан Тангудыг гуравдугаар удаа дайлсан цагийг “Юань улсын түүх”, “Д’Оссоны Монголын түүх” зэргийг баримталж 1209 оноор тэмдэглэв. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д 1210 оноор тэмдэглэж байна. Энэ тухай Ван Го Вэй авгай доорхи тайлбарыг хийжээ: “...энэ явдлын цагийг Рашид-ад-Диний номд могой жил (1209 он - эшлэгч)-ээр тэмдэглэж буй. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т шарагчин могой жил гэдэг бөгөөд “Газар зүйн тэмдэглэл”-д Тайцзу-гийн дөрөвдүгээр онд Урахай хотыг эзлэв гэж тэмдэглэж буй, эдгээр нь бүр Рашидын тэмдэглэлтэй нийцэж байна. Харин тус тэмдэглэл (“Биеэр дайлсан тэмдэглэл” – эшлэгч)-гийн уг эх дэх шарагчин могой жилийн учрыг сүүлчийн хүмүүс орхигдуулж, цагаан морин жил (1210 он – эшлэгч)-ийн явдал болгон тэмдэглэсэнч магадгүй. Тиймээс “Юань улсын түүх” болон Рашидын номын тэмдэглэлээр залруулбал зохино. ...” гэжээ (“Монгол түүхийн материал дөрвөн зүйл”, 155-156 нүүр). Гэтэл Рашидын номын нэгдүгээр хувиар дэвтрийн гуравдугаар найруулал – аймаг угсааны тэмдэглэлд:

“Морин жилийн намар” (1220 он – эшлэгч) гэж тэмдэглэж байна. Тиймээс Ван Го Вэй авгай Рашидын номыг баримталлаа гэсэн нь юуг үндэслэснийг бүү мэд.

5 Гао Лин Гун гэдэг бол Тангуд улсын баруун мөрийн сайд Гао Хуй Лян гэгч болно. Тангудчууд Тан улсын түшмэдийн дүрмийг улируулан хэрэглэж байсан тул “чинсан”-аа Лин Гун гэж нэрлэдэг байна. Энэ тухай “Юань улсын түүх”-ийн 125 дугаар боть дахи “Гао Жи Йо-гийн намтар”-т лавлаарай.

6 Тайфу түшмэл гэдэг бол “Хааны тайцзи нарыг туслан сургагч түшмэл болно. Баруун Хань улсын үед тайцзи-гийн тайфу гэдэг билээ” (“Үгсийн далай”, багасгамал хэвлэл, 640 нүүр). “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” (14 нүүр)-т: “Тайфу Сиби овогтныг барив” гэж нэрийг нь дурдсангүй, дараа өгүүлбэрт нь “Тайфу А Да-г тавин Яргай хотод очуулж ...” гэж тэмдэглэж байх нь бүр нэг хүн болно. Энэ “Сиби овогтон” гэсэн нь “Сяньби үндэстэн”-ийг эндүү тэмдэглэсэн бололтой. Учир нь Тангудыг ер нь Сяньби-гийн үрс гэдэг юм.

7 Вэй Мин бол “Тангуд улсын хааны угсаатан” гэж Ту Цзи авгай тэмдэглэв. “Малгайн арын улаан бүчийг Вэй Мин гэдэг, сүүлдээ энэ нь овог болжээ” гэж “Ляо улсын түүх, Тангудын намтар”-ын тэмдэглэл нуталж байна. “Нууц товчоон”-д дурдагддаг Аша Гамбу болон “Юань улсын түүх” дэх Вэй Мин Лин-гун гэдэг нь нэг л хүнийг хоёр янзаар нэрлэсэн бололтой. Төвд хэлний гамбу (Sgam-po) гэдэг бол хятад хэлний лин-гун (монгол хэлний линху) мэт нэг зүйлийн зэрэг цол болно. Харин Аша гэдэг нь түүний нэр, Вэй Мин гэдэг нь овог нь болох магадгүй” гэж Паул Пеллио дурдаж байжээ. 1226 онд Чингис хаан Тангудыг хамаг эцэс дайлж, Түрэмгий балгасыг довлоход, Тангудаас Вэй Мин-гээр туслах цэрэг захируулж томилж байснаас үзэхүл, энэ хүнийг 1209 онд барьж аваад, эвслийн гэрээ тогтоосон учраас тавин явуулсан нь илэрхий байна.

8 Яргай хот бол Тангуд улсын нийслэл хот нь болно. Хатан голын баруун эргэд байжээ. Ляо улсын үед Син Цин Фу, Юань улсын үед Нинся Лу, Мин улсын үед Нинся Вэй, Чин улсын үед

Нинся Фу гэж тус тус нэрлэж байв. Одоогийн Нинсянгийн Хотон Үндэстний Өөртөө Засах Орны төв Иньчуань хот болно.

9 Чагаа-г “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн Ван Го Вэй-н тайлбарт “Чахус” (монгол хэвлэл, 115 нүүр) гэж ондоогоор тэмдэглэжээ. Чагаа гүнжийг “Юань улсын түүх, хатад татварын намтар” дахи гуравдугаар ордны Чар хатан мөн гэж Япон түүхч Накамичиё авгай үзжээ. Мураками Шёожи авгай харин Мэргидийн Тогтуга бэхи-гийн охин Чагурун бол Чар хатан мөн гэж, Дорнотив нөхөр бас тийм бололтой гэжээ. Гэтэл эдгээр тэмдэглэлд хангамжтай баримтгүйг тэмдэглэх хэрэгтэй.

10 Чжунду (дунд нийслэл) бол эртний байлдаант улсын үе дэхи Янь улсын нийслэл байсан болохоор тэр үедээ Яньцзин хот гэж байжээ. Алтан улсын эхний үед бас Яньцзин хот гэж нэрлэж байв. Дараа нь 1153 онд Алтан улс нийслэлээ Яньцзин хотод нүүлгэн ирж, одоогийн Бээжингийн баруун өмнө өнцөгт байсан Си Цзин Фу ордныг Чжунду-гийн Да Син Фу ордон гэж халснаас “Чжунду хот” гэдэг нэртэй болжээ. 1215 онд Монгол цэрэг эзэлж авсныхаа дараа бас Яньцзин хот гэж нэрлэж байсан юм. Сүүлд нь Чжи Юань-ий тэргүүн он (1264 он)-д бас Чжунду гэсэн нэрийг нь сэргээж, Чжи Юань-ий дөрөвдүгээр он (1267 он)-оос хуучин хотын зүүн хойд өнцөгт нь шинэ хот байгуулж, Чжи Юань-ий есдүгээр он (1272 он)-д Дайду хот (их нийслэл) гэж нэрлэн, Юань улс нь энд нийслэжээ. Зуугаад жилийн сүүлд (1368 он) Чжо Юань Чжан Юань улсын доройтмол ноёрхлыг түлхэн унагаж, Мин улсын төрийг байгуулж, умар дахиныг дарангуйлсан болохоор “Дайду хот”-ыг “Бэйпин” гэж нэрлэсэн бөгөөд Юнло хааны үеэс Мин улс бас энд нийслэжээ. Дараа нь манж үндэстэн өрнөж, Мин улсын төрийг мөхөөн, Чин улсын төрийг байгуулж, 1644 оноос “Бэйпин”-д нийслэж, “Бээжин” (энэ бол Монголын заншил бичлэг болно, чухамдаа “Умар нийслэл” Бээжин гэсэн үг юм) гэж халжээ. 1911 оны цагаагчин гахай жилийн хувьсгалаар мөн умар дахиныг төвшитгөсөн тул гоминьдан бас “Бэйпин” гэдэг нэрийг нь сэргээжээ. 1949 онд Бүгд Найрамдах Дундад Ард Улс байгуулагдаад, үндэстнийг доромжлогч нэрийг нь үгүйсгэж, “Бээжин” гэдэг нэрийг нь сэргээн ардын нийслэл болгосон байна.

11 Чингис хааны Алтан улсыг дайлсан цагийг “2 сар” гэсэн нь “Юань улсын түүх”-ийг баримтлав. Энэ тухай “цэрэг аялах цагийг цас хайлсны хойно сонгосон явдал бол энэ улиралд говийн элсэнд ус байдгаар барахгүй өвс бас байдаг юм” гэж Березиний тэмдэглэж байсан нь бараг энэ “2 сар” гэсэнтэй тохирох юм. Гэвч “Ту Цзи-гийн тэмдэглэл” ба “Д’Оссоны Монголын түүх”-д “3 сар” гэж, “Алтан улсын түүх”-д “4 сар” гэж тус тус адил бус тэмдэглэж буй. Энэ “4 сар” гэдэг нь монгол цэрэг Алтан улсын хилд хүрсэн цагаар тэмдэглэсэн бололтой. Бас “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “намар” гэж тэмдэглэж буй. Энэ нь бараг түрүү жилийнх нь намар Алтан улсыг дайлахаар тогтсон явдлыг цэрэг мордсоноор эндүү тэмдэглэсэн бололтой.

12 Чингис хаан Алтан улсад цэрэг мордохоос өмнө мөнх тэнгэрт даатган тангараг хийлээ гэдэг нь Д’Оссон нарын тэмдэглэл болно. Гол санаа нь зөрөөгүй боловч, бодтой агуулгын талаар сүүлчийн үеийн хүмүүс баахан зөрөөтэй тэмдэглэж байдаг. Жишээлбэл, тэр аян дайнд мордохосоо өмнө, ганцаараа нэгэн харш өрөөнд гурван хоног саатаж даатгалыг хийжээ. Үүний зэрэгцээгээр орчин тойронд нь байсан байлдагчид ба ард иргэд нь цөм “Тэнгэр өршөө! Тэнгэр өршөө!” гэж хашгиралдаж байв. Дөрөвдүгээр өдөр болоход нь тэр сая

харш өрөөнөөсөө гарч ирээд “мөнх тэнгэр” түүний ялалтыг ивээн соёрхов, бид одоо мордож, өшөөтөн Жүрчидийг залхаан шийтгэж болно гэж хэлсэн гэлээ. Энэ бол Б.Я.Владимирцовын тэмдэглэл болно. Бид энд үндсэндээ Цю Шо Сэнь болон Чжан Чжэнь Пэй авгайн тэмдэглэлийг баримтлав.

13 Энэхүү Цзинчжоу-гийн хот нь одоохи Өвөр Монголын Өөртөө Засах Орны Дөрвөд хошуунаас баруун хойно бүхий Цзий Шэн-тэй нэгдлийн харьяанд байжээ. Хуучин хот нь долоон газар шахам хэмжээтэй. “Алтан улсын түүх, газарзүйн тэмдэглэл”-д Цзинчжоу-гийн төвийг Тянь Шань сянь гэдэг. Энэ Тяньшань сянь бол Далан хар уулыг хэлж байна. Энэ нь урьддаа Алтан улс ба Монголын хилийн боомт байсан билээ.

14 Да Суй Луань нь монголоор “Их нуур” гэсэн утгатай үг болно. Ту Цзи авгайн тэмдэглэлийг үндэслэвэл энэ нь Чин улсын үед Шулуун Хөх хошууны нутаг болох бөгөөд нуурынхи нь баруун өмнө нь нэгэн хуучин хотын суурь буй гэдэг. Энэ байдал нь одоогийн Өвөр Монголын Тайпусэ хошууны өмнө зах дахи “Баян цагаан нуур”-тай маш төстэй юм. Түүний баруун өмнө нь нэгэн хуучин хотын дов болсон хэрмийн орыг машин тэргэн дээрээс тов тодорхой олж үздэг билээ. Гэтэл зарим материал (“Манай улсын умард оронд болж өнгөрсөн дайралдааны жишээ”)-д үүнийг “одоогийн Хэбэй мужийн Чжанбэй сянь-ий орчмын Ангал цагаан нуур” гэж тэмдэглэж байдаг.

15 Ушабуу цайзыг “Дайчин улсын нэгтгэсэн ойлговор” гэдэг бичигт “Шороон хот” гэдэг бөгөөд түүнийг хуучин Хөвөөт шар хошууны малжилын талбайгаас баруун хойш хорин газар, хуучин Синхэ хотоос хойш арван газарт буй гэжээ. Ян Жун-гийн бичсэн “Умарш дайлсан тэмдэглэл”-д “Шороон хот” гэдэг бол Юань улсын дундад нийслэл мөн, энэ газар адуу адуулахад хамгийн тохиромжтой. Түүнийг нутгийн ард “Цагаан балгас” гэдэг. Хотоо тойроод долоон газар, дөрвөн хаалгатай гэжээ. Энэ хот бол Уцзун хаан (Хайсан хүлэг хаан)-ы шастир дахи “Ван-у-ча-ду” хот бөгөөд “Ушабуу”-гийн хуучин суурь дээр барьсан бололтой гэж Ту Цзи авгай тэмдэглэжээ.

16 Го Бао Юй бол Хуачжоу газрын хүн, өргөсөн нэр Юй Цэн гэдэг. Тан улсын үеийн Фэнь Ян-гийн ван Го Ци И-гийн үр ач нь болно. Одон орны судлал болон цэргийн ухаанд нэвтэрсэн бөгөөд харвах, намнахдаа чадамгай билээ. Алтан улсын сүүлчийн үед Фэнь Ян Цзюнь (Шаньси мужын сянь-ий нэр)-ы Хун түшмэлээр өргөмжлөгджээ. 1211 онд монгол цэрэгт бууж өгсөн хойно, Мухулай ноён дагуулж Чингис хаан лугаа учирсан гэдэг билээ. Тугтам төрийг засахуйд шинэ хуулийг тогтоовол зохино гэж тэр дуртган айлтгасан бөгөөд таван зурвасыг тогтоосон гэлээ. Сүүлд нь Чингис хааныг дагалдан баруун орнуудын дайралдаанд оролцсон бөгөөд Хятаны үлдэгдлийг дайлж, Хятан, Бо Хай зэрэг орныг хураан нэгтгээд байлдаанд гавьяа зүтгэл байгуулжээ. Хожим нь их заргачийн түшмэлийг хариуцаж байв. Дараа нь Алшаа ууланд үхлээ гэдэг юм.

17 Хушаху-гийн жинхэнэ нэр нь Хишли Хушаху гэдэг. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Чжаотао түшмэл Хишли Жүгин” гэжээ. Энэ “Жүгин” гэдэг нь Хушаху-гийн хятад нэр “Чжи Чжун” гэсний авианы хувирал болно. “Чжаотао түшмэл” нь түр хариуцуулсан тушаал болно.

18 Цавчаал боомтыг хятадаар Цзюй Юн Гуань гэдэг. “Шар дэгтэр”-ийг Ту Цзи авгай “Лун Гу Дай” гэжээ. Цавчаал боомт бол өмнө амаас умар амаа хүртэл дөчин таван газрын хавцал

болох бөгөөд дундаа гурван боомттой, “Шар дэгтэр” бол төв дунд нь буй. “Нийслэлийн нэвтэрхий тэмдэглэл”-д “Шар дэгтэр”-ийг Чан Пинчжоу-гаас баруунш хорин газар зайтай байдаг гэжээ.

19 Энэ хэсгийг “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т Өвлийн 10 сард Алтан улсын адуун талбайг нь довтолж, адууг нь хөөн буцав. Елюй Ахай орж өгөөд, хаан лугаа аяны газар бараадав (“Юань улсын түүх”, нэгдүгээр боть) гэж тэмдэглэж байна. Энэ тэмдэглэлийг Ту Цзи авгай ташаа гэж үзсэн бөгөөд доорхи тайлбарыг хийжээ: Ахай Балжуна-ын тангараг хийхэд байлцсан тул түүний орж өгсөн цаг нь харагчин гахай жил (1203 он)-ээс өмнөх учир билээ. Тиймээс энэхүү цагагчин хонин жил (1211 он)-ийн 10 сард орж өгөв гэсэн нь буруу болжээ. Алтан улсын адуун талбай бол нэгэлхэн газар биш юм. Энэ удаагийн довтолсон талбай нь хаа байсан, тэр талбайн элч нь ямар хүн болох, хэн очиж довтолсон зэргийг “Юань улсын түүх”-д огт дурдсангүйгээр, харин залгаад Елюй Ахай орж өгөөд Чингис хаан лугаа аяны газар бараадвай гэж хэлснийг нь ойлгоход бэрх бөлгөө. Гэвч “Анькуйми-гийн намтар”-т: Анькуйми Онгуд овогтон, урьддаа Юньнэй-н боомтод сууж байсан бөгөөд эцэг нь Онгу Дангун гэдэг, Алтан улсын адуун сүргийн элч байжээ. Тэр цагагчин хонин жил (1211 он) адуулж байсан адуугаа хөөн ирж (Чингис хаан)-д даган өгчээ гэж тэмдэглэж байх бөгөөд “Елюй Тохуа-гийн намтар”-т: Их цэрэг Алтан улсын хилд орохуйд замчилсан бөгөөд адуу морийг арвин олжээ гэж тэмдэглэж байдаг. Шастир, намтрын эдгээр тэмдэглэлийг харьцуулан үзэхүл, “адун талбай” гэдэг нь “Юньнэй-н боомт дахи адуун талбай” болох бөгөөд түүний элч нь “Онгу Дангун” байжээ, адуу хөөн ирсэн нь Тохуа биш харин Ахай байжээ. Дангуний орж өгсөн нь Ахай-н элсэлтээр орсон байна. Шастирт “Ахай орж өглөө” гэсэн нь Ахай Дангуныг дагуулан ирж бараалхуулсан нь тодорхой байна. Ту Цзи авгайн энэ магадлалт нь нарийн тодорхой бөгөөд зүйтэй юм.

20 1212 оны хавар болсон “Үнэгэн давааны байлдаан” зэргийг “Д’Оссоны Монголын түүх”, “Ту Цзи-гийн тэмдэглэл” ба “Биеэр дайлсан тэмдэглэл”-д цөм 1211 оны намрын явдлаар тэмдэглэж байна. “Юань улсын түүх” ба “Манай улсын умард оронд болж өнгөрсөн дайралдааны жишээ” гэдэг товхимолд бүр 1212 оны хаврын явдлаар тэмдэглэж байна. Бид сүүлчийнхээр нь баримт болгов. Учир нь 1211 оны зун Чингис хаан Онгудад зусаж, намар нь сая Алтан улсын баруун нийслэл Датун өөд довтолжээ. Тэр үед Хушаху бол Алтан улсын баруун фронтын захирагч байсан бөгөөд тэнд дийлэгдэж, цөөн хүнтэй нийслэл Чжунду-даа дутаан харьсан билээ. Ингээд бас охорхон хугацаанд гучин түмэн цэргийг зохион байгуулж Үнэгэн даваанд хориглолт хийх бололцоо, тэр үеийн нөхцөл байдал доор байтугай, одоо үеийн машинчилсан нөхцөл байдал доор боловч хүчиртэй асуудал юм. Тиймээс энэ удаагийн байлдаан - Үнэгэн давааны байлдаан зэрэг олон байлдаан нь 1212 онд боллоо гэдэг нь зүйтэй юм.

21 Үнэгэн даваа-г хятадаар “Ва-гу Ши, Сан-чэнь, Ху-ша” гэдэг. Энэ нь тухайн үеийн Сюн Дэ Фу-гийн харьяат Ваньцюань сянь-аас баруун хойшивтор бүхий Дэ Шэн Ко гэж Ту Цзи авгай тэмдэглэж байсан (“Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн тайлбар 183 бас адил) бөгөөд Х.Пэрлээ “Чуулалт хаалгаас өрнө тийш гучны газар буй” гэжээ. Энэ нь яриангүй одоогийн Хэбэй мужийн Чуулалт хаалгын ар даваа - Ваньцюаньба даваа болно. Гэтэл зарим материалд “Бээжингийн баруун хойгуур байгаа ба Далин даваа” гэсэн нь арай таарахгүй юм.

22 Энд Ту Цзи авгай “Судрын чуулган”-ыг үндэслэж “Ба Гу Ши”, “Сан Чэнь” гэсэн хоёр нэрийг нөхвөрлөн тэмдэглэжээ. Гэтэл “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “зөвлөгч Хуша” гэдэг. “Сүн улсын түүхийн үүсэл дуусал”-ын 85 дугаар ботид мөн “Ху Ша”-гаас “Цзю Цзинь”-д сануулснаар тэмдэглэж буй. Ингээд би “Биеэр дайлсан тэмдэглэл”-ээр баримт болгов.

23 “Доругу-гийн хошуу”-г “Нууц товчоон”-д “Фучжоу-гийн хошуу” гэдэг юм. Энэ нь Фучжоу-гаас өмнө, Үнэгэн даваанаас ард буй (Хэбэй мужийн Чжанбэй сянь-аас баруунш буй - “Манай улсын умард оронд болж өнгөрсөн дайралдааны жишээ”) гэдэг билээ.

24 Шимо Мянган бол Алтан улсын Хуаньчжоу-гийн хүн. Чингис хаан энэ удаа Фучжоу-г эзэлсний дараа, тэр Монгол цэрэгт орж өгсөн бөгөөд олон удаагийн дайн байлдаанд гавьяа байгуулж, Монголд үйлчилж байсан хятад цэргийн нийтлэн захирагч юаньшуай болсон байна. Хожим нь Цзюнь Го гүн цолоор өргөмжлөгджээ.

25 “Нууц товчоон”-д дурддаг “Жүйн (цэрэг)” гэдэг бол “элс гэсэн утгатай” гэсэн үгийн хувирал болох бөгөөд Алтан улсын умард чжоу-гийн хятад цэргийг нэрлэсэн мэт гэж Ту Цзи авгай үзжээ. Рашид-ад-Диний номд “хятад” гэж, Хун Цзюнь “хятад цэрэг” гэж орчуулжээ.

26 Хуй Хэ Бао цайз бол Сюань Пин-гийн хуучин хот болно. Одоогийн Хэбэй мужийн Ваньцюань сянь-аас зүүн өмнөшивтэр арван дөрвөн газар зайтай байжээ. Үүнийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монгол хэвлэлд “Хуйху бэхлэлт” гэж орчуулсан байна. Гэвч бодтой ирлийг нь тодорхойлсонгүй болохоор, би хятад авиагаар галиглав.

27 Чингис хаан Алтан улсын баруун нийслэл Сицзин хотыг бүслэн байлдаж байгаад шархадсан явдлыг эл материалд баахан зөрөөнтэй тэмдэглэж байдаг. “Юань улсын түүх”, Сун Цзюнь Жун-гийн бичиг зэрэгт бүр баруун нийслэлийг бүсэлж ахуйд хотын доор шархадлаа гэдэг. Гэтэл Оросын хуурайн цэргийн дэслэгч генерал Иварин гэгчийн зохиосон “Тэмүжиний цэрэг хэрэглэх тухай” гэдэг товхимолд: “Хаан Дэ Син (Чжочжоу)-ийг довлохуйд зэрлэг суманд шархдаж, бүслэлтээс ухарч, Цагаан хэрэмийн гадна гарав” гэж адилгүй тэмдэглэжээ. Энэ нь найдваргүй тэмдэглэл гэж Ли Цзэ Фэнь үзжээ.

28 Бочэ гэдэг нэрийг “Биеэр дайлсан тэмдэглэл”-ээр баримт болгов. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т “Боша” гэж бичжээ. Рашид-ад-Диний номд “Бочэ” гэж бичээд “Гэтэй, Бочэ бүр Хонгирад овогтон” гэжээ. Энэ “Бочэ” харин хонгирад овогтон байж мэднэ. Гэвч “Гэтэй” бол лавгайяа Уругудын Жүрчидэй-н хөвгүүн юм.

29 Энд дурдсан “Жүхү Гуучи” гэдгийг Ту Цзи авгай “Мухулайн намтар” (“Юань улсын түүх”, шинэ хэвлэл, 2930 нүүр)-ыг үндэслэж залруулжээ. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: “Уудунг томилов” гэж тэмдэглэж буй. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т:

Алтан улсын цэрэг Цавчаалыг чанга хамгаалсан тул Хэтэ (Гэтэйн ондоо бичлэг – эшлэгч), Боша-гаар сахиулахаар зарлиг өгч, (өөрөө) Чжо Лу өөд нисгэн довтолгосонд Алтан улсын баруун нийслэлийн сэргийлэгч Хушаху дутаав гэж тэмдэглэж байдаг. Гэтэл Хушаху Дин Ань-д ялагдсанаас хойш нийслэл Чжунду хотдоо дутаан очиж дахин ер гарч ирээгүй бөгөөд түрүүхэн Юн Цзий хаанаа хорлон алж одоо яг төрийн гол эрхийг барьж байх атал хэрхэн биеэрээ Цицзингуань-д ирж, дутаах явдал гарч болох вэ? Тиймээс энэ тэмдэглэл нь

оновчгүй гэсэн нь илэрхий байна.

30 Хадай гэдэг нэр “Биеэр дайлсан тэмдэглэл”-д дурдагдсан бөгөөд “Нууц товчоон”-ы ерэн таван гавьяат сайдын дотор Хадай хүргэн гэж байдаг нь даруй энэ Хадай болно гэж Ван Го Вэй авгай тэмдэглэжээ.

31 Энд дурдсан Алчи ноён бол Хонгирад овогтны Дэй сэцэний хөвгүүн болно. Гэтэл түүнийг “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”, “Биеэр дайлсан тэмдэглэл” зэрэгт бүр “Очин ноён” (“Биеэр дайлсан тэмдэглэл”-ийн монгол хэвлэлд “Отчигин” гэсэн нь буруу галиглажээ) гэж тэмдэглэж байна. “Очин ноён” бол Алчи ноёны хөвгүүн нь болно. Энд “Нууц товчоон”-ыг үндэслэж тэмдэглэв.

32 “Шар хээр” гэдэг газрын нэрийг “Нууц товчоон”-ы 252 дугаар зүйлд: “Чингис хаан, Хасиу (Хэсиу)-д бугаад дараа нь Чжунду-гийн Шар хээрт буув” гэж тэмдэглэж буй. “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Хаан Чжунду-гийн умардахи их дүүрэгт буув” гэж, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т “Чжунду-гийн умард дүүрэгт буув” гэж, Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Да-коу” гэж тус тус адилгүй тэмдэглэж байна. Гэвч хэрэг дээрээ энэ нь бүр Бээжингийн баруун хойд дүүргийг хэлж байна. “Шар хээр”, “Их дүүрэг”, “Умард дүүрэг” гэдэг нь хийсвэрлэсэн ерөнхий нэр болох мэт. “Да-коу” гэдэг нь Чанпин болон Ваньпин-гийн хооронд байдаг гэлээ. Тиймээс харин бодтой газрын нэр нь болох мэт.

33 “Загасан нуур”-ыг “Юань улсын түүх” зэрэгт бүр “Юй Эр Луань” гэдэг. Энэ бол одоогийн Өвөр Монголын Хишигтэн хошуун дахи “Далай нуур” болно. Энэ нуурт үнэхээр загас элбэг гардаг тул нутгийн ард одоо болтол бас “Загасан нуур” гэсээр байна. Чөлөөлөхөөс өмнө жил бүрийн дөрвөн сарын арван таванд хол ойрын ардууд ирж, “буян үйлдэх” гэсэн мухар биширлийн зорилгоор хятад загасчны шүүсэн загасыг нь худалдан аваад дахин нуурт нь тавин оруулдаг, үүнээ “загасны амь тавина” гэдэг. Энэ газрыг хожим нь Хонгирадын Учан ноёнд зуслангийн газраар шагнаж, тэнд Барс хотыг байгуулжээ.

34 Моняньцзиньчжун-ыг “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Зүүн жигүүрийн Зайсан Цзинь Чжун” гэж, “Юань улсын түүх”-д “Зөвлөгч Моняньцзиньчжун” гэж, “Алтан улсын түүх”-д “Зүүн мөрийн түшмэл эрхин сайд Моняньцзиньчжун” гэж, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Зүүн мөрийн дэд юаньшуай” гэж тус тус баахан зөрөөнтэй тэмдэглэж байна. Энд бид “Алтан улсын түүх”-ийг баримтлав.

35 Алтан хааны хамгаалагч цэрэг дэх Хятан хүмүүсийн урвасан байдлыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д нэлээд бодтой тэмдэглэж байдаг билээ. Доор лавлалт болгон тэмдэглэв. “Алтан улсын эзэн нь Чжочжоу-д хүрч, бараа болж бүхий Хятан цэргүүд Лянсянь-д хүрсэн хойно хувьсал гаргах болгуузай хэмээн сэжиглээд, уулын түгээсэн хуяг, морийг нь хураан авч, хуарандаа буц хэмээн зарлиг болгосон гэнэ. Ингээд олон Хятан цэргүүд урван босолцож, тус чжоу-гийнхаа Сэнгүм ноёныг алж, Канда (Д’Оссоны номд Жода [Jcho-da] гэжээ), Бишер, Жалар нарыг жолоодогчоор сонгож, Чжунду хот өөдөө буцсан гэнэ. Чжунду хотын захирагч Ваньгинь Чэнхүй урвал гаргасныг нь сонсч, умарш хэтрүүлэхгүйн тулд, цэрэг томилон Лу Гоу Цзяо гүүрийг сахиулсан гэлээ. Энэ үед Канда гарамгай жанжин Татар гэгчээр мянган морьт цэргийг дайчлуулан, дээд урсгалаар нь сэмээр гэтлүүлж, гүүр сахиж байсан цэргийг араас нь цохиж ихээр сөнөөн, хуяг зэвсгийг нь цөм хураан авч, бас Чжунду-гийн ойр дүүрэгт байсан

агт морьдыг нь булаан авч, харж байсан түшмэдийг нь үлдэн явуулжээ. Ингээд Чжунду хотод оръё гэсэн боловч сэргийлэл хориглолт чанга бэхи болохоор орж чадсангүй, элч томилж (Чингис хаанд) бууж өгсөн бөгөөд бас Елюй Люгэ-д элч томилон найрамдахыг мэдэгдэв” (“Ту Цзи-гийн тэмдэглэл”, гуравдугаар боть, 14 нүүр) гэжээ.

36 Энэ “Ляоси” гэснийг нь “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т “Ляодун” гэж тэмдэглэжээ. Гэвч энэ удаа Мухулайн байлдсан газар нь бүр Ляоси-гийн газар болно. Үүнийг Су Тянь Цзюайн зохиосон “Алдарт сайдын товч намтар” гэдэг зохиол ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д бүр “Ляоси” гэж залруулжээ. Бид үүнийг нь баримтлав.

37 Зэв ноёны Алтан улсын зүүн нийслэл Дунцзин-ийг дайлсан явдлыг цагийн талаар, газар нэрийн талаар хүртэл эл түүх шастирт бүр адил бусаар тэмдэглэж байдаг. Тиймээс сүүлчийн хүмүүсийн магадлалт ч янз бүрээр тэмдэглэж буй. “Нууц товчоон”-ы 247 дугаар зүйлд: Хонин жил (1211 он, цагагчин хонин жил) ... бас Зэвийг томилж Дунчан хотыг байлдав гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: Цагагчин хонин жил ... бас Зэвийн захирсан цэргийг томилон Дунцзин-г эзлүүлэв гэж, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т: Долдугаар он (Чингисийн он тоолол – эшлэгч) Хар бичин жил (1212 он)-ийн өвлийн 12 сарын хөх бичин өдөр Зэв Дунцзин-г довтлов гэж, “Юань улсын түүхийн нөхвөр”-т: Хонин жилийн намар Зэв Дунцзин-г эзлэв гэж, “Д’Оссоны Монголын түүх”-д: 1213 оны нэгдүгээр сард Монголын эзэн өрлөг жанжин Зэвээр цэрэг захируулж, Дундад улсаас томилж, Дунцзин Ляо Ян-г довглуулав гэж тус тус адил бус тэмдэглэж буй.

Эдгээр тэмдэглэлүүдэд цагийг 1211 он, 1212 он болон 1213 он гэж гурван янзаар тэмдэглэж байх бөгөөд газрыг Дунчан, Дунчин гэж хоёр янзаар тэмдэглэж байна. Дунчан бол Шаньдун мужийн Ляосин сянь болно, Дунчин бол Ляонин мужийн Ляо-ян хот болно. Тус товчоонд би Д’Оссоны тэмдэглэлийг баримтлав. Учир нь Д’Оссоны тэмдэглэл хэдийгээр ууган тэмдэглэл биш боловч тэр нь нэлээд олон тулгар баримтыг магадалж тэмдэглэсэн болохоор үнэн байдалтай тохирох мэт.

Наймдугаар бүлэг



Чингис хаан баруунш дайлсан нь

Чингис хаан нийтийн он тооллын 1211 онд Алтан улсыг биеэрээ дайлж, Алтан улсын нийслэл Чжунду хотоор гол харалт болгон гурван удаа довтлоод, эцэстээ 1215 оны 5 сард Чжунду хотыг эзлэн авсан бөгөөд энэ намар нь Хэрлэний их ордондоо буцжээ. Чингис хаан хэдийгээр ар газартаа буцсан боловч Алтан улсыг дайлах явдлыг 1217 оны 8 сард Мухулай ноёноор захируултал бас л өөрөө ерөнхийлөн захирч байсан юм.

Чингис хаан Алтан улсыг бүрэн мөхөөхөөсөө өмнө ар газраа буцсан учрыг бид долдугаар бүлэгт нэгэнт дурдсан билээ. Чингис хаан энэ удаа Алтан улсаас буцаж ирээд 1219 он болтол их төлөв доорхи их явдлуудыг гүйцэтгэсэн байна.

Нэгд, Түмэд зэрэг Ойн иргэд ба Киргиз (=Хиргис - хө.)-ийн босолгыг дарангуйлжээ.

Хоёрт, Худу, Чулуун тэргүүтэй Мэргидийн үлдэгдлийг устгажээ.

Гуравт, Хүчүлүг түрүүтэй Найманы үлдэгдлийг устгахын хамт хар Хятаныг мөхөөжээ.

Дөрөвт, Хятан үндэстнийг оруулан авсан бөгөөд оргодлыг нь устгаж, Гуули улстай анх

харьцаа байгуулжээ.

Тавд, Тангуд улсыг дөрөв дэх удаагаа дайлжээ. Эдгээр бодтой учрыг бид төвлөрөнгүй тодорхойлохын тулд зургадугаар, долдугаар хоёр бүлэгт тусгай тусгай сэдвээр бичсэн байна.

Тус бүлэгт Чингис хааны баруунш дайлсан явдлыг тэмдэглэх болно. Энэ нь зөвхөн Чингис хааны өөрийн биеэрээ Дундад Азид цэрэглэж, Хорезм улсыг мөхөөснийг хэлж байна. Энэ бол Хаант Монгол Улсаас Дундад Ази ба өрнө дахин өөд дайлсныхи нь эхлэлт болно. Чингис хаанаас хойш бас хоёр удаа их дайралт хийсэн юм.

Нэг удаа нь 1235 онд Өгөөдэй хааны үед явагджээ. Тэр удаагийн дайралтыг Жочи-гийн хоёрдугаар хөвгүүн (зарим материалд ахмад хөвгүүн гэдэг нь буруу юм) Бат, Чагаадайн ахмад хөвгүүн Бидэр, ач хөвгүүн Бүри, Өгөөдэйн ахмад хөвгүүн Гүюг, Тулуйн ахмад хөвгүүн Мөнх нараар тус тус их цэрэг дайчлуулж, Батаар ерөнхий захирагч болгон баруунш дайлуулжээ. Үүнийг түүхчид “Ахмад хөвгүүдийн баруунш дайралт” гэдэг билээ. Үүний дүнд Кипчак хант улсыг байгуулсан байна.

Нөгөө нэг удаа нь 1252 онд Мөнх хааны үед явагджээ. Энэ удаагийн дайралтыг Мөнх хааны дүү Үлэгү дайчлан баруун Ази өөд довтолсон бөгөөд Ил хант улсыг байгуулжээ.

Тус товчоонд зөвхөн Хаант Монгол Улсын анхдугаар удаагийн баруунш довтоллт – Чингис хааны Хорезм улсыг биеэрээ дайлсан явдлыг бичих болно.

57. Хорезм ба Монголын харьцаа

Хорезм гэдэг нэр бол перс үг гэлээ, тэр нь эртний Курасмия хант улсаас улирч нэршжээ. Монголчууд “Сартуул” гэж нэрлэдэг. Энэ “сарт” гэдэг язгуур үг бол санскрит хэлний “худалдаачин” гэсэн үг болно. Монголчууд үүгээр нь нэрлэжээ. Зарим хятад түүх шастирт “Хо Сюнь” гэж нэрлэдэг байв¹. Бид “эзнийх нь хэллэгээр нэрлэх” зарчмыг үндэслэж, “Хорезм” гэснээр нь гол болгож, Монголын заншил нэрийдэл “Сартуул” гэснийг нь хослуулан хэрэглэв.

Хорезм улс нь Дундад Азийн Аму мөрөн (одоо Аму-Дарья мөрөн гэдэг)-ий доод урсгалаар нутагтай эртний улс болно. Нийслэл нь анхандаа Ургенч (Зөвлөлтийн Узбек улсын Гурганач) хотод байжээ. Хорезм нь бараг нийтийн он тооллоос өмнөх долдугаар зууны үед боолт нийгмийн байгуулалд шилжсэн гэдэг. Нийтийн он тооллын долоон зуун оны урьд хождоор араб хүнд эзлэгджээ. Арван нэгдүгээр зуунаас арван гуравдугаар зууны хооронд Сельджукын Түрэгчүүд ноёрхож, газар нутаг нь улам улмаар өргөдөж Сыхун мөрөн (одоогийн Сыр-Дарья мөрөн)-өөс Персийн булан хүртэл, Сын мөрөн (одоогийн Инди мөрөн)-өөс Ирак, Араб, Азербайджан хүртэл Перс, Афганистаныг багтаасан том улс байжээ. Өөрөөр хэлбэл, одоогийн Зөвлөлт улсын Дундад Ази дахи бүх нутаг ба Иран, Афганистан зэрэг улсыг хамарсан улс болно. Хорезм нь Дундад улс ба Газрын дундад тэнгисийн хооронд, Энэтхэг ба Өмнөд улсын харилцах замын уулзвар дээр оршиж байсан учраас өрнө дорно өмнө умар зүгийн худалдааны төв болж тэр үеийнхээ олон улсын харилцаанд чухал байрыг эзэлж байжээ. Арван хоёрдугаар зууны дунджаар Хятаны Елюй Даши-гийн байгуулсан Хар Хятанд эзлэгдээд, Хорезмын хоёрдугаар залгамжлалын эзэн Ажис гэгч жил бүр гурван түмэн алтан

зоосын өргөл барихаар тогтож албат харьяа болон эвслээ гэдэг билээ.

Тус улс бол Исламын шашныг шүтэгч олон үндэстнээр бүрэлдсэн том улс болох бөгөөд “Иргэдийнх нь хагас нь майхан гэрт суудаг нүүдэлчин, тэдэнд мал адгуусаас өөр хөрөнгөгүй” (“Д’Оссоны Монголын түүх”) хагас суурьшмал, хагас нүүдэлчин улс болно.

Дэлхийд алдартай сайн морьд энд төрдөг, бас үзэм, буудайн гаралт элбэг, алт мөнгөний урлал ба шилний үйлдвэрлэл нь алдартай юм. Тэр үед Хорезмд дөчин түмэн (энэ тоо нь маш ихэсгэсэн тоо гэж Ли Цзу Бэн авгай үзэж байсан бөгөөд хэрэг дээрээ арваад түмээс хэтрэхгүй гэж үзжээ) их цэрэгтэй байсан бөгөөд ард иргэд нь их төлөв туркмен хүн болон ханлин хүмүүсээр бүрэлдсэн байжээ.

Арван гуравдугаар зууны эхээрх Хорезмын эзэн нь Ала-үд-Дин Мухаммед гэдэг. Мөн ч “Нууц товчоон”-д дурдагддаг султан хаан болно. Тэр бол Сельджук Туркийн хан Мелиг султаны боол Нестигин гэгчийн үр хойч гэдэг юм.

Чингис хааны Хаант Монгол Улс нь урьд хожид Уйгур Харлуг зэрэг үндэстнийг оруулан авснаас, ялангуяа Хар Хятаныг мөхөөснөөс хойш шууд Хорезм улс лугаа зах зэргэлдээ болжээ.

“Чингис хааны ноёрхсон сүүлчийн үед, энх тайван амар түвшин орчин тойрныг буй болгож, хөгжил бадралыг биелүүлэн, зам гудаст аюул түгшүүргүй, үймээн дэвжээн зогсож, олз ашгийг олж болохуйц орон болсон учраас хол ойрын арилжаа худалдаачин бүр тийшээ (Монгол өөд - эшлэгч) зүглэх болжээ” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, хятад хэвлэл, дээд дэвтэр, 90 нүүр) гэж перс түүхч Джувейни дурдаж байсан нь монгол орон ба гадаад харьцааг харуулж байна. Монгол Хорезм хоёр улсын харьцаа ч ийм байжээ. Ялангуяа Хэрэйд, Найман, Онгуд зэрэг Монголын баруун аймгууд нь нэн эрт дээд үеэсээ түүнтэй арилжаа худалдааны харьцаатай байсныг бид “Нууц товчоон”-д тэмдэглэсэн Сартуул худалдаачин Асан зэргийн явдлаас мэдэж болно. Тиймээс Чингис хаан ч Хорезмыг нэлээд эртнээс ойлгон мэдэж байсан нь дамжиггүй юм.

58. Монгол Хорезмын хооронд дайн үүссэн шалтгаан

Чингис хаан Хорезмыг дайлсан чухамхүү шалтгааны тухай сүүлчийн хүмүүс янз бүрээр шүүмжлэн хэлэлцэх болжээ. Хураангуйлан хэлбэл, нэг зүйлийн санал нь “Дээрмийн дайн” гэдэг. Тухайлбал, “Чингис хаан түрүүтэй Монголын боол эзэмшигч ангийн гүн ухаан нь: Баян эрхэм больё гэвэл дээрэмдэх хэрэгтэй; эзэрхэглэн ноёрхоё гэвэл харь улсыг эзлэн авах хэрэгтэй. Энэ бол Чингис хаан болон түүний залгамжлагчдын тасраагүй гадагш дайлж байсны шалтгаан нь болно.

Чингис хаан жич түүний залгамжлагчдын баруунш дайлсан дайн нь, 1218 онд Найманы Хүчүлүгийг устгаж, Хар Хятаныг мөхөөхөөс өмнөх нь улсын дотоодохи үндэстний хоорондохи дайн болно. 1219 онд Чингис хаан өөрөө цэрэг дайчилж, Хорезм улсад халдсанаас эхэлсэн дайн бол харь улс өөд түрж түрэмгийлсэн дээрэмдсэн дайн болно” гэж Чю Шу Сэнь орчимхон үзэж байсан юм (“Юань улсын түүхийн тухай яриа”, гуравдугаар бүлэг). Гэтэл энэ саналыг эхлээд дурдсан нь Дундад улсын хүн биш, харин Армени гаралтай

түүхч Д'Оссон болно. Тэр: “Чингис хааны улс нь Мухаммед султан ханы улс лугаа зах нийлсэн тул хөгжингүй зэргэлдээгийн баялаг нь татар орны эл нүүдэлчин аймгийн ховдогийг нь хөглөхгүй байж чадсангүй, дэмий удалгүй энэхүү Монголын түрэмгийлэгчид шалтаг олж халдсан билээ” (“Д'Оссоны Монголын түүх”, 1 дүгээр боть, тавдугаар бүлэг) гэж тэмдэглэв. “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх” (гурван ботийн, дорогш “Монгол улсын түүх” гэж товчлов)-д: Чингис хаан Хорезм улсыг байлдан эзэлж газар нутгаа талж, их хэмжээний олз ашиг олж авахыг гол зорилго болгосноос гадна бас Дундад Азийн нутгаар дамжин гарч байсан тэр үеийн дорно өрнийн худалдааны их замыг эзэмших давхар бодлоготой байсныг тэмдэглэх хэрэгтэй (тэргүүн боть, дэд хэсэг, нэгдүгээр анги, гуравдугаар бүлэг) гэж тэмдэглэсэн байна.

Нөгөө нэг зүйлийн санал нь “Байлдах бодолгын хэрэгцээ” гэдэг. Энэ саналыг тус зууны хориод оны үед Дундад улсын түүхч Чжан Чжэнь Пэй авгай дурдаж байсан юм. Түүний хэлсэн нь: “Хаан их говийн өмнө умрыг нэгтгэсэнээс хойш, өмнөш Алтан улс ба Тангудыг дайлах явдалд хүчээ тавьжээ. Харин зүүн өмнө дэх цэрэг дайны явдал туйлбартай тууштай атлаа баруун фронтод дайны хоёрдугаар талбарыг нээсэн явдал түүний хүчин чадал төгөлдөр ба цөс зориг их ахуйгаар эрт өдгөөг үнэнхүү донсолгосон билээ. Гэвч хаан бол зэр зэвсгээр хэнээрхэн тоглогч биш тул тэр баруунш дайлсан дайралдаан нь хэрэг дээрээ гэнэт бүрэлдсэн биш бөгөөд байлдах бодолгын хэрэгцээгээс нь болсон юм. ... Чжунду хотыг эзлэн авсан хойно, олон жанжин нарын айлтгалаар Бяньлян хотыг шууд довтолсонгүй учир бол хаан цэрэг хэрэглэхүйд эрэлхэг зоригтой, дайсныг тольдохүйд гэгээн мэргэн тул Алтан улсад бас хөнгөвчилж болошгүй хүчин байхыг мэдэж байсанд оршино. Ингээд хаан, Дундад орон болон баруун орныг алийг нь урьдаар дайлбал зохих тухай Го Бао Юй-гээс асууж байжээ. Үүнд Го Бао Юй-гийн хэлсэн нь: Дундад орны хүчин их, эзлэхүйд бэрх, баруун орны олон улсыг урьдаар эзлэн авч, түүний эрэлхэг чадамгай цэргийн хүчнийг Алтан улсыг дайлахүйд хэрэглэж болмуй гэжээ. Го Бао Юй-гийн энэ үг хааны бодлого лугаа яг нийлсэн тул урьдаар баруунш дайлахаар шийдсэн билээ. Сүүлд нь баруун орны олон өрлөгүүд Дундад орныг дайлахад оролцож гавьяа бүтээсэн нь харин Го Бао Юй-гийн хэлсэн зөв болохыг гэрчлэв. ... (“Чингис хааны шүүмжлэл шастир”, зургадугаар бүлэг) гэжээ. Энэ саналыг багцлаад хэлбэл, Чингис хааны баруунш дайлсан явдал бол эцэстээ Алтан улсыг мөхөөх байлдах бодолгын хэрэгцээ гэсэн үзэлт болно.

Гуравдугаар зүйлийн санал бол “дээрмийн дайн” гэдгийг үгүйсгэж, “ял асуух” явдал бол өнгөн талын шалтгаан, жинхэнэ шалгаан нь бол хоёр талын хэрэгцээгээр тайлбарлагдана гэжээ. Нэг нь, “Нутаг дэвсгэрээ өргөтгөх” хэрэгцээ гэдэг. Тухайлбал, “хөвгүүдийнхээ хоорондохи зөрчлийг шийдвэрлэхийн төлөө хувь хувилахаар шийдсэн бөгөөд баруун оронд цэрэглэж, нутаг дэвсгэрээ өргөтгөсөн явдал бол энэ шийдвэрийнх нь үр дүн болно”; Нөгөө нь, “Алтан улсыг бүслэх” хэрэгцээ гэдэг. Тухайлбал, “Чингис хааны баруунш дайлсан явдал бол, Алтан улсыг бүсэлж аваад, дараа нь хүчээ төвлөрүүлэн устгах байлдах бодолгын төлөвлөгөөнийнх нь тун чухал бүрэлдэл нь болно. ... Чингис хаан баруун оронд цэрэглэсэн, Мухулай, өмнөш Алтан улсыг довтолсон, Хажихи (тус товчооны долдугаар бүлэгт дурдсан Хажиньг хэлж буй - эшлэгч) зүүнш Гуули улсыг дайлсан явдал ба өмнөд Сүн улстай холбоолсон явдал нь Алтан улсыг дөрвөн талаас нь бүсэлсэн байлдах бодолгын байдлыг бүрэлдүүлэв” гэжээ. Энэ бол Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн дэд профессор нөхөр Баярын орчимхон дурдсан санал болно (“Өвөр Монголын Багшийн Дээд Сургууль” сэтгүүл,

хятад хэвлэл, 1981 оны гуравдугаар хугацаа).

Дөрөвдүгээр зүйлийн санал бол “ял асуух” буюу “цээрлүүлэх” цохилт гэдэг. Энэ талаар “Нууц товчоон”, “Юань улсын түүх” жич Ил хант улсын түүхч Джувейни, Италийн алдарт жуулчин Марко Поло нар ба бусад тэмдэглэлд үндсэндээ адилавтар тэмдэглэжээ. Сүүлийн үед Дундад улсын алдарт түүхч Хань Жо Линь профессор ч ингэж үзэж байв. Тэр тэмдэглэхдээ: “... Мухаммед Дундад Азийг нэгтгэсний хойно ба Чингис хаан Монголын өндөрлөгийг нэгтгэсний хойно, хоёр талын язгууртад нь ойр зэргэлдээгээр дээрэмдэхээр гадагш түрэх нь лавтай хэрэг юм. Гэвч Тангуд улс ба Алтан улсыг мөхөөхөөс өмнө, хэрвээ Хорезмоос Монгол өөд довтолсонгүй бол Чингис хаан цэрэг зэвсгээ баруунш хандуулах нь сэтгэгдэшгүй хэрэг юм. Хорезмоос гутааж доромжилсон явдал нь өш өшөө хариулахыг чухалчилдаг бөгөөд дийлэгдэшгүй хүчинтэй болоод байсан Монголын язгууртдад авч хэлбэл, үнэхээр хүлээж болошгүй явдал юм. Тиймээс Чингис хааны өшил өших хясал хясах дайны шийдвэр нь тэдний байлдах зоригийг нь хөгжөөжээ” (1962 оны гуравдугаар хугацааны “Түүхийн судлал” сэтгүүл) гэв. Харин түрүүчийн шалтгаануудаар тайлбарладаг эрдэмтэд ч энэ нэгэн бусдач шалтгааныг мэдрэхгүй байж үл чаддаг. Гэвч түүнийг “шууд шалтгаан” буюу “өнгөн шалтгаан” гэж үзэцгээдэг байна.

Эрдэм шинжилгээний хувиас ийм тийм зүйчлэл жишилтийг дурдаж бүр болох юм. Гэвч бид түүхэн тэмдэглэлд тулгуурлаж, тухайн цаг үеийн байдалтай нь холбогдуулж үздэг бол энэхүү дөрөвдүгээрт дурдсаныг гол шалтгаан биш гэж хэлэх баримт дэмий хангамжгүй шиг санагдана. Би хувьдаа мөн үүнийг нь гол шалтгаан гэж үзэж байна.

Чингис хаан баруунш Хорезмыг дайлсан дайны үүсэлт нь үнэндээ нэгэн будлиантай явцыг өнгөрөөжээ. “1214 онд Чингис хаан Бээжингийн орчим Алтан улсын эвслийг хүлээн авсан үед, Дундад Азийн Хорезм улсын Султан хан нь Сайид, Бухадин, Раши гэгч элчийг томилон Бээжингийн дүүрэгт ирүүлж, Монголын хүчийг нь тагнах зорилгоор Чингис хаантай учруулжээ” (Хан Жо Линь-ий дээрх өгүүлэл). Дараа нь Монголын цэрэг 1215 онд Алтан улсын нийслэл Чжунду хотыг эзлэн авсан хойно, тус оны намар нь Чингис хаан Хэрлэний их ордондоо буцаж, улсын дотоодын явдлаа биеэрээ шийдвэрлэсэн билээ. Үүнд 1216 оны хавар зуны үес Сүбээдэйг Мэргидийн үлдэгдлийг, Зэвийг Найманы үлдэгдэл Хүчүлүгийг устгахаар тус тус баруунш томилсон явдал багтаж буй. Ингээд Хаант Монгол Улс нь Хорезм улстай шууд харилцах бололцоотой болсон юм. Бараг энэ үест Исламын шашинт Дундад Азийн том улс Хорезм лугаа арилжаа худалдаа хийж найрамдлаар харилцах зорилгоор Чингис хаан түүний улсад байсан Исламын шашны мөргөлт Хорезмын худалдаачин Махмуд, Бухара-ын худалдаачин Али-Ходжа, Отрарын худалдаачин Юсуф гурвыг өөрийн элч болгож Мухаммед султан ханы захад томилсон билээ. Эдгээр элч нь тэнд очиж, хоёр улсын хооронд арилжаа худалдаа нэвтрэлцэх тухай анхны хэлэлцээрийг тогтоогоод буцаж иржээ. Дараа нь баруун орны худалдаачдын аюулгүйг батлахын тулд, монгол орны гол гол их замууд дээр харуул тавьж байв.

Ингээд эл газрын худалдаачдын тэнд очиж ашиг хонжоо олох замыг нь нээжээ.

Энэ үед Хорезмын Ходженд хотын Ахмад, Ими ноён Хусейны хөвгүүн Ахмад, Балхиг гэгч гурван хүн Монголд бараа таваар ачин ирж, хэдийгээр эхлэнгүүтээ бараа таваартаа их үнэ хаяж, Чингис хааны эсэргүүцлийг олсон боловч удалгүй хааны итгэлийг олж, хүндэт зочны

ёсоор зочлуулжээ. Эд гурав буцах үед Чингис хааны зарлигаар олон ван, ноёд, өрлөг нарын харьяатаас Ухуна түрүүтэй дөрвөн зуун тавин³ Мусульманчуудыг цуглуулж, таван зуун тэмээгээр эд бараа, алт мөнгийг ачуулж, бас элчин мэдээг бариулан, Хорезм улс лугаа арилжаа хийхээр томилон явуулжээ.

Чингис хааны энэхүү элчин харилцааны тусгай үүрэгтэй худалдааны бригад нь 1216 оны сүүлч буюу 1217 оны эхээр⁴ Хорезмын харьяат Отрар хотод хүрсэнд, тэр хотын түрүү ноён Иналчук гэгч эд ашигт нь шунахайрч, эдэнд “Чингис хааны тагнуул” гэсэн ял нөмөргөж, бүгдийг барьж авсан бөгөөд сонсохул Султан хан Мухаммеддаа мэдүүлж, түүний зарлигаар цөмийг хядан алж, эд барааг нь хураан авчээ. Энэ дөрвөн зуун тавин хүний дотроос ганцхан хүн арай чамайн дутаан гарч, 1217 оны 8 сарын үед Чингис хаанд аюулын мэдээг хүргэжээ. Ингээд Чингис хаан Алтан улсыг дайлах явдлыг Мухулай ноёноор ерөнхийлүүлэн захируулж, өөрөө баруун орны хэргийг шийдвэрлэхээр шууджээ.

Анхандаа Чингис хаан, худалдаачдыг алсан явдлыг Отрар хотын эрх мэдэгч Иналчук-ын хийсэн ялт ажиллагаа гэж үзэж байсан бөгөөд зөвхөн тэрхүү амин хэрэгт ялтыг нь шийтгэж өшөө авья гэж бодож байснаас биш, хоёр улсын хоорондохи харьцааг нэг л доор дайны шатанд хүргэе гэж бодсонгүй билээ. Ингээд 1218 онд жинхэнэ элч Бахра-г дэд элч хоёр монгол хүний хамт Отрар хотод Монголын худалдаачдыг хядан алж, тонон дээрэмдсэн ялт Иналчук-ыг авахуулахаар Хорезм улсын султан хан Мухаммедын дэргэд томилон илгээв. Гэтэл доройтож мунхурсан нь хоёр улсын хооронд эд бараа солилцож, улс үндэстний соёл, аж ахуйн харилцааны тайван замыг нээгч зүтгэлтэн - жирийн худалдаачныг алан тоносон харгис ялтныг хууль ёсоор шийдсэнгүй мөртөө энэхүү ялтнаа өмөглөж, нэн их ялт хэргийг үйлджээ. Тухайлбал, Чингис хааны томилсон төрийн элч Бахра-г алан хороож, хоёр дэд элчийн сахал санчгийг хусаж, гутаан доромжлоод буцаасан гэлээ.

Энэ явдлыг эртний ба өдгөөгийн ямар нэгэн бүрэн эрхэт улс үндэстэнд авч хэлсэн ч хүлээж болошгүй явдал юм. Энэхүү гутаал доромжлолын мэдээг Чингис хаан олж сонсоод, өөрийн эрхгүй нүдний нулимс асгаруулж, уур хилэн нь тэнгэр тулам бадарч, бөө мөргөлийн сүсэгтний хувиар “Мөнх тэнгэрийн хүчин”-д даатгаж, “Алтан аргамжаа сартуул иргэнээр таслуулсан ... өшлийг өшиж, хяслыг хясаж, Сартуул улс (Хорезм)-тай байлдах” (“Нууц товчоон”, 254 дүгээр зүйл)-аар шийдсэн тул Монгол Хорезмын хоорондохи нэгэн удаагийн цусан байлдаан зайлшгүй болов.

59. Чингис хааны баруунш дайлсан дайны бэлтгэл ба байрлуулалт

Чингис хаан 1218 онд Хорезмыг цэргийн хүчээр залхаан цээрлүүлэхээр шийдсэнийнхээ дараа, 1219 оны зун цэрэг мордотлоо гол анхаарлаа дайны бэлтгэлд тавьжээ.

Чингис хааны энэ удаагийн баруунш дайлсан дайралдаан бол Хаант Монгол Улсын хийж байгаа бүх дайны хоёрдугаар талбар буюу баруун фронт нь болно. Тиймээс юуны урьд өөрийн цэргийн хүчээ тохируулах чухалтай байв.

Ингээд Онгуд, Горлос, Уругуд, Мангуд, Хонгирад, Ихирэс, Жалайр, Салжигуд зэрэг монгол аймгуудын хоёр түм гурван мянган морьт цэрэг болон Монголд орж өгсөн Жүрчин, Хятан, Хятад цэргийг нийлүүлэн зүүн гарын түмний ноён Мухулайгаар ерөнхийлөн захируулж,

өмнөд фронтод Алтан улсыг үргэлжлэн дайлуулжээ. Чингис хаан өөрөө баруунш Хорезмыг дайлахаар бэлтгэв. Энэхүү бэлтгэл нь 1218 онд болсон Чингисийн алтан ураг ба олон ноёд, сайд нарын хуралдайгаар эхэлжээ. Энэ удаагийн хуралдай бол Владимирцовын хэлсэнчлэн Чингисийн хуралдуулсан “хуралдай” нь, өөрийн төлөвлөгөөгөө алтан ураг ба язгууртадаараа зөвшөөрүүлэхийн төлөө хийсэн биш, харин хамгийн амжилттай аргаар нэгэн агуу их төлөвлөгөөг зохиохын хамт ирээдүйн дайралдааны жолоодогч нараа биеэрээ сургахын тулд хийсэн хуралдаан болно .

Дайны үед улс гүрний ар талын амар түвшнийг батлах явдал бол өмнө фронтод дайн хийхтэй нэгэн адил чухал гэдгийг Чингис хаан Алтан улсыг дайлсан дайны явцаас танин мэдсэн нь яриангүй хэрэг байжээ. Ингээд энэ явдал нь тус хуралдайн бас нэгэн чухал агуулга болсон байв. Тухайлбал, хааны гүнж Алага бэхи болон хааны дүү Отчигин ноён хоёроор төрийн хэргийг захируулж, говийн өмнө умраа тус тус хариуцуулжээ. Бид тус товчооны тавдугаар бүлэгт танилцуулсан “Төр захирагч гүнж бөгөөд голын умардын ерөнхийлөн захирах зарлигын элчийн тамга” гэдэг бол яг энэ үед Алага бэхи гүнжээр Хатан голоос умарш их говиос өмнөхи орны төрийн хэргийг захируулахын тулд үйлдсэн тамга бөгөөд энэхүү түүхэн явдлын археологийн баримт болно. Тиймээс Чингис хаан холдахины аян дайнд морилсон ч улс нийтийн бүх хэргийг орлон захирах хүнтэй болжээ.

Аян дайнд явахад, ялангуяа алс холын аян дайнд мордоход ямар завшаан бусын учир явдал тохиолдож болох юм. Ингээд хожим Чингис хааны их орыг ширах залгамжлагчаар гуравдугаар хөвгүүн Өгөөдэйг тогтоосон байна. Энэ дурдлагыг Чингис хааны татар хатан Есүйгээс “Сартуул улстай байлдаа хэмээн мордоход” дуртган айлтгасан гэж “Нууц товчоон” (254 дүгээр зүйл)-д тэмдэглэж байдаг нь хэдийгээр бодтой цагийг дурдсангүй боловч, энэ удаагийн хуралдай дээр шийдвэрлэх нь зүйтэй хэрэг юм. Энэ явдал бол хэн бүхний мэдэж байхаар Монголын тулгуур төрийн бэхжил, хөгжил ба Монголын нийгмийн цаашдын гүнзгийрэлд чухал ач холбогдолтой юм.

Энэ удаагийн хуралдай дээр цэрэг дайны явдлыг бодтойгоор ярилцсан нь нэн ч дамжиггүй хэрэг билээ. Чингис хаан баруун орныг биеэр дайлсан дайнд, Хаант Монгол Улсын зэвсэгт хүчний гол хэсгээ хэрэглэсэн байв. Жишээлбэл, хааны дөрвөн хөвгүүн ба Боорчу, Шигихутуху, Елюй Ахай, Елюй Чу-сай нарыг багтаасан төрийн долдугаар түшмэд сайд, Зэв, Сүбээдэй зэрэг өрлөг жанжин нар жич дайчилж болохуйц зэвсэгт хүчнийг бүр оролцуулжээ. Хатдаас Хулан хатан дагалдан явжээ. Үүнээс гадна гадаадын тусламж бас хэрэгтэй байв. Тиймээс юуны урьд Тангуд улсад элч томилж хүч элсүүлжээ. Гэвч Тангуд улс цэрэг тусалсангүй мөртөө түүний түшмэл Аша Гомбу гэгч нь их үг хэлж, Чингис хааныг хорсгосноос, 1218 оны хавар Чингис хаан Тангуд улсыг дөрөвдэх удаа дайлсан байна. Чингис хаан хэдийгээр Тангудаас тусламж олсонгүй боловч Харлугийн Арслан хан, Уйгурын Итүгүд Баржуг Арт Тигин болон Алимарынб түрүү Сүйхэнэр Тигин нар тус тус өөрийн цэргээ авч Чингис хааныг даган баруунш дайлсан хэрэг билээ. Ингээд Хорезм улсыг дайлсан бүх цэрэг нь хорин түмд хүрэв⁷.

Зэв, Сүбээдэй ноёны удирдсан их цэрэг нь хэлэлгээнгүй Хар Хятан зэргийг сөнөөсөн баруун фронтоосоо цааш хошуучлан явжээ.

Энэ удаагийн дайнд Чингис хаан, Алтан улс ба Дундад ардаас олзолсон цэрэг дайны

давшингуй мэргэжил ба хурц зэр зэвсгийг хэрэглэсэн нь ч мэдээжийн хэрэг бөгөөд тэдгээрийг хэрэглэснээс байлдах хүчээ ихээр дээшлүүлжээ. Энэ тухай Ли Цзэ Фэнь авгайн номонд: “Чингис хаанд бууж өгсөн Алтан улсын жанжин Цзинчжоу-гийн Чжан Жун гэгч ... цэргийн дархадыг удирдан, хааныг дагалдан баруунш дайлсан бөгөөд онгоц сал үйлдэх, гүүр тавих үүргийг хариуцжээ. ...Бас Садархай гэгч ...Чингист бууж өгсөн хойно усчны ба их буугийн цэргийн юаньшуай байсан бөгөөд хааныг дагалдаж Хорезм ба Тангудыг мөхөөх дайнд оролцжээ. ...” гэж тэмдэглэж байсан бөгөөд бас “Елюй Чусай-н шүлгийн анд Жабашао юаньшуай гэдэг бол “Юань улсын түүх”-д дурдагддаг Жадархад бололтой. Жадархад бол хятаджаад удсан Чжи чжоу-гийн хятан хүн юм. Чингис хаан Алтан улсыг дайлах үед их буу хэрэглэж чадагчдыг цэрэгтээ элсэж, Жадархадаар захируулжээ. Баруунш Хорезмыг дайлах үед тэр харьяат их буут цэргээ ба Хятан, Жүрчин, Хятад цэргийг дайчилж, Чингис хааныг дагалдан Отрар хотыг довтлоход өөрийн цэргээ удирдан хотыг нь нүхэлж урьдаар дайран орсон тул юаньшуай цолоор өргөмжилжээ” гэж тэмдэглэсэн нь бүр баримттай юм. Үүнээс гадна, Оросын анхны монголч эрдэмтний нэг, “Судрын чуулган”-ы оросчлогч Березин нэлээд тодорхой мэдээг хангасан байв. Жишээлбэл: “Харийн мэргэжилтэн, эмч, үйлдвэрчний буй бүхий мэргэжил нь цэрэг ангийн байлдааны чадварыг хамгийн өндөр хэмжээнд хүргэжээ...”, “Энэ удаагийн дайнд бас нэгэн маш их “чөдөр оньс” гэгч зэвсэгтэй үхэр бууны анги (энэ бол дээр дурдсан Жадархадын захирсан цэрэг болно - эшлэгч) морьт цэргийг дагалдан явжээ. Энэхүү үхэр бууны ангид чулуу, төмөр мэтсийг холоос харвах багажтай юм. Тэд нар аялах үедээ энэхүү үхэр буюу хэдэн хэсэг болгон задалж, үхэр буюу тэмээнд ачиж явдаг. Энэхүү үхэр бууны ангид нь бас Европ хүн Бертурд гэгч дарийг буунд хэрэглэхээс хэдэн зуун жилийн өмнө үүдэн бүтээсэн хот дэлбэлэгч гэдэг “галт буу”-г хэрэглэж байжээ. Тэд үүнээ харваж, дайсан этгээдийн модон хийцтэй бэхлэлт зэргийг нь шатаадаг бөгөөд хориглож байгаа дайсны орой дээрээс чулуу, төмөр буулгаж, дайсны сүрийг нь дардаг байна”. “Монголын морьт цэрэг нь бас боловсронгуй барилгын мэргэжилтэй хятад мэргэжилтэдийг дагуулж явж байсан тул тэд орчин үеийн барилгын цэргийн үйлдлийг үзүүлжээ. Жишээлбэл, гүүр тавих (Чагаадайн цэрэг Сыр-Дарья мөрнийг гэтлэхэд арван найман гүүр тавьсан гэлээ – уул тайлбар), голын усыг дарж хот балгасыг урсгах зэрэг ажиллагааг гүйцэтгэдэг байна”.

Цэрэг тус бүрийн байлдааны бэлтгэлийн ажлыг ч урьд урьдынхаас улам сайн хийжээ. “Байлдагч тус бүр гурваас дөрвөн хөтөлгөө морийг авч явахын хамт, холын байлдаан ба ойрын байлдаанд хэрэглэх хоёр зүйлийн зэвсэг – хүн бүр нэг нум, хоёр ховд сум, нэг ховдыг нь ил авч, нэг ховдыг нь ус оруулалгүйгээр битүүмжлэн авч явдаг бөгөөд бас хүн бүр нэлээд бялуу (шийдэм - хө.) буюу дайсныг боомилон чирэх боомийг авч явжээ. Монголчууд боомийг хэрэглэхэд алдалгүй уургалдаг гарамгай чадвартай юм”. “Тэрчлэн байлдагч тус бүрт дутагдаж болзошгүй эд, жишээлбэл зүү утас ба зэвээ билүүдэх билүүг хүртэл бүр өөрсдөө авч явжээ. Бас дайнд мордох хүн бүр нэгэн мяндсан цамц буюу ханжаарыг авч явах хэрэгтэй гэж тогтоожээ. Учир нь мяндас бол зохих зайн дотор зэвийг халхалж чаддаг бөгөөд зэвийг ороолдон маханд нь орвол хятад эмч нар нь зэвийг амархан татан авдаг байна”. Бас “Эл цэрэг ангид зэвсэг тоногийг үйлдэх ба байцаагч тусгай цэргийн түшмэлийг томилж, зэвсэг тоногоо эвдэж сүйтгэснийг мэдвэл тэрхүү хэрэглэж бүхий цэргээр барахгүй, түүний шууд захирагч ноёдыг нь хүртэл шийтгэдэг. Бас цэргийн хэрэгцээний тусгай түшмэдийг томилж, тэдний зарим нь хошууч цэргийн хамт яван, эл цэрэг ангийн аяны хуаран буудлыг нь тогтоодог бөгөөд бусад нь цэрэг нүүж явсан хойно цэргийн аяны буудал дахи гэж орхисон зүйлийг нь байцаадаг, тэд бас байлдааны олзыг зохистой хувьдах ажлыг хариуцдаг байна”. Ингээд их

цэрэг мордохоос өмнө, цэрэг аялах бэлтгэлийн ажлаа эхлэн хийжээ. ”Баруунш зорчсон тэмдэглэл”-ээс үзэхүл, Алтай дахи зам засах барилгын ажлыг гуравдугаар хөвгүүн Өгөөдэй хариуцжээ; Тэнгэр уулан дахи зам засах ба гүүр тавих ажиллагааг хоёрдугаар хөвгүүн Чагаадай хариуцжээ. Хоёр хөвгүүний зам зассан ажиллагаа их төлөв зэрэг явагдсан бөгөөд их цэрэг мордохоос өмнө, түрүүний анги удирдаж биелүүлсэн байна. Чингис хаан барилгын цэрэг ба их буут цэргийг тун эрхэмлэж байжээ. Алтан улсыг дайлах үед Дундад улсаас маш олон дархад урчуудыг олзолж аваачсан тул энэ үе Монголын цэргийн барилгын ба их буут цэрэг өнөр олон байжээ. Тиймээс энэ удаагийн барилгын ажиллагаа нь хэдийгээр их хэмжээний ажиллагаа байсан боловч амжилттайгаар биелэгджээ” (“Чингис хааны шинэ намтар”, 426 нүүр).

Өөрийн хүчээ зохион байгуулахаас гадна, дайсны талын байдлыг ойлгох явдал бол дайны жолоодогчид дутагдаж болошгүй нөхцөл юм. Энэ талаар Чингис хаан мөн амжилттай ажиллажээ. Энэ удаагийн дайнд хэрэгцээтэй мэдээний найдвартай ирэлт гэвэл, юуны урьд Сартуулын дотоодоос ирсэн мэдээ болно. Чингис хааны хуучин анд найзын дотор хэд хэдэн Хорезм хүн байдаг бөгөөд сүүлд нь Дундад Азиас Монголд ирэх арилжаачид ч цөөнгүй байв. Эднээс хангадаг мэдээ бол бүр Хорезмын дотоод байдал - улс төр, аж ахуй, цэрэг дайн жич орон нутгийнх нь тухай байдал болно. Дараа нь, Уйгур, Харлуг ялангуяа Хар Хятан зэрэг Хорезм улс лугаа зах зэргэлсэн буюу харьцаа холбоотой улс үндэстэнүүдээс ирсэн мэдээ болно. Гуравдугаарт, Зэв, Сүбээдэй нар их цэрэг дайчилж, Найманы үлдэгдэл ба Мэргидийн үлдэгдлийг устгахаар баруунш дайлахдаа Хорезмын байдлыг нэлээд нарийн ойлгожээ.

Багцлаад хэлбэл, Чингис хаан баруунш дайлсан дайны бэлтгэлийг Тангуд ба Алтан улсыг дайлсан дайны суурь дээр хийсэн тул алс холын аян дайны туршлага сургамжаа дүгнэж, урьд урьдынхаасаа нэн нарийн, нэн төгөлдөр, нэн амжилттай хийсэн нь дамжиггүй юм.

60. Чингис хаан Дундад Азид дайлсан явц

Чингис хаан алс холын аян дайны бэлтгэлээ хийж дуусаад, их цэрэг цэрэглэх цагийг дараа жил (Чингис хааны арван дөрөвдүгээр он, шарагчин туулай жил буюу 1219 он)-ийн 5 сар, цугларах газрыг Уйгурын нутаг Эрчис мөрнөөр тогтжээ.

Ингээд Чингис хаан өөрөө гол эх цэргээ дайчилж, туулай жил (1219 он)-ийн 4 сард8, тавин найман настайдаа Монголын эх газраасаа мордож, Арайн давааг даван, 5 сард Найманы нутгаар дайран, Эрчис мөрөнд зусжээ. Уйгур, Харлуг болон Алимарын цэрэг энд Монголын цэрэгтэй нийлэлдсэн тул Чингис хааны баруунш дайлсан хүч бас ихээр нэмэгдсэн байна.

Их цэрэг мордохын өмнө Зэвийг манлайд илгээв. Зэвийн гэээгт Сүбээдэйг илгээв. Сүбээдэйн гэээгт Тогучарыг илгээв. Энэ гурвыг илгээхдээ тушаасан нь: “Султан хааны нутгийн гадуур явж цаана нь гараад биднийг очиход хамтарч нийлтүгэй! гэв (“Нууц товчоон”, 257 дугаар зүйл). Тухайн үед эд гурав Монголын баруун хилээр байжээ.

Монголын баруун орон ба Уйгурын нутгаас Дундад Ази өөд ороход эрт урьд цагт Азийн өндөрлөг дэх нүүдэлчин үндэстнүүд баруунш довтолж байсан Жунгарын боомт гэдэг ганцхан зам байдаг гэлээ. Эндээс Сыхун мөрөн (Сыр-Дарья мөрөн) хүрэхэд, нэгэн өвч усгүй уудам их говь газрыг туулж гарах л ёстой билээ. Энэ газраар өнгөрөхөд хэдэн арван түмэн

цэрэг ба түүнээс хэд хэд дахин олон унаа малын хүнс тэжээл зэрэг асуудлыг заавал шийдвэрлэх хэрэгтэй байсан юм. Хэрвээ умардахи өвс бэлчээртэй тал газраар явж Хорезмын төв газар хүрэхэд аль дөтдөө хэдэн зуун км-ийн тойруу зам явахаар барахгүй, бас яг дайсны дундуур явах болно. Хорезм улсын зүүн талаар орох нь дөт зам боловч бүр далайн төвшнөөс дээш долоон мянган метр өндөр цаст уул далдалж байдаг. Энэхүү бэрхшээлийг давахад Зэв ноён чухал үйлдлийг гаргажээ. Тэр Хар Хятаныг дайлж байхдаа уулын хавцлаар баруунш Хорезм өөд нэвтрэх нэгэн нарийн замыг олж мэджээ. Энэ зам бол Хорезм улсын зүүн талаас орох ганцхан зам гэж хэлж болох юм. Ингээд Чингис хаан түүнийг хошууч цэргээр томилсон гэдэг.

Зэв ноёны удирдсан, бараг таван мянгаас гурван түмэн хүнээр бүрэлдсэн цэрэг нь 1218 оны өвлийн улирлын тасхийм хүйтэн өдрүүдэд, Памир ба Тэнгэр уулын цавчим хавцлаар үзэгдээгүй ертөнц өөд замнан эхлэв.

Тэд, хүний чинээн гүн цасан дундуур, агт морины хөл хөлдөм хүйтэнд, моринынхоо хөлийг сарлагийн арьсаар боож, хүмүүс нь нэхий дээл дээрээ бас ямаан арьсан дахыг эргүүлэн өмсч, долоон мянган метр орчмын өндөр уул дахи мөст ертөнцөд байлдан урагшилж байлаа. Хатуу бэрхшээлтэй замаар өдөржин шөнөжин явж, үл даарч биеэ дулаацуулахын төлөө, моринынхоо судлыг ханаж, цусыг нь сорсон явдал ч яг энэ замд гарч байв. Тэд түргэн урагшлахыг бодож илүү дутуу зүйлээ бүр орхижээ. Тэдний явж өнгөрсөн замын хоёр талаар үхсэн морь, малын хэнхдэг, хөлдөж үхсэн хүний хүүр үхдэл ба эдлэл хэрэгсэл зэрэг явах тутам олширч байв.

Хүчир хатуу аян дайны дүнд, үзэсгэлэнт сайхан ногоон дэлхий – Фергана-ын хотгор (Зөвлөлтийн Узбек улсын зүүн хойд булан) тэдний өмнө илрэх үед, тэнд нэгэнтээ урьхан хавар ирээд байжээ. Энэ газар бол үзэм буудайн элбэг гаралтайгаар үл барам, хуухан гэгч алдарт морьд ч энд төрдөг байна. Холын аян замыг туулсан Монголын хошууч цэрэг дөнгөж энэхүү тэнэгэр талд бууж, айл тосгоноос агт унаа, амуу хүнс татварлаж эхлэхтэй зэрэг, Мухаммед Султан хан хэдийн энэ чимээг олж мэдээд, ядаж тартсан монгол цэргийг хурц хүчээр устгахаар шилдэг хүчирхэг цэргээ дайчлан иржээ.

Энэ бол Монгол Хорезм хоёр улсын хооронд болсон их дайны өмнө тохиолдсон туршигч чанартай нэгэн бяцхан байлдаан болно. Энэ удаагийн байлдаан бол монгол цэрэг холын аян замыг явж, ихэд ядан зүдэрч, хүч нь нэлээд хохирсон байдал доор Хорезмын хүчирхэг хүчинтэй тулалджээ. Ялангуяа Зэв бол хошуучлан зам нээх ба дайсны ар талд гарч, их цэрэгтэйгээ хамтран гадар дотроос нь хавчин байлдах даалгавартай тул энэ удаагийн байлдааныг хийх санаагүй байжээ. Тиймээс анх удаагийн байлдаанд монгол цэрэг нь нэгэн талаар түргэн ухарч, бас нэгэн талаар монгол цэргийн харвалгын гарамгай чадварыг төгөлдөр бадруулсан байна. Мухаммед султаны цэрэг, Зэвийн цэргийг нэхсээр уулын хавцалд хүрчээ. Хэрвээ монгол цэрэг дахин ухарвал Султан ханы цэрэг уул бартааны ашигтай газрыг эзлэх нь зайлшгүй бөгөөд ингэвэл Сыр-Дарья мөрнөөр байлдааны гол талбар болгож, дайсанд сөнөөгч цохилт өгөхөөр туурвисан Чингис хааны ерөнхий байлдах бодлогыг нь нөлөөлөх болно. Ингээд монгол цэрэг нь ухарч байснаасаа гэнэт гэдрэг довтлон, аймаар сүрхий урай хашгиралтын дунд янз бүрийн туг далбааны командлалаар довтолж байгаад гэнэт ухрах, төвлөрч байгаад гэнэт тархах мэт гавшгай гайхамшгаар маневрласан тул, бүрээ бишгүүр

болон хэнгэрэг цангийн цохилгоор байлдаж байсан Мухаммедын цэрэг нь хааш довглохоо ч олохгүй байтал, монгол цэрэг гэнэт цугларан дайсны гол жагсаал өөд нь шувтладаг байв. Хорезмын цэрэг нь хэдийгээр цэргийн хүч ба зэвсэг тоногийн талаар давуу байсан боловч сүр хүч нь нэг л доор дарагдаж, Мухаммед султан ч бараг баригдахдаа шахжээ. Энэхүү ширүүн байлдаан нь шөнө бүрий болтол үргэлжилж, хоёр этгээдээрээ байлдааны талбараас цэргээ татан буудаллаж галын түүдгийг дүрэлзүүлж байлаа.

Мухаммед султан маргааш өглөө нь босоод үзсэнд, үхдэлээр дүүрсэн хоосон талбай л үлдэж, Монголчуудын бараа сүүдэр нь ч үгүй болжээ. Харин монгол цэрэг урьд шөнө нь баахан гал шатааж, хуурмагаар буудаллах байдал гаргаад, ачаа хөсөг, шархтан өвчтөнөө авч, ойр орчмоос булаан авчирсан адуу малаа хөөн, хөтөлгөө морьдоо унан байлдааны талбайгаас түргэн ухарч, хэдийн нэгэн өдрийн аяны зам явсан байжээ. Ингээд Мухаммед Султан хан ч монгол цэргийг цаашид нэхэхээсээ болгоомжилж, “ялсан” цэргийн янзаар Самарканд хотдоо буцсан байна. Энэ үед Султан ханы өнөөх айхавтар омог сүр нь дарагдсан бөгөөд “Ийм эрэлхэг, ийм самбаалаг байлддаг цэргийг өдий болтол би ер олж үзээгүй” гэж ноёд түшмэддээ хэлсэн гэлээ. Тиймээс тэр ч нэлээд хичээмтгий болж, Чингис хаанд хянамгайгаар хандахгүй болохгүй гэж, нэгэнтээгүүр цэргээ төвлөрүүлэн, нөгөөтэйгүүр тагнуул туршуул илгээж монгол цэргийн байдлыг ойлгохоор оролдов.

Монгол хошууч цэрэг анх удаа Хорезмын Султан ханы цэрэгтэй тулалдсан байдлыг бид Березиний тэмдэглэлээр гол болгож тэмдэглэв. Гэтэл Ли Цзэ Фэнь авгайн зохиосон “Чингис хааны шинэ намтар”-т: 1218 оны хавар, Сыр-Дарья мөрний доод урсгал хавь дахь Ханлины нутагт Жочи-гийн цэрэг хүрсэнийг Хорезмын Мухаммед Султан хан сонсоод, өөрөө хэдэн түмэн цэрэг дайчлан очиж байлдаж гэж тэмдэглэж буй. Байлдааны өнгөрөлтийг тэмдэглэсэн нь Березиний тэмдэглэл лүгээ бараг адил байна. Гэвч би хувьдаа үзэхэд энэ явдал арай бодот байдалтай нийцэхгүй мэт. Тэр үед Мэргидийн үлдэгдлийг устгахаар Чүй мөрөн орчим хүрсэн цэрэг бол Сүбээдэйн удирдсан төмөр тэрэгт цэрэг болно. Жочи-гийн цэрэг бол Зэв (Хар Хятаныг дайлах үед), Сүбээдэйн ард алсын түшиг болж Монголын баруун зах орчмоор байсан юм. Тиймээс Султан хан Жочи-тай байлдах бололцоогүй мэт. Нөгөө талаар хэлбэл, Мухаммед тэр үед баруунш Багдадыг дайлж дийлэгдэж, цэрэг морио хохируулаад ирсэн лүгээ тохиолдсон бөгөөд хэрвээ умарш Ханлин хүрч байлдвал бас хэдэн зуун км-ын хол замыг туулах ёстой. Тиймээс тэр үед түүнд ийм бололцоогүй мэт. Харин 1219 оны хавар Зэвийн хошууч цэрэг гэнэт Фергана-д цөмрөн орсон байдал доор, Мухаммед өөрөө хөдөлж байлдсан нь зүйтэй хэрэг юм. Учир нь,

Нэгд, Фергана бол Хорезмын төв Самаркандаас дэмий холгүй тул дайсан цэрэг энд нэвтрэн орох нь тэдэнд маш их сүрдүүлэл болох ёстой.

Хоёрт, Зэвийн цэрэг дэмий олонгүй гэдгийг Мухаммед лав тодорхой мэдээ авсан болохоор ялах баталгаатай гэж үзэж байсан нь магад юм. Ингээд би Березиний тэмдэглэлийг баримтлав.

Энэ үед Хорезм улс нь дөчин түмэн их цэрэгтэй бөгөөд хурц давшингуй зэвсэг, элбэг баялаг эд гаралт, өргөн уудам нутаг дэвсгэртэй том их улс байсан боловч, энэ улсын дотоодохи үндэстний харьцаа будлиантай, дээр доороо хүмүүсийн сэтгэл нэгдэхгүй мөртөө Мухаммед султан бол нэгэн ганцаар эзэрхэгч хөдхи мунхаг ноёрхогч байсан тул дотоод бэхжил нь

чангагүй, дайчин хүчин нь маш буурай байсан юм. Тиймээс бүх хүчээ төвлөрүүлж, харийн халдлагыг эсэргүүцэж чадахгүй байв.

Энэ бол Монголын их цэргийн хошууч - Зэв, Сүбээдэй нарын нэгэн бүлэг цэрэг юуны урьд зам нээсэн байдал болно.

1219 оны зун, Чингис хаан Эрчис мөрний хөвөөнд зусаж, нэг талаар бүх цэргээ цуглаан цэгцэлж, морь унаагаа таргалуулсан бөгөөд нөгөө талаар Мухаммед султанд элч томилж, худалдаачид ба элчийг алсан өсийг өслөхийн тулд цэрэглэн дайлахаа мэдэгдсэн байна.

1219 оны зуны сүүлч буюу намрын эхээр, Чингис хаан хорин түмэн их цэргээ дайчилж, Эрчис мөрний хөвөөнөөс мордож, нэгэн зам шууд хориглолгүйгээр явж, Сыхун мөрний дэргэдэх Отрар хотын хаяаг даран буужээ.

Энэ удаагийн нүгэлт дайны уршгийг чирсэн Отрар хотын сэргийлэгч жанжин Иналчук Гайир хан гэгч байлдааны аливаа бэлтгэлээ хийж дуусаад, “Өөрөө хотын хэрэм дээрээ гарч алсыг бараалаад, бодлого санаанд нь байсангүй үзэгдэлд сүрдэгдэн гайхаж, өөрийн эрхгүй гарын араа хэмлэн зогсжээ. Учир нь, тоо томшгүй хүчит цэргийн сүрт жагсаал, догшин давалгаан шиг хотын дүүрэгт нь зай завсаргүй дүүрч, хурдан морины төвөргөөн ба янцгаах дуу, хуягт цэргийн хашгиралцах цуурай нь тэнгэр тулам донсолж байжээ” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”).

Чингис хааны Дундад Азид цэрэглэсэн энэ удаагийн дайныг ерөнхийд нь гурван их дайралдаанаар хувааж болох юм. Нэгдүгээр их дайралдаан нь Мухаммед султаны гол хүчийг устгасан “Хэ Чжун⁹ орны дайралдаан” болно. Хоёрдугаар их дайралдаан нь Мухаммедын хөвгүүн Джалал-ад-Дин султан лугаа байлдсан “Шин мөрний¹⁰ дайралдаан” буюу өмнөд орны дайралдаан болно. Энэ хоёр удаагийн их дайралдааныг бүр Чингис хааны шууд жолоодлогоор хийжээ. Гуравдугаар их дайралдаан нь Мухаммед султаны үлдэгдлийг нэхэж, Оросын холбоот цэрэгтэй хийсэн “Каспийн тэнгис орчмын дайралдаан” буюу умард орны дайралдаан болно. Энэ их дайралдааныг бол Чингис хааны хошууч жанжин Зэв, Сүбээдэйн жолоодлогоор хийжээ. Энэ гурван их дайралдааныг зарим тэмдэглэл, тухайлбал Владимирцовын номонд “Туркестан, Афганистан ба Персийн дайралдаан” гэж нэрлэдэг байна. Энэ бол сүүлчийн үеийн нэрийдлээр нь нэрлэсэн явдал болно.

Монголын их цэрэг юуны урьд Сыхун мөрний зүүн эрэг дэх Отрар хотыг бүслэн аваад, Чингис хаан бүх цэргээ дөрөв хувааж, “Хэ Чжун орны дайралдаан”-ыг дөрвөн замаар зэрэгт нь хийжээ. Нэгдүгээр замын цэргийг Чагаадай, Өгөөдэйгээр захируулан, Отрар хотод үлдээн байлдуулав. Хоёрдугаар замын цэргийг Жочи-гоор захируулан, бүх фронтын баруун гараар баруун хойш Дженд, Барчигкент, Янджикент зэрэг Сыхун мөрний адаг дахи хот балгасуудыг довглуулжээ. Гуравдугаар замын цэрэг нь Нүцгэн Багарины Алаг, Хонхотаны Сүйхэтү чэрби болон Сүлдүсийн Тахай гурваар захируулсан таван мянган цэрэг болно. Эднийг зүүн өмнөш Фенакет (Зөвлөлтийн өмнөд Казакстан чжоу-гийн Илчи хот орчим, Сыр-Дарья мөрний зүүн эрэгт байжээ), Ходженд зэрэг хот балгасыг эзлүүлэхээр томилжээ. Дөрөвдүгээр замын цэрэг - гол хүчний цэргээ Чингис хаан өөрөө захирч, Хэ Чжун орны төв, мөн ч Хорезм улсын төв Самарканд, Ургенч шинэ хуучин хоёр нийслэлийн харилцааны боомт бологч Бухара хот өөд шууд довтолжээ. Чингис хааны захад хөвгүүнээс нь Тулуй дагалдан явж байв.

Отрар хотыг эзэлсэн байлдаан

Чагаадай, Өгөөдэй нарын жолоодсон нэгдүгээр замын цэргийн анх байлдаан бол Отрар хотыг эзэлсэн байлдаан болно. Хэн бүхний мэдэж байх ёсоор, энэ хотын сэргийлэн сахигч жанжин бол Монголын худалдаачны бригадыг хядаж, энэ удаагийн нүгэлт дайны уршгийг чирсэн түрүү ялтан Иналчук Гайир хан гэгч билээ. Тэр бол Мухаммед султаны эх хатан Теркений угсааны язгууртан болохоор Хорезмд их л эрх сүртэй ноёрхогч байсан юм. Ингээд түүний эзэмшиж байсан цэрэг морь ч олон бөгөөд хүчирхэг байсан билээ. Энэ үед - Монголын цэрэг ирж халдах үед Мухаммед Султан хан түүний бэлтгэл хүчнээсээ таван түмэн цэрэг нэмж өгснөөс гадна Карача, Хас-Хаджиб гэгчээр түмэн цэрэг дайчлуулж, Иналчук-ийг туслахаар илгээжээ.

Бас Отрар хотын цайз бэхлэлт ба хотын хэрэм зэрэг нь маш бэхлэг үйлдсэн байв. Тиймээс Иналчук-ийн сэргийлэх хүч нь маш хүчирхэг байсан билээ. Тэр энэхүү давуулаг хүчээ түшиж, бүхэл таван сар эсэргүүцэн байлджээ. Монгол цэрэг ч тасралгүй байлдаж, алхам алхмаар шахамдуулж байсан тул Отрар хотын хүмүүс зориг мохож, туслах цэргийн түрүү Карача, Хас монгол цэрэгт бууж өгөх дурдлагыг тавьжээ. Гэвч Иналчук юу болсон ч худалдаачныг алсан ялаас мултарч, амьд гарч чадахгүйгээ мэдэж байх тул үхэвч үл буун өгч, эзэндээ шударгыг гүйцэтгэнэ гэж хариулсан гэлээ. Ингээд энэ Карача, Хас шөнийн харанхуй болохыг хүлээлцэж байгаад, өөрийн олонхи цэрэг морио авч, Отрар хотын Суфи-хана гэгч хаалгаар шувтлан гарч дутаан зугтаасан боловч монгол цэргийн гараас мултарч чадсангүй амьдаар баригдаж, Чагаадай, Өгөөдэй хоёрын захад хүргэгджээ. Карача, Хас амьд гарахыг бодож, Чингис хаанд хүчээ өргөө гэж амалдсан (ам алдан тангарагласан - хө.) гэлээ. Гэтэл Чагаадай, Өгөөдэй хоёр хот доторхи байдлыг нь асууж мэдээд:

Танай эзэн чинь та нарт өршөөл хишгийг хүргэж, та нарыг үнэхээр шударга байтугай гэж захиж байсан атал, чи одоо өөрийн эзэндээ үнэнч шударгаа гүйцэтгэсэнгүй байгаад бидэнд хүчээ өргөнө гэдэг чинь шал дэмий хэрэг гэж хэлээд харьяатынхи нь хамт аллаа гэдэг билээ.

Монгол цэрэг ч мөн Суфи-хана хаалгаар шувтлан орж Отрар хотыг эзлэн авчээ. Гэвч Иналчук хоёр түмэн байлдамгай цэргээ авч дотоод бэхлэлтдээ орж, бас сар шахам шургуу байлдаж, монгол цэрэгт хүнд хохирлыг учруулсан байна. Тэр сүүлдээ хоёрхон хүн үлдсэн боловч мөн баригдан баригдталаа тоосго чулуугаар байдаж байжээ. Эцэстээ монгол цэргийн олзлогсод болж, хүнд гав дөнгийг зүүлгэж, Самарканд орчим байсан Чингис хааны хуаранд хүргэгдэж, хатуу эрүүгийн хариугаар худалдаачны амин төлөөс болжээ. Үүнээр ч зогссонгүй, монгол цэрэг Отрар хотыг нь үнэсэн товрог болтол эвдэж, тэдгээр сэлмийн ир доор амьтай үлдсэн суугуул ард ба урчуудыг нь барьж аван цэрэгтээ үйлчлүүлсэн буюу урлалын ажлыг нь хийлгэжээ. Иналчук ба Отрар хотын хувь заяаг ингэж дуусгаад, монгол цэрэг ч өөр фронт өөд шилжжээ. Энэ үед нэгэнтээ 1220 оны хаврын хагас болсон байв.

Сыхун мөрний хөвөөгөөрх дайралт

Дундад Азийн их мөрний нэг нь болсон Сыхун мөрний сав газар бол аж ахуй хөгжсөн Хорезмын зүүн хойдохи чухал орон болно. Юуны урьд энэ орныг эзлэн авах нь байлдах бодлогын чухал ач холбогдолтой юм. Ингээд Монголын гурван замын их цэрэг урьдаар энэ оронд төвлөрөн байлджээ.

Жочи-гийн захирсан хоёрдугаар замын цэрэг, түүний гол харалт Дженд, Енджикент өөд довглохдоо, юуны урьд Сыхун мөрний хөвөөн дэх Сыгнак, Узкент, Барчигкент, Ашнас зэрэг хотыг дараа дараагаар дайран эзэлж, 1220 оны хаврын сүүлчээр¹¹ Дженд хотод шахан хүрэхэд хотыг сахиж байсан Хутулуг хаан гэгч их цэргээ авч шөнө дүлээр Сыхун мөрнийг гэтлэн Ургенч хот өөд дутаажээ. Жочи Чинтөмөр гэгч элчийг томилж, Джендийн суугуул ардыг бууж өг гэж хэлүүлсэн гэлээ. Гэтэл энэ хот нь нэгэнтээ эзэн захирагчгүй байсан тул ард иргэд нь самуурч, Чинтөмөрийг хүрмэгц нэн ч үймэлдэн, алахыг завдав. Чинтөмөр энэхүү живтрэгийг олж мэдмэгц, уран самбаалаг үгээрээ Сыгнакт гарсан явдлыг танилцуулж, үймээнийг дарж авсан бөгөөд харь цэргийг Джендэд оруулахгүй гэж илэрхийлсэн тул суугуул ардууд түүнийг хорлохыг болив. Дараа нь монгол цэрэг шат тавин хот өөд нь ороход суугуул ард нь эсэргүүцсэнгүй тул, тэднийг хотоос нь хөөн гаргаж, хотыг нь есөн хоног талхисан боловч, суугуул ардын амийг нь хэлтрүүлсэн байна. Ингээд Жочи эртнээс Монголд үйлчилж байсан нэгэн сартуул хүн Али-Ходжа-г тэндэхийн даргачаар томилж захируулаад, өөрөө Енджикент хотыг эзлэн авав. Енджикент хот бол Арлын тэнгисээс ойролцоо, Ургенч хотоос хоёр өдрийн зайтай, Сыхун мөрний адаг дахи (голын өмнөд эрэгт буй) нэгэн хот болно. “Енджикент” гэдэг нь “Шинэ хот” гэсэн утгатай түрэг үг юм. Үүний дараа Жочи, эцэг хааныхаа зарлигаар Туркмений малчидаас түмэн цэрэг элсэж, Тайнул ноёноор захируулж, Ургенч хотын байлдаанд туслахаар илгээгээд, өөрийн Кара-кум өөд довтолжээ. Гэтэл эдгээр туркмен хүмүүс нь хэдэн өдөр яваад, Тайнул ноёны ард нь урвалга гаргасан тул Тайнул буцаж ирээд их хагасыг нь сөнөөж, үлдсэн хэсэг нь Мерв, Амуя хот өөд дутаажээ. Ингээд дэмий удсангүй, Сыхун мөрний адаг хүртэл бүр монгол цэрэг эзлэв.

Баржуг Арт Тигиний удирдсан Уйгурын түмэн морьт цэрэг нь Жочи-гийн харьяанд байлдаж байжээ. Жочи-гийн цэрэг Енджикент-ийг эзлэн авсны дараа, “Уйгурын түмэн морьт цэрэг хааны зарлигаар улстаа буцжээ. Тэд монгол цэргийн ар талын зам харилцааны шугамыг хамгаалахаар явсан бололтой” (“Чингис хааны шинэ намтар”).

Алаг, Сүйхэтү, Тахай нарын захирсан нөгөө нэгэн замын таван мянган морьт цэрэг Сыхун мөрний эх өөд довтолж, юуны урьд Фенакет хотод хүрэв. Тэндэхийн сэргийлэгч жанжин Илэтхү Мэлиг гэгч түрэг, Ханлин цэргээрээ гурван өдөр тасраагүй байлдуулж, дөрөвдүгээр өдөр дээрээ сая бууж өгөхөөр гуйчилжээ. Монголчууд тэднийг цэрэг ардаар нь ялгаж тус тус ангилсан бөгөд цэргийг нь бүр устгаж, ардынхи нь мэргэжилтэй хүмүүст зохих ажлыг хуваан өгч, бусад залуучуудыг нь цэргийн албанд элсжээ. Дараа нь монгол цэрэг Ходжент хотод хүрэв. Энэ хотын сахигч бол Исламын түүхэнд алдартай баатар жанжин Төмөр Мэлиг гэгч болно. Тэр Сыхун мөрний нэгэн арал дээр өндөр цайз байгуулж, мянган нэр байлдамгай цэргээр сахиулж байв. Энэхүү цайз нь голын хоёр эргээс хол доор байсан тул сум, чулууны харвалт ер хүрэхгүй байлаа. Алаг нарын цэрэг Отрар зэрэг газраас түмэн монгол цэрэг, таван түмэн нутгийн хүмүүсийн тусламжийг олж, эдгээр нутгийн хүмүүсийг арав, зуугаар ангилан, монгол ноёдын захирлагаар гурван газрын холоос чулуу зөөн голыг бөглөн эхлэв. Энэ үед Төмөр мэлиг бас арван хоёр битүүлсэн онгоц (гадуур нь нойтон эсгийгээр бүтээж, түүний дээр нь хүчлэгээр зуурсан шавар шивэн, галаас сэргийлжээ)-ыг үйлдэн, өдөр бүр зургаан онгоцыг томилон монгол цэрэг өөд дайралт хийдэг байв. Гэвч өдрийн удаанд Төмөр Мэлиг тэсвэрлэж чадсангүй арга мухардаж, нэгэн шөнө цэргээ талан онгоцонд суулгаж, голын урсгал уруу дутаажээ. Монгол цэрэг Фенакет хот орчим голыг төмөр гинжээр хөндлөн хааж байсан боловч гинжийг нь таслан цааш явав. Энэ үе нэхэх цэрэг голын хоёр хөвөөгөөр дүүрч

байсан бөгөөд Жочи Дженд хотын орчим Сыхун мөрний хавцал эрэгт хүнд хориглолыг бэлтгэж байна гэснийг Төмөр Мэлиг сонсч, онгоцоо төвлөрүүлэн усан замыг тасалж, өөрсдөө морь унан хуурайгаар дутаав. Ингээд нэхэж байсан монгол цэрэгтэй тулгарч байлдлаа. Урьдаар ачаа хөсгөө баахан хол явуулаад цэрэг нь хойноос нь явдаг байна. Энэ мэт өдөр болоход, цөөн цэрэг нь улмаар цөөрч, арга бус ачаа хөсгөө орхиод явав. Дэмий удсангүй цэрэг морь нь хохирч, ганц бие болоод дутаав. Гурван монгол цэрэг түүнийг салалгүй нэхэж байв. Энэ үед Төмөр Мэлигийн биед гурван сум үлдээд байсан тул, нэг сумаа авч ойр нэгэн цэргийг харван унагаж, нөгөө хоёрт нь: “Та хоёр хурдан буц, надад бас хоёр сум байна, эс буцваас та хоёрыг бас нэг нэгээр чинь ална” гэж хэлэв. Тэр хоёр цэрэг ч үнэхээр буцаад явж гэнэ. Ингээд Төмөр Мэлиг урьдаар Ургенч хотод хүрч, дараа нь Джалал-ад-Дин-ийг түшихээр явжээ. Монгол цэрэг Ходженд хотыг эзлэн авахад ийм нэгэн үлгэртэй гэж өрнө дахины тэмдэглэлүүдэд маш нарийн дүрслэгээр тэмдэглэж байдаг билээ.

Ходженд хотоос Енджикент хүртэлх Сыхун мөрөн дагуу бүх орон нь одоогоор бүр Монголын гарт орсноос анх удаагийн их дайралдааны шийдвэрлэгч амжилтыг олжээ.

Чингис хааны өөрөө захирсан гол их цэрэг Бухара, Самаркандыг дайлах замд, 1219 оны өвлийн нэгэн үүрээр гэнэт Зернук хотыг нөмрөн буужээ. Түмэн агтын төвөргөөн аянга мэт нижигнэн, тоос шороо гэгээн цагаан өдрийг харанхуй шөнө мэт болгож, хотын дөрвөн дүүрэг нь зэр зэвсгээр дүүрэв. Зернук хотын суугуул ард энэхүү байдлыг олж үзээд туйлын ихээр айн эмээж, бэхлэлт цайздаа орж, үүд хаалгаа чанга хаан, хувь заяагаа хүлээн суужээ. Энэ үед Чингис хаан Данишманд Хаджиб гэгчийг элчээр томилж, суугуул ардыг битгий аюулт замаар яв гэж цээрлүүлжээ. Гэтэл нэг хэдэн “чөтгөр сүнсэн” амьтад Хаджибыг хорлохоор оролдов. Энэ үед Хаджиб их дуунаар: Би бол Мусульман (Исламын шашинтан гэсэн утгатай үг) болохоор барахгүй, бас ч Мусульманы хөвгүүн, эзэн тэнгэрт өршөөгдөхийн тулд, өдгөө Чингис хааны зарлигаар, та нарыг мөхлийн далай, цусан голоос аврахаар энд элчлэн ирсэн билээ. Чингис хаан биеэрээ хэдэн мянган байлдагчийг дагуулан ирээд байна.... Та нар хэрвээ бага л эсэргүүцдэг бол нүд ирмэхийн зуур хот балгас чинь үнсэн товрог болж, хээр талыг цусан далай болгох болно. Хэрвээ та нар үнэхээр ятгалыг болгоомжлон сонсдог бол та нарын амь нас, эд хөрөнгө чинь эснүүн (бүрэн бүтэн - хө.) баталгаатай (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, нэгдүгээр боть, 16 дугаар бүлэг) гэж уриалжээ. Суугуул ард нь сэтгэл уярч, “ятгалыг сонсох нь ашигтай гэж үзээд”, Зернук хотын түрүү нар элч томилон, Чингис хаанд бэлэг сэлт хүргэв. Элч нар Чингис хааны цэргийн хуаранд хүрэхэд, тэдний түрүү яагаад ирдэггүй буй гэж хаан хилинлэж, бас элч томилон дуудуулав. Тэдгээр түрүү нар чичрэн дагжиж, тэр даруй ирж, Чингис хаанд баригджээ. Энэ үед Чингис хаан зөөлөн үг, өршөөлийн царайгаар тэднийг тайтгаруулж, үхэх ялаас хэлтрүүлэв. Дараа нь хотын ардыг гарган ирж, идэрчүүдийг нь цэрэгтээ татварлаж, Бухара-ын байлдаанд оролцуулахаар бэлтгэсэн бөгөөд бусад ардыг нь гэр гэрт нь буцаав. Ингээд Зернук хотын ард хотоо “Хутулуг балаг” (“Буянт хот” гэсэн утгатай) гэж нэрлэв гэдэг билээ.

Дараа нь Чингис хааны их цэрэг Бухара хотод хрэх хоёрдугаар харалт - Нур хот (Зөвлөлтийн Узбекистаны Нурата хот) өөд замнаж зам сайн мэддэг нэгэн туркмен замчаар замчлуулж, хүн амьтан бараг явдаггүй бартаат замаар явсан учраас энэ замыг хожим нь “хааны зам” гэж нэрлэх болов гэж Персийн түүхч Джувейни тэмдэглэсэн байв.

Чингис хааны хошууч Хонхотаны Дайр баатарын цэрэг Нур хотод шахан хүрээд элч томилон, дэлхийг дайлан дагуулагч хаан биеэрээ морилон буув. Суугуул ард эсэргүүцэлгүйгээр бууж өгөх хэрэгтэй гэж зарлиг өгөв. Гэтэл дэлхийг дайлан дагуулагч Чингис хаан биеэрээ хүрч ирлээ гэдгийг суугуул ардууд арай л итгэхгүй байсан бөгөөд нөгөө талаар Султан ханаас бас айж байсан тул тэд яахаа ч олохгүй байв. Эцэстээ элч нар олон дахин очсон тул Нур хотын ард амуу хүнс өргөж бууж өгөхөөр тогтов. Дайр баатар зөвшөөрч, өргөл бэлгээс тун багаханыг авч, элчдийг Чингис хааны захад хүргүүлж, өөрөө үргэлжлэн урагшлав. Чингис хаан бас тус хотыг хошууч цэргийн өрлөг Сүбээдэй баатарт тушаан өгч, өөрөө цаашид явжээ. Сүбээдэй баатар ч эндээс зохих тооны алба татвар аваад, хотын ардыг огт хорлосонгүй тул “Нур хотод хөгжил бадралын туяа дахин сацарчээ”.

Бухара-ыг дайлсан нь

1220 оны 3 сард, Чингис хааны их цэрэг Бухара хотын үүдэн гадаа нь хүрч буулаа. “Бухара” гэдэг үг бол Зороастрын шашин (гал шүтэгчид)-ыхны хэлэнд “Эрдэм шинжилгээний төв” гэсэн утгатай үг гэлээ. Тиймээс Бухара хот бол эрт урьдаасаа эл шашны их эрдэмтдийн цуглардаг газар болсон бөгөөд дорнодын мужийн орнуудадад тэр нь Исламын тоорцогийн оройт дуган бүхий энх тайвны хот болж байсан билээ. “Чингис хааны цэрэг нь тоо томшгүй шоргоолж, нүүдлийн царцаахай шиг олон бөгөөд нэг бүлэг нь нэг бүлгээ залгалдсан, их далайн давалгаан мэт хойно хойноосоо ирж, хотыг тойрон бууж, сүрхий ширүүн дайралт хэдэн өдөр үргэлжлэв”. Энэ үед Бухара хотыг хэдийгээр Султан ханы бэлтгэл цэрэг хоёр түмэн хүн сахиж байсан боловч, командлагчид нь хүч мөхөстөж, шөнө дөлөөр бүх цэргээ авч дутаав. Энэ явцад монгол цэрэг нь дутааж бүхий цэрэгт санамсаргүй дайрагдаж, яаруу сандруугаар ухарсан байна. Гэтэл Султан ханы командлагчид нь монгол цэргийг нэхэн байлдсангүй, харин өөрсдөө цаашид буруулан дутаажээ. Ингээд монгол цэрэг өөрийн эгнээгээ дахин эмхэтгэн засаж, Охус мөрөн (Аму-Дарья мөрөн)-ий хөвөөнөө нэхэж эчээд бүх цэргийг нь сөнөөсөн байна. Дараа өглөө нар цухуйж байх үед, Бухара-ын хүмүүс хотын үүдээ дардайтал нээж, эсэргүүцэл тулалдааны хаалгаа таг дарав. Тэдний төлөөлөгчид гарч ирээд Чингис хааныг угтан оруулж, хот балгас, зээл гудамжаа сонирхуулав. Чингис хаан морь довтолгон орж, Мусульманчуудын ёслолын дуган Махсура гэгчийн өмнө эчиж жолоо татан зогсоод, “энэ чинь султаны харш уу?” гэж асуусанд, энэ бол эзэн “тэнгэрийн ордон” гэж тэнд байлцсан хүмүүсээс хариулжээ.

Энэ үед Чингис хаан мориноосоо бууж, тахилын индэрийн шатыг хоёр гурав дээш давж:

“Хөдөө тосгонд өвс буртгаргүй билээ, одоо морио тэжээн цагтах хэрэгтэй” гэж хэллээ. Ингээд тэд хот доторхи амуу үрийн бүх хөмөргийг нь нэхэж, амуу будааг нь зөөлцөв. Тэд коран судрын хайрцгийг авчран онгоц болгож морьдоо тэжээлээ гэж Джувейни-гийн тэмдэглэсэн нь үнэн байдалтай нийцэхгүй юм. Чингис хаан эл шашинд ерөөс зөв ханддаг юм. Монгол цэргүүд энд хоёр цаг шахам архи ууж, дуу дуулалдан наргилдсаны хойно, Чингис хаан хотоос гарч, Бухара-ын хүмүүсийн хурал цуглаан хийдэг Мусалла гэгч талбайд хүрч ирэв. Дараа нь суугуул ардууд цугларан ирцгээлээ. Тэдний дотор хэн нь баян хүмүүс буй гэж хаан асуусанд, нийт хоёр зуу наян хүн (үүний дотор зуун ер нь тус хотын хүмүүс, бусад нь гаднахи хүмүүс, тухайлбал эл газраас ирсэн худалдаачид байжээ)-ийг дурдан гаргаж, хаанд бараадуулав. Чингис хаан яриа тавин эхэллээ. Тэр яриандаа, султан хааны өдөөлгө ба арга бус

байдал доор цэрэг хэрэглэсэн учрыг тодорхойлж дуусаад: Сонсогчид оо, та нар их ял хийснээ мэдэх хэрэгтэй, ялангуяа танай доторхи эрхэт их хүмүүс эдгээр ялыг хийсэн юм. Энэ үг чинь ямар баримттай вэ? гэж та нар надаас асуувал, энэ бол дээд тэнгэрийн бошиг гэж би хариулсугай! Та нар хэрвээ энэ их ялыг үйлдсэнгүй бол, дээд тэнгэр надаар шийтгүүлэхээр таны дээр буулгахгүй билээ гэж яриагаа дуусгахын хамт: Танай ил байгаа эд агуурсыг хэлэхийн хэрэггүй, булж далдласан юмаа л надад хэлж өгөх хэрэгтэй гэжээ. Дараа нь тэдний гэрийн хамаарагчдыг дуудаж гаргаад, цэрэг байлдагчдаар тэднийг үл доромжлуулахын тулд, хүн нэг бүрт нэгэн монгол хүн буюу түрэг хүнийг томилон даргалуулав. Монголчууд хэдийгээр тэдний зоос мөнгийг нь хурааж авсан боловч, тэднийг ичээж гутаасангүй бөгөөд зоос мөнгөө гарган өгөгсдийг ер эрүүдэж зовоосонгүй, бас үнэнхүү тушаах чадалгүй хүмүүсийг албадан тушаалгасангүй байв. Энэ үед өөр нэгэн санамсаргүй явдал тохиолдов – Султан хааны цэрэг Бухара хотоос дутаан гарах үед, дөрвөн зуун морьт цэрэг гарч чадсангүй үлдэж, тэд дотор цайздаа ухран ороод үхэн эсэргүүцэж байв. Монгол цэрэг дотор цайз өөд довтоллоо, бас суугуул ардын дотроос идэр чийрэг эрсийг нь сонгож, дотор цайзын сувгийг бөглүүлж, дараа нь үхэр буугаар буудав. Арван хоёр өдөр ширүүн тулалдаад цайзыг бас эзэлж чадсангүй бөгөөд монгол цэрэг ба суугуул ард цөөн бус үрэгджээ. Дотор цайзын дайсан ч тэдний амь насныхаа төлөө үхэн байлдаж байсан бөгөөд шөнө бол дайралт хийж байв. Ийм байдал доор, Чингис хаан зарлиг буулгаж, бүх хотын тойрогт гал тавиулжээ. Хотын олонхи гэр байшин нь модоор үйлдсэн тул хэдхэн өдрийн дотор ихэнх нь бүр үнэсэн товрог болов¹². Зөвхөн тоосго чулуугаар барьсан Исламын сүм дуган ба хэдэн ордон харш л үлдээд байв. Дараа нь, бас хэдэн өдрийн ширүүн байлдаан болж, тэдгээр эсэргүүцэгчдийг үхлийн далайд живүүлжээ. Дотор цайзад үхэгсэд нь нийт гурван түмэн хүн байв гэж Джувейни тэмдэглэж байлаа. Гэтэл энэ тухай Д`Оссон: Гурван түмэн гэдэг нь үнэн байдлаас хэтэрчихсэн тоо байж мэднэ, тиймээс би тухайн үеийн хүн, бүрэн түүхийн зохиогчийн хэллэгийг баримтлав (“Д`Оссоны монголын түүх”, нэгдүгээр боть, долдугаар бүлэг) гэж тэмдэглэв. Хотын ба дотор цайзын эсэргүүцэл нь устгагдсан бөгөөд хотын хэрэм болон гадар бэхлэлт нь тэгш талын адил балбачигджээ. Энэ үед суугуул ардыг эр эм хөгшин залуу гэсэнгүй цөмийг Мусалла талбайд аваачиж, Чингис хаан тэднийг үхлээс хэлтрүүлэв. Гэвч цэрэгт татваас зохих насны идэр залуучуудыг цэрэгт албадан татаж, Самарканд ба Дабусия-гийн фронт өөд авч явжээ. Чингис хаан ч Самарканд өөд дайллаа.

Самаркандын хувь заяа

Самарканд хот бол Бухарааас зүүн өмнөш таван өдрийн газар байдаг. Тэр нь султан ханы эл чжоу-гийн дотор хамгийн их, хамгийн баялаг нэг хот болох юм. Үзэсгэлэнт сайхан Согд гол (одоогийн Зеравашан гол)-ын сав газарт байгуулагдсан энэ хотыг хүний ертөнц дэх “Диваажингийн орон” гэгцгээдэг бөгөөд одоо Хорезмын шинэ нийслэл болжээ. Монголын их цэрэг хүрэхээс өмнө Султан хаан арван нэгэн түмэн их цэрэг (үүний дотор зургаан түм нь түрэг цэрэг, таван түм нь таджик – перс цэрэг байсан гэлээ)¹³-ээр сахиулж байсан бөгөөд хотын дөрвөн талаараа гадар бэхлэлт бүхий хориглолтын шугамыг засаж, хотын хэрмээ Гиртиг одтой тэгш шугам болтол өндөртгөж, сувгийг нь усан судас болтол гүн малтжээ. Үүнээс гадна бас хүдэр том биетэй, догшин сүрлэг байлдааны заан хорь байв. Самаркандын суугуул ардыг арван түмэн өрх айл байсан гэж Чан-чунь арш тэмдэглэв. Чингис хаан Самарканд өөд урагшилсан зам зуураа бууж өгсөн айл тосгон, хот балгас бүхнийг огт хөндсөнгүй, гагцхүү Дабусия, Сертел цайз эсэргүүцсэн болохоор тэнд цэргийг үлдээж

байлдуулаад, өөрөө сааталгүй түргэн явж 1220 оны 3 сард Самаркандыг бүслэн авав. Жочи, Чагаадай, Өгөөдэй болон Алаг нарын удирдсан бусад гурван замын цэрэг ч Хэ Чжун орны умардахи эл газрыг эзэлж дуусаад, бас Самаркандад ирж, Чингис хааны их цэрэг лүгээ нийлэлдэв. Энэ удаагийн байлдаанд бас эл газраас барьсан олзлогсод ба нутгийн ардыг зохион байгуулж оролцуулжээ. Монголын бүх цэрэг морь бүр ирж, байр байраа эзлэн авсны хойно, Чингис хаан морь унаж, хоёр өдөр хотыг тойрон байдлыг үзээд гуравдугаар өдрөөс нь байлдаан эхэллээ. Анх эхлэхдээ Самаркандын сэргийлэгч Алп-Эр хан, Шейх хан, Бала хан зэрэг түрүү нар нь цэрэг авч хотоос гарч ирээд монгол цэрэгтэй байлджээ. Тэр өдөр Султан хааны цэрэг нь монгол цэрэг өөд ширүүнээр дайрч, монгол цэргийг нэлээд хохируулсан бөгөөд заримыг нь олзолж явжээ. Гэвч тэд бас өөрөө мянган хүн сүйдсэн байлаа. Бамбай барин довтлох монгол цэргийн сэлмийн гялбаа шөнийн харанхуй хөшгийг ярахын дагуу, өвч хуягласан Чингис хаан хурдан хүлэгтээ мордон сүр жавхаатай дайрч байв. Хоёрдугаар уулзалт эхэллээ. “Чөдөр оньс” ба том нумын хөвчийг эрийн чадлаар татан тавихтай зэрэг сум шуугилдан, чулуу нисч байлаа. Монгол цэрэг хотын хаалгыг тойрон байр эзэлж, султан ханы цэрэг дайран гарч ирэхийг хориглож байв. Байлдаан явагдах тутам улам ширүүсч, хоёр этгээдээрээ улам ойртож, морь унан дайрахын аргагүй болжээ. Ингээд Султан хааны цэрэг догшин заанаа тавьж гарган, түүнээрээ бамбай болгон довтоллоо. Гэвч монгол цэрэг огт ухарч дутаасангүй мөртөө өнөөх “сахиулсан сум”-аараа харваж, заанаар довтолж байсан явган цэргийн жагсаалыг нь бусниулжээ. Энэ үед шархдсан заан нь гэдрэгээ дутаан, хүн амьтныг нь дайран гишгэлж бусниулсан тул дайсан өөрийн биедээ шор шаав. Дараа өдөр нь монгол цэрэг улам эрэлхэг баатраар байлдаж, Самаркандын хүмүүсийн сүр сүлд нь буурч, байлдах санаагүй болж, эсэргүүцлээ зогсов. Самаркандын төлөөлөгч хүмүүс нь Чингис хааны хуаранд ирж, хаантай бараадлаа. Тэд, Чингис хааны халамж, зоригжуулал ба бодолгыг олж хотдоо буцан харив. Ингээд Исламын мөргөлчид наманчлалын цаг болохтой зэрэг Самаркандын үүд нээгдэж, Монголчууд хотод орлоо. Тэд хотын хэрэм ба гадар бэхлэлтийг эвдэхэд яаралдсанаас биш суугуул ардыг огт доромжилж халдсангүй байв. Тэд өдөр шөнийг ялгалгүй, галдах нураах ажиллагаагаа үргэлжлүүлж, хотын хэрмийг газартай тэгш болгож, явган морьтой хүн саад тороогүй явж болох болгожээ.

Дараа нь Монголын их цэрэг хотод орж, таван түмэн онцгой хамгааллыг ологсоодоос бус суугуул ардыг зуу зуугаар ангилж, хотоос хөөн гаргаад, хотыг нь талхидан байтал дотор бэхлэлтэд нь нуугдаж байсан Алп-Эр хан тэргүүтэй мянган хүн шувтлан гарч, монгол цэргийн дундуур цусан зам гарган довтолж, Султан хаандаа нийлэн зугтав.

Монгол цэрэг дотор бэхлэлтийг нь хуруу орохын зайгүй бүслэн авч, бас нэгэн удаагийн ширүүн байлдаанаар дамжиж эзлэн авчээ.

Дараа өглөө нь монгол цэрэг, сэлмийн ирээс хэлтрэгсдийг бүртгэн үзэж, гурван түмэн урчуудыг ураг төрөлдөө хуваан өгсөн бөгөөд идэр залуучуудаас нь нэг бүлэг хүмүүсийг цэрэгт татан авч, бусад таван түмэн хүмүүсийг хотод буцаасны хамт тэднээс хорин түмэн динар (dinar гэдэг бол арабын алтан зоосын нэр болно. Мөнгөн зоосыг нь дирхам dirham гэдэг. Нэг динар нь арван хоёр дирхамтай тэнцдэг гэлээ) зоосын татвар авчээ. Мөн эдгээр зоосыг Самаркандын Сихат-Ал-Мүлиг ба Амид-Бүзүрэг гэгч хоёр их ноёнд тушаан өгсөн бөгөөд төрийн гүн Елюй Ахай тайшийг томилж тус хотыг захируулжээ.

Самаркандын хувь заяа ийм л байсан бөгөөд энэ бол 1220 оны 3 сарын 19-ны өдөр 14-ийн хэрэг мөн.

Үүний урьд Чингис хаан Самарканд хотод хүрэхээс өмнө, Хорезм улсын эзэн Мухаммед султан хан Самарканд хотоо орхиод, Термезийн гармаар Аму-Дарьяа мөрнийг гатлан дутаасан байв. Чингис хааны их цэрэг Самарканд хотод хүрмэгц, өрлөг хошууч Зэв, Сүбээдэй, Тогучараар тус тус түмэн цэрэг дайчлуулж, урьд хожид Аму-Дарьяа мөрнийг гатлуулан, султан ханыг нэхүүлэхээр томилжээ.

Бухара, Самарканд ба Сыхун мөрний хөвөө дагуу олон хот чжоунуудыг дайлан дагуулснаас Хэ Чжун орны их дайралдаан шийдвэрлэгч чанартай ялалт олжээ. Одоо гагцхүү Ургенч хот хэц нь тасарсан цацар шиг төв дунд нь үлдэж байв. Чингис хаан Жочи, Чагаадай, Өгөөдэй нараар 15 баруун гарын цэргээ захируулж, 1220 оны 7 сард Ургенч хотыг дайлуулахаар томилжээ.

Самаркандын байлдааны дараа, Чингис хаан биеэрээ Султан ханыг нэхэх зорилгоор их цэргээ авч Хорасан муж (Хорасан бол тухайн үедээ Хорезмын гол орон болж байжээ. Одоогийн Зөвлөлтийн Туркмен улсын өмнөд хэсэг, Иран улсын хойд хэсэг, Афганистаны баруун хойд хэсэг дэхи орон болно)-ын эл газрыг эзлэхээр мордов.

Ургенч хотыг эзэлсэн нь

Ургенч хот 18 бол Хорезм улсын анхны нийслэл хот болох бөгөөд Аму-Дарьяа мөрний адагт мөрнийг сундлан байгуулагдсан том хот байжээ. Ургенч хот чухам хэдий хүн амтай байсныг хэн ч оновчтой хэлэх баримтгүй. Тухайн үеийн түүхч Джувейни хүртэл “Суугуул ардын тоо нь элсээс олон” гэж ойлгохын аргагүй бөөрөнхийлөн дурджээ. Тухайн үед Ургенч хот нь султан ханы эх Теркен хатны төрөл Хумар Тигин гэгчийн захиралд байв.

Жочи, Чагаадай, Өгөөдэй түрүүтэй Монголын баруун гарын таван түмэн их цэрэг, 1220 оны 7, 8 сарын үесээр Самаркандаас мордож, тус оны өвлийн эхээр Ургенчийн байлдаан эхэлжээ. Эхлээд, монгол цэрэг цөөн хүнээр Ургенчийн цэргийг хотоос нь өдөөн гаргаж, их цэргийнхээ бүгэлтэд оруулан, ихээр хохируулж байв. Гэтэл дэмий удсангүй, Жочи, Чагаадай хоёрын хооронд зөрчил гарч, жолоодлого нь нэгдэж чадахгүй мөртөө цэргийн сахилга суларсан байна. Ургенчийн цэрэг ард монгол цэргийн энэхүү зөрчлийг нь ашиглан эрэлхэгээр байлдаж зургаан сар эсэргүүцжээ. Энэ байдлыг Чингис хаанд мэдэгдсэн тул, Чингис хаан Өгөөдэйгээр баруун гарын бүх цэргийг ерөнхийлөн захируулж, цэрэг морио цэгцлэн шинээр дайралт хийснээс 1221 оны 5 сард монгол цэрэг эцэстээ Ургенч хотыг эзлэн авчээ. Монгол цэрэг Ургенч хотыг ихээр цөлбөсний хамт, аллага хядалгыг ихээр хийлээ гэдэг. Джувейни зэрэг Персийн түүхчийн тэмдэглэлийг үндэслэвэл, Тэд нар (монгол цэргийг хэлж буй - эшлэгч) хотын ардыг хотын гадна хөөн аваачиж, арван түм гаруй уран дархчууд ба эмс хүүхдийг нь боол зардас болгохоор олзлон аваад, үлдсэн хүмүүсийг нь цэрэг бүртээ хорин дөрвөн хүн хуваан өгч цөмийг алуулжээ”. Энэ үед монгол цэрэг нь таван түмэн хүн байлаа гэдэг, ийм бол нийт алсан хүний тоо нь зуун хорин түм болно. Энэ тоонд байлдааны дунд үхсэн хүн бас багтсангүй юм. Джувейни-гийн тэмдэглэлийг үндэслэвэл, түрүү удаагийн нэгэлхэн байлдаанд Монголчууд “бараг арван түмэн байлдагчийг элсэн талбай дээр аллаа” гэдэг, ийм нэгэн бодтой тоог түүх шастирт тэмдэглээд үлдээчихсэн болохоор бид ч дурдахгүй

байхын аргагүй. Гэтэл эдгээр тоо чухам аль зэрэг баримттай болох тухай санал шүүмжээ би тусгай нэг бүлэгт ярих болно. Аллага тонооны дараа, монгол цэрэг нь Аму-Дарья мөрний усыг сэтэлж, Ургенч хотыг мөхлийн далайд живүүллээ гэдэг.

Султан хан ба түүний эцэслэл

Ала-үд-Дин Мухаммед бол нийтийн он тооллын 1200 онд Хорезм улсын Султан (хан)-ы орыг залгамжилжээ. Тэр үед Хорезмын нутаг дэвсгэр нь Арал, Каспи хоёр тэнгисийн орчмоор байсан бөгөөд Хэ Чжун-ы хан Османтай адил хар Хятаны харьяат улс байжээ. Нэгэн Исламын шашинтан улс нь Буддын мөргөлтнөөр эзнээ болгох нь гутамшигтай явдал гэж үзээд Мухаммед өөрийн хүчиндээ итгэж, Хар Хятанаас салахыг оролдов. Хэ Чжун орон ба Самарканд ч үүнийг нь дэмжиж, Мухаммедыг эзэн өргөмжилж харьяат нь болжээ. Ийнхүү Мухаммед Хэ Чжун-ы хан Османы дэмжлэгтэйгээр 1208 он – 1209 оны хооронд хар Хятан өөд цэрэглэсэн бөгөөд энэ удаагийн байлдаанд Мухаммед ялагдаж, нэгэн жанжныхаа хамт Хар Хятаны олзлогдогсод болжээ. Тэр жанжин нь Мухаммедыг өөрийн зарц гэж Хятан хүнийг мэхэлж, бас зарцаараа төлөөс мөнгө авахуулах хэмээн буцааснаас Мухаммед султаны амь нь сая мултарчээ. Дараа нь Мухаммед бас түүний харьяат Самаркандын султан лугаа цэрэг холбоолж, 1209 он-1210 оны хооронд хар Хятан өөд дахин нэг удаа цэрэглэсэн бөгөөд энэ удаа Хар Хятаныг ихээр ялсан тул Мухаммедын омог сүр нь ч ихээр бадарч, “хоёрдугаар Александр”¹⁷ гэсэн цолтой боллоо гэдэг билээ. Ингээд тэр нийслэлдээ буцсан хойно, охиноо Хэ Чжун-ы хаан Османд хатан болгон өгч, бас нэгэн Хорезм захирагчаар Самарканд дахи хар Хятаны элчийг орлуулжээ. Энэ нь Хэ Чжун, Самарканд зэрэг орон бол Мухаммедын нутаг дэвсгэр боллоо гэдгийг үзүүлсэн явдал болно. Гэтэл, дэмий удсангүй Мухаммедын хүргэн болсон Осман хан нь тэрхүү Хорезм захирагчийн ноёрхлыг нь хүлээж эс чадан, Мухаммедад харьяат болсон явдалдаа гэмшиж, 1211 онд өнөө Хорезм захирагчаа алаад бас Гүр хан (Хар Хятаны ханыг хэлж буй)-д харьяалагджээ. Энэ чимээг Мухаммед сонсоод ихэд уурлаж, тэр даруй Самаркандыг цэргээр дайлсан байна. Мухаммедын цэрэг Самарканд хотыг эзлэн авч гурван өдөр алан талхидсанаар барахгүй Мухаммед өөрийн хүргэн Османы бүх гэрийг хүйс тэмтрэн алсан бөгөөд Хэ Чжун орныг эзлэн авч, Самаркандад нийслэжээ. Ингээд Самарканд хот нь Хорезмын шинэ нийслэл болсон байна.

Дараа нь Мухаммед султан, ойр хавийн улс угсааг хүчээр эзлэн авсан бөгөөд өөрийн хэдэн хөвгүүндээ хуваан захируулжээ. Мухаммедын хөвгүүддээ хуваан өгсөн газар нутгийн олонхи нь шинэхэн эзлэн авсан орон нутаг болохоор Хорезмд үнэнчээр үйлчлэх явдал тун бэрх байлаа. Хорезм улсын иргэдийн харьцаанд адил зүйл гэвэл зөвхөн шашин суртахуун л байсан юм. Гэтэл, шашны дотроо бас аймаг бүлэг олон байдаг тул нэг л орны Исламчууд ч хэзээд өрсөлдөж байдаг билээ. Ялангуяа эл үндэстэн нь дарлал талхидлыг удаан амссан учраас Мухаммедын байлдагчдын сүрдүүлэл доор толгой бөхийхгүй байжээ (“Д’Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, зургадугаар бүлэг).

Дотооддоо туйлын харгис хэрцгий ноёрхогч Мухаммед султан бол Монголын худалдаачид ба элчийг алан хядаж, их дайны аюулыг Хорезмын ард түмний толгой дээр чирсэн хамгийн гол хэрэгтэн нь болох юм.

Монголын их цэрэг Хэ Чжун оронд цөмрөн орж ирэхэд, Мухаммед султан сүр сүлдээ алдаж, сөс зориг нь хэмхрэв. Эхэндээ бас Самаркандынхаа цайз бэхлэлтийг бэхэлж байсан боловч,

монгол цэргийн гүнзгийрэн орж ирэхийг үзээд, Самаркандаа сахихыг ч больж, арван нэгэн түмэн цэрэгтэйгээ орхиж дутаажээ. Султан хан дутаах тэр өдрөө Самаркандын ард цэрэг хотын сувгаа сэтэлж ус оруулж байсныг үзээд: “Удалгүй маньг довтлох гэж байгаа цэргүүд ташуураа л хийвч энэхүү сувгийг чинь бөглөж чадахгүй юм” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, хоёрдугаар боть, арван нэдүгээр бүлэг) гэж хэлээд Нагшаб (одоогийн Узбекистаны Карш хот) өөд явсан гэлээ. Тэр, замын туршдаа ард иргэдийг дутаан зайлж, нуун далдлах газраа өөрсдөө иртүгэй гэж ятгаж байсан бөгөөд монгол цэргийг эсэргүүцэж болошгүй гэж хэлж байж гэнэ. Эдгээр үгс нь цэрэг ардынхаа зоригийг мохоожээ. Тэр бас Ургенч хот өөд хүн томилж, өөрийн гэр бүлээ тэндээс Мазандеран хот өөд хүргүүлжээ. Энэ үед Мухаммед султаны доорхи шударга жанжин нар ба түүний хөвгүүн Джалал-ад-Дин идэвхтэй арга гарган Хорасан, Иракийг бүх хүчээр хамгаалж, бас эл газрын хүчийг төвлөрүүлэн, Аму-Дарья мөрнөөр хориглолт болгож, монгол цэргийг бүх хүчээр эсэргүүцэх сануулгыг дурджээ. Мухаммед султан эдгээр идэвхтэй сануулгыг нь сонссонгүй мөртөө өөр нэгэн бүлэг дутаагч этгээдийн саналаар Газни өөд дутаажээ. Тэр, энд тогтож эс чадвал цааш Энэтхэг өөд дутаахад амар гэж үзэв. Замдаа тэр Балх хотод буухдаа, монгол цэрэг Бухара, Самаркандыг эзэлсэн мэдээг олж сонсоод, бас тэндээс санд мэнд дутаажээ. Энэ үед түүнийг хамгаалан явж байсан цэрэг нь бүр түрэг хүмүүс байсан бөгөөд ноёд нь бүр Теркен хатны төрөл садан байсан гэлээ. Тэд нар замдаа Мухаммед султаныг алахаар зөвдсөн боловч хэрэг нь задарч, Мухаммед чанга сэргийлэлийн арга авч, 1220 оны 4 сарын 18-д морин давхиагаар Нишапур хотод хүрчээ. Монголын цэрэг Аму-Дарья мөрнийг гаталж чадахгүй гэж бодоод энд баахан тогтмоор байжээ. Гэтэл гурван гарагийн дараа Монголын морьт цэрэг Хорасан өөд орж ирсэн мэдээг олж сонсоод, ав хийх нэрээр цөөн дууны дагалт нараа авч Нишапур хотоос бас дутаажээ.

Энэ үед Мухаммед султаныг нэхээр томилогдсон Монголын цэргийн хошууч жанжин Зэв, Сүбээдэй нарын их цэрэг, Термезийн гармын орчим Пенджаб гэсэн газраар Аму-Дарья онгоц салгүйгээр, эдлэл зэвсгээ үхрийн арьсанд боож үүрээд, моринынхоо сүүлээс барьж гатлан гарчээ. Зэвийн цэрэг Аму-Дарья мөрнийг гатлан гармагц Балх, Нишапур зэрэг Хорасаны харьяат хот балгасыг дайран, Раей хотын дэргэд Сүбээдэй лүгээ нийлэлдэн, хотыг нь сөнөөгөөд, Мухаммед султаныг мөрдөн нэхэж Ирак өөд довтолжээ. Мухаммед султан Иракад дутаан ирэхэд, тус газрыг захирч байсан Мухаммед султаны хөвгүүн Рукнуд-Дин-Хорсайджи гэгч гурван түмэн ирак цэрэг цуглуулан байжээ. Ингээд Мухаммед энд хориглолт хийх санаатай байв. Гэвч монгол цэрэг Раей хотыг эвдсэн чимээг соносмогц хамт явж байсан ноёд язгууртад нь эмээн сүрдэж, амь цөлөн дутаасан бөгөөд дагаж байсан цэрэг нь ч бутран сарнисан гэлээ. Ингээд Мухаммед султан хүүхдийнхээ хамт, Харун цайз өөд дутаажээ. Монгол цэрэг хойноос нь нэхсээр гүйцэж хүрсэн боловч, Мухаммед султан гэж таньсангүй тул морийг нь харваж шархдуулаад барьж чадсангүй явуулжээ.

Үүний дараа дэмий удсангүй, 1220 оны 12 сарын нэгэн өдөр, олон арвин улс угсааг мөхөөж, өргөн уудам газар нутгийг эзлэн байсан Хорезм улсын эзэн Мухаммед султан шургах газаргүй мухардахдаа Каспийн тэнгисийн зүүн өмнө өнцөг дэх Мазандеран хотоос ойролцоо нэгэн бяцхан зэлүүд арал дээр дутаан гарчээ. Мухаммед султан бараг жил шахмын хугацаанд айн эмээж, зовон зүдэж, зугтан дутаасаар байж, цээж хальсны өрөвсөл өвчинд нэрвэгдэж, арал дээр гараад сар болсонгүйгээр 1221 оны 1 сарын 11-ний өдөр үхлээ гэж түүхч тэмдэглэжээ. Тэр үхэхээсээ өмнө, Султан ханы ороо отгон хөвгүүн Озлагшахаар залгамжлуулна гэж уулын

тогтсоноо өөрчилж, хөвгүүн Джалал-ад-Дин Мөнх-Бирди-гээр залгамжлуулахаар шийдэж, өөрийн сэлмээ авч Джалал-ад-Динд зүүлгэлээ гэдэг юм. Тэр өдрөөс хойш Хорезм улсын султан бол Джалал-ад-Дин болжээ.


Одоо Хорезм улсад маш их эрх сүртэй байсан Мухаммед султаны эх Теркен хатан - “Дэлхий ертөнц ба сүсэг шүтлэгийн хамгаалагч орчлонгийн эм хаан” гэгчийн тухай хэдэн үг ч болтугай эцэслэлийг нь тэмдэглэх хэрэгтэй болжээ. Чингис хаан Самарканд хотыг эзлэн авах тэр үесээр Ургенч хотод сууж байсан Теркен хатны захад элч томилон, тэр эх хөвгүүн хоёрын зөрчлийг нь ашиглаж, Теркенийг оруулж авахыг оролджээ. Гэвч Теркен хатан хориглосонгүй бөгөөд дэмий удсангүй бас Мухаммедын хатад, хөвгүүдийг нь дагуулан, хөнгөвтөр эд эрдэнээ авч Мазандераны орчмын уулан дахи ялалгүй нэгэн бэхлэг цайзад орчиж суужээ. Түүний дараа Сүбээдэйн цэрэг хүрч, цайзыг нь хэдэн сар бүслэн байлдаж, эцэстээ Теркен хатан ба султан ба Султан ханы хатад охид нь бүр монгол цэргийн олзлогсод болж, хожим нь монгол газар авч ирсэн гэлээ. 1233 он (Өгөөдэй хааны үе)-д Теркен хатан Монголын нийслэл Хар хорум хотод үхсэн гэдэг билээ.

Чингис хааны шинэ дайлалдаан

Чингис хаан 1220 оны 3 сард Хорезмын шинэ нийслэл Самарканд хотыг эзлэн авсны дараа, өөрөө гол цэргээ захирч Хорасан өөд довглохоос өмнө, Самарканд болон Термезийн хооронд бүхий Нагшабын талд 18 зусаж, 1220 оны зуныг тэнд өнгөрөөж, агт морьдоо таргалуулан, цэргээ амруулсан байна.

Тус оны намар цэрэг мордож, юуны урьд Аму-Дарья мөрний хойд хөвөөн дэх Термез хотыг довтолжээ. Тус хот нь бэхлэг зузаан хэрэм цайзтай бөгөөд шилдэг олон цэрэг зэвсэгтэй байсандаа эрдэж, өдөр шөнөгүй шургуу эсэргүүцсэн тул, арван өдрийн ширүүн байлдааныг өнгөрөөгөөд, монгол цэрэг эцэстээ Термез хотыг эзлэн авч, суугуул ардыг нь үлдээлгүй хядан сөнөөсөн гэлээ.

Тэндээс Чингис хаан Кангарт болон Шуман (энэ бол одоогийн Таджикстаны төв Сталинабад хотын байгаа газар гэж зарим түүхч тайлж байдаг билээ) оронд орж, хоосортол булаагаад, 1220 оны өвөл тэнд өвөлжжээ. Дараа нь Чингис цэргээ хувааж, нэг хэсгийг нь зүүнш томилон Бадахшан орныг дайлан дагуулжээ. Бас нэг хэсэг цэргийг отгон хөвгүүн Тулуйгаар захируулж Аму-Дарья мөрнийг гатлуулан Хорасан эл газрыг довглуулаар томилов. Тулуйн цэрэг Хорасаны хилээр нэвтрэн орж, 1221 оноос 1222 оны эхэн хүртэл дайтжээ. Энэ хугацаанд Тулуйн цэрэг Хорасаны Мерв, Нишапур зэрэг олон хотыг эзэлж, улмаар Афганистанд нэвтрэн оржээ. Мерв хот бол монгол цэргийн хөлд хамгийн их сүйдсэн Дундад Азийн эртний соёлт хотуудын нэг нь байлаа гэдэг.



Зураг – 77. Хорезм улс ба Чингис хаан баруунш дайлсан том зураг

Энэ үед Аму-Дарья мөрний умард орныг бүрмөсөн эзэлж (ганц Ургенч хот л үлдээд бүслэн

байлдаж байв), “Хэ Чжун орны дайралдаан” дуусч, нэгэн шинэ дайралдаан - Джалал-ад-Дин султанаар гол харалт болгосон “Шин мөрний дайралдаан” буюу өмнөд орны дайралдаан эхэлжээ.

1221 оны хавар, Чингис хааны өөрийнх нь захирсан цэрэг Аму-Дарья мөрний олмоор гаталж, шууд Балх хот өөд довтолжээ. Энэхүү баялаг сайхан хотын тэргүүн нар нь бэлэг өргөлөө барьж буун өгсөн боловч, эдгээр газар нь Джалал-ад-Дин султаны самуурч байсан газар болохоор монгол хүний сэжиглэлийг алдрааж чадсангүй, бас л хөгшин залуугүй хэрцгий балмадаар алан хядагдлаа гэдэг билээ.

Дараа нь Чингис хаан Талаханы уулархаг орон өөд довтлов. Тэнд нэгэн Носрат Хо гэдэг нэртэй цайз байжээ. Энэхүү цайзыг бэрх бартааны дунд бэхлэг зузаан барьснаар барахгүй, түүнийг сахиж байсан цэрэг ч тун айхавтар эрэлхэг хүчтэй байв. Чингис хаан элч томилж оруулж авахаар хэдий чармайсан боловч, тэд ер бууж өгсөнгүй мөртөө шургуугаар эсэргүүцэж байв. Хоёр этгээд зургаан сар шахам ширүүнээр байлдаж, эцэстээ Тулуйн цэрэг Хорасаны эл газрыг дайлан авсан хойно, түүний их цэргийг шилжүүлэн авчраад сая энэ цайзыг шийдвэрлэсэн бөгөөд бүтэн барилга, амьд хүн үлдсэнгүй гэдэг.

Чингис хаан Талаханыг шийдвэрлэсэний дараа, 1221 оны зуныг мөн энэ орчмын уулархаг оронд өнгөрөөжээ. Хаан энд байхад Чагаадай, Өгөөдэй нар Ургенч хотыг шийдвэрлэгчид ирж цэрэг нийлсэн бөгөөд Жочи Сыхун мөрнийг гаталж умарш яван хоёр мөрний хоорондох говь газраа сахиар үлджээ.

Энэ үед Чингис хаан нэгэн бачим мэдээ олж сонсчээ: Урьд Чингис хаан ба Тулуйн их цэрэг өмнөш довтлох үед энэ хоёр их цэргийн тусламж болгон Забилистанд суулгаж, байсан Монголын нэгэн салаа цэргийг энэ хавар Джалал-ад-Дин султаны цэрэг устгаж, дараа нь Джалал-ад-Дин султан Газни-гийн орныг дахин эзлэн авч, тэндэх нутгийн зургаа, долоон түмэн морьт цэргийг цуглуулан, Газни-гаас мордож, Бамианы орчим дахи Бараан хээрт ирж, Валиян цайзыг бүслэн байлдаж байсан монгол цэргийн хошууч цэргийг бас дайрч мянган хүн алсан байжээ.

Чингис хаан энэхүү мэдээг сонсмогц, Джалал-ад-Дин султаныг тосон байлдахаар бачим мордов. Зам зуур Курзиван гэдэг газраар өнгөрөхөд тэндэх цэрэг ард сүрхий эсэргүүцэж, байлдааныг нэг сар үргэлжлүүлж сая шийдвэрлэжээ. Курзиванаас цааш урагшилж Цаст уул(Гиндукуш уул)-ыг даван Бамиан цайзыг бүслэн байлджээ. Хоёр этгээдээрээ нум сум харвалцан ширүүн тулалдаж байхад гэнэт хот дотроос нэгэн сум нисэн ирж, Чагаадайн хөвгүүн Мугадуганыг онон алсан байлаа. Үүнд Чингис хаан харсахын туйлаар харсаж, хатуу зарлиг буулган, хотыг нь балбачин орж, ард иргэдээс нь түрүүлэн, адгуус малд нь хүртэл амьтай бүхнийг үлдээлгүй алан хядаж хотыг нь үнсэн товрог болгов гэлээ.

Энэ үед Чингис хаан бас нэгэн муу мэдээг хүлээн авчээ. Юу гэвэл, урьд Талаханаас Шигихутуху-гаар гурван түмэн цэрэг захируулж Кабул, Забилистаны захын уулархаг газар томилж, нэгэн талаар Джалал-ад-Дины чимээг тагнан, нөгөө талаар Чингис хааны аялалыг хамгаалахаар явуулжээ. Шигихутуху томилсон газартаа очоод дэмий удсангүй, Джалал-ад-Дин султан зургаа, долоон түмэн морьт цэрэг дайчилж Валияныг бүслэн байлдаж байсан монгол цэргийг хохируулсан чимээг сонсч Джалал-ад-Дин лугаа байлдахаар түргэн мордож,

найман хоногийн дараа Бараан хээрт ирж Джалал-ад-Дин цэрэгтэй золгодож, Бараан хээрийн ширүүн байлдаан эхэлжээ. Энэ удаагийн байлдааныг Шигихутуху цэрэг цөөн (гурван түм) бөгөөд тусламжгүй байдал доор хийжээ. Хоёр талын цэрэг маш ширүүнээр байлдаж, эхэндээ хэн алин нь ч хүнд хохирсон бөгөөд дараагаар нь Джалал-ад-Дин султан дун үлээмэгц бүх цэргээрээ дайрч, Шигихутуху-гийн цэргийн их хагасыг нь алан шархдуулсан тул Шигихутуху ялагдан буруулсан байв. Джалал-ад-Дин султаны цэрэг хэдийгээр ялсан боловч, Монголын их цэрэг хүрч ирэхийг мэдэж байсан тул цаашид нэхсэнгүй бөгөөд Шин мөрнийг гатлахаар Газни өөд ухран явжээ.

Чингис хаан энэ чимээг 9 сард сонсч, маш сүрхий хилинлэн, өдөр шөнийг ялгалгүй, хоол будаа хийх завгүй бачим түргэн урагшилж хоёр өдрийн дотор Газни-д хүрсэнд Джалал-ад-Дин султан арван таван хоногийн өмнө эндээс нэгэнтээ явсан байв. Хотын иргэд нь эсэргүүцэлгүйгээр даган өгсөн тул Мама, Ялавачи¹⁹ гэгчээр Газни хотын даргач болгож, Чингис хаан бас Джалал-ад-Дин-ийг нэхээр цаашид урагшилжээ.

1221 оны 10 сард²⁰, Чингис хааны их цэрэг Джалал-ад-Дин султаныг Шин мөрний хөвөөнд нэхэн гүйцсэн байв. Түүх шастирт тэмдэглэгдэн алдаршсан “Шин мөрний дайралдаан” ингээд эхэлжээ. Энэхүү түүхэн дайралдааны явагдсан бодтой газар нь одоогийн Калпак орчмын Динкут (одоо бүр Пакистаны хилд буй) бололтой гэж Бартольд “Туркестан” гэдэг номдоо тэмдэглэжээ (Ту Цзи авгай Дэрэс Мэлиг хан хот гэжээ).

Чингис хааны цэрэг гүйцэн хүрэхэд, Джалал-ад-Дин султан хүнд ачаа хөсгөө голд хаяж, онгоц сал бэлтгэн, маргааш нь гол гатлахаар бэлтгэн байжээ. Ингээд Чингис хааны их цэрэг шөнө дүлээр бачим түргэн довтолж, Джалал-ад-Дин-ий цөөн цэргийг Шин мөрний эндэх эргэд давхар давхар бүслэн авч, үүрээр ерөнхий довлолтын зарлиг тунхаглав. Монгол цэрэг урьдаар Джалал-ад-Дин-ий баруун жигүүрийн цэргийг сөнөөсөн тул зүүн жигүүрийн цэрэг нь ч ялагдан сарнив. Энэ үед Джалал-ад-Дин султан долоон зуухан хүнтэй үлдэж, баруунаас зүүнш дайран, дахиад зүүнээс монгол цэргийн төв өөд довтолж мултарч гарахаар хатуу шургуу байлдаж байв. Чингис хаан түүнийг амьдаар барьж авахын тул нум харвахыг зогсоож, алхам алхмаар шахан, бүслэлтийн хүрээ нь улмаас улам багасч байлаа. Энэ үед Джалал-ад-Дин султан байн дахин морио сольж унаад, галзуурсан адил бүслэлтийн дотор нааш цааш довтолж өглөөнөөс үд болтол байлдав.

Гэвч тэр хуруу орох завсаргүй гэмээр хүчирхэг бүслэлтээс мултарахад бэрх болсноо мэдээд, хуяг бамбайгаа тайлан хаяж, туг сүлдээ өндөр өргөн, хорин тохой өндөр асга хадаас хурдан морийг нь тавин нисгэж, Шин мөрний түргэн урсгалд харайлган орж, тэртээ эрэг өөд умбан гаталжээ. Монголын цэрэг бас гол туулан нэхэх гэснийг Чингис хаан хориглон зогсоож, өөрөө голын хөвөөнд очиж, Джалал-ад-Дин султаны гатлан гарсан байдлыг үзээд “Эцэг хүнд ийм хөвгүүн байх хэрэгтэй” гэж өөрийн хөвгүүддээ дахин дахин хэлж гэлээ. Джалал-ад-Дин султаны цэрэг нь мөрөнд живж үхсэнээс бусад нь бараг бүр сэлмийн доор эцэслэжээ.

“Шин мөрөний дайралдаан” ч ингээд дуусчээ. Хорезм улсаас “өшөл өшин, хясал хясан” цээрлүүлэх хувиас үзэхүл, Чингис хаан үүнээ хол хэт биелүүлж, Монгол Хорезм хоёр улсын хооронд арван гуравдугаар зууны эхэн үеэр үүссэн энэ удаагийн дайнд Хорезм улсын Мухаммед, Джалал-ад-Дин хоёр үеийн эзнийг нь мөхөөж, бүх улсын зэвсэгт хүчин ба эд бодосын хүчийг нь хүнд сүрхий хохируулсан тул энэ дайн үндсэндээ дуусав. Үүнээс сүүлд

нэгэн охор хугацаанд явагдсан байлдаанууд бол үндсэндээ шүүрдэлтийн чанартай байлдаан болно.

Гэвч, Джалал-ад-Дин султан мэтийн нэгэн эрэлхэг чадамгай эзнийг нь хэдийгээр ганц бие болгосон ч амьдаар тавин гаргасан явдал хожимдоо уршиг болох магадгүй гэж Чингис хаан үзэж байсан болохоор, түүнийг нэхэн устгах явдлыг маш хүндэтгэж байжээ. Ингээд Жалайрын Бала ноён түрүүтэй нэгэн салаа цэргээр Джалал-ад-Дин султаныг нэхүүлэхээр Индус (умард Энэтхэг) өөд томилов.

Бас Дөрвөний Дөрбэй өөр нэгэн салаа цэргийг Индус, Багдад хоёрын хоорондохи Ару, Мару, Мадасари зэрэг үндэстний авт балгасыг дайлуулахаар томилжээ²¹.

1221 оны 11 сард, Аму-Дарья мөрний умард дээрэм дэгдсэн чимээг сонсч Чагаадайг томилон дарангуйлсан бөгөөд их мөрний хөвөөг засуулжээ (энэ хэсгийг “Баруунш зорчсон тэмдэглэл”-ийг үндэслэв).

“Шин мөрөний дайралдаан”-ы дараа, Чингис хаан эдгээр цэргүүдийг томилж явуулаад, өөрөө их цэргээ авч, 1222 оны хавар, Шин мөрний баруун эргээр хойш Джалал-ад-Дин султаны үлдэгдлийг цэвэрлэсээр буцжээ. Энэ үед Чингис хаан, Газни хот урьд бууж өгөөд эвдэрсэнгүйгээр үлдээсэн явдалд баахан алгасаж, хожим дайсан ашиглуузай гэж бодоод, Өгөөдэйг томилж Шин мөрний адаг өөд баруунш шүүрдэлт хийлгэхийн хамт бусад бэхлэлт цайзыг шийдвэрлэсэн ёсоор Газни-г шийдвэрлүүлжээ. Энэ үед Балаг хот дахин урвасан тул хаан өөрөө очиж дарсан бөгөөд суугуул ардыг нь хядаж орон сууцыг нь шатаасан гэлээ.

1222 оны зун, Чингис хааны их цэрэг Эх горхи, Гэгүн горхид хүрч Бараан хээрт²² зусчээ.

Үүний хамт Элжигэдэй ноёныг Газни-гийн харьяат Ели балгасын бослогыг дарангуйлуулахаар томилжээ. Урьд Тулуйн их цэрэг Газни-г дайлахад ганц энэ Ели балгас дайрагдсангүй хуурмагаар буун өгөөд, дараа нь Джалал-ад-Дин султаны цэрэг Бараан хээрт Шигихутуху-гийн цэргийг ялсан чимээг сонсч, энэ балгас монгол цэргийг эсэргүүцэн боссон байна.

1222 оны зун, Чингис хаан Гэгүн горхины орчимд зусаж байхад Өгөөдэйн цэрэг Газни-гаас буцан ирж нийлсэн байна. Бас Бала ноёны цэрэг Джалал-ад-Дин султаныг нэхээр явж, Шин мөрнийг гатлан гарч Джалал-ад-Дин-ий барааг²³ ч олж үзсэнгүй тул умард Энэтхэгийн зарим газрыг талхиж, уур амьсгал халуун учраас цааш нэхэж чадсангүй, дахин Шин мөрнийг гаталж, Газни-гаар дайран, Гэгүн горхины орчим ирж Чингис хааны их цэрэг лүгээ нийлжээ. Дөрбэй догшины цэрэг ч бас буцаж иржээ.

Чингис хаан баруун орныг үндсэндээ дайлан дагуулсан тул гол гол газар орон ба хот балгасад дарагчдыг томилж захируулав. Үүний тул Ургенч хотын Ялавачи (энэ бол “Нууц товчоон”-ы бичлэг болно. Өрнөдийхний дурддаг Махмуд Ялавачи буюу Мама Ялавачи бүр нэг л хүн юм), Масхунд гэгч эцэг хөвгүүн хоёртой хаан ярилцаж, хот балгадын ёс заншлын тухай ойлгосон бөгөөд Бухара, Самарканд, Ургенч, Удан, Хисхар, Уриан, Гүсандарил²⁴ зэрэг орныг тайш Елюй Ахай-гаар захируулж, Ялавачи-гийн хөвгүүн Масхундаар хавсруулжээ.

1222 оны намар Чингис хаан аян замдаа Хятадын бумбын шашны бясалгагч Чан-чунь арш лугаа уулзсан юм. Үүнийг төвлөрөнгүй танилцуулахын тулд тус бүлгийн сүүлчийн хэсэгт тохируулав.

1222 оны өвөл Монголын их цэрэг Шин мөрний эх орчим дахи Буя Катурын ууланд өвөлжжээ. Энэ газар бол өндөрлөг орон бөгөөд агаар сийрэг, уур амьсгалын хувирал их тул монгол цэргүүд тохирч эс чадан, цэргийн дотор хижиг өвчин дэлгэрчээ.

Зэв, Сүбээдэйн хийсэн хол дахины аян дайн

Одоо бид Монголын их цэргийн нөгөө нэгэн салаа цэрэг-умарш дайлан Зэв, Сүбээдэйн хийсэн хол дахины аян дайны тухай дөхөм тэмдэглэх хэрэгтэй байна.

Зэв, Сүбээдэй, Тогучар нарын захирсан гурван түмэн их цэрэг, 1220 оны өвөл Хорезм улсын Мухаммед султаныг Каспийн тэнгисийн нэгэн бяцхан зэлүүд арал дээр хөөн гаргаад, арга бус буцаж, Каспийн тэнгисийн баруун талаар умарш Азербайджаны төв Тбилиси (одоогийн Зөвлөлтийн Гүрж улсын төв) өөд довтолжээ.


Монголын цэрэг Тбилиси-д ойртон хүрэх үед тухайн үедэх Азербайджаны эзэн түрэг угсааны Узбек гэгч нэгэнтээ нас ахиж, архинд автаад зөнөг болсон тул монгол цэрэгт зоос мөнгө, хувцас хунар, мал унаа зэрэг эд хүргэж эвсэхийг гуйчилжээ. Ингээд Зэв, Сүбээдэйн их цэрэг Азербайджаны хилээс ухран гарч Каспийн тэнгисийн эрэг дагуу Муганы тал нутагт өвөлжив. Энэ өвөл тун хүйтэн бөгөөд цас их, зам нэвтрэлгэ бүр түгжирсэн байв. Гэвч, энэ Моганы тал нутаг бол өвч бэлчээрээр сайн бөгөөд дулаавтар орон билээ. Монголын цэрэг буйд замаар замнаж, Гүрж өөд довтолжээ.

Гэтэл энэхүү хөхөө өвлийн хүйтэнд Моганы дулаавтар оронд өвөлжсөн монгол цэргийг гарч ирнэ гэж Гүржийн хүмүүс ер санасангүй байжээ. Тиймээс тэд Азербайджан, Джазира хоёр орны тэргүүн нар лүгээ холбоо байгуулахаар тус тус элч томилж, хойд хавар хүч хамтарч Монголын цэрэгтэй байлдаж гэж хэлүүлжээ. Ийнхүү санамсаргүй байтал, Монголын их цэрэг тэсгим хүйтэн улиралд Гүржийн хилд гэнэт цөмрөн орж, Гүржийн түмэн цэргийг ялж, их хагасыг нь сөнөөв. Гүрж хүмүүс бол Христосын шашныг шүтдэг болохоор түүний харьяат дахи Исламын шашныг шүтэгч туркмен хүн ба күрт хүмүүсийг доромжлон дарладаг байжээ. Ингээд энэ хоёр угсааны хүмүүс нь монгол цэрэгт сайн дураасаа орж өгсөн бөгөөд монгол цэрэг ч эдний хоорондохи зөрчлийг нь ашиглан, тэднээр хошуучлуулж, Гүржийн хүчийг нь бууруулахаар 1221 онд Армени ба Гүржийн зүүн өмнө хэсэг орнуудыг довтолсон боловч, Гүржийн хавцал бартаа олон олон тул айж доромж нэвтэрсэнгүй байв.

1222 оны өвөл, Зэв, Сүбээдэйн их цэрэгтэй Хэ Лин нуруу (одоогийн Кавказ нуруу)-г даван өнгөрч уран аргаар асу аймгийн холбоот цэрэг (Лэсжи, Саркис, Кипчак зэрэг аймаг багтана)-ийг сарниулан мөхөөж, Кипчакын²⁵ нутагт гүнзгийрэн довтолсон тул Кипчакын иргэд хамгийн сайхан бэлчээрт тал нутгаа орхиж зах хязгаар орон өөдөө дутаажээ. Зөвхөн Дон мөрнийг гаталж Византийн хаант улс өөд дутаасан нь даруй түмэн өрх байсан бөгөөд бас Орос өөд нүүн явагсад цөөн бус байлаа гэдэг билээ.

Монгол цэрэг 1222 оны өвөл Кипчакын төв газар өвөлжсөн бөгөөд 1223 оны хаврын сүүл


буюу зуны эхээр Кипчакын цэргийг Бузу голын хөвөөнд дайран ялжээ.



Зураг – 78. Зэв Сүбээдэй Орос Кипчак оод довтолсон зураг



Чингис хаан Хорезмд байлдаж байгаа зураг



Самарканд дахи Төмөрийн сүм - Чингис хаан сургаал тавьж бүхий зураг

Vertical columns of Chinese calligraphy, likely a poem or inscription, located at the top of the image.




Чан-чунь ариш Цю Чу Цзи-гийн хөргүүд:

А. Чан-чунь ариш энгийн хувцас өмсч зам явж бүхий зураг



Чан-чунь ари хувхай модыг эдгээсэн зураг



Чан-чунь аришийн өтөл насны шуумал хөрөг



Чан-чунь аришийн идэр насны шуумал хөрөг



Бээжин дэх Бай Юнь Гуань сүм



Бумбын шашны дээд Цю Чу Цзи-гийн харш



Бай Юнь Гуань сүмийн дундад харшийн үүдэн дэх гуулин морь

成吉思皇帝聖旨遣與諸處官
每丘神仙應脊底脩竹底院舍等係
逐日念誦經文告天底人每與
皇帝祝壽萬萬歲者所據大小美
丘神仙底應係出家門人等隨處
院舍都教免了差發稅賦者其
外詐推出家影占差發底人每
如此不得違錯須至給付照用
右付神仙門下收執
照使所據神仙應係出家門下
精嚴住持院子底人等并免差
發稅在此
癸未羊兒年三月 日
寶

Чингис хааны зарлигийн сийлээс (1)

差阿里群面奉
吉思皇帝聖旨丘神仙
知來應公事是也照好我
前時已有聖旨文字與你
來教你天下應有盡出家
善人都管若者好應及
五神仙你就便理會只你識
者奉到如此
癸未年九月二十四日
西域化胡歸頓而至燕京
皇帝感勞即賜金虎符牌曰
真入到處如朕親臨丘神
池其啞漢地凡朕所有之城
下道門事務以聽神化處
置他人勿得干預宮觀差
役盡行蠲免所在官司常
切衛護免所
天樂進人李道德書

Чингис хааны зарлигийн сийлээс (2)



Чингис хааны шударга залгамжлагч - Өгөөдэй хаан

1223 оны 5 сард, Оросын холбоот цэрэг²⁶ Монголын цэрэг лүгээ байлдахаар Днепр мөрний орчимд хүрч иржээ. Энэ үед Монголын цэрэг элч томилж хэлүүлсэн нь: Бид Оросыг халдах санаагүй, зөвхөн түүний зэргэлдээ аймгийг дайлахаар ирсэн билээ. Эдгээр аймгууд урьд Оросыг халдан түйвээж он жил удсан биш үү, таны Оросууд харин манай монгол цэрэг лүгээ хамтран энэхүү завшааныг далимдуулан урьдын өшөөгөө авч олз ашгаа бид хамтаар хувааваас ямар буй? гэжээ. Гэтэл Оросын олон ван нар Монголчуудын дурдлагыг нь сонссонгүй мөртөө арван элчийг нь алжээ. Дараа нь Днепр мөрнийг гаталж, Монголын үзүүр цэргийн захирагчийг нь барин авч Кипчакуудад тушаан өгч алуулсан бөгөөд Оросын холбоот цэрэг нь Дон мөрөн орчим дахи Калка голд довтлон иржээ. Ингээд Зэв, Сүбээдэйн захирсан монгол цэрэг болон Оросын холбоот цэргийн хооронд Калка голын хөвөөнд хийсэн ширүүн их дайралдаан үүсэв. Байлдаан эхлэх үед монгол цэрэг нь Оросын цэргийг өдөөн хязгаараас нь холдуулж байгаад байлдахаар төлөвлөж, санаатайгаар хойш ухарч байв. Орос цэрэг энэ аргад нь орж, Калка голыг гаглан гарч ирсэн хойно, монгол цэрэг байлдах бэлтгэлийг хийж, 5 сарын 30-ны өдөр гэдрэг довтлов. Энэ үед Оросын Галич гүнт улсын ван Метислав гэгч өөрийн хүчиндээ бардаж, Киев ба Тернигов (Чернигов)-ын вантай болзолдсонгүйгээр тэр өдөртөө Монголын цэрэгтэй ганцаараа байлджээ. Энэ байлдаанд түүний цэрэг ба Кипчакийн хүмүүс бүр монгол цэрэгт ялагдсан тул Метислав өөрийн цэргээ орхиж, санд мэнд дутаажээ. Монгол цэрэг Калка голыг гэтлээд, голд байсан онгоц салыг бүр галдсан болохоор, түүний цэргийн аравны нэг нь сая дутаан гарч чадсан байна. Энэ удаагийн Оросын зургаан ван, далан хэу нь алагдсан бөгөөд Кипчак хүмүүс бас завшааныг далимдуулж, ялагдсан цэргийг нь алж, морь унааг нь булаан авсан гэлээ.

Энэ үед Киевийн ван нь Метиславын цэргийн ялагдахыг үзээд очиж тусласангүй байв. Монгол цэрэг хоёр салан, нэг хэсэг нь Метиславын ялагдсан цэргийг нэхэж, нэг хэсэг нь Киевийн цэрэг лүгээ байлджээ. Киевийн ван нь гурван өдөр эсэргүүцсэний дараа, Монголын нөгөө хэсэг цэрэг хүрч ирсэн тул, түүний амь ба хоёр хүргэн (хоёулаа Оросын бага ван байжээ)-ийх амийг хэлтрүүлбэл өөр нөхцөлгүй бууж өгөхөөр гуйчилжээ. Монголчууд хуурмагаар зөвшөөрч, бүгдийг барьж авсны дараа цөмийг алсан гэлээ.

Оросын нөгөө нэгэн улс Владимир гүнт улсын их гүн Курки гэгч өмнөд Оросын эл вангийн гуйчлалаар цэрэг авч туслахаар явж байгаад холбоот цэрэг ялагдсан чимээг сонсмогц өөрийн цэргээ дагуулан ухран буцжээ. Ингээд монгол цэрэг өмнөд Оросын нутгийг намрын салхи унасан навчийг хийсгэх мэт ховх шүүрдэж, Азовын тэнгисийн араар тойрон, Крым-ийн хойг (одоогийн Крым-ийн хойг) ба Днепр мөрний адаг орчмыг талхидаж, дараа зүүн хойш Булгарыг зүглэн, Ижил мөрний дунд урсгал орчим хүрчээ.

Булгарчууд бол Ижил мөрөн ба Кама мөрний эхээр нутаглаж, голдуу тариалан аж ахуйг эрхэлдэг үндэстэн бөгөөд суугуул ард нь Исламын шашинтан ба Христосын шашинтнаар бүрэлджээ. Тэд бол Орос болон Каспийн тэнгис дагуу улс орнуудтай арилжаа хийлцдэг байжээ.

1223 оны сүүлч буюу 1224 оны эхээр, Монголын цэрэг Булгарын нутагт хүрэхэд Булгарын цэрэг тосон байлдав. Энэ удаагийн байлдаанд “Булгарчууд дийлэгдэж, тэрчлэн Богоми-ийн гэрээг хүлээн авч, монголыг эзэн улсаар зөвшөөрөн, Жочи-г хувь газар (Кипчак)-ын гадаад харьяат нь болжээ” (Ли Цзэ Фэнь). Зэв, Сүбээдэй нарын холын аян дайн²⁷ ч ингээд дуусч,

Сакасин хот (энэ Сакасин бол “Нууц товчоон”-д дурдагддаг “Сасуд” мөн гэж Фэнь Чэн Цзюнь авгай үзжээ)-оор дайран, Ханлиний нутаг хүрч Зэв ноён өвчнөөр нас баржээ. Сүбээдэй ноён 1224 онд Хорезмоос Монголын эх нутаг өөдөө буцаж байсан Чингис хааны их цэрэг лүгээ нийлэлджээ.

Зэв, Сүбээдэй нар энэ удаагийн гурван түмэн цэргээр хэдэн жилийн хооронд түмээд газрын хол замыг явж, хэдэн арван удаагийн дайралдааныг хийж, маш олон улс үндэстнийг дайлан эзэлж, нэлээд олон алдарт хот балгасыг товрог болгосон явдлыг үнэхээр дэлхий дахины түүхэн дэх гайхамшигт явдал гэж үзэлтэй. Гэтэл энэ нь хэрэг дээрээ нэгэн удаагийн зэвсэгт тагналт буюу Монголчууд Хорезмыг дайлах явцад санамсаргүй тохиолдсон дайралдаан гэж Европынхон үздэг байна. Бас “Энэ удаагийн байлдааныг санамсаргүй тохиолдсон хэрэг буюу завшаанаар өсөлсөн хэрэг гэж үзэлтэй. Чингис хаан Монголын эх газартаа байхад Крым-ийн хойгт цэрэглэж байлдах төлөвлөгөөгөө хийлээ гэх тийм бололцоо байгаагүй мэт” гэж Хан Жу Линь-ий хэлж байсан нь зүйтэй юм.

Монголын энэ нэгэн салаа цэрэг буцаж ирсэн хойно, Чингис хаан Зэв, Сүбээдэй хоёрыг сайшаав. “Тогучар, Хан Мэлигийн хязгаарын хотуудыг өөрийн дураар шийтгэж, хаан Мэлигийг дайсан болгов. Цээрлэл болгож түүнийг алья хэмээн хэлсэн боловч, дараа нь алахаа байж маш буруушаан зэмлэж, цэрэг захирах эрхийг нь хасав” (“Нууц товчоон”, 257 дугаар).

61. Чингис хааны цэрэг Монгол орондоо буцсан нь

Чингис хаан 1222 оны өвөл, Буя Катурын ууланд өвөлжихөд цэргийн дотор дэлгэрсэн хижиг өвчин нь, хойд хаврыг үзмэгц зогсож илаарь болов. Ингээд Чингис хаан Энэтхэг, Төвдөөр дайрч, Монгол орондоо буцахаар шийджээ.

Чингис хаан юуны учир цэрэг буцсан буй гэвэл, тэр нэгэнтээ сэтгэлээ ханатал зорилгодоо хүрсэн тул буцахгүй байх хэрэгцээгүй болжээ. Гэвч “Тэр яаран буцсан шалтгаан нь: Хятанчууд ба Тангудчууд, түүнийг улстаа байсангүй завшааныг далимдуулан хүчирхэгжиж, урвахаар хуйвалдаж байсанд оршино” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”) гэж зарим түүхчид тэмдэглэж байсан.

Чингис хааны баруунш дайлсан явдал нь яг Алтан улсыг дайлж байх явцад гэнэт гарч, Тангудаас тусламж гуйгаад олсонгүй мөртөө хэтэрхий хорсогдсон билээ. Энэ хоёр явдлыг Чингис хаан мартаж өсгүй бөгөөд бас өөрийн зохистой гэж үзсэн аргаараа шийдвэрлэх нь лавгай хэрэг юм. Тиймээс, Чингис хаан Хорезм улсад “өшөл өшин хясал хяссан” явдлаа бараасан (дуусгасан – хө.) байдал доор, эх улсаа түргэн буцах нь зүйтэй билээ. Чингис хаан 1223 оны хавар²⁸ цэрэг буцахад хийвээс зохих аливаа бэлтгэлээ хийж дуусаад, Энэтхэг, Төвдөөд хэдэн өдөр замнаад явах аргагүй болж, Пайшавар (өдгөө Пешавар – хө.) хүрч уулын цэрэг орсон замаараа буцжээ. “Бэрх бартаатай уул нуруу, балар харанхуй ой шугуй, урваан хөрвөөнтэй уур амьсгал ба уухуйд бэрх муухай ус тохиолдсоны хамт, Тангуд урвалаа гэдэг мэдээ зэрэг нь бүр Чингис хааны цэрэг буцсан шалтгаан нь болов” гэж Рашид-ад-Дин Энэтхэг, Төвдөөр эс явсан тухайг нь тэмдэглэжээ.

Пайшавараас хөдөлж, Бамианы уул нуруудыг давж, Бараан хээрт үлдээсэн ачаа хөсөгтэйгээ

нийлж, аяны зам зуураа ав тавьсаар, мөн 1223 оны зун энд зусжээ. Намар тэндээс цэрэг хөдлөн, Аму-Дарья мөрнийг гатлан, тус оны өвөл Самарканд хотоос зүүнш хорин газар зайтай буув.

Энэ өвөл Чингис хаан их ав тавив. Урьд Жочи, Чагаадай хоёр Ургенчийн байлдааны үед эвдрэлцэж, Жочи Сыхун мөрнийг гатлан хойш явснаас нааш хаан эцэгтэйгээ ер уулзсангүй байжээ. Ингээд хаан эцэг нь элч томилж, Жочи-г авын олзоо авч учраар ир гэж хэлүүлжээ. Гэвч Жочи эцэг хаанынхаа зарлигаар авын амьтан (олонхи нь хулан чихтэй байлаа гэдэг)-ыг хааны авын хүрээнд хөөн өгснөөс биш, өөрөө ирж учирсангүй гэлээ. Чагаадай, Өгөөдэй хоёр Бухара дахи авын газраас ганзага хүргэхээр ирсэн байв. Дараа нь тэр хоёр Каракөл (энэ бол “Хар нуур” гэсэн утгатай, энэ орчмын намаг газрыг нэрлэж байжээ. Одоо Узбекистаны нэгэн хот Каракөл гэж нэрлэх болжээ) гэдэг газар хүрч хун галуу агнан зугаацдаг бөгөөд авын ганзагаа долоон хоног бүрт нэгэн удаа тавин тэмээ ачаагаар хаан эцэгтээ хүргэдэг байжээ.

1224 оны хавар, Чингис хаан Самарканд орчмоос хөдөлж буцах замдаа орж монгол орон өөдөө хаандлаа. Чингис хааны их цэрэг Сыхун мөрний эрэг орчмын Фенакет (одоогийн Ангара голын цутгал орчим) голын хөвөөнд хүрч, хаан эцэг хөвгүүд цугларч хуралдай хийжээ. Энэ зун Хулан баш29-д хүрч зусав.

1224 оны намар туж Чингис хаан аяны замд явж байв. 10 сард, Чингис хааны ач хөвгүүн арван настай Хубилай, зургаан настай Үлэгү хоёр Эмил гол (одоогийн Казакстаны Алакул нуурт цутгадаг нэгэн гол) орчим өвөг эцгээ угтан ирж бараадав. Тэр хоёр ирэхдээ Хубилай нэгэн туулай харваж, Үлэгү нэгэн буга харваж алсан гэлээ. Өвөг эцэг нь монгол хүний заншлаар анх авынхи нь махаар дунд хурууг нь мялааж өгөв.

Дараа нь Монголын их цэрэг Алтайн ойролцоо Эрчис мөрний эх орчмын Буха сочигай (бас Буха сочиху буюу Сүчигай гэж бичсэн харагддаг) гэдэг газар ирж их найр хурим хийж, ялалттай буцаж ирсэн бүх цэргээ тохинуулсан байна. Энэхүү найр наадам дээр сур харвахад, Чингис хааны дүү Хасарын хоёрдугаар хөвгүүн Есүнхэ мэргэн гурван зуун гучин таван алд хол оносон байна. Хожим нь түүнийг дурсгаж, нэгэн чулуун хөшөө босгожээ. Энэ бол сүүлчийн үед “Есүнхэ мэргэний гэрэлт хөшөө” буюу “Чингисийн чулууны бичиг” гэж алдаршсан, одоо Зөвлөлт Холбоот улсын Ленинград хотын Азийн музейд хадгалж бүхий чулуун хөшөө болно.

Чингис хааны хоёрдугаар он, хөхөгчин тахиа жил, нийтийн он тооллын 1225 оны хаврын эхээр30 Чингис хаан жаран дөрвөн насан сүүдэртэйдээ Сартуул иргэнийг дайлан дуусгаад Туулын Хар түн дэх их ордондоо ирж буув. Чингис хааны баруунш Хорезм улсыг дайлсан дайн долоон жил (1219-1225 он)-ийн нүүрээ үзэж дуусчээ.

62. Энх тайвны элч - Чан-чунь арш ба Үгүсүн Жүанда

Чингис хаан хорин түмэн их цэрэг дайчилж Дундад Азийг дайлан Хорезм улсыг цэрэг зэвсгээр цээрлүүлж байсан дайны дунд, Дундад Улсын дотор газрын хоёр энх тайвны элчийг өмнө фронтод хүлээн авч уулзсан сонирхолтой явдал гарчээ. Нэг нь өмнөд Сүн улсын бумбын шашны бясалгагч Чан-чунь арштай уулзсан, нөгөө нь Алтан улсын элч Үгүсүн Жүанда-тай уулзсан явдал болно. Энэ хоёр удаагийн уулзалтын үүсэл төгсгөлийг доор тус тус товч

ТЭМДЭГЛЭСҮГЭЙ.

Чан-чунь арш ба түүний “Баруунш зорчсон тэмдэглэл”

“Чан-чунь арш” гэдэг нь түүний бясалгалын цол болно. Чухам нэр нь Цю Чу Цзи, өргөсөн нэр нь Тун Ми гэдэг. Тэр бол нийтийн он тооллын 1148 оны цагаан сарын 11-ний өдөр Дэнчжоу-гийн Цися сянь (одоогийн Шаньдун мужийн харьяа газар)-ы Биньдули гэдэг газар төрж, арван есөн насандаа гэрээсээ гарч Нинхай (одоогийн Шаньдун-гийн Мупин)-д очин бумбын шашны хоёр их салбарын нэг нь болох “Үнэн төгөлдөр суртахуун”-ыг үүдэгч Ван Чун Ян-ыг багшаар шүтэж, бумбын ёсыг бясалгажээ. Багш нь үхсэн хойно, тэр Лун Мэнь Шань ууланд далд бясалгалыг хийж, бумбын шашны Лун Мэнь гэгч нэгэн салбар болсон бөгөөд “Үнэн төгөлдөр суртахуун”-ы долоон аршийн нэг нь болжээ. Ингээд түүний нэр улс даяарт алдаршив. Дараа нь шарагчин туулай жил (1219 он) Лайчжоу (одоогийн Шаньдун мужийн Е сянь)-д сууж байв.

1216 онд Алтан улсын хаанаас, 1219 онд өмнөд Сүн улсын хаанаас Чан-чунь аршийг тус тус урьсан боловч тэр алинд ч очсонгүй байв.

1219 оны 5 сард, Чингис хаан Хорезм улсыг дайлаар мордож, Найманы нутгаар явж байхдаа хааны шадар барлаг Лю Чжун Лу (хятад хүн, Чингис хааны элч байсан бөгөөд дуут зэв үйлдэж чаддагаараа Чингис хааны дотночлолыг олов гэдэг), Жабар (Дундад Азийн Сайрам газрын хүн гэдэг. Тэр бол Балжуна нуурын тангарагт оролцсон бөгөөд Чингис хаан Цавчаал боомтоор Чжунду өөд довглоход замчилж, чухал үйлдлийг үзүүлсэн ба Алтан улсад элчилж байсан Арачан гэгч мөн гэдэг билээ) нарт барсын толгойт алтан пайз (пайзын дээр “хаан биеэрээ морилж ахуй мэт асартугай” гэсэн үсэгтэй гэж “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-гийн дээд ботид тэмдэглэж буй)-г өгч, Чингис хааны урилгын зарлигийг бариулан, Чан-чунь аршийг уриулахаар Шаньдун мужийн Лайчжоу өөд томилжээ.

Лю Чжун Лу нар Чжунду болон И Ду Фу (Шаньдун мужийн Вэй сянь)-гаар дайрч, шарагчин туулай жил (1219 он)-ийн билгийн улирлын 12 сард Лайчжоу-д хүрч, Чан-чунь арш Цю Чу Цзи-г урьжээ.

Чингис хаан чухам ямар зорилгоор Чан-чунь аршийг урьсан, Чан-чунь арш яагаад Алтан улсын хаан ба өмнөд Сүн улсын хааны урилгад очсонгүй, гагцхүү Чингис хааны урилгыг хүлээн авч, түмэн газрын алс замыг алжаалгүй, Дундад Азийн дайны фронтод очиж Чингис хаантай учирсан тухай сүүлчийн үеийн хүмүүс янз янзаар хэлэлцдэг байна. Миний хувийн үзэлт гэвэл доорхи мэт:

Энэ тухай Чингис хааны талаас үзвэл, энх төрийг эмхлэн засахад эрдэмтэн мэргэд хэрэгтэй байжээ. Энэ нь мөн ч Чингис хаан зэр зэвсгийг л хөөцөлддөг биш, энх тайвныг эрхэмлэж байсныг харуулж байна. Энэхүү зорилгыг нь бид түүний зарлигийн бичгээс нь мэдэж болно.

Чингис хаан Чан-чунь аршийг урьсан зарлигийн бичиг нь:

Мэдэгдэх нь, Чжун-юань (энд Алтан улсыг заажээ - эшлэгч)-ий жаргал цэнгэл доор хэтийдсэн учир мөнх тэнгэр буруу үзжээ. Хаан миний бие ар газар төрсөн тул тугал хургын

хамт өсөж, хүчир бэрхшээлийн дунд бойжин, идэж уух өмсч эдлэх нь дөхөм борогжуун бөгөөд хүсэл тачаалд үл шунах ажгуу. Ард иргэдийг үр хөвгүүдээр үзэж, цэрэг байлдагчид ах дүү мэт ханддаг. Хэлэхүүд эелдэг, энэрэхүүд өгөөмөр, харьяатныг боловсруулахуйд биеэр манлайлж, хатгалдан байлдахуйд үхэхийг үл сэтгэмүй, тийнхүү долоон оны дотор их үйлсийг бүтээж, таван өнгө дөрвөн харийг нэгэн жолоогоор шударгатгавай. Энэ болбоос хаан миний эрдэм чадал бус болой, харин Алтан хааны төр доройтсны үр бөгөөд мөнх тэнгэрийн ивээлээр их суурийг хаан надад соёрхож, өмнөш Чжао овогтны Сүн улс лугаа зах залган, умарш Уйгур лугаа үргэлжилж, дорно өрнийн улс угсаатан цөм өргөл барин харьяат болов. Бодвоос энэ нь манай Чань Юй-гийн улс (Хүннү-г заажээ - эшлэгч)-аас нааш олон зуун жилд ер байгаагүй хэрэг болжээ. Түүнчлэн төр гүрний энх үйлсийг засахуйд эс хүрэлцэх газар бас байх тул бэрхшээмүй. Харинхүү онгоц салыг үйлдэх нь гол мөрнийг гатлах хэрэгцээ мэт, мэргэн эрдэмтнийг урин сонгох нь дэлхий дахиныг төвшитгөх хэрэгцээ болжээ. Хаан миний бие сууринаа сууснаас нааш төр улсын түмэн засагт сэтгэлийг чилээсэн атал, түшмэд сайдын дотор зөвлөх мэргэд хараахан илрээгүй болой. Сурвалжлан сонсвоос, багш Цю авгай болбоос төр тунгалаг, суртахуун цэгц, үзсэн түгээмэл, сонссон оновчтой, эрдэм гүн, мэдлэг өргөн, ёс ариун мораль эрхэм тул эзэн хаадын оврыг ахиулж, эрхэм хувилгаадын сурталыг бүрэлдүүлжээ. Басхүү аглаг агуйд удаан саатаж, агуу дүрийг далд байлган, аршийн их ёсыг бясалгаснаас агуйн оронд хурсан билигтэн номтон асар олон хэмээлээ. Багшийг Шаньдун-ы уул нутагтаа бясалган саатаж ахуйг хаан би Чжунюань-гаар дайлахуйдаа сонссон бөгөөд цээж дүүрэн бишрэн бахдаж байлаа. Тийн атал хэрхэн “Вэй Шуй голоос хөсгөөрөө залсангүй (эртний Чжоу У вангаас Цзян Цзи Я-гаас залснаар үлгэрлэжээ - эшлэгч), Улалжин овоохойд гурвантаа эчиж урьсангүй (гурван улсын үед Лю Бэй биеэрээ Чжу Гэ Лянь-ий өвсөн овоохойд эчиж урьснаар үлгэрлэжээ – эшлэгч)” учир нь, уул усан аглаг хол, албан тушаал биед тулгаран аху тул өөрөө эс бараадаж ёсыг алдвай. Өдгөө шадар түшмэл Лю Чжун Лу нарыг сонгож, хөнгөн унаа хөсөг тэргийн хамт түмэн газрын алсаас багшийг урихаар томилбой. Хэрвээ багш та алс холын элсэн говийг бэрх хэмээн алжаалгүй, түмэн иргэдэд амгаланг энэрэх, хаан миний тэнхлүүнийг тохинуулах сэтгэлийг өвөрлөж морилон ирвээс, таны аршийн ширээнд хаан би биеийг ариутган үйлчилж, багшийн сургасан үгсийг хэдүй ч болов эрхэмлэн хүлээх ажгуу. Өдгөө, хаан миний өчүүхэн сэтгэлийг илтгэж, түмний нэгэн төдийг бичиглэн бариулав. Эрхин багш их ёсондоо толилж, хамаг тусыг хэзээд үйлддэг атал хар тэргүүтний хүслийг хэрхэн хөсөрдүүлэх буй за! Үүний тул зарлиг бариулав, толилму. Таван сарын шинийн нэгнээ (энэ бол 1219 оны билгийн улирлын 5 сар болно – эшлэгч) бичжээ (уул зарлигийг “Чжу Гэн Лу бичиг”-ийн 10 дугаар ботид тэмдэглэжээ) гэжээ.

Энэхүү зарлигийн бичиг нь хэдийгээр тоотойхон хэдхэн үгс боловч Чингис хааны санааг бүрмөсөн илтгэжээ. Чан-чунь аршийг урьсан зорилгод нь бас урт наслах ёсыг ирсэн нэгэн агуулга буй, гэвч тэр нь чухал бус гэдгийг мөн энэ зарлиг ба “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-ээс мэдэж болно.

Энэ явдлыг Чан-чунь аршийн хувиас авч үзвэл, өөрөөр хэлбэл Чан-чунь арш Алтан хаан ба Сүн улсын хааны урилгыг нь яагаад хүлээсэнгүй буй гэвэл, тухайн үе дэх Алтан улс ба Сүн улсын төр нь нэгэнтээ доройтон уруудаж, ард түмэнд зовол хагарлыг учруулахаас биш, зол жаргалыг олгож чадахгүй гэдгийг тэр танин мэдсэн бөгөөд Дундад улсын нэгдэл ба өнөдийн энх тайвныг биелүүлэх их үйлийг гагцхүү Чингис хаан гүйцэтгэж чадах их чиглэлийг үзэж гарснаас болжээ. Тиймээс Чан-чунь арш бол нэгэн мэргэн шашинтан болохоор барахгүй, алс

холын бодлоготой төрийн зүтгэлтэн болохыг бас түүний энэхүү ажиллагаа нь гэрчилжээ.

Чан-чунь арш, Чингис хааны урилгыг хүлээн авч, шавь нараасаа Чжао Дао Цзян, Сун Дао Ань, Ли Чжи Чан зэрэг арван есөн хүнийг сонгон дагуулж 1219 оны билгийн улирлын 12 сарын 18-ны өдөр уг нутаг Шаньдун-ы Лайчжоу-гоос мордон гарчээ.

Тухайн үед нэгэнтээ далан хоёр насан сүүдэртэй Чан-чунь арш Лайчжоу Вань булан (одоогийн Бо Хай тэнгисийн булан)-гаас Дундад Азийн өндөрлөгт хүртэлхи бэрх бартаат мянга түмэн газрын замыг хэрхэн туулж явсан тухай доор бид товч тэмдэглэе.

Нийтийн он тооллын 1220 оны 2 сарын 22-ны өдөр Чан-чунь арш нар Алтан улсын нийслэл байсан Чжунду хотод хүрч ирэв. Чан-чунь арш Чингис хааныг буцаж иртэл энд хүлээж байсан Чжунду хотод хүрч ирэв. Чан-чунь арш Чингис хааныг буцаж иртэл энд хүлээж байх санаатай байсан бөгөөд Чингис хаанд айлтгал өргөжээ. Гэтэл Чингис хаан дахин зарлиг бариулж тулгам шаардсан тул баруунш явахаар болж, Чжунду-гаас мордож баруун хойш яван, тус оны таван сард Дэ Син (одоогийн Хэбэй мужийн Чжо Лу сянь) балгасан дахи бумбын шашны Лун Ян Гуань гэгч сүмд хүрч зуныг энд өнгөрөөсөн байна.

1220 оны 8 сарын эхээр Сюань Дэчжоу (одоогийн Хэбэй мужийн Сюаньхуа хот)-гийн юаньшуай Илэ Гүн (энэ бол Елюй Ахайн дүү Елюй Тохуа болно)-ий урилгаар Сюань Дэчжоу-гийн Чао Юань Гуань гэгч сүмд эчин суув. Тус оны 10 сард Чингис хааны дүү Отчигин ноён (энэ үед тэр, Чингис хааны даалгавараар Монгол улсын төрийг түр захирч байжээ) Аришан гэгч элчийг томилж, Чан-чунь аршийг уриулжээ.

Чан-чунь арш 1221 оны 2 сарын 8-ны өдөр Отчигин ноёны урилгаар Сюда Дэ-гээс умарш мордож, Үнэгэн даваагаар даван, Хар балгас (одоогийн Чжанбэй сянь)-ыг дайран, Алтан улсын хилийн Бор Хэрэмээс гарч, их элс (одоогийн Шулуун хөх хошууны элсэн нутаг бололтой)-ээр туулан, тус оны 3 сарын 1-ний өдөр Хишигтэний Загасан нуур хүрэв.

3 сарын сүүлчээр Хайлар гол (тэр үедээ Си Ша Хэ гэж нэрлэж байжээ)-ыг гаталж гурван өдрийн зам явж, 4 сарын 1-ний өдөр Отчигин ноёны ордон³¹д хүрчээ. Энд арван хэд хонож, Хөлөн нуурыг дайрч, Хэрлэн голыг даган баруун хойш яван, дахин баруунш Туул, Орхон, Тамир, Сэлэнгэ зэрэг голоор өнгөрч, 6 сарын 28-ний өдөр Эдэр гол (Сэлэнгэ мөрний нэгэн салбар)-ын дэргэдэх Чингис хааны татвар хатан хятад, тангуд гүнжийн³² ордонд хүрчээ.

Гүнжийн ордноос гараад Хангайн нуруугаар дайрч, 7 сарын 25-ны өдөр Алтайн ард тариалж байсан Тянь-ий Хингайн балгасан³³-д хүрчээ. Дараа өдөр нь Хингай ирж арштай учрав. Би нэгэнт өтөлж, хаан хоёр удаа зарлиг буулган дахин давтан дуудсан тул арга бус хэдэн мянган газрын хол замыг явж, таны харьяа газар хүрч ирэв. Элсэн говьд олонхидоо тариа тарьдаггүй боловч, эндэх намрын тариалан боловсорсныг үзэж баясав. Би энд өвөлжиж, хааны хөсөг буцан ирэхийг хүлгэлзвээс ямар буй? (“Баруунш зорчсон тэмдэглэл”) гэж Чан-чунь арш түүнд хэлсэнд, “Дээд багшийн номын зарлигийг Чжун Лу би хэрхэн дагах аж, гагцхүү эрхин сайд Хингай хянах буй за” гэж зарлигийн элч Лю Чжун Лу хэлэв. “Эл газрын түшмэд албатад хэрвээ арш лугаа тохиолдвоос түүний аян замыг саатааж үл болно гэж орчимд эзэн хаан зарлиг тархаасан билээ, бодохуйд арш лугаа түргэн учрах гэсэн буй за. Дээд багш хэрвээ энд саатах хэрэгцээтэй болбоос ял нь Хингай минийх болой. Тиймээс дуртайяа биеэр

хүргэсүгэй. Багшийн хэрэгсэх зүйлсийг үл бэлтгэх нь үгүй” гэж Хингай хэлжээ. “Хувь иймийн тул өдрийг сонгон явбаас зохимуй” гэж Чан-чунь арш хэлсэнд, “Цаашдын замд уул хад бартаатай бөгөөд ус гол арвин байх тул тэрэг хөсөг явахад бэрх билээ. Тиймээс тэрэг хөсгийг орхиж хөнгөн унаагаар морилбоос зохистой” гэж Хингай бас хэлжээ. Ингээд түүний үгээр Сун Дао Ань зэрэг есөн шавиа энд үлдээсэн бөгөөд газар сонгон сүм бариулжээ. Эл талын тусламжаар сар болсонгүйгээр нэгэн бяцхан шавар сүмийг байгуулж “Цисягуань сүм” гэж нэрлэсэн байна. Чан-чунь арш өөрийн нутаг Шаньдун-ы Цися сянь-аас түмэн газрын алс дахи Монголын өндөрлөг (энэ газар нь одоогийн Монгол улсын Ховд аймаг орчим байна)-т сүм барин, түүнийг “Цисягуань” гэж нэрлэсэн нь эх нутгаа дурдсан нь илэрхий юм.

1221 оны 8 сарын 8-ны өдөр, Чан-чунь арш шавь нараасаа Чжао Цзю Гу зэрэг арван хүнийг дагуулж, хоёр тэрэгтэй, Монголын морьт улаачин хорин хүний хамт адил нурууны бэлээр баруунш замнав. Бас зарлигийн элч Лю Чжун Лу, Хингай нарын зуун морьтон хамгаалан явжээ. Тэд улаан даваагаар Алтай нурууг давж, Булган гол Жунгарын алсаар өнгөрөөд, 8 сарын 27-ны өдөр Тэнгэр ууланд хүрэв. Хэлэлгээнгүй тухайн үед дорно өрнийн харилцааны боомт болж байсан Бишбалак хот (энэ бол одоогийн Шинжааны Жимиссайраас умардах По Чэн хотын эртний нэр - Биш балгас болно. Гэтэл Чан-чунь арш түүнийг Бэсма хот гэжээ)-оор дайран, Богдын гурван оргил ба Тэнгэр нуурыг сонирхож, цаашид Ил мөрнийг гатлан, Алимар хот ба Хар Хятан нутгаар өнгөрч, 11 сарын эхээр Хорезмын нутагт орж Ташкентаар дайран, Сыхун мөрнийг гаталж, 11 сарын 18-ны өдөр, Хорезм улсын шинэ нийслэл Самарканд хотод хүрчээ.

Энэ үед Чингис хаан яг өмнө фронтод байсан тул хойд хавар ичиж учирна гэж Чан-чунь арш Самаркандад өвөлжив. Самарканд хот хэдийгээр монгол цэргийн хөлд сүрхий дайрагдсан боловч, энэ хот харин өрнөдийн түүхчдийн тэмдэглэсэн мэт бүрэн мөхсөн биш гэдгийг Чан-чунь арш нүдээр үзсэний хувьд “Султан овогтон (Мухаммед султаныг хэлж буй – эшлэгч) ялагдахын өмнө, тус хотод арван түмэн өрх айл байжээ. Одоо улс нь мөхөснөөс дөрөвний нэг нь үлджээ. Түүний дотор олонхи нь Хотонгийн мөргөлтөн байж, тариалангийн ажлаа өөртөө хийхгүйгээр хятад, Хятан ба Хашин хүмүүсээр хавсруулдаг байв” гэж тэмдэглэжээ.

1222 оны 3 сарын эхэнд, Отчигиний элч Аришан (Чан-чунь арштай хамт иржээ) Чингис хааны аяны ордноос ирж, урьдаар Чан-чунь аршид: “Арш наран мандах орноос мордож, алс замын уул мөрнийг гэтэлж, асар их чилэв. Хаан би өдгөө нэгэнтээ буцаж, номлолыг хурдан сонсохыг хүсэж буй, ядралыг бодолгүй учрах болов уу” гэж, дараа нь зарлигийн элч Лю Чжун Лу-д: “Чи зарлигийн ёсоор урилгыг гүйцэтгэсэн нь хаан миний сэтгэл лүгээ нийлэлцэв. Хожим чамайг зохистой газар тохируулсугай” гэж, гутгаарт Хингайд: “Чи аршийг хамгаалан ирэхүйд маш зүдсэн тул сайшаалтай” гэж тус Чингис хааны зарлигийг уламжилсан бөгөөд түмний ноён Боорчу-г мянганы хуягт цэрэг авч аршийг хамгаалан “Төмөр хаалгын боомт”³⁴-ыг гартугай гэсэн зарлигийг уламжилсан байна.

Чан-чунь арш нар 3 сарын 15-ны өдөр Самарканд хотоос мордож, Төмөр хаалгын боомтоор өнгөрөн, 4 сарын 5-ны өдөр Чингис хааны ордонд хүрч ирэв. Энэ үед Чингис хаан цаст уулын зүүн өмнө дэх Бараан хээр орчим байжээ. Энэ нэгэн замын байдлыг Чан-чунь арш доорхи мэт уянгалж дүрсэлжээ.

“Аглаг замд ад буг аюултай ч

Ас шуудсан бумбыг мятаан үл чаднам.

Уг өргөө дорно далайгаас аялаж,

Унах нарны чухам нутагт ирэв.

Тахиа галууны дуун үл соностовч,

Тал бялхам адуу мал харагдмуй.

Уул нуруу ус мөрөн сүлжилж,

Учрыг эс мэдэгчид аль гүрэн хэмээмүй”

Чан-чунь арш Чингис хааны ордонд ирж орон сууцаа төвхнүүлмэгц, хаанд барааджээ. Чингис хаан Чан-чунь арштай анх учирсан цаг бол хар морин жил (Чингис хааны арван долдугаар он буюу 1222 он)-ийн 4 сарын 5-ны өдөр билээ. Тухайн үеийн учирсан байдлыг “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-д доорхи мэт тэмдэглэж байна:

“Хаан өгүүлрүүн: “Бусад гүрнээс учирсан боловч цөм эчсэнгүй. Өдгөө түмэн газрын алсаас энд ирсэнд хаан би машид баярлав.”

Хариу өгүүлрүүн: “Хөдхи бумба зарлигаар ирсэн нь тэнгэрийн санаа болой”. Хаан баярлаж суудал соёрхов.

Зоогийн дараа хаан асууруун: “Арш хол дахинаас ирлээ, хаан надад ямар урт наслах эмийг хайрлах буюу?”

Багш өчрүүн: “Амь насыг хамгаалах ёсон буйгаас бус, ашид мөнхрөх эм үгүй болой.” Хаан түүний шулуун цагааврыг сайшааж, хааны цацрын зүүн этгээдэд хоёр майхан бариулж байрлуулав.

Хэлмэрч асууруун: “Багшийг тэнгэрээс түрүүлсэн мөнх хүн хэмээн хэлэлцдэг бөлгөө. Өөрөө нэрлэсэн буюу? Бусдаас дуудсан буюу?”

Багш өчрүүн: “Хөдхи бумба өөрөө нэрлэсэн бус, өөр хүмүүсийн дуудлага бөлгөө.” Хэлмэрч дахин эчиж асууруун: “Хэрхэн энэ мэт дуудсан буюу?”

Хариу айлтгаруун: “Анх хөдхи бумба дөрвүүл Ван Чжун Ян хэмээгч багшаас бумбын ёсыг сурсан бөлгөө. Бусад гурван шавь нэгэнтээ хальж, гагцхүү хөдхи бумба амьд аху тул хүмүүс Сянь-шэн хэмээх болой”

Хаан Хингайгаас асууруун: “Аршид ямар цол өргөмжилбөөс зохих буюу?”

Хингай айлтгаруун: “Хүмүүс дээд багш, арш, хутагт арш хэмээн өргөмжлөх бөлгөө”

Хаан өгүүлрүүн: “Энэ өдрөөс хойш хутагт арш хэмээн дуудсугай”. Тэр үед тэнгэр бөгчим

халуун тул хааны хамт Цаст уулнаа (Бараан хээр - эшлэгч) зусав. 4 сарын 14-ний өдөр (Бумбын суртахууны) ёсыг асуухаар болзвой.

...Гэтэл Хотонгийн мөргөлтний дээрэм дэгдсэн тул хаан өөрөө дайлахаар шийдэв. Иймийн тул 10 сарын өлзийт өдөр асуухаар тогтов. Багш уулын байртаа буцахыг гуйчлав.

Хаан өгүүлрүүн: “Дахин ирвээс бас чилээх ажгуу”.

Энэ бол Чингис хаан болон Чан-чунь арш түрүү удаа уулзаж ярилцсан байдал болно. Ингээд Чан-чунь арш мянган морьт цэргээр хамгаалуулж, өөр замаар Самаркандад буцжээ.

1222 оны 8 сарын эхээр Чан-чунь арш Самаркандаас дахин мордож, тус сарын 22-ны өдөр, Чингис хааны ордон (энэ үед хааны аяны ордон нь Гиндукуш нурууны хойд бэл Аму-Дарья мөрнөөс гурван өдрийн зайтай газар байлаа гэдэг)-д хүрч хаан лугаа хоёрдугаар удаа бараадсан бөгөөд зам турш хэдэн удаа ярилцсан байна.

Тухайн үеийн бодтой байдал нь доорхи мэт:

“22-ны өдөр, Тянь Хингай ирж угтав. Хааны ордонд хүрсний дараа, хаан Хингайг дахин томилон асууруун:

“Даруй уулзах буюу? Баахан амсхийх буюу?”,

Багш өчрүүн:

“Бараадахыг хүсмүй.” Бумбын сүсэгтэн хаан лугаа учрахуйд ерөөс сөгдөн мөргөдөггүй тул цацарт ороод хоёр гараа өмнөө атгаж мэхэсхийн ёслов. Уулзалтын дараа, цэгээ соёрхсоныг цөм талархан эс хүртэв.

Хаан асууруун: “Хотод суухуйд, хэрэгсэл хангалт бүрэн буюу?”

Багш хариу өчрүүн: “Ерөөс Монгол Уйгурын тайш (Елюй Ахай-г хэлж буй – эшлэгч) хангаж байв. Ойрд идэш баахан хүчиртэй боловч тайш тусгайлан шийдвэрлэв”. Дараа өдөр, хаан бас шадар бараалхагчаа томилж: “Арш өдөр бүр ирж зоог бариваас ямар?” хэмээн хэлүүлжээ.

Багш өчрүүн: “Хөдхи бумба болбоос бясалгал бясалгагч хүн тул гагцхүү нам сэлүүнд дуртай бөлгөө” гэсэнд, хаан тааваараа болтугай хэмээн зарлиг болов. 8 сарын 27-ны өдөр хаан умарш буцав. Замын зуур орчмын архи, тарвас, цай мэтийн зоогийг соёрхож байв. 9 сарын 1-ний өдөр мөрөн (Аму-Дарья мөрөн - эшлэгч)-ий гүүрээр гаталж умарш явав.

Багш айлтгаруун: Болзсон өдөр ойртов, Ахай тайш (энд Елюй Ахай-г хэлж байх мэт, гэвч өмнөх тэмдэглэлийг үндэслэвэл, Елюй Ахай энэ үед Самаркандад байснаас биш Чан-чунь аршийг дагалдан ирсэнгүй мэт – эшлэгч)-ийг дуудаж болох болой .

9 сарын тэргэл өдөр (арван зургаан) хаан цацар босгож, цав бэлтгэн, зул хүж барин, эмс охидыг зайлуулаад, зөвхөн чэрби, хингай, зарлигийн элч Лю Чжун Лу зэрэг гадаа нь үйлчилж байв. Багш, Ахай тайш, Арашаны хамт цацарт орж суув. “Чжун Лу түмэн газрыг хамтад аялж”

Хингай хэдэн мянган газрын холоос хүргэн ирсэн тул цацарт оруулж ёсыг сонсговоос зохих болой хэмээн (багш) айлтгасанаа тэр хоёрыг дуудун оруулав. Багшийн хэлснийг Ахай тайшаар монголчлуулан айлтгасан тул богд (Чингисийг хэлж буй-эшлэгч)-ын таалалд маш хангамжтай тохиров.

Тус сарын 19-ны саруул шөнө багшийг дахин залж ёсыг номлуулсан бөгөөд хаан их баярлав.

Тус сарын 23-ны өдөр, багшийг бас цацарт саатахаар зарлав, уулзсан ёслол тэргүүнийнх лүгээ адил. Хаан амирлангуй дүрээр сонсч, бичиглэн автугай хэмээн дэргэдэх хүмүүстээ тушааж, үл мартагын тулд хятад үсгээр тэмдэглэсүгэй хэмээсэн бөгөөд “Хутагт аршийн гурван удаа өгүүлсэн урт наслахуй ёс нь миний сэтгэлд гүн суугдав, гадагш задруулж үл болмуй” хэмээн дээрх хүмүүст хэлэв.

Чингис хаан Чан-чунь арштай хоёрдугаар удаа уулзан ярилцсан байдал ийм билээ.

Дараа нь Чан-чунь арш Чингис хаантай хамт умарш буцсан бөгөөд хойд жилийн 3 сард нутагтаа харихаас өмнө бас Чингис хаантай зам зуур хэдэн удаа ярилцжээ.

Тус оны 12 сарын сүүлчээр, Ходжен мөрөн (энэ бол Сыхун мөрөн буюу Сыр-Дарья мөрөн болно, тус мөрөн нь Ходженд хотоор өнгөрдөг болохоор ингэж нэрлэжээ-эшлэгч)-ийг гатлан гарсны дараа голын гүүр шөнө дүлээр нурж их доргион сонссонд Чингис хаан аянтын тухай Чан-чунь аршаас асуужээ.

Хариуд нь: Хөдхи бумба соносхул, эрхин улсын хүмүүс зуны цагт голын уснаа бие угаадаггүй, хувцас угаадаггүй, эсгий үйлддэггүй бөгөөд мөөг арвин ургавч түүнийг түүдэггүй хэмээмүй. Учир нь тэнгэр ниргэхээс аймуй. Энэ болбоос тэнгэрээс тотоосон ёсон бус болой. Харин сонсохуйд, гурван мянган ял нүглийг үйлдсэн ч ачлалгүй нэгнээс үл хэтэрмүй, учир нь ачлалгүй явагсадыг тэнгэр ерөөс цээрлүүлдэг болой. Өдгөө сонсвоос, эрхэм улсын зан заншилд эцэг эхийг үл ачлах нь цөөн бус хэмээмүй. Хаан та эрдэм сүрээ бадруулан, ачлалгүй тэдгээрийг олноо сэрэмжлүүлбээс болох ажгуу гэж хэлжээ.

Чингис хаан баярлаж: Хутагт аршийн үг, хаан миний санаанд чив хэмээн нийлэв гэж хэлээд бас “Дэргэдэх хүмүүсээ уйгур үсэг (уйгуржин монгол үсэг болох нь дамжиггүй - эшлэгч)-ээр тэмдэглэн автугай хэмээн зарлиг буулгав”. Дараа нь (үүнийг) улс даяарт мэдэгдвээс болох хэмээн багш гуйчилсанд, хаан зөвшөөвэй. Бас хөвгүүн, олон ван, олон сайд нарыг цуглуулж: “Хятад хүн хутагт аршийг хүндлэх нь үлгэрлэвээс та нар тэнгэрийг бишрэх лүгээ адил болой. Өдгөө би тэнгэрийн мөнх хүнийг улам итгэх болов” гэж хаан хэлээд, багшийн урьд хожид айлтгасан үгсийг уламжилсан бөгөөд “Дээд тэнгэр хутагт аршаар эдгээрийг хаан надад хэлүүлсэн бөлгөө. Та нар тус тус марташгүй цээжлэн автугай” хэмээв. Багш ёслон ухрав.

Түүний дараа, цэрэг зүүнш буцаж, нэгэн их мөрөн (Ташкент орчмын Киргиз мөрөн бололтой)-д хүрсэн байв. Энэ үед нэгэнтээ 1223 оны хавар болжээ.

Чингис хаан болон Чан-чунь аршийн хамаг сүүлчийн хэдэн удаагийн уулзалт энд явагджээ. Эдгээр уулзалтууд нь Чан-чунь арш улстаа буцах үеийн ёслолын чанартай уулзалт болно.

2 сарын 7-ны өдөр, Чан-чунь арш Чингис хаанд бараадаж: Хөдхи бумба уг нутгаас гарч ирэх үед, гурван жил болоод буцаж харьсугай хэмээн болзсон бөлгөө. Өдгөө нэгэнтээ гурван жил болсон тул агуйдаа буцахыг хүсэж амуй, хаан соёрхох болов уу гэж айлтгав.

Хаан: Хаан би нэгэнтээ зүүншилбээс, хамтдаа буцваас болох буй за хэмээн өгүүлэв.


Хариу: Хөдхи бумба ирэхүй үес хятад хүмүүс хэзээ буцахыг асуусанд, гурван жил хэмээн хариулсан бөлгөө. Өдгөө буцах тухай тодорхой айлтгаж дуусав, хаан зөвдөн тольдох болов уу гэж өчив.

Хаан: Тав, гурван хоног түр хүлгэлзэх болов уу, тайцзи нар ирсэн хойно, урьдахи үгсийг үл ухагсадыг хаан би ухааруулаад даруй мордсугай хэмээв.

2 сарын 24-ний өдөр, төрөөс салах ёслолыг дахин гүйцэтгэв. “Хутагт арш буцах учир ямар эдсийг хүргэхийг хаан би бодолхийлон амуй, нэн охорхон хэдэн өдөр хүлгэлзэх болов уу” гэж хаан өгүүлжээ .

3 сарын 7-ны өдөр, дахин салах ёсыг гүйцэтгэв. Хаанаас морь үхэр зэрэг зүйлсийг шагнав. Багш цөм үл тогтоосон бөгөөд “гагцхүү агт улаа гүйцвээс барав” гэж өгүүлэв. “Хятад газар хутагт аршийн шавь нар хэчнээн буй?” хэмээн хэлмэрч Аришанаас хаан асуусанд: “Маш олон амуй. Хутагт арш нааш ирэх үед Дэ Син Фу-гийн Лун Ян Гуань сүмд түшмэд лүгээ учрахуйд, алба гувчуурыг шаардаж асан бөлгөө” хэмээн хариулав. “Доод шавь нарт зарлигаар мэдэгдэн хэлтрүүлбээс зохимуй” хэмээн хаан айлтгаж, хааны тамгыг дарсан зарлигийн бичгийг соёрхов. Бас Аришанаар зарлигийн элч болгон, Мөнхтэй, Харабахай хоёроор дэдлүүлж, багшийг хамгаалан зүүнш хүргэхээр зарлиг буулгав (“Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”).

1223 оны 3 сарын 10-ны өдөр, Чан-чунь арш Чингис хаанаас салан мордов. Дархан түрүүтэй олон сайд түшмэд үзмийн архи, үнэт жимсийг өргөн хэдэн арван газар гартал хүргэж, бүр нулимс унаган салалцсан гэлээ.



Зураг – 82. Чан-чунь арш баруунш зорчсон аяны шуум зураг

Өмнөд Сүн улсын алдарт бумба Чан-чунь арш Монголын анхдагч их хаан Чингисийн

урилгаар алс холын мянга түмэн газрын аян замыг туулж, Азийн төвд хүрч Чингис хаантай уулзаад явсан түүхэн явдал ч ингээд дууссан юм.

Чан-чунь арш 1223 оны сүүлчээр Сюань Дэ хотод буцан ирж, дараа жилд нь Яньцзин хотын Тянь Чан Гуань сүмд очин суусан бөгөөд 1227 онд наян настайдаа мөн энд нас барсан байна. Үхсэн дараа нь түүний шарилыг одоогийн Бээжингийн баруун өмнө Си Бянь Мэнь хаалгын гадна бүхий Бай Юнь Гуань сүмд оршуулсан байна. Чан-чунь аршийн сууж байсан Вань Ань Гүн ордон (Алтан улсын аяны ордон байжээ)-г бас “Умард ордны аршийн арал” гэдэг. Энэ бол одоогийн Бээжин хотын Бэй Хай цэцэрлэгт бүхий цагаан суваргат арал болно.

“Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл” гэдэг алдарт жуулчлалын бичгийг Чан-чунь аршийн шавь Ли Чжи Чан (1193 - 1256) гэгч зохиожээ. Тус тэмдэглэлээр бол Ли Чжи Чан, багшаа дагаж монгол орноор дайран, Дундад Азид очиж Чингис хаантай уулзсан бодтой байдал ба зам зууртаа үзэж сонссон зүйлс жич Монголын газар орон, зан заншлын тухай нарийн тодорхой тэмдэглэсэн ууган тэмдэглэл болно. Тиймээс тэр нь Монголын түүхэн судлалд олтгойлж болшгүй чухал материал болох ёстой.

Тус зохиолыг дээд доод хоёр боть хуваадаг. Тус ном зохиогдоод таван зуун далаад жил болтол хүмүүст ер анхаарагдсангүй байв. Сүүлд нь Чин улсын Тэнгэр Тэтгэгчийн жардугаар он (1795 он)-д, тухайн үеийн эрдэмтэн Цзянь Да Синь, Дуань Юй Цай нар Шу Чжоу хотын Юань Мяо Гуань сүмээр тойрч, “Дао Цзан” номыг урвуулж байгаад сая олж мэдсэн бөгөөд Цзянь Да Синь сийрүүлэн авч дэлхий нийтэд тархаажээ. Сүүлийн үед Ван Го Вэй, Чжан Син Лян нар тайлбарлан барлуулжээ. Гадаадад Орос, Франц, Англи хэлээр орчуулагдсан байна.

Үгүсүн Жүанда “Умарш элчилсэн” нь

Үгүсүн Жүанда гэгч бол Алтан улсын ёслолын яамны дэд сайд болно. Түүний чухам нэр нь Бүхи гэдэг.

Алтан улсын Сюаньцзун хааны Син Дин-гийн дөрөвдүгээр он (Цагаан луу жил, 1220 он)-ы 7 сард, Үгүсүн Жүанда-г бичгийн яамны жасааны Ань Тин Чжэнь (бас Ань Янь Чжэн гэж бичдэг)-ий хамт эвсэхийг гуйчилахаар их Монгол улсад элчлүүлэв. Тэд урьдаар умард оронд Го ван Мухулай лугаа уулзав. Ингээд Ань Тин Чжэнь-ээ үлдээж, Үгүсүн Жүанда ганцаараа Чингис хаанд бараадахаар Дундад Ази өөд явжээ. Тиймээс Үгүсүн Жүанда хэрэг дээрээ бас л баруунш элчилсэн явдал болно. “Үгүсүн Жүанда-гийн умарш элчилсэн тэмдэглэл” гэдэг нь, тэр эхлэхийн үедээ Алтан улсын өмнөд нийслэлээсээ умарш явсан болохоор ингэж нэрлэсэн ч магадгүй.

Үгүсүн Жүанда Синь Дин-гийн дөрөвдүгээр он (1220 он)-ы 7 сард Тангуд улсаар дайрч, элс манхаар туулан, Хар Хятаны нутгаар өнгөрөөж, 1221 оны 7 сард³⁴ баруун оронд дайлж байсан Чингис хааны ордонд хүрч, төрийн бичгээ өргөн эвсэхийг гуйчилжээ.

Чингис хаан энэ үед Талаханы уулархаг оронд зусаж байв. Алтан улсын төрийн бичигт Чингис хааныг “ах” гэж дуудаж байсан гэлээ. Энэ нь Чингис хаанд авч хэлбэл, яриангүй өдөөлгийн чанартай хэллэг байжээ. Чингис хаанаас Үгүсүн Жүанда-д өгсөн хариу нь Алтан хааны хүсэлтэй нь нэлээд зайтайхан байв. Чингис хаан хэлсэн нь: “Хэрвээ надад голын

умардахи (Хатан голын умаршихийг хэлж буй- эшлэгч)орноо тавин өгч, Алтан хаан цолоо орхиж, Хэнань (Хатан голын өмнөд орны) ван болох болбоос харилцан цэрэг ухарсугай хэмээн би урьд чиний эзэнд мэдэгдсэн бөлгөө, гэтэл чиний эзэн эс хүлээв. Өдгөө Мухулай нэгэнт эзлэн дуусахуй үед сая эвсэхийг гуйчилсан буюу” гэв. Энэ үед Үгүсүн Жүанда бас хөөрхийлөлтэй байдлаар дахин давтан гуйчилсанд “Чамайг хол газраас ирсэн учир (дахин нэг удаа өгүүлсүгэй): голын умард орон нэгэнт минийх болов, боомт (Тунгуань боомтыг хэлж байх мэт - эшлэгч)-оос баруунш эс эзлэгдсэн хэдэн хотыг надад харьяалуулан өгөх хэрэгтэй бөгөөд чиний эзнийг мөн хүү Хэнань ван болсугай хэмээн тушаа, дахин зөрчиж үл болмуу” гэж Чингис хаан хэлэв.

Ингээд Үгүсүн Жүанда буцан явжээ.

Үгүсүн Жүанда-гийн “Умарш эзэлсэн тэмдэглэл” гэдэг бол Үгүсүн Жүанда Алтан хааны зарлигаар баруун оронд элчилж, Чингис хаан лугаа уулзсан явцыг товчхон тэмдэглэсэн тэмдэглэл болно. Энэ бол Үгүсүн Жүанда-гийн хэлснийг Лю Ци гэгч тэмдэглэн авч түүний зохиосон “Гуй Цзянь Чжи” гэдэг номын арван гуравдугаар ботид дагалдаас болгожээ.

Тус жил (1221 он)-ийн 12 сард Үгүсүн Жүанда нар төрдөө буцаж албаа тушаажээ. Алтан хаан тэднийг зүдрэв гэж Үгүсүн Жүанда-г хоёр зэрэг, Ань Тин Чжэнь-ийг нэгэн зэрэг тус тус дэвшүүлж сайшаасан гэлээ.

Алтан улсын элч Үгүсүн Жүанда, өмнөд Сүн улсын алдарт бумба Чан-чунь арш хоёр бол Чингис хааны хол замын өргөн довтолгооны өмнө фронтод очсон энх тайвны элч юм. Нэг нь бол уригдаж очсон, нэг нь бол зорьж очсон, нэг нь бол хүн төрөлхтөний боловсон ёсыг сурталчлах, нэг нь бол газар сайгүй төрөлжин өрөвсч бүхий дайны түймрийг зогсоож, төрийн эрхээ хамгаалах үүргээ гүйцэтгэхийн төлөө тус тус зорьж иржээ. Гэтэл тэдний олсон үр дүн нь тус тус адилгүй байсан нь тодорхой байна. Тус бүлэгт бид Чингис хааны баруунш дайлсан дайралт - Хорезм улсад цэрэглэсэн их дайныг тэмдэглэв.

Энэ удаагийн дайн нь Хорезм улсыг туйлбартай мөхөөсөн дүнгээр дуусчээ. “Монголын байлдан дагууллын амжилтын нэг шалтгаан нь Монголын цэргийн зохион байгуулалт, байлдах чадвар өндөр байсантай холбогдолтой юм. Гэвч Монголын байлдан дагууллын амжилтыг зөвхөн монгол цэргийн сайн зохион байгуулалт, байлдах чадвар төдийгөөр тайлбарлавал маш учир дутагдалтай бөгөөд үнэн байдалд нийцэхгүй. Монголын цэргийн амжилтын гол нэг шалтгаан бол Монголын довтолгоонд эрсэдсэн орнуудын ихэнх нь феодалын бутралын уршгаар сулран доройтож, дотооддоо эе эедэлгүй байснаас Монголын цэргийн эсрэг эсэргүүцэл үзүүлж чадалгүй байснаар тайлбарлана” (“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”, тэргүүн ботийн дэд хэсгийн нэгдүгээр ангийн гуравдугаар бүлэг) гэж тэмдэглэж байх нь энэ удаагийн дайны тухай нэг зүйлийн үзэлт болно.

Энэ удаагийн дайн бол түүний өмнөш дайралт - дээдсийн өстөн Алтан улсад цэрэглэж байх явц дунд үүссэн юм. Хэрвээ Хорезм улсын эрх баригчид Чингис хааныг тийм их хорсгосонгүй бол, хүчирхэг өшөөтөн Алтан улсад хийж байгаа дайны шийдвэрлэгч цаг үед өөрийн хүчээ салгах ёсгүй байх аа.

Дундад Азид болсон энэ удаагийн их дайныг Монгол улсын арилжааны анги ба төрийн элч

хорлогдож, Чингис хаан түрүүтэй шинэхэн мандсан Хаант Монгол Улсын нэр хүндийг гутаасан өсийг өслөж цээрлүүлэхийн тулд маш ширүүн догшноор явуулжээ. Энэ удаагийн дайны бүх үр дүнгээс үздэг бол тэр нь эхлэлтийнхээ зорилгоос хол хэтэрч, феодал ноёрхогчдын хоорондохи өсөл хясал нь айхавтар сүрхий аюул болж, жирийн ард түмний толгой дээр буужээ. Гэтэл, энэ аюул чухам яаж үүссэн, аль хир гамшиг учруулсан жич түүнийг яаж таних тухай сүүлчийн хүмүүс хараахан адилгүйгээр үзэцгээдэг юм. Урьдын хүмүүсийн үйлдсэн ямар нэгэн хэрэг (сайн хэрэг ба муу хэрэг)-ийн хариуцлагыг яасан ч сүүлчийн хүмүүсээс даан хариуцах ёсгүй, гэвч урьдын хүмүүсийн үйлдсэн ямар нэгэн хэргийг боловч шинжлэх ухаанчаар, үнэн зөвөөр, төв голчоор тодорхойлж үнэлэх явдал бол сүүлчийн хүмүүсийн заавал хариуцах хариуцлага болох ёстой.

Дагалдвар

1 Хорезмын тухай бас хэдэн янзын хятад бичлэг буй. Жишээлбэл, Накамичиё-гийн зохиолд “Ко-ла-цзы-мэй”, Эрдманы зохиолд “Ко-лэ-цзы-мэй”, Елюй Чу-сай-н “Баруунш зорчсон тэмдэглэл”-д “Мо-су-лу-мань” гэж тус тус тэмдэглэж байдаг.

Хорезм усун сүүлчийн байдал гэвэл, 1388 онд Чагаадай хаант улсын хойч үрс Төмөр (энэ бол Төмөр хаант улсыг байгуулсан доголон Төмөр гэгч болно)-т эзлэгджээ. Арван зургадугаар зууны эхээр Узбект харьяалагдсан бөгөөд арван зургадугаар зууны дунджаар Хива (Khiva) гэдэг хотод нүүн нийлсэн учир Хива Хант Улс гэж нэрлэх болжээ. 1873 онд хаант Орос улс эзлэн авсан байна.

2 Чингис хааны баруунш дайлсан шалтгааны тухай тэмдэглэлүүд: “Нууц товчоон”-ы 254 дүгээр зүйлд: Түүний хойно Чингис хааны сартаул иргэнд явуулсан Ухуна тэргүүтэн зуун элч алагдсанд, Чингис хаан өгүүлрүүн: “Алтан аргамж”-аа сартаул иргэнээр таслуулаад зүгээр орхиж болох уу? Ухуна тэргүүтэй зуун элчийн өшлийг өшиж, хяслыг хясаж, Сартаул улстай байлдъя” гэж мордоход... (Ц.Дамдинсүрэнгийн одоочлого, 332 нүүр) гэжээ.

“Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т: (Чингис хааны) арван дөрөвдүгээр он (1219 он), шарагчин туулай жил ... зуны зургаан сар, баруун орон (Хорезмыг хэлж буй – эшлэгч)-ыхон элчийг алсан тул хаан өөрөө цэрэг дайчилж дийлэв... (Чжунхуа бичгийн хорооны шинэ хэвлэл, нэгдүгээр боть, 20 нүүр) гэжээ.

“Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: (Чингис хааны) арван хоёрдугаар он (1217 он)-ы 8 сар ... Монголын худалдаачид Ухуна нарын зуун хүнийг Хорезм улсын Отрар хотын түрүү нь алж, эд агуурсыг нь дээрэмдэн авсан чимээг хаан сонсч, Алтан улсыг дайлах явдлыг Мухулайгаар хариуцуулан, өөрөө баруун орны явдлыг бодолхийлов (гуравдугаар боть, 19 нүүр) гэжээ.

Елюй Чжу (Елюй Чусайн хөвгүүн)-гийн зохиосон “Шуан Си Цзуй Инь Цзий” гэдэг номд: “Өнгөрсөнд манай Тайцзу хаан баруун оронд цэрэглэж ял асуужээ” (Баярын “Алтан улсын үндэстний харьцаа ба Чингис хаанаас Алтан улсад хэрэглэсэн байлдах бодлого” гэсэн өгүүлэлээс дам эшлэв) гэжээ.

“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-д: Чингис хаан монгол орныг нэгтгэсэнээс хойш, монгол орон амар тайван болж, эл газрын худалдаачид тэнд очиж ашиг хонжоо олдог байжээ.

“Тиймээс Ходженд хотын Ахмад, Ими ноён Хусейн-ий хөвгүүн, бас нэгэн Ахмад, Балхиг гэгч худалдаачид гурвуул дорно дахины орнуудаар явахаар тогтож, олон арвин эд таваар - хоргой, бүс, занданы нэхмэл (Бухараас умардахи Зандана хотод гардаг нэгэн зүйл нэхмэл) болон бусад зохистой гэсэн эд барааг төхөөрч аялжээ. Энэ үед Монголын эл аймгуудын олонхи нь Чингис хаанд ялагдаж, тэдний орон сууц нь эвдэгдсэн бөгөөд бүх орны урвалган нэгэнтээ устгагджээ. Тиймээс Чингис хаан их зам дагуу харуул (Үүнээ тэд харагч qaraqchis гэж нэрлэдэг) тавьж, бас нэгэн засаг (хууль - эшлэгч) нийтэлжээ. Тэр нь: тэдний улст орох худалдаачдад цөм гэрч баталбар олгох хэрэгтэй бөгөөд хаан хэрэгсвээс зохих эд барааг эзнийх нь хамт урьдаар хааны дэргэд хүргэж бараадуулах хэрэгтэй гэжээ. Эдгээр худалдаачид Монголын хилд хүрсэн хойно, Балхиг-ийн нэхмэл ба эд барааг нь харагч нар тоосон болохоор Чингис хаанд хүргэн барагдуулсан байв. Ингээд Балхиг эд бараагаа дэлгэн гаргаж, арав буюу хорин динар (энэ динар бол Арабын алтан зоос биш, Ираны нөхвөр зоос болно. Зуун динар нь нэг риалтай тэнцдэг гэлээ – эшлэгч)-аар авсан нэхмэлээ гурван алтан балишийн үнэ хаясан гэлээ. Түүний энэхүү оргио үнэлсэн явдалд Чингис хаан ихэд хилинлэн: “Энэ амьтан, ийм нэхмэл эд манай энд ерөөс ирээгүй гэж үзэж байна уу?” гэж хэлээд хааны санд хадгалж бүхий нэхмэлийн зүйлийг гаргаж Балхигт үзүүлээд, түүний бараа таваарыг нь хураан авсан бөгөөд Балхигийг барьж авчээ. Дараа нь Чингис хаан түүний хань сэлтийг нь дуудун авчирч, бараа таваарынхи нь үнэ өртгийг дахин давтан асуусан боловч, эдгээр худалдаачид ер үнэ ханш дуудсангүй мөртөө: “Бид эдгээр нэхмэлийг дуртайяа хаанд өргөсүгэй” гэж хэлсэн гэлээ. Энэ үг нь харин Чингис хааны сайшаалыг олж, нэгэн толгой хоргой, хоёр толгой бүс буюу Зандана-гийн нэхмэлд нь тус бүр нэгэн алтан балиши зоосны үнэ өгсөн байв. Бас тэдний хань сэлт Ахмад (Балхиг)-ыг тавин гаргаж, бараа таваарыг нь адил үнээр худалдан авсан бөгөөд тэд гурвыг цөм эрхэм хүндээр зочилсон байв. ...

Эдгээр худалдаачид буцах үед, Чингис хааны зарлигаар, түүний хөвгүүд, ноёд, өрлөг тус бүрийн харьяатаас хоёр гурван хүнийг сонгон татварлаж, тэд нарт нэгэн алтан балиши буюу мөнгөн балишийн бэл мөнгө өгч, тэдгээр худалдаачдын хамт Султан (хаан)-ы улс (Хорезмыг хэлж байна – эшлэгч)-д илээн, тэнд очиж арилжаа худалдаа хийн, ховор сонин эд эрдэнийг авчир гэж тушаасан байна. Энэхүү зарлиг ёсоор татварласан дүнд нийт дөрвөн зуун тавин Мусульманчуудыг цуглуулсан байв. Дараа нь Чингис хаанаас Султан ханд доорхи элчин мэдээг бариулжээ: Манай энд ирсэн танай улсын худалдаачдыг одоо буцаав. Байдлыг нь ч удалгүй мэдэх байлгүй. Бид бас худалдаачны бригадаа тэдний хамт таны улсад очуулж, танайхны эд эрдэнээс худалдан авахаар томилов. Үүнээс хойш, бидний хоорондохи харьцаа ба найрамдлын хөгжихийг дагалдан, тэрхүү өс өслийн урхагийг анагааж, урваан үймээнийг хорыг цэвэрлэж болох юм гэсэн байв.

Энэхүү худалдаачны бригадынхан Отрар хотод хүрсэн байв. Тус хотын түрүү ноён нь Иналчук гэдэг хүн байжээ. Тэр бол Султан ханы эх Теркен хатны угсаатан бөгөөд Гайир хан гэдэг цолоор өргөмжлөгдсөн гэлээ. Эдгээр худалдаачдын дотор, уулаасаа энэхүү ноёныг таньдаг нэгэн Энэтхэг гаралтай хүн байсан юм байна. Энэ худалдаачин бас урьдынхаа ёсоор хотын ноён гуайг Иналчук гэж дуудсан бөгөөд өөрийн хаан (Чингис хааныг хэлж байна - эшлэгч)-ыхаа хүчин чадалд эрдэж, өөрийн биеийн аюул түгшүүрийг хайхралгүйгээр хотын ноёныг эс хүндэлж гэнэ. Тиймээс Гайир хан ихэд төвдүүргүй болсны хамт эд хөрөнгөд нь шунах санаа үүсчээ. Ингээд тэр эдгээр худалдаачдыг барьж авсан бөгөөд Иракад бүхий Султан хандаа элч илгээж, худалдаачдын тухай хэргийг мэдүүлжээ. Султан хан нь харин өчүүхэн ч

болгоомжилсонгүйгээр худалдаачдын амийг нь хороохыг зөвшөөрсөн бөгөөд тэдний эд барааг нь хураах нь зүйтэй гэж үзжээ...

(Султан ханы) энэхүү зарлиг хүрэхээс өмнө, нэгэн худалдаачин гяндангаас нь дутаан гараад, учир явдлын үнэн өнгөрөлтийг нь тодорхойлж, хань сэлтийнхээ байдлыг нь сураглаж ойлгоод, тэндээс зайлан гарч (Чингис) хааны дэргэд хань сэлтийнхээ учралыг мэдүүлжээ. Эдгээр чимээ нь хааны сэтгэлийг дутаахын аргагүй болгож, тэрхүү өс хилингийн хуй салхинаас дэгдсэн тоос шороо өршөөлийнх нь нүдийг бүрхэж, хилингийн гал тэнгэр тулам бадарч, хайрын нулимас нүүр дүүрэн асгарч, халуун цуснаасаа өөр юуны ч гэсэн энэ галыг унтрааж эс чадах болжээ. Энэхүү хэнээрэл доор, Чингис хаан ганцаараа нэгэн уулын орой дээр гарч, малгайгаа авч, эх дэлхийг бараалан гурван хоног наманчилж: Би бол энэхүү аюул гаслангийн өдөгч биш, надад өшөө авах хүчийг соёрхох болов уу гэж уулаас бууж, дайнд бэлтгэх ажилгаагаа хийсэн гэлээ. ...Дараа нь Чингис хаанаас Султан ханд элч томилж, түүний тэрхүү итгэмжээ алдсан явдлыг нь дурдсан бөгөөд өөрөө дайлах гэж байгаагаа мэдэгдэж, түүний жад сэлмээр зэвсэглэж, байлдааны бэлтгэлээ сайтар хийсүгэй гэж сэрэмжлүүлсэн байна (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн хятад хэвлэл, 90-93 нүүр) гэв.

“Д’Оссоны Монголын түүх”-ийн тэмдэглэл нь “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-ийн тэмдэглэлтэй үндсэндээ адил билээ. Гэвч бас лавлууштай зүйл байх тул голдлогыг нь доорхи мэт сийрүүлэв: Анхандаа Татар орны олон нүүдэлчин аймгууд дээрмийн ажиллагаагаар гол амьдралаа болгож байв. Одоо олон аймаг бүр Чингис хааны харьяат болжээ. Ингээд Чингис хаан орон нутгийн аян замын амар түвшнийг хамгаалахын тулд олон зам дээр хамгаалагч томилж, анхаарууштай бараа таваарыг авч явж бүхий гадаад улсын худалдаачдыг Монголын хааны ордонд хүргэдэг байна. Хар Хятаны хаант улс мөхсөнөөс Мухаммедын харьяат газар нь Туркестаны төв бологч, Монголын хаанд харьяалагдсан уйгур улс лугаа зах зэргэлсэн бөгөөд Хүчүлүгийн эзэлж байсан газар нь зөвхөн Кашгар, Хотон, Яркент төдий л байв. Энэ үед Мухаммедын харьяат Исламын шашны мөргөлтөн гурван хүн бөс бараа тээж монголд хүрчээ. Эд гурвын нэг нь урьдаар Чингис хаантай учирч, бараа таваартаа айхавтар их үнэ дуугарч гэнэ. Үүнд Монголын хаан хилинлэж: “Биднийг ийм бөс бараа олж үзээгүй гэж чи үзэж байна уу?” гэж өөрийн хадгалж байсан зүйлсээ гаргуулж үзүүлсэн бөгөөд бас хураан авсан Хорезмын эд барааг нь гаргаж үзүүлжээ. Дахиад нөгөө хоёр худалдаачныг нь дуудун авчирсанд тэр хоёр үнэ хэлэлцэхээс айж, (хаанд) өргөн барья гэж хэлсэн гэлээ. Гэтэл Монголын хаан нь харин их үнэ өртгийг өгсөн бөгөөд түрүүчийн худалдаачинд нь бас үнэ шагнажээ. Ингээд гурван худалдаачныг шинэ цагаан эсгий гэрт суулгаж, хүндээр зочилсон гэнэ. Эдгээр худалдаачныг буцах үед, Чингис хааны зарлигаар олон ван, ноёд, өрлөгүүд тус бүрээс эд бодос ба нэг, хоёр итгэмжит зарц татварлан гаргаж, Хорезмын ховор гаралтыг арилжуулахаар тэдний хамт явуулжээ. Эд нар нийлээд дөрвөн зуун тавин хүн байсан бөгөөд бүр Исламын шашны мөргөлтөн байв. Эд нэгэн зам явж Сыхун мөрний эхэн дэх Отрар хотод хүрчээ. Энэ хотын түрүү нь Гайир хан гэдэг цолтой Иналчук гэсэн хүн байжээ. Тэр, эдгээр худалдаачдын авч яваа зүйлд нь шунахайрч бүгдийг Чингис хааны тагнуул гэж гүтгэн барьж авсан бөгөөд Мухаммеддаа мэдүүлж, бачим сандруугаар алж орхижээ.

Энэхүү чимээ нь дамжсаар байж, Чингис хааны чихэнд хүрсэнд, хаан цочин хилэглэж, нулимсаа асгаруулсаар нэгэн довын дээр гарч, малгайгаа аван, бүсээ хүзүүн дээрээ тавин

сөгдөж, өшөө авахыг тэнгэрээс гуйчилж, гурван хоног наминчлаад сая буун иржээ. Хорезмд цэрэглэхээс өмнө, үлдэгдэл дайсан Хүчүлүг-ийг устгаж, дараа нь Бахра гэгч нэгэн элчийг хоёр дэд элч монгол хүний хамт томилон, (худалдаачныг алсан) ялтныг авуулахаар Хорезмд илгээж, Мухаммедад: “Тус улсын аливаа худалдаачныг доромжлохгүй хэмээн бид урьд болзон баталсан биш үү? Нэгэн улсын эзэн атал өдгөө гэнэт гэрийг эвдэх учир юун? Отрарт худалдаачныг алсан явдал хэрвээ эрхэм таны зарлиг бус болбоос тэрхүү худалдаачныг алсан сахиул жанжнаа надад тушаан өгч миний шийтгэхийг хүлээгтүн, эс бөгөөс байлдахаар бэлтгэж байсугай” гэж хэлүүлсэн гэлээ.

Мухаммед хэдийгээр Гайир ханыг барьж тушаасугай гэж бодсон боловч, Гайир хан бол Султан ханы эхийн төрөл болохоор түүнийг үнэндээ хөдөлгөж чадахгүй бөгөөд олон жанжин нар нь эрх хүч их тул Султан хан захирч чаддаггүй билээ. Тэгээд харин элч Бахра-г алж, монгол дэд элч хоёр хүний сахал санчгийг нь хусаж буцаан явуулсан гэлээ (хятад хэвлэл, нэгдүгээр боть, зургадугаар бүлэг).

“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-д: .. Чингис хаан зоригтоо (зорилгодоо – хө.) хүрч санаа гүйцээд (Алтан улсыг дайлсныг хэлж буй – эшлэгч) дахин өөр эрмэлзэлгүйгээр Мухаммед эзэнд бичиг явуулан хэлсэн нь: “Тусгайлан элч явуулж баяр мэдүүлэх нь, би чиний сүр хүч хийгээд чиний улсын газар нутгийн уудам ихийг мэдэх бөгөөд бас чамайг миний өөрийн туйлын хайрт хөвгүүн мэт хайрлан санамуй. Жич миний этгээдийг өгүүлбээс, би нэгэнтээ Дундад улс хийгээд түүний умард этгээдийн аливаа түрэг угсаатныг дайлан авсныг чи мэдэх нь болой. Бас миний улс болбоос байлдагчдын хүрээ бөгөөд алт мөнгөний уурхай гэдгийг чи бас мэдэх буй за, тийнхүү миний улсад бус улсаас ирэх зүйлгүй болжээ. Өдгөө би миний олон ардын доторхи худалдааны ажлыг хөхиүлэн хөгжүүлсүгэй хэмээж бүхий нь хамтаар ашиг тусыг олох явдал амуй хэмээжээ. Энэ дурдсаныг эсрэг этгээд нь угаас сайхнаар хүлээн авсан боловч нэгэн зүйлийн завшаан бус хэрэг хамтаар дагалдан гарсан нь, тэргүүн удаагийн худалдааны элчийг тэндэх нэгэн ухваргүй цагдан захирагч түшмэл нь дайран довтолж баривчлан алжээ. Үүнд Чингис хаан дахин элч зарж, ялт цагдан захирагчийг барьж тушаахыг хэлүүлсэнээ, Мухаммед нь тэргүүлэгч элчийн толгойг цавчаад, үлдсэн хүмүүсийн сахлыг огтлон авч, Чингис хаанд хариу бэлэг болгон буцааж хэлүүлжээ. Энэхүү доромжлол гутаалын нөхцөл дүн нь даруй байлдааны үүсвэр болжээ (Гириний ардын хэвлэлийн хорооны монгол хэвлэл, 17-18 нүүр) гэжээ.

Владимирцовын зохиосон “Чингис хааны шастир”-т: Монгол цэрэг Дундад улст ялсан мэдээг Хорезмын Султан хан олж сонсоод, Монголын дайлан дагуулагчдын тухай гадуур хэлэлцэж байгаа янз бүрийн цуурхлыг тодорхойлохын хамт Монголын зэвсэгт хүчний найдвартай мэдээг олохын тулд элч томилж, Чингис хааны дэргэд илгээв. Энэ элч нар Чингис хааны аяны ордонд хүрсэн нь монгол цэрэг Бээжин хотыг эзлэн авсны дараахи явдал болно. Элчид нь хааны хүндэт зочлолыг хүртжээ. Монголын хаан нь дорно дахины Исламын шашныг боловсон гүрэн лүгээ арилжааны харилцаа байгуулж завшаан олоход маш дуртай байсан юм. Энэ явдал нь бараг үйлдвэрлэлийн хүчин үгүй Монголын нүүдэлчин үндэстэнд авч хэлбэл, тэдний таваарын хэрэгцээг хангах шинэ эх сурвалж болох ёстой. Чингис хаан түүний хуучин анд - Исламын мөргөлт худалдаачдаас Хорезм хаант улсын байдлыг ойлгож байсан бөгөөд түүн лүгээ нөхөрсөг арилжааны харьцаа байгуулвал аль хир ашиг хонжоотой гэснийг зөвөөр жишиж байжээ. Ийм ашиг хонжоог Исламын мөргөлт худалдаачид ч сайн мэдэж байсан юм.

...

Чингис хаан Хорезмын Султан ханд илгээсэн зарлигтаа, өөрийгөө дорно дахины ноёрхогч гэж үздэгтэй адил, түүнийг өрнө дахины ноёрхогч гэж үзэж байжээ. Ингээд тэр, хоёр улсын хооронд нөхөрсөг харьцааг байгуулж, худалдаачид дураар нааш цааш явалцахыг зөвшөөрөх хэрэгтэй гэж хүссэн байв. Хоёр хаант улсын нутаг орон зах зэргэлснийг дагалдан Хорезмын худалдаачид үнэнхүү ашиг хонжоог олсон тул одоо тэр нэгэн арилжааны бригадыг зохион тоноглож, Чингис хааны аяны ордонд сааталгүйгээр хүрч ирсэн бөгөөд худалдаачид нь эрхэм хүндэт зочлолыг хүртсэн байв. Гэтэл эдгээр харийн худалдаачид хааны зан чанарыг үнэхээр мэдэхгүй байсан бололтой, эхлэнгүүтээ тэдний бараа таваартаа хэтэрхий их үнэ дуугарсан тул хааныг ихэд хилэнлүүлэв. Тэдний авчирсан бараа таваар нь харин монгол хүнд тийм сонихон юм биш гэснийг тэд дэмий удсангүй олж мэдээд, Монголын хаан тэдэнд голч бөгөөд өршөөнгүйгээр хандсаныг сэрж мэджээ.

Хорезмын Султан ханаас элч томилсон явдалд хариу ёслолыг гүйцэтгэхийн тул Чингис хаан бас өөрийн элчээ томилж, худалдаачны бригадын хамт явуулав. Энэхүү элчид ба худалдаачид нь бүр Хорезм ба Бухара ба Мухаммедын харьяат бусад эл газрын Исламын мөргөлтнүүд байжээ. Эдгээр элчид нь Хорезмын Султан ханд хүргэхийн сонин гайхалтай эд эрдэнийн бэлэг сэлтийг авч, хоёр улсын хоорондохи арилжааны харьцааны аюулгүй байдлыг батлах зорилгоор хүрсэн байлаа. Элчид ба худалдаачны бригад нь нэгэн зам явж, 1216 онд Хорезмын нутагт хүрсэн байв. Гэвч Мухаммед элчидтэй учрах үед, худалдаачны бригад нь Отрар хотод дээрэмдсэн бөгөөд тус орны сахиул жанжны зарлигаар бүх худалдаачдыг цөм алан сөнөөжээ. Ингээд Чингис хааны томилсон хүмүүс цөм Хорезмын Султан ханы сонирхол ба сэжиглэлийнх нь тахилгын эд болжээ. Отрарт хядалга хийсэн зарлигийг хэрэг дээрээ Мухаммед нийтлэсэнгүй ч байж мэднэ. Гэвч хэрэг гарсны дараа тэр, амин хэрэгтэн сахиул жанжнаа өмгөөлж байснаар барахгүй, Монголд тушаан өгөхийг огт хүлээн авсангүй бөгөөд амин хэрэгтнийг авахаар томилсон Чингис хааны элчийг нь хүртэл алж, хааныг доромжлон гутаахын тулд бүх хүмүүсийнх нь сахлыг нь хусаж авсан гэлээ.

(Хоёр улсын) байдал ийм хэмжээнд хүрсэн тул дайтах явдал хэрэг дээрээ зайлшгүй болжээ. Анхандаа Чингис хаан, түүний амарлингуй бодлогоороо энэхүү явдлыг энх тайвнаар шийдвэрлэхийг хүсэж байв. Гэвч сүүлдээ Хорезмын Султан ханы зэрлэг балмад ажиллагаагаар буй болсон доромжлолыг хүлээхийн аргагүй байсан бөгөөд монгол хүний зан заншлаар үзэхүл, элч хүний хувь биеийг халдаж болошгүй юм. Сонсохул, Отрарт гарсан хядалгын гаслант мэдээг Чингис хаан олж сонсмогц сочин хилэглэж, өөрийн эрхгүй халуун нулимсаа асгаруулжээ. Түүний заншлаар бол, аюул түгшүүр учрах бүрт “Мөнх тэнгэр”-т дууддаг юм. Тиймээс тэр бас нэгэн довын дээр гарч, малгайгаа авч, бүсээ тайлан хүзүүн дээрээ тавин, энэхүү доромжлолыг өшөөлөх хүч соёрхохыг тэнгэрт даатган гуйчилжээ” гэж тэмдэглэж буй (Юй Юань Ань-ий хятадчилга, арван хоёрдугаар бүлэг).

Чжан Чжэнь Пэй-н зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир” болон Фэн Чен Цзюнь-ий зохиосон “Чингис хааны намтар”-ын тэмдэглэл нь их төлөв Марко Поло, Д’Оссоны тэмдэглэлтэй адилаар боловч бас нэлээд бодтой агуулгыг нөхвөрлөсөн байна. Түүнд: Чингис хаан баруун Ляо улс (Хар Хятан)-ыг дайлах үед, баруун хойдод тийм нэгэн их улс (Хорезмыг хэлж буй – эшлэгч) байна гэж сонсчээ. Ингээд худалдаачид нааш цааш амар

түвшин явалцахыг хамтаар батлах явдлыг хэлэлцүүлэхээр, Исламын шашны мөргөлтөн гурван хүнийг найрамдлын элчээр томилж мөнгөн цутгаас, хүдрийн заар, хасын эдлэл ба цагаан эсгий дээл зэрэг бэлэг сэлтийг өгч: “.....”(хэлүүлсэн үг нь Марко Поло-гийн тэмдэглэл лүгээ адил) гэж хэлүүлжээ. Үүнээс үзэхүл, хаан анхандаа зэр зэвсэг, дайн дажныг хөдөлгөх санаагүй байсан байна.

Мухаммед энэхүү бичгийг хүлээн авч, гурван элчийн доторхи нэгэн хорезм хүн Махмуд гэгчийг дУудун уулзаж: “Чи бол чухамдаа хорезм хүн билээ, чиний үнэнч шударгаа баримталдгийг би мэдэж байх юм. Чи хэрвээ үнэнээр мэдүүлбэл, ялангуяа Чингис хааны хожмын ажиллагааг нь мэдүүлбэл хүнд шагналыг хүртэх ёстой” гэж хэлээд, нэгэн эрдэнийн чулуугаар үйлдсэн бугуйвчийг гарган, түүний хэлснээ батлах итгэмжийн эд болгоод: “Чингис хаан Дундад орны газрыг дайлан авсан нь үнэн үү?” гэж асуусанд: “Ийм нэгэн том хэрэг хэрхэн худал байж болох буй” гэж элч хариулжээ. Мухаммед бас: Миний улсын уудам ихийг мэдэж байлгүй, гэтэл тэр (Чингис хааныг хэлж буй – эшлэгч) аймшиггүйгээр намайг хөвгүүн гэж хэлдэг учир юун, түүний цэргийн хүч нь хэдий байх бөгөөд дээрэмдсэн эд бодос хэдий байх буй? гэж асуулаа. Энэ үед Мухаммедад уурласан байдал илэрч байсан тул Махмуд шууд хариулахаас зайлсхийж, Монголын цэргийг хэрхэн Хорезмын цэрэг лүгээ адилтгаж болох буй гэж хэлсэнд, Мухаммед хилэн нь эхлэн тайтгарч, эвгэй хэдэн үг хэлж, элчийг буцаан явуулжээ.

Гурван элч буцан харьж, худалдаачдын аюулгүйг баталж, найрамдлаар харилцах хэлэлцээр тогтоосноо мэдүүлжээ. Ингээд (Чингис) хаан олон их замуудад харуул тавьж, болмоор бараа таваарыг авч яваа гадаадын худалдаачид ирвэл Хар хорум хотод дагуулан иртүгэй гэж тушаажээ. Энэ үед Хорезмын Исламын шашны мөргөлтөн гурван хүн бөс бараа тээвэрлэн монголд хүрч ирэв. ... (доошхи агуулга нь Джувейни ба Д’Оссоны тэмдэглэлтэй бараг адил тул товчлов)” гэжээ.

Ли Цзэ Фэнь-ий зохиосон “Чингис хааны шинэ намтар”-т Чингис хаан эхлэнгүүтээ Хорезм лугаа дайсагнах санаагүй байжээ. Хоёр улсын хооронд дайн үүссэн шууд шалтгаан бол хоёр буй. Нэг нь, Хорезм улс Монголын худалдаачны бригад ба элчийг алсан явдал болно. Нөгөө нь, Жочи болон Мухаммед хоёр санамсаргүй дайралдсан явдал болно гэжээ.

3 Хаант Монгол Улсаас Хорезмд томилсон худалдаачдын тоог “Нууц товчоон”-д “Зуун элч” гэдэг, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д мөн дээрх тоог үндэслэжээ. Зарим материалд тоо дурддаггүй. “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, “Д’Оссоны Монголын түүх” зэрэг өрнө дахины тэмдэглэл ба бусад тусгай товхимолуудад бараг бүр “Дөрвөн зуун тавин хүн” гэдэг байна.

4 Чингис хааны худалдаачны бригад хэдийд Хорезм өөд явсан, хэдийд хорлогдсон, тэрчлэн Чингис хаан хэдийд чимээ олж сонссон ба дахин элч илгээсэн зэрэг цагийн асуудал нь эл тэмдэглэлд хараахан адилгүй тэмдэглэгдэж байдаг. Цю Шу Сэнь-ий номд “1218 он”-д худалдаачны бригад явлаа гэж тэмдэглэж буй. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: (Чингис хааны) арван хоёрдугаар он, улаагчин үхэр жил (1217 он)-ийн намрын 8 сар ... Сартуул угсааны Хорезм улсын Отрар хотын түрүү нь Ухуна түрүүтэй Монголын худалдаачин зуун хүнийг алж, эд барааг нь булаасан чимээг олж сонсов ... гэж тэмдэглэж буй. Владимирцовын номд, Хорезмын элч Монголд ирсэн цагийг Чингис хаан Чжунду хотыг эзлэн авсны дараа гэдэг

бөгөөд Монголын худалдаачин нь 1216 онд Хорезм өөд явлаа гэж тэмдэглэж байх нь “Ту Цзи-гийн тэмдэглэл” дэх 1217 оны намар худалдаачид алагдсан чимээг олж сонслоо гэдэгтэй тохирох мөртөө “Д’Оссоны Монголын түүх” дэх Хар Хятаныг мөхөөсөн хойно (Хар Хятаныг хамаг эцэс мөхөөсөн цаг бол 1218 он болох юм) хоёрдохи удаа элч (Бахра тэргүүтэй) томилсон гэдэг тэмдэглэлтэй ч тохирч байна. Иймээс би худалдаачны бригадын Хорезмд хүрсэн цагийг 1216 оны сүүлч буюу 1217 оны эх гэж тэмдэглэв.

5 Чингис хаан Хорезмыг дайлах явдалд зориулж хуралдуулсан хуралдайг нийтийн он тооллын 1218 онд болсон гэж Д’Оссон тэмдэглэв (“Д’Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, зургадугаар бүлэг). Гэтэл Чжан Чжэнь Пэй-гийн “Чингис хааны шүүмжлэл шастир” гэдэг товхимолд 1219 оноор тэмдэглэжээ. Чингис хаан Хорезм улс өөд дайлан мордсон цаг бол 1219 оны зуны эхэн сар гэж олон түүх тэмдэглэлд зөрөөнгүй тэмдэглэж байдаг тул “хуралдай”-г түүрүү жилд нь дайны бэлтгэлээс урьд хийх нь зүйтэй хэрэг юм. Ингээд тус товчоонд Д’Оссоны тэмдэглэлийг баримтлав.

6 “Алимар” гэдэг бол эртний нэгэн хотын нэр юм. Хятадаар бас “А-ли-ма-ли буюу А-ли-ма” гэж бичдэг. Энэ үг бол “Алим жимс”-ний “алма” гэсэн түрэг хэлний үг болно. Хуучин хотынхи нь ор нь одоогийн Шинжааны Өөртөө Засах Орны Хуачин сянь-ий Сүйдин балгаснаас баруун хойш буй. Хубилай хааны үед энд мужийн захиргааныг байгуулж байсан бөгөөд сүүлд нь Чагаадай хаант улсын харьяат газар болж, олон хаад нь энд төвлөж байв. Алимар хот бол Тэнгэр уулын умар дахи дорно өрнийн зам харилцааны чухал боомт болж байсан юм. Хот нь арван тавдугаар зууны сүүлч буюу арван зургадугаар зууны эхээр мөхсөн хэрэг билээ.

7 Чингис хааны Хорезмыг дайлсан цэргийн тоог олонхи материалд бүр “хорин түмэн их цэрэг” гэдэг юм. Гэвч “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Жаран түмэн цэрэг гэсэн цуутай” гэж, Березиний товхимолд: “Хорин таван түмэн монгол цэрэг ба бусад эл улсын хэдэн арван түмэн цэрэг...” оролцлоо гэж, Гиббоны зохиосон “Ромын доройтон мөхсөн түүх” гэдэгт: “Далан түмэн хүн” оролцлоо гэж, Владимирцовын номд: “Хорезмын Султан ханыг эсэргүүцэхээр Чингис хааны цуглуулсан цэргийн ерөнхий тоо нь хорин түм хүрэхгүй байлаа” гэж тус тус адилгүй тоог мэдээлжээ. Эдгээр тоо бол “эртний түүхчдийн ихэсгэсэн тоо” гэж Ли Цзэ Фэнь авгай үзэж байсан бөгөөд арван таван түмээс хэтрэхгүй гэжээ. Хорин түмэн цэрэг гэсэн нь нэлээд өргөн хэрэглэдэг тоо болно.

8 Чингис хааны баруунш Хорезм өөд дайлсан цагийг эл түүх бичигт доорхи мэтээр тэмдэглэж байдаг.

“Нууц товчоон”-ы 257 дугаар зүйл болон “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: Туулай жил (1219 он, шарагчин туулай жил) гэж, “Юань улсын түүх”-ийн нэгдүгээр ботид: Арван дөрөвдүгээр он, шарагчин туулай жилийн ...зуны зургаан сар, баруун орныхон элчийг алснаас хаан өөрөө цэрэг дайчилж дайлбай... гэж, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: Арван дөрөвдүгээр он шарагчин туулай жилийн ... зуны дөрөвдүгээр сар (уг тайлбар: тавдугаар сард Найманы нутагт явж байсан болохоор дөрөвдүгээр сард цэрэг мордсон нь зүйтэй)-д хаан өөрөө Сартуулыг дайлбай... тавдугаар сард Найманы нутгаар өнгөрч, ... Эрчис мөрөнд зогсов. ...Зургадугаар сард цэрэг оров гэж, “Д’Оссоны Монголын түүх”, Владимирцовын “Чингис хаан”, Кобаяши Такаширо-гийн “Чингис хаан”, Цю Шу Сэнь-ий “Юань улсын түүхийн тухай яриа” зэрэг

сүүлчийн үеийн зохиолуудад бүр 1219 оны намар цэрэг орсон гэж тус тус тэмдэглэж байх бөгөөд “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-д: “...615 дугаар он (Исламын он тоолол) буюу 1218-1219 оноос эхлэн цэрэг оров...” гэж тэмдэглэж байна. Энэ нь харин 1218 оны өвөл Зэвийн удирдсан хошууч цэрэг мордож, дараа жилийнх нь хавар их цэрэг цугларсан гэж Березиний мэдээлсэнтэй нийцэж байна.

9 “Хэ Чжун” (Голын дунд орон гэсэн утгатай) гэдгийг Исламынхан “Голын гадар орон” Мавераннахр гэдэг гэлээ. Энэ орон бол одоогийн Аму-Дарья мөрөн (эртний Охус мөрөн, oxus) дагуу орон болон Аму-Дарья, Сыр-Дарья (Сыхун мөрөн) хоёр мөрний хоорондуур бүхий Хорезм улсын төв орныг хэлж байна. Энэ орон нь эртнээсээ түрэг үндэстэн оршиж байсан орон юм. Наймдугаар зууны эхээр Халифт харьяалагдаж, Исламын шашныг шүтсэн байна. Монгол цэрэг дайлах үед, энэ орны хот балгасанд нь перс хүн болон араб хүн цөөнгүй байжээ. Хэ Чжун орон бол Хорезм улсын доторхи их баялаг орон байжээ. Тэндэх нүүдэлчин түрэгчүүдийн мал сүрэг ба бэлчээр ус нь Каспийн тэнгисийн элсэн оронд тулж байв. Энэ нь одоо Зөвлөлт Холбоот Улсын Узбекистан, өмнө Казакстан, Таджикстан ба Киргизстаны нэгэн хэсэг орон нутаг болжээ.

10 “Шин мөрөн” гэдэг бол одоогийн өмнөд Азийн дунд мөрөн “Инд мөрөн”-ийг хэлж байна. Түүний эх нь Дундад улсын төвдийн Гандис нуруунаас ундарсан Сычуань гол болон Гал гол болно. Тэр нь Кашмир, Пакистанаар дайрч, Араб далайд цуггадаг билээ. Бүх урсгал нь 3.180 км урт буй.

11 Жочи-гийн захирсан нэгэн салаа монгол цэрэг Дженд хотыг эзэлсэн цагийг Джувейни-гийн зохиолд: Исламын он тооллын “616 оны шафар сарын дөрөвний өдөр (1219 оны 4 сарын 21-ний өдөр)...” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, нэгдүгээр боть, арвангуравдугаар бүлэг) гэж тэмдэглэж буй. Ли Цзэ Фэнь авгайн номд Мухаммед Жочи-гийн цэрэг лүгээ Дженд хотын орчим байлдлаа гэсэн нь харин энэ тэмдэглэлийг үлдээсэн бололтой. Гэтэл Чингис хаан Хорезм улсад цэрэглэсэн цаг нь харин 1219 оны зун намрын үес болохыг эл түүхэн тэмдэглэл үндсэндээ адил (гагцхүү сар нь бага сага зөрдгөөс биш жил нь бүр адил байдаг) тэмдэглэжээ. Тиймээс Дженд хотыг эзэлсэн цаг хэрхэвч 1219 оны дөрвөн сар байж болохгүй. Харин Рашид-ад-Диний номд “могой жил (1221 он)-гийн хоёрдугаар сар” гэж байдгийг Ту Цзи авгай “могой жил нь луу жилийг эндүүрчээ” гэж магадалсан байна. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Жочи-гийн Дженд хотыг эзэлсэн цагийг 1220 оны гуравдугаар сар болон тавдугаар сарын хооронд тэмдэглэж буй. Ингээд би баахан бодтой шиг болгож “1220 оны хаврын сүүлч” гэж тэмдэглэв.

12 Бухара хотыг үнэсэн товрог болголоо гэдэг бол Джувейни-гийн тэмдэглэл болно. Гэвч Джувейни бас Бухара хотын дахин сэргээгдсэн байдлыг нэлээд тодорхой тэмдэглэж байсныг энд дагалдвар болгож тэмдэглэе: Самарканд хотыг эзэлсний дараа, Чингис хаан нэгэн Басха (даргач - эшлэгч) Тагуша гэгчийг томилж Бухара-ыг захируулжээ. Тэр хүн тэнд очоод, тус хотын хөгжил бадралыг нь сэргээжээ. Хамгийн сүүлд нь, одоогийн Хатим (Исламаас өмнөх нэгэн энэрэл халамжаар алдаршсан араб хүн - уг тайлбар) дэлхий дахины хаан (энэ бол Чингис хааныг зүйрлэж буй - эшлэгч)-ы зарлигаар (Бухара-гийн) засгийн эрхийг түшмэл Ялавачид тушаан өгч захируулжээ. Түүний голч, өршөөнгүй захирал нь ядуу тосгод ба буйд газар дугаан бутрагсадын анхаарлыг татаж, нутагтаа харьцгаасан бөгөөд дэлхийн олон

газрын хүмүүс ч тэнд очих болов. Түүний (Ялавачи-гийн) үнэнч шударга ажиллагаагаар тус хот нь өдрөөс өдөр бадран хөгжсөн бөгөөд оргилдоо ч хүрсэн юм. Ингээд Бухара-гийн нутаг орон нь нэр төрт угсаатны гэр хүрээлэн болж, эрхэм язгууртад ба энгийн иргэдийн цугларах газар болсон байна” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, нэгдүгээр боть, арван зургадугаар бүлэг).

13 Энэ тоог бид Джувейни-гийн тэмдэглэлийг баримтлав. Гэтэл Д’Оссоны тэмдэглэлд “Султан дөрвөн түмэн түрэг, перс цэргээр Самаркандыг сахиулж байв. ...” (“Д’Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, долдугаар бүлэг) гэж тэмдэглэж байна.

14 Самаркандын байлдааны цагийг бид Джувейни-гийн тэмдэглэлийг баримтлав. Гэтэл Д’Оссон “Исламын он тооллын гуравдугаар сар, өрнөдийн тоолол (даруй нийтийн он тоолол)-ын дөрөвдүгээр сар” гэж, Ту Цзи “Чингис хааны арван тавдугаар он цагаан луу жилийн тавдугаар сар (энэ нь бараг билгийн улирлын сар бололтой, Чингэвэл нийтийн тооллоор бодвол зургадугаар сар ч байж мэднэ)” гэж тус тус адилгүй тэмдэглэж буй. Гэвч он ба улирал нь үндсэндээ адил юм.

15 “Жочи, Чагаадай, Өгөөдэй нараар баруун гарын цэргээ захируулж...” гэсэн тэмдэглэл бол Ту Цзи-гийн тэмдэглэл болно. Д’Оссоны тэмдэглэлд, Хорезм хот (Ургенч хот)-ыг эцэг (Чингис хаан) нь Жочи-д хувьдсан тул тэр хүн томилж, энэ нийслэл хотыг бүрэн бүтэн байлгах дуртай гэж хотын ардад хэлүүлсэн гэдэг бөгөөд хотыг зургаан сар байлдаж эс эзэлсэн шалтгаан бол Жочи, Чагаадай хоёул хоорондоо зөрчил гарснаас болов гэжээ. Үүнээс үзэхүл, Жочи, Ургенч хотын байлдаанд оролцсон нь үнэн бөгөөд энэ нь Ту Цзи-гийн тэмдэглэлээр нийцэж байна. Гэтэл Джувейни-гийн тэмдэглэлд: “Тэр, ахмад хөвгүүн Чагаадай (Чагаадайг ахмад хөвгүүн гэсэн нь ташаарчээ, хоёрдугаар хөвгүүн нь болно – эшлэгч), Өгөөдэй-гээр нэгэн салаа цэрэг морийг захируулан томилж, өдөр сарын үргэлжлэн залгалдах мэт үзүүр хязгааргүйгээр уул хайрхан тал нутгийг бүрхэж, Хорезм хотод цэрэглэв. Тэр (Чингис хаан – эшлэгч) бас Жочи-г Дженд хотоос цэрэг шилжүүлж тусласугай гэж зарлиг өгөв” гэж тэмдэглэж байх бөгөөд англи орчуулгынхи нь тайлбарт: “Джувейни-гийн өгүүлснээс үзэхүл, Жочи Ургенч хотыг бүсэлсэн байлдаанд өөрөө оролцсонгүй байна. Энэ нь харин бусад тэмдэглэл - Исламын ба дорнодахины тэмдэглэлтэй бүр адилгүй болжээ” гэж заажээ.

16 Ургенч хотыг бид одоогийн дуудлагаар нь нэрлэв. Энэ нь эртний нэрээ үндсэндээ хадгаласаар билээ. Түүний хятад галиглал нь “Нууц товчоон”-ы хятад эхэд: “У-лун-гэ-чи” (үүнийг Ц.Дамдинсүрэнгийн одоочлогод: “Өргнэчи” (Гурганачи) гэж, Баярын монголчилгод: “Үрүнгэчи” гэжээ), “Юань улсын түүх”-д: “Юй-лун-цзэ-чи” гэж хоёр янзаар бичдэг. Ургенч хотыг тухайн үедээ бас “Хорезм” гэж нэрлэдэг тул Джувейни-гийн зохиолд үүнийг нь хэрэглэжээ (англи орчуулгад нь Urganchi гэжээ). Араб хүмүүс “Жүржания” (Jurjaniya) гэж дууддаг байсан гэлээ.

17 “Хоёрдугаар Александр” гэсэн нь манай тооллоос өмнөх эртний Македония улс (өмнө 336 - өмнө 323 он)-ын ван Александр (Alexander) их хаан лугаа үлтгэн цолложээ. Их хаан Александрын тухай “Үгсийн далай” гэдэг хятад хэлний бүрэн толь (1979 оны хэвлэл, хураамал дэвтэр, 1825 нүүр)-д лавлаарай.

18 “Нагшабын тал” гэдэг бол одоогийн Зөвлөлт Холбоот Улсын Узбекистаны Карши хот

орчмыг хэлж байна. Үүнийг Ту Цзи авгай “Баруун орны нөхвөр намтар”-ыг үндэслэж “Кеши” гэж тэмдэглэжээ. Энэ нь одоогийн дуудлага Карши-гийн эртний хэлбэр болно. Гэвч Ту Цзи авгай тайлбарлахдаа, “Кеши” гэдэг нэртэй газар хоёр байдаг, нэг нь Самарканд хотоос өмнөш зуун тавин газарт байдаг “Цзий Да Фу” хотыг Тан улсын үед “Ши Го” буюу “Чю Ша, Чжя Шуань На” гэдэг, энэ нь даруй Чингис хааны зуссан “Кеши” мөн. Нөгөө нь, Цзий Да Фу-гаас баруун өмнөш хоёр зуу гаруй газарт “Гарзи” гэдэг нэгэн хот байдаг, тэр нь мөн ч “Кеши” гэсэн авианы хувирал болно. Үүнийг Тан улсын үед “Ся Ши” гэдэг буюу “На Си Бо” гэдэг. “Баруун хойд орны газрын нэрсийн дагалдаас”-д “Нагшаб” гэдэг. Тус газарт, Чагаадайн зургадугаар үеийн ач Хэб хаан гэгч Юань улсын гэгээн хаан (Инцзун Содбала)-ы Чжи Чжигийн анхдагч он (1321 он)-оос хойш ордон байгуулан суужээ. Монгол хэлэнд ордныг “харш” гэдэг тул Нагшабыг “харш” гэж нэрлэдэг нь дуудлага хувирч “Гаржи” болжээ. Энэ бол “Мин улсын түүх, баруун орны намтар” дахи “Кеши” болохоос биш, Чингис хааны зуссан “Кеши” биш гэжээ.

19 Мама, Ялавачи (Mama Yalavach) ба Махмуд, Ялавачи гэдэг нь бүр Джувейни-гийн ном дахи бичлэг болно. Хэрэг дээрээ бүр нэг л хүн юм. Түрүүчийнх нь Махмуд гэсний товчлол болох мэт. Үүнийг “Нууц товчоон”-д “Хоромса овогтон” гэжээ. Энэ “Хоромси” гэдэг бол овог биш, харин “Хорезм” гэсний хувирал болно. Тэр бол Ургенч хотын хүн болохоор ингэж дууддаг байжээ. Өгөөдэй хааны үед энэ Мама Ялавачи-гаар Хятан (Умар Хятад)-ы газар (“Нууц товчоон”-д Чжунду гэдэг)-ыг захируулсан бөгөөд түүний хөвгүүн Масхудаар Уйгур, Удан, Кашгар ба Хэ чжун-ы газрыг захируулжээ.

20 Шин мөрний байлдааны цагийг Джувейни: Энэхүү тэнгэрээс тохируулсан гайхамшигт хэрэг нь 618 оны Лажаб сар (Исламын он тооллоор долдугаар сарын хугас – эшлэгч) (Нийтийн он тооллын 1221 оны 8-аас 9 сар)-д үүсчээ гэж тэмдэглэж буй. “Джалал-ад-Диний намтар”-т: “Исламын он тооллын аравдугаар сарын хорин хоёрын өдөр, гарагийн гурван (Өрнөдийн тооллын 12 сарын 9-ний өдөр)” гэж тэмдэглэж буй (“Д’Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, долдугаар бүлэг). Ту Цзи авгай цагаагчин могой жил (1221 он)-гийн 10 сар гэж магадлалт хийжээ. Учир нь, Чан-чунь арш 11 сарын 18-нд Самаркандад хүрмэгцээ хаантай учрах санаатай байсанд, зарлигийн элч Лю Чжун Лу хэлэхдээ их мөрний гүүр эвдэрсэн учраас хойд хавар учирвал зохино гэснээс биш хаан байлдаан хийж байна гэсэнгүй. Тиймээс Шин мөрний байлдаан 11 сарын 18-наас өмнө нэгэнтээ дууссан хэргийг харуулж байна. Насави-гийн зохиосон “Джалал-ад-Дин султаны намтар”-т: “11 сарын 24-ний өдөр, гарагийн гурван” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, Боэлэ-гийн англичилгийн тайлбар) гэж дурджээ. Үүнийг Дундад улсын он тооллын билгийн улирлаар бодвол, Ту Цзи-гийн “10 сар” гэсэнтэй тохирох юм. Ингээд би ч мөн энэ сар гэснээр нь баримтлав.

21 Энэ хэсгийг “Нууц товчоон” ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ээр баримт болгов. Энэ хэсэгт дурдсан Ару, Мару, Мадасари гурван аймгийн тухай Ту Цзи авгай магадлалт хийжээ. Тэр хэлэхдээ “ар” гэдэг бол “Тан улсын судар”-т дурдагддаг “Я-цзюй-ло” мөн бөгөөд энэ “Я-цзюй-ло” бол Каспийн тэнгисийн нэр гэжээ. Гэтэл энэ “Я-цзюй-ло” бол одоогийн Ирак улсын Багдадаас өмнүүр урсдаг Евфрат голын баруун эрэгт байсан эртний Куфа хотын нэр гэж “Үгсийн далай” (1979 оны хятад хэвлэл, хураамал дэвгэр, 1825 нүүр)-д тайлбарлажээ. Түүнийг сири хэлээр “Akula” (Акула) гэж, араб хэлээр “Al-Kufah” гэж нэрлэдэг гэнэ. Ингээд Юань улсын үед арабаар нь үндэслэж “Ку-фа” гэж дууддаг байжээ. Тиймээс Ту Цзи авгайн

тайлбар арай таарахгүй мэт. “Мару” гэдэг бол “Мурай” гэсний бичлэгийн хувирал гэжээ. Энэхүү Мурай гэсэн нь “Murai” гэсэн араб үсгийн авиачлал болно. Утгачилбал, “Хуурмаг ёс” гэсэн үг болох бөгөөд Исламын шашны нэгэн салбар болно. Түүнийг нийтийн он тооллын 1090 оны баргаар Хасан, Сабба гэгч байгуулсан гэдэг. Тэд ер дайснаа нууцаар хорлодог болохоор “нууцаар хорлогч бүлэг” гэдэг. Энэ аймаг нь арван нэгдүгээр зууны сүүлчээр Каспийн тэнгисийн өмнө эрэг дэх Дэйлэм орчмоор улсаа байгуулж, Аламут цайзаар төв болгосон бөгөөд цайз бэхлэлт олонтой улс байжээ. Чингис хаан баруунш дайлахад бууж өгсөн дараа нь урважээ. 1256 онд Үлэгү хаан баруунш дайлахдаа дайлан эзэлжээ. (“Үгсийн далай”, хураамал дэвгэр, 1244 нүүр). “Мадасари” бол “Мазандеран” хүн мөн гэж Ту Цзи тэмдэглэжээ. Энэ Мазандеран бол мөн Каспийн тэнгисийн өмнө эргэд байсан нэгэн хотын нэр билээ.

22 “Эх горхи, Гэгүн горхи, Бараан горхи” гэдэг нэрс бол “Нууц товчоон”-д гардаг нэрс болно. “Эх горхи, Гэгүн горхи” гэснийг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д: “Цзы-му-хэ” гэж орчуулжээ. Энэ орчуулга баахан балархай болсон нь илт байна. Джувейни “Баглан - Baghlan гэсэн бөгөөд Боэлэ-гийн англичилгын тайлбарт “Нууц товчоон”-ы “Бараан хээр” мөн гэжээ.

23 Хорезмын залуу эзэн Джалал-ад-Дин Султан хан байлдаанд дийлэгдэж, хурдан морины харайлтаар гүн мөрний урсгалд орон, баахан дорогш хөвж, ганц биеэрээ зүүн эрэгт нь гарав. Дараа нь түүний үнэнч, шударга нар нь бас голыг гаталж цугларав. Гэвч тэд аливаа бүхнээ гээн орхиж амь зугатан явж байх тул хэрэглэх зүйл юу ч үгүй байв. Ингээд тэд очсон газар бүхнээсээ унаа морь, зэр зэвсэг, эд хэрэгслийг дээрэмдэн авах буюу цөөн тоотой хүмүүсээрээ Энэтхэгийн хэдэн мянган цэргийг сөнөөж, өөрийгөө нэлээд зэвсэглэсэн билээ. Энэ үед Чингис хааны томилсон Бала ноёны цэрэг нэхээр ирж байгаа чимээг Джалал-ад-Дин султан сонсч, тэдний энэ цэрэгтэй дахин байлдах хүчин бүрэлдээгүй тул Дели өөд дутаан явжээ. Тиймээс Монголын цэрэг Джалал-ад-Дин султаны барааг ч олж үзсэнгүй буцсан байв.

24 “Бухара” (“Нууц товчоон”-ы бичлэг) бол одоогийн Зөвлөлт Холбоот Улсын Узбекистаны нэгэн хот болно. “Самарканд”-ыг “Нууц товчоон”-д “Самискэб буюу Самискэн” гэдэг, “Юань улсын түүх”-д “Сю-сы-ган-чэн” гэдэг бөгөөд одоогийн хятад бичлэгт бас “Са-ма-эр-хань, са-ма-эр-гань” мэт бага сага зөрөөнтэй бичдэг байгаа. Тэр нь одоо бас Зөвлөлт Холбоот улсын Узбекистаны нэгэн хот болно. “Удан” гэдэг бол одоогийн Шинжааны Уйгурын Үндэстний Өөртөө Засах Орны Хэ Дян сянь-ий орчим газрыг хэлж буй. Бас энэ “Удан” буюу “Хэ Дян”-ийг “Хотон” гэдэг үгийн үүсэл гэж хэлдэг ч байсан. “Хисхар” гэдэг бол “Нууц товчоон”-ы бичлэг болно. Энэ бол эртний “Су-лэ-фу”-гийн газар болно. Одоогийн Шинжааны Уйгур Үндэстний Өөртөө Засах Орны Кашгар хотыг хэлж байна. Тэр нь эртний “торгон зам”-ын чухал нэгэн боомт болохоор барахгүй одоо ч гээд Наньцзян орны чухал нэгэн хот болж байна. “Уриян” гэдэг бол үнэндээ “У-ли-цзян” гэсний ташаарал болно. “У-ли-цзян” бол одоогийн “Яркент” голын эх ба дунд урсгал (Тарим хотгорын өмнөд зах) дагуу орон - одоогийн Сачэ, И Чэн зэрэг сянь-ий газрыг хэлж байна. Сачэ бол эртний Сачэ улс, “торгон зам”-ын өмнөд салбарын чухал боомт байжээ. “Гүсандарил Гу-шань-да-ли-лэбуюу Гу-шань-да-лин-лэ”-г эртний Сучжоу (одоогийн Ганьсу мужийн Цзю Чуан)-ээс баруун өмнөш байсан Си Жун-гийн газар гэдэг, Хань улсын үед Си Цян, Тан улсын үед Төба (Төвд), Юань улсын үед ч Цюй Сянь Да Линь-ий юаньшуай-н орон гэдэг. Энэ “Цюй-сянь Да-лин” бол “Гүсандарил” гэсний хувирал гэж Накамичиё авгай тэмдэглэжээ. Энэ орон нь одоогийн Хөхнуур мужид байвал

зохино гэж Ту Цзи авгай үзжээ.

25 Кипчакийн хятад бичлэг дэх “у-ти” гэсэн нь хэрэг дээрээ монгол хэлний нэр үгийн олон тооны дагавар “ууд” болно. Түүнийг “Юань улсын түүх”-д “Цинь Ча” гэж бичдэг. Кипчак үндэстэн бол Каспийн тэнгисээс умарш, Хар тэнгис ба Кавказын нуруугаар нутагладаг түрэг төрлийн үндэстэн болно. Тэр нь тухайн үедээ Византимын хаант улс, Хангари, Орос, Булгар, Ханлин зэрэг их улс үндэстнүүд лүгээ зах зэрэгцэн нутагладаг байжээ. Энэ үндэстнийг Исламын мөргөлтөн “Кипчак” гэдэг, Оросчууд анхандаа “Половци” гэдэг, бусад Европынхон Куман буюу Кумания гэдэг байна. Кипчак бол Жочи-гийн хувь газар юм. Хожим нь Хаант Монгол Улсаас хоёрдугаар удаа баруунш дайлах (1236-1242)-даа Жочи-гийн хөвгүүн Бат хаан Кипчак хант улс (бас Алтан ордот хаант улс гэдэг)-ыг байгуулжээ. Гэвч энэ үеийн зах хязгаар нь Кипчакын хуучин нутгаас хол өргөжсөн байв.

26 Тухайн үеийн Орос бол зүүн хязгаар нь зүүнш Ижил мөрний салбар Ока голоос хэтэрдэггүй, дотроо хэд хэдэн бага улс хувааж байв. Тэдний эзэд нь бүр Вареге хүн (буюу Орос хүн) Рурик гэгчийн хойч нар байжээ. Есдүгээр зууны үесээр Рурик цэрэглэж, Днепр мөрнөөс зүүнш буюу умарших эл слав төрлийн үндэстнүүдийг дайлан дагуулжээ. Хожим нь эдгээр үндэстнүүдийг ерөнхийд нь орос хүн гэдэг байна. Рурикийн хойч нь улсаа олон хөвгүүддээ хуваан захируулж, түүний дотор нэгэн их гүнг өргөмжилж улсын эзэн болгодог бөгөөд энэ их гүн болсон нь цөм Киев хотод нийслэж хэдэн зуун жил болжээ. Дараа нь 1169 онд Владимир хотод шилжин нийслэснээс хойш эл харьяат нь урван хагарч дайн дажин хийдэг болжээ. Зэв, Сүбээдэйн захирсан монгол цэрэг 1223 онд Орос өөд халдахад Галичийн ван Метислав гэгч Оросын өмнөд орны аймгуудын ван нарыг Киевт цуглуулан, монгол цэргийг эсэргүүцэх тухай зөвлөлдөж, холбоот цэргийг зохион байгуулжээ.

27 Зэв Сүбээдэй нар Каспийн тэнгисээс умарш Оросын нутаг хүртэл цөмрөн дайлсныг “Нууц товчоон”-ы 262-р зүйлд: Бас Сүбээдэй баатарыг умагш (умарш) Ханлин, Кипчакууд, Бажигид, Оросууд, Мажарууд, Асу, Сасу, Саркисууд, Кэсими́р, Булгар, Рарал эд арван нэгэн аймаг харийн иргэнд хүртэл, Ижил, Заяг, Устан мөрдийг гэтлэн Гиваман, Кэрмэн балгасанд хүртэл Сүбээдэй баатарыг аялуулав гэж тэмдэглэжээ.

28 Чингис хааны цэрэг буцсан цагийг Дундад улсын түүх тэмдэглэлд Чингис хааны арван долдугаар он, хар морин жил (1222 он)-ийн өвлөөр тэмдэглэж байх нь олон билээ. Энэ нь хэлэлгээнгүй билгийн улирлаар тэмдэглэсэн нь дамжиггүй юм. Тиймээс Хотонгийн буюу нийтийн он тоололтой зөрж байна. Ингээд би Өрнөдийн ба Персийн түүхчдийн тэмдэглэлүүд лүгээ ойртуулахын тулд Чингис хаан баруун орноос цэрэг буцсан цагийг 1223 оны хавар гэж тэмдэглэв.

29 1224 оны зун Чингис хааны зуссан газрыг “Д’Оссоны Монголын түүх”-д “Хулан тайш” гэжээ. Үүнийг Джувейни-гийн номд “Хулан баш” гэж тэмдэглэсэн бөгөөд Боэле-гийн тайлбарт: “Уул бичлэг нь Хулан ташы гэдэг, уншихдаа Хулан башы гэдэг. Тэр бол Арис, Талас хоёрын дунд бүхий нэгэн уулын ам газар болно. Тэр нь Чимкентээс Аулия Атан (Джамбул хотын өөр нэр) хүрэх зам зуур Хуухан (энд сайн морь төрдөг тул энэ “Хуухан” гэснээр Цахар нутагт сайн морийг нэрлэдэг бөгөөд “Хөгшин Хуухан” гэдэг нэгэн ардын дуу одоо болтол уламжилсаар билээ – эшлэгч) гэдэг алдартай газрыг хэлж буй. “Хулан баш” гэдэг нь “зэрлэг элжгийн толгой” гэсэн утгатай үг (монгол хэлэнд зэрлэг элжгийг хулан чихтэй гэдэг нь

үүнээс ирэлтэй ч магадгүй - эшлэгч) юм” гэж тэмдэглэжээ. Гэтэл Ту Цзи-гийн тэмдэглэлд Чингис хааныг 1224 оны зун Алимарт зусав гэж тэмдэглэж буй. Алимар бол одоогийн Шинжааны баруун зах дахи Хо Чэн, Суй Дин Сянь-аас баруун хойш байсан болохоор газрын байц нь Д’Оссон, Джувейни нарын дурдсан лугаа зөрөөгүй юм. Энэ “Хулан баш” нь Алимарын харьяаны газар болох мэт. Тиймээс Джувейни бодот газрыг нь тэмдэглэж, Дундад улсын түүхэнд ерөнхий газрыг нь тэмдэглэсэн мэт.

30 Чингис хаан баруун орноос цэрэг буцаж, Туул голын Хар шугуй дахи их ордондоо буусан цагийг “Д’Оссоны Монголын түүх”-д “Нийтийн он тооллын 1225 оны 2 сард ордондоо буув” гэж, “Ту Цзи-гийн тэмдэглэл” ба “Юань улсын түүх”-д: Хорьдугаар он (Чингис хааны он тоолол), хөхөгчин тахиа жил (1225 он), хаврын тэргүүн сар хаан Туул голын Хар түн дэх хуучин ордондоо харьж ирэв гэж тэмдэглэж байна. Дээрх тэмдэглэлүүд тус тус арга, билгийн улирлаар тэмдэглэсэн болохоор хэлбэр дээрээ зөрөөнтэй боловч хэрэг дээрээ бүрмөсөн нийцэж байна. Рашид-ад-Дин ба Джувейни-гийн тэмдэглэлд бүр “хаврын улирал” гэж баахан бөөрөнхий тэмдэглэжээ. Энэ нь “Биеэр дайлсан тэмдэглэл” дэх хөх бичин жил (1224 он) цэргээ татаж өвөлжиж зусаж явсаар хөхөгчин тахиа жил (1225 он)-ийн хавар улс нутагтаа буцаж иржээ” (монгол хэвлэл, 63 нүүр) гэсэнтэй бүрмөсөн нийцэж байна. Гагцхүү “Нууц товчоон”-д: “Тахиа жил (1225 он)-ийн намар Туулын Хар түн Ордост буув” (264 дүгээр зүйл) гэдэг. Энэ тэмдэглэлийн тухай “Хаан хөх бичин жил (1224 он)-гийн зун замдаа Алимарт зуссан бөгөөд Кипчакын ялалтын мэдээг ч тэр жил сонссон атал Хар хорумд харьж ирэхийг хэрхэн тахиа жилийн намар болтол хойшлуулах буй? Тиймээс “Нууц товчоон”-ы тэмдэглэл ташаарсан нь тодорхой байна” гэж Ту Цзи авгай тайлбарлаж байв. Эдгээр байдлуудыг үндэслэж, би “1225 оны хаврын эхээр” гэж баахан чөлөөтэйхэн шиг тэмдэглэв.

31 Чингисийн дүү Отчигин ноёны ордон хаа байсан тухай Чжан Син Лян авгай доорхи тайлбарыг хийжээ:

Их ван Отчигиний ордоныг Калка голын хөвөөнд байв гэж Палладис мэдээлж байв. Гэтэл Чан-чунь аршийн тэмдэглэлээс үзэхүл гол (Хайлар голыг хэлж буй - эшлэгч)-ыг гаталж хойш гурван өдөр яваад сая түүний ордонд хүрсэн тул нэн хойш байвал зохино, тиймээс одоогийн Лу Бинь сянь-ий хязгаар дотор байсан мэт гэжээ. Чжан Син Лян авгайн дурдсан энэ Лу Бинь сянь бол одоогийн Өвөр Монголын Хөлөн Буйр аймгийн Манжуур хотыг хэлж буй. Манжуур хотыг Чин улсын сүүлчийн үед Лу Бинь Фу гэдэг, 1913 онд Лу Бинь сянь гэж өөрчлөөд 1934 онд Манжуур хот гэж нэрлэсэн байна.

32 Чан-чунь аршийн тэмдэглэлд дурдсан энэ “хятад гүнж” гэдэг нь Алтан улсын Вэй Шао вангийн охин Чигу гүнжийг хэлж байх мэт. Түүнийг 1214 онд Чингис хаан Алтан улсын нийслэл Чжунду хотыг бүслэн байлдахад хоёр улс эвсэж, Чингис хаанд хүргэсэн байна. Түүхэнд гүнж хатан гэдэг юм. “Тангуд гүнж” гэсэн нь Тангуд улсын эзний охин Чагаа гүнжийг хэлж буй. Гэтэл “Юань улсын түүх, хятад охидын илтгэл”-д эдний нэрийг тэмдэглэсэнгүй.

33 “Тян Хингайн балгас”-ыг “Ховдын зүүн өмнөдөх Түргэн нуурын баруун өмнө байсан” гэж Чжэн Тун Вэнь, Дэн Цзянь нар тайлбарлажээ. Энэ “Түргэн нуур” гэдэг нь одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ховд аймгийн Дөргө нуур (уртраг нь 93°, өргөрөг нь 47,5°) болох мэт. Гэтэл Хингайн тариалсан газрыг би тавдугаар бүлэгт Ли Цзэ Фэнь авгайн

тэмдэглэлийг үндэслэж “Абухан уул” гэсэн билээ. Энд дурдсан нь түүний барьсан хотын газар байж мэднэ.

34 “Төмөр хаалгын боомт” гэдэг бол одоогийн Зөвлөлт Узбекистаны өмнөх Дербент (Дербент-Джербент гэж авиална)-ээс баруунш арван гурван км зайтай байжээ. Түүнийг эртдээ “Төмөр хаалга” гэдэг, Монголын үед “Төмөр хаалгын боомт” гэж нэрлэсэн бөгөөд дараа нь Чагаадай хаант улсад харьяалагдаж байжээ. Тэр нь эртний Дундад Азийн өмнө умрын харилцааны зам өнгөрдөг хоёр уулын хоорондхи хавцал болно.

35 Үгүсүн Жүанда-гийн Монголд элчилсэн цагийг “Алтан улсын түүх”-ийн 124 дүгээр ботид “Син Дин-ий дөрөвдүгээр он (1224 он)-ы долоон сараас мордож, хойд жилийн арван хоёрдугаар сард буцаж ирэв” гэж явсан ирсэн цагийг нь л тэмдэглэж буй. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Үгүсүн Жүанда Чингис хаанд барадсан цагийг цагаагчин могой жил (1221 он)-ийн долоон сар гэж тэмдэглэж буй. Бас “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”-д: Цагаагчин могой жилийн аравдугаар сарын арван дөрвөнд зүүн Ся улсын элч буцахдаа багштай учрав. Хэзээн ирэв? хэмээн асуусанд, “долдугаар сарын арван хоёрт хаан (Чингис хааныг хэлж буй - эшлэгч) Султан хан (Джалал ад Дин-ийг хэлж буй - эшлэгч)-ыг нэхэхээр Энэтхэг өөд цэрэглэсэн тул аялан буцаж ирэв” гэжээ гэсэн тэмдэглэл байдаг. Үүнийг Ту Цзи авгай: Үгүсүн Жүанда-г Чан-чунь арш зүүн Ся улсын элч гэж эндүү тэмдэглэв гэж үзжээ. Ли Цзэ Фэнь авгай: Чан-чунь арш зүүн Ся улсын элч лүгээ нүүр ярилцсан тул энэ нь ууган баримт болох бөгөөд бид үл итгэх ёсгүй гэжээ. Гэтэл зүүн Ся улсаас элч томилж Чингис хаан лугаа баруун оронд бараадсан тэмдэглэл манай тулгар бичгүүдэд ер харагддаггүй. Энд бид голдуу Үгүсүн Жүанда-гийн Чингис хаанд бараадсан цагийг тодорхойлохын тулд эдгээр тэмдэглэлийг дурдсан юм. Юу болсон ч Үгүсүн Жүанда 1221 оны билгийн улирлын долдугаар сард Чингис хаантай уулзсан нь тодорхой байна.

Есдүгээр бүлэг



Тангуд улсыг мөхөөсөн ба Чингис хаан нас барсан нь

Дайны үүсэлт

Чингис хааны хорьдугаар он, хөхөгчин тахиа жилийн намар буюу нийтийн он тооллын 1225 оны 7 сард, Хаант Монгол Улсаас Тангуд улс өөд тавдахи удаагийн дайралтыг эхэлжээ.

Чингис хаан урьд 1205 оноос 1218 оны хооронд, Тангуд улсыг урьд хожид дөрвөн удаа дайдж, дараа нь Дундад Азид зургаан жил гаруй байлдаж саяхан буцаж ирсэн атал, яахин Тангуд улсыг дахин дайлах буй гэвэл, үүний шалтгааныг бас түрүүчийнхээс залган хэлэх хэрэгтэй байна.

Чингис хаан Тангудыг дөрөвдөх удаа дайлсан шалтгаан бол, тэр яг Алтан улс өөд цэрэглэж байх хооронд, Хорезм улсыг бачим дайлах хэрэгцээтэй болж, урьдын хэлэлцээрээр Тангудаас цэрэг элссэнд, Тангуд хүлээсэнгүй тул тэр удаа охор хугацааны дайралдаан хийжээ. Тэр үед, Тангудын эзэн Ли Цзунь Со баруунш Си Лян өөд дутаасан бөгөөд түүний хөвгүүн Ли Дэ ван “Цэрэг гарган туслая гэж хуурмагаар найрамдах”-ыг гуйчилсан болохоор Чингис хаан Ли Цзунь Со-г нэхэн байлдсангүй байна. Гэвч, эцэстээ Тангуд улс цэрэг гаргаж Чингис хааны баруунш дайралтад тусласангүй бөгөөд Тангудын сайд Аша Гомбу гэгч “Хүч хүрэхгүй болбоос хаан юунд болов?” гэж хэлээд Чингисийг хоргосон байв. Тэр үед, Чингис хаан: Аша Гомбу-д яахин ингэж хэлэгдэх билээ? Урьдаар тэдэнтэй очиж байлдаас зохилтой биш үү? Гэвч өөр хүн (Сартуулыг хэлж байна – эшлэгч)-д зорьж буй цаг тул энэ удаа больё. Мөнх тэнгэрт ивээгдэж, алтан жолоогоо бат татаж ирвээс, тэр цагт магад болтугай! (“Нууц товчоон”) гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл, Чингис хаан Сартуул улсаас буцаж ирээд Тангудыг заавал дайлна гэсэн үг болно. Хэлбэл хийдэг, хийвэл дуусгадаг явдал бол Чингис хааны өвөрмөц зан чанарынхи нь нэгэн илрэл юм. Энэ үед тэр нэгэнтээ Алтан жолоогоо бат татаж ирсэн тул урьдын хэлснээ биелүүлэх нь дамжиггүй хэрэг билээ. Энэ бол Тангуд улсыг тавдахи удаагаа дайлсныхи нь үндсэн шалтгаан болох бөгөөд хэдэн жилийн өмнө туурвисан зайлшгүй үүсэх нэгэн дайралдаан болно.

Энэ бол нэгдүгээр шалтгаан мөн.

Хоёрдугаар нь “Тангуд урвалаа” гэсэн шалтгаан болно. Энэхүү “Тангуд урвалаа” гэдэг нь Тангуд улс ба Алтан улстаа эвссэнийг хэлж байна. “Тангуд улс Монголын харьяат улс болж, Алтан улсыг байлдахад туслаж байсан боловч Монголын цэрэг баруун зүг байлдахаар явсан ба зарим нь (Мухулайн удирдсан цэрэг – эшлэгч) хятад (Алтан улсыг хэлж буй - эшлэгч)-д

байлдаж хүч нь тарамдаж байсан энэ бүхий байдлыг ашиглан хараат байдлаас гарахыг оролдсон байжээ” (“Монгол Ард Улсын Түүх”, тэргүүн боть, дэд хэсэг, нэгдүгээр анги, гуравдугаар бүлэг). Үүний бодтой илрэл нь, Алтан улсын Айцзун хааны “Чжэн Да-гийн анхдагч он (хөх бичин жил, нийтийн он тооллын 1224 он – эшлэгч)-ы өвлийн аравдугаар сар, шар морин өдөр Ся улс элч томилон ирүүлж, эвсэн найрамдахыг зорив” (“Алтан улсын түүх”, арван долдугаар боть, Айцзун хааны шастир, дээд бүлэг). Ингээд Тангуд ба Алтан улсын харьцаа дахин сайжирсан тул хэлэлгээнгүй Тангуд Монголын харьцаа нь эвдрэх юм, өөрөөр хэлбэл “Тангуд урвасан” (Рашид-ад-Диний номд) явдал болно.

Гуравдугаар нь “Барьцаа хүүгээ ирүүлсэнгүй” гэсэн шалтгаан болно. Энэ тухай хамгийн анхны мэдээ бол “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” дахи “[Чингисийн он тооллын] хорин нэгдүгээр он (нийтийн он тооллын 1226 он – эшлэгч)-ы Цагаан сар, Баруун Сяо улс ... барьцаа хүүгээ ирүүлсэнгүй учир хаан өөрөө дайлав” гэсэн тэмдэглэл болно. Түүний бодтой өнгөрөлт нь ийм байна:

1223 оны 3 сард Мухулай ноён Шаньси мужийн Вэнь Си сянь-д өвчнөөр нас барж, түүний хөвгүүн Бору Дундад Азийн дайны фронтоос буцан ирж, Го вангийн орыг залгамжлах үед, Тангуд улсын эзэн сэтгэл урвасан тул, түүнийг дайлах тухай Чингис хааны нууц зарлигийг хүлээсэн бөгөөд улсдаа буцаад энэ талын бэлтгэлийг хийж байжээ. Энэ үед Тангуд улсын Монголтой холбоолж Алтан улсыг эсэргүүцэх төрийн бодлого нь тууштай сүйрч, тус оны 12 сард Тангудын наймдугаар эзэн Ли Цзунь Со өөрийн сууриа хоёрдугаар хөвгүүн Ли Дэ ванд уламжилж, өөрөө өвөг хаан гэж нэрлэжээ. Ингээд Тангудын төрийн бодлого нь Алтан улстай холбоолж, Монголыг эсэргүүцэх болж хувирсан бөгөөд умардахины аймгуудад элч томилж, Монголыг хориглох гадаад тусламж олохоор холбоолсноор үл барам, “Чингис хаан Дундад Азийн байлдаанаас буцаж, Хар Эрчис голд буудаллан байхад Тангуд улсын хаан Ли Де Ван (1223 - 1226)¹ Монгол нутгийг Эзнэй голын зүгээс уулгалан халдсан байна”. Энэхүү мэдээг Чингис хаан олж аваад “Мухулай жанжны хүү Бору-д үлэмжхэн цэрэг өгч Тангуд улсын нутгийн хамгийн зүүн захын хот Яньчжоу-г эзлүүлэхээр явуулжээ. 1224 оны 5 сард² Бору цэргийн хамт Яньчжоу хотын дэргэд ирэхэд Тангудын жанжин Тахай хабу угтан байлдсан боловч бут цохигдож, Яньчжоу хотоо алдахад хүрчээ. Ли Дэ ван цэрэг дарагдсаныг сонсоод бачимдан элч зарж найрамдахыг гуйжээ. Чингис Тангудыг бүрмөсөн номхотгохыг зорьж байсан боловч байлдаанаас саяхан бууж, бэлтгэлгүй байсан учраас, хэрвээ өөрийн нэг хүүгээ барьцаа болговол найрамдаж болно гэж хариу өгчээ. Ли Дэ ван тэр шаардлагыг хүлээн зөвшөөрч, Монголын цэрэг хойш буцжээ. Гэвч 1224 оны намар (Алтан улсын түүхэнд хөх бичин жилийн арван сар гэж тэмдэглэсэн билээ, энд сар нь зөрж байна – эшлэгч), Ли Дэ ван Алтан улстай Монголын эсрэг нууц холбоо байгуулжээ. Чингис хаан 1225 оны 2 сар Туул голд ирээд Ли Дэ ванд элч явуулж, хүүгээ ямар учраас барьцаа болгон ирүүлэхгүй байгааг асуулгасан байжээ. Гэвч энэ завсар Тангуд улс Монголтой байлдахаар бэлтгэж, хэрэм боомтоо бэлтгэхийн хамт Алтан улсаас цэрэг зэвсгийн тусламж авахаар хэлэлцээ хийж, 1225 оны 10 сард уул хэлэлцээнд гарын үсэг зурж, 11 сард тэр тухай илэрхий зарлажээ” (“Монгол Ард Улсын Түүх”, тэргүүн боть, дэд хэсэг, нэгдүгээр анги, гуравдугаар бүлэг). Энэ бол Монгол улсын түүхийн тэмдэглэл болно. “Юань улсын түүх, Бору-гийн намтар”-т: “Тайцзу-гийн арван есдүгээр он, хөх бичин жил (1224 он)-ийн намрын долоон сар, Бору баруун Ся улсыг довтолж, Янь чжоу хотыг эзлэн авч, түмээд хүний толгойг цавчиж, олзолсон хүмүүс ба морь тэмээ үхэр хонь хэдэн арван түм байсан бөгөөд Тангудын захирагч Тахайг амьдаар

барьж авчээ. Ингээд Бору нийтлэн захирагч Мөнх-бух юаньшуай-гаар цэрэг захируулан, чухал боомтыг сахиулаад, өөрөө цэрэг буцав” гэжээ. Ийм гурван шалтгаан байсан тул, Чингис хааны хувиас авч үзэхүл, энэ удаагийн дайралтыг хийх л хэрэгтэй байжээ. Тангуд улсын талаас авч хэлбэл, энэ үед Монгол улстай байлдах нь аль үеэс ч ашигтай гэж үзэж байв. Учир нь: “Монгол Сүн улс хоёр эвдрэлцэн Шаньдун мужид байлдаж байсан тул Тангуд ба Алтан улс энэ ташрамыг тохиолдуулан Монголтой тэмцэхээр шийдвэрлэжээ” (“Монгол Ард Улсын түүх”, тэргүүн боть, дэд хэсэг, нэгдүгээр анги, гуравдугаар бүлэг).

Тангуд улсын хувь заяаг шийдвэрлэсэн энэхүү эцсийн нэгэн их дайн Чингис хааны хэдэнтээ гишгэлсэн мөр дээр зайлшгүй үүсэх боллоо.

64. Хандсан зүгээ шувт дайрч, хамаг Тангудыг мөхөөв

Чингис хаан Тангуд ба Алтан улсын байдлыг цаг тухайд нь тагнан эзэмшиж байсан тул, баруун орноос буцаж ирсэн цэргээ охор хугацаанаа амруулан цэгцлээд 1225 оны намар³ өөрийн биеэрээ арван түмэн цэргийг дайчилж, Тангуд улсыг дайлаар хөдөлсөн байна. Хөвгүүдээс Өгөөдэй, Тулуй; өрлөгүүдээс Боорчу, Сүбээдэй нар ба хатдаас Есүйг авч явжээ. Чагаадайн цэргийг туслах цэрэг болгон ар талдаа үлдээжээ.

Чингис хааны их цэрэг Туул голоос хөдөлж, тус оны 11 сард Түй Онгийн голын хөндийд ирээд тэндээ өвөлжиж цэргээ сургуулилсан бөгөөд Арбух⁴ гэдэг газар Чингис хаан их ав тавьжээ. Энэ авд явж байхад хааны унаж байсан зост бор (Толбот бор – Ц.Дамдинсүрэн) морь нь олон хулан чихтээс үргэж, Чингис хаан мориноосоо унаад бие мариа нь ихэд чилээрхэж, Чугурахун⁵ гэсэн газар буужээ.

Чингис хааны бие бэртэж, халуурч байсан тул, дараа өдөр нь Есүй хатны дурдлагаар олон сайд ноёд, өрлөг жанжин нар ба хөвгүүдийг нь цуглуулан хуралдсаны дүнд, бүгдээрээ хойш буцаж, хааны биеийг сайжруулаад дахин байлдахаар мордьё гэж зөвлөлдөөд Чингис хаанд айлтгав. Гэвч Чингис хаан:

Бид байлдана гэж ирээд гэдрэг буцвал “Тангуд иргэн, биднийг зүрх шантарч буцав гэх болно. Бид элчийг илгээж, мөн элчийг иртэл, энд Цоорхад (Чугурахун – Баярын монголчилго)-д биеэ сувилж байгаад Тангудын хэлэх үгийг сонсож буцвал болно” (“Нууц товчоон”, 265 дугаар зүйл, Дамдинсүрэнгийн одоочлого) гэжээ.

цээжлэвч амархан тул дуу гэж нэрлэсэн мэт – Дамдинсүрэн) буруушаан донгодуулжээ.

Үүний хариу Тангудын эзэн нь “Дайрах муу үгийг би хэлсэнгүй” гэсэнд Аша Гомбу “Дайрах үгийг би хэлсэн. Одоо Монголчууд та нар байлдаж сураад байлдая хэмээвээс миний Алшаа нутагт тэрэм (ханат) гэртэй, тэмээн ачаатай хүмүүс буй, Алшаа өөд зорьж над ирэгтүн! Тэнд байлдая! Алтан мөнгөн агуурс таваар хэрэгтэй болбоос Яргай, Эрижэүб хотод ирэгтүн!” гэж элчийг буцаажээ.

Энэ хариуг Чингис хаан сонсч, бие нь их халуурч байсан боловч, “Ийм их үгийг хэлж байхад бид яаж буцаж болох буй? Үхэвч тэр их үг(хэлснийг) зүгээр орхиж болохгүй. Мөнх тэнгэр чи мэд!” гэж хэлээд цааш цэрэг орохоор шийджээ.

Монголын их цэрэг Чингис хааны хорин нэгдүгээр он (улаан нохой жил) буюу нийтийн он тооллын 1226 оны хаврын тэргүүн сар (аргын улирлаар хоёрдугаар буюу гуравдугаар сар болох нь дамжиггүй)-д, Түй Онгийн гол орчмоос цэрэг хөдөлж, Гурван сайхан уулыг давж, Эзнэй голын зүгээс Тангуд улс өөд байлдааны ажиллагаагаа эхэлж, Хар балгас⁷ зэрэг хотуудыг эзлэн авав.

Чингис хаан, 1226 оны зун Хунь Цуй Шань ууланд⁸ зусаж халууныг өнгөрөөжээ. Тус оны 7 сард Тангудын төр барьж байсан эзэн Ли Дэ ван үхэж, орыг нь түүний ач хөвгүүн Ли Сянь залгамжилжээ. Энэ бол Тангудын хамаг сүүлчийн нэг эзэн нь болно.

Энэ намар, Монголын их цэрэг Ганьчжоу (одоогийн Ганьсу мужийн Чжан И хот) зэрэг газрыг эзлэн авсан бөгөөд нэлээд урт хугацааны ширүүн тулалдааныг дамжиж Сучжоу (одоогийн Ганьсу мужийн Цюань) хотыг эзлэн авчээ. Дараа нь элс манхныг туулж, Хатан голын Есөн олом (энэ олом бол Хатан голын эхэнд байдаг есөн олом биш, харин Инличжоу-гоос өмнөш байдаг есөн олом болно)-д хүрч Инли (Нинся-гийн Чжунвэй сянь) зэрэг сянь-ийг эзлэн авчээ.

Тус оны 11 сарын Цагаан бичин өдөр, Чингис хаан Түрэмгий балгас (хятад түүхэнд Линчжоу хот гэдэг)-ыг бүслэн байлдав. Энэ үед Тангуд улсын эзэн нь тавин хүрээ цэрэг авч, алдарт жанжин Вэй Мин-гээр хошуучлуулаад, Түрэмгий балгасыг туслахаар иржээ. Долоо хоногийн хойно улаан барс өдөр, Чингис хааны цэрэг мөсөн дээгүүр голыг гаталж, Тангудын туслах их цэргийг Түрэмгий балгасын орчим тосон байлдав. Энэ удаагийн тулалдаанд “Сумыг хоосон харваж үл болно” гэж хаан зарлиг буулгасан тул Тангудын цэргийг ихээр сөнөөсөн бөгөөд монгол цэрэг ч нэлээд хохирол амслаа (тангуд цэргийн үхсэн нь аравны гурав, монгол цэрэг аравны нэг) гэдэг билээ. Тангудын эзэн нь дийлэгдэж нийслэл Яргай хотдоо дутаан харьжээ. Бас арван өдрийн дараа улаан хулгана өдөр, Монголын цэрэг Яргай хотыг нөмрөн хүрч, Яньчжоу-гийн тал (Түрэмгий балгаснаас зүүншхэн байдаг Янь Чи Чэн – Давсан нуурын хот)-д буув.

Гэвч Монголын цэрэг Яргай хотыг хараахан шууд байлдан авч чадсангүй бөгөөд Чингис хаан энэ хотыг байлдан эзлэхэд цаг хугацаа хэрэгтэйг харгалзан, хотыг байлдан эзлэх үүргийг тусгай жанжинд тушааж, өөрөө гол цэргээ авч, 1227 он (улаагчин гахай жил)-ы билгийн улирлын хаврын тэргүүн сард Хатан голыг гатлан гарч, Тангуд улсын хил зэргэлдээ Алтан улсын хот балгас өөд довтолжээ. Ингээд урьдаар Цзи Ши чжоу (Хөх нуур мужийн Ланьчжоу

сянь-ий харьяанд байжээ)-г эзлэн авч, 2 сард Линь Тао (Гуй Дэ хотоос зүүн өмнө Тао Хэ голын хөвөөнд буй)-г, 3 сард Тао чжоу (Ганьсу мужийн Линьтань сянь), Хэ чжоу (Ганьсу мужийн Линься-гаас хойно байжээ), Синин сянь (Ганьсу мужийн Хунин сянь) зэргийг тус тус байлдан эзэлсэн байна. 4 сард Чингис хаан Лүндэ (Нинся-гийн өмнөх Лю Пань Шань уулан орон)-д хүрчээ.

Тус оны 5 сард Тан Цин9-ийг Алтан улсад элчээр томилов. Илүү таван сард, Чингис хаан Лю Пань Шань ууланд10 зусав. 6 сарын шинийн нэгэн бол шар бичин өдөр, Чингис хаан Лю Пань Шань-д байхад, Алтан улсаас Ваньгинь Хэчжоу, Уудун аху хоёрыг элчлүүлж эвсэхийг гуйчилсан байв. Чингис хаан: “Ноднин өвөл би Яньчжоу-д буухад таван одон баруун өмнө агаарт төвлөрч байсныг олж үзээд алан хядахыг больсугай гэж амласан бөлгөө, гэвч яарах учраас тунхаглахыг мартав. Өдгөө нийтэд мэдэгдсүгэй, зам хөөн ирэгсэд та нар ч хаан миний санааг мэдтүгэй” гэж хэлсэн бөгөөд Алтан улсаас бэлэглэсэн нэгэн том гэрэлт сувд ба тоо томшгүй олон жижиг сувдыг нэгэн тавагт таваглаж, шадар бие бологсоддоо түгээн өгч, үлдсэнийг нь олны дунд сацаж өгсөн гэлээ.

Хэрэг дээрээ Чингис хааны хувь биеийн бүх насны дайчин амьдрал нь 4 сард нэгэнт дууссан бөгөөд дээр дурдсан зүйл бол түүний эцсийн үеийн төрийн ажиллагаа болжээ.

65. Чингис хаан нас барсан ба түүний гэрээс

6 сард Чингис хаан Лю Пань Шань-ий зуслангаасаа Цин Шуй Сянь-ий Си Цзян гэдэг газар шилжин хүрэв. Чингис хаан энд ирээд байх үед, Тангуд улсын эзэн Монголын цэргийн довтлогоо няцаан чадахгүй болоод Чингис хаанд элч зарж, нэг сарын хойно бууж өгөхөө илэрхийлжээ. Монголын талаас Толун чэрби-г томилж хүлээн авч хэлэлцүүлсэн байв.

Чингис хаан, хорин хоёрдугаар он (улаагчин гахай жил)-ы билгийн улирлын 7 сарын шинийн тавны хар морин өдөр буюу нийтийн он тооллын 1227 оны 8 сарын 18-ны өдөр11 халуун өвчин12-өөр хүнд чилээрхэж, найман өдөр болоод 7 сарын 12-ны шарагчин үхэр өдөр (аргын улирлын 8 сарын 25-ны өдөр) жаран зургаан настай (ой насаар бодвол жаран таван настай)-даа Лю Пань Шань уулын орчим дахи Цин Шуй Сянь-ий Си Цзянд13 нас баржээ.

Чингис хаан амьд сэрүүн байхдаа жич амьсгал хураахаасаа өмнөхөн болтол, өөрийн хөвгүүд ба шадар түшмэд, өрлөг жанжин нартаа гэрээс зарлиг үлдээж байжээ.

Чингис хаан урьд улаан нохой жил (1226 он)-ийн хавар Чугурахун-аас нүүж, Онго талын худаг гэсэн газар буугаад байхад нэг шөнө муу зүүд зүүдлэж, үхэх цаг ойртов гэж сэжиглэсэн гэлээ. Тэр үед хүүхдээс ганцхан Хасарын хөвгүүн Есүнхэ, дэргэд нь байжээ. Түүнээс Өгөөдэй, Тулуй нар хэдий хол байх буй? гэж асуусанд, хоёр гурван газар хол буй гэж Есүнхэ хариулсан гэлээ. Ингээд хүн томилж тэр хоёрыг дуудуулжээ. Маргааш өглөө нь Чингис хаан сайд жанжин ба бараа бологч түшмэдийг зайлуулж, гагцхүү хөвгүүддээ: Миний насан эцэс нэгэнтээ тулсан мэт. Би та нарын төлөө энэхүү өмнө умар, өрнө дорно хаа хаашаа бүр нэгэн жил явах өргөн уудам нутаг орон бүхий их улсыг анх цогцлон байгуулав. Та нар дайснаас сэргийлж, иргэдийг илүүц хураан, олны сэтгэлийг нэгэн сэтгэл болгож чадвал сая төр сууриныг удаан эдэлж чадах аж. Намайг үхсэн хойно та нар Өгөөдэйг эзнээр өргөмжлөх хэрэгтэй. Одоо та нар буцаж тус тусын хэргээ эрхлэж болно. Би ийм их алдар хүндийг

эдлэсэн тул үхэвч харамсах зүйлгүй. Миний сүг сүнс эх нутагтаа буцах болтугай! Чагаадай хэдийгээр дэргэд байхгүй боловч миний гэрээсийг зөрчиж, самуурал гаргахгүй байх аа гэж гэрээслэж байжээ.

Чингис хаан нас барахын өмнөхөн өөрийн хөвгүүд болон шадар жанжин сайд нартаа: Тунгуань боомтод бүхий Алтан улсын шилдэг цэрэг нь өмнөш Ляньшань уулаар халхалж, ардаа их мөрөн (Хатан гол – эшлэгч)-ийг түшин байх тул түргэн эвдэхэд бэрх билээ. Сүн улс, Алтан улс хоёр эртнээс өстэй учир, хэрвээ Сүн улсаас зам гуйвал манд сааргүй өгөх юм. Тэр үед бид Танчжоу (Хэнань мужийн Танхэ Сянь), Дэнчжоу(Хэнань мужийн Дэн сянь)-гийн газраар цэрэг орж, дахин буцаж Алтан улсын өмнөд нийслэлийг байлдвал, Алтан улс шахамдахад эрхгүй Тунгуань боомтоос цэргээ татах болно. Гэвч хэдэн түмэн олон цэрэг мянган газрын алс холоос туслахаар одоход хүн морь нь цөхөж ядрах тул, хэдийгээр хүрч эчвээс байлдах чадалгүй юм. Тиймээс эвдэрхүйеэ хялбар билээ гэж Алтан улсыг хамаг эцэс байлдан эзлэх арга бодлогыг заан гэрээслэсэн бөгөөд хожим нь ч ингэж хийсэн юм.

Чингис хаан бас: Бид болбоос дайсны дотор буй бөгөөд Тангудын эзэн бууж өгсөн атал ирээгүй билээ. Тиймээс миний үхсэн чимээг хэрхэвч дайсанд мэдэгдэж үл болно, Хашин хаан (мөн Тангудын эзнийг хэлж байна – эшлэгч) ирсэн хойно алтугай! гэж гэрээслээд өнөд амьсгаа хураажээ!

Олон жанжин, сайд түшмэд нь Чингис хааны гэрээсээр түүний нас барсан гашуудлын мэдээг огт мэдэгдэлгүй маш чанд нууж байсан тул, Тангудын эзэн Ли Сянь арга бус бууж өгөхөөр хүрч ирэв. Хаан өвчинтэй тул учирч чадахгүй гэж шалтаглан, түүнийг цацар харшийн гаднаас ёслуулжээ. Гурван өдрийн хойно, Толун чэрби түүнийг гэр хотлоортой нь хүйс тэмтрэн алсан гэдэг билээ. Ингээд Тангуд улс бүрмөсөн мөхөж, газар нутаг нь Монголчуудад эзлэгдсэн байна.

66. Чингис хааны шарилыг оршуулсан нь

Тангудын явдлыг бүрмөсөн дуусгаад, Чингис хааны хөвгүүд, олон жанжин сайд нар нь хааны гэрээслэсэн ёсоор түүний шарилыг нь хошууч жанжин Сүбээдэй их цэргээрээ хамгаалан, өлгий нутаг Монгол орон, төрсөн газар Хэнтий нуруунд оршуулахаар эмгэнэл гашуудлын бэрх замыг хөөжээ. Энэ тухай арван долдугаар зууны үед зохиогдсон монгол түүхийн сурвалж бичгүүдэд уянгын хэлбэрээр дүрслэг сайхан тэмдэглэсэн байдаг¹⁴.

Чингис хааны шарилыг нь олон хүлгээр чирүүлсэн хам их хасаг тэргэнд нь тээж, Мони уулаар дамжин, тус оны 9 сар (энэ цагийг Ту Цзи авгайн жишилтийг баримтлав)-д Саарь хээрийн харилтад¹⁵ их ордонд нь хүргэжээ.

Энэ үед Чингисийн отгон хөвгүүн Тулуй төрийн хэргийг орлон захирч, бүх улсад гашуудлын тунхаг тархаасан бөгөөд гашуудах ба оршуулах явдлыг эрхлэн гүйцэтгэжээ. Холын хүмүүс бараг гурван сар болоод ирлээ гэдэг юм. Үүнээс үзэхүл, Чингис хааны шарилыг онголсон цаг нь тус он (1227 он)-ы эцэс болох мэт. Чингис хааны шарилыг онголоход дөрвөн ордон зэргээр гашуудаж, Хэнтий нурууны энгэрт Их өтөг¹⁶ гэдэг газар оршуулжээ.

67. Чингис хааны онгон, монгол хаадын онгон, Найман Цагаан гэр жич Эзэн хороо

Чингис хааны шарилыг түүний уусан ус Хэрлэн голын ундрал, унасан шороо Хэнтий ханы энгэрт оршуулсан явдлыг бол бас түүний гэрээсээр нь гүйцэтгэсэн гэдэг билээ. Урьд Чингис хааны авд морилж байгаад энэ газар ирж, нэгэн том бүдүүн сахлаг сайхан навч намаатай модны доор сэрүүцэхдээ намайг үхсэн хойно энд оршуул гэж дэргэдэх хүндээ хэлсэн гэлээ (“Ту Цзи-ийн тэмдэглэл”, гуравдугаар боть). Тиймээс Чингис хааны шарилыг ийм нэгэн модны доор оршуулсан нь лав юм. Гэвч хожимдоо олон модод нь ой шугуй болж, аль нэгэн модны доор байх нь танигдахаа больсон байна. Ялангуяа тэд (Монголчуудыг хэлж буй - эшлэгч) хүүр оршуулахдаа овоо бунхан босгодоггүй, харин адуугаар гишгүүлж тэгш газар мэт болгодог (Чингис хааны нас барсны дараахи есөн жил – 1236 онд Өгөөдэй хааны төрд айлчилсан Өмнөд Сүн улсын элч Пэн Да Я нүдээрээ олж үзсэнээ түүний зохиосон “Хар Татарын тухай хэргийн товч” гэдэг номдоо ингэж тэмдэглэжээ)17 тул танигдахгүй нь зүйтэй юм.

Тэмүжиний онгоныг тойруулан сум хатган хүрээ (гучин газрын хэмжээтэй – уул тайлбар) болгож, морьт харуулаар хамгаалуулдаг (дээрх ном) бөгөөд энэхүү “Онгоны хамгаалагч нь мянган өрх урианхан болно” (Рашид, Джувейни нарын ном).


Хожим нь Тулуй эзэн, Мөнх хаан, Хубилай хаан болон Аригбөх нарын шарилыг Чингис хааны хамт оршуулж, бусад үр хөвгүүдийг нь өөр газар оршуулсан гэдэг билээ18.

Чингис хааны шарилыг оршуулахын хамт, “Мөнхийн дурсгал” тахилын орон болгож найман цагаан гэрийг үүдэн байгуулжээ. “Эзний найман цагаан гэр” гэдэг нь энэ үед ингэж үүссэн байна. Энэ тухай арван долдугаар зууны үеийн Ордос түүхч Саган сэцэн:


Мөнх хүүрийг ану үүдэн. Ерөнхийн шүтээн найман Цагаан гэрийг тэнд байгуулжухуй (“Эрдэнийн товч”, 1962 оны гэрэл зургийн хэвлэл, 89 нүүр) гэж тодорхой тэмдэглэжээ. Үүнийг одоогийн зөв бичлэг болговол:

Мөнх хүүрийг нь үүдэн. Ерөнхийн шүтээн найман Цагаан гэрийг тэнд байгуулжээ гэсэн үг болно. Энэхүү найман цагаан гэрийн тухай “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх”-д: Нас барсан газар нь мөнх хүр дурсгал болгон Ордос нутагт найман цагаан гэр байгуулж, эдэлж хэрэглэж байсан зүйлийг онголон тахих болгосноор тэр нь Чингисийн шарил гэж хожим алдаршсан аж гэж тэмдэглэж буй. Энэ нь манай баримтлаж байгаа тулгар бичгүүдтэй баахан зөрөөнтэй байхыг зааж гаргах хэрэгтэй. Энэхүү найман цагаан гэрийг анх байгуулахдаа “Ордос нутаг”-т биш, харин Чингис хааны шарилыг оршуулсан газар – Хэнтий ханы энгэр хавь буюу тухайн үе дэх Монголын төв газарт байгуулсан нь нэлээд баримттай бөгөөд зүйтэй юм. Тэр үед Чингисийн онгоныг сахиж байсан нь Ордос аймаг биш, харин мянган өрх урианхан аймаг байжээ. “Ордос” гэдэг нэр Чингисийн үед байтугай, Юань улсын үед ч байсан мэдээ хараахан харагддаггүй. Их төлөв Юань улсын мөхсөнөөс хойш, дотор газраас ухран гарсан зургаан түмэн Монголчууд ба Монголын эх газар дахи Монголчуудыг түүх, сударт Ордос, Цахар, Халх зэрэг зургаан түмэн гэж тодорхой тэмдэглэжээ. Одоогийн Ордос нутаг Чингисийн үед Тангудын нутаг байсан бөгөөд Юань улсын үед Шаньси муж болон Төв бичгийн мужид тус тус харьяалагдаж байжээ. Одоогийн Ордосчууд бол Чингис хааны дөрвөн ордны хойчис болох бөгөөд уулдаа Монголын төв газраар нутаглан байж, их төлөв арван тав, арван зургадугаар зууны үед өмнөшилж, Бортохой хавьд нутаглажээ. Тэд Хатан голыг гатлан одоогийн Ордосын өндөрлөгт нутагшсан нь бараг арван зургадугаар

зууны сүүлч буюу арван долдугаар зууны эхээр биелэгдсэн мэт. Одоо хэн бүхний мэдэж байх ёсоор, Өвөр Монголын Их Зуу аймгийн Эзэн хороо хошуунд “Чингис хааны онгон” гэж тахиж байх нь ч үнэн учир юм. Гэвч тэр нь үнэн Чингисийн онгон биш, ялангуяа тэр үед байгуулагдсан ч биш гэдэг баримт одоо нэлээд тодорхой болсоор байна.



Шинэ хуучин хоёр үеийн цомцог



“Чингисийн онгон”-ы шар хасаг



Чингисийн сүлд А. Сүлдийн хороо В. Шинэ сүлд





“Чингис хааны онгон”-ы гол танхим



“Чингис хаан ба Бөртэ үжсиний шарилын авдар”



“Хулан хатны шарилын авдар” - “Эш хатны шарилын авдар”



“Чингисийн онгон”-ы тахилгын хэрэгсэл А. “Чингис хааны онгон”-ы жолооны эмээл



Данх - Цомцогийн түлхүүрийн хайрцаг



Тахилгын суулга - Эзэн хорооны овоо



Чингис хаан ба Чан-чунь ари

Эзэн Чингисийн тахилын орон болсон найман цагаан гэрийг анх Монголын эх газар байгуулж, мянган өрх урианханчуудаар сахиулж байсан бөгөөд Өгөөдэй хааны үеэс Мөнх хаан (Тулуйн ахмад хөвгүүн)-д хүртэлх гучаад жилийн дотор Монголын их хааны ор нь хэдэнтээ солигдсон боловч тэрхүү найман цагаан гэр мөн ч Монголын төвөг дагалдан уламжлагдаж иржээ.

Хаант Монгол Улсын дөрөвдүгээр их хаан – Мөнх хаан 1259 онд үхсэн хойно, Монголын язгууртадын дотоод хямралдаан гарч, Тулуйн тавдугаар хөвгүүн Ариг бөх Хар хорум хотод өөртөө хуралдай хийж Мөнх хааны орыг залгамжласны зэргээр, Тулуйн гуравдугаар хөвгүүн Хубилай Кайфун хүрд балгас (Хожмын Юань улсын дээд нийслэл Шаньду)-д өөрийгөө их хаанаар өргөмжилж, Хаант Монгол Улсын тавдугаар их хаан болсон бөгөөд хожим нь бүх Дундад улсыг хамтран их Юань улсын анхны хаан нь болжээ. Энэ үед уулын эх газар дахи найман цагаан гэрийг хэрхсэн тухай тэмдэглэл харагддаггүй байна.

Гэвч, найман цагаан гэрийн уламжлал ер тасраагүй. Юань улсын эхэн үед энэхүү найман цагаан гэр нь Хятадын уламжлалт “Дээдсийн сүм” гэдэг дүрэм лүгээ уялдаж, Юань улсын хаадын тайлга тахилын газар болжээ. Юань улсын анхдагч хаан Хубилай сэцэн Чжи Юань-ий гуравдугаар он (1266 он)-ы 10 сард Дээдсийн сүмийг байгуулж, Хубилай сэцэн хаан түшмэл Ань Тунь, Баян нарын айлтгалыг үндэслэж Пань Чжан ноён Чжао Би зэрэг олон сайд түшмэддээ зарлиг буулган ярилцуулж, өвөг дээдсийн үе уламжлал, сүмийн нэр, тахилгын тавилга зэргийг тогтоосон бөгөөд сүмийг найман гэрээр тогтоожээ. Энэ найман гэр нь яриангүй Юань улсын төв Дайду хотод байжээ. Найман гэрийг байрлуулсан нь доорхи мэт:

Нэгдүгээр гэрт: Чингис хааны эцэг, Юань улсаас Лянцзу богд эш хаан гэж нэхэмжлэн

өргөмжлөсөн Есүхэй баатар болон Сюань И хуанхүү Өгэлүн эх-ийг;

Хоёрдугаар гэрт: Хаант Монгол Улсын анхдугаар хаан, Юань улсаас Тайцзу Богд Баатар гэж нэхэмжлэн өргөмжилсөн Чингис хаан болон Богдын Түшээ Гэгээн Ивээлт хатан Бөртэ үжин-ийг;

Гуравдугаар гэрт: Хаант Монгол Улсын хоёрдугаар их хаан, Юань улсаас Тайцзун Эрдэмт Гэгээн хаан гэж нэхэмжлэн өргөмжилсөн Өгөөдэй болон Чжао Сы хуанхүү Дөрөгэнэ хатан-ыг;

Дөрөвдүгээр гэрт: Чингис хааны ахмад хөвгүүн Жочи болон түүний хатан Бедачүмиши-ийг;

Тавдугаар гэрт: Чингис хааны хоёрдугаар хөвгүүн Чагаадай болон түүний хатан Есүлүн-ийг;

Зургадугаар гэрт: Чингис хааны отгон хөвгүүн, Хубилай хааны нөгчсөн эцэг, Юань улсаас Жуйцзун Цзин Сян хаан гэж нэхэмжлэн цоллосон Тулуй болон түүний хатан, Хубилай хааны нөгчсөн эх Жуан Шэн хуанхүү Сорхагтани бэхи хатан-ыг;

Долдугаар гэрт: Хаант Монгол Улсын гуравдугаар их хаан, Юань улсаас Динцзун Цзяньпин хаан гэж нэхэмжлэн цоллосон Гүюг болон түүний хатан Цинь-шу хуанхүү Хамиши хатан-ыг;

Наймдугаар гэрт: Хубилай хааны нөгчсөн ах, Хаант Монгол Улсын дөрөвдүгээр их хаан, Юань улсаас Сяньцзун Хуаньсу хаан гэж нэхэмжлэн өргөмжилсөн Мөнх болон түүний хатан Чжэнь Цзе хуанхүү Хутугтай хатаныг тус тус цоллон тахижээ.

Энэ бол “Юань улсын түүх, тайлга тахилгын тэмдэглэл” (74 дүгээр боть) дэх найман цагаан гэрийн тус бүрийн тахилгын орныг тогтоосон анхны тэмдэглэл болно. Хубилай хаанаас хойш, Юань улсын хаан орыг залгамжласан олон хаад нь бас энэ дүрмийг үе улиран залгамжилж, сүүлчийн хаан нь түрүү хаандаа сүмийн цол өргөмжилж, тогтсон цаг хугацаандаа тахилга тавилгаа гүйцэтгэсээр байсан билээ.

1368 онд Юань улс төрөө алдаж, түүний эцсийн хаан – Ухаант хаан Тогоонтөмөр цөөн хүмүүсээ дагуулж Дайду хотоосоо дутаан явахаас гурван өдрийн өмнө, илүү 7 сарын 26-нд Дээдийн ёслолын хорооны түшмэл Арухуныг дээдийн сүмийн эл гэрийн шүтээн ба тайцзи нарыг авч умарш одтугай” гэж зүүн мөрийн түшмэл Ширэмүн зарлиг уламжлуулж байсан бөгөөд “Арухун нар даруй дээдсийн сүмд очиж, ёслолын тушаалтан Ван Сы Цзун, тайж түшмэл (тахилгын сайд) Харбуха-гийн хамт шүтээнийг хамгаалан явах бэлтгэлийг дуусгаж, гэрт нь хүлээн байв гэж “Юань улсын түүх, Тогоонтөмөр хааны шастир”-т тэмдэглэж буй. Үүнээс үзэхүл, Тогоонтөмөр хаан “Эзний найман цагаан гэр” буюу адагтаа түүнд тахиж байсан “шүтээн” мэтийн зүйлсээ авч явсан нь лав үнэн хэрэг юм.

1368 оноос хойш, сүүлчийн Юань улс гэж дуудах болов. Ухаант хаан Тогоонтөмөр 1370 онд Барс хотод нас барсан хойно түүний хөвгүүн Аюушридара хаан орыг нь залгамжилж, Билигт хаан гэдэг билээ. Мөн тэр жил Мин улсын цэрэг Барс хотыг довтолсонд Билигт хаан хүч мөхөсдөж, цөөн хэдэн хүмүүсээ авч Хар хорум хот өөд дутаажээ. Тэр, энэ удаа дутаахдаа “Эзний найман цагаан гэр”-ийг хэрхсэн тухай мэдээ байдаггүй. Хэрвээ үнэнхүү арван хэдхэн

хүн бачим яаруу дутаасан бол авч завдсангүй ч магадгүй. Чингэвэл “Найман цагаан гэр” ингээд тасарчихав уу? гэвэл, үгүй байна! Сүүлчийн түүхэнд бас тэмдэглэл байдаг. Жишээлбэл, 1434 онд (Билигт хаан Барс хотоос дутаасны дараахи 64 дэх жил) Ойрадын Тогоон тайш зүүн Монголыг эзлэн авсан тухай:

Монголын төрийг авсан хойно, Тогоон тайш их төр барьж, эзний найман Цагаан гэрт мөргөж, хаан ор авья гэж ирээд мөргөж хаан болов гэж “Хураангуй Алтан товч” (1980 оны хэвлэл, 85 нүүр)-д тэмдэглэж байдаг бөгөөд “Эрдэнийн товч”-д:

Тохан (Тогоон - эшлэгч) тайш Мирасуны хонгор морин хэмээхээр. Эзний ордын цомцог (найман цагаан гэрийг Ордост одоо ч мөн “цомцог” гэдэг билээ – эшлэгч)-ийг гурвантаа эргэж дайрлан цавчил. Чи суут бие найман цагаан гэр болса (болоосой - хө.). Би суутай үр Тухан байнам. ... гэж тэмдэглэж буй. Энэ тэмдэглэлүүд юуг харуулж байна гэвэл, сүүлчийн Юань улсын төв нь Хар хорум хүрээд бас “Эзний найман цагаан гэр”-ийг сэргээснийг харуулж байна.

1470 онд Мандухай сэцэн хатан долоон настай Батмөнхийг гараас хөтлөн Эш хатны шүтээний өмнө ирж, сацал сацаж тангараг хийгээд Батмөнхийг Даян хааны орд суулгасан гэдэг билээ. Энэ Эш хатан гэдэг бол Тулуйн хатан Сорхагтани бэхи-д Чингис хаанаас соёрхсон цол болох бөгөөд тэр нь түрэг хэлний “бэр” гэсэн утгатай үг гэж Японы монголч эрдэмтэн Окада Хидэхиро мэдээлж байв. Энэ Эш хатны шүтээнийг хэлэлгээнгүй найман цагаан гэрт тахиж байжээ. Дараа нь Даян (Даяун) хаан Батмөнхийн найман Цагаан орд харагчин могой жил (1473 он)-ийн зургаан сар Хэрлэн голд байсан бөгөөд тэнд бүх улсын их чуулганыг хийжээ гэж Рашипунцагийн зохиосон “Их Юань улсын түүх” (Чуулалт хаалгын хорголжин бар, 667 нүүр)-д тэмдэглэж байсан бөгөөд бас “Эрдэнийн товч” (132 нүүр)-д:

Тэндээс Даян хаан баруун гурван (Ордос, Түмэд, Харчин - Юншээбү гурван түмнийг хэлж буй - эшлэгч)-ыг бүрнээ оруулан. Зургаан түмнийг их улсаа түгээрэн төвшитгөөд, найман цагаан гэрийн өмнөөс хаан цолоо тунхаг авч бүрүн. ... гэж тэмдэглэж байв. Эзний уламжлалт найман цагаан гэр нь бүх Монголыг хоёрдохи удаа нэгтгэсэн Батмөнх даян хааны үед бас их хааны төвдөө байсныг бид дээрх тэмдэглэлүүдээс мэдэж болно. Энэ үед Ордос найман цагаан гэрийг хадгаласан их заяат улс бөлгөө. ... (“Эрдэнийн товч”, 131 нүүр) гэж Даян хааны хэлж байснаас үзэхүл, Монголын төв дэх эзний найман цагаан гэрийг Ордос түмэн хадгалан хамгаалж байсан бөгөөд тэр үед Ордос аймаг ч бас Монголын төв газартаа байсан бололтой.

Гэвч Даян хаанаас хойш, Монголын их хааны төв нь Цахар хаадын харьяанд шилжсэн юм. Даян хааны их орыг шууд залгамжласан хаан бол Батмөнхийн ач хөвгүүн Боди Алаг болно. Боди Алаг зүүн гурван түмнийг авч ... найман Цагаан гэрт мөргөж Боди Алаг хаан их орон суувай (“Хураангуй Алтан товч”, 117 нүүр) гэдэг билээ. Энэ бол Эзний найман цагаан гэр хаан орынхоо хамт Цахар өөд шилжсэнийг харуулж байна. Цахар аймаг нь Дарайсун Гүдан хааны үеэс эхлэн, Монголын төв газраасаа зүүнш Ляодун өөд шилжсэн юм. Тэд шилжихдээ бас тэрхүү найман Цагаан гэрээ авч явсан нь дамжиггүй хэрэг. Энэ тухай “Эрдэнийн товч”-д:

Дарайсун Гүдан тайж... Уу бичин жилээ (шарагчин бичин жил буюу 1548 он - эшлэгч) цагаан гэрийн өмнөөс хаан цолыг аван, баруун(баруун гурван түмнийг хэлж байна - эшлэгч) лугаа эе төрөөр барилдан харьж одохуйя... гэж тэмдэглэж буй.

Дарайсун Гүдан хааны ачинцар хөвгүүн Лигдэн бол хэрэг дээрээ зүүн гурван түмний л захирч байсан цахар хаан юм. Гэвч түүнийг бүх Монголын их хааны залган төрлийн уламжлалаар бүх Монголын хамаг эцсийн нэгэн их хаан буюу гучин дөрөвдэх их хаан гэдэг. Тиймээс эзний найман цагаан гэр ч Лигдэн хаанд уламжлагдан очсон нь мэдээжийн хэрэг билээ. Нийтийн он тооллын 1628 онд, Манжийн дайлан дагуулагчид Монгол өөд довтолсон үед, Лигдэн хаан Ляодун-гийн газраас ухарч, баруун гурван түмний нутагт иржээ. Ингээд тэрхүү “Ерөнхий шүтээн” болсон эзний найман цагаан гэр ч мөн хаанынхаа хамт баруун гурван түмний нутагт шилжиж ирсэн нь зайлшгүй хэрэг билээ. Ордос түмэн ч яг энэ үед Лигдэн хааныг дагажээ. Энэ бол бүр түүхэн тэмдэглэлтэй хэрэг юм. Тэр нь 1634 онд Лигдэн хааны цэрэг ялагдаж өөрөө цөөн хүмүүс дагуулан Хатан голыг гаталж баруунш дутаасан байна. Энэ үед тэр хааны алтан тамга, хатад хүүхдээ хүртэл авч завдсангүй тул тэрхүү “Эзний найман цагаан гэр”-ийг авч явсангүй нь мөн ч дамжиггүй хэрэг. Энэ үед найман цагаан гэр нь цахар түмний олонхитойгоо одоогийн Бортохой орчим үлджээ. Сүүлчийн Юань улс гэдэг нь ч ингээд туйлбартай мөхсөн байна. Чингэвэл “Эзний найман цагаан гэр” яав гэсэн асуудал тавигдана. Үүнийг бид бас Ордос түүхч Саган сэцэний тэмдэглэлээр хангамжтай хариулж болно. Тэр тэмдэглэсэн нь: Тэр цагт, Цахарын Алтан суварга зайсан Сэрэн Бодумал хэмээх, эзний цагаан гэрийг Туба Тайсун хунтайж дүүд нь, өөд болгон ирж, Жихи-д нь буулгасан ажгуу” (“Эрдэнийн товч”, 176 нүүр) гэжээ. Энд дурдаж байгаа “тэр цаг” гэдэг бол, Ордосын Ринчин сэцэн жонон болон Саган сэцэн нар 1634 онд Цахараас салж, Ордостоо харьж ирсэн үеийг хэлж байна. Мөн ч Лигдэн хаан баруунш явснаас дараахи явдал билээ. “Эзний цагаан гэр” гэсэн нь даруй тэрхүү үе улиран залгамжилж ирсэн ерөнхийн шүтээн болсон эзний найман цагаан гэрийг хэлж байна. “Туба Тайсун хунтайжийн дүү” гэсэн нь Ринчин жононгийн дүү болно. “Жихи” (зарим хуулбарт “еихи” гэдэг) бол Саган сэцэний нутаг Их Шавар гэдэг газрыг зааж байх мэт. Жононгийн ордон нь бас энэ газар байсан бололтой. Чин улсын үеийн хятад орчуулгад “И-на-цзи-цзя” гэж, нөхөр Дорнотивийн шинэ орчуулгад “дэргэд нь” гэжээ. Харин “и-кэ” гэж хятадчилбал зохих мэт. Үүнээс үзэхүл, энэхүү эзний найман цагаан гэр нь хэдийд Ордост шилжин очсоныг маш тодорхой тэмдэглэжээ.

Сүүлчийн хүмүүс Чингис хааныг Ордост онголлоо гэдэг нь доорхи хоёр баримтлалыг үндэслэжээ. Нэг нь, арван долдугаар зууны үед зохиогдсон монгол түүхүүдэд тэмдэглэсэн мэтээр, Чингис хааны шарилыг умарш хүргэж явж байхад хасаг тэрэг нь Монийн хөхбөр гэдэг газар ирж бул чинээ шигдсэн учраас тэр газар нь Чингис хааны өмссөн цамц, өргөө гэр, өрөөсөн оймсыг нь онголов гэдэг. Энэ бол нэлээд уран домгийн шинжтэй тэмдэглэл болох нь дамжиггүй. Чухам ийм түүхэн хэрэг байсан эсэхийг нотлох өөр баримт хараахан үгүй байсаар билээ. Ийм учир байлаа ч гэсэн, тэр нь Чингисийн үнэн онгон биш гэдгийг ингэж тэмдэглэсэн хүмүүс ч зөвшөөрч байсан билээ. Бас энэ “Монийн хөхбөр” гэдэг газар одоогийн Их Зуу аймагт байгаагүй нь лав юм. Учир нь энэ Мони уул бол Алшаа уулаас зүүнш, Хатан голоос умарш байдаг тул “Монийн хөхбөр” ч лав Хатан голоос хойш байх ёстой. “Монийн хөхбөр”-ийн бодтой байрыг нотлоход бэрх боловч Чингис хааны нас барсан Цин Шуй Сянь-аас умарш Онон, Хэрлэнгийн эх газар өөд явах замд нь байсан нь дамжиггүй. Энэ зам нь лав одоогийн Ордос нутгаар дайрах ёсгүй. Тэгэж явбал хол тойруу болох юм. Чингис хаан ирэхдээ ч энэ замаар ирсэнгүй нь лав юм. Ялангуяа энэ нутаг бол тэр үедээ Тангуд улсын харьяат газар байсан тул Монголчууд эзнийхээ шарилыг харь нутагт оршуулах ёсгүй.

Нөгөө нэг нь: “Залуусын хурим”19 ба “Чингисийн их өчиг” зэрэг номд Монголын зургаан түмнийг тус тус магтан үнэлэхүйдээ:

“Эрчимт начинь жигүүр болсон

Эргэх хасаг тэргийг хадгалсан

Эрхийдээ мэргэн

Өвчүүндээ их омог зүрхтэй төрсөн

Эзний уул мэт цагаан гэрийг хадгаласан Ордос түмэн” (“Залуусын хурим”, гар бичмэлийн гэрэл зураг) гэжээ.

Уул мэт сод цагаан гэрийг чинь

Осолдол үгүй хадгаласан

Умарталгүй хүчээ өгсөн

Наранд өдөр төрсөн

Найман цагаан гэрийг чинь төрийн төв

Түмний ах болсон

Болд төмөр зүрхтэй (зүрхт)

Баатар Ордос түмэн чиний энэ бүхийгээр ажаамуу”

(“Чингисийн их өчиг”) гэж тэмдэглэж байдаг. Хэрвээ үүнээр үндэслэж, Чингис хааныг Ордост онголлоо гэх нь түүхийн баримтаар дутмаг байна. Учир нь энэ хоёр зохиол нь арван долоо, наймдугаар зууны үеийн зохиол болохыг хэд хэдэн талаар нотлосоор байна. Жишээлбэл, энэ “Залуусын хурим” гэдэг нь “Хаадын үндсэн их шар тууж”-тай үг үсэг зөрдөггүй тул нэг зохиолын нэр өөр хоёр хуулбар байж мэднэ. Харин сүүлчийнх нь арван долдугаар зууны гучаад оноор зохиогдлоо гэдэг юм. “Чингисийн их өчиг” гэдэг номыг Ц.Дамдинсүрэн авгайн тодорхойлсныг үндэслэвэл, тус номд гурван хуулбар байдаг гэлээ. Түүний дотор нэгэн хуулбарынхи нь дээр “Энх Амгалангийн жаран нэгдүгээр он” гэж бичиж байжээ. Тэр бол нийтийн он тооллын 1722 он билээ. Хэлэлгээнгүй арван наймдугаар зууны үеийн зохиол болно. Энэ хоёр зохиолыг Чин улсын үеийн зохиолоор тодолог бол, Ордос нутагт Чингис хааныг онголголоогүй гэдгийг нотлохоор барахгүй, Ордост эзний найман цагаан гэрийг хадгаласан цаг бол 1634 оноос эхэлсэн нь хэдэн талын баримттай болно.

Ялангуяа Саган сэцэний мэдээ бол итгэмжтэй юм. Учир нь Саган сэцэн бол тэрхүү түүхэн явдал - Лигдэн хаан дийлэгдэн Хөх нуур өөд явсан ба эзний найман цагаан гэрийг Цахарын Алтан суварганы зайсан Сэрэн Бодумал, Ордосын Ринчин сэцэн жононгийн дүү Туба Тайсун хунтайжид тушаан өгснийг биеэр өнгөрөөж, нүдээр үзсэн хүн юм.

Чин улсын эхээр “Эзний найман цагаан гэр” одоогийн Их Зуу аймгийн Далад хошуун дахи Вангийн Зуу буюу Их Зуу сүмд шилжжээ. Энэ үед Манжийн хаанаас Ордос аймгийг зургаан хошуу болгож, эл хошууд жил бүр нэгэн удаа Их Зуу сүмд хурал чуулган хийдэг байжээ. “Их Зуугийн чуулган” гэдэг нэр ч ингэж буй болсон юм. Эеэр засагчийн зургадугаар он (1649 он)-д Ордос зүүн гарын дундад хошууны Ринчинийг Чин улсын төрөөс Жүн ван цолоор өргөмжилж, Их Зуугийн чуулганы даргаар томилжээ. Ринчин Жүн ван жил бүрийн чуулган хийх дөхмийг бодолхийлж, “Эзний найман цагаан гэр”-ийг Далад хошуунаас түүний харьяат зүүн гарын дундад хошуун (ердөө Жүн вангийн хошуу гэдэг)-даа тухайлбал одоогийн Эзэн хороонд шилжүүлжээ. “Эзэн хороо” гэдэг нэр ч энэ үеэс буй болж, жил бүрийн чуулганыг энд хийдэг болохоор, Монголын их хаадын ерөнхийн шүтээн болсон эзний уламжлалт найман цагаан гэрийг “Чингис хааны онгон”-оор үзэн, тахиж шүтээд ирсэн явдал үүсэв.

Гэвч “Чингис хааны онгон” гэсэн албан ёсны нэрийдэл нь Чин улсын Сайшаал ерөөлт арван дөрөвдүгээр он (1809 он)-д Чин улсын засгийн газарт өргөдөл барьж зөвшөөрүүлснээс эхэлжээ. Энэ тухай “Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-т: Их Зуугийн хязгаарт Чингисийн онгон байх тул Ордос долоон хошуунаас таван зуун өрх дархадыг томилж, онгоныг хамгаалах ба тахилгын ажлыг эрхлүүлтүгэй. Бас жил бүр лан мөнгө гаргаж, сэлбэлт ба тахилгад хэрэглэтүгэй. Эдгээр айл өрхийг тус бүрийн ван нарт үл харьяалуулах бөгөөд тус чуулганаас эрдэм чадварт нэгэн засгийг томилж тусгайлан захируултугай. Хэрвээ дахин томилох хэрэгцээтэй болбоос тус чуулган дарга бүх засгийн нэрсийг жагсаан тус яамнаа мэдүүлж, дахин тус яамнаас хаанаа өргөдөл бичиж айлтгамуй гэж тэмдэглэж байдаг билээ. Түүнчлэн жил бүрийн билгийн улирлын гурван сарын хорин нэгнийг их тахилгын өдрөөр тогтжээ. Энэ таван зуун өрх айлыг “Дархад” гэж нэрлэдэг бөгөөд тэд нь үеийн үеэрээ “Чингисийн онгон”-ыг сахих үүрэгтэй билээ. Онгоныг голлон тахигч дархадыг хамаарагчыг “жонон” гэж нэрлэдэг (энэ бол Даян хаанаас нааш баруун гурван түмнийг захирах тушаалтны нэрээр нэрлэжээ). 1939 оны 6 сард “Чингис хааны онгон”-ыг Өвөр Монголын Их Зуугийн чуулганаас Ганьсу мужийн Юй Чжун сянь-ий Син Лун Шань гэдэг газар шилжүүлжээ. Тэр удаа “Чингис хааны онгон”-ыг шилжүүлсэн шалтгааны тухай тус зууны тавиад оноос нааших ном бичгүүдэд баахан зөрөөтэй тэмдэглэж байна. Үнэндээ үүний тухай тэмдэглэл хангамжтай байдаг. Жишээлбэл, тэр удаа Чингисийн онгоныг хамгаалан шилжүүлсэн ерөнхий жолоодогч, монгол партизан цэргийн хоёрдугаар тойргийн захирагч байсан Чэнь Юй Цзя “Чингисийн онгоныг шилжүүлсэн тэмдэглэл” гэсэн тусгай товхимолыг зохиож, 1942 онд хэвлүүлжээ. Ялангуяа Фан Шао Гун нөхөр “онгон” шилжүүлсэн тэр үе дэх сонин мэдээллийн ууган баримтыг үндэслэж, чухамхүү шалтгааныг нь тодорхойлж, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүл (1980 оны дөрөвдүгээр хугацаа)-д нийтлүүлэв. Эдгээр тэмдэглэлүүдийн гол агуулга нь ийм байна:

Японы эзэрхэг түрэмгийчүүд бүх Өвөр Монголыг ноёрхохын тулд, Монгол Хятад үндэстний хооронд ба монгол үндэстний эл давхаргын хооронд завсардуулан салгах төрийн бодлогыг авч салгах ажиллагаагаа хийсэн бөгөөд “Чингис хааны онгон”-ыг уулгалан Гуй Суй хот(одоогийн Хөх хот)-д шилжүүлж, Монголын ард түмнийг мэхлэхээр зальхайчуудыг нууцаар томилж Дэ ван (тухайн үед баруун Монголыг захирч байсан Дэмчүгдонров)-д заавар өгч байв. Тэр үед Өвөр Монголын ард түмэн болон Их Зуугийн чуулган дарга Шагдаржав түрүүтэй эх оронч дээд давхаргатай энэ байдлыг олж мэдээд маш хорсч байв. Ингээд “Чингис хааны онгон”-ыг Японы түрэмгийлэгчид ба хятад Монголын зальхайчуудын халдлагаас

хамгаалахын төлөө, Ша ван нар Монгол үндэстний эл давхаргатныг төлөөлж, онгоныг шилжүүлэх тухай Гоминьдан-гийн засгийн газраас гуйчилжээ. Гоминдан-гийн засгийн газар нь энэхүү гуйчлалыг үндэслэж, Монгол Төвдийн хэрэг эрхлэх журганы хэлтэсийн дарга Чу Мин Шань, цэргийн явдлын комиссын тусгай тушаалтан Тан Чжин Чжань, Жүн вангийн хошууны Гомбожав нарыг онгон шилжүүлэх тусгай гишүүнээр, монгол партизан цэргийн хоёрдугаар тойргийн захирагч Чэнь Юй Цзя-г онгоныг хамгаалан шилжүүлэх ерөнхий жолоодогчоор тус тус томилон, Ша ван тэргүүтэй монгол үндэстний эх оронч хүмүүстэй хамтаар онгоныг шилжүүлэх явдлыг гүйцэтгэжээ.

1939 оны 6 сарын 9-ний өдөр, “Чингис хааны онгон”-ы уул газар - Эзэн хороонд тахилга хийж, онгоныг ачаалан шилжүүлжээ. Тус сарын 15-ны өдөр, онгоны ачаа нь Шаньси мужийн Юй Линь (Тэмээт) сянь-д хүрч, хотын өмнөх нисгэлийн буудалд өв тэгш их тахилгын ёслолыг явуулсан бөгөөд дараа өдөр нь машин тэргэнд ачаалан бас өмнөш явжээ. Тус сарын 21-ний өдөр, онгоны ачаа нь тухайн үе дэх хувьсгалын төвийн Янь Ань хотоор өнгөрөх үед, Янь Ань-ий эл этгээдийн зуугаад байгууллага, түм шахам хүмүүс цуглаж, өвтэгш их тахилгын ёслолыг явуулжээ.

Тахилгад, Дундад улсын эв хамт намын төлөөлөгч Сэ Цзюэ Цзай, найман замын цэргийн ерөнхий захиргааны төлөөлөгч Тэн Дай Юань, Найман замын цэргийн харилцааны хэлтсийн дарга Ван Чжо Фэй болон хязгаар орны засгийн газрын төлөөлөгчид оролцсон байв.

Бас Дундад улсын Эв Хамт Намын төв хороо, нөхөр Мао Цзэ Дун, найман замын цэрэг болон хязгаар орны засгийн газраас “Чингис хааны онгон”-д цэцгийн цагираг өргөжээ. 6 сарын 22-ны өдөр Янь Ань-ий эл байгууллага, сургууль ба монгол хүмүүс жагсаал жагсан онгоныг бараадсан бөгөөд хүргэжээ.

1946 онд “Чингис хааны онгон”-ыг цааш Хөхнуур мужийн Гүмбүм хийдэд шилжүүлсэн байна.

1954 оны 3 сард, Их Зуу аймгийн Ардын төлөөлөгчдийн их хурлын дурдлагаар, “Чингис хааны онгон”-ыг шилжүүлэн авчрах төлөөлөгчдийн бүлгэмийг зохион байгуулж, Гүмбүмд хүрч, онгоныг залах их тахилга хийж, тус оны 4 сарын 3-ны өдөр Өвөр Монголын төв Хөх хотоор дайран, 4 сарын 7-ны өдөр Их Зуу аймгийн Эзэн хороон дахи уулын газарт нь дахин тохируулжээ. 1955 онд Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ардын Зөвлөлөөс сүйтгэл гаргаж “Чингис хааны онгон”-ыг шинээр байгуулав. Ингээд бас уул тогтоосон жил бүрийн их тахилгын өдөр - 3 сарын 21 нь хүйтэн гачиг цаг болох учраас өөрчилж 5 сарын 15-наар тогтоожээ.

Энд онцгойлон дурдах нэгэн зүйл гэвэл, бид Чингис хааны уламжлалт найман цагаан гэр Ордост уулаасаа байлаа гэсэн домог яриаг түүхэн баримтаар үгүйсгэсэн явдал бол түүхт шинжлэх ухаанч овроор хандахыг зорьжээ. Гэвч Ордосын ард түмний Монгол үндэстний түүхэн уламжлалт Эзний найман цагаан гэрийг нэлээд урт хугацаагаар нандигнан хадгаласан өнөд балрашгүй түүхэн гавьяаг хэзээ ч үгүйсгэж болшгүй! Эзний найман цагаан гэр нь 1634 онд Ордост шилжин ирснээс нааш гурван зуун дөчин найман жил болж байна. Тиймээс Эзний найман цагаан гэр Ордос аймагт хадгалагдсан цаг хугацаа нь хамгийн урт удаан бөгөөд энэ хугацаа нь Монголын түүхэнд хүнд бэрх цаг байжээ.

Чингэвэл сүүлчийн хүмүүсийн тахин шүтэж байгаа “Чингис хааны онгон” гэдэгт ямар зүйлс байдгийг уншигчид сонирхох байлгүй гэж бодоод доорхи мэдээнүүдийг тэмдэглэлээ.

1875 онд, Христосын шашны номлогч хоёр бельги хүн Вос Лринтон гэгч Ордос нутагт ирэн Чингис хааны онгоныг тойрон үзээд:

Ордосоор аялахдаа Чингис хааны онгоныг олж үзэв. Түүний байх газар нь хэдэн тохой өндөр дов болно. Довын дээр хоёр танхим буй. Өмнөх танхим нь тойроод хашаатай, ар тэнхмийнх нь төвд Дундад улсын ардын гэр мэт барилга буй бөгөөд бас зургаан монгол гэр буй. Их хааны хүндэт шарил (энэ бол түүний сонссон зүйл болно. Хэрэг дээрээ энд шарил байхгүй юм – эшлэгч) нь нэгэн давхарлаг барьсан монгол гэрийн дотор буй гэлээ. Бусад гэрийнх нь дотор эл зүйлийн эд эрдэнэ, жишээлбэл: алтан эмээл нэг, пял цом түрүүтэн нэжгээд хувь, гурван хөлтэй тогоо нэг, бас бус олон эдлэл хэрэгсэл байна, эдгээрийг бүр мөнгөөр үйлджээ гэж мэдээлсэн бөгөөд бас энэхүү мэдээнийхээ хамт Чингис хааны онгоны тойм зургийг хавсруулсан байна. Энэхүү мэдээг нь 1875 оны 5 сарын 18-ны өдөр хэвлэгдсэн “Ромын шашны сэтгүүл”-ийн 315 дугаар хугацаанд нийтлэгдсэн байна.

Дээрх хоёр хүнээс хорин жилийн дараа – 1896 онд Францын жуулчин Бунин гэгч бас Ордос нутгаар тойрч Чингисийн онгоны тухай: Майхан цацар мэтийн гэр хориод буй. Үүнээс гадна онгоны дээр нь зэрэгцүүлэн барьсан хоёр том эсгий гэр буй. Хоёрдугаар гэрийнх нь дотор нэгэн дөрвөлжин улаан эсгийгээр Чингис хааны мөнгөн авсыг нь бүтээж буй. Эсгийг нь сөхвөл нэгэн том авдар мэт мөнгөн авс нь үзэгдэнэ. Түүний дотор нь их хааны чандрыг хийж байна гэлээ. Авсын гадуур нь цанхуй цэцгийн хуарыг сийлсэн байв гэж мэдээлжээ(1898 оны 2 сарын 15-д хэвлэгдсэн “Парис” сэтгүүл, “Монголын толь”, хоёрдугаар ботид лавлаарай).

1959 оны 10 сарын сүүлчээр, би Эзэн хороон дахи “Чингис хааны онгон”-ыг анх удаа сурвалжилжээ. Тэр үеийн “Чингис хааны онгон” гэдэг бол 1955 онд шинээр байгуулсан барилга болно. Шар, хөх өнгийн шаазан ваараар чимэглэсэн гурван тэнхим буй. Төв дунд нь нэгэн том танхим, түүний зүүн баруун тал ба ард нь (арынхи нь тэгш дээвэртэй) тус бүр нэгэн бага тэнхимтэй бөгөөд тэнхим бүрийн хооронд нь хонгилоор холбожээ. Түүний хэлбэр нь бүр монгол гэрийн орой шиг бөмбөлжүүн бөгөөд хөлтрөгийн чимэгтэй. Гол их танхмийн гол хэрмийн дээр нь нэгэн Франц зурагчин зурлаа гэдэг Чингис хааны хөргийг өлгөж байв. Энэ танхимд бүр тахилгын эдлэл хэрэгсэл, зэр зэвсэг ба энд тэндээс хүргэсэн дурсгалын зүйлсийг тавьж байв. Баруун талын бага танхимд Чингисийн хар сүлд гэдгийг тахиж байв. Тэр нь нэгэн том жадын дээр монцоглож уясан хээр адууны дэлээр үйлдсэн жалаат жад болно. Дархадын хэлэхээр, үүнийг Чин улсын үед уламжлалт заншлаар дахин сэргээн үйлдсэн гэнэ. Гэхдээ бүх аймгийн доторхи хэдэн зуун хээр азарганы унаган дэлээс бага бага аваад нийлүүлж хийдэг гэлээ. Бас нэгэн алтадсан эмээл байв. Үүнийг дээд төрлийн Банчин эрдэнээс хүргэсэн гэж эрхлэгч нэгэн дархад танилцуулж байв. Арын бага дөрвөлжин танхимд нь цацарын хэлбэртэй шар торгон монгол гэр гурав байв (Үүнийг Ордост цомцог гэдэг). Гол их шиг цомцогт нь “Чингисийн шарил” гэгч мөнгөн авдрыг чанга оньслоод тахиж байв. Зүүн баруун талын хоёр цомцогийн хэлбэр нь дундахтайгаа бараг адил, гэвч хэмжээ нь бага, доторхи “шарилын авдар”-ынхи нь сийлбэр зэрэг нь адилгүй. Энэ нь Чингисийн хатдын “шарил” гэж, зүүн талын бага танхмынхыг Тулуй эзний “шарил” гэж дархад нар танилцуулж байв. Тэдгээр авдрын зарим нь Бадаргуулт төрийн үед үйлдсэн, Дэмчүгдонровын нэрийг

сийлсэн авдар ч байсан билээ.

Энэ удаа миний үзсэн эдгээр зүйлс нь бараг сүүлчийн хүмүүс заншил ёсоор үйлдсэн зүйл болох мэт.

“Чингис хааны онгон”-ыг 1980 онд шинээр сэргээн засчээ. Ингээд би өвөг дээдсийнхээ дурсгалт орон - Эзэн хороог 1983 оны 4 сард хоёрдохи удаа тусгай сурвалжиллаа. Энэ удаагийн олж харсан “Чингис хааны онгон” гэвэл: дөрвөн цомцог, сүлд, “шарилын авдар” зэргийг уулын хэлбэрээр цөм шинээр сэргээн үйлджээ. Үүнээс гадна шинээр нэмсэн зүйл гэвэл, голын их танхимд Чингис хааны том их шуумал хөргийг бүтээж, ар хэрмээр нь Ази, Европын газрын зургийг шаван сийлжээ. Зүүн баруун хоёр хонгилын хананд нь бүр ханын зургийг зурсан байв. Ар танхимын гурван цомцогийн голынхид Чингис хааны цээжин биеийн гуулин хөргийг тавьжээ. Бас баруун хонгилд нь Чингис хаанаас Чан-чунь аршид өгсөн зарлигийн бичиг (уул сурвалж нь Шаньдун мужийн Лаошань-д буй - тус товчооны зураг - 86)-г цайвар өнгийн гантиг чулуун дээр шинээр сийлэн тавьж байв (одоогийн байдал зураг – 89-98-аас лавлаарай).

Багцлаад хэлбэл, энэхүү “Чингис хааны онгон” гэдэг нь хэрэг дээрээ “онгон” биш, харин “Эзний уламжлалт найман цагаан гэр”-ээр бэлгэ шинж болгосон “Ерөнхийн шүтээн” нь үе улиран залгамжлагдсан мөнх дурсгалын газар болно.

Тус бүлэгт Тангуд улсыг хамаг эцэс мөхөөснөөс аваад Чингис хааны нас барсан ба түүний онгон зэргийг тэмдэглэв. Ялангуяа сүүлчийн асуудлыг баахан дэлгэрэнгүй шиг бичив. Учир нь, энэ асуудал дээр янз бүрийн яриа хэлэлцээ ба бичиг тэмдэглэл байдаг бөгөөд хүмүүсийн анхаарлыг ч татсаар ирсэн юм. Иймээс би, энэ тухай яриа тэмдэглэлүүдийг илүүхэн танилцуулсан бөгөөд өөрийн үзэлтээ ярьж, олны судлахад тусламж болохыг хичээв.

Дагалдвар

1 “Ли Дэ ван”-ыг Монгол улсын түүхэнд “Ли Дэ ван” гэж галиглажээ. Тэр бол Тангуд улсын наймдугаар эзэн Ли Цзунь Сюй-гийн хөвгүүн билээ. Харагчин хонин жил (1223 он)-ийн 12 сард Ли Цзунь Сюй сууринаа хөвгүүн Ли Дэ вандаа уламжилж, өөрийгөө өвөг хаан гэж нэрийдэв.

2 Бору вангийн дайлсан цагийг 1224 оны 5 сар гэдэг нь “Монгол Ард Улсын Түүх” дэх тэмдэглэл болно. “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Бору вангийн намтрыг үндэслэж хөх бичин жил (1224 он)-ийн намрын 7 сар гэж тэмдэглэжээ. “Дундад улсын нэвтэрхий түүх” (6 дугаар дэвтрийн 4 дүгээр бүлэг)-д эхлэн дайлсан сарыг дурдсангүй, харин 1224 онд их цэргийг захиран байгуулж, Ся улсын хилийг зүүн этгээдээс нь довтолж шууд Иньчжоу-д хүрчээ. 9 сард монгол цэрэг Иньчжоу хотыг эзлэн авав. Ся улсын цэрэг хэдэн түмэн хүн алагдсан бөгөөд монгол цэрэг хэдэн арван түмэн үхэр хонь зэрэг малыг олзолж, бас Ся улсын жанжин Тахайг амьдаар барьж авав гэж тэмдэглэж буй.

“Иньчжоу” хот бол тухайн үедээ Тангуд улсын зүүн хилийн хот болно. Түүний харьяат газар нь одоогийн Шаньси мужийн Ми Чжи сян, Цзя сян-ий хэмжээгээр байжээ. Тус чжоу-гийн төв нь умард Сүн улсын үед Юнлэ хот (одоогийн Тэмээтээс зүүн өмнө байжээ)-д байгаад

хожим нь 1106 оны үесээр Юнлэ хот нь эвдэрч Иньчуань хот гэж нэрлэдэг байжээ.

3 Чингис хаан тавдахи удаа Тангуд улс өөд дайлсан цагийг их төлөв 1225 он ба 1226 он гэж хоёр янзаар тэмдэглэж байна. 1225 он гэдгийн тухай “Биеэр дайлсан тэмдэглэл”-д: Хөхөгчин тахиа жил (1225 он)-ийн хавар нутагтаа буцаж (Сартуулаас – эшлэгч) ... намар бас цэргийг ерөнхийлөн захирч Тангудыг дайлав. Улаан нохой жил (1226 он)-ийн хавар Тангудад хүрсэн ... гэж, “Д`Оссоны Монголын түүх”-д:

1225 оны сүүлчээр Чингис хаан өөрөө цэрэг дайчилж ордноосоо хөдлөн Тангудыг дайлав. ... 1226 оны 2 сард цэрэг оржээ гэж, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д:

Хорьдугаар он (Чингисийн он тоолол), хөхөгчин тахиа жил (1225 он) ... намар, хаан өөрөө Тангудыг дайлав. ... Хорин нэгдүгээр он улаан нохой жилийн хаврын тэргүүн сар, цэрэг Тангудад оров гэж, “Чингис хааны шүүмжлэл шастир”-т:

Хаан тавдахи удаа Тангудыг дайлсан, мөн ч хамаг эцэс Тангудыг мөхөөсөн цаг бол Сүн улсын Бао Цзин-гийн тэргүүн он, хөхөгчин тахиа жил буюу нийтийн он тооллын 1225 оноос эхэлж ... дараа жилийнх нь 2 сард даруй Тангудад оров ... гэж, “Монгол ард улсын түүх”-д:

...1225 оны 11 дүгээр сарын эхээр өөрийн биеэр 10 түмэн цэргийг авч Тангуд улсыг дайлаар хөдөлсөн байна гэж тус тус тэмдэглэж буй. 1226 он гэдгийн тухай “Нууц товчоон”-д: “Нохой жил (1226 он)-ийн намар Чингис хаан Тангуд иргэнд морилов (265 дугаар зүйл) гэж, “Юань улсын түүх”-д:

Хорин нэгдүгээр он (Чингисийн он тоолол, улаан нохой жил)-ы хаврын тэргүүн сар, баруун Ся улс өштөн Нилха Сэнгүмийг далдалсан (энэ нь эндүүрсэн мэт – тус товчооны долдугаар бүлгийн дагалдварт 2 лавлаарай - эшлэгч) ба барьцааны хүүг ирүүлсэнгүй учраас хаан өөрөө дайлав (энэ нь хөдөлсөн цаг биш, цэрэг хүрсэн цагийг тэмдэглэжээ) гэж тус тус тэмдэглэж байдаг. Владимирцов, Юй баян нар бүр “Нууц товчоон”-ыг үндэслэж тэмдэглэжээ. 1226 оны хавар Тангудад хүрснээр үзэхүл 1225 оны намар цэрэг хөдөллөө гэдэг нь зүйтэй юм. Ингээд би үүнийг нь баримтлав.

4 1225 оны 11 сард Чингис хааны их цэрэг “Түй Онгийн голын хөндий”-д өвөлжлөө гэдэг бол “Монгол Ард Улсын Түүх”-ийн тэмдэглэл болно. Энэ “Түй онгийн гол” гэдэг нь одоогийн “Ту Инь Хэ” (уртраг нь 101°, өргөрөг нь 45.5°)-г хэлж байх мэт. Арбух гэдэг газар ав тавьсан явдлыг “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д 1225 оны өвлөөр, “Нууц товчоон”-д 1226 оны өвлөөр, “Монгол Ард Улсын Түүх”-д бас 1226 оноор тус тус тэмдэглэж буй. Гэтэл 1226 оны өвөл Чингис хааны цэрэг нэгэнтээ Тангудын нутагт гүнзгийрэн байлдаж байсан тул ав хийх нь арай зохисгүй юм. Ингээд би Ту Цзи-гийн тэмдэглэлийг баримтлав. Энэ “Арбух” гэсэн газар бол хуучин халхын Сайн ноён хаан аймгийн Арцбогд уул мөн бөгөөд тэр нь Хар хорумаас Тангуд өөд явах элсэн замд байх нэгэн үхрийн хэлбэртэй уул гэж Ту Цзи авгай тайлбарлажээ.

5 “Чугурахун” гэдэг газар бол “Нууц товчоон”-ы нэр (Ц.Дамдинсүрэнгийн одоочлогод “Цоорха” гэжээ) болно. Үүнийг Д`Оссоны номд “Онго талын худаг” гэсэн газраар тэмдэглэж байх бөгөөд “ганц худаг” гэсэн утгатай гэж Ту Цзи тайлж байлаа. Рашидын номд “Онгон далан худаг” гэжээ. Д`Оссоны мэдээ нь үүнээс гаралтай нь илхэн байна. Гэвч Ту Цзи-гийн

тайлбар ямар үндэстэйг одоогоороо ойлгоход хүчиртэй санагдана.

6 “Эрижэү” (“Нууц товчоон”-д “Э ли цзэ у”, “Юань улсын түүх, Елюй Люгэ-гийн намтар”-т “Аличжоу” гэдэг байна) хот бол Сүн улсын үе дэх “Си Лянь Фу”, одоогийн Ганьсу мужийн “У Вэй” хотыг хэлж байна. Ц.Дамдинсүрэн авгай “Си-лян” гэж тайлсан нь таарч байх юм.

7 “Эзнэй гол” гэсэн нь “Монгол ард улсын түүх” дэх нэр болно. Энэ нь одоогийн “Эзнэй гол” (өөр нэр нь Жо Шуй гэдэг) бололтой. “Хар балгас” гэдэг бол одоогийн Өвөр Монголын Эзнэй хошууны төвөөс зүүн хойш нарийн голын зүүн эрэгт байсан эртний хот болно. Үүнийг Юань улсын үед Эзнэй зам (лу) гэж хэлдэг. Марко Поло-гийн тэмдэглэлд дурдсан “Эзинэ хот” (“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-ийн 197 нүүр дэх тайлбар “34”-ийг лавлаарай) болно.

8 “Хунь Цуй Шань уул” гэдэг бол Эрижэү-гээс өмнөш буй. “Юань улсын түүх”, “Д’Оссоны Монголын түүх”, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д бүр энэ нэрээр тэмдэглэжээ. Үүнийг “Нууц товчоон”-д “Цаст дээр” (Цаст уул) зусав гэдэг. “Монгол Ард Улсын Түүх”-д Чингис хааны энэ зун зуссан газрыг “Эзнэй гол орчим” гэж адил бусаар тэмдэглэж байна.

9 “Тан Цин” бол Чингис хаан Алтан улсыг дайлах үед зүүн гарын цэргийг захирах юаньшуай байжээ. Сүүлд нь Өгөөдэй хааны үед бас Алтан улсад элчилж очоод алагдсан байна.

10 “Лю Пань Шань уул” бол Нинся-гийн Хотон Үндэстний Өөртөө Засах Орны өмнө ба Ганьсу мужийн зүүн хэсэгт байна. Өмнөш умарш урталжилсан (бараг 240 километр буй) уул болно. Өмнө хэсгийг нь бас Лун Шань уул гэдэг. Тэр нь Шаньбэй болон Лун Чжун хоёр өндөрлөгийн зааг болдог билээ. Хамгийн өндөр оргил нь Ми Ган Шан (2.942 метр өндөр), Лю Пань Шань (2.928 метр өндөр) хоёр болно. Зам нь уулаа зургаа ороож оргилд нь гардаг учраас Лю Пань Шань гэж нэрлэжээ.

11 Чингис хааны нас барсан он жил нь түүх шастирт бүр нэгдэлтэй байдаг. Тэр нь Чингис хааны хорин хоёрдугаар он, улаагчин гахай жил буюу нийтийн он тооллын 1227 он болно. Гагцхүү сар өдрийг нь хэд хэдэн янзаар тэмдэглэсээр байна. Жишээлбэл, “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т: “Намрын долоон сар хар морин өдөр, чилээрхэв, шарагчин үхэр өдөр Саарь хээрийн харилт дахи ордондоо халив” гэжээ. “Хаадын үндсэн хураангуй алтан товч”-д: Бин гахай (бин гэдэг нь улаан гэсний хятад хэллэг болно. Чухамдаа “дин” байвал зохих юм. Тиймээс энэ нь хуулбарын алдаа буюу хэвлэлийн алдаа болсон нь тодорхой байна – эшлэгч) жилд жаран долоон настай долоон сарын арван хоёроо тэнгэрт халив (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1980 оны хэвлэл) гэжээ. “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д: Жаран зургаан насандаа дин гахай жилийн долоон сарын арван хоёр өдөр. Түрэмгий балгаснаа. Тэнгэр эцэгтээ өөд болон одов (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1962 оны гэрэл зургийн хэвлэл) гэжээ. Лувсанданзаны “Алтан товч”-д: Хорин хоёрдугаар он(Чингисийн он тоолол – эшлэгч) улаагчин гахай жилд жаран зургаан насандаа долоон сарын арван хоёроо тэнгэр болов (Улаанбаатарын 1937 оны хэвлэл, 107 нүүр) гэжээ. “Шар тууж”-д: Гал гахай жилийн хаврын адаг сарын 16-наа (энэ бол 3 сарын 16 болно – эшлэгч) жаран зургаан насандаа Милэгийн Түрэмгий балгасанд нөгчив (энэ нь “гал гахай” гэсэн нь төвд тоолол болно. Хятадын “дин”, Монголын “улаагчин” лугаа тэнцэнэ. “Милэг” гэдэг нь “махан”-ы өөр бичлэг болно. Чухамдаа “минаг” – minag, хятадаар “ми-ю, му-я” гэж бичдэг. Тангудын өөр нэгэн нэр нь болно – эшлэгч)” (Москва, Ленинградын 1957 оны хэвлэл) гэжээ.

“Тангын урсгал”-д: Жаран зургаан өлзий гал гахай жил, өвлийн сүүл сар Лю Пань Шань ууланд тэнгэр болов (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо, 1981 оны хэвлэл) гэжээ. Ту Цзи-гийн “Монголын түүхэн тэмдэглэл”, Вэй Юань-ий “Шинэ найруулсан Юань улсын түүх”, Кэ Шао Мин-ий “Юань улсын шинэ түүх” зэрэг сүүлчийн үеийн хятад түүхчдийн зохиолд бүр “Юань улсын түүх”-ийн тэмдэглэлийг баримталжээ. Эдгээр бол монгол, хятадаар зохиогдсон гол гол тулгар бичгийн тэмдэглэлүүд болно.

Үүнээс гадна, гадаадын түүхчдийн тэмдэглэл гэвэл доорхи хэдэн зүйл байна. Рашид-ад-Диний номд: “Гахай жилийн намрын хоёрдугаар сарын арван таванд, тэр өөрийн алдарт ураг төрөлдөө өөрийн хаан ор, улс орноо ба харьяат газраа үлдээж, ертөнцөөс ангижрав” гэжээ. “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-д: Чингис хааны өвчин улам хүндэрсэн тул түүний байсан газраас нь авч явахын аргагүй, 624 он (Исламын он тоолол – эшлэгч)-ы рамадан сарын дөрөвний өдөр (1227 оны 8 сарын 18 өдөр) тэр тэндээ ертөнцөөс өнөд ангижрав гэжээ. “Д’Оссоны Монголын түүх”-д: Хаан 1227 оны 8 сарын 18-ны өдөр, жаран зургаан настайдаа, найман өдөр өвдөөд үхжээ. Сууринаа хорин хоёр жил байв (нэгдүгээр боть, есдүгээр бүлэг) гэжээ. Владимирцов, Кобаяши Такаширо нар ч мөн энэ 8 сарын 18-ныг баримталжээ. Гэтэл Накамичиё авгай Шарагчин үхэр өдөр бол Христосын он тоолол (нийтийн он тоолол – эшлэгч)-ын 1227 оны 8 сарын 25-ны өдөр болно. “Судрын чуулган”-ы орчуулгад 8 сарын 15 гэсэн нь таарахгүй юм гэжээ. “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”-д: Мөн он (1227 оныг зааж байна - эшлэгч)-ы 8 дугаар сарын 25-ны өдөр Чингис дээр дурдсан Циншуй сянь гэдэг газар цөөн хоног өвчилж байгаад нас баржээ. Чингис 65 настай байжээ гэв. Бас нэг зүйлийн тэмдэглэл бол Японы Китамура Казу-гийн зохиосон “Чингис хаан” гэдэг номд: Хаан өрнө дахины он тооллын 1227 оны 8 сарын 16-ны өдөр Лю Пань Шань-д нас барав гэж тэмдэглэжээ. Дээр дурдсан бодтой тэмдэглэлүүдийг би эл талаар магадлаж үзээд анх алхам доорхи дүнг олов.

(1) Долдугаар сар гэдэг нь бүр монгол, хятад тулгар бичгүүдэд дурдагдаж байх бөгөөд энэ нь Дундад улсын он тооллын журмаар бол билгийн улирал болох юм. Наймдугаар сар гэдэг нь бүр гадаадын түүхчдийн тэмдэглэлд дурдагдаж байх бөгөөд тэр нь нийтийн он тооллын журмаар бол аргын улирал болох юм.

(2) “Юань улсын түүх” зэрэгт тэмдэглэсэн намрын 7 сарын шарагчин үхэр өдөр гэдэг бол бусад тэмдэглэлүүд, ялангуяа монгол тэмдэглэлүүдэд дурдсан “долдугаар сарын арван хоёрны өдөр” болох нь бүр түүхэн баримттай гэж үзэж болно. Хятад түүхчид өдрийг арван хоёр жилээр тэмдэглэдэг байна. Гэхдээ сар бүрийн шинийн нэгэнд оногдох тэр зүс буюу жилийг “шинэтгэл өдөр” гэж тодорхойлж өгөөд доргогш нь арван хоёр жилийг тэнгэрийн эш (буюу арван өнгө)-ээр дэс дараалан тэмдэглэдэг. Гэвч “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т Чингис хааны анхдугаар оноос нааш энэ (шинэтгэл өдөр)-ийг ер тэмдэглэсэнгүй байна. Энэ нь бодтой өдөр сарыг тодлоход нэлээд бэрхшээлийг учруулав. Гэвч энэ асуудлыг шийдвэрлэх өөр арга зас бас байдаг. Юу гэвэл, бусад тэмдэглэлээр нотолж болно. Би “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” лугаа адил цагт оршиж байсан “Алтан улсын түүх”-ээр сүвэгч болгов. 1227 он бол Алтан улсын Айцзун хааны Чжэн Да-гийн дөрөвдүгээр он болно. Гэтэл энэ онд “шинэтгэл өдөр”-ийг хоёрхон удаа тэмдэглэжээ. Нэг нь: Чжэн Да-гийн дөрөвдүгээр он, цагаан сар шинэтгэл өдөр цагаагчин гахай гэж, нөгөө нь: зургадугаар сар шинэтгэл өдөр шар бич гэж тэмдэглэж буй. Энэ “шар бичин өдөр” (адил өнгийн адил жил нь

жаран нэгэн өдөрт нэг удаа тохиолддог)-ийг цагаан сарын шинийн нэгний цагаагчин гахай өдрөөс хойш жагсааж үзвэл, 58 дугаар өдөрт, 118 дугаар өдөрт, 178 дугаар өдөрт тус тус нэг удаа (нийт гурван удаа) тохиолддог. Цагаан сарын шинийн нэгнээс зургаан сарын нэгэн болтол хэвийн байдалд бүхэл таван сар байх ёстой. Хэрвээ нэг сарыг 29 хоногоор жишвэл нийт 145 өдөр, 30 хоногоор жишвэл 150 өдөр байх ёстой. Хэрэг дээрээ бүгд 29 өдөр буюу бүгд 30 өдөр байж болохгүй. Учир нь билгийн улирлын бага сар нь 29 хоног, их сар нь 30 хоногтой байдаг бөгөөд их бага сар ээлжилж байдаг юм. Алинаар нь бодсон ч 118 дугаар өдөрт тохиолдох “шар бичин өдөр” бол тус оны зургадугаар сарын шинийн нэгэн лав биш. Чингэвэл 178 дугаар өдөрт тохиолддог “шар бичин өдөр” бол зургаан сарын шинийн нэгэн болох ёстой. Гэтэл бас нэг асуудал гарч ирлээ:

Энэ нь 27-32 өдөр илүү болчлоо! Ийм болохоор энэ хооронд заавал нэг “илүү сар” байх ёстой байна. Гэтэл “Алтан улсын түүх”-д Син Дин-гийн тавдугаар он (1221 он)-д илүү арван хоёр сартай гэж тэмдэглэснээс хойш 1227 он болтол “илүү сар”-ын тэмдэглэл үгүй. Харин “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-ын хорин хоёр жил (1206-1227 он)-ийн дотор нэг л “илүү сар”-ыг тэмдэглэж байна. Энэ нь 1227 онд “илүү таван сар”-тай гэж тэмдэглэж байна. Үүнийг “Алтан улсын түүх”-д тэмдэглэсэн 1221 оны “илүү сар”-тай хамтруулан үзэхүл, яг билгийн улирлын илүү сарыг тохируулж одон орны ухаан (илүү сар нь гурван жилд нэг удаа, таван жилд хоёр удаа, долоон жилд гурван удаа тохиолддог)-тай яв цав тохирч байна. Өөрөөр хэлбэл, 1221 онд нэг илүү сартай тул 1223 он, 1225 он ба 1227 онд тус тус нэг удаа тохиолдох ёстой. Тиймээс “Юань улсын түүх” дэхи 1227 оны “илүү таван сар” нь шинжлэх ухааны баримттай зөв тэмдэглэл болно.

Бид 1227 оны билгийн зургаан сарын нэгэн бол “шар бичин” өдөр гэснийг бодтой мэдсэн суурь дээр, Чингис хааны чилээрхсэн “хар морин өдөр”-ийг цаашид тоолоход, яг гучин дөрөвдүгээр өдөрт нэг л “хар морин өдөр” тохиолдож байна. Хааны нас барсан “шарагчин үхэр өдөр” нь дөчин нэгдүгээр өдөр тохиолджээ. Хэрвээ бид олонхи монгол түүхэн тэмдэглэлд тэмдэглэсэнчлэн “долоон сарын арван хоёр”-ыг “шарагчин үхэр өдөр”-өөр үздэг бол “хар морин өдөр” нь долоон сарын шинийн тавны өдөр болох бөгөөд долоон сарын шинийн нэгэн бол “шар барс өдөр”, зургаан сарын хорин есөн өдөртэй бага сар болно. Ингээд бид, Чингис хаан бол 1227 оны билгийн улирлын долоон сарын шинийн таван хар морин өдөр чилээрхэж (өвдөж), тус сарын арван хоёрны шарагчин үхэр өдөр нас барсан нь оновчтой тэмдэглэл гэсэн дүнг олов. Чингис хаан найман өдөр өвдөөд үхлээ гэсэн “Д’Оссоны Монголын түүх”-ийн тэмдэглэл ч баримттай бөгөөд Дундад улсын тэмдэглэлийг хөндлөнгөөс гэрчилж өгөв. Ингэвэл бид билгийн улирлын долоон сарын арван хоёрноос бус тэмдэглэл – тухайлбал “Гангын урсгал”-д тэмдэглэсэн “Өвлийн сүүл сар” гэдэг нь буруу гэдгийг нотолж болно.

(3) Гадаадын түүхчид найман сар гэж тэмдэглэснийг, ялангуяа “8 сарын 18-ны өдөр” ба “8 дугаар сарын 25-ны өдөр” гэснийг шинжлэх ухааны баримттай гэж үзэлтэй байна. Бид дээр нэгэнтээ “хар морин өдөр”-ийг долоон сарын таван, “шарагчин үхэр өдөр”-ийг долоон сарын арван хоёрон гэж нотолсон нь Чингис хааны өвдсөн цаг нь найман өдөр болох бөгөөд ийм ч тэмдэглэл (Д’Оссоны)-тэй юм. Чингэвэл энэ 8 сарын 18-наас 25 хүртэл бас яг найман өдөр болох юм. Ингээд үздэг бол, “8 сарын 18-ны өдөр” гэдэг нь Чингис хааны өвдсөн өдөр - билгийн улирлын долоон сарын шинийн тавны хар морин өдрийг тэмдэглэсэн, “8 сарын 25-

ны өдөр” гэдэг нь Чингис хааны чухам нас барсан өдөр - билгийн улирлын долоон сарын арван хоёр буюу шарагчин үхэр өдрийг тэмдэглэсэн гэж үзэхэд мөн ч зүй үгүй газаргүй мэт. Энэ нь арга билгийн цаг улирлын харьцуулал ч тохирч байна. Жишээлбэл, аргын 8 сарын 25-ны өдрийг билгийн 7 сарын 12-ноор нотолдог бол, тэр жилийн билгийн цагаан сарын шинийн нэгэн нь аргын улирлын 1 сарын 19-ний өдөр болно. Тэр жил бол 2 сар нь 29 хоногтой илүү жил юм (учир нь аргын улирлын оны тоо нь дөрвөөр бүхэл хуваагдвал тэр жил нь илүү жил, 2 сар нь 29 өдөртэй. 1227 он нь 4-өөр бүхэл хуваагдаж болдог байна). Тиймээс 1 сарын 1-нээс 8 сарын 25 хүртэл нийт 238 өдөр буй. Түүнээс билгийн улирлын 219 өдөр (Цагаан сарын шинийн нэгний цагаагчин гахай өдрөөс долоон сарын арван хоёрны шарагчин үхэр өдөр хүртэл)-ийг хасвал, тэр нь билгийн цагаан сарын шинийн нэгэн болно. Энэ бол нийтийн он тооллын зүй ёстой бүрмөсөн нийцэж байна.

Бид Чингис хааны нас барсан цагийг нийтийн он тооллын ёсоор бодвол, 1227 оны 8 сарын 18-ны өдрөөс эхлэн өвдөж, найман өдөр болоод тус сарын 25-ны өдөр нас барсан гэж нотолж болмоор байна. Энэ нь Джувейни, Д’Оссон, Владимирцов, Кобаяши нарын тэмдэглэсэн (8 сарын 18)-ийг нь өвдсөн цаг гэж, Накамиchie болон “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх”-д тэмдэглэсэн (8 сарын 25)-ийг нас барсан цаг гэж үзсэн явдал болох бөгөөд тэр нь Дундад улсын тулгар бичгүүдэд билгийн улирлаар тэмдэглэсэнтэй ч нэгдэх юм.

12 Чингис хааны нас барсан шалтгааныг бас янз бүрээр тэмдэглэсээр иржээ. Түүнийг доорхи хэдэн зүйлээр хураангуйлж болно.

(1) Өвчнөөр нас барсан гэдэг. Жишээлбэл: “Юань улсын түүх”-д “чилээрхэв” гэжээ. Д’Оссон “хүнд өвчин хүрч” гэв. Юй баян “өвчнөөр үхэв” гэжээ. Гэвч чухам ямар өвчин гэснийг эдгээр материал дурдсангүй. Джувейни Тэр (Чингисийг хэлж байна – эшлэгч), муухай уур амьсгалаас болсон засрашгүй өвчнөө нэрвэгдэв гэж баахан бодтой тэмдэглэжээ. Түрэмгий балгаснаа, богд эзэн хүнд халууцаад, алтан амиа гарахуй цагт ... хэмээн хамаг зарлигийг буусан хойно ... тэнгэр халив (энэ нь “Хураангуй алтан товч”-ийн тэмдэглэл болно. Лувсанданзаны “Алтан товч” ч цөөн хоёр үсгийн бичлэгээс бусдыг нь бүр адил байдаг) гэж арван долдугаар зууны үеийн монгол түүхчид бодосч үзлээр тэмдэглэжээ. Сүүлчийн үед Германы монголч эрдэмтэн Хэйнишээс энэхүү “халуурах” өвчнийг нь “эсэргэнэ хижиг бололтой” гэжээ. Ямар өвчин ч болтугай, Чингис хаан ихээр халуурах хүнд өвчин хүрч нас барлаа гэдэг нь зүйтэй гэж би үзэж байна. Гэвч бас өөр өөр янзаар, зарим нь авахын аргагүй сэтгэлч үзлээр буюу хөдхөөр тэмдэглэж ном бичигт үлдээсэн болохоор, энд тэмдэглэж анхаарал болгоё.

(2) Чингис хаан мориноос ойчиж бэртсэн нь түүний нас барсны шалтгаан мэт зарим тулгар бичигт тэмдэглэж байдаг. Чингис хаан ав тавьж байгаад мориноосоо ойчсон мэдээ байдаг. Гэвч энэ бол 1225 оны өвлийн явдал болно. 1227 оны намар болоход бараг хоёр жил шахам болжээ. Харин тэр бэртсэнийг нь илаарь болов гэж үзэж болох мэт. Түүний дараагаар Тангуд улсын өргөн уудам нутгаар жил илүү байлдаж явснаар нь үзэвч, тэр удаагийн бэртсэн нь илаарь боллоо гэдгийг гэрчилж байна.

(3) “Хамаг эцэст нэгэн Тайгинь хэмээх цайз хотыг бүслэн байлдах үес, Чингис хаан ану өвдөгтөө зэвийн шарх олж, тэр шархаар насан эцэслэж, хүүрийг Алтай ууланд оршуулжээ” гэж Марко Поло мэдээлэн тэмдэглэжээ. Энэ нь үзэхэд сонихон боловч, үнэндээ зөвхөн аман

уламжлалын сонсгол төдийхөн юм.

(4) “Тангудын эзний хатан Гүрбэлжин гуа гэгч хорлов” гэдэг. Арван долдугаар зууны үеийн түүхч Саган сэцэний зохиосон “Хаадын үндэсний эрдэнийн товч”-д Чингис хааны үхсэн шалтгааны тухай хэмээхдээ: Тэндээс Шударга хаан (Тангудын эзнийг хэлж буй – эшлэгч)-ыг могой болон хувилахад нь, эзэн (Чингисийг хэлж буй, дорогш адил – эшлэгч) жигүүртний хаан гарьд болон хувилж, барс болон хувилахад нь, эзэн гөрөөдийн хаан арслан болон хувилж, хөвгүүн болон хувилахад нь тэнгэрсийн хаан Хурмаст болон хувиран бүхийд, Шударга хаан эрх эрхгүйеэ баригдав. Тэндээс Шударга хаан: намайг албаас энэ биед чинь муу, аварваас хойд үр чинь муу хэмээсэнд, эзэн: энэ биед минь гай үгүй, хойд үрд минь сайн болтугай хэмээгээд харваж, цавчиж, бүлж даалган ядахуйд Шударга хаан: та намайг бус мэсээр үл даалгагдмуй, мөн миний гутлын улд гурван хугас хийж (гурав нугалж гэсэн утгатай мэт – эшлэгч) эвхсэн мисэри нэрт болд илдээр, түүгээр цавчваас болох хэмээсэнд, тэр илдийг гарган авахуйяа, бас бээр ийн өгүүлрүүн: өдгөө та бээр, намайг алан амуй, биеэс минь сүү гарваас, биед чинь муу, цус гарваас үрд чинь муу буюу, бас бээр Гүрвэлжи гуа минь чи биедээ авах бөгөөс, бүх бие (ийг) нь сайтар нэгжиж үзэгдэхүй (үзтүгэй – эшлэгч) хэмээв. Тэндээс тэр мисэри болд (илд)-оор хүзүүг нь тас цавчин алахуйд хүзүүнээс нь сүү гарчээ. Тэр мэт Шударга хааныг алж, Гүрвэлжи гуа хатныг нь аван, ... тэндээс шөнө болдож (болгож – эшлэгч), унтсаны хойно, эзний алтан биед гэм болгосноор, эзэн чилээрхэн бүхийеэ, Гүрвэлжи гуа хатан босч одоод хар мөрнөө унаж үхэв. ... Тэндээс эзэн чилээгээ бэрхэд амиа ойртохуйяа ... зарлиг болруун, жаран зургаан насандаа, дин гахай жил долоон сарын арван хоёр(ны) өдөр, Тормэгэй (Түрэмгий – “Нууц товчоон”) балгаснаа, тэнгэр эцэгтээ өөд болон одов (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны 1962 оны хэвлэл) гэж бүрмөсөн хий хоосноор зохион бичжээ. Үүнийг “Шар тууж”-д: “Гүрбэлжин гуа хатан нууц орондоо химхин (хямсаа гэсний хуулбарын ташаарал бололтой – эшлэгч) хавчуулж, эзний нууц орон (-ы) (-ыг) гэм болгоод, дутааж Хар мөрөн (Хатан голын эртний нэр – эшлэгч)-д унаж үхэв. ... Тэндээс эзэн (-ийг) (-ий) бэрхдэн (бэрх болон – эшлэгч) амиа ойртохуйд ... хэмээн зарлиг болоод, гал гахай жилийн хаврын адаг сарын 16-наа (арван зургаан – эшлэгч) жаран зургаан насандаа Милэгийн Түрэмгий балгасанд нөгчив” (Москва, Ленинградын 1957 оны хэвлэл) гэж хөдхи бүдүүлэгээр Чингисийг доромжлох хувиас зохиожээ.

Хэрэг дээрээ, Тангудын эзэнд “Гүрбэлжи гуа” (буюу Гүрвэлжин гуа) гэдэг хатантай гэсэн түүхэн тэмдэглэл ер байгаагүй мөртөө Чингис хаан энэ удаа Тангудаас хатан авсангүй бөгөөд Тангуд улс хамаг эцэс бууж өгөхөөс өмнө нас барсан байна (харамсалтай нь, Эзэн хорооны “Чингис хааны онгон”-д одоо болтол “Гүрбэлжи гуа хатны шарил” гэж тахиж буй). Чингис хаан Тангудаас нэгэн татвар хатан авсан учир бол 1209 онд гуравдахи удаа Тангудыг дайлах үед гарсан явдал болно, нэр нь Чагаа гүнж гэдэг билээ. Тэр үед нэгэнтээ арван найман жилийн өмнөх учир болжээ. Тангуд улсыг мөхөөсөн хойно Тангудын эзэн Ли Сянь-ийг аллаа гэдэг тэмдэглэл байдаг. Гэвч Чингис хаан биеэр алсангүй бөгөөд тэр үед Чингис хаан нэгэнтээ нас бараад нууж байжээ. Тиймээс эдгээр тэмдэглэл нь өчүүхэн ч түүхийн баримтгүй юм. Одоо бид түүхийн үнэнч хуудсыг ариутгах хувиас энд анхаарал болгон тэмдэглэв.

(5) Гүюг хааны үед Монголд элчлэн айлчилсан (1245 оны 4 сарын 16 - 1246 оны 11 сарын 13) анхдагч европ хүн – Ромын шашны хааны төлөөлөгч Плано Карпини гэгчийн зохиосон

“Монголд элчилсэн тэмдэглэл” гэдэгт Чингис хааны нас барсан шалтгааныг:

“Тэр аянгад дайрагдан үхэв” (тус тэмдэглэлийн тавдугаар бүлгийн нэгдүгээр хэсэг, 11 дүгээр зүйл) гэж тэмдэглэжээ. Энэ бол Карпини-гийн сонссон нэгэн зүйлийн домог болох л төдийгөөс биш, өөр ямар ч баримтгүй юм.

13 Чингис хааны нас барсан газрыг олон түүх шастирт бас янз бүрээр тэмдэглэсээр иржээ. Түүний гол голыг нь авч хэлбэл доорхи мэт:

(1) “Цин Шуй Сянь-ий Си Цзян” гэж тэмдэглэсэн нь “Д’Оссоны Монголын түүх”, “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх” (гурван ботийн), Чжан Чжэнь Пэй-н зохиосон “Чингис хааны шүүмжлэл шастир”, Владимирцовын зохиосон “Чингис хааны намтар”, Юй Юань Ань-ий зохиосон “Чингис хааны намтар” болон Кобаяши Такаширо-гийн зохиосон “Чингис хаан” зэрэг болно.

(2) “Түрэмгий балгас” гэж тэмдэглэсэн нь “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, Лувсанданзаны “Алтан товч”, Кэ Шао Минь-ий зохиосон “Юань улсын шинэ түүх, Тайцзу-гийн шастир” болон Ту Цзи-гийн зохиосон “Монголын түүхэн тэмдэглэл” зэрэг болно.

(3) “Лю Пань Шань уул” гэж тэмдэглэсэн нь Рашид-ад-Диний зохиосон “Судрын чуулган” болон үзэмчин Гомбожавын зохиосон “Чингис эзний алтан ургийн түүх Гангын урсгал нэрт бичиг оршив” (“Гангын урсгал” гэж товчилдог) зэрэг болно.

(4) “Саарь хээрийн харилт аяны ордон” гэж тэмдэглэсэн нь “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” болно.

(5) “Лю Пань Шань-ий Саарь хээрийн аяны ордон” гэж тэмдэглэсэн нь Вэй Юань-ий зохиосон “Шинэ найруулсан Юань улсын түүх, хааны шастир” болно.

Үүнээс гадна, Тайгинь (Марко Поло-гийн аяллын тэмдэглэл), Яргай (Дэлхийн түгээмэл түүх) гэж тэмдэглэдэг ч буй.

Эдгээр тэмдэглэлүүдийг нарийн хянаж үзэхүл, “Цин Шуй Сянь-ий Си Цзян”-д нас барлаа гэдэг нь нэлээд баримттай мэт санагдуулна. Учир нь:

(1) Чингис 1227 оны билгийн улирлын илүү 5 сард Лю Пань Шань ууланд зусаж, 6 сард нь мөн энэ газар Алтан улсын элчийг хүлээн авч уулзаад, дараа нь Цин Шуй Сянь-ий Си Цзян гэдэг газар хүрчээ. Энэ үед бараг 6 сарын сүүлч болсон ёстой. Чингис хааны өвдсөн цаг бол 7 сарын шинийн 5-ны өдөр болох бөгөөд наймхан өдөр болж 12-ны өдөрт нь нас барсан юм. Тиймээс цагийн талаар үзэхүл Чингис хааны гол их цэрэг хойш буцах завгүй.

(2) Газар байцын талаар авч үзвээс Цин Шуй сянь-аас Түрэмгий балгас (Нинсяы Иньчуань хотоос өмнөхөн Хатан голын зүүн хөвөөнд бүхий Лин У сянь) хүрэх бололцоогүй юм. Түрэмгий балгасаас өмнөш Цин Шуй сянь нь газрын зургийн асхан (шулуухан - хө.) шугамаар 360 км (долоон зуун хорин газар, хэрвээ зам барин явбал мянган газраас доошгүй юм) байдаг.

Дахиад хэлбэл, Түрэмгий балгасыг Монголын цэрэг 1226 оны 11 сард нэгэнтээ эзлэн авч талхидсан атал энэ үед дахин эчих хэрэгцээ ч үгүй мэт.

(3) Чингис хаан Тангуд улсын газар нутгийнхи нь олонхийг нь эзэлж, нийслэл Яргай хотыг нь бүслэн хаагаад, өөрөө өмнөш Цин Шуй өөд орсон явдал бол өмнөд Сүн улсын газраар тойрч, Алтан улсыг мөхөөх зорилготой гэж зарим түүх шастирт тэмдэглэдэг юм. Энэ зорилгоо биелүүлээгүй тул 7 сарын 5-нд өвдөхөөсөө өмнө буцах ёсгүй.

(4) Чингис хаан өвдсөн хойно буцах бололцоо нэн ч үгүй мэт. Чингис хаан бол шинийн 5-нд түргэн өвчнөөр өвдсөн бөгөөд өвдмөгцөө их хүнд байсан тул зам явахад тохиромжгүй юм.

(5) “Алтан улсын түүх, Саханян-ы намтар” (111 дүгээр боть)-д: “Их Юань улс (Хаант Монгол Улсыг хэлж буй, энэ үе Юань улсыг байгуулаагүй байсан юм - эшлэгч) баруун Ся улсыг мөхөөж, Шаньси-д цэрэг оров. 8 сард Цин Шуй-гийн мэдээг хаан олж аваад, цэргийн хэрэгцээний гааль тохируулалыг бачим эрхлэгчдээс бусад нь зогсох хэрэгтэй гэж зарлиг буулгав” гэж тэмдэглэж байдаг. Энэ “Цин Шуй-гийн мэдээ” гэдэг бол Чингис хааны үхсэн мэдээ гэж зарим түүхчид үзэж байдаг нь зүйтэй юм. Тиймээс Алтан улс ч цэрэг дайны бэлтгэлээ баахан сулавтар болгожээ.

“Лю Пань Шань”-д нас барлаа гэсэн нь их газрын нэрээр нь уламжлагдсан ч байж мэднэ. Учир нь Лю Пань Шань бол өмнөш умаршаа хоёр зуун дөчөөд км урт бөгөөд яг Цин Шуй Сянь-ий хажуугаар байдаг юм. Лю Пань Шань нь Монгол түүхэнд “Луу Ван хан” гэдэг алдартай юм. Цин Шуй бол нэгэн сянь-ий газар болохоор хол ойрд Лю Пань Шань мэт алдар цуугүй нь мэдээжийн хэрэг.

“Саарь хээрийн харилт” дахи аяны ордон бол Монголын эх газар байдаг тул нэн ч алс хол хэдэн мянган газарт байх юм. 6 сард нь Цин Шуй сянь-д байсан Чингис хаан 7 сарын шинийн 5-нд нь Саарь хээрийн ордондоо буцаж хүрээд өвдөх зам бололцоо яасан ч байхгүй. Чингэвэл нас барсан өдөр сарыг нь хүртэл тийм оновчтой тэмдэглэсэн “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” яагаад газрыг нь ийм их зөрөөнтэй тэмдэглэсэн буй гэвэл, би бодоход энэ явдлыг санаачилгатайгаар өөрчилсөн ч байж мэднэ. Чингис хааныг нас барах үед Тангуд улс нэгэнтээ хүч мухардсан боловч хамаг эцэс бууж өгөөгүй, бас нэг сарын цагийг гуйж байсан юм. Хаан нас барах үедээ үхсэн мэдээг бүү задруул гэсэн гэрээстэй хэрэг юм. Энэ бол зүйтэй хэрэг юм. Хэрвээ Чингис хааны нас барсан мэдээ задарвал, нэгд өөрийн дотор их самуурал гарч мэднэ. Хоёрт Тангуд улс бууж өгөхөө больж ч мэдэх юм. Тиймээс Чингис хааны үнэн ажиллагааг тэмдэглэгчид зориудаар шарилыг ар газар хүргэж очсон анх газраар нь нас барсан газар болгон тэмдэглэснийг “Юань улсын түүх”-ийг бичих үед хянан залруулсангүй уламжилсан бололтой. Одоо дотоод гадаадын түүхчид Чингис хааны нас барсан газрыг энэ Цин Шуй Сянь-аар үзэх нь олширч байна. Ингээд би ч өчүүхэн хувиа нэмэрлэв.

Энэ Цин Шуй сянь бол одоогийн Ганьсу мужийн зүүн зах дахи Шаньси муж лугаа залгалдсан (уртраг нь 106.10° , өргөрөг нь 34.42°) нэгэн сянь болно. Тэр нь эртний Хань улсын үед байгуулагдаад үе улиран иржээ. Түүхэнд бас Циньчжоу гэж нэрлэдэг билээ. Си Цзян гэдэг нь Цин Шуй сянь-ий харьяан дахи нэгэн бяцхан голын нэр гэдэг билээ.

14 Чингис хааны шарилыг оршуулсан тухай монгол түүхийн сурвалж бичгүүд дэх тэмдэглэл гэвэл:

“Хураангуй Алтан товч” (Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны 1980 оны хэвлэл)-д:

“Хасаг тэргэнд хүлгүүдийг хүлж, хаан эзний алтан хүүрийг өргөн тээж харьж ирэхүйд Сөнидийн Гилүгэдэй баатар эзнийг магтруун:

Халих харцгай[н] жигүүр болон одов уу чи эзэн минь,

Хангинах тэрэгний тээш болов уу чи эзэн минь,

Туулих харцгай[н] жигүүр болов уу чи эзэн минь,

Тойрох тэрэгний тээш болов уу чи эзэн минь,

Жиргэх шувууны жигүүр болон одов уу чи эзэн минь,

Жирхрах тэрэгний тээш болов уу чи эзэн минь

гэж магтан иртэл, Өмнийн (бусад сурвалжид: Монан, Мона, Онайн гэж байсныг анхаарах болов уу! – эшлэгч) Хөхбөрт хүрээд хасаг тэрэг нь бул чинээ шаварт шигдэж хөдлөн чадахгүй, таван өнгийн хүлгүүдийг хүлж гарган ядангираад гүр их улс бүхэн зовхуйд, Сөнидийн Гилүгэдэй баатар мөргөн өчрүүн:

Хөх мөнгөн (мөнх) тэнгэр тэнээс заяагаар төрсөн

Хүлэг богд эзэн минь,

Гүр их улсаа орхиж хүрэв чи.

Дээд төрөлдөө төвшнөө байгуулсан төр чинь,

Төрлөн байгуулсан улс чинь,

Төрүүлсэн хатан хөвгүүн чинь,

Төрсөн хаан газар ус чинь тэнд бөлгөө.

Ариунаа байгуулсан төр чинь,

Албалан байгуулсан улс чинь,

Амрагт хатан хөвгүүд чинь,

Алтан орд харш чинь тэнд бөлгөө.

Урнаа байгуулсан төр чинь,

Учралдсан хатад хөвгүүд чинь,

Урьд зөөсөн олон улс чинь,

Ураг элгэн чинь тэнд бөлгөө.

Ургамал улс иргэн чинь,

Угаасан ус чинь,

Олон Монгол улс чинь,

Онон Дэлүүн Болдог төрсөн газар ус чинь тэнд бөлгөө.

Хээр азарганы чинь гөхлөөр гөрж хийсэн туг сүлд чинь,

Хэнгэрэг бүрээ уриа чинь

Хэлэх бүгд улс чинь,

Хэрлэн Хөдөө арлын

Хаан суусан газар ус чинь тэнд бөлгөө.

Бүтэхийн урьд учирсан

Бөртгэлжин хатан чинь,

Бурхат хаан газар ус нутаг чинь,

Боорчу Мухулай хоёр амраг нөхөр чинь,

Бүрэн их төр ёс чинь, тэнд бөлгөө

Хувилгаанаар учирсан Хулан хатан чинь,

Хуур цоор хөг дуун чинь,

Хотол бүгд их улс чинь,

Хугуст (хутагт) хаан газар ус чинь тэнд бөлгөө.

Харгуна хан*-ыг дулаан гэж,

Хатан Гүрбэлжинийг гуа гэж,

Харьтан Тангуд улсыг олон гэж

Хайрт Хуучин Монгол Улсаа тэвчив үү чи эзэн минь.

Хайрт алтан амь чинь гарваас

Хас эрдэнэ мэт хүүрийг чинь авч харьцгаая.

Хатан Бөртгэлжинд чинь үзүүлье.

Хамаг улст чинь хүргэе хэмээн өчив.

Хаан эзэн энэрэн соёрхов,

Хасаг тэрэг нь хангирсан хөдлөв,

Хамаг улс нь баясгалант болов,

Хаан их газраа тэнд хүргэв.

Хамгийн мөнх их хүр (хүүр) тэнд үүсч,

Хаан их зайсангуудын тулга болж,

Хамаг улсын шүтээн болоод,

Хамгийн мөнх гадаасан найман цагаан гэр болов за.

эзэн богд эндээс эчихүйдээ бахархан зарлиг болсны шалтгаанаар, өдгөө тугаар (саяын – эшлэгч) хасаг тэрэг булын чинээ шигдэв. Эн их улсад худал тунхаг өгч, өмссөн цамц, өргөө гэр, өрөөсөн оймсыг тэнд онголов гэх. Үнэн хүүрийг нь заримууд нь, Бурхны халдунд онголов гэх, заримууд нь Алтай ханы ард Хэнтий ханы өвөрт Их өтөг нэрт газар онголов гэх буюу гэж тэмдэглэж байдаг.

“Эрдэнийн товч” (1962 оны гэрэл зургийн хэвлэл)-д:

“Тэндээс хаан эзний алтан хүүрийг нь хасаг тэргэнд тээж өөд болгон, хамаг их улс нь хүйлэн хайлан явахуйяа, Сөнидийн Гилүгэн баатар ийн магтан өгүүлрүүн:

Харцгай шувуун мэт халин одов уу чи эзэн минь,

Хангирсах тэрэгний моо болон одов уу чи эзэн минь,

Хатад хөвгүүд ээ үнэхээр гэв үү чи эзэн минь,

Харалмай албат улсаа үнэхээр тэвчив үү чи эзэн минь,

Жиргэх начин мэт завхан одов уу чи эзэн минь,

Жигирэх ногоо мэт хийсэн одов уу чи эзэн минь,

Жаран зургаан насан дээрээ есөн өнгө улстаа,

Жаргаланг үзүүлэн өөд болов уу чи эзэн минь? хэмээж магтаж ирэн атал, Монийн Хөхбөр хүрээд хасгийн бул чинээ шигдэж эс хөдлөв. Төдий таван өнгө улсын хүлгүүдэд хүлж хөдөлгөн ядан, хүр их улс нь зовон ахуй (г)-д Сөнидийн Гилүгэн баатар, бас ийн өчрүүн:

Хөх мөнх тэнгэрээс заяагаар төрсөн,

Хүний арслан тэнгэрлэг богд эзэн минь,

Хүр их улс бүгдээ гээж орхиод,

Хүрэн зорчив чи эзэн минь дээд төрөлдөө?

Төвөлдөн учирсан хатад чинь,

Төвшнөө байгуулсан төр чинь,

Төрлөн зохиосон засаг чинь,

Түмэлэн зохиосон улс чинь тэнд бөлгөө.

Амраглан учирсан хатад чинь,

Алтан орд харш чинь,

Ариунаа тогтсон төр чинь,

Албалан хураасан улс чинь тэнд бөлгөө.

Унасан газар, угаасан ус чинь,

Ургамал ахул албат Монгол улс чинь,

Олон яамтан, ноёд сайд чинь,

Ононгийн Дэлүүн Болдог төрсөн нутаг чинь тэнд бөлгөө.

Хээр азаргын хөхлөөр хийсэн сүлд чинь,

Хэнгэрэг, цан, бүрээ, бишгүүр чинь,

Хэлэх бүгдийг хураасан алтан орд харш (гэр) чинь,

Хэрлэнгийн хөдөө арлун суусан орон чинь тэнд бөлгөө.

Бүтэхийн урьд учирсан Бөртэ жисин сэцэн хатан чинь,

Бурхат* хан өлзийт их нутаг чинь,
Боорчу, Мухулай хоёр чухал нөхөр чинь,
Бүрнээ байгуулсан төр ёс чинь тэнд бөлгөө.
Хувилгаанаар учирсан Хулан хатан гэргий чинь,
Хуур цуур тэргүүтэн хөг дуун чинь,
Гуа үзэсгэлэнт Есүй, Есүхэн хоёр хатан чинь,
Хотлыг хураасан алтан орд гэр чинь тэнд бөлгөө.
Хар хуна ханыг дулаан хэмээж,
Харьтан Тангудыг олон хэмээж,
Хатан Гүрбэлжинийг гуа хэмээж,
Хуучин Монгол Улсаа үнэхээр тэвчив үү чи эзэн минь?
Халуун алтан аминаа чинь халх эс болбоос бээр,
Хас эрдэнэ мэт хэсгэн язгуурыг чинь хүргэж,
Хатан Бөртэ жисин гэргийд чинь үзүүлье,
Хамаг их улсыг чинь хангая хэмээн өчсөнд,
Хаан эзэн хайрлан соёрхож,
Хасаг тэрэг хангирсан хөдөлж,
Харалмай их улс баясгалант болж,
Хаан их газар хэмээхүй орноо хүргэжээ.

Тэндээс хатан хөвгүүн нь түрүүлэн хотлоор гасалж, хүйлэн хайлан, алтан биеийг нь гаргаж ядан цөхрөөд, мөнх хүүрийг нь үүдэн, ерөнхийн шүтээн найман цагаан гэрийг тэнд байгуулжээ. Төдий эзний алтан хүүрийг нь Алтай ханы ар, Хэнтий ханы өлхөд (өвөрт - хө.) Их өтөг нэрт газраа онголов хэмээх” гэж тэмдэглэж байдаг билээ.

“Лу. Алтан товч” (Улаанбаатарын хэвлэл)-д:

“Хасаг тэргэнд хүлэг (-ийн) [-хээ] хүлж, хаан эзний алтан хүүрийг хасаг тэргэнд өргөн тээж, харьж өөд болон ирэхүйд, Сөнидийн Гилүгэдэй баатар магтруун:

Халих харцгайн жигүүр болон одов уу чи эзэн минь,

Хангинах тэрэгний тээш болов уу чи эзэн минь,

Туулих хайрцгайн жигүүр болон одов уу чи эзэн минь,

Тойрох тэрэгний тээш болов уу эзэн минь,

Жиргэх шувууны жигүүр болов уу чи эзэн минь,

Жирхирах тэрэгний тээш болов уу чи эзэн минь?

гэж магтаж иртэл, Монийн хөхөөр (бусад сурвалж бичигт хөхбөр буюу хөхбөри гэснийг анхаарах болов уу - эшлэгч)-т хүрээд, хасаг нь бул чинээ шигдэж, хөдөлгөн ядахад, таван өнгийн хүлгүүдийг хүлж гарган ядаж, хүр улс зовоход Сөнидийн Гилүгэдэй баатар мөргөн өчив:

Хөх мөнх тэнгэрээс заяагаар төрсөн,

Хүлэг богд эзэн минь,

Хүр их улсаа орхиж хүрэв чи дээд төрөлдөө?

Төвшнөө байгуулсан төр чинь,

Төрлөн байгуулсан улс чинь,

Төгс хүрүгэлэгсэн* хатад хөвгүүд чинь

Төрсөн хан газар ус чинь тэнд бөлгөө.

Ариунаа байгуулсан төр чинь,

Албалан байгуулсан улс чинь,

Амраг хатад хөвгүүд чинь,

Алтан орд харш чинь тэнд бөлгөө.

Урнаа* (уран нарийнаар - хө.) байгуулсан төр чинь,

Учралдсан хатад хөвгүүд чинь,

Урьд зөөсөн олон улс чинь,

Ураг элгэн чинь тэнд бөлгөө.

Ургамал улс иргэн чинь,

Угаасан ус цас чинь,

Олон Монгол улс чинь,

Ононы Дэлүүн Болдог төрсөн газар чинь тэнд бөлгөө.

Хээр азарганы хөхлөөр хийсэн туг сүлд чинь,

Хэнгэрэг бүрээ уриа чинь,

Хэлэх бүгд улс чинь,

Хэрлэнгийн хөдөө арал хаан суусан газар чинь тэнд бөлгөө.

Бүтэхийн урьд учирсан Бөртгэлжин хатан чинь,

Буянт (Бурхант) хан газар нутаг ус чинь,

Боорчу, Мухулай хоёр амраг нөхөр чинь,

Бүрэн их ёс чинь тэнд бөлгөө,

Хувилгаанаар учирсан Хулан хатан чинь,

Хуур цоор хөг дуун чинь,

Хотол бүгд улс чинь,

Хутагт хан газар ус чинь тэнд бөлгөө.

Харигуна ханыг дулаан гэж,

Хатан Гүрбэлжинийг гуа гэж,

Харьтан Тангуд улсыг олон гэж,

Хуучин Монголоо ийн тэвчив үү чи эзэн минь?

Хайрт амь чинь гарваас,

Хас эрдэнэ мэт хүүрийг чинь авч харья,

Хатан Бөртгэлжинд чинь үзүүлье,

Хамаг улст чинь хүргэе!

хэмээн өчвөөс:

Хаан эзэн энэрэн соёрхов

Хасаг тэрэг хангирсан хөдлөв,

Хамаг улс баясгалант болов,

Хаан их газар тэнд хүргэв.

Хамгийн мөнх хүр (хүүр) тэндээс үүсч,

Хаан зайсангуудын тулга* болж,

Хамаг улсын шүтээн болгоод,

Хамгийн мөнх хадсан найман цагаан гэр болов за.

Эзэн эндээс эчихүйд бахархан зарлиг болсны шалтгаанаар, өдгөө тугаар хасаг тэрэг бул чинээ шигдэв. Эн их улсад худал тунхаг өгч, өмссөн цамц, өргөө гэр, өрөөсөн оймсыг тэнд онголов. Үнэн хүүрийг нь заримууд Бурхан Галдунд онголов гэх, заримууд Алтай ханы ард, Хэнтий ханы өвөрт Их өтөг нэрт газар онголов гэх буюу гэж тэмдэглэж байна.

“Шар тууж” (1957 оны Москва, Ленинградын хэвлэл)-д:

“Алтан хүүрийг нь хасаг тэргэнд өөд болгож, харьж [явахуй]-д Гилүгэдэй баатар магтруун:

Халих харцага (харцгай)-ны жигүүр болон одов уу эзэн минь,

Хангинах тэрэгний дээр (тээш) болов уу эзэн минь,

Туулих харцаганы жигүүр [болон] одов уу эзэн минь,

Тойрох тэрэгний дээр болов уу эзэн минь,

Жиргэх шувууны жигүүр болон одов уу эзэн минь,

Жирхрэх (чархрах) тэрэгний дээр болов уу эзэн минь

гэж магтан иртэл, Монайн хөхбөрт хүрээд хасаг тэрэгний бул шигдэв. Дөчин таван хүлгээр хөдөлгөн ядаж, хүр их улс зовохуйд Сөнидийн Гилүгэдэй баатар мөргөн сөгдөөд өчив:

Хөх мөнх тэнгэрийн заяагаар төрсөн хүлэг богд эзэн минь,

Хүр их улсаа орхиж хүрэв чи дээд төрөлдөө?

Төвшнөө байгуулсан төр чинь,

Төрүүлсэн хатад хөвгүүд чинь,

Төрсөн хаан газар ус чинь тэнд бөлгөө.

Ариунаа байгуулсан төр чинь,

Албалан байгуулсан улс чинь,

Амраг хатад хөвгүүд чинь,

Алтан орд харш чинь тэнд бөлгөө.

Урнаа* байгуулсан төр чинь,

Учралдсан хатад хөвгүүд чинь,

Урьд зөөсөн улс чинь,

Ураг элгэн чинь тэнд бөлгөө.

Ургамал улс иргэн чинь,

Угаасан ус цас чинь,

Олон Монгол улс чинь,

Ононы Дэлүүн Болдог төрсөн газар чинь тэнд бөлгөө.

Хээр азарганы гөхлөөр хийсэн туг бүрээ уриа чинь,

Хэрлэнгийн хөдөө арал хаан суусан газар чинь,

Хэлэх бүгд улс чинь тэнд бөлгөө.

Бүтэхийн урьд учирсан Бөртгэлжин хатан чинь,

Бургад хан газар ус чинь,

Боорчу Мухулай 2 (хоёр) амраг нөхөр чинь,

Бүрэн их төр ёс чинь, тэнд бөлгөө.

Хувилгаанаар учирсан Хулан хатан чинь,

Хуур цоор хөг дуун чинь,

Хотол бүгд улс чинь,

Хутагт газар ус чинь тэнд бөлгөө.

Харгуна хааныг дулаан гэж,

Харьтан Тангуд улсыг олон гэж,

Хатан Гүрбэлжинийг гуа гэж,

Хуучин Монгол Улсаа тэвчив үү чи эзэн минь.

Хайрт алтан амь чинь гарваас,

Хас эрдэнэ мэт хүүрийг чинь авч харина нь.

Хатан Бөртгэлжинд чинь үзүүлье нь.

Хамаг улст чинь үзүүлье нь!

хэмээн өчвөөс:

Хаан эзэн энэрэн соёрхов. Хасаг тэрэг нь хангирсан хөдлөв. Хамаг улс нь баясгалант болов. Хаан их газар тэнд хүргэв. Хамгийн мөнх их хүр (хүүр) тэнд гэж, хаан зайсангууд тулга болж, хамгийн шүтээн болгон, хамгийн мөнх хадага сун (хадаасан) найман цагаан гэр болов. Эзэн богд эндээс эчихүйд Мона хааны Бахар хан (өөр сурвалжид Бахархан гэжээ – эшлэгч) зарлиг болсны шалтгаанаар, өдгөө тугаар хасаг тэрэгний бул шигдэв гэх. Нэн олон улсад худал тунхаг үг өгч өмссөн цамц, өрөөсөн оймсыг тэнд онголов гэх. Үнэн дээд хүүрийг нь заримууд Бурхан Галдунд онголов гэх, заримууд нь Алтай ханы ард, Хэнтий ханы өвөрт Их өтөг нэрт газар онголов гэх” гэж тэмдэглэж буй.

Энэ хэдэн зүйлийн тэмдэглэлийг үндсэндээ гарал нэгтэй гэж үзэж болох мэт. Одоогийн оршиж бүхий бага сага зөрөө бол хуулан уламжлах явцад буй болсон бололтой. Дээрх тэмдэглэлүүдийг эшлэхдээ зөвхөн мэдэгдэхүйц ташаа үсгийг нь залруулж, агуулгыг нь огт зассангүй. Тайлбарлсан зүйлээ хаалт ()-аар хааж, орлуулбал, эсхүл байвал зүйтэй гэсэн зүйлээ дөрвөлжин хашилт [] дотор бичив.

15 “Саарь хээрийн харилт” гэдэг бол “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир” дахи “Са-ли-чуань ха-ло-ту” мөн. Энэ бол Чингис хааны их ордон - Бөртэ үжин хатны ордон байсан газар, тэрчлэн Чингис хааны шарилыг анх хүргэж, гашуудал хийсэн газар мөн гэж Ту Цзи магадлажээ. Энэ газрын бодтой байр нь Туул голын эхний зүүн эрэг, Хэрлэнгийн хөдөө арлаас баруунш зургаан өдрийн газар – хуучин Халхын Түшээт хан аймгийн Дундад хошууны Галуутай нурууны доорхи Галуутай нуурын хөвөөнд байсан бололтой гэж Ту Цзи тэмдэглэжээ. Чухамдаа хөдөө арлаас умарш зургаан өдрийн газар гэвэл зүйтэй мэт. Үүнийг хөндлөнгөөс гэрчлэх нэгэн баримт бол “Юань улсын түүх, Минцзун хутагт хаан Хүсэлэ-гийн шастир” болно. Хүсэлэ бол Хүлэг хаан Хайсангийн ахмад хөвгүүн нь юм. Тэр, 1325 оны цагаан сар Хар хорум (буюу Хар хорин – одоогийн Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Улаанбаатараас баруунш Орхон голын дээд урсгалын зүүн хөвөөнд буй) хотын хойно, Юань улсын долдугаар хаан орыг залгамжилж, дээд нийслэл өөд явахдаа “Саарь хээр”-ээр дайрсныг энэ бичигт тэмдэглэжээ:

Тянь Ли-гийн хоёрдугаар он (1325 он)-ы цагаан сар ... хаан Хэнинь (Юань улсын үед Хар хорумыг бас Хэнинь гэж нэрлэж байв)-ээс хойно их ор суув. ...Гуравдугаар сард Гайган Цагаан гэдэг газар хүрэв. ...Тавдугаар сарын шинийн дөрвөн (Цагаан бичин өдөр, шинийн нэгэн бол улаагчин могой)-д Орхон голын зүүн биед хүрэв ... шарагчин туулай (хорин гурван өдөр)-д Туул голын зүүн биед хүрэв ... зургадугаар сар (шинийн нэгэн улаагчин гахай)-ын цагаан барс (арван тавны өдөр)-т саарь гэсэн газар хүрэв ... шарагчин гахай (хорин нэгний өдөр)-д “Хөдөө” гэсэн газар хүрэв гэж явсан замыг нь тэмдэглэж буй. Энэ “саарь” гэдэг нь “Саарь хээр”-ийг хэлж байх бөгөөд “хөдөө” гэдэг нь Хэрлэнгийн “Хөдөө арал”-ыг хэлж байна. “Хөдөө арал”-ыг Улаанбаатар хотоос зүүн өмнө байдаг “Баян улаан” уул мөн бололтой гэж Дамдинсүрэн авгай тэмдэглэжээ. Хүсэлэ хаан Хар хорумаас умар дахи нэгэн газраас өмнөш явж, урьдаар Саарь хээрт ирж, дараа нь хөдөө аралд хүрсэн шиг юм. Тиймээс, энэ “Саарь хээр” нь Хэрлэнгийн “Хөдөө арал”-аас умарш байсан гэдгийг мэдэж болно. Өөрөөр хэлбэл Чингис хааны шарилыг анх хүргэсэн, түүний их ордон байсан Саарь хээр бол Улаанбаатар хотоос зүүн хойдохи Онон, Хэрлэнгийн эх хавиар байсан нь дамжиггүй мэт. Ту Цзи авгай “Саарь хээр”-ийг Хэрлэнгийн Хөдөө арлаас “баруунш зургаан өдрийн газар” гэсэн нь Хар хорумаас зүүнш явж байснаар жишсэн бололтой. Гэтэл Хүсэлэ хаан бол Хар хорумаас хойно хаан ор суусныг Ту Цзи авгай нарийн анхаарсангүй байна.

16 “Чингис хааны шарилыг оршуулсан газар”-ыг Монголын түүхэн сурвалж бичгүүдэд бүр Хэнтий ханы өвөр (буюу өлхи)-т Их өтөг (буюу Өтөг) гэдэг газар оршуулав гэж тэмдэглэж байдаг билээ. “Юань улсын түүх”-д “Ци Нянь Гу” гэж тэмдэглэжээ. “Хар Татарын тухай хэргийн товч” гэдэг номд, Сүн улсын элч Сюй Тин дагалдаас бичихдээ:

Тэмүжиний онгон Хэрлэн голын хөвөөнд нэгэн уул усаар хүрээлүүлсэн газар байхыг Сюй Тин миний бие олж үзэв гэж тэмдэглэжээ. “Монгол Ард Улсын түүх”-д: Чингисийн шарилыг түүний гэрээслэсэн ёсоор төрсөн эх газар Хэнтий нурууны Их өтөг гэдэг газар авчирч оршуулжээ гэж тэмдэглэж буй.

17 “Цао Му Цзи” гэдэг бичигт: Юань улсын хаадыг оршуулах ёс бол бүхэл модыг хоёр хэсэг болгож, дунд нь биеийн хэмжээгээр нүхэлж нийлүүлээд авс болгодог. Түүний дотор шарилыг нь хийж, гадуур нь будаг шир тавьж, дахин шижир алтан цагирагаар гурав цагираглаж, умарш онгоны газарт хүргэж, гүн булж оршуулдаг. Улсын ёсонд бунхан байгуулдаггүй. Оршуулж дуусаад түмэн адуугаар гишгүүлж тэгш болгох бөгөөд түүний дээр нэгэн ботго алж тахилга хийгээд мянган морьтноор сахиулдаг байна. Ингээд дараа хавар нь өвс ногоо ургасан хойно нүүж явдаг тул үзэхүйд тэв тэгш, хүмүүс олж мэддэггүй. Дахин тахилга хийхэд, алсан ботгын ингээр замнуулж, ингийн буйлсан газрыг оршуулсан газар гэж мэддэг юм гэж тэмдэглэж байдаг. Үүнээс гадна, “Д’Оссоны Монголын түүх”-д: Олон жанжин нар нь шарилыг хүргэн Монголдоо буцахад, хааны үхсэн чимээг задруулахгүйн тулд зам зуур учирсан хүмүүсийг шарил хамгаалж яваа цэргүүд бүр алжээ. Хэрлэн мөрний эхэн дэх Чингис хааны их ордонд хүрээд сая гашуудлын тунхаг тархаасан бөгөөд шарилыг эл гол хатдын ордонд дэс дараалан хүргэж гашуудав. Олон ван нар, гүнж нар ба жанжин нар Тулуйн тунхагласан гашуудлын мэдээг олж, хаант улсын өргөн уудам нутгийн эл газраас гашуудахаар цугларав. Хол замын хүмүүс нь гурван сар яваад сая хүрч иржээ. Гашуудлын ёслолыг гүйцээсний дараа, шарилыг нь Онон, Хэрлэн, Туул гурван голын эхэн дэх Бурхан Халдуны олон уулын нэгэнд нь оршуулжээ. Урьд Чингис хаан энэ газар ирж, нэгэн ганц модны сүүдэрт амасхийн суухдаа

Хожим намайг энэ газар оршуултугай гэж хэлсэн гэлээ. Тиймээс хөвгүүд нь түүний гэрээсийг үндэслэж энэ газар оршуулсан байна. Оршуулсан хойно нь ойр орчмынхи нь мод ой шугуй болж, аль модны доор оршуулсан нь танигдахгүй болжээ. Түүний хойчоос хэдэн хүнийг мөн энэ ойд оршуулсан гэдэг билээ. Шарилыг оршуулсны дараа, урианхад аймгийн мянган хүнээр сахиулж, тэднийг цэргийн албанд татдаггүй байна. Бас эл хааны хөргийг зурж тэр газар нь тахиж хүж зул тасардаггүй гэлээ. Энэ газар өөр хүнийг оруулдаггүй, Чингис хааны дөрвөн ордны хүмүүс ч мөн ийм билээ. Энэ ёсыг Чингис хааныг үхсэнээс хойшхи зуун жилд бас уламжилсаар байжээ (“Д’Оссоны Монголын түүх”, нэгдүгээр боть, есдүгээр бүлэг) гэж тэмдэглэжээ.

18 Чингис хаантай энэ дөрвөн хүнийг хамт оршуулсан гэдэг мэдээ бол “Ту Цзи-гийн тэмдэглэл”-ийн мэдээ болно. “Цао Му Цзи” гэдэг бичигт бол “Юань улсын эл хаадыг бүр Ци Нян Гу-д оршуулав” гэжээ.

“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-д Аливаа их хаан хийгээд түүний анхдугаар эзэн Чингисийн хамаат төрөл аймгийн тэргүүлэгчийн хүүрийг ямар газарт үхсэн боловч цөм Алтай хэмээх нэгэн ууланд аваачиж оршуулмуй. Даруй зуун өдрийн холын замын газраас ч болов, бас ч тэр газар хүргэн аваачмуй. Энэ нь халж үл болох зан суртал болжээ (1977 оны монгол хэвлэл, 210 нүүр) гэж тэмдэглэж байдаг.

Чжан Пэн Хэ-гийн зохиосон “Орост элчилсэн аяны тэмдэглэл”-д: Гуй Хуа хот (одоогийн Хөх хот – эшлэгч)-оос хойно есөн газарт Ци Лянь Шань (Далан хар уул – эшлэгч) гэдэг уул буй. Юань улсын хаад хатдыг бүр энэ ууланд оршуулсан бөгөөд бунхан босгодоггүй гэсэн яриа буй гэж тэмдэглэжээ. Гэтэл Хун Цзюнь авгай энэ тухай:

Гуй Хуа хотын ард Тайцзу (Чингис хаан – эшлэгч)-г лав оршуулсангүй, харин бусад үр хөвгүүдийг нь өөр газар оршууллаа гэсэн нь энд байх магадгүй гэж тэмдэглэжээ.

Бас Юань улсын олон хатад ба тайцзи нарын онгон нь бүр Үхэр чулуун амаас умаршихи Чжань Мао Шань (Цзянь Мао Шань) гэдэг ууланд буй. ... Юань улсын хаадын онгон нь умардад буй, оршуулсан хойно түмэн адуугаар гишгүүлж тэгшилдэг бөгөөд тэмдэг үлдээдэггүй. Хатад татвар зэргийн онгон нь ч ийм байлгүй. Одоогийн үхэр чулуун амын умар үлдсэн онгоны ор мөр ер мэдэгдэхгүй тул магадлах аргагүй гэж “Цахарын бүрэн тэмдэглэл”-д мэдээлж байдаг.

19 “Залуусын хурим” гэдэг ном бол арван есдүгээр зууны үеийн Монгол үндэстний их бичгийн хүн Инжаннаши түүний том роман “Их Юань Улсын мандсан төрийн хөх судар”-аа зохиоход ашиглалаа гэсэн арван зүйлийн номынхи нь нэг нь болох “Далай ламын залуусын хурим” мөн бололтой. Инжаннашийн дурдсан энэ ном өдий болтол манд ер олдоогүй билээ. Одоо Бээжин ном санд “Далай ламын номлосон залуусын хурим хэмээх хаад ноёдын уг түүх энэ болой” гэсэн гарчигтай нэгэн гэрэл зурагласан эх бичиг хадгалагдаж буй. Түүний уул судар нь Монгол улсын Улаанбаатар дахи улсын номын санд хадгалагдаж байна гэлээ. Энэ нь харин Инжаннашийн дурдсан “Далай ламын залуусын хурим” гэдэг ном мөн болох ч магадгүй.

Чингэвэл энд бас нэгэн сонирхолтой явдал тохиолджээ. Тэр нь, 1957 онд Зөвлөлт Холбоот

Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Дорно дахины судлах газраас “Арван долдугаар зууны Монголын он дараалсан түүх – Шар тууж” (“Шара туджи” - Монгольская летопись XVII века)гэсэн нэрээр хэвлүүлсэн “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж оршив” гэдэг ном нь энэхүү “Далай ламын номлосон залуусын хурим хэмээх хаад ноёдын уг түүх энэ болой” гэдэг судартай бараг үсэг зөрөлгүй адил байна. Энд зөвхөн номын нэрийн асуудал оршиж байна. Энэ “Залуусын хурим” гэдэг нэр нь эсхүл далай ламыг биширч сурталчилахын үүднээс зориуд нэрлэсэн байж мэднэ. Эсхүл нэргүй нэгэн зохиолыг сүүлчийн хүмүүс уул номын эхний нэгэн бадаг үгээр нэрлэсэн байж мэднэ. Учир нь энэ хоёр ном эхэлмэгцээ:


Далай ламын номлосон залуусын хурим хэмээх түүхэнд ер хүн өөрийн уг язгуураа эс мэдвээс ойд төрсөн сармагчин лугаа адил. ... гэж бичиж байдаг.

Энэ бадаг үг бол үнэнхүү тавдугаар төрлийн далай лам Агваанлуvsсанжамц (1617-1682)-ын усан хонин жил (харагчин хонин жил – 1643 он)-д төвд хэлээр зохиосон Төвдийн буддын шашны түүх “Залуусын хурим” гэдгээс эшлэсэн гэж Н.П.Шастина (“Шар тууж”-ийн орчуулагч ба тайлбарлагч) мэдээлжээ. Энэхүү тавдугаар далай ламын зохиосон “Залуусын хурим” гэдэг төвд түүх-д нь Монголын хаадын үүслийг Энэтхэг – Төвдийн хаадтай холбож, Бөртэ чоноос Гүүш хаан хүртэл дөхөм тэмдэглэв гэдэг билээ. Гэтэл Үнэндээ Монголын түүхнээ холбогдох зүйл, энэ зохиолд асар их үгүй буй (Хөдөөгийн Пэрлээ: “Асрагч нэртийн түүх”-ийн тайлбар) гэжээ.

Энд бас нэгэн анхаарууштай зүйл гэвэл, энэхүү “Залуусын хурим” ба “Шар тууж” нь агуулгын талаар Саган сэцний зохиосон “Хаадын үндсэн эрдэнийн товч”-той бүрмөсөн адил гэж үзэж болно. Гагцхүү түрүүчийнх нь товч, сүүлчийнх нь дэлгэрэнгүй шиг бичжээ. Иймээс бид, энэ бол Саган сэцэний ашигласан долоон тулгар бичгийнх нь нэг нь болох “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж” (энэ бол Саган сэцэн зохиолоо хойно өөрөө тэмдэглэсэн данс болно) мөн гэдгийг баттай мэдэж болох бөгөөд “Шар тууж”-ийг бол тавдугаар далай лам зохиосон биш гэж хэлж болно. Учир нь Саган сэцэн (1604 онд төрсөн) 1663 онд өөрийн зохиолоо бичиж дуусгасан тул эхэлсэн нь яриангүй үүнээс нэлээд өмнө болно. Тиймээс тавдугаар далай ламын 1643 онд зохиосон “Залуусын хурим” нь монгол оронд нэвтэрч, монгол хэлнээ орчуулагдаж, Саган сэцэн ашиглалаа гэх нь тэр үеийн зам харилцаа ба соёлын нөхцөлөөс баахан хэтэрч байх мэт.

Энэ бүхнийг ерөнхийлөн үзэхүл, Инжаннашийн ашигласан “Далай ламын залуусын хурим” гэдэг ном харин энэ Саган сэцэний тэмдэглэсэн “Эртний Монголын хаадын үндэсний их шар тууж” байж мэднэ.

Аравдугаар бүлэг



Тэнгэрлэг богд Чингис хаан

Чингис хааны их үйл ажиллагааг дээр үндсэндээ танилцуулж дуусчээ. Зөвхөн түүхэн тэмдэглэлийн хувиас авч үздэг бол дахиад яримаар зүйлгүй мэт. Чингис хаан мэтийн ийм нэгэн гайхамшигт түүхэн хүний хувиас авч үзэхүл, бичиж тэмдэглэвээс зохих зүйл, бичиж тэмдэглэсэнээс хол илүү байхыг хэн бүр мэдэж байх юм. Тухайлбал түүний үзэл санаа, зан чанар, арга бодлого зэрэг оюун санааны талаархи зүйлсийг тэмдэглэх ёстой. Энэ бол мөн ч сүүлчийн хүмүүсээс Чингис хааныг үнэлж шүүмжлэхийн гол агуулга болсоор иржээ.

Харамсалтай нь, тухайн үед эл талын түүхэн нөхцөлийн хязгаарлалаас болж, Чингис хааны үзэл санаа, зан чанар, арга бодлогын талаар шууд тусгасан тэмдэглэл ховор байсан буюу манай үе хүртэл хадгалагдаж ирсэн нь нэн ховор болжээ. Тиймээс энэ талын агуулгыг бичихэд нэлээд хүчиртэй байдаг бөгөөд хүн хүний үзэх нь ч хараахан адилгүй байдаг учраас янз бүрийн үнэлэлт буй болжээ 1.

Энэ асуудал хэдийгээр хүчиртэй шиг боловч, ер сэтгэшгүй хэрэг бас биш, харин билигтнүүд оюунаа бадруулж, бичигтнүүд эрдмээ шалгаруулах уудам ертөнц тэнд буй. Учир нь Чингис хааны үйл ажиллагаа нэг бүрд нь түүний үзэл санаа, зан чанар, арга бодлого нь нэвтэрч байдаг сан. Ингээд үзвэл хаанаас нь аваад бичивч бүр болох мэт. Гэвч түүхийг түүхийн үнэнээр нь тусгагчид, өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөний түүхэнд шинжлэх ухаанчаар ханддаг хүмүүс, ялангуяа түүхийн бодосч үзэлтэд бол энэ асуудалд ер хариуцлагагүй өөрөөр ханддаггүй юм. Тэр түүхийг хувийн дур сонирхол ба ямар нэгэн улс угсаатны онцгой ашиг сонирхолтой холбогдуулж үздэггүй бөгөөд өвөг дээдэстээ хандахыг өөрийн бие ба үр ач нартаа хандахтай адилаар үздэг байна. Би ч ийм оврыг авахаар чармайн ажиллажээ.

Гэвч мэдлэг мөхөс, чадвар дорой учраас таниж мэдээгүй зүйл олон байхаар барахгүй, санаж бодсон зүйлээ ч төгөлдөр илтгэж эс чадах нь мөн ч мэдээжийн хэрэг билээ. Хувь нэмэр болохгүй боловч, хохирол самуурал бүү болоосой гэж зориод өөрийн танилтаа бичлээ.

Чингис хааныг “цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт” цэрэг дайны зүтгэлтэн гэх буюу “цэрэг дайны бодлогоч”, “гарамгай удирдагч” гэж олонхи түүх шастирт үнэлдэг байна. Энэ нь хэлэлгээнгүй буруугүй. Гэвч Чингис хааныг ганцхан цэрэг дайны талаар үнэлэх нь хол дутуу юм.

Чингис хаан бол юуны урьд эртний монгол үндэстний нэгэн агуу их төрийн зүтгэлтэн болох ёстой гэж би үзэж байна. “Дайн - хувийн хөрөнгөөр болсон ба анги буй болсон үеэс эхэлж, анги ба ангийн хоорондохи, үндэстэн ба үндэстний хоорондохи, улс орон ба улс орны хоорондхи, улс төрийн бүлгэм ба улс төрийн бүлгэмийн хоорондхи хөгжлийн зохих шат үедэх зөрчлөө шийдвэрлэх тэмцлийнх нь дээд хэлбэр” гэж нөхөр Мао Цзэ Дун тэмдэглэв. Дайн бол улс төрийн үргэлжлэл, улс төр бол цус үл урсгах дайн, дайн бол цус урсгах улс төр мөн. Энэ бол эрт ба өдгөөхийн аливаа дайны нийтлэг жам ёс болно. Арван хоёр, гуравдугаар зууны үед Чингис хааны явуулж байсан дайн ч ийм байсан бөгөөд байх ч ёстой. Чингис хааныг эртний монгол үндэстний нэгэн агуу их төрийн зүтгэлтэн гэсэн нь түүний их үйл хэрэг ба өвөрмөц онцлогоос нь хэлсэн юм.

Юуны урьд, цагийн байдлыг зөв таньж, түүхийн хөгжлийн урсгалыг дагаж чадсан нь Чингис хааны давшсан төрийн зүтгэлтэн болсныхи нь үндсэн нөхцөл болно. Арван хоёрдугаар зууны сүүлчийн үе буюу арван гуравдугаар зууны эхэн үе - Чингис хааны төрж өссөн үе бол:

“Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлон булаалдаж байв.

Хөрст дэлхий хөрвөж

Хөвчин улс хямралдаж

Хөнжилдөө унтах завгүй

Хөнөөлдөн тэмцэж байв.

Хаан богд эцэг чинь

Хамаг улсыг байлдахдаа

Хар толгойгоо хайрлахгүй

Халуун цусаа гамнахгүй

Хамхих нүдээ ирмэхгүй

Гарын ханцуйг дэрлэж

Гадаад хормойгоо дэвсэж

Шүлсний хөөсөөр ундалж

Шүдний махаар хооллож

..... “ (“Нууц товчоон”-ы 254 дүгээр зүйл)

байсан цаг үе болно. Энэ үед дотооддоо Монголын эл аймгийн хуучин язгууртад илжрэн доройтож, ард иргэдийг гаслангийн туйлд тулгаснаар барахгүй, аймаг бүлгийн хоорондоо дээрэмдэн талхидах дайн дажныг дэгдээж, занал хорслыг хурцатгаж байв. Гадаадад Алтан улсын ноёрхогчид “Харийг хариар захирах” тэрслүү төрийн бодлогыг хэрэгжүүлж, Монголын дотоодын зөрчил хямралыг ашиглан, Монголыг Монголоор нь алан хядуулж байснаар барахгүй, өөрөө ч олон тооны цэрэг зэвсгийг хөдөлгөж шууд алан хядаж байв.

Энэхүү эрин үеийн эргэлтийн үед, Монголын ард түмэн энх тайвнаар аж төрөхийг эрмэлзэж, бүх монгол аймаг нэгдэн нягтарч үндэстний хамтын цогцыг бүрэлдүүлэн, боловсон цаг үед шилжин орохыг шаардаж байв. Энэхүү их үйлийг биелүүлэхэд түмнийг манлайлах төрийн зүтгэлтэн хэрэгтэй байсан.

Тухайн үед шинэ мандсан феодал язгууртны гарамгай төлөөлөгч болсон Тэмүжин энэхүү эрин үеийн байдлыг зөв таньж, түүхийн хөгжлийн урсгалд тохиролцсон учраас монгол үндэстний анхдагч агуу их төрийн зүтгэлтэн болж чаджээ.

Хоёрдугаарт, түм буман хүмүүсийг дайчилж, түгээмэл хүчээ зохион бузгайруулж, дайснаа дарж, дархан гавьяагаа бүтээж чадсан явдал бол Чингис хааны агуу их төрийн зүтгэлтэн болсныхи нь товойсон илрэл болно. Чингис хаан ах дүү хэдүүлээ найман шарга морьтой өнчин өрөөсөн хүүхэд байснаасаа хэдэн арван түмэн их цэрэгтэй Хаант Монгол Улсын анхдагч их хаан болсон түүх бол нийт олноо түшиглэж, цэрэг зэвсэггүй байснаасаа цэрэг зэвсэгтэй болж, бага буурай байснаасаа хүчирхэг их болж, алхам алхмаар хамаг дайснаа дарж, хаант их улсаа байгуулсан түүх юм. Чингис хааны үйл ажиллагаа бол монгол үндэстний түүхэнд, цаашилбал дэлхийн түүхэнд ч нэгэн том их үйлсээр тэмдэглэгдэх ёстой бөгөөд тэмдэглэгдсээр байна. Ийм нэгэн агуу их үйлсийг бүтээхэд, ялангуяа дундад зууны нөхцөл дор хэдэн арван түмэн цэрэг морийг нэгэн жолоогоор захирч, зохион байгуулалттай, сахилга баттай, ялалттайгаар байлдахад ард олны сэтгэлийг олохгүй бол бүтээн чадахгүй, дайчид нийтийн сэтгэлийг нэгтгэж чадахгүй бол ялж чадахгүй юм. Хэрвээ Чингис хаан “гагцхүү бүргэд намнах”-ыг л мэддэг дан цэргийн үзэлтэн болсон бол тэр ямар ч үйлсийг бүтээж чадахгүй, тийм олон хүмүүс түүнийг дагаж нэгэн сэтгэл нийтийн хүчээ лав гаргаж чадахгүй буюу цаашилбал амь насаа үрэгдүүлэхгүй юм. “Олны мэдээжээр хэрвээ Монголын хээр нутгийн язгууртан нар Чингисийг өргөн дэмжлээ гэх юм бол, Монголын нийгмийн доод давхарга ангийн маш олон хүмүүс нь Чингисийг мөрдөн дагаж, шударгаар зүтгэсэн юм гэдгийг ч зааж гаргах хэрэгтэй” (“Монголчуудын нийгмийн байгууллын түүх”, 164 дүгээр нүүр) гэж Владимирцов тэмдэглэж байв. Энэ тухай хүний дур бахыг булаасан үзэгдэм харагдам үлгэр домог олон арвин байдгийг хүмүүс бүр мэдэж байх юм. Жишээлбэл, Чингис хааны залуу үедээ тулгарсан хэдэн удаагийн амин аюулаас Сорхан шар, Боорчу, Зэлмэ нарын их тусламжаар хэлтэрсэн юм. “Арван гурван хүрээний байлдаан”-д Жамуха их цэргээр

Чингис хааныг гэнэт дайрах мэдээг Ихирэс аймгийн Мүдхэ тутаг, Борулдай хоёр, “Муу Өндрийн байлдаан”-д Хэрэйдийн Ван хан хурц цэргээр Чингис хааныг гэнэт дайрах мэдээг Их Чэрэнгийн адууч Бадай, Хишилиг хоёр тус тус Чингис хаанд урьдчилан мэдэгдсэнээс Чингис хаан түгшүүртэй байдлыг ялалтын зам өөд жолоодож чадсан байна. Бас Найманы Таян хан Онгуд аймагтай хамтран урьдаар гар хөдлөн Чингис хааныг устгахаар оролдож байсныг Онгудын түрүү Алахуши Дигит Хури Найман лугаа холбоолсонгүй мөртөө энэхүү мэдээг Найманы элчийн хамт Чингис хаанд хүргэж, Чингис хаан Найман аймгийг гэнэт дайрч, байлдан нэгтгэхэд нь чухал үйлдлийг үзүүлсэн байна. Эдгээр явдал нь хүмүүсийн сэтгэл Чингис хааны тийш хандсан хэргийг харуулж байна. Тэр яагаад хүмүүсийн сэтгэлийг олж чадсан буй гэвэл, “түүний нийтлэн захирах нь туйлын төв голч бөгөөд эелдэг найрамдуу, ард иргэд нь түүнийг хүндлэн хайрлах нь эзэн бусаар шууд эцэг мэт санах” (“Марко Пологийн аяллын тэмдэглэл”)-д оршино.

Чингис хааны их үйл явдал нь хэрэг дээрээ тухайн үеийн монгол үндэстний гарамгай зүтгэлтэн ба өрлөг жанжин нарынхи нь хамтын гавьяа болох юм. Тэдгээрийн шалгарсан төлөөлөгчид бол Чингисийн дөрвөн хүлэг, есөн өрлөг, дөрвөн хошууч, хоёр манлай (Уругудын Жүрчидэй, Мангудын Хуйлдар сэцэн) жич наян аймгийн гавьяатан болон Чингисийн “бодлогоч бүлгэм” зэрэг нь болох бөгөөд Чингис хаан бол тэдний дээд удирдагч нь болно. Чингис хаан өөрөө ч бүх гавьяаг ганц өөрийн биедээ авсангүй. Тэр хэдийгээр:

“Эзэн эс боллоо би.

Эрхэт тэнгэр

Эцгийн хайраар

Эзэн боллоо би.

Эцэг тэнгэрийн ачаар

Эсрэг дайснаа дарлаа би”

гэж юуны урьд “тэнгэр”-ийн гавьяагаар үзэж байсан боловч, гавьяатан зүтгэлтэн нарын үйлдлийг ер үгүйсгэсэнгүй. “Төрөхийн хамт төрөлцсөн, өсөхийн хамт өсөлцсөн өлзийт буянт чиний, өршөөл тус хүргэсэн нь өдий төдий болжээ... тэр тусыг чинь сэтгэж ургийн урагт хүртэл үүрд мартаггүй” гэж хэлдэг билээ. Ялангуяа Боорчу, Мухулай хоёрыг “Зөв явдлыг минь зөвшөөн тэтгэж, буруу явдлыг минь буцаан зогсоож энэ сууринд хүргэв” (“Нууц товчоон”-ы 205 дугаар зүйл) гэж сайшааж байсан бөгөөд “улс төрийг байгуулалцсан урьдын гавьяат нөхдөө” мартаггүй тус тусад нь сайшаан шагнав.

Гуравдугаарт, зөв шугам, зөв бодлого, зөв байлдах бодлого байлдах аргыг тогтоож чадсан явдал бол Чингис хааны уян хатан төрийн зүтгэлтэн болсныхи нь бас нэгэн илрэл болно. Чингис хааны их үйл явдал бол өөрийн шинэхэн бойжуулсан нялх нимгэн хүчээрээ дотоод гадаадын мужууд хүчирхэг олон дайсныг ялж, олон мянган жилийн турш саланги бутархай амьдарсан монгол нутаг дахи аймаг угсааг нэгэн жолоогоор хурааж, монгол үндэстний нэгдмэл цогцыг бүрэлдүүлсэн явдал болно. Ийм нэгэн түүхэн үүргийг биелүүлэхэд гагцхүү

хүч байгаад болохгүй, өөрөөр хэлбэл гагцхүү сумаа онилж нумаа харваад болохгүй. Харин эрхбиш зөв шугам, зөв төрийн бодлого, зөв байлдах бодлого байлдах арга байх хэрэгтэй.

Чингис хааны ерөнхий шугам бол урьдаар дотоодын дайснаа дарж, улс үндэстнээ нэгтгэж, дараагаар нь харийн дайсан өстөн Алтан улсыг мөхөөх явдал мөн. Дотоодын дайснаа дарахад урьдаар Мэргид, Татар мэтийн тал нутагт өшөө хорслыг гүн зузаан тарьж, хүний сэтгэлийг алдаж, нийтийн эсэргүүцлийг олсон аймаг бүлгээс эхлэн гар хөдөлжээ.

Дотоод гадаадын дайсныг устгахад ерөнхийдөө холбоолж болохуйц этгээдтэй холбоолж, ашиглаж болохуйц зөрчлийг ашиглан дайсан этгээдээ нэг нэгээр устгаж, өөрийн хүчээ алхам алхмаар зузаатгаад хамаг эцсийн ялалт олох арга бодлогыг авчээ. Энэ нь олонхидоо “Холынхтой холбоолж, ойрхоо довтлох” байлдах бодлогоор илэрдэг байна. Энэ бол түүний урьдаар дотоодоо нэгтгэж, нэгдмэл бэхжүүн хүчээр гадаадын дайсанд хандах ерөнхий чиглэлтэй нь нийцэж байх юм. Жишээлбэл, Чингис хаан Мэргидэд анх удаа цохилт өгсөн “Буур хээрийн байлдаан”-ыг Хэрэйдийн Ван хан болон Жадараны Жамуха-тай холбоолж хийсэн, өшөөтөн Татарыг нэгдүгээр удаа устгахад Ван хантай холбоолон, Алтан улсын хүчийг ашиглаж байлдсан, Алтан улсыг дайлахад өмнөд Сүн улстай холбоолж, Тангудын сүрийг нь дарж, Хятаны хүчийг ашигласан зэрэг болно.

Дөрөвдүгээрт, Азийн зүрхэн дэх нэгэн нүүдэлчний “ертөнц”-ийг байлдан нэгтгээд зогссонгүй, бас энэхүү “ертөнц”-өө чадамгайгаар цогцолж, нэгэн харьцангуй бүрэн төгөлдөр, тусгаар тогтносон, цэрэгжсэн феодалист хаант улс болгосон явдал бол Чингис хаан агуу их төрийн зүтгэлтэн болсны хувь дахи алс хэтийн бодлого нь болох бөгөөд чухал илрэл нь болно. Чингис хаан бүх монгол хэлтнийг нэгтгэсэн ба Хаант Монгол Улсыг байгуулсан явдал юуг харуулж байх буй гэвэл, Чингис хаан угсаа үндэстнээ байлдан нэгтгэж чадсанаар барахгүй бас “ертөнц”-ийг засаж, ялангуяа хууль (“засаг”)-аар засаж чадсаныг харуулж байна. Үүнийг зөвхөн дайтахыг мэддэг хүн гүйцэтгэж лав чадахгүй мөртөө алс холын бодлогогүй энгийн нэгэн төрийн зүтгэлтэн ч гүйцэтгэж чадахгүй юм. Чингис хаан 1206 онд улс байгуулаад 1227 онд нас бартлаа сууринаа хорин хоёр жил суужээ. Харин Чингис хааны гардан байгуулсан Хаант Монгол Улс нь Чингис хаанаас хойш 1271 онд бүх Дундад Улсын нэгдсэн төр - Их Юань Улс болтол бас дөчин дөрвөн жил болов. Энэ цаг үе бол Хаант Монгол Улс дотооддоо батжин бэхжиж өнөржин мандсан цаг үе болно. Хэлэлгээнгүй, харь улс үндэстнийг халдан түрэмгийлсэн нүгэлт ажиллагаа ч энэ хугацаанд үүссэн билээ. Энэ нь өөр нэгэн талын асуудал болно. Монгол үндэстний нэгдмэл цогцыг бүрэлдүүлэхэд, тэрчлэн бусад улс үндэстний соёл боловсныг шингээн авч өөрийн үндэстний боловсон цаг үеийг нээхэд Хаант Монгол Улсыг байгуулсан явдал чухал үйлдлийг үзүүлсэн байна.

Хаант Монгол Улсыг байгуулснаас, монгол үндэстний аж ахуй, ялангуяа мал аж ахуй хөгжиж чаджээ. Хэрвээ хөгжсөн аж ахуй нь хангалтгүй бол Чингис хаан ба түүнийг залгамжлагчдын явуулсан их хэмжээний аян дайн нь ялж чадахгүй юм. Нэгдсэн Хаант Монгол Улсыг байгуулмаанжин, Монголын гар үйлдвэр, хот балгас, тариалан зэрэг сая их хурднаар хөгжиж чаджээ. Ялангуяа уйгуржин үсгийг монгол үндэстний нэгдмэл үсэг бичиг болгож, сурган хүмүүжлийн явдлыг эхлэн эрхлэсэн явдал бол Монгол үндэстний боловсон цаг үеийн хөшөө тэмдэг гэж үзэж болох юм. Мөн ч монгол үндэстний бүх талын хөгжилтийн зангилааны чанартай эхлэлт болох нь дамжиггүй хэрэг ээ. Учир нь аливаа улс үндэстний “боловсон цаг

үе нь аялгуу тэмдэглэх цагаан толгойг үүдэн бүтээснээс ба утга зохиолын дээрх хуучин олон мөрөөс эхэлсэн” буюу “хүдэр хайлуулахаас эхэлж, бас үсэг бичгийг үүдэн бүтээгээд түүнийгээ бичиг материалд тэмдэглэх болсноос сая боловсон цаг үед шилжин орсон” гэж Маркс Энгельс дурдаж байсан нь монгол үндэстний түүхэн хөгжилд ч тохирох юм.

Найман, Онгуд зэрэг Монголын баруун захын аймгууд бусад соёлжсон аймгийн нөлөөгөөр нэлээд эрт үсэг бичгийг авч хэрэглэсэн бололтой гэж би тус товчооны тавдугаар бүлэгт дурдсан билээ. Гэвч уйгуржин бичгийг монгол үндэстний албан ёсны нэгдэлтэй үсэг бичиг болгосон явдал бол Чингис хаан бүх Монголыг нэгтгэж, Тататунгаа зэрэг соёлт үндэстний их бичгийн хүнийг хүндэтгэн хэрэглэсэнтэй холбогдох ёстой. Түүх шастирт нэг Тататунгаа-гийн нэрийг хэрэглэдэг. Гэвч Найманы ноёрхогчид ганцхан уйгур бичээч Тататунгаа-г л хэрэглэх ёсгүй, Чингис хаан ч бүх Найманыг нэгтгэн авсан бөгөөд уйгур үндэстэнтэй ураг садны нягт харьцааг байгуулсан тул ганцхан Тататунгаа-г л хэрэглэсэн өөр Тататунгаа мэтийн эрдэмтнийг олсонгүй буюу хэрэглэхгүй гэдэг нь сэтгэшгүй хэрэг юм. Харин тэр бүгдийг тэмдэглэсэнгүй буюу тэмдэглэсэн нь манай үе болтол үлдсэнгүйгээр үрэгдсэн ч байж мэднэ. Тиймээс Тататунгаа-г ийм хүмүүсийн доторхи нэгэн шалгарсан төлөөлөгч гэж үзэж болох юм.

Тавдугаарт, чадвартныг хэрэглэж, эрдэмтнийг эрхэмлэдэг явдал бол Чингис хааны сэцэн мэргэн бодлогыг харуулж байх бөгөөд түүний их үйлсийн хөгжил бадралынхи нь чухал нэгэн шалтгаан болжээ. Ямар хүнийг хэрэглэх гэсэн асуудал бол эрт ба өдгөөгийн аливаа улс үндэстний аливаа ноёрхогч ангид бүр тулгарч байсан асуудал бөгөөд тухайн ноёрхогч ангийн хөгжил бадралтай нь холбогдох чухал асуудал болж байдаг. Кадр (“боловсон хүчин, мэргэжилтэн” гэсэн утгаар хэрэглэдэг үг - хө.)-ыг хэрэглэх энэ асуудал дээр ... ерөөс эсрэг тэсрэг хоёр шугам оршсоор ирсэн юм:

Нэг нь эрдэмтэн мэргэдийг л хэрэглэх шугам мөн, нэг нь ойр дотночуудаа л хэрэглэх шугам мөн. Урьдахи нь зөв шугам, хойнохи нь зөв бус шугам юм (“Мао Цзэ Дун-ы сонгомол зохиол”, 2 дугаар боть, 926 нүүр) гэж нөхөр Мао Цзэ Дун хэлж байсан билээ. Энэ нь мөн ч “алт шалгах билүү”-тэй адил төрийн зүтгэлтнийг шалгаж байдаг сан. Энэ асуудлыг эртний түүх шастир, тухайлбал Чингис хааны тухай түүх шастирт ингэж шууд тэмдэглэсэн мэдээ харагддаггүй боловч Чингис хааны бодтой ажиллагааг нэлээд тодорхой харуулжээ. Жишээлбэл, Чингис хаан “нөхөр бүлгэм”-ээ байгуулахад хүн сонгон хэрэглэсэн явдлыг манай одоогийн үгээр хэлбэл кадр хэрэглэх зарчим болно. Өөрөөр хэлбэл Чингис хаан “эрдэмтэн мэргэдийг л хэрэглэсэн” үү, эсхүл “ойр дотночуудаа л хэрэглэсэн” үү гэсэн асуудалд түүний “нөхөр бүлгэм”-ийн бүрэлдэхүүн нь тодорхой хариулт өгч чадна.

Чингисийн дөрвөн хүлэг, дөрвөн хошууч, есөн өрлөг зэргийг багтаасан наян найман гавьяатны дотор, овог аймаг нь тодорхой дурдсангүй арав есөн хүнийг гаргавал, бусдад нь гучин нэгэн овог аймгийн хүмүүс багтаж байсан билээ. Энэ нь Чингис хааны “нөхөр бүлгэм”-ийн хүрээ хэмжээг харуулж байна. Ялангуяа эдгээрийн дотор Жалайр, Урианхан, Сүлдүс, Баягуд, Дархад зэрэг унаган (өтгөс) боол овгийн хүмүүс, Татар, Мэргид, Тайчигуд, Хэрэйд зэрэг дайсан овог аймгийн хүмүүс, Онгуд, Ихирэс, Хонгирад, Горлос зэрэг харь овгийн хүмүүс багтаж байх бөгөөд бас анхандаа биеэрээ Чингис хааныг дайсагнаж, сүүлд нь үнэн сэтгэлээсээ дагаж өгсөн хүмүүс ч буй. Жишээлбэл хошууч жанжин Зэв зэрэг болно.

Үүнээс гадна, Чингис хаан бас уйгур хүн Тататунгаа, Баржуг Арт Тигин, сартуул хүн Ялавачи, Жабар галч, хятан хүн Елюй Ахай ах дүү хоёр, Елюй Чусай, Шимо Мянган, Жүрчин хүн Жаньха Жуншань эцэг хөвгүүн, хятад хүн Го Бао Юй, Лю Чжун Лу, тангуд хүн Чаган, Чэмбэхин зэрэг харь улс үндэстний нэлээд олон эрдэмтэн чадвартныг хэрэглэсэн байна. Эдгээр байдлаас үзэхүл, Чингис хааны хүн хэрэглэх зарчим нь “ойр дотночуудаа л хэрэглэдэг” хуучин ноёрхогчдын доройтлыг тусгасан биш, харин “эрдэмтэн мэргэдийг л хэрэглэдэг” феодал ангийн шинэ ноёрхогчдын мандал хөгжлийг харуулж байжээ.

Багцлаад хэлбэл, Чингис хааныг зөвхөн “цэрэг дайны бодлогоч” гэснээс нэгэн төрийн зүтгэлтэн, ялангуяа монгол үндэстний анхдагч агуу их төрийн зүтгэлтэн гэх буюу “бичиг цэргийг хослуулсан” зүтгэлтэн гэж үзвэл нэн зохислог мэт.

69. Чингис хаан бол цэрэг дайны шалгарсан бодлоготон бөгөөд агуу их удирдагч мөн

Чингис хааныг “цэрэг хэрэглэхүй дор сахиулсан мэт” цэрэг дайны зүтгэлтэн гэж үнэлдэг нь бүр баримттай юм.

Чингис хааны цэрэг хэрэглэхийг “сахиулсан” мэт гэсэн нь миний ойлголтоор ийм байна:

Нэгд, Чингис хаан бол монгол үндэстний түүхэн дэх шалгарсан гарамгай цэрэг дайны зүтгэлтэн болно. Хэлэлгээнгүй монгол үндэстний түүхэнд цэрэг дайны зохион байгуулагч, бодлогоч ба удирдагч нар Чингис хаанаас өмнө, ялангуяа Чингис хааны үед ба түүнээс хойш маш олон гарч байсан нь бүр түүхийн үнэн хэрэг билээ. Гэвч Чингис хаантай адил цэрэг дайны агуу их зохион байгуулагч, агуу их бодлогоч, агуу их удирдагч ер байгаагүй. Монгол үндэстний түүхэнд Чингис шиг ийм нэгэн агуу их цэрэг дайны зүтгэлтэн буй болсон явдлыг гэнэтийн тохиол гэж үзэж болохгүй. Тэр бол гүн гүнзгий нийгмийн үндэс суурьтай юм.

Монгол үндэстэн бол төрөлх харвалга намнаанд бахтай, онох сорих удамтай, аюул гамшгаас айдаггүй, хүчир бэрхшээлээс халширдаггүй эрэлхэг баатар үндэстэн болохоор үл барам, агт морь олон, ан гөрөө элбэгээрээ Монголын аж ахуйн өвөрмөц онцлог ба чухал бүрэлдэхүүн нь болж байсан тул монгол үндэстэн нь эрт урьдаасаа морь уналга сайтай, харвах намнах авьяастай үндэстэн юм. Тиймээс дайн байлдаан хийх явдал бол монгол үндэстний түүхэнд онцгой байрыг эзэлсээр иржээ. Энэ бол Чингис хаан мэт агуу их цэрэг дайны зүтгэлтэн буй болсны нийгмийн үндсэн нөхцөл - хэрэг бодосын хөгжлийн дотоод хүчин зүйл болно. Чингис хааны цэрэг дайны бодлого нь ямар нэгэн гадаадын цэргийн эрдэмтнээс суралцсан гэж зарим хүмүүс үздэг байна. Миний үзэхээр, монгол үндэстэн нь дэлхийн түүхт үндэстний хувьд авч үзэхүл, бусад улс үндэстнээс ямар нэгэн нөлөөнийг олж болох юм. Гэвч цаг үеийн хөгжлөөс болж, Чингис хаанаас өмнө буюу Чингис хааны түрүү хагас үед ийм нөлөөг олох нөхцөл бололцоо арай бүрэлдээгүй байсан мэт. Тиймээс Чингис хаан бол Монголын нийгмийн орчин тойронд өсч бойжсон, Монголын онцлогтой “сахиулсан” мэт цэрэг дайны зүтгэлтэн болно.

Хоёрт, Цэрэг дайны үйлдлэгийн талаар, Дундад Улсын бүх феодал хаад ба цэргийн эрдэмтний дотор Чингис хаан “цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт” гэж үнэлэгдсэн тул хосгүй нэгнээр тооцогдох ёстой. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т Чингис хааныг “Хаан хянамгай лавдуун бодлого гүн, цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт тул дөчин улсыг мөхөөж,

баруун Ся улсыг төвшитгөжээ. Түүнд асар гайхамшигт гавьяа, агуу их үйлс нь адбиш үлэмж ажгуу ... “ гэж үнэлсэн бөгөөд “Тэнгэрийн бошгоор улирлыг нээсэн богд баатар хаан” гэсэн цолыг өргөмжилсөн билээ. Дэлхий дахинд алдар нэртэй, Дундад Улсын түүхэнд анх удаа нэгдсэн феодалын эзэрхэг ёсыг байгуулсан хаан Цинь Ши Хуан² байтал зөвхөн зургаан улсыг устгаж, Цагаан хэрэмээс өмнөших, мөрнөөс умаршхийг л ноёрхож чаджээ. Харин Чингис хаан бол Байгал далайгаас Хатан гол, Солонгосын хойгоос Крым-ийн хойг хүртэлх Ази Европын их хуурайг эрхшээж дөчин улс (хэрэг дээрээ тусгаар нутагшиж байсан аймаг бөлгийг ч багтааж байх мэт)-ыг мөхөөсөн байна.

Дэлхий дахинд одоо болтол гэрэл гялбаагаа алдаагүй “Сун-цзы-гийн цэргийн бодлого”-ыг бол Чунь Цю-гийн үеийн агуу их цэрэг дайны эрдэмтэн Сунь УЗ зохиосон юм. Гэвч тэр өөрийн биеэрээ У улсын цэргийг дайчилж Чу улсыг эвдэлсэн нэгээхэн удаагийн байлдааныг хийлээ гэдэг тэмдэглэл байдаг. Дайны үйлдлэгийн талаар тэр, Чингис хаан лугаа хэрхэн тэнцэж чадах буй? Тиймээс Дундад улсын цэрэг дайны ухаан болбоос Суньцзы-гийн үед онолын талаар өндөр их амжилтыг бүтээжээ. Юань улсын Тайцзу Чингис хааны үед үйлдлэгийн талаар агуу гайхамшиг үйлсийг биелүүлжээ. Эд хоёр хэдийгээр мянга гаруй жилийн урт удаан цагийг алслан амьдарч байсан боловч, нэг нь хулсан бийрийг таталж хосгүй онолыг зохиогоод, нэг нь хурц сэлмийг далайж гайхамшиг үйлдлийг бүтээгээд Дундад улсын түүхэн дэх цэргийн сүр хүчийг бадруулж, Ази Европыг донслогосон агуу их үйлсийг мандуулжээ” гэж Дундад улсын хөрөнгөтөн ангийн нэгэн цэргийн эрдэмтэн Вань Яо Хуан жанжин тэмдэглэсэн юм. Дундад улсын эртний хэдэн мянган жилийн боловсон түүхэнд цэрэг дайны онолын талаархи сацрангуй нэгэн цамхаг нь Сунь-цзы болдог бол, цэрэг дайны үйлдлэгийн талаархи баларшгүй хөшөө нь Чингис хаан болох юм. Иймээс, тэр “богд”, “сахиулсан” гэж өргөмжлөгджээ.

Гуравт, Дэлхийн түүхийг шүүж үзсэн ч Чингис хаан мэт “цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт” цэрэг дайны зүтгэлтэн ба удирдагч бол тэр ганцаараа байжээ. Чингис хааныг нас барахаас түрүү нэгэн жил - 1226 онд төрсөн Персийн түүхч Джувейни арван гуравдугаар зууны дундаж үеэр бичсэн “Дэлхийн дайлан дагуулагчдын түүх” гэдэг зохиолдоо Үнэнийг хэлэхэд, тэрхүү арга бодлогодоо чадамгай, дайсныг ажихад сахиулсан гэдэг алдартай Александр хэрвээ Чингис хааны үед амьд байсан бол, арга сүвэгчилж бодлого хэрэглэх талаар Чингис хааны сурагч нь болох бөгөөд хот балгасыг довтлох зүйл бүрийн уран аргын талаар Чингис хааныг үг дуунгүйгээр дагаж хийвэл дээр гэдгийг тэр лав олж мэдэх юм гэж дүрсэлсэн нь их оновчтой юм. Чингис хаан бол манай Азийн хүн гэж зарим харийн хүмүүс, жишээлбэл, Японы хөрөнгөтөн ангийн төлөөлөгч хүмүүс хүртэл омогшингуйгаар ярьдаг байна. Өрнө дахины хүмүүс Наполеон, Молтке, Ганнибал⁴, Александр зэргийг бишрэхийн туйлаар биширдэг, гэтэл тэд Суньцзы, Чингис хааны дэргэд өлөн тоосыг нь ч үл үзэхгүй, өвдөг доор нь сөгдөж л явах хүмүүс юм. Манай дорно дахины хүмүүс Суньцзы, Чингис хаан мэт агуу их хүмүүстэй байсандаа тэргүүн өргөн, цээж тэнийн урагшилна гэж Японы нэгэн дархалсан жанжин Эймурашики гэгч тэмдэглэв. Эдгээр бол Чингис хааныг үнэлж нуталдаг хүмүүсийн яриа болно. Тэр ч байтугай, Чингис хааныг зүхэж хараадаг хүмүүс ч гээд Чингис хааны хүч чадал, арга ухааныг эс гайхан сүрдэгдсэн үгүй. Арменийн түүхч Д’Оссон бол ийм нэгэн талын төлөөлөгч нь юм. Д’Оссон Чингис хааны сүр хүчийг ингэж тэмдэглэжээ: “Түүний эзэлж эрхшээсэн орон нутаг нь хязгааргүй өргөн уудам, түүнийг эзэн хэмээн өргөмжилсөн үндэстэн хэрхэн зуугаар тогтох буй? Тэр бүх дэлхийг түрэмгийлэн эзлэх хүслээ тэнгэрээс

соёрхсон хэмээн оморхоглодог билээ. ...Чингис хааны ялалт нь түүний шантрашгүй хагуу зоригоор нь батлагддаг бөгөөд арга бүхнийг хэрэглэдэгээр нь биелэгддэг юм. Түүний эвдлэл талхидал нь тэнгэрийн аюултай тэнцэх бөгөөд гайхамшигт алдар нь газар сайгүй дуурсч, харьяалагдаж эзлэгдсэн улс үндэстэн нь хариуцах сөсгүй болдог” (Д’Оссоны “Монголын түүх”, нэгдүгээр боть, аравдугаар бүлэг).

Багцлаад хэлбэл, Чингис хаан нь бүх монгол үндэстний түүхэнд “цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт” агуу их цэрэг дайны зүтгэлтэн болохоор барахгүй, бүх Дундад улс, бүх дэлхийн түүхэнд ч гайхамшигт тэмдэглэлийг үлдээсэн “хүний арслан тэнгэрлэг богд эзэн” (“Эрдэнийн товч”) юм.

Чингэвэл түүний “сахиулсан” мэт гайхамшиг нь юугаараа илэрч байсан буй? гэвэл:

Юуны урьд, Чингис хааны зэвсэгт хүчин нь үгүйгээсээ байх болж, өчүүхэнээсээ өргөжиж, буурайгаасаа хүчирхэгжсээр байж “дэлхийг дайлан дагуулах” хэдэн арван түмэн морьт цэрэгтэй болжээ. Чингис хааны өмнө тулгарч байсан дайсан нь “нэг нэгээрээ бүр тэнгэрээс төрүүлсэн эзэн, одоо үеийн Хосров (персийн “Сашан” (Sasanid – хө.) вант төрийг хэлж байна - уул тайлбар) мэт, хүн олон, хүч их, цэрэг арвин, зэвсэг хурц байсан, Чингис хаан бол биеээрээ тэмцэн босч, цөөн цэрэг барагтай зэвсгээрээ дорнод дэлхийгээс өрнөд дэлхий хүртэл дайлан дагуулж, талхин төвшитгөөд дайчин баатараа гайхуулав. Хэн хэрвээ түүнийг аймшиггүй эсэргүүцдэг бол тэр даруй түүний нийтэлсэн засаг ба хуулиа үндэслэж, тэрхүү эсэргүүцэгчийг харьяат иргэд, эмс хүүхэд, нам сэлт, цэрэг анги, улс орон болон газар нутгийнхи нь хамт ор мөргүй устгадаг” (“Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, нэгдүгээр боть, хоёрдугаар бүлэг) байна. Чингис хааны түүх бол бүр цөөнөөр олныг ялсан түүх юм.

Монголын эл аймгийг нэгтгэхэд хэлэлгээнгүй бүр цөөнөөр олныг ялж байсан түүхтэй билээ. Жишээлбэл, Чингис хаан Алтан улсыг дайлсан бүх дайн нь цөөнөөр олныг ялснаар барахгүй, олонхи бодтой байлдаан нь ч цөөнөөр олныг ялсан байна. Хуй Хэ Бао цайзын дайралдаанд Алтан улсын гучин түмэн хурц их цэргийг нь Чингис хаан цөөн цэргээр туйлбартай устгасан явдал бол үүний нэгэн жишээ болно. Хорезм ба Тангуд улсыг мөхөөхөд мөн ч цөөхнөөр олныг ялжээ. Чингис хааны биеэр хийсэн дайн нь ийм байснаар барахгүй, Чингисийн жанжин нарын тусгаар хийж байсан дайн байлдаан нь ч мөн цөөхнөөр олныг ялж байв. Ялангуяа Чингис хааны дөрвөн хүлгийн манлай Мухулай, хэдэн түмхэн цэргээр Алтан улсыг таван жил гаруй дайлсан ба хошууч жанжин Зэв, Сүбээдэй нар цөөн цэргээр түмэн газрын хол замын дайралт хийж, үй олон улс үндэстнийг дайлан довтолж, Европ дахиныг сүрдүүлж байсан юм.

Хоёрдугаарт, Чингис хааныг үндсэндээ нэгэн “ялагдашгүй жанжин” гэж хэлж болно. Үнэн хэрэг дээрх ялагдашгүй жанжин эртнээс нааш цөөн байсан гэж нөхөр Мао Цзэ Дун тэмдэглэж байв. Чингэвэл энэ “цөөн”-ий дотор нь Чингис хаан лав багтах ёстой. Чингис хааны бүх дайчин амьдралынхи нь дотор тун цөөн хэдэн удаагийн нугарлыг гаргавал, бусад байлдаан нь бүр ялалттай явагдаж байв.

Гуравдугаарт, Чингис хаан бол дайны жам ёсыг сайтар эзэмшиж, мөн энэхүү жам ёсоор журамлан ажиллаж чаддаг чадамгай удирдагч байжээ. Дайны жам ёс - энэ бол дайныг жолоодох хүн нэг бүрийн судлахгүй байж болохгүй, шийдвэрлэхгүй байж болохгүй асуудал

мөн (“Мао Цзэ Дун-ий сонгомол зохиол”, 1 дүгээр боть, 295 нүүр). Чингис хаан хэрвээ энэ асуудлыг шийдвэрлэж чадсангүй бол, тэр тийм олон ялалттай дайныг хийж “сахиулсан” мэт цэрэг дайны зүтгэлтэн болж чадахгүй юм.

Энэ талаар Чингис хааны чухал нэгэн илрэл гэвэл, тэр, хувиран хөгжиж бүхий цагийн байдлыг үндэслэж, өөрийн хүчээ тасраагүй цэгцлэн тохируулдаг бөгөөд уян хатан байлдах бодлого байлдах аргыг хэрэглэдэг байна. Жишээлбэл, “Арван гурван хүрээний байлдаан”-аас өмнө, зохион байгуулалтын талаар буюу байлдах аргын талаар их төлөв эртний Монголын овгийн байгууллын уламжлалтай “хүрээн”-ий хэлбэрээр зохион байгуулах ба байлдаж байжээ.

Гэтэл энэ нь Чингис хааны бүх Монголыг нэгтгэх их нэгтгэлээр байлдахад нь тохирохгүй болжээ. Ингээд Чингис хаан нийтийн он тооллын 1204 онд Найманыг нэгтгэн авахаас өмнө, цэргийн зохион байгуулалтаа өөрчилж “мянгатын байгуулал” болгосон бөгөөд байлдааны арга бодлого нь ч ихээхэн хөгжин хувирсан байв. Энэ талаар Чингис хааны чухал нэгэн онцлог бол, ямар нэгэн аргыг боловч тэр ер үхэн баримталдаггүй. Жишээлбэл, 1203 оны хавар зуны хооронд Хэрэйдийн Ван хантай анх удаа хийсэн “Муу өндөрийн байлдаан”-д хоёр талаар нэлээд хохирлыг олсон тул Чингис хаан санаачлагатайгаар байлдааны талбараас ухран гарч, цэрэг морио амруулан цэгцэлж, хүчээ шинээр зохион байгуулаад тус оны намарт нь “Жэжэгэр өндөрийн байлдаан”-аар Хэрэйдийг туйлбартай мөхөөжээ.

Гадагш явуулсан дайнд ч мөн ийм уян хатан аргыг хэрэглэж байв. Жишээлбэл, 1213 онд, Чингис хаан Алтан улсын нийслэл Чжунду хоёрдугаар удаа довтлоход, Чжунду хотын сэргийлэл хамгаалалт нь бат бэх тул олонтоо довтолсон боловч хотыг нь ер эзэлж чадсангүй билээ. Ингээд Чингис хаан Чжунду хотыг довтолох төлөвлөгөө өөрчилж, бүх цэргээ гурван замаар хуваан, Алтан улсын ар талын гүн тийш довтолов. Бас Хорезмын Татар хот ба Тангудын нийслэл Яргай хотыг байлдахад ч бүр ийм аргыг хэрэглэж байв.

Дөрөвдүгээрт, дайсны талынхаа зөрчил хагарлыг гярхай түргэн ажиж, ашиглаж болохуйц хүчийг чадамгайгаар ашигладаг явдал бол мөн ч Чингис хааны ялалтгад дутагдашгүй нөхцөл болж байсан билээ. Жишээлбэл, Чингис хаан Дундад улсын умар дахиныг ноёрхож байсан хүчирхэг гүрэн Алтан улсыг дайлах үед, өмнөд Сүн улс болон Алтан улсын хооронд, Тангуд улс болон Алтан улсын хооронд, Хятан болон Алтан улсын хооронд эвлэршгүй зөрчил оршиж байснаас оршиж гадна, Алтан улсын дотооддоо бас тариачдаас газрын эзнийг эсэргүүцэх ангийн зөрчил ба хятад үндэстэн, хятан үндэстнээс Жүрчиний төрийг эсэргүүцэх үндэстний зөрчлөөр бялхаж байснаар зогсоогүй, харин газрын эздийн дотроо ч Жүрчин хаанд үйлчлэх юм уу, эсхүл Монголын хаанд бууж өгөх юм уу гэсэн зөрчлөөр дүүрч байв. Чингис хаан юуны урьд эдгээр зөрчлүүдийг чадамгайгаар ашиглан, өмнөд Сүн улс лугаа найрамдлын холбоо байгуулсан бөгөөд Алтан улсын сүрдүүлэл дор арга бус түүний халхавч болж байсан Тангуд улсыг хэдэнтээ цэрэглэж, Монголд алба өргөл барих харьяат болгосон тул, Тангуд улс ба Алтан улсын хоорондохи хагарал зөрчлийг улам гүнзгийрүүлэн, Тангудын хүчийг нь дам ашиглажээ. Бас Хятан ба Жүрчиний хоорондохи гүн зузаан үндэстний зөрчлийг нь ашиглаж, Алтан улсыг эсэргүүцсэн Елюй Люгэ түрүүтэй Хятаны бага төрийг дэмжсэн бөгөөд Алтан улсад үйлчилж байсан аль олон Хятан цэрэг буюу хятад цэргийг бие зүгээ татан авч, Алтан улсыг дайлах чухал хүч болгожээ. Бүрэн бус бүртгэлийг үндэслэвэл, 1211 оноос 1215 оны

хооронд Чингис хаанд бууж өгсөн алдарт жанжин нар нийт гучин найман хүн байжээ, үүний дотор:

1211 онд бууж өгөгсдөд, Елюй Нэрхэ (хятан хүн), Лю Бо Линь (хятад хүн, Алтан улсын Вэйнин хотын сахиул цэргийн мянганы ноён), Хо Бао Юй (хятад хүн, Алтан улсын Фэнь Ян Цзюнь гүн ноён), Шимо Мянган (Хятан хүн, Хушаху-гийн дор Алтан улсын баруун нийслэлийг хамгаалж байжээ), Чжан баатар (хятад хүн, чухам нэр нь гээгджээ) зэрэг байв.

1213 онд бууж өгөгсдөд, Ши Тянь Ний (хятад хүн, Алтан улсын түмний ноён), Чжао Гуй (хятад хүн, Алтан улсын түмний ноён), Уудун Ши Ин (Жүрчин хүн, Цзычжоу-гийн циши түшмэл), Чжао Жоу (хятад хүн, Шаньси мужийн Бао Сян-ын өрхийн цэргийн удирдагч), Ван Цзи (хятад хүн, Алтан улсын цэргийн дэд захирагч), Цзяо Юн (хятад хүн, Алтан улсын мянганы ноён), Янь Цзе Чжи Гэ (хятад хүн), Элүбүр (хятан хүн, Цавчаал боомтын сахиул цэргийн дарга), Шимо Бүдэр (хятан хүн, Алтан улсын Бачжоу-гийн Пинчуй хэмээх газрын усчныг захирагч ноён), Сунь У (хятад хүн, Алтан улсын Сиюнчжоу-гийн элч ноён) зэрэг байв.

1214 онд бууж өгөгсдөд, Жалар (Хятан хүн, Алтан улсын Жүйн цэргийн захирагч), Канда (Жалартай адил), Бишер (Жалартай адил), Лу Цун (хятад хүн, Алтан улсын Гао чжоу-гийн жанжин), Цзинь Пу (Лу Цун-тай адил), Чжан Цзин (хятад, Алтан улсын Цзинчжоу-гийн цэргийн захирагч), Ли Шоу Сянь (хятад хүн), Ди Сунь (хятад хүн, Цюй Ян-ын журмын цэргийн тэргүүн), Елюй Төмөр (хятан хүн, Алтан улсын амбан), Шимо Есөн (хятан хүн), Чжан Жун (Цинчжоу-гийн хятад хүн), Садархай (Яньцзин хотын хүн, үндэстэн нь тодорхойгүй) зэрэг байв.

1215 онд бууж өгөгсдөд, Ю Харбаатар (жүрчин хүн), Үгүлүн Индаху (жүрчин хүн, Алтан улсын дээд нийслэлийн нэгэн жанжин), Ши Тянь Инь (хятад хүн, том газрын эзэн), Тянь Сюн (хятад хүн, Алтан улсын умард нийслэлийн амбан), Ду Сю (хятад хүн), Ван Сюнь (хятан хүн), Пуча Чигин (Жүрчин хүн, Алтан улсын баруун мөрийн дэд юаньшуай), Кижу (үндэстэн нь тодорхойгүй, Алтан улсын тохируулагч элч), Дун Цзюнь (хятад хүн, Алтан улсын Гао Чэн хотын сахиул цэргийн захирагч), Чжао Ди (хятад хүн, Гао Чэн сянь-ий түшмэл), Сямби Чжунхи (дээдэс нь Чжун Шань хүн) зэрэг байв. Эдгээр бууж өгөгсдийн зонхилох олонхи нь Монголын цэргийн хамт Алтан улсыг эсэргүүцэх хүч болж байснаар үл барам, зарим нь Чингис хааныг дагалдан Дундад Ази ба Тангудыг дайлж дайнд оролцож байв. Эдгээр нь Чингис хааны цэрэг хэрэглэх үйлдлэгэд бодосч үзлийн хүчин зүйл агуулагдаж байсныг харуулж байна.

70. Чингис хааны үзэл санаа ба зан чанарт холбогдох зарим зүйлс

Чингис хааны үзэл санаа ба зан чанарыг бүх талаар системтэй бичих явдал бол тун хүчиртэй асуудал болох бөгөөд одоохондоо ийм нөхцөл бололцоо ч надад үгүй байсаар байна. Тиймээс түүнд холбогдох онц зарим зүйлсийг л бүдүүвчлэн дурдаж хяналт болгоё.

Нэг. Эзэндээ үнэнч шударга байхыг Чингис хаан онцгой эрхэмлэдэг. “Эзэндээ үнэнч шударга байх”-ыг эрхэмлэх ёс бол феодал ангийн үзэл санаа ба зан чанарын онцлог болно. Энэ талаар Чингис хааны түүхэнд тун олон амьд дүрслэг үлгэр байдаг сан. Жишээлбэл, 1202 оны өвөл

Чингис хаан Тайчигуд аймгийг мөхөөсний дараахан, Тайчигудын тэргүүн Таргутаг Хирултуг ой шугуй дотор ганцаараа дутааж бүхийд Нүцгэн багарины Ширүгэтү өвгөн Алаг, Наяа гэдэг хоёр хөвгүүнтэйгээ барьж аваад тэргэнд тээж, Чингис хаанд хүргээр ирсэн боловч, “Бид өөрийн эзнээ барьж хүргэн очвол, Чингис хаан биднийг эзэндээ халдсан ард гэж үл итгэх нь лав” гэж зөвлөлдөөд, Таргутаг Хирилтуг-ийг замаасаа тавьж явуулаад, эцэг хөвгүүн гурвуул Чингис хааныг дагаар хүрчээ. Үүнийг нь Чингис хаан эзэндээ шударга хүн гэж сайшаан магтаж дотночлон нөхөрлөсөн бөгөөд сүүлд нь Наяа-г түмний ноён болгожээ. 1203 оны намар Хэрэйдийг мөхөөсөн “Жэжэгэр өндөрийн байлдаан”-д Ван ханы их жанжин Жирхиний Хадаг Баатар гэгч өөрийн эзэн Ван хан, Сэнгүм нарыг дутаалгахын тулд Чингис хааны цэрэгтэй гурван шөнө гурван өдөр ширүүнээр байлдаж, эзэн нь хол дутаан гарсан хойно сая Чингис хаанд буун өгч, “тус хаанаа үзсээр хэрхэн алуулах хэмээн тэвчин ядаж, амь оргон хол дутаалгахын тулд гурван шөнө гурван өдөр үхэн байлдав. Өдгөө үхүүлбээс үхсү, соёрхогдвоос Чингис хаан танаа хүчээ өгсү” гэж хэлжээ.

Чингис хаан түүнийг уучилж, Мангудын Хуйлдар сэцэний гэр бүлд өгчээ.

Нөгөө талаар, Чингис хаан эзэндээ шударгагүй хүнийг туйлаар жигшиж, чанга шийтгэдэг билээ. Жишээлбэл, мөн “Жэжэгэр өндөрийн байлдан”-аас амь зугтан гарсан Ван ханы хөвгүүн Нилха Сэнгүм эцгээсээ салан, агтач Хөхэчү-гийн эхнэр гурвуул цөл талд тэнэн явж байгаад нэгэн сүрэг хуланг олж үзээд Сэнгүм морио агтачдаа бариулж, өөрөө хуланг мяраан явсан хооронд агтач Хөхэчү Сэнгүмийн морийг нь аваад, Сэнгүмийг хээр орхиж дутаах гэхэд, Хөхэчү-гийн эхнэр өнгөрсний журмыг бодож эрээ зэмлэжээ. Гэтэл Хөхэчү “Чи Сэнгүмийн эхнэр болох гэв үү?” гэж эмээ хараасанд эм нь “Чи намайг нохой мэт ичгүүргүй амьтан гэх буюу. Чи алтан зандуу (хундага)-г нь орхитугай. Ядахдаа ус уух савтай үлдэг” гэсэнд, Хөхэчү арга бус алтан хундагыг нь хойш хаяж, Сэнгүмийг орхиод Чингис хааны дэргэд ирж, энэ учраа хэлжээ. Гэтэл Чингис хаан түүнийг орж өгөв гэж онц гавьяагаар огт үзсэнгүй мөртөө “тус хаанаа ийн тэвчиж ирсэн хүн өдгөө хэнд нөхцвөөс итгэгдэх буй?” гэж цавчиж алаад, ганц эхнэрийг нь уучилжээ (“Нууц товчоон”-ы 188 дугаар зүйл). Бас нэгэн үлгэр бол, Чингисийн дайсан Жамуха мухардал гачигдлын туйлд хүрч, тавхан нөхөртэй үлдэн Тагна ууланд гарч, нэгэн угалз алж махыг нь шарж идэн байтал таван нөхөр нь гар хөдлөн эзнээ барьж аваад Чингис хаанд хүргэжээ. Гэтэл Чингис хаан тэднийг эс итгэн, “Хаан эзэндээ халдсан хүнийг яаж орхих вэ? Тийм хүн хэнтэй нөхөрлөх вэ? Хаан эзэндээ халдсан харц ардыг ураг төрлийг нь хүртэл устга” гэж зарлиг болгоод, Жамуха-гийн нүдэн өмнө нь урьдаар тэр тавыг алж дараа нь сая Жамуха-г алжээ. Энэ тухай “Боол өөрийн эзэндээ үнэнч шударгагүй агал, бусад хүнд хэрхэн үнэнч шударга байж чадах буй?” гэсэн Чингис хааны сэцэн үг байдаг (“Юань улсын түүх”, 121 дүгээр боть, “Сүбээдэйн намтар”).

“Эзэндээ үнэнч шударга байх”-ыг эрхэмлэх явдал бол Чингис хаанаас өөрийн ураг төрөл, нөхөр сэлт, сайд түшмэлдээ хандах ба хүн хэрэглэхийнх нь чухал нөхцөл баримжаа болж байжээ. Тиймээс энэ бол Чингис хааны үзэл санаа ба зан чанарынх нь чухал илрэл болж байсан нь илт юм.

Хоёр, Чингис хаан сахилгыг баримтлахад гуйвдаггүй, цаазыг хэрэгжүүлэхэд буцдаггүй. Энэ тухай бас нэлээд үлгэр байдаг юм. Жишээлбэл, 1200 онд Чингис хаан Далан Нөмөргөс гэдэг газар Татар аймагтай хоёрдугаар удаа байлдах үед, Чингисийн дүү Хасар өөр нэгэн салаа

цэргийг захирч бус газар байсан бөгөөд “Хонгирад урван явлаа” гэдэг чимээг доорхи хүн Жэбхэ-гээс сонсч, Чингис хаанд мэдүүлсэнгүйгээр өөрийн цэргээ дагуулан очиж талхиджээ. Хонгирад аймаг нь ёс бус талхигдсандаа хорсч үнэнхүү урван гараад Жамухатай нийлсэн байна. Энэ чимээг Чингис хаан сонсоод Хасарыг буруушаан донгоджээ.

1202 оны намар, Татартай байлдахад Чингис хаан гурван зурвас цааз сахилгыг тогтоожээ. Энэхүү цаазыг нь өөр хүн зөрчсөнгүй, харин Хотала хааны хөвгүүн Алтан, Нэгүн тайжийн хөвгүүн Хучар болон Бартан баатарын отгон хөвгүүн Даритай зэрэг Чингис хааны дээд үеийн ураг төрөл нь зөрчиж, олзонд шунан байлдаанаас саатсан байв. Ингээд Чингис хаан цэргийн цаазыг чанга биелүүлэхийн тулд Хубилай зэрэг ноёныг томилж, бүх олзолсон зүйлийг нь хураан авч олонд хуваан өгчээ. Сүүлд нь тэр гурвуул урван тэрсэлж Жамуха-г дагасан бөгөөд Алтан, Хучар хоёр мөн Жамуха-гийн адил алах ялаар шийтгэгдсэнийг хожим нь Чингис хаан Мүнлигийг донгодон хэлснээс мэдэж болно. Тэр хэлсэн нь: Та хөвгүүдийнхээ авир занг ятгахгүй тул тэд, бидэнтэй тэнцэх хэмээгээд Тэв тэнгэрийн толгойг алдав. Та нарын ийм зан гаргахыг мэдсэн бөгөөс та нарыг хэдийн Жамуха, Алтан, Хучар нарын адил болгох билээ (“Нууц товчоон”-ы 246 дугаар зүйл) гэжээ.

Мөн энэ удаагийн байлдаанд Татар аймгийг мөхөөгөөд, Чингис хаан алтан ургаа цуглуулан хуралдай хуралдаж, Татарын эрсийг нь тэрэгний тэнхлэгт хэмжээлж алахаар тогтоожээ. Гэтэл энэхүү дотоодын нууцыг Чингис хааны өөр эхээс төрсөн дүү Бэлгүтэй гарч, Татарын Их Чэрэн гэдэгт задруулсан тул Татарчууд “дэр авч үхье” гэж урвалга гаргаж, Чингисийн цэрэгт нэлээд хохирлыг учруулжээ. Ингээд Чингис хаан хилэглэж, Бэлгүтэй-гийн алтан ургийн хуралд орох эрхийг нь хасжээ.

Дээр дурдсан хэдэн үлгэр бол Чингис хаан бүр цааз сахилгыг бататгахын тулд өөрийн ураг төрлөө хүртэл чанга шийтгэсэн жишээнүүд болно. Өөр хүмүүсийг ч бас адил шийтгэдэг. Үнэхээр “Хууль цаазын өмнө хүн бүхэн эрх тэгш” гэж хэлж болмоор.

Гурав, Чингис хаан бол өсөл хяслын хэтийдэгч бөгөөд өршөөл хайрын үүдэгч мөн. “Өсөл хясал” болон “өршөөл хайр” гэдгийг аван үзэхэд хамт оршиж болшгүй мэт. Гэтэл энэ нь Чингис хааны бие дээр мөн амьд дүрслэгээр илэрч, түүний өвөрмөц зан чанар нь болжээ.

Чингис хаан бол Монголын нийгмийн дотоод гадаадын гүн гүнзгий өрсөлдөөн хямаргааны дунд төрж, хүнд сүрхий өсөл хяслын дунд бойжиж хүмүүжсэн юм. Тиймээс Чингис хаан хараахан багаасаа өшөө хорсол авах шантаршгүй хатуу зоригтой байв.

Чингис хаан өөрийн бүх насандаа дотоод гадаадын өстөн дайснаас өвөг дээдсийнхээ ба өөрийн биеийн өшөө хорслыг бүр санасан санаа, зорьсон зоригоороо авсан байна. Ингэхдээ тэр “цусыг цусаар, амийг амиар” хариулснаар барахгүй, олонхидоо бүр хэд дахин хэтрүүлж авдаг байна. Жишээлбэл, дотооддоо Татар, Тайчигуд, Мэргид зэрэг аймгийг хураан нэгтгэхийн хамт өшөө хорслоо авчээ. Ялангуяа Татар нар эцгийг нь алсан өштэй тул сүрхий хэцүүгээр өшилж байв. Гадааддаа өвөг дээдэс, үндэстэн угсаатныхаа өшил хяслыг авахын тулд юуны урьд Алтан улсад мөхлийн дайныг тулгасан бөгөөд өөрийн арилжааны брагид ба элчээ алуулан доромжлогдож, “Алтан аргамжаагаа Сартуул иргэнээр таслуулсан” өшлийг өшиж, хяслыг хясаж, Дундад Азийн их гүрэн Хорезм улсыг үнсэн товрог болтол мөхөөжээ.

Эдгээр явцад Чингис хаан түүний догшин ширүүн зан чанараа илрүүлж, өшөө хорслыг хэтэрхий хариулж, ард иргэдэд аюул түгшүүрийг ч учруулж байв. Энэ бол яриангүй феодал ангийн ноёрхогч болсон Чингис хааны харангуй тал нь болно. Гэвч Чингис хааны “хайр хорсол нь тодорхой” байдаг. Өөрөөр хэлбэл, тэр өөрийн дотно нөхөр, шударга сайд, өрлөг жанжин, үнэнч чадвартан болон шадар зарч нартаа туйлын өршөөл хайртай байдаг сан. Ингээд тэр олон тооны хүмүүсийн сэтгэлийг олж, их үйлсээ бүтээн чадсан юм. Тиймээс эртний Монголын түүхэнд өршөөл хайрыг үүдэгч нь бас Чингис хаан байжээ. Хүмүүс Чингис хааныг нэгэн өршөөл ихтэй хаан мөн гэж байгаа нь шалтгаангүй учир огт биш (“Монголчуудын нийгмийн байгууллын түүх”, 164 нүүр) гэж Владимирцов хүртэл нотолж байв. Энэ талаар бас арвин үлгэр домог байдаг билээ. Жишээлбэл, Монголыг нэгтгэх дотоодын дайны талбараас олж авсан Хүчү, Хөхэчү, Шигихутуху, Борухул зэрэг үнэнч дөрвөн өнчин хүүхдийг өөрийн дүү болгож асран бойжуулсан, Чингисийг дайсагнан эсэргүүцэж байсан Зэв, Хадаг баатар нарыг уучилж дотноор нөхөрлөсөн, дайсантай байлдах бүр урьдаар хүн томилж бууж өгвөл ялыг хэлтрүүлнэ гэж хэлүүлж байсан зэрэг болно. Үхлийн их дайсанд ч арга мухардсан үед нь уучлах бодлогыг авдаг.

Жишээлбэл, Чингисийн нэгдлийг дайсагнагч Жамуха ганц биеэрээ баригдан ирсэн үед:

“Одоо бид хоёул

Ойртож бас нөхөрлөе.

Өнө болох үед чи

Өрөөсөн арал болоод

Өөр санаа агуулахгүй буй за.

...

Өөр замаар

Явсан боловч

Өлзийт сайн нөхөр минь

Мөн билээ чи”

гэж уучлах санаагаа илтгэжээ. Сүүлд нь Жамуха-гийн гуйчлалаар сая алжээ (“Нууц товчоон”-ы 200 дугаар зүйл). Хорезмд дайлж байх үед, хүчирхэг дайсан Джалал-ад-Дин султан хамаг эцэс дийлэгдэж Инд мөрөнд ганц мориор харайлган орж умбан дутаахад, Чингис хаан бүх цэрэгтээ зарлиг болгоод харвахыг зогсоож, Джалал-ад-Дин-ийг аюулгүй гаталган явуулсан билээ. Үүнээс гадна, Чингис хаан санаачлагагүйгээр осолдогсдыг ерөөс уучилж байдаг. Баруунш Хорезмыг дайлж байхад Шигихутуху нэгэн удаагийн байлдаанд дийлэгдсэн боловч, түүнийг буруушаасангүй явдал бол Чингис хааны өршөөл хайрын уужуу зан чанарыг харуулж байна. Чингис хааны уур хилэнгээ дарж чадах эрхэм нандин зан чанарын тухай хүмүүсийг

бишрүүлэм гэрч баримт олон арвин байдаг. Ерийн байдал дор ял хийснийг маш чанга ширүүн шийтгэдэг боловч, чухалтай үес ихээр уучлах нь ашигтай гэснийг тэр мэдэж байв. ... Чингис хаан цэрэг ангидаа хамгийн чанга цэргийн цааз, хаант улсдаа хамгийн бат эмх дэглэмийг байгуулсны дагуу, тэр ямагт эрх чөлөөг эрхэмлэж, уужуу талбиу энэрэнгүй өршөөлтэй байсан юм (Владимирцов: “Чингис хаан”, 16 дугаар бүлэг).

Чингис хаан баруунш Хорезм улсыг дайлаар мордох үед: Иргэнийг асрах ёсон нь эх үнээ мэт, дайсныг дарах ёсон нь шаах шувуу мэт (“Богд Чингис хааны байлдааны бичиг”-ийн оршил) гэж хэлсэн үг бол түүний ард түмэндээ ба дайсанд хандах овор болно.

“Алтан биеэ амсу хэмээвээс

Аху төр минь алдруузай

Бүтэн биеэ амсу хэмээвээс

Бүрэн улс минь сандруузай

Алтан бие минь алжааваас алжаатугай

Аху төр минь бүү алдартугай

Бүтэн бие минь зовбоос зовтугай

Бүрэн улс минь бүү сандартугай”

гэсэн “Чингис хаан улс юугаа хайрлах” энэхүү өршөөл хайрын зан чанар нь улс орноо хайрлах эрхэм дээд билиг сургаал болон төвлөрчээ.

Дөрөв, Чингис хаан бол “Мөнх тэнгэр”-ийг шүтэгч бөө мөргөлийн сүсэгтэн боловч, мухар бишрэлтэн биш. “Монголын Нууц товчоон” зэрэг түүх шастирыг үндэслэвэл, Чингис хаан “Мөнх тэнгэр”-т даатгадаг тэмдэглэл өдий төдий байдаг билээ. Жишээлбэл, Чингис хаан залуу бага байхдаа Тайчигудаас дутаан шугуй дотор гурав хонож, морио хөтлөн гарч ирэхэд нь эмээл нь битүүгээр мултран унасанд, “Тэнгэр ятгаж байгаа болов уу?” гэж бас гурван хоног хүлээжээ. Дахиад гарч ирэхэд нь нэгэн гэрийн чинээ цагаан чулуу замыг нь бөглөсөн байв. Бас “Тэнгэр ятгаж байгаа болов уу?” гэж дахин буцаж гурав хоножээ (“Нууц товчоон”-ы 80 дугаар зүйл). хоёрдугаар жишээ нь, мөн Чингис хааны бага залуугийн үед, гурван Мэргид гэнэт дайрч шинэхэн урагласан гэргий Бөртэ үжинийг нь булаан явсан хойно өөрөө Бурхан Халдун уул дээр гарч, “...өнчин бидний өмөг болсон өндөр дээд Бурхан Халдун чамайг өглөө бүр мялааж байя! Өдөр бүр тахиж байя! Үрийн үрд үүрд тахиж үе тутам үргэлж шүтэе!” гэж бүсээ хүзүүндээ өлгөж, малгайгаа гарт сэгэлдэрч (өлгөж - хө.), гараараа өвчүүгээ дарж наран өөд хандаж Бурхан Халдунд есөнтөө сөгдөж, өчлийг өчин, сацлыг сацав (“Нууц товчоон”-ы 103 дугаар зүйл) гэдэг. Гуравдугаар жишээ нь, Тайчигудыг дарах Тэр цагт Чингис хаан, тэнгэр эцэгтээ мөргөө гэж Товцог Өндөр дээр гарч, тохмоо дэлгэж тавиад бүсээ хүзүүндээ өлгөж залбиран өчив:

Эрэмгий сайнаар

Эзэн эс боллоо, би

Эрхт тэнгэр

Эцгийн хайраар

Эзэн боллоо, би

Эцэг тэнгэрийн ачаар

Эсрэг дайснаа дарлаа, би ...

гэж мөргөв (“Нууц товчоон”, Ц.Дамдинсүрэнгийн одоочилго, 149 дүгээр зүйл) гэсэн тэмдэглэл байдаг. Бас “Муу өндөрийн байлдаан”-д Өгөөдэй шархтаж цэргээсээ хоцорсонд Чингис хаан өвчүүгээ дэлдэж “Мөнх тэнгэр мэдтүгэй” гэж даатгаж байсан (“Нууц товчоон”-ы 172 дугаар зүйл) билээ. Дөрөвдүгээр жишээ нь, Чингис хаан гадагш цэрэглэхээс өмнө бүр “Мөнх тэнгэрт даатгалаа” гэдэг бөгөөд зарим тэмдэглэлд ганцаар довын дээр барьсан нэгэн гэрт гурван хоног сууж даатгадаг байсан гэж тэмдэглэсэн байв.

Чингис хаан бол “Мөнх тэнгэр”-ийг шүтэгч бөө мөргөлийн сүсэгтэн (бас онгодын шүтээнтэн гэдэг) болохыг эдгээр явдлууд гэрчилж байна. Энэ бол тухайн тэр үеийн Монголын нийгмийн байдалтай тохирч байна. “Бөө мөргөл” бол эртний Монголын нийгмийн балас (уугуул - хө.) шашин шүтээн болохоор үл барам, арван гуравдугаар зууны үеийн гол шашин шүтээн нь болж байжээ. Арван гуравдугаар зууны дөчөөд онд монголд айлчилсан анхдагч Европын хүн Плано Карпини гэгч Монголчууд идуга гэдэг нэгэн шүтээнд мөргөдөг. Бас галыг хамгийн ариун зүйл гэж үздэг гэж тэмдэглэж байсан бөгөөд түүнээс хориод жилийн сүүлд ирсэн Италийн алдарт жуулчин Марко Поло бас Тэд бас нэгэн надагай хэмээх сахиулсыг тахимой. Түүний дүрийг нь эсгий буюу эсхүл бус бөс мэтсийн юмаар бүтээсэн буй гэж тэмдэглэж байв. Энэхүү “идуга” буюу “надагай” гэсэн нь эм бөө “удган” (зарим оронд удган, этүгэн гэж ч нэрлэдэг) гэсэн үгийн эртний дуудлага буюу хувирал болох мэт. Чингис хааны дэгжрэлтийн үед Хорчи, Усун, Хөхэчү мэт бөө нар Монголын ард түмний мухар бишрэлд автагдсан хоцронгуй байдлыг ашиглаж, Чингис хааныг улсын эзэн болгох суртал агуулгын бэлтгэлийг хийж байсан бөгөөд 1206 онд Хаант Монгол Улсыг байгуулсан хойно бөө мөргөл нь хууль ёсны байр суурьтай болжээ.

Арван хоёр, арван гуравдугаар зууны үед, Монголын зарим аймгуудад, тухайлбал, Найман, Хэрэйд, Онгуд зэрэг аймгуудад Христосын шашны несториан бүлэг мэтийн бусад шүтлэг ч дэлгэрч байв. Гэтэл, Тэр үеийн Монголд бөө мөргөл гол шашин болж байсан тул Чингис хаан ба түүний залгамжлагчид нь дэмий хүндэтгэн үздэггүй байсан гэж “Азийн түүх” (Японы) гэдэг номд тэмдэглэж байв. Энэ нь үндсэндээ бодот байдалтай тохирох юм. Гэвч Чингис хаан бусад шашинтныг гадуурчилдаггүй бодлогыг нэлээд зөв хэрэгжүүлж байсан нь ч бодтой учир юм. Чингис хааны сайд түшмэд ба хэрэглэж байсан хүмүүсийн дотор олон янзын шүтлэгтнүүд байжээ. Жишээлбэл, мусульманчууд (Сартуулын), бумбын шашинтнууд (Хятад, Хятан зэргийн), Буддын шүтлэгтнүүд (Тангудын), несторианчууд (Хэрэйд, Найманыхан)

зэрэг болно. Чингис хааны цэрэг хар Хятаны улсыг эзлэн авахад, дээрх олон зүйлийн шашин шүтлэгт зөв төрийн бодлогыг авснаас хүний сэтгэлийг ихэд олж, байлдааныг маш түргэн дуусгажээ.

Гэвч, Чингис хаан хэдийгээр энгийн нэгэн бөө мөргөлийн шүтлэгтэн болох боловч, мухар бишрэлтэн биш юм. Дээр дурдсан мэтээр, тэр Тайчигуд аймгаас дутаан “Тэнгэр ятгаж байгаа болов уу?” гэж шугуй дотор ес хоног хоолгүй суусан боловч, эцэстээ “Энэ мэт нэргүй үхэхээр гарья” гэж “тэнгэрийн ятгал”-ыг хайхарсангүй гарч явав. Энэ нь “Хүн хоол идэхгүй бол өлбөрч үхнэ” гэсэн бодосч үзлийг итгэж, “тэнгэрийн ятгал”-ыг итгэсэнгүй гэдгийг харуулж байна. Ялангуяа, Чингис хааны өөрийн биширч байсан Мүнлиг эцгийн хөвгүүн Хөхэчү мэтийн маш их эрх сүртэй бөөг зангилааны үед амийг нь эцэслүүлж, сүрийг нь дарсан явдал нь, Чингис хаан бол эрх хүчийг л итгэдэг бодосч үзэлтэн болоход төстэйгээс биш, шашин шүтлэгэд автсан мухар бишрэлтэн биш гэдгийг харуулж байна. Тиймээс Чингис хаан эрх хүчээ өргөтгөхийг хэзээд аль нэгэн шүтлэгээс илүү хүндэтгэж байдаг юм.

Багцлаад хэлбэл, бүх монгол үндэстний эрт урьдын түүхэнд Чингис хаан адил агуу их хүн тэр ганцаараа байсан юм. Тэр, үймээн тэмцээнтэй цаг үед төрж, нэг насаараа морины нуруунаас буусангүй, хуяг дуулгаа тайлсангүй, зэр зэвсгээ тавьсангүй, дайны талбараас салсангүй бөгөөд мөн энэхүү талбар дээр амь насаа эцэслүүлжээ! Ийм нэгэн хүний үзэл санаа, зан чанар бол өвөрмөц онцлогтой байх нь яриангүй юм. Тэр бол ер бусын үйл ажиллагааг эрхэлж, ер бусын үр дүнг бүтээсэн ер бусын хүн болно!

71. Чингис хааныг яаж үнэлэх вэ?

Чингис хаан бол нэгэн дэлхийн чанартай түүхэн хүн болохоор, улсын дотоод гадаадад эрт урьдаас аваад хүмүүсийн анхаарлыг сүрхий татаж, янз бүрээр үнэлэн шүүмжлээд ирснийг бид тус бүлгийн дагалдвар¹-д төлөөлөгч чанартайгаас нь цөөн хэдийг танилцуулав. Үүнд адил бусын улс үндэстний адил бусын ангийн адил бус үзэлт, адил бус шашинтан, адил бус ажил үйлсийг эрхлэгчдээс адил бусын цаг үеүүдэд нийтэлж илтгэсэн үнэлэлт шүүмжлэл багтаж байна.

Эдгээрийг ерөнхийд нь хураангуйлаад үзвэл гурван зүйлээр ангилж болох мэт.

(Нэг) Чингис хааныг бүх талаар нотолж магтсан үнэлэлт.

(Хоёр) Чингис хааныг хагас нотолж, хагас үгүйсгэсэн үнэлэлт, тухайлбал түүний өмнө хагас нас буюу Монголыг нэгтгэснийг нь нотолж, түүний сүүлчийн хагас нас буюу гадагш дайлсныг нь үгүйсгэсэн үнэлэлт.

(Гурав) Чингис хааныг бүх талаар бүрмөсөн үгүйсгэдэг ба харааж зүхсэн үнэлэлт зэрэг болно.

Бид бол Маркс Лениний үзэлт болохоор, ямарваа асуудлыг үзэхдээ хэзээд хувьсангүй бодосч үзэл (диалектик материализм - хө.) ба түүхийн бодосч үзэл (түүхийн материализм - хө.)-ийг баримталдаг юм. Ленин: Нийгмийн ямар ч асуудалыг задлах үес, Марксын үзлийн онолын шилжишгүй шаардлага бол, асуудлыг түүхийн зохих хэмжээнд тавих явдал мөн (“Лениний

сонгомол зохиол”, 2 дугаар боть, доод дэвтэр, 848 нүүр) гэж хэлэв. Нөхөр Мао Цзэ Дун: Ленин хэлэхдээ, бодтой байдлыг бодтойгоор задлах нь Марксын үзлийн хамгийн мөн чанар бүхий зүйл, Марксын үзлийн амьд сүнс мөн гэжээ (“Мао Цзэ Дун-ы сонгомол зохиол”, 3 дугаар боть, 146 нүүр) гэж зааж гаргасан байна. Тиймээс, бид энэхүү бодтой түүхэн хүн - Чингис хааныг үнэлэхдээ:

Нэгд, одоогийн байдал, одоогийн баримжаагаар биш, харин Чингис хааны амьдарч байсан арван хоёрдугаар зууны сүүлч буюу арван гуравдугаар зууны эхэн үеийн Монголын нийгмийн байдал, түүний орчин тойрон - Дундад улсын байдал ба дэлхийн байдлын бодот “түүхийн хүрээнд аваачиж” үзэх нь зүйтэй юм. Тийм бол, бид түүхийн хөгжилтөд үзүүлсэн үйлдлээр нь үнэлэх хэрэгтэй. Хэлэлгээнгүй ард түмэн бол түүхийн хөдөлгөгч хүч мөн гэдэг бол хэзээ ч хувирашгүй үнэн ёс юм. Гэвч ард түмэн түүхийг ахиулах хүч болохдоо мөн ч заавал түүний “Улс төрийн удирдагч” ба “Тэргүүний төлөөлөгч” байх хэрэгтэй. Учир нь, Түүхэн дээр ямар ч нэг анги хэрвээ хөдөлгөөнийг чадамгай зохион байгуулж чадамгай удирддаг улс төрийн удирдагч ба тэргүүний төлөөлөгчөө дэвшүүлэн гаргахгүй бол ноёрхох байр суурийг олж чадахгүй юм (“Лениний сонгомол зохиол”, 1 дүгээр боть, дээд дэвтэр, 349 нүүр). Чингис хаан бол Монголын феодал язгууртны гарамгай төлөөлөгч нь болж байжээ. Олон улс үндэстний түүхийг хянаж үзэхүл, ямар нэгэн улс үндэстэн ч болтугай, тухайн үеийн хөдөлгөөнийг чадамгайгаар зохион байгуулан удирдаж байсан “улс төрийн удирдагч” ба “тэргүүний төлөөлөгч” нь олонхидоо язгууртан ангийн тэргүүний хүмүүс байдаг буюу хаяа заримдаа доорд гаралтай хүмүүс байсан ч, тэр нь ийм байр суурийг олсныхоо хойно мөн ч язгууртан болон хувирсан жишээ зөндөө байдаг. Чингис хаан бол тухайн үедээ яг ийм “улс төрийн удирдагч”, “тэргүүний төлөөлөгч” байсан гэж хэлж болно.

Хоёрт, Бодтой асуудалд бодтойгоор хандах арга бол үнэнээс зөвийг эрэх, асуудлыг чухамхүү байдлаар нь зөв тусгах овор болно. Тиймээс би Чингис хаанд бүрмөсөн нотлох, бүрмөсөн үгүйсгэх буюу хагас нотолж хагас үгүйсгэх аргаар хандсангүй, харин түүний чухал чухал түүхэн хэргүүдийг нь нэг нэгээр задлан судлах аргаар ханджээ. Бодтойгоор хэлбэл, Чингис хааны өмнө хагас нас буюу бүх Монголыг нэгтгэсэн үйлст нь назгай тал буюу харангуй тал өчүүхэн ч үгүй, цөм нутлуштай гэж үзэж болохгүй. Харин аль нь гол болж, аль дэдлэхийг үзэх хэрэгтэй. Энэ үед Чингис хаанд харанхуй тал ч байж байсан юм. Жишээлбэл, Татараас өшөө авахын тулд хэтэрхий алан хядсан, бүх Монголыг нэгтгэсэний дараа, урт удаан хугацааны дайн дажины шарх гэмийг сувиалан засаж, улс үндэстнийхээ энх тайван хөгжилд бүх хүчээ төвлөрүүлсэнгүй мөртөө өргөн хэмжээний гадагш дайралт хийсэн зэрэг болно. Гэвч энэ хугацаанд идэвхи үйлдэл нь гол байрыг эзэлж, назгай үйлдэл нь гол бус байрыг эзэлж байсан нь дамжиггүй юм. Тиймээс энэ хугацааг нь үндсэндээ нотолвол зүйтэй.

Чингис хааны сүүлчийн хагас нас буюу гадагш дайлан дайныг нь ч мөн энэ аргаар үнэлэх хэрэгтэй. Тиймээс Чингис хааны гадагш дайралтыг нь тухайн үеийн үүсэл ба бодтой байдлаар нь задлан судалж, дээрмийн дайн гэж үзсэнгүй. Учир нь, нэгэн бүрэн эрхт улс үндэстэн түүний халдашгүй эрх хүнд ба ашиг сонирхлоо хамгаалах явдал, ялангуяа энэхүү эрх хүнд ба ашиг сонирхол нь бусдад ёс бусаар халдсан үед тэр улс үндэстэн нь бус ч өөрийн эрх хүнд ба ашиг сонирхлоо хамгаалахын төлөө хариу авах буюу сэрэмжлүүлэх явдал бол эртний нийгмийн байгуулал дор аль ч улс оронд бүр гарч байснаар барахгүй, одоогийн дэлхий дахины аль ч улс үндэстэнд мөн гарсаар байна. Энэ нь бүр зүй ёсонд нийлэлцэх

шударга үйлс юм. Тиймээс өөр улсын нутаг дэвсгэр дээр хийсэн дайн бүхнийг түрэмгийлэл буюу дээрмийн дайн гэж үзэхэд хүрвэл одоо үеийн боловсон дэлхийд гарсаар байгаа маш олон явдлыг тайлахад бэрх юм.

Хэрвээ бодтой асуудалд бодтойгоор ханддаг бол ойлгошгүй учир явдал гэж үгүй. Алтан улс Монголын ард түмнийг тархай бутархай, дорой буурай байх үед тэр мэт алан хядаж, талхин дээрэмдэж, завсардуулан салгаж, эцэг дээдсийг нь хүртэл харгис хэрцгийгээр тамлан хорлосон ба Хорезм улс Монголын энх тайван худалдаачныг хүйс тэмтрэн алснаар барахгүй, бүрэн эрхэт төрийн элчийг нь бас алахыг нь алж, гутаахыг нь гутаасан байдал доор Чингис хаан мэтийн догшин ширүүн хаан хариу авахгүй гэдэг бол харин үнэнхүү ойлгошгүй хэрэг юм. Ийм байдал тэр үед байтугай, одоогийн дэлхий дахины ямар нэгэн улс үндэстэнд тулгараад, тэр улс үндэстний удирдагч бүлгэм буюу ноёрхогч бүлгэм нь хариу авахгүй буюу ямар ч тусгалгүй суудаг бол тэр ноёрхогч бүлгэм нь өөрийн ард түмэндээ тушаахын аргагүй юм. Хэдийгээр Чингис хааны гадагш дайлсан дайн нь “үндэстний дарлалыг эсэргүүцэх шударга чанартай” байсан боловч, дайны явцдаа тэр дайлагдсан орны ард түмэнд аюул түгшүүрийг учруулж, уучлашгүй ял хийжээ. Тиймээс Чингис хааны гадагш дайлсан дайныг ч мөн бодтойгоор задалж, нотлох талыг нь нотолж, үгүйсгэх талыг нь үгүйсгэвэл зохино. Харин бүрмөсөн нотлох буюу бүрмөсөн үгүйсгэх аргыг авсангүй.

Бид ямарваа хэрэг бодосыг нэгийг хоёрлох Марксын үзлийн аргаар үздэг бол, Чингис хааны гадагш дайлсан дайн нь алж хядсан ба эвдэлж сүйтгэсэн назгай нэгэн тал байхыг олж үзэхийн хамт, өрнө дорнын харилцаа нэвтрэлцээг нээж, хүн төрөлхтөний боловсон соёл гэгээрлийг нэн өргөн хэмжээнд дэлгэрүүлэн солилцсон идэвх үйлдлийг ч олж үзэх хэрэгтэй. Плано Карпини, Рубрук, Марко Поло нар бол Чингис хааны цэргийн замаар дорно дахинд ирсэн анхдагч Европ хүмүүс гэж хэлж болно. Түүнээс гурван зуугаад жилийн дараа Колумб Америк тивийн их хуурайг олж мэдэхдээ тэр энэ их хуурайг олъё гээд явсан биш, харин Испанийн вангаас Дундад улсын хаанд өгсөн төрийн бичгийг барьж, Дундад улсад очно гэж, Марко Поло-гийн буцсан далайн замаар явсаар байгаад санаандгүйгээр Америк тивд хүрсэн бөгөөд түүнээ Энэтхэг гэж эндүүрээд “Баруун Энэтхэгийн олтриг” гэж нэрлэсэн ба тэндэх хүмүүсийг “Индиан хүн” гэж нэрлэжээ. Дорно дахины боловсон соёл ч мөн Чингисийн “Морин төвөргөөн”-ий хамт өрнө дахинд гүнзгий дэлгэрчээ. Тиймээс Чингисийн дайны нөлөө бол дэлхийн чанартай гэдгийг эдгээр жишээ амьдарлагаар харуулж байна.

Гуравт, Чингис хаан олон хүн алсан гэдэг асуудлыг бид бас бодтойгоор задлан судлах хэрэгтэй. Чингис хаан урт хугацаагаар өргөн хэмжээнд дайн байлдаан хийж байсан болохоор, тухайн үеийн ард түмэнд үхэл мөхлийн аюулыг учруулж байсан нь мэдээжийн хэрэг юм. Гэвч Чингис хаан чухам хэдий хүн алсан тухай оновчтой тоо баримт ерөөс байгаагүй бөгөөд дайн байлдааны бодтой байдал дор тийм оновчтой тоо бүртгэлийг хийх нөхцөл бололцоо тэр үед байсангүйгээр үл барам, одоо хийхэд ч маш нарийн төвөгтэй юм. Одоо манай мэдэж байх Чингис хааныг олон хүн аллаа гэдэг тоо баримт бол бүр дам сонсгол буюу бараглан жишсэн тоо болох бөгөөд ялангуяа түүний дотор санаатай санаагүйгээр нэмж хассан тоо ч бүр байх юм. Жишээлбэл, Чингис хааны цэрэг Хорезмын хуучин нийслэл Ургенч хотыг эзэлсний дараа, монгол цэрэг нэг бүрд хорин дөрвөн хүн хувьтан өгч алуулав гэдэг. Тэр үед монгол цэрэг таван түмэн хүн байж гэлээ. Ингээд бодвол яг монгол цэрэгт баригдсанынхаа хойно алагдсан хүн нэг зуу хорин түм болох нь дамжиггүй. Бас Ургенч-ээс Монголд хүрсэн

дархан арван түмэн хүн байжээ (дээрх тэмдэглэлийг “Д’Оссоны Монголын түүх”-ийн нэгдүгээр ботийн долдугаар бүлгээс эшлэв). Монгол цэрэг Ургенч хотыг зургаан сар байлдаад эзэлж дийлсэнгүй байдлыг Чингис хаанд мэдүүлж байсан юм. Чингэвэл энэ зургаан сарын байлдааны явцад хүн үхсэнгүй гэж үү? Сүүлд нь зуун хорин түмийг нь алаад, арван түмийг нь олзлоод бас хүн үлдсэн үү үгүй юү? Ингээд бодвол Ургенч хот тухайн үедээ хэдий хүн амтай байсан бэ? гэх мэтийн асуултыг тавьж болно.

Энэ тоо баримтыг тун их сэжиглэлтэй гэж би үзэж байна. Учир нь дээрх тэмдэглэлээр үздэг бол тухайн үеийн Ургенч хот нь ядахдаа зуун тавь, жаран түмэн хүн амтай их хот байсан нь дамжиггүй байна. Чингэвэл бүх Хорезм нь хэдий хүнтэй болох вэ? Хорезмын бүх улсын цэрэг нь сая дөчин түм байлаа гэж мөн Д’Оссон нар тэмдэглэж байв. Одоо нэг алхам ухраад, Ургенч-ийг төдий хүн амтай байсан гэж үзсэн ч болно. Гэтэл зуун хорин түмэн хүнийг яаж алсан гэдэг бас нэг асуулт тавигдана. Хүн бүхний мэдэж байх ёсоор, арван гуравдугаар зууны үеийн хүн төрөлхтний нийгмийн үйлдвэрлэлийн хүчний хир хэмжээ бол сэлэм, жад, нум, сум мэтийн хүйтэн зэвсгийг л үйлдвэрлэж чадах хэмжээтэй байжээ. Ийм байдалд нэг зуун хорин түмэн хүнийг ална гэдэг чинь тийм хялбар уу? Нэгхэн хүн хутга сүх бариад хорин дөрвөн хүнийг алж байтал, тэр хорин дөрвөн хүн яагаад эсэргүүцдэггүй вэ? Энэ бол зөвхөн энэ нэгэн тоо тэмдэглэлийн хувьд тавьсан асуулт болно. Нөгөө талаар бид одоо үеийн байдалтай харьцуулан адилтгаж, түүний боломжийг басцаашид судалж болно. Жишээлбэл, хүн төрөлхтний түүхэнд хамгийн сүрхий хөнөөгч зэвсэг бол атом бөмбөг болно. 1945 оны 8 сарын 6 ы өдөр, Америкийн агаарын цэрэг Японы Хирошима хотод анхдагч атом бөмбөгийг дэлбэрүүлсэн бөгөөд гурван өдрийн дараа хоёрдахи атомын бөмбөгийг Нагасаки хотод дэлбэрүүлэв. Тэрхүү хүн төрөлхтний түүхэнд анхдагч атомын их аюулд Хирошима хотын хохирогдсон хүн найман түмээд байсан бөгөөд бүх хотын хүн амын дөрөвний нэгийг эзэлнэ гэдэг (Лидадел Харт: “Дэлхийн хоёрдугаар их дайны түүх”). Нагасаки хотод хохирогдсон хүн долоон түм гурван мянга гаруй байжээ. Хоёр хот нийлээд арван таван түм гаруй байв. Үүнийг Чингис хааны цэрэг Ургенч хотод алсан “Зуун хорин түмэн хүн”-тэй харьцуулбал тооны талаар хол цөөн байна. Гэтэл тэр нь үнэндээ түүхэнд байсангүй туйлын их аюул юм. Хэдийгээр тийм боловч Хирошима, Нагасаки-г бүрмөсөн мөхөөж чадсангүй. 1950 оны бүртгэлээр үзэхүл, Хирошима-д 258.700 хүн, Нагасаки-д 242.000 хүнтэй байв.

Дөрөвг, бид Чингисийн хийсэн дайныг багтаасан аливаа дайны тухай зөв үзэлтийг авах хэрэгтэй. Хүнийг алахаас илүү аюул, дайны эвдлэл талхидалаас илүү хөнөөл байдаггүй. Ард түмэн дайн дажиныг ер хүсдэггүй. Гэтэл дайн бол хүн төрөлхтний нийгэмд хувийн эд хөрөнгө буй болж, эсэргүүцэлдсэн анги буй болсноос нааш үүссэн бусдачаар оршиж бүхий нийгмийн үзэгдэл болно. Хүн төрөлхтөн нэгэнтээ хэдэн мянган жилийн дайны амьдралыг өнгөрөөжээ.

“Дайн - Хүн төрөлхтөний харилцан алалдагч жигтэй үзэгдэл” нь бас хүн төрөлхтөний нийгмийн хөгжилтийг дагалдаж, улам хөгжиж, улам өргөжсөөр байна. Зөвхөн дэлхийн хэмжээний их дайнаар хэлэхэд, хүн төрөлхтөн нэгэнтээ хоёр удаагийн их дайны аюулыг өнгөрөөв. Ямар нэгэн хэсэг талын дайн ерөөс тасраагүй бөгөөд энэхүү аюул нь явах тутам ихдэж байв. 1914 оноос 1918 онд эзэрхэг түрэмгий улсуудын хооронд явагдсан дэлхийн анхдугаар дайнд гучин гурван улс оролцож, арван таван дүншүүр илүү хүн ам хамрагдан дайрагдаж, алагдаж шархдсан нь гурван мянган түм шахам хүн байв. 1939 оноос 1945 онд

Герман, Итали, Японы Фашистын дэгдээсэн дэлхийн хоёрдугаар дайн бол хүн төрөлхтөний түүхэнд урьд өмнө урьд өмнө ер байсангүй юм. Энэ удаагийн дайнд урьд хожид оролцсон улс орон нь жар гаруй байсан бөгөөд хорин дүншүүр илүү хүн ам дайнд хамрагдан орж, зургаан мянган түм хүн хохирлоо гэдэг юм. Энэ нь харин үнэнхүү аюул, гамшиг, мөхөл, хөнөөл юм! Гэтэл энэ бол машинжсан үе буюу цахилгаанжсан үеийн аюул болно. Одоо нэгэнтээ атомын үеэс дэвшиж электроны үе болоод байх бөгөөд дайны хэнээтнүүд шинжлэх ухааны шинэ шинэ дээжийг бүр юуны урьд хүн алах ашиглалтад оруулсаар байна!

Бид бол Марксын үзэлтэн болохоор юуны урьд дайныг эсэргүүцнэ, гэвч бид дайн бүхнийг эсэргүүцэх биш, бодтой байдлыг бодтойгоор задалж, аливаа шударга дайныг бол эсэргүүцэхгүй мөртөө дэмжнэ, аливаа шударга бус дайныг туйлбартай эсэргүүцнэ. Түүхэн дэх дайнд ч ингэж хандах хэрэгтэй.

Бид дайныг хэзээд зорихгүй, хүн төрөлхтөн дайнгүй бол нэн хурдан хөгжих ёстой. Гэтэл бид бас дайны гутарагчид биш. Хүн төрөлхтөний түүхэн дэх хэдэн мянган жил явагдсан дайн нь хүн төрөлхтөнд хүнд хохирлыг учруулсан боловч хүн төрөлхтөнийг бүрмөсөн хөнөөж чадсангүй бөгөөд нийгмийн хөгжил, шинжлэх ухаан техник мэргэжлийн дэвшилт тасраагүй урагшилсаар байна. Хүн төрөлхтөний дэвшил хөгжил нь эцэстээ энэхүү “хүн төрөлхтөний харилцан алалдагч жигтэй үзэгдэл” - дайныг бүрмөсөн устгаж чадах юм.

Миний товч дүгнэлт: Чингис хааныг үнэлэхэд бусад аливаа хэрэг бодосч хандахтай адил, бодтой асуудлыг бодтойгоор задлан судлах хэрэгтэй. Бүрмөсөн нотлох биш, бүрмөсөн үгүйсгэх биш, эсхүл түрүү хагас насыг нь бүрмөсөн нутлаад, сүүлчийн хагас насыг нь бүрмөсөн үгүйсгэх ч биш, харин үнэнээс зөвийг эрэх овроор хэдий нутлах зохистой бол төдий нуталж, хэдий үгүйсгэх зохистой бол төдий үгүйсгэвэл зүйтэй. Нутлалтын дунд үгүйсгэл байж болох бөгөөд үгүйсгэлийн дунд нотлол ч байж болно.

Чингис хааныг ерөнхийд нь авч хэлбэл, тэр бол монгол үндэстний түүхэн дэх агуу их улс төрийн зүтгэлтэн, цэрэг дайны зүтгэлтэн болохоор барахгүй, Дундад улсыг нэгтгэхэд, өрнө дорныг нэвтрүүлж, дэлхийн соёл боловсныг дэлгэрүүлэхэд балрашгүй үйлдлийг үзүүлсэн дэлхийн чанартай түүхэн хүн болно. Гэвч Чингис хаан бол тэр биеэрээ Монголын феодал язгууртан ангийн төлөөлөгч болохоор тэр өөрийн ангийн ашиг сонирхлын үүднээс үүсч Монголын ард түмэн болон дайлагдсан орны ард түмэнд сүрхий их дарлал мөлжлийг тулгасан нь ч мэдээжийн хэрэг юм. Энэ бол Чингис хааны харангуй тал буюу назгай тал нь болно. Түүний назгай үйлдэл ба идэвх үйлдлийг нь харьцуулж үзвэл, нийгмийн дэвшил хөгжилд үзүүлсэн идэвх үйлдэл нь назгай үйлдлээс илүү байсан нь ч лавгай үнэн хэрэг юм. Чингис хааныг чухам “хоёр наймаар хугаслах” уу? “гурав долоогоор хугаслах” уу? эсхүл “дөрөв зургаагаар хугаслах” уу? гэдгийг бас цаашид нарийн гүнзгий судлах хэрэгтэй. Чингис хаан бол үндсэндээ нутлууштай түүхэн хүн мөн гэсэн дүнг одоо олонхи хүмүүс зөвшөөрөх тийш хандаж байна.

Дагалдвар

1 Чингис хаан бол дэлхий дахины түүхэнд холбогдох түүхэн хүн болохоор эрт ба өдгөөд гадаад дотоодын анхаарлыг хүчтэй татсаар ирсэн бөгөөд түүний тухай янз бүрийн шүүмжлэл үнэлэлтийг хийсээр иржээ. Бид уншигчиддаа лавлалт болгох зорилгоор (харин тэр бүхнийг

хүлээн зөвшөөрсөн үүднээс биш) зарим төлөөлөх чанартай үнэлэлт шүүмжийг энд дагалдвар болгон сийрүүлэв. Ингэхдээ нэлээд өргөн хэмжээнд дэлгэрсэн, уншигчид ба зохиогч тус хүний ойлгож мэддэг буюу тэгж ч болохуйц хүрээн дотроос сонгов. Дэс дарааг нь монгол хүний өөрийн үнэлсэн, Дундад улсад үнэлсэн ба гадаад улсын хүмүүсийн үнэлсэн дараалалаар, тэрчлэн аль болохоор цагийн урьд хожидоор жагсаав.

“Монголын нууц товчоон” бол ерөнхийдөө Чингис хааны бүх үйл ажиллагаагаар хөтөлбөр болгож, эртний Монголын бодтой байдлыг тусгасан түүх юм. Гэхдээ Чингис хааныг ерөнхийлөн үнэлсэн зүйл ч өдий төдий байдаг. Жишээлбэл, бүх Монголыг нэгтгэх үйлс дэх эцсийн нэгэн гол дайсан этгээд Жамуха-гийн үгээр тэмдэглэсэн зүйл (201 дүгээр зүйл) бол ийм шинжтэй юм. Тэр нь:

“ ...

Тэмүжин чи

Түмэн улсыг

Төвшин болгож

Харь улсыг

Хамтатган захирч

Хамгийг эзэлсэн

Хаан болоод

Дэлхий дахин

Бэлэн байхад

Дэмий надаар

Юу хийх буй?

...

Энэ насан дотор

Эрхэм анд бидний

Энхрий нэр алдаршиж

Ургах нарнаас аваад

Шингэх нарыг хүртэл

Улс даяарт дуурсгав.

Сэргэлэн баатар чамд

Сэцэн эх заяажээ.

Эрэлхэг баатар андад

Эрдэмтэн дүү нар төржээ.

Далан гурван хүлэгтэй

Дархан өрлөг нөхөдтэй

Далай Чингис чамдаа

Дарагдаж мөхөв би” гэжээ.

“Лу. Алтан товч”д:

“Есүхэй баатар эцэгт,

Өгэлүн хатан эхт,

Есөн өрлөгүүд түшмэлт,

Ер таван өнгө дөрвөн харь улсыг

Эрхэндээ оруулсан,

Суут Чингис хаан эзэн минь.

Өгэлүн хатан эхт,

Өгөөдэй, Тулуй хувилгаан хөвгүүнт,

Өшөөтөн дайсныг өлмийдээ гишгэсэн

Суут хааныг байхад

Юунаас хайхрах билээ.

Хамтаар явбаас

Харьтан дайснаас

Юунд айх билээ.

Хунгийн зулзага мэт

Бүү гуйвалзая

Худалч муу хүний үгэнд

Бүү оролцоё.

Хатгалдахуй дайсан дор

Амь биеэ бүү хайрлалцая.

Ангирын зулзага мэт

Бүү найбалзая.

Алиа муу хүний үгэнд

Бүү оролцоё.

Алалцахуй дайсан дор

Амь биеэ бүү хайрлалцая” гэжээ.

Монголын ойр үеийн их бичгийн хүн Инжаннаши “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” гэдэг түүхэн романдаа: Үүнээс эзэн минь арван гурван наснаас эхлэн дээд эзний өшийг нэхэж цэрэг байгуулан, дөрвөн зүгт байлдан дайлж яван, махбодын гашуун ба барсын зовлон хийгээд өлсөх даарах гачигдах мохогдох хилсдэх дарлагдах хөөгдөх баригдах басамжлагдах доромжлогдох гүжирлэгдэх зэрэг зуун зүйл мянган ангийн зовлон зүдгүүр эдлэсээр өдгөө дөчин таван сүүдэр хүртэл, дөрвөн зүг найман зовхист цэрэглэн дайлан явж зэр зэвсгийн мод шугуйд шургалан, мах цусны мөрөн далайд умбаж, мянган удаагийн үхлээс гэтэлж, түмэн зэрэг мөхөхөөс мултран арайхийн гэж гучин хоёр жилийн хүчээр сая эргэн тойрон түмэн газрыг нийгэмлэж, хэд хэдэн чийрэг улсыг цөм оруулав (“Хөх судар”, 1981 оны хэвлэл, 1155 - 1156 нүүр) гэж Чингис хааны бүх Монголыг нэгтгэсэн хатуу шургуу тэмцэлийг нь дүрсэлжээ.

1935 онд Ли Бин гэгч нэгэн монгол сурагч “Агуу их Чингис хаан” гэсэн гарчигтай өгүүллийг “Шинэ Монгол” сэтгүүлийн нэгдүгээр ботийн хоёрдугаар хугацаанд нийтлүүлжээ. Түүний гол үнэлэлт нь доорхи мэт:

(Нэг) Чингис хааны агуу их дүр

Зарим хүмүүс Чингис хаан гэгч энэхүү дүрийг олонхидоо буруугаар ойлгож, түүнийг дарлан талхигч харгис эзэн гэх үгүй бол алаан хядаанаар хэнээрхэгч мангас гэдэг. Ингэж үздэгийн шалтгаан нь Чингис хаан зэр зэвсгээр бусад улс гүрнийг цэрэглэн дайлсан явдлаар баримт болгожээ. Харин Чингис хааны энэхүү ажиллагаа нь үнэнхүү дэлхийн соёл боловсныг зориуд эвдэхээр өөрийн үүргээ болгосон гэж үү? Үнэнхүү дээрэмдэл талхидлаар дээд жаргалаа болгосон гэж үү? Хэрвээ тийм бол агуу их хүн, баатар хүн эс болох мөртөө хүн төрөлхтөний анир ч үгүй мангас болох нь дамжиггүй. Гэтэл ингэж үзэх нь туйлын их чалчаа гүтгэл болно. Энэ мэт хөдхөөр (болхиор - хө.) шүүмжлэгч ба буруугаар дүрслэгчид, эсхүл дайлагдсан үндэстэн нь өөрийн доройтлоо өмөглөхийн төлөө ингэж үздэг ... эсхүл шашин шүтлэгийн адилгүйгээс болж, өөр шашинтан монгол хүний ажиллагааг жигшиж зориудаар муулдаг. ...

Өчүүхэн би Чингис хааны хойч үрсийн хувьд авч хэлбэл, өвөг дээдсийнхээ гүтгэгдэлийг цагаатгах үүрэг хариуцлагатай бөгөөд дээдсийнхээ агуу их зоригийг залгамжлаж бадруулах эрхтэй юм. Ингээд би түүх шастирыг дэлгэрэнгүйгээр уншиж, үнэн худлыг нь хянамгайгаар магадлаад, Чингис хаан бол хүний цусыг уугч мангас биш, түрэмгийлэл ба дайлан дагууллаар хэнээрхсэн зэрлэг санаатан ч биш, үнэндээ харин өршөөл энэрэлийн сэтгэлтэй, найр журмыг эрхэмлэж, ёс ёслолыг анхаардаг, учир шалтгаангүйгээр зэр зэвсгийг хөдөлгөдөггүй агуу их хүн гэдгийг эхлэн мэджээ. Хэлэлгээнгүй түүний зан чанарт алаан хядаанаас буцдаггүй нэгэн тал буй, энэ бол түүний оршиж агсан цаг үе ба орчин тойрноос шалтгаалсан арга бусын байдал доор бүрэлдсэн зүйл юм”.

(Хоёр) Чингис хааны улс байгуулсан их гавьяа

... Дэлхий дахинаа улс гүрнийг үүдэн байгуулагчид нь ард иргэдийн хүмүүжил боловсрол, эд гаралтын баян чинээлэг, зам харилцааны нэвтрэл зэрэг бусдач нөхцөлийг бүрэлдүүлдэг билээ. Гэтэл Чингис хаанд ийм нөхцөл байсангүй бөгөөд тэр бол хоцрогдонгуй Монголын өндөрлөгт өсөн бойжсон үндэстний баатар юм. ... Чингис хаан аливаа хүчир бэрхшээлээс халширсангүй, Онон мөрний хөвөөнөө оройлон босч, цөөн тоот аймаг угсаагаа дайчлан, Тайчигудыг мөхөөж, Ван ханыг няцааж, Алтан улсын хүчийг ашиглан Татарыг устгаж, Найманы Таян ханыг сөнөөж их орыг суугаад умар дахиныг нэгтгэв. ...

Чингис хааны цэргийн хүч хүрсэн газрыг бүртгэвээс, баруунш Дундад Азийн Хорезм болон Каспийн тэнгисээс баруунш Орос хүртэл, өмнөш Энэтхэг хүртэл явсан бөгөөд хойш умар дахиныг нэгтгэжээ. Энэхүү үр дүнд Дундад Азийг төвшитгөж, улс гүрнийнхээ суурийг тавьсан тул түүний хойчид үе улиран их орыг залгамжлан, төр улсын буяныг мандуулан, нутаг дэвсгэрээ өргөтгөж, дорно өрнийн соёл боловсныг нэвтрүүлжээ. ... Чингис хааны нэгэн аймаг нь говийн умардад мандаж, ... хэдэн арван жилийн дотор дэлхийн бөмбөрцгийн зүүн хагасыг хэдэнтээ дайралсан нь үнэхээр түүхэн дэхи нэгэн догшин хуй салхи мэт ... гэж Лян Ци Цао үнэлж байв. Түүний сөс зориг хэчнээн баатар, сүр алдар хэчнээн их гэдгийг үүнээс мэдэж болно .

(Гурав) Чингис хааны дэлхийн соёлд оруулсан хувь нэмэр

Дундад улсын үндэстний байдал маш будлиантай билээ. Жишээлбэл, Хятан, Жүрчин, Тангуд

бүр хятад үндэстэнд хайлагдсан тул тэдний соёл ч Дундад улсын соёлын хэмжээнээс гарахгүй юм. Гэтэл Чингис хаан умар дахинд мандаж, нутаг дэвсгэрээ өргөтгөн, Энэтхэг, Араб, Хятадын ба Европын соёлоос шингээн авч, гоё сайхан өвөрмөц соёлыг бүтээсэн явдал нь харь үүлдрийн хуараас дэлгэрсэн анхилам үнэрт хурц соргог өнгийн цэцэг мэт байв. Дундад улс ба өрнө дахины хоорондох зам харилцаагаар авч хэлбэл, Хань улс, Тан улсын үед нэвтэрч болох хэдэн удаагийн завшаан байсан боловч бүр талаар өнгөрсөн тул нэвтэрч чадсангүй байв. ... Гагцхүү Чингис хааны үед сая Европод нэвтэрч чаджээ. Хэдийгээр нутаг дэвсгэрээ өргөтгөх зорилгоор нэвтэрсэн боловч хэрэг дээрээ дорно өрнийн соёлыг солилцуулсан болохоор өрнө дахины соёл дурсгалыг дорно дахин өөд оруулж, дорно дахины эртний соёл боловсон нь тэнгис далайг туулан өрнөдахинд нэвтэрч, харилцан холилдноос соёлыг ахиулж, өнөөдрийн шинжлэх ухаан бүхий ертөнц буй болон чаджээ. Үүний тухай Монголын түрэмгийлэл нь түүхнээ өөр нэгэн шинэ замыг нээжээ. Түүнчлэн үндэстэн бүхнийг бүлгэмдүүлж, соёлыг нэвтрүүлсэн тул улс үндэстний харилцааныг буй болгожээ. ... гэж Английн түүхч Хэрүй гэгч үнэлж байв. Үүнээс үзсэн ч дэлхийн соёлд оруулсан түүний хувь нэмэр их гэдгийг мэдэж болно. Дахиад хэлбэл, Буддын шашныг хөгжүүлсэн, цэргийн сахилгыг чангатгасан, Христосын шашны дорно дахин дахи хөгжлийг нь дэмжсэн, шуудангийн тэмдгийг хэрэглэсэн, цэрэг засгийг хуваан зассан талаар одоогийн хөгжилтэй адилтгавал хэдийгээр анхны нярай байдалтай боловч тухайн үедээ цаглашгүй юм. Одоогийн хүмүүс өрнө дахиныг ойлгохуйд Дундад улс ба Японд хүрэхгүй, Дундад улсыг ойлгохуйд өрнө дахиныхин Японд хүрэхгүй гэж гайхуулдаг атал, Чингис хааны байгуулсан Хаант Монгол Улс нь өмнөхөөсөө нэн хэтэрсэн гэснийг хэрхэн мэдэх ажээ.

Багцлаад хэлбэл, Чингис хааны агуу их дүрийг энгийн хүмүүс бишрэлтэй, улсаа байгуулсан их гавьяаг түүний хойчис нь дурсгууштай, дорно өрнийн соёлыг нэвтрүүлсэн хувь нэмрийг бүх дэлхийн хүмүүс магталтай ...

“Богд Чингис хааны байлдааны бичиг” гэдэг ном бол тус зууны дөчөөд онд Чуулалт хаалганд Алтан-Очир гэгчийн хэвлүүлсэн ном билээ. Энд сийрүүлэн авсан хэсэг бол тухайн үеийн төлөөлөх чанартай үнэлэлт болно. Тус номын оршилд: Манай Монгол болбоос, их эртнээс дорно зүгийн Азийн умар дахины их хуурай газрыг эзэлж, цэргийн сүр хүчээр дэлхий дахинд хосгүй их гэрэлтэй түүх судрыг үлдээн сацруулж ажгуу, мөнхүү их богд Чингис хааны түүх судрын мэт цог жавхлан нь, өдий болтол дэлхий дахины олон улсын түүх лүгээ адилтгаж үзвээс, үнэхээр тэнгэр тулам гэгээн гэрэл сацруулсаар амуй, ... манай монгол угсаатанд угаас соёл гэгээрэл агсаныг нь, энэ богд Чингис хааны хол дахиныг дайлсан түүхийг уншаад сац сая ихэд ухаарч мэдэх нь болой, тэр үеийн цэргийн хэрэглэлийн хуяг дуулга хийгээд зэвсэг зэрэг нь нийтээр монгол хүний өөрийн үйлдвэрчний гараар бүтсэний дээр цэргийн амуу идээний зэрэг ба дээл хувцасны хэрэгсэл бараа бодосыг басхүү монгол хүн өөрснөө үйлдэж асан нь ч илхэн мэдэж болмой, хэрвээ энэ өдөр мэт зүйл бүхнийг бус этгээдээс эрэх болбоос, тэрхүү бүх дэлхий дахины их үйлсийг яаж бүтээж чадмой гэж тэмдэглэжээ.

“Өвөр Монголын түүхэн хөгжлийн тойм байдал” (дээд дэвтэр) гэдэг номыг 1957 онд нөхөр Тогтох хятад хэлээр зохиожээ. Энэ бол Өвөр Монголын Өөртөө Засах Оронд монгол хүний өөрийн зохиосон анхдагч түүхээр тэмдэглэгдэх ёстой. Тус номд: Дээр дурдсаныг хураангуйлаад үзэхүл, арван гуравдугаар зууны эхнээс хойш, Чингис хааны ажиллагаа нь Монголын нийгэмд маш олон шинэ хувиралтыг лавтай үзүүлж байв. Эдгээр хувиралтад нь

хамгаас голлох зүйл гэвэл улс байгуулсан явдал болох бөгөөд энэ улс гүрнийхээ дотор түүний хаант засгийн байгууллага хэрэгжүүлсэн явдал болно.

Чингис хааны улс нь хэлэлгээнгүй малын эзэн язгууртнаас Монголын ард түмнийг дарлах багаж болох юм. Гэвч нийгмийн хөгжлийн жам ёсоор үздэг бол, улс буй болсон явдал нь улс үгүй байсан цаг үеэс давшсан нь дамжиггүй юм. Улс гүрэн нь иргэнийг орон нутгаар хуваадаг болохоор овгийн байгууллын заагийг тэвчсэнээр үл барам, монгол үндэстэн гэгч хамтын цогцын түрэгдлийг монгол хүнд гүнзгийрүүлсэн бөгөөд монгол үндэстний бүрэлдэл ба хөгжлийн талаар ч бас чухал үйлдэлтэй юм.

Хаант байгуулал нь балар эртний самуурал тэмцээнийг бодвол үнэнхүү нэгэн дэвшил юм. Хаант байгуулал бол самуурлын доторхи дэглэмийн төлөөлөгч мөн гэж Маркс хэлж байв. Энэхүү хаант байгуулал нь тухайн үеийн Монголчуудад авч хэлбэл, бүрэлдэн бүтэж асан үндэс угсаатныхи нь төлөөлөгч болно .

... Чингис хааныг дээр дурдсан нэг тал (хожмынхи нь түрэмгийллээс гадна)-аас авч үзвэл, Монголын түүхэн дээр үнэнхүү нэгэн баатар хүн гэж хэлж болно. Түүний маш олон ажиллагаа ба хүсэл эрмэлзэл нь тухайн үеийн нийгмийн аж ахуйн хөгжлийн шаардлагыг илтгэжээ. Яг ийм нэгэн тал байсан учраас, монгол хүмүүсийн хэдэн зуун жилийн турш түүнийг бишрэн хүндэтгэж, магтан дуулдаг шалтгааныг олж болно. “Монголын Нууц товчоон”, “Хаадын үндэсний эрдэнийн товч”, “Алтан товч” мэтийн монгол хүний өөрийн зохиосон зохиолд ба ардын аман зохиолд Чингис хааныг “богд” гэж үнэлж, хөгжил бадралынхаа хүч болсоор ирсэн явдлыг бүрмөсөн санаачлаагүй тохиолдол гэж хэлж болохгүй.

Гэвч Чингис хааны түүхэн үйлдлийг хэтэрхий ихэтгэх явдал мөн ч бүрмөсөн буруу юм. Чингис хаан бүх Монголыг нэгтгэж, Алтан улсын ноёрхлоос мултарсан талаар, Монголын нийгмийн хувьсгалыг ахиулсан талаар л зохих үйлдлийг гаргасан юм. Бусад талаар Чингис хаан жич түүнийг үйл ажиллагаа нь үнэлмээр зүйл огт үгүй. Гэвч түүнд дэвшилт үйлдлийг үзүүлсэн нэгэн түүхэн тал байх учраас зохих ёсоор үнэлэх хэрэгтэй. Харин бүхнийг үгүйсгэх үзэлтийг авч болохгүй. Зарим түүхчдээс Чингис хааныг Улс төрийн хэрцгий зүтгэлтэн, Хүн төрөлхтөнийг бүрмөсөн доромжилсон яргачин гэж үздэг буюу цаашилбал Зэрлэг балмад Монголын түүхийг дармаллахад зөвхөн хөдхи мунхгын тухай өгүүлснийг илтгэж болно гэж үздэг (“Д’Оссоны Монголын түүх”, дээд дэвтэр - уул зүүлт) явдал бол бүрмөсөн чалчсан явдал болно гэжээ.

1966 онд Улаанбаатарт хэвлэгдсэн гурван боть “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх”-д: Түүхийн тавцан дээр Чингисийн гарч ирсэн цаг нь Монголын нийгмийн амьдралд өөрчлөлт дэвшилт гарч хуучин овгийн байгуулал халагдан шинэ үйлдвэрлэлийн харьцаа феодалын ёст байдал үүсэн тогтож, улс төр байгуулах бүх нөхцөл шалтгаан бүрэлдэн нэгэнтээ түүхт хэрэгцээ болон тулгаран байсан үед тохиолджээ.

Чингис бол Монголын феодалжиж байсан язгууртадын нэг бөгөөд бүх хүч чадлаа язгууртан ангийн төлөө зориулсан юм. Чингис Монголын эзэн хаан болоод өөрийн төрийн дотоод бодлогодоо феодал ёст байдлыг бэхжүүлэн, харц ардыг дарангуйлан захирах ба түүний эрхшээлд орсон бусад нүүдэлчин аймгуудын эцэргүүцэл, тэмцлийг хатуу хэрцгийгээр номхотгон дарах чиглэлийг тууштай баримталж байжээ.

Тэмүжин бол ард түмнийг дарангуйлан захирах эрх мэдлийн төлөө хоорондоо өрсөлдөн дайсагналцсан феодалжиж байсан язгууртны нэг мөн бөгөөд харин тэгэхдээ тэдэн дотроо төрөлх ухаалаг, зохион байгуулахаараа авьяаслаг, цэрэг удирдах жанжны хувьд чадварлаг хүн байжээ.

Чингис хаан ноёдын дунд удаан хугацаагаар үргэлжилсэн шаргуу тэмцлийн дундаас өөрийн чадал, ухаанаар нэн ялангуяа тэр үеийн хэрэг явдал түүнд маш таатайгаар болж байсны хүчээр өрсөлдөгч нараа ялан дийлж эрх захиргаандаа бүх монголыг нэгтгэн чадсан юм.

Чингис Монголын олон тархай бутархай аймаг улсуудыг нэгтгэж нэгэн улсын хүрээнд оруулан, Монголын үндэстний төр бүрэлдэн тогтоход түүнийг анх үүсгэн байгуулагчийн хувьд зохих үүргийг гүйцэтгэсэн боловч 1211 оноос эхлэн бусдын газар орныг булаан дээрэмдэх дайныг өргөн хэмжээгээр явуулсан бөгөөд чухамхүү тэр үеэс эхлэн Чингисийн үйл ажиллагаа нь эрс харгис шинж чанартай болсон юм. Чингис түрүүтэй Монголын байлдан дагуулагчдын дээрмийн дайн нь Ази Европийн ард түмэнд цаглашгүй их үхэл гамшиг эвдрэл сүйрлийг учруулж, түүхийн үнэлж баршгүй хосгүй нандин зүйлийг сүйтгэн, тэдгээр орны хөгжлийг асар ихээр хойш татсан юм (нэгдүгээр боть, дэд хэсэг, нэгдүгээр анги, гуравдугаар бүлэг) гэжээ.

Нөхөр Дорнотив 1978 онд “Шинээр орчуулж товчоор тайлбарласан Монголын Нууц товчоон”-ы оршилд:

Дахин Амбагай хаан, Хотала хааныг дамжиж Чингис хааны үе болоход, тэр мөхөл доройтлын ирмэгт тулсан байдал доор, үндэстний дотоод гадаадын янз бүрийн дайсагнагч хүчтэй улс төрийн ба цэрэг дайны төвөг будлиантай тэмцлийг явуулжээ. Тэрчлэн алхам алхмаар хүчирхэгжиж, эцэстээ дээрмийн дайны аргаар, эл аймаг бүлгийн хооронд хэдэн зуун жилийн турш байн дахин явагдаж байсан дээрмийн дайныг устгав. Ингээд Чингис хааны угсаагаар гол болгосон, боол эзэмшигч язгууртны нэгдсэн хаант улсыг байгуулжээ.

Тэр тэмцлийнхээ явцдаа, тэнгэрийн хүчийг итгэх үзэл ба эзэндээ шударга байх сургаалиар жолоодлогынхоо дээд зарчим болгож, зоригтойгоор хуучныг эвдэн шинийг үүдэж, илээр гавьяатныг шагнаан ялтныг яллаж, цэрэг засаг, цэрэг ард нэгдсэн зохион байгуулалтын хэлбэрээр дүрэм, сургаал, зарлиг мэтийн улс төрийн дэглэмийг байгуулсан бөгөөд хишигтэн цэргээрээ гол болгож ерэн таван мянган нэгтгэлийг байгуулжээ. Энэ цэрэг нь байлдах бүртээ ялах, довглох бүртээ эзлэх хүчтэй байв. Энэ цэрэг нь хэдийгээр тооны талаар дэмий олонгүй байсан боловч харин төрөлхи чанар ба байлдах чадварын талаар авч хэлбэл тухайн үедээ дэлхий дахинд түүнтэй тэнцэх дайсангүй байсан юм. Тиймээс маш олон аж ахуй, соёлын талаар давшингуй аймаг угсаануудыг дайлан дагуулж, шинэ улс гүрнийг байгуулах их үйл ажиллагаагаа биелүүлжээ. Энд түүхийн хөгжлийн тэнцүүргүй жам ёсыг амьдлагаар харуулжээ. Зохих нөхцөл доор, хоцрогдогсод нь давшигсадыг ялж болохыг энэхүү жам ёс тодорхойлов. Энд дурдаж бүхий зохих нөхцөл гэдэг нь даруй Чингис хаан тэмцлийнхээ үйлдлэг дунд, улс төрийнхөө чадвар ба цэрэг дайнынхаа чадварыг төгөлдөр бадруулсан явдал болно. Бусад эл аймаг бүлэгт ийм нөхцөл байсангүй тул нэг нэгээрээ ялагдлаар дуусчээ.

Чингис хаан хүчирхэг их хаант улс байгуулснаа залгаад, дэлхий ертөнцийг донсолгосон, дээрмийн чанартай их дайралтаа эхэлжээ. ... Ингээд боол эзэмших байгуулалт шинэ

мандсан, төвлөрсөн, хүчирхэгжин бадарсан улс нь феодалын доройтон буурсан, хэсэглэн ноёрхсон, тархай бутархай улсыг ялсан түүхийг бүтээжээ (энэ асуудлыг онолын талаар системтэй тайлбарлахаар бэлтгэж байна). Чингис хаан энэ үед нийгмийн түүхэн хөгжлийн ахиулагч байснаасаа хувирч давшингүй үйлдвэрлэлийн арга маягийг талхин эвдлэгч болсноо өөрөө мэдэхгүй байсан нь дамжиггүй бөгөөд мэдэж ч чадахгүй юм гэжээ. Нөхөр Мансаны зохиосон “Монголын уран зохиолын түүх”-д: Монгол аймгийн хаан хөвгүүн Тэмүжин дөчин таван нас хүртэл Урт чагур чагуран охор булга булгалдаад 1204 онд Монголын олон аймгийг хураан тогтоож, 1206 онд их ор сууж, улсын нэрийг Монгол улс хэмээн нэрийдэж хааны цолыг Чингис хаан гэж өргөмжлөв. ...

Монгол үндэстэн үүсэл хөгжлийн гурван шатыг өнгөрүүлээд түүхийн тавцанд алхаан гарч ах дүү үндэстний эгнээнд оров. Мөн энэ өнгөрөлтийн явцад монгол үндэстний нийгмийн хөгжилтөд ч нэг үсрэлт гарч - боолын нийгмийн эхний шатаасаа феодалын нийгэмд дэвшин орж тэргүүний үндэстэнүүдтэй мөр зэрэгцэн оршихоор барахгүй хүчирхэг их үндэстэн болон хөгжсөн байна гэжээ.

Дундад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Хорооноос 1981 онд хэвлүүлсэн “Монгол үндэстний түүхэн хүмүүсийн тухай өгүүллийн түүвэр” гэдэг товхимолд нөхөр Бүрэн, Лю Цзинь Со хоёрын нийтлүүлсэн “Чингис хааны өмнө хагас насны үйл ажиллагааг нь товч үнэлэх нь” гэсэн өгүүлэлд (энд эшлэхдээ гол гол үзэлтийг нь товчлон түүвэрлэсэн боловч эшлэсэн хэсгийнхээ уг үг өгүүлбэрийг огт хөдөлгөсөнгүй - эшлэгч):

Чингис хаан бол Монголын түүхэн дэх агуу их түүхэн хүн мөн. Түүний бүх насны үйл ажиллагаа нь Монголын түүхийн хөгжилтөд маш их нөлөөг үзүүлснээр барахгүй, бүх дэлхийн түүхийн хөгжилд ч ийм нөлөөг үзүүлжээ .

Арван хоёрдугаар зууны сүүлч ба арван гуравдугаар зууны эхээр, Монголын нийгэм нь овгийн байгууллаасаа феодалын байгуулалд шууд шилжсэн энэхүү өвөрмөц чанарыг Монголын нийгмийн үйлдвэрлэлийн хүчний хөгжил ба түүний оршиж асан түүхэн тойрноос шийдвэрлэсэн юм. Монгол нь түүний ойр зэргэлдээ ардуудтайгаа аж ахуйн талын өргөн харилцаа ба улс төр соёлын талын солилцоотой байсан тул түүний харилцаа болон хүлээн авдаг зүйлс нь бүр феодалын байгууллын түрээс байв. Энэхүү нөлөөний доор, Монголын овгийн байгуулал нь задарсны дараа феодалын нийгэмд шууд шилжин оржээ.

Чингис хаанаас энэхүү шилжилтийг биелүүлж чадсан учир гэвэл, тэр үйлдлэгийнхээ явцад овгийн байгууллын уламжлалыг зоригтойгоор эвдэж чадсанд оршино .

Чингис хаан долоон жилийн охор хугацаанд Монголыг нэгтгэсэн агуу их ялалтыг олсон явдал бол өчнөөн төчнөөн ахуйч нөхцөлийг бүрэлдүүлсэнд шалтгаална .

Нэгдүгээрт, Чингис хаан монголыг нэгтгэсэн ба бүрэлдүүлсэн явцад, үйлдвэрлэлийн хөгжилт ер олтгойлсонгүй юм. Тэр юуны урьд дайн дажины гамшигт олон жилийн турш талхигдсан өргөн олон малчдын үйлдвэрлэл ба амьдралыг нь төвхнүүлсэн бөгөөд байлдааны үед цэрэгт элсэх арга хэмжээг ч тодорхой тогтоосноор малчин түмэн аж үйлдвэрлэлдээ амар оролцохыг баталсан байна. Үүний хамт, Чингис хаан дайсан этгээдээ ялсан үед, тэдгээрийг ялангуяа тэдний доторхи янз бүрийн дархчуудыг идэвхитэй хамгаалах ба хүндэтгэн хэрэглэх арга

шийдвэрийг авсан тул Монголын нийгмийн гар үйлдвэр ба барилгын ажлыг маш их хөгжүүлжээ.

Хоёрдугаарт, Чингис хаан Монголыг нэгтгэснийнхээ хойно, төрийн зохион байгуулалтаар овгийн байгууллын зохион байгууллатыг орлуулжээ .

Гуравдугаарт, феодалын шинэ үйлдвэрлэлийн харьцааг байгуулжээ. Чингис хаан бол Монголын шинэ мандсан феодал ангийн төлөөлөгч хүн болно. Чингис хаан Монголыг нэгтгэснийнхээ дараа, харьяат нарынхаа гавьяа зүтгэлийн их багаар тус бүр шагналыг соёрхож, феодалын харьяалагдах харьцааг байгуулсан билээ .

Дөрөвдүгээрт, Чингис хаан овгийн байгууллын хуучин заншлын хуулийг эвдэж, албан ёсны бичиглэсэн хуулийг тогтоож, Монгол орныг хуулиар зассан байна .

Тавдугаарт, хуучны овгийн байгуулалын язгууртны өв уламжлах эрхийг нь эвдэж, чадвар хэмжээгээр нь хүн хэрэглэх явдлыг хэрэгжүүлжээ. Чингис хаан хүн хэрэглэх талаар Мэргидийг басаж чадвартныг атаархах эзэн хаан биш, харин эрдэм чадвараар нь хэрэглэх ноёрхогч юм .

Чингис хаанаас авсан шашин суртахууны тухай төрийн бодлого нь үндсэндээ зөв юм. Тэр нь дорно өрнийн бусад улс орны хаад эзэд лүгээ адилгүй, хүмүүсийн шашин мөргөлд эрх чөлөөтэй байх төрийн бодлогыг хэрэгжүүлжээ .

Чингис хаан зам харилцааны үйлсийг хөгжүүлсэн бөгөөд бэхжүүлсэн байна. Тэр, хүн амаар маш сийрэг уудам тэнэгэр тал нутагт юуны урьд өртөө замыг байгуулжээ .

Чингис хаан монголыг нэгтгэхийн тулд хэрэгжүүлсэн төрийн бодлого ба олон арвин бодтой арга хэмжээг дээр дурдсан зүйлээс авч үзэхүл, тэр Монголын нийгмийн хөгжлийг ахиулсан нь дамжиггүй юм. Энэхэн зүйлүүдээр нь хэлсэн ч, Чингис хаан арван хоёр дугаар зууны сүүлч ба арван гуравдугаар зууны эхний үеийн Монголын нийгэмд, нийгмийн хөгжлийн чиглэлд зохицолдсон давшсан хүчний төлөөлөгч болоход гутаамаар газаргүй бөгөөд үнэлэн нутлууштай хүн юм. Гэвч Чингис хаан бол Монголын шинэ мандсан феодал ангийн төлөөлөгч хүн болохыг хэлэхгүй ч мэдэж байх юм. Түүний дотооддоо хэрэгжүүлж байсан аливаа төрийн бодлого ба арга шийдвэр нь цөм феодал ангийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Шинэхэн мандсан феодалын төр нь Монголын ард түмэнд авчирч өгсөн зүйл нь зөвхөн феодалын хэрцгий ноёрхол ба мөлжил байлаа. Чингис хааны сүүлчийн хагас насанд хойно хойноосоо явагдсан гадагш түрэх ба түрэмгийлэх ажиллагаагаар авч хэлбэл тэрслүү болох нь сэжиггүй бөгөөд түрэмгийлэгдсэн эл улсын ард түмэнд туйлын их аюул гамшиг учруулсныг түүхийн бодот хэрэг гэрчилж байна. Энэ талаар эрхбиш үгүйсгэх хэрэгтэй гэжээ. Нөхөр Алтан-Очир “Өвөр Монголын багшийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл”-д нийтлүүлсэн “Чингис хаан монгол үндэстний түүхнээ үзүүлсэн үйлдлийн тухай туршин өгүүлэх нь” гэдэг өгүүлэлдээ:

Сарнин бутарсан монгол аймаг угсаатныг нэгтгэж, Монголын нийгмийн хөгжил бадралыг буй болгож, монгол үндэстний хамтын цогц бүрэлдэх ахицыг түргэтгэсэн ба монгол үндэстний боловсон цаг үеийг нээсэн нь даруй Чингис хааны монгол үндэстний түүхэнд Урьдын

хүмүүсээсээ өөр шинэ юмыг олгосон зүйл болно.

Түүхийн эрдэм шинжилгээний хүрээн дэх нэг бүлэг хүмүүс Чингис хааны гадагш дайлж үйлдсэн ялаар нь түүний хүн төрөлхтөний хөгжлийн түүхнээ үзүүлсэн үйлдлийг бүрмөсөн үгүйсгэжээ. Энэ бол түүхийн бодосч үзэлтэй эс нийцэх юм. Марксын үзлийн үзэхээр ямар нэгэн анги ба нийгмийн бүлгийн үйлдлээс давсан хувь хүний үйлдэл гэж байдаггүй юм. Монгол цэргийн гадагш довтолсон нь Монголын феодал ангийн үйлдэл юм. Харин тэд нарын үйлдсэн ялыг бүрмөсөн Чингис хаан нэгэн хүний бие дээр нөмөргөж болохгүй юм. Гэвч монгол цэргийн гадагш довтолсон нь хөрш улс үндэстэн ба монгол үндэстний тус биеийн хөгжилтөд назгай үйлдлийг үзүүлсэн боловч, бусдач тал дээрээ Дундад улсын түүх ба дэлхийн түүхэнд лут их идэвхи үйлдлийг үзүүлсэн юм. Ялангуяа энэхүү идэвхи нь харин назгайгаасаа давсан юм гэж үзэж болмоор байна. Ленин: Нийгмийн ямар ч асуудлыг задлах үес, Марксын үзлийн онолын шилжишгүй шаардлага бол, асуудлыг түүхийн зохих хэмжээнд тавих явдал мөн (“Үндэстний өөртөө шийдвэрлэх эрхийн тухай”, “Лениний сонгомол зохиол”, 2 дугаар боть, доод дэвтэр, 848 нүүр) гэж хэлэв. Бид Чингис хааны монгол үндэстний түүхнээ үзүүлсэн үйлдлийг өгүүлэхэд, Монголын нийгэм, монгол үндэстэн, хөх монгол улс зэрэг эдгээр үндэстэн суурь ба арван хоёрдугаар зууны сүүлч, арван гуравдугаар зууны эхэн болох энэхүү цаг үеэс салж болохгүй. ...Иймээс бид эрхбиш Чингис хааны тухай зөв үнэлэлтийг дурдаж түүний монгол үндэстний түүхнээ үзүүлсэн агуу их үйлдлийг нотлох хэрэгтэй. Мөн үүгээр суурь болгож байгаад, түүний Дундад улсын түүх ба дэлхийн түүхнээ үзүүлсэн нөлөөг уялдуулан ерөнхий талаас нь үзвэл, Чингис хаан бол нэгэн нотлууштай түүхэн хүн мөн гэжээ.

Чингис хааныг Дундад улсын түүх ба хятад үндэстний алдарт хүмүүс жич түүхчдээс хэрхэн үнэлж байсныг доор товчлон тэмдэглэе.

1221 онд Монголын төрд элчилсэн Сүн улсын элч Чжао Хун “Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-дээ:

Чингис залуудаа Алтан улсад баригдаж арван хэдэн он боол болоод оргон гарч ирснээр, Алтан улсын учрыг дуустал мэддэг юм (энэ тухай өөр тэмдэглэл ер байдаггүй бөгөөд дурдсан зүйл нь үнэн байдалтай нийцэхгүй юм - эшлэгч). Тэр хүн баатарлаг бөгөөд эрс шуурхай, цээж уудам, олныг багтааж чадна. Тэнгэр газарт сүсэгтэй, бат журмыг хүндэтгэмүй гэжээ. “Юань улсын түүх, Тайцзу-гийн шастир”-т:

Хаан хянамгай лавдуун бодлого гүн, цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт тул дөчин улсыг мөхөөж, баруун Ся улсыг төвшитгөжээ. Түүний асар гайхамшигт гавьяа, агуу их үйлс нь адбиш үлэмж ажгуу. Гэтэл тухайн үеийн түүхч түшмэд тэмдэглэсэнгүй буюу тэмдэглэсэн зүйлсийн олонхи нь үрэгдсэн тул харамсму гэжээ.

Вэй Юань-ий зохиосон “Шинэ найруулсан Юань улсын түүх”-д:

Хаан хянамгай лавдуун, бодлого гүн, цэрэг хэрэглэхүйд сахиулсан мэт тул дөчин улсыг мөхөөж, эээр Тангуд улсыг төвшитгөн Алтан улсыг эзэлж, Дундад орны гуравны хоёрыг нь эзлэв. Хэрвээ баруун орныг дайлсангүй бүх хүчээр Бяньлян хотыг дайрсан аваас Тайцзун (Тайцзун гэдэг нь Өгөөдэй хааны сүмийн цол болно - эшлэгч)-ы үе бололгүй их үйлийг

бүтээн чадах болой. Харин баруун далайн тэртээ түмэн газарт цэрэглэж, элээ шувуу нисээд гарахгүй Кунь Лунь хааны гангыг эмээлт морины туурайгаар үүд хаалгаар өнгөрөх мэт гишгэлүүлэн, газар дэлхий юүрэн аянга бороон болж, гарди галбинга зайлан далай давалгаалж, галав тогтноос битүү асан ертөнц нээгдэв гэжээ.

Кэ Шао Минь-ий зохиосон “Юань улсын шинэ түүх”-д: Дэлхий дахины ёсонд салан одвоос нийлэх учир, уул нуруу, мөрөн далай халхалсан ч өөр төрөлтөн онцгой заншилтан эцэстээ нэгдмүй. Тайцзу говийн умардад мандаж, Тангудыг гишгэлэн Жүрчинийг устгаж, харь түмэн газар цэрэглэсэнийг өгүүлбээс хаалга үүдээр орж гарах мэт. Энэ нь гурван үеэс хойш эс харагдав. Тайцзу тэнгэрээс соёрхсон есөн тив (Дундад улсыг хамран хэлсэн үг - эшлэгч)-ээс гадна нэгэн харьяат (Харь улсыг хэлж байна - эшлэгч)-ыг нь харьяалуулан, газрыг нь гишгэлүүлэн, эчсэн (очсон - хө.) газар бүрт цэргийг нь мохоов. Хэрвээ Дундадын олон үндэстний их нэгдэл хэмээвээс боржигин овогтноос эхэлжээ гэжээ.

Лу Сиюнь 1934 оны 11 сард нийтлүүлсэн “Энэ тэр номыг шүүж байгаад” гэдэг зохиол (“Лу Сиюнь-ий бүрэн зохиол”, 1958 оны нэгдүгээр хэвлэл, 6 дугаар боть, 109 нүүр)-доо:

Манай Чингис хаан Европыг байлдан дагуулсан үе бол, манай хамгийн сортоотой үе байлаа гэж би хорь хүрээд сонсчээ. Харин энэ манай хамгийн сортоотой үе гэдэг нь үнэндээ Монголчууд Дундад улсыг байлдан дагуулж, бид боол болж байсан гэдгийг харин тавь хүрээд сая олж мэдэв. Энэ жилийн 8 сард зарим үлгэрийг эрэх ташрамаар гурван иж Монголын түүхийг урвуулж үзээд, Монголчууд Орос-ыг байлдан дагуулж, Унгар, Австрид түрэмгийлэн орсон нь бүх Дундад улсыг байлдан дагуулахаас өмнөх учир байсныг сая мэдэв. Тэр үеийн Чингис хаан бол манай хаан биш, харин Оросчууд боолчлогдсон нь биднээс эрт болохоор Манай Чингис хаан Дундад улсыг байлдан дагуулсан үе бол манай хамгийн сортоотой үе байлаа гэж тэд хэлэх ёстой юмсан.

Одоогийн хэрэглэж бүхий түүхийн сургах бичгийг би үзсэнгүй удсан тул түүний дотор чухам юу хэлж байхыг ер мэдээгүй. Гэвч сонин сэтгүүл дээр Чингис хаанаар омог сүрээ болгосон зохиол өгүүлэлүүд байн байн харагддаг билээ. Хэрэг явдал аль хэдийн өнгөрсөн тул дэмий их холбогдолгүй билээ, харин үнэндээ их холбогдолтой ч магадгүй, гэтэл юу гэсэн ч үнэнээр нь хэлсэн нь дээр юм гэжээ.

Чжан Чжэнь Пэй “Чингис хааны шүүмжлэл шастир”-таа:

Чингис хааны бүх насны гавьяа зүтгэл нь Ази Европыг донсолгож, эрт өдгөөгөөс бүр хэтэрсэн байна. ... (энд, дээр сийрүүлсэн Юань улсын гурван зүйлийн түүхийн үнэлэлтийг эшлэжээ. Ингээд товчлов - эшлэгч) энэ гурван зүйлийн үзэлт цөм хааны гавьяа зүтгэлийг дурдахдаа зөвхөн цэрэг дайн ба эрх сүрийн талаар л үнэлжээ. Ганц баруун оронд цэрэглэсэн явдлыг эс таарав гэж Вэй Юань гүн харамссанаар үзэхүл, тэр Го Бао Юй-гийн хэлснийг хянамгай ойлгосонгүй мэт. Их нэгдлийн анх суурь бол хаанаас эхэлсэн гэж гагцхүү Кэ Шао Минь авгай хэлсэн явдал бол хааны гавьяа зүтгэлийг цэрэг дайн ба эрх сүрээс өөр нэгэн талаар үзсэн мэт. Гэтэл тууштай дурдсангүй нь харамсалтай болжээ. Соёл боловсныг давшуулсан түүхэн үзэлтээр хааныг анх үнэлэгсэд бол хэрэг дээрээ өрнө дахины түүхчид байсан юм. Гэвч тэдний юуны урьд олж үздэг түүхийн ном гэвэл, бүр Чингис хааны өшөөтдийн үр ач нарын хорсолт санаагаа багтаасан чалчаа болох тул, хааны баруун оронд

цэрэглэсэн тухай түүхийг сөхмөгц тэдгээр тэмдэглэл нь бүр хэрцгий балмад ажиллагаагаар бялхаж байдаг билээ. Тиймээс Сандикэ (1874-1949 он, Америкийн сурган хүмүүжлийн ухаантан ба сэтгэцийн зүйц - эшлэгч) мэтийн соёл түүхийн алдарт эрдэмтэн хүртэл түүний үнэнхүү учрыг нь олж мэдсэнгүй байв. Алдарт түүхч Уэлсс (1866-1946 он, английн алдарт зохиолч - эшлэгч)-ийн зохиосон “Дэлхийн түүхийн товч”-оос эхлэн Чингис хаан болон түүний үр ач нарын бүтээсэн гавьяа зүтгэлийг нэлээд зөвөөр үнэлэх болжээ. ... Уэлсс авгайн үнэлэлт нь нэгдүгээрт, хүн төрөлхтөний үзэлтийн нөлөөг өргөтгөсөн явдал бол хааны агуу их гавьяа гэж нэр хүндтэйгээр дурдаж гаргажээ. Хоёрдугаарт, Ази Европын нэвгэрлэг харьцааг нээсэн гавьяаг магтан сайшаажээ. Гуравдугаарт, хаан оюун мэдлэг ба үйлдэх аргыг дэлгэрүүлсэн гавьяатай гэж тунхаглажээ. Тиймээс Чингис хааны гавьяа зүтгэл нь зөвхөн цэрэг дайн ба сүр хүчний төдий огт биш бөгөөд түүний амжилт бүтэмжээр үнэнхүү орчин дэлхийн боловсон ёсны гүүр, Дундад улсын үндэстний соёлын суурь гэхэд огт гутаах газаргүй .

Чингис хааны үйл амьдралыг нь тус хүн товч шүүмжлэн өгүүлээд дууссан ч гүн төрөгдөл өөрийн эрхгүй дахин төрөгдөнө. Хаан умард говийн эрэлхэг баатарын хувьд, богд баатар зоригоороо бадруулж, Сүн улсын сүүлчээр тархан бутарсан Дундадыг дахин нэгтгэж, ган бат сахилгаар дорно дахи Бо Хай тэнгисээс өрнөш Каспийн тэнгис хүртэлх орныг ерөнхийлөн захирснаас аймаг бүлгийн хоорондоо эрт урьдаас тасралгүй тэмцэлдэж байсан самуун байдлыг устгав. Түүнчлэн энх тайван амар төвшний жаргалыг аянчин, худалдаачинд урт хугацаагаар эдлүүлснээр үл барам, дорно өрнийн соёлыг солилцуулж, орчин дэлхийн боловсныг энэ үеэс нээжээ. Шүүмжлэгчээс хэдийгээр хааны насаараа дайн байлдааныг эрхэлснийг өгүүлсэн боловч түүний үр дүн нь хүн төрөлхтөний энх тайвныг тогтоосонд оршино. Хааны нас барсныг “гэгээн сэцэн хүмүүсийн их хохирол” гэж Марко Поло хэлж байсан нь мөн чанараас нь үзсэн шүүмж болно. Гэтэл хөдхи түүхчид олж мэддэггүй бөгөөд хааныг сүрдүүллээр хуулиа болгож, хядлагаар ажилгаагаа болгодог гэж хэлдгээр ч барахгүй, Чингис хаан гэсэн нэгэн нэрийг ч догшин хэрцгийн бэлгэ тэмдгээр үздэг байна. Үүнээс илүү гүтгэл дэмийрэл хэрхэн байж болох вэ?

Тус номын эл бүлэгт тэмдэглэсэн түүхэн хэргүүдийг багцлаад үзэхүл, хаан ер зэр зэвсгээр тоглогч хуумгай хүн биш гэдгийг мэдэж болно. Хаанаас явуулсан байлдааны олонхи нь өөрийгөө хамгаалахын төлөө гэж байсан бөгөөд алж хядлаа гэдэг нь ч аргагүй байдал доор илэрч байсан юм. Жишээлбэл, Тайчигуд лугаа байлдсан нь бүр ч өөрийгөө хамгаалахын төлөө, Мэргидийг анх довтолсон нь булаагдсан гэргийгээ буцаан авахын төлөө, Татар бол эцгийг нь алсан өшөөтөн, Жамуха олон дахин өдөөж байсан, Ван хан харин өршөөлийг өшөө болгон халдсан, Найман бол оморхоглон урьдаар гар хөдлөхөөр өдөөсөн гэх мэт. Тэр үед хааны хүч бага буурай байсан тул урьдаар лав довтолохгүй юм. Энэ ч байтугай, улаан барс жил их ор сууснаас хойшхи байдлаар авч хэлсэн ч, Тангуд улс оргодлыг далдалсан, Алтан улс өвөг дээдсээс өшөөтэй, Хорезм элчийг алж аралжаачныг хядсан мэтийн үнэн түүхийг дахин шалгасан ч тов тодорхой баримтыг хангаж байдаг. Хэрвээ бага л хүний аниртан бол хүлээн тэсвэрлэхүйеэ бэрх юм. Нэгэн халамж тэтгэлээр зорилгоо болгосон агуу их эр бологч сэтгэгч цэрэглэлээ хойшлуулж хэрхэн болох аж? ... гэжээ.

Янь Чжи Мэй-н 1954 онд нийтлүүлсэн “Чингис хааны түүхэн байр суурь” гэдэг сэдэвтэй өгүүлэл (“Түүхийн сургах ухаан” сэтгүүл, 1954 оны аравдугаар хугацаа) бол Чингис хааны

тухай чөлөөлөгдсөний дараахи шинэ Дундад улсын анхны үеийн төлөөлөгч зохиол болно. Тус өгүүлэл нь нийт таван сэдвээр бүрэлджээ. Доор сонгон нийтэлсэн хэсэг бол тус өгүүллийн тавдугаар сэдвийн бүх агуулга болно.

“Дөрөв. Чингис хааны түүхэн байр суурь”

Дээр дурдсан зүйлүүдийг үндэслэвэл Чингис хааны түүхэн байр суурийг доорхи мэтээр дүгнэж болно.

Чингис хааныг мандан дэгжихээс өмнөх Монгол бол бусдад ноёрхогдогч хоцрогдонгуй угсаатан байжээ. Түүний дотроо зөвхөн бат бус холбоо бүхий маш олон бага адил бусын овог аймаг байдаг бөгөөд байнгадаа харилцан өрсөлдөж байдаг билээ. Бас Алтан улсын салган завсардуулах бодлогын үр дүнгээр тэр нь ойр зэргэлдээ аймаг бүлгүүдтэйгээ үргэлж тулалдаан байлдаан хийдэг учраас хэн алиныхи нь хүч нь ч бүр буурчээ. Нийгмийн байгууллын талаар тэр нь овгийн байгууллын задралаасаа феодалын байгуулал өөд шилжиж байсан учир нийгмийн урагшлалтаа ахиулахын тулд нийгмийн өөрчлөлт чухал хэрэгцээтэй байв.

Чингис хааны мандалт нь Монголыг нэгтгэх ба нийгмийн байгууллыг өөрчлөх шаардлагад тохирсон тул нийгмийн хүчнийг өргөн хэмжээгээр татан авч, түүний үйлсээ бүтээн чаджээ. Чингис хаан дэгжрэн мандсаныхаа дараа тархай бутархай монгол аймгаа нэгтгэснээр үл барам, бүх говийн умардахи эл аймаг бүлгийг нэгтгэж, Монголын хүчээ өргөтгөн, Алтан улсын ноёрхол ба дарлалаас мултрав.

Чингис хааны өөрчлөлтийн үйлс нь Монголын феодалын байгуулалыг тогтворжуулж, түүнчлэн Монголын улс төрийн зохион байгуулалтыг бэхжүүлэн хөгжүүлж, монгол хүний соёлын хэмжээг тэгшрүүлжээ. Гадагш хөгжсөн явцдаа монгол хүн тухайн үеийн боловсон ертөнц лүгээ учралдах боломжийг буй болгосон учраас монгол хүний нүдийг нь нээлгэж, тэдний оюуны ба бодосын амьдралыг нь баялагжуулжээ.

Чингис хааны мандалтаар аймаг бүлэг хоорондоо өнөд тасрашгүй явагдаж асан дайныг устгаж, арилжааны бригадад ерөөс эдлээгүй амар түвшнийг эдлүүлжээ. (“Монгол түүхийн тойм”, 27-28 нүүр) бас Иран болон Туран (Дундад Азийн түрэг хүний нутгийг зааж байна)-ы хооронд энх түвшнийг буй болгосон тул хүмүүс толгой дээрээ алтан пял тавиад зүүнээс баруунш явавч халдах хүн үгүй болжээ (Дээрх эшлэсэн номын 30 дугаар нүүр дэхи Абул-Хжи-гийн хэлсэн үг) энэ мэт зам нэвтрэлгэ ба арилжааны бригадын амар түвшнийг баталсан тул дорно дахин ба өрнө дахины аж ахуй, соёлын харилцааныг ахиулан чадсан байна.

Чингис хааны мандалтаар монгол үндэстний хоцрогдонгуй байдлыг өөрчилж, түүнчлэн анхандаа бусдад доромжлогдогч, нэр төргүй асан аймаг угсааны нэр нь тухайн үеийн дэлхий ертөнцийг донсолгож, монгол хүний дэлхийн байр суурийг ихээр дээшлүүлжээ. Хэдийгээр Хаант Монгол Улс нь хожимдоо мөхсөн боловч үүнээс хойш монгол үндэстэн нь түүний тусгаар чанараа хадгалж, өнөд оршин тогтсон бөгөөд Чингис хаан ба Хаант Монгол Улсын түүхэн уламжлалдаа омогшдог билээ. Ингээд Чингис хааны нэр нь монгол үндэстний бүлгэмдлийг уриалах, монгол үндэстний нэр хүнд ба итгэл зоригийг нь хөгжөөх уриал болжээ.

Хэлэлгээнгүй, Чингис бол Монголын ноёрхогч ангийн төлөөлөгч гэснийг мартаж болохгүй. Чингисийн аливаа ажиллагаа нь голдуу түүний өөрийн ба түүний төрөл угсаа, алтан ургийнхаа ашиг сонирхолын төлөө явагдаж байдаг сан (“Чингис хааны намтар”, хятад орчуулгын дэвтэр, 164 нүүр) тэдний зарим талын ашиг сонирхол хэдийгээр ард түмний ашиг сонирхолтой нийцдэг боловч ард түмний ашиг сонирхолтой харшилдах зүйл ч олон байдаг юм. Кипчакыг дайлсан дайралтад арван гурав дөрвөн настай хүүхдийг хүртэл цэргийн албанд татан явуулж байсан билээ (“Хар Татарын тухай хэргийн товч”). Гадаадын дайнд Монголын ард түмэн нь үрэгдэн хохирч, гэр нутгаасаа салан зүг зүгт бутарч байв. Гэтэл байлдааны гол олз эд ба боолыг харин Монголын язгууртад эзэмшдэг билээ. Монголчууд Дундад улсыг эзэлснээс хойш, Монголын энгийн ард түмний амьдралын байдал ч тийм их сайжирсангүй юм. Шаньдун, Хэнань-д сууж байсан монгол цэрэг нь Ганьсу муж өөд шилжихдээ аяны бэлтгэлээ төхөөрөхийн тулд газар тариа буюу эмс хүүхдээ хүртэл худалдаж байсан болохоор явах тутам ядууран хоосорч (“Юань улсын түүх”, 134 дүгээр боть, Хэ Шангийн намтар), зарим монгол хүүхдийг хотон хүн буюу хятад хүнд боол шивэгчнээр худалдан өгч байв (“Юань улсын түүх, Содбала хааны шастир” дахи Чжи Чжи-гийн тэргүүн он). Цаашилбал, зарим саригаачид гадаад улсад аваачиж боол болгон худалддаг (“Юань улсын хууль дүрэм”, 57 дугаар боть). Түүнчлэн Монголын ард түмэн нь дарлагдаж агсан хятад хүнтэй адил ноёрхогч ангийн мөлжигдөгч этгээд нь болж байсан юм. Монголын засгийн газар нь хэдийгээр өнгөн дээрээ тэднийг хамгаална гэдэг боловч хэрэг дээрээ тэдэнд хавсарлага болоогүй.

Бид эдгээр явдлыг дурдахдаа Чингис хааны гол түүхэн байр суурийг баллая гэж бодсонгүй. Харин Чингис хаан ноёрхогч этгээд байсан тул түүний ангийн байр суурийн хязгаарлалыг үгүйсгэхийн аргагүй юм. Энэ мөн ч түүхэн дээрх аливаа ноёрхогч ангийн баатар хүмүүст байдаг нийтлэг зүйл болно.

Ингэж нийгэмд үндэстэн (эсхүл угсаатан)-ий дарлал оршиж байдгийг бас дурдах хэрэгтэй. Чингис хаан болон түүний үр ач нараас Дундад улс ба бусад улс орныг ноёрхож байхад ангийн дарлал оршиж байснаас гадна бас үндэстний дарлал оршиж байжээ. Ингээд дарлагдагч ард түмний дургүйцлийг онцгой хөдөлгөж байв. Тиймээс Юань улсад ноёрхогдож байсан хятад хүмүүс энэхүү давхар дарлалыг нь эсэргүүцэж байсан явдал нь үнэн шударга ёсны ажиллагаа болно.

Гагцхүү Бүгд Найрамдах Дундад Ард Улсыг байгуулснаас хойш, үндэстний дарлалыг сая үндэснээс нь үгүйсгэж, манай улс нэгэнтээ эл үндэстний ард түмэн бүлгэмдэн хамтралцсан их гэр бүл болсон бөгөөд бид сая Монгол ханьтантайгаа хамт ямар ч үндэстний хэлбэрэлгүйгээр энэхүү түүхэн дээрх агуу их хүн Чингис хаанд төв голч үнэлэлтийг хийж байна (1954 оны 8 сарын 29-ний өдөр).

Юй Юань Ань 1955 онд зохиогдсон “Чингис хааны намтар” гэдэг товхимолдоо:

Монгол орон нэгдсэнээс эл аймаг бүлгийг завсардуулж байсан саад арилж, аж ахуйн харилцаа нэмэгдэж, малчдын амьдрал тогтнон, үйлдвэрлэлийн хүчин ч хөгжжээ. Тэрчлэн Монголын ард олны амьдралыг нэгтгэхээс өмнөхитэй адилтгаж үзвэл хэллэгэнгүй тэгшилсэн нь тодорхой учир юм. Тиймээс Чингис хааны Монголын нэгдлийг түргэтгэсэн явдлыг тухайн үеийн Монголын ард түмэнд авч хэлбэл давшсан үйлдлийг үзүүлжээ.

Монгол орны нэгдэл нь Монголын ард түмний нягтрал бүлгэмдлийг ахиулж, Монгол үндэстнээ хамгаалах хүчийг нь нэмэгдүүлж, тэрчлэн монгол үндэстнийг Жүрчин язгууртны дээрэмдэл талхидал ба алаан хядааны доороос авран гаргасан бөгөөд Монголын ард түмний мал аж ахуй, гар үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд нийгмийн нөхцөлийг бий болгов .

Чингис хаан Монголын эл аймгийг байлдан нэгтгэх явцдаа, өөрийн хүчээ хөгжүүлэхийн төлөө цэргийн зохион байгуулалт, хэвтүүлийн дүрэм (иймэрхүү дүрмийг тухайн үед Хэрэйд зэрэг бусад монгол аймгуудад ч хэрэгжүүлж байв. Чингис хаан түүнийг цэгцэлж улам төгөлдөржүүн болгожээ), улс төрийн дүрэм, засаг захиргааны хувиар (мянгатын дүрэм), ордны хамааралт зэргийг байгуулсан бөгөөд хууль цаазын зурвасыг тогтоож, бас уйгуржин үсгийг монголд оруулан хэрэглэжээ. Эдгээр арга хэмжээ нь, уулаасаа дэс дэглэмгүй, төгөлдөржүүн дүрэмгүй, зохион байгуулалтгүй, үсэг бичиггүй байсан Монголын нийгмийг нэг алхам түлхэн ахиулжээ. Энэ бүхэн нь мөн ч Монголын түүхэнд зохих нотлууштай үйлдлийг гаргасан юм. Засаг захиргааны хувиарыг байгуулсан явдал бол овгийн байгууллын цусан барилдлагын харьцааг ихээр бууруулж, феодалын харьцааг улам цаашид хөгжүүлсэн хэрэг болно .

Түүнчлэн Чингис хаан удам их хаант улсыг байгуулснаас, монгол хүн энэ үеэс дэлхийн түүхийн тавцанд сүр жавхаатай гарч, хэзээд хүмүүст доромжлогдож байсан өчүүхэн монгол аймгийн нэр нь дэлхий ертөнцөд дуурсчээ.

Чингис хааны Монголын түүхэнд үзүүлсэн нотлууштай үйлдлийг нь багцлаад хэлбэл дээрх мэт. Гэвч энэ нь бүх хүн төрөлхтөний түүхэнд тэр мөн ийм үйлдлийг үзүүллээ гэсэн үг биш юм. Харин үүнтэйгээ яг эсрэгээр, тэр Монголын эл аймгийг нэгтгэснийхээ хойно, дотоодын нутаг дэвсгэрээ бэхжүүлэх ба нутаг дэвсгэр, эд хөрөнгө олохын төлөө гадагш түрэх дайныг дэгдээв. Ийм дайн бол түрэмгийлэх чанартай дайн мөн. Тэр, түрэмгий дайны дунд дайсан этгээдээ ялах зорилгоор, нөгөө улсын энгийн ард иргэд ба байлдах хүчингүй болсон цэргийг хүртэл ихээр алан хядаж, хот балгасыг шатаан эвдэх, аливаа соёлын бүтээлийг сүйтгэхээс ер халширдаггүй тул дайлан дагуулсан орон ялангуяа Дундад Азийг хэд хэдэн зууны хугацаагаар доройтуулжээ. Тиймээс тэр нь дэлхийн түүхэнд эвдлэх үйлдлийг үзүүлжээ. Тэр, хэдийгээр аян дайн хийхийн төлөө олон арвин замыг зассан ба Ази Европын өргөн удам нутаг газрыг эзэлснийхээ дараа, хаант улсын эл газартай харилцахын төлөө өртөөний дүрмийг байгуулснаас дорно өрнийн зам нэвтрэлгийг нээж, таваар ба соёлын солилцоог өргөжүүлсэн явдал нь бусдач талаар бас ч зохих идэвх ач холбогдолтой боловч, энэ бүх нотлууштай үйлдэл нь өргөн удам орны хүн төрөлхтөнд учруулсан түүний аюул гамшгийг нь үгүйсгэж чадахгүй. Энэ нь даруй Марксын үзэлтээс дэлхийн түүх буюу холбогдол бүхий эл улсын түүхийг өгүүлэхэд түүнд нотлох байр эс олгосон шалтгаан болно гэжээ. 1955 онд Шанхайн шинэ мэдлэг хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн Чжоу Цин Цзи-н зохиосон “Чингис хаан” гэдэг товхимолын дүгнэлтэд: Чингис хаан бол Монголын түүхэн дэх нэгэн агуу их хүн билээ. Түүний ажиллагаа нь Монголын нийгэмд маш их нөлөөг үзүүлжээ. Түүний үзэлт ба хүсэл нь тэр үеийн Монголын нийгмийн аж ахуйн хөгжлийн шаардлагатай тохиролцож, ажил үйлс нь Монголын нийгмийн аж ахуйн хөгжлийг ахиулсан тул тэр нь Монголын түүхэнд зохих давшсан үйлдлийг гаргажээ.

Чингис хаан бол Монголын түүхэнд эргэлтийн үе болж байсан цаг үед амьдарч байв. Тэр үед,

Монголын овгийн байгуулал нэгэнтээ задарч, ангийн ялгарал өдөр ирэх тутам хурцдан, феодалын байгууллын хүчин зүйл ч эхлэн бүрэлдэж, үйлдвэрлэлийн хүчний хөгжил нь үйлдвэрлэлийн харьцааны хуучин хүлээсийг эвдэхийг шаардаж байв. Чингис хаан энэхүү нийгмийн хөгжлийн шаардлагыг хангасан юм. Тэр, бүх Монголыг нэгтгэснээс нийгмийн аж ахуйн хөгжлийг саатаагч аймаг бүлгийн явцуу холбоо болон овгийн байгууллын цусан барилдлагын харьцааг устгаж, аймаг бүлэг ба овог угсааны хоорондоо тасралгүй явагдаж агсан дайн дажныг зогсоож, тэрчлэн Монголын үйлдвэрлэлийн хүчин нэгдсэн шинэ байдал доор цаашид хөгжих боломжийг олгожээ. Тэр их ор суусны дараахи аливаа арга шийдвэрээрээ хуучны овгийн байгуулалд хүнд ноцтой цохилт өгч, Монгол улсын бүрэлдэл ба нийгмийн улам дээд шат үе - феодалын нийгэм өөд шилжих явдлыг ахиулжээ.

Чингис хааны цэрэг зэвсэглэлийн доор нэгдсэн Монгол нь маш охорхон хугацаанд нэгэн хүчирхэг бадрангүй улс болж, ахуй соёлын талаар эхлэн бадарсан тул тэр нь тархай бутархай хоцрогдонгүй аймаг бүлэг биш болсон бөгөөд Алтан улсын ноёрхлоос мултарчээ. Энэ бүхэн нь Монголын ард түмэнд ашигтай явдал юм.

Чингис хааны үйл ажиллагаа нь хэдийгээр Монголын ард түмэн ба Монголын нийгмийн аж ахуйн хөгжилд ашигтай байсан боловч, тэр нь ангийн хязгаарлал ба цаг үеийн хязгаарлалыг хүлээхгүй байхын аргагүй юм. Тэр бол Монголын феодал язгууртны ашиг сонирхолын төлөөлөгч болох бөгөөд түүний аливаа ажиллагааны зорилго нь бүрэлдэж бүхий феодалын байгууллыг бататгах, ард түмнийг язгууртаддаа албадан дагуулах ба язгууртан ангийн ноёрхлоо чангатгахын төлөө тавигддаг, гадааддаа нутаг бэлчээр, боол зардас ба эд хөрөнгийг булаахын төлөө өргөн хэмжээний дайн байлдааныг хийдэг билээ.

Чингис хаан болон түүний залгамжлагчдын явуулсан дайн нь хэдийгээр Монголчуудыг өндөр хөгжилтэй феодалын аж ахуй ба соёл лугаа танилцуулж, түүнчлэн Монголын нийгмийг нэн өндөр шат өөд хөгжүүлсэн боловч, эдгээр дайн нь дайлагдсан улс оронд туйлын их аюул гамшгийг учруулж, Ази Европын түүхэнд том их нөлөөг үзүүлсэн юм. ...

Багцлаад хэлбэл, Чингис хаан ба түүний залгамжлагчдын гадагш дайлсан дайн нь Монголын нийгмийн дэвшлийг түргэтгэсэн бөгөөд Монголын нийгмийн дэвшилд нь маш олон улс орны ард түмэн хатуу хүнд үнэ өртгийг зарцуулсан юм гэжээ.

Наньжин Их Сургуулийн профессор, монголч эрдэмтэн Хань Жо Линь 1962 оны гуравдугаар хугацааны “Түүхийн судлал” сэтгүүл дээр “Чингис хааны тухай” гэсэн сэдэвтэй өгүүллийг нийтлүүлжээ. Доор гол гол үзэлтээс нь танилцуулъя:

Өнгөрсөнд зарим түүхчид Чингис хааныг бүрмөсөн үгүйсгэдэг. Тэд дайны явц дахи Монголчуудын алаан ба эвдлээнийг нь товойлгож, Чингис хааны үзүүлсэн түүхэн дэвшилт үйлдлийг нь олж үздэггүй байна. Чингис хааныг сайн гэж үнэлдэг хүмүүс ч байдаг. Жишээлбэл, арван гуравдугаар зууны сүүлчид биеэрээ Дундад улсад ирсэн итали хүн Марко Поло, францын түүхч Ро.Анвер (1224-1317 он) жич бага Арменийн Хайдум болон Гүржийн түүхчид зэрэг болно. Гэтэл тэдний үнэлэлт ч тус тус голдлоготой байдаг. Тиймээс Монголын түүхэнд, Дундад улсын түүхэнд ба дэлхийн түүхэнд үзүүлсэн Чингис хааны үйлдлийг нь өнөөдөр бид залгалдаагаар хянаж магадлах нь хэрэг үгүй явдал биш байх аа. ...

Одтой тэнгэр орчиж

Олон улс байлдаж

Орондоо унтах завгүй

Олзлолдон булаалдаж байв гэсэн “Монголын Нууц товчоон”-ы 254 дүгээр зүйл дэхи энэ бадаг шүлэг нь арван хоёрдугаар зууны сүүлчийн үеийн Монголын өндөрлөг дэх нийгмийн самуун байдлыг тэр ёсоор нь тусгажээ. Энэхүү самуун байдал бол тэр үе дэх аймаг бүлгийн хооронд явагдаж асан өсөл хясал ба дээрэмдэл талхидлын дайны үр дүн болно. Чингис хааныг илрэхээс өмнө, тэдэнд удирдагч буюу эзэн тэргүүлэгч байгаагүй. Тэд нэг хоёр аймаг бүлгээрээ тархан нутаглаж, харилцан холбоолдоггүй бөгөөд хоорондоо тасраагүй дайтдаг буюу дайсагнадаг байна. ...Бас Алтан улсын хаан нь үргэлж тэдний эд хөрөнгийг албадан татах буюу дээрэмдэн булаадаг байна гэж арван гуравдугаар зууны үеийн Персийн түүхчин бас хэлж байв. Энэхүү хэмжээ хэрээгүй дайны дунд, Монголын өргөн олон ард түмэн нь маш их аюул гамшиг ба үхэл мөхөлд учирчээ. Тэр үед хэн хэрвээ эл аймгийг нэгтгэж, дээрэмдэл талхидал ба алаан хядааныг зогсоож чаддаг бол тэр даруй ард түмний хүрээлэл ба магтаалыг олох ёстой бөгөөд тэр даруй түүхийн хөгжлийг ахиулж чадах ёстой байсан. Чингис хаан бол даруй энэхүү агуу их үүргийг биелүүлсэн хүн юм.

Тэр үед Монголын өндөрлөгт маш олон овог аймаг байжээ. Эдгээр аймгууд урт хугацаагаар өсөл хяслын дайн ба булаан дээрэмдэх дайныг хийж, монголыг бутрал самууралд тулгаруулжээ. Хамгийн сүүлд нь Чингис хаан тэдгээр аймаг бүлгүүдийг цөм ялж, бүх Монголыг нэгтгэсэнээс ард түмэн сая амар түвшнийг эдлэв. Хэлэлгээнгүй, Чингис хаан нь мөн бусад хэдэн аймаг бүлгийн түрүүчүүдтэй адил ард түмний амар түвшний төлөө санаачилгатайгаар хийсэн биш, харин бузар хүсэл - ховдоглол ба эрхийг хүсэх-ийн үүднээс дайлж байсан юм .

Чингис хаан Монголын эл аймгийг нэгтгэсэнээс хойно, монгол бус төрлийн ард түмэн ч хамрагдан ирсэн нь цөөнгүй байлаа. Ингээд хоморхон зуур монгол гэдэг нь хүч их, ард иргэн олонтой хамтлаг цогцын нэр болон дуурсчээ. Хэлэлгээнгүй, Чингис буй болсноос монгол үндэстэн сая буй боллоо гэж хэлж үл болно. Гэвч Чингис хааны нэгтгэсэн үйлс нь монгол үндэстний бүрэлдэлд маш их гавьяа зүтгэл үзүүлснийг үгүйсгэж үл болно. Татаж хэлэхэд, агуу их монгол үндэстний дэлхийн түүхэнд үзүүлсэн чухал үйлдэл нь Чингис хааны үеэс эхэлсэн гэж бид үзэлтэй.

Чингис хаан түрүүтэй язгууртдад авч хэлбэл, дээрэмдлээр олох нь хөдөлмөрөөр олохоос бас өнгө гэрэлтэй байдаг. Тиймээс Монголыг нэгтгэсний дараа, нийгмийн дэглэм хэдийгээр төвширсөн боловч тэд мал аж ахуйг хөгжүүлэх явдлыг эрхэмлэхгүй, харин Монголын малчдыг Монголын өндөрлөгөөс хол татан аваачиж, зэргэлдээ улс оронд гүнзгийрэн өргөн хэмжээний дээрмийн дайныг хийж байв.

Умард Дундад улс нь Ань Ши-гийн самуурлаас хойш хэсэглэн тусгаарлах байдалд оржээ. Хятанчууд Янь Юнь-ий арван зургаан чжоу-г эзлэн авснаас Бай Гоу Хэ гол нь Хятан болон умард Сүн хоёр улсын хоорондохи давшгүй зааг болсон байна. Арван хоёрдугаар зууны эхээр Жүрчин үндэстэн өмнөш халдаж, Хуй Хэ голын дундад урсгалаар зааглан Дундад улсыг хоёр

хэсэглэжээ. Үүнээс гадна, Тангудчууд Хашиныг эзлэн, хар Хятанчууд Шинжаан болон түүнээс барууншихи оронд улсаа байгуулав. Чингис хаан дэгжрэн мандах үед Дундад улс яг энэ мэт сарнин задарч, доройтон мөхөх байдалтай болоод байсан юм.

Мөхлийн шатандаа хүрсэн энэ хэдэн хаант төрийг Чингис хаан бут ниргэсэн буюу эхлэн бут ниргэж, эл үндэстний хоорондохи зааг хилийг цэвэрлэн, Хятад үндэстнийг салгасан хэрмийг нурааж, Хань улс, Тан улсаас нааш олон үндэстнээр бүрэлдсэн манай их гүрний байдлыг нь сэргээжээ. Ингээд эл үндэстний ард түмний санаа сэтгэл нь дороо хувирсан билээ

Манай улсын түүхнээс үзэхүл, умар дахины үндэстэнд маш олон шалгарсан удирдагчид байжээ: Хүннүгийн Мэдоу (Модунь – хө.), Түрэгийн Түмэн ... бол цөм нэгэн үеийн баатарчууд билээ. Гэтэл тэд яагаад Дундад орныг эзэлж чадсангүй, гагцхүү Чингис хаан болон түүний үр ач нар л биелүүлж чадсан буй? гэвэл, Чингис хаан нь Мэдоу зэрэг хүмүүсээс онцгой илүү чадвартай буюу зэвсэгт хүчний талаар онцгой хүчирхэг биш бололтой. Харин тэр үеийн умард Дундад улс нь онцгой дорой буурай байсан тул дээрх хүмүүсийн нүүрлэлдэж агсан Хань улс, Тан улс лугаа адилтгавал байдал ихээхэн зөрөөнтэй байжээ.

Тухайн үед Тангуд бол хамгийн бага улс байсан, тэр нь “Ляо улс, Алтан улс, Сүн улс лугаа дамжин оршихдоо гурван улсын хүчний хүчирхэг буурайг нь үзэж холдох ойртохоо тасраагүй хувируулж байсан билээ”. Гэтэл ийм нэгэн өчүүхэн улсыг Чингис хаан дөрвөн удаа дайлж, үхэхээсээ өмнө бас түүний эцсийн мөхөлтийг нь олж үзсэнгүй юм. Үүнээс үзэхүл, түүний зэвсэгт хүчин нь хандсан зүгтээ дайсангүй байсан биш байна.

Монгол болон Алтан улсын хоорондохи дайн нь хамгаас удаан явагдаж, дайны гамшиг ч хамгаас сүрхий их байсан юм. Ингээд зарим хүмүүс “Голын умардын амьтай зүйл дуусч, хээр хөдөөг хувхай ясаар дүүргэв” гэсний хариуцлагыг цөм Чингис хаанд нөмөргөдөг билээ. Энэ нь голч гэж үү? Бид Алтан улсын дотоод байдлыг нарийн задалж үзээд, тийм дөхөмхөн дүн өгч болохгүй гэж үзэж байна.

Мөхөл доройтолдоо тулсан Алтан улсын хилд Монголын цэрэг хүрмэгц бүх зөрчлүүд нь илэрч байсан....

Чингис хааныг мандах үед, Алтан улс нь задралтынхаа ирмэг дээр хүрээд байжээ. Тэр үед Өмнөд Сүн улс болон Алтан улсын хооронд, Тангуд улс болон Алтан улсын хооронд, Монгол улс болон Алтан улсын хооронд, Хятан болон Алтан улсын хооронд дайн байлдаан үүсч байснаас гадна, Алтан улсын дотооддоо бас тариачдаас газрын эзнийг эсэргүүцэх ангийн зөрчил ба хятад үндэстэн, Хятан үндэстнээс Жүрчиний төрийг эсэргүүцэх үндэстний зөрчлөөр бялхаж байснаар барахгүй, газрын эздийн дотроо ч Жүрчин хаанд залгалдаагаар үйлчлэх юм уу, эсхүл Монголын хаанд бууж өгөх үү? гэсэн зөрчлөөр дүүрч байв. ... Тиймээс бид энэ бүх аюул гамшгийг цөм Чингис хаанд нөмөргөх нь бодтой байдал лугаа тохирохгүй нь илхэн байна.

Гэвч ийм аюул гамшгийн нэг хэсгийг нь бас ч Чингис хаан буй болсон юм. Чингис хаан Дундад оронд анх орохдоо зөвхөн эд бодосыг дээрэмдэх зорилготой тул нутаг дэвсгэрийг нь эзлэхгүй байсан юм. Хатан голоос умаршихи Алтан улсын нутаг дэвсгэрийг арван нэгэн чжоу сянь-аас бусдыг нь бүр эзэлсэн боловч тэр Алтан улсын эвслийн нөхцөлийг нь хүлээн авч

Цавчаал боомтоос ухран гарсан билээ. Монгол бол малжлаар аж ахуйгаа болгодог тул их хэмжээний хөдөлмөр хүч хэрэгцээгүй байдаг бөгөөд ард түмнийг алан хядахаас халширдаггүй

... Чингис хаан цэрэг дайны хэрэгцээнийхээ төлөө тухайн үе дэх дэлхий дээрх янз бүрийн хамгийн давшсан цэрэг дайны туршлага ба мэргэжлийг аль болохоор оруулан ирж байв. Ингээд тэр Дундад орноос олон тооны гар урчууд - нум үйлдэгч, хуяг үйлдэгч, дуут сум үйлдэгч, хот дайралтын зэвсэг үйлдэгч ... зэргийг элсэн цуглуулсан байв. Ингээд Монголчуудын зэр зэвсгийг сайжруулсан бөгөөд гар үйлдвэрийн мэргэжлийг нь ч дамаар дээшлүүлжээ. Тэр бас гүүр тавих мэргэжил ба пайз тэмдгийн дүрэм, өртөө улааны дүрмийг Дундад орноос оруулж, тэдний зам нэвтрэлгийн нөхцөлөө сайжруулсан бөгөөд Дундад орны эмчийг голлон хэрэглэж, Монголын эм эмнэлгэ ба эрүүл хамгааллыг сайжруулжээ. Ялангуяа олон тооны тариачдыг говийн умардад авчирч, Монголын тариаланг хөгжүүлжээ. Чингис хааны гол зорилго нь хэдийгээр эдгээр тариачид, мэргэжилтэд ба гар урчуудыг ашиглаж зэвсэгт хүчээ чангатган, дээрмийн дайныг хийх гэсэн боловч нөгөө талаар Монголын эд бодосын амьдралын нөхцөлийг сайжруулж, үйлдвэрлэлийн хүчийг хөгжүүлсэн тул тэр нь Монголын ард түмэнд ч идэвхитэй үйлдлийг үзүүлжээ

Чингис хаан Номхон далайгаас баруунш Каспийн тэнгис хүртэлх зааг хязгаарыг цөм цэвэрлэн нэвтрүүлэв. Тэр үеийн дэлхийн байдлаар авч хэлбэл, соёл аж ахуй хамгаас илүү хөгжсөн орны нэг нь Дундад улс байв. Дундад улсын байдлаар авч хэлбэл, Дундад орны соёл аж ахуйн хөгжилт нь хамгаас өндөр байв. Харь үндэстний хүмүүс олон тоогоор Дундад улсад орж ирсэн ба цөөн тоот үндэстнүүд бүлэг бүлгээр дотор газар шилжин суурьшнаас тэд нар аж ахуй соёлын талаар чадвараа бадруулах тохиолыг олжээ. Ялангуяа дотор газар орж ирсэн цөөн тоот үндэстнүүд эх орны найраглал, шүлэг дуулал, уран бичлэг, зураг зурмалын талаар эм эмнэлгэ ба тариалан шинжлэх ухааны талаар гарамгай бүтээлийг бүтээжээ.

Чингис хааны байгуулсан хаант төрийг Дундад улсын бүх түүхийн хувиас үздэг бол нийгмийн аж ахуй нь хөгжсөн юм уу? Ухарсан юм уу? гэвэл, цөөн тоот үндэстэн Дундад улсын хаан суусан цаг үе бол харанхуй цаг үе гэсэн хэлбийгүү үзэлт зарим Хятадын дээрэнгүй үзэл бүхий түүхчдийн нүдийг бүрхэж байдаг. Тиймээс тэд өөрийнх нь хэрэгцээнд тохирсон хэсэг бусаг түүхэн материалыг олмогц улмаар өргөтгөх ба түгээмэлжүүлж, тэрхүү түүхэн цаг үеийг орчлон дахи тамын орон болгон дүрслэдэг билээ. ...Аль нэгэн феодалын хаант төр ч гэсэнгүй цөмөөрөө үндэстний гяндан юм. Зохих цаг үе буюу зохих нөхцлийн доор, үндэстний зөрчил бүр товойн илэрдэг билээ. Монголын хаант төрийг өчүүхэн ч гэгээгүй гэж үзэх нь түүхийн үнэн лүгээ нийцэхгүй юм.

Чингис хаанаас Юань улсын Ухаант хаан хүртэлх энэхүү хаант төрийг ерөнхийд нь хоёр шат хуваан үзэж болно. Хубилай хаанаас өмнө, Хар хорумаар улс төрийн төв болгосон нэгдмэл төр байсан бөгөөд соёл аж ахуй өндөр хөгжилттэй Хятад орон бол зөвхөн энэ улсын нэгэн хэсэг нь болж байжээ. Харин Монголын язгууртад нь энэ оронд зөвхөн хүн томилж, хэрэгцээтэй зүйлсээ тонон хураахаас биш, бүх хүчээ энэ оронд тавьсангүй байлаа. Хубилай хаанаас хойш баруун хойдохи харьяатууд нь тусгаарлаж, төр улс нь хагарсан тул тэр зөвхөн дорно дахинаа эзэлж бараг л ганц Дундад улсын хаан болсон юм

Монголын ноёрхогчид аж ахуйгаар хоцрогдонгуй хил хязгаар оронд цэргээр тариалуулах

бодлогыг хэрэгжүүлсэн нь тун их амжилтыг олжээ. Энэхүү цэргээр тариалуулах бодлого бол Чингис хааны үеэс даруй эхэлсэн юм. Тэр, олон тооны хятад тариачдыг говийн умардад нүүлгэж, Хингайгаар захируулан тариалах явдлыг өрнүүлж байв. Хожим нь түүний үр хүүхэд ч энэхүү бодлогыг нь залгалдаагаар хэрэгжүүлж байв. ...

Монголын Орхон голын сав газраас баруун өмнөдийн Юнь Нань зэрэг муж хүртэл нутаг газрыг нээсэн нь Хань улс, Тан улсаас нааш ер байгаагүй юм.

Монголын ноёрхогчид адуу малжихын тулд бэлчээрийн газраа ч өргөтгөжээ... .

Монголын хаан цэргээр тариалах ба талбайн тухай засгаа чангатгасан явдлаа улсын дотоодын эл үндэстний ард түмнийг дарангуйлах ба амуу хүнс, зам нэвтрэлгийн асуудлаа шийдвэрлэхэд зориулсан боловч, тариалах газар ба бэлчээрийн талбай нь үрэгдэж, тариалангийн бүтээгдэхүүн болон малын тоо толгой нь нэмэгдсэн тул нийгмийн аж ахуйн хөгжилд ашигтай байсан юм....

Юань улсын үед ноёд түшмэдийг дэвшүүлж бууруулах нь түүний тариалан үйлдвэрлэл дэх амжилтаар тогтоодог гэдэг билээ. Хэлэлгээнгүй энэ нь бичиглэл төдий л юм. Гэвч үйлдвэрлэлийн тухай алдаа оноог тоо баримтаас үзэхүл, ядахдаа зохих цагийн дотор үйлдвэрлэлийн хүч нь үнэнхүү жил тутам нэмэгдэж байжээ. ... Хэрвээ Юань улс нь Монгол хүн хаан суусан учраас нийгмийн аж ахуй доройтлоо гэж хэлдэг бол түүхийн бодот байдалтай лавтайяа тохирохгүй юм .

Чингис хаан баруунш дайлсан тухай одоо манай олж уншсан тэмдэглэл бол голдуу Исламын шашинт газрын эзний сэхээтдийн тэмдэглэл болно. Монгол хүн бөө мөргөлийг шүтдэг болохоор, Исламын шашны зан заншлыг тийм их хүндэтгэхгүй нь магад хэрэг юм. Тиймээс эдгээр Исламын шашинт түүхчид Чингис хааныг зүхэн хараах нь ч дамжиггүй билээ. Тиймээс бид эдгээр тэмдэглэлүүдэд шүүмжлэлтэйгээр хандах хэрэгтэй . Чингис хаан насаараа байлдаж Дөчин улсыг мөхөөлөө гэж түүхчид хэлдэг. Баруун оронд устгасан эл улс ч энэ тоонд багтах ёстой. Эдгээр улсууд боол эзэмшигчид болон феодалууд өөрийн ноёрхлоо мөлжлөөр бататгахын тулд өөрийн улсаа хориот орноор үзэж, тус улсынхаа ард түмний чих нүдийг нь халхалж, гадаад улс лугаа зааглаж тасалдаг билээ. ... Нэгэн үеийн тэнгэрлэг хөвгүүн илэрсэн тэр үеэс, тэдгээр ард түмнээ хорин битүүлж байсан их бага дөчин улс-ын болд төмөр хэрмийг нь морин тойргоороо болов тойрч, тэндэх ард түмнийг ажиллууштай нэн их ертөнц лүгээ, суралцууштай нэн өндөр соёл лугаа танилцуулан учруулжээ. Түүхийн хөгжлийн хандлагаас үзэхүл, Чингис хааныг үгүйсгэж болох уу? Дөчин улсыг мөхөөхөд цус урсахгүй, эвдлэхгүй байж чадахгүй, гэвч бидний эл аймаг улсын их бага боол эзэмшигчид ба феодалуудын цаазлан битүүлэхийг нь хүрээлэх үү? Эсхүл Чингис хаанаас хорио цаазыг эвдэж, эл үндэстний ард түмэнд аж ахуй соёлын талаар харилцан солилцох, харилцан суралцах нөхцөлийг буй болгож өгснийг нь сайшаах уу? Нийгмийн хөгжилд ахиулах үйлдлийг үзүүлдэг нь хорио цааз юм уу? Эсвэл хорио цаазыг эвдлэх явдал уу? Хэлэлгээнгүй өмнөх нь биш юм .

Чингис хаан дорно өрнийн харилцааны их зам дээрх энэтээх тэртээх зааг хязгаарыг нь цэвэрлэсэнээс, аж ахуй соёлын солилцоог харшлагч бэхлэлт цайзыг нь нурааснаас дорно өрнийн зай нь ойртож, харилцаа нь олширчээ. Дундад улсын дарь, цаасан зоос, өртөөний

дүрэм мэтийн үүдэлт бүтээлт нь өрнө дахинд нэвтэрч, өрнөдийн эмийн зүйл, нэхмэл бодос, одон орны ухаан зэрэг нь ч Дундад улсад нэвтрэн иржээ. ... гэжээ.

1962 оны 6 сарын 22-ны өдрөөс 29 өдөр болтол, Өвөр Монголын Түүхийн Нийгэмлэгээс эрхэлсэн Чингис хааны мэндлэсэн 800 жилийн ойг дурсгах монгол түүхийн шинжлэх ухааны ярилцаан Хөх хотод явагджээ. Ярилцаанд Дундад улсын Монголын судалгааны эрдэмтэд ба ажилтадын төлөөлөгчид оролцсон байв. Энэ удаагийн ярилцаан нь Чингис хааны тухай судлалын түүхэн дэх анхдагч эрдэм шинжилгээний ажиллагаагаар тэмдэглэгдэх ёстой. Тэр нь шинэ Дундад улсын үндэстнүүдийн бүрэн эрх тэгш ба эрдэм шинжилгээний чөлөөтэй байдлыг харуулсан байв. Ярилцаан дээр Чингис хааныг үнэлэх талаар олон талын саналыг төвлөрөнгүй тусгасан байна. Энэ тухай “Түүхийн судлал” сэтгүүлийн 1962 оны дөрөвдүгээр хугацаанаа доорхи мэт хураангуйлжээ.

“Чингис хаан бол Монголын үндэстний баатар, манай улсын түүхэн дэх гарамгай нэгэн эзэн хаан” гэж ярилцаанд оролцогсад нийтээрээ санал нэгтэй үзэж байв.

Чингис хааны монгол үндэстний гавьяа зүтгэлийг нь төгөлдөр нотолбол зүйтэй гэж ярилцаанд оролцогсад бас нийтээрээ үзэж байв. Чингис хаан Монголын тал нутагт тархай бутархай амьдарч байсан нүүдэлчин аймгуудыг бүлгэмдүүлж, Монголын хаант улсыг байгуулснаас Монгол үндэстэн нь бүрэлдэн тогтносон юм. Монголын хаант улсыг байгуулснаас хойш, Монголын аж ахуй, улс төр ба утга соёл нь маш их хөгжив. Мал аж ахуйн эзэгнэлт дээшилж, Монгол оронд тариалан ба гар үйлдвэр хөгжиж, үндэстний хот балгастай болов. Бас үндэстний үсэг бичиг үүсч, Монголын нийгэм нь түргэнээр хөгжсөн байна. Олон үндэстэнтэй манай улсын түүхэнд, аль нэгэн ах дүү үндэстэн нь Чингис хааны үеэс эхлэн бүрэлдсэнээс хойш, одоо болтол уламжилж ирсэн тул Чингис хааны гавьяа зүтгэлийг үгүйсгэж болохгүй гэж зарим хүмүүс үзэцгээжээ. Чингис хаан бол арван хоёрдугаар зууны сүүлч, арван гуравдугаар зууны эхний үеийн Монголын нийгмийн дэвшилтийн явц дахи төлөөлөгч хүн мөн гэж бас зарим хүмүүс үзэцгээжээ.

Монголын хаант улсыг байгуулах тэмцлийн дунд илрэн гарсан Чингис хааны хувь хүний үйлдлийн тухай олноороо өндөр үнэлэлт хийжээ. Чингис хаан бол эрдэмтэн чадвартныг эрхэмлэн хэрэглэдэг, агуу чадвар алсын бодлоготой төрийн зүтгэлтэн болох бөгөөд цэрэг хэрэглэхэд сахиулсан мэт удирдагч болно гэж үзэцгээжээ. Чингис хаан Монголын эл аймгийг нэгтгэх тулгам эрмэлзлэлтэй байсан нь хэрэг дээрээ ард түмний хүслийг тусгажээ гэж байсан зарим хүмүүс үзэцгээж байв.

Чингис хаан өмнөш Дундад орныг дайлсан тухай

Чингис хааны байгуулсан Монголын хаант улс нь Юань улсын үеийн их нэгдлээр манай улсын түүхэн дээрх Сүн улс, Алтан улс, Тангуд улс, Төвд, Да Ли зэрэг улсуудын хэсэглэн захирч байсан байдлыг эцэслүүлж, олон үндэстэнтэй нэгдсэн Дундад улсын бүрэлдэл ба хөгжилд чухал хувь нэмрийг оруулсан билээ. Энэ бол олны санал нэгтэй үзэлт болно. Монгол үндэстэн болон Дундад орны харилцаа бол урьдаас байсан бөгөөд Чингис хаан болон түүний үр ач өмнөш Дундад оронд орж бүх улсын эзэн болсон явдал бол тухайн үеийн аж ахуй, улс төр хөгжсөний үр дүн болох бөгөөд гүн гүнзгий бусдач суурьтай гэж ярилцаан дунд дурдацгааж байв.

Чингис хаанаас Алтан улс ба Тангудыг дайлсан дайныг бодтойгоор задлан ярилцах үед, доор дурдагдах хэдэн зүйлийн адил бусын саналыг тавьж байв.

Зарим хүний үзэхээр бол, Чингис хаан Алтан улсыг довтолсон дайн нь бод биеэрээ тэрслүү дайн болох бөгөөд түүний зорилго бол эд хөрөнгийг дээрэмдэхэд оршино. Өшөө авна гэдэг нь шалтаг төдий л юм. Зөвхөн сүүлчийнх нь үр дүнгээс үздэг бол энэ удаагийн дайн нь хожмын Юань улс бүх улсыг нэгтгэхэд бусдач талаар ашигтай байв гэжээ. Бас зарим хүний үзэхээр бол, монгол цэрэг нь Алтан улсыг дайлсан ба Тангудыг мөхөөсөн явцад Хуабэй орон ба Хашин орныг маш их сүйтгэсэн бөгөөд зарим хот балгасыг хэрцгий балмадаар хядсан байна. Энэ цөм хортой явдал болох бөгөөд тухайн үед бүх улсыг ихээр нэгтгэхэд зарцуулсан үнэ өртөг болно. Ангит нийгэмд түүхийн удаа бүрийн их их дэвшилтэд ард түмэн байнгадаа хүнд их үнэ өртгийг зарцуулж байдаг гэжээ.

Зарим хүмүүс эдгээр үзэлтийг нь зөвшөөрөхгүй байлаа. Тэдний үзэхээр бол, Чингис хаан Алтан улсыг дайлсан явдлаар Монголын ард түмний мөлжил дарлалыг эсэргүүцэх хүслийг нь тусгажээ. Учир нь Алтан улсын ноёрхогчид нь Монголын эл аймгийг албадан жил бүр алба өргөл татаж, аж ахуйн талаар цөлбөн хяхдаг байлаа. Бас Алтан улсын Сицзун хааны үед Цэрэг эрийг устгах гэсэн зусар хэрцгий төрийн бодлогоо Монголын эл аймагт хэрэгжүүлж, гурван жил бүрд нэг удаа их алаан хядаан хийдэг байна. Алтан улсын ноёрхогчид бас Монголын тал нутгаас хүн амыг уулгалан дээрэмддэг бөгөөд барьж ирсэн хүмүүсээ Шаньдун, Хэбэй зэрэг хол газар боол болгон худалддаг байв. Алтан улсын ноёрхогчид нь Монголын эл аймаг бүлгэмдэн нэгдэхээс айж, эдгээр аймгуудыг үргэлж хатган завсардуулж, харилцан алан хядуулж байв. Чингис хааны Алтан улсыг дайлсан дайны шинж чанар нь зөвхөн сүүлчийн үедээ үндэстний дарлалыг эсэргүүцэж байснаасаа хувирч, эд бодосыг булаан дээрэмдэх ба орон нутгийг нь дайлан дагуулах шударга бус дайн болжээ гэв.

Бас зарим хүмүүсийн үзэлтээр бол, Монголчууд Алтан улсыг дайлсны улмаар Дундад орны соёл боловсныг хүлээх замыг нээжээ. Чингис хаан Елюй Чусай зэрэг хүмүүсийг элсэн хэрэглэсэн явдал бол Дундад орны уламжлалт ноёрхох аргыг хүлээн авсны эхлэлт болно. Энэхүү хувиралтын явц нь Чингис хааны өтөл үеэс эхэлж, Хубилайн үе болтолхи урт хугацаанд үргэлжилжээ гэлээ.

Чингис хааны баруунш дайлсан дайны тухай санал гэвэл: Чингис хааны баруунш дайлсан явдлыг хэрхэн зөв үнэлэх тухай ярилцааны явцад бахтайгаар маргалдацгааж байлаа.

Нэг зүйлийн санал бол: Чингис хааны баруунш дайралт бол Хорезмын ноёрхогчид Монголын элчийг алж, Монголын арилжааны бригадыг хядан дээрэмдсэн тул Чингис хаан Хорезм лугаа энх тайвнаар харилцаж арилжаа худалдаа хийх бодлогоо сая орхижээ. Дараа нь дайны хэмжээ өргөдөхийг дагалдан, монгол цэрэг ч улам улмаар барууншлав. Тухайн үед Монголчууд нь овгийн нэгдлийн сүүлч үеэс ангит нийгэмд саяхан шилжин орсон шатад оршиж байсан тул алж шатаах булааж дээрэмдэх нь зайлшгүй юм. Бас Монголчууд нь нүүдэлчин үндэстэн болохоор, тал нутгийн амьдралын дадал ба нүүдэлчний амьдралын аргаа үндэслэж, хот балгасыг эвдэн, тариа төмсийг атаршуулсан тул тус орны аж ахуй соёлын хөгжилд нь нэгэн цагийн нугарал ба сүйрлийг учруулжээ. Гэвч дайны нэвтрэлгэ ба дайны түүхэн үйлдэл нь адилгүй байдаг билээ. Чингис хаан баруунш дайлсны гавьяа нь Хаант Монгол Улсын нутаг дэвсгэрийг өргөтгөсөнд байгаагүй, харин дорно өрнийн харилцаанд нэгэн зам нэвтрэлгийг

нээн өгсөнд оршино. Чингис хаан болон түүний үр ачаас ноёрхож агсан үед дорно өрнийн хуурай замын нэвтрэлгэ саад тороогүй болж, зүг бүхэнд өртөө замыг байгуулснаас арилжаа худалдаачдын явалцахад тун их дөхөм болсноор барахгүй, дорно өрнийн соёлын солилцоонд чухал үйлдлийг үзүүлжээ. Тэр үед, Дундад Ази ба өрнө дахины эм эмнэлэг, нэхмэл бодос, цаг улирлыг бодох арга зэрэг Дундад улсад нэвтрэн ирсэн бөгөөд Дундад улсын дарь, цаасан зоос, хэвлэлийн мэргэжил зэрэг ч өрнөдийн хол дахинд нэвтрэн хүрсэн байна. Эдгээр зүйлсийг нь нотолбол зохино гэжээ. Бас зарим хүмүүсийн үзэхээр, Монголын язгууртад нь дөхөмхөн дээрэмч биш, харин газар нутгийг нь оруулж, ард иргэдийг нь эзлэгч дайлан дагуулагч болно. Хэдийгээр зэр зэвсгээр дайлан дагуулах үед сүрхий их эвдрэлтэд учруулсан боловч, Монголын ноёрхогчид нь хожимдоо тэр тухайн дэвшилт орны ноёрхох хэлбэр маягийг нь хүлээн авсан байна. Жишээлбэл, Ил хант улсын соёл нь арван гурваас арван дөрөвдүгээр зууны үед маш их хөгжиж, Хазан мэтийн мэргэн гэгээн эзэн буй болж байв. Тиймээс бодтой байдлыг бодтойгоор задлан судлах хэрэгтэй. Харин тэр бүхнийг дөхөмхнөөр үгүйсгэж болохгүй гэжээ.

Нөгөө нэг зүйлийн санал бол яг эсрэг байлаа: Чингис хааны баруунш дайралт бол Монголын цэргийн язгууртадын дэгдээсэн дээрмийн тэрслүү дайн болох бөгөөд Монголын ноён язгууртан ангийн мөн чанрынхи нь илрэл болно. Ноён язгууртад нь саяхан овгийн нэгдлийн үеэсээ ангит нийгэмд шилжсэн болохоор дээрэмч чанар ба эвдлэгч чанар нь ихээхэн байсаар билээ. Тиймээс өнгөн талын илрэлийг нь үндсэн шалтгаанаар үзэж болохгүй. Хорезмынхон элчийг алж эдийг дээрэмдсэн явдал нь зөвхөн Монголын язгууртадын дээрмийн дайн дэгдээхийнх нь шижим л болж байсан юм. Дайн бол төрийн бодлогын үргэлжлэл болохоор, баруунш дайслыг үндсэн зорилго нь Монголын язгууртад өөрийн эд хөрөнгөө өргөтгөж, ховдог хүслээ хангахад оршино. Чингис хаан тэргүүтэй Монголын ноёрхогчид нь өөрийн цэргийн тоо олонгүй болохоор дайсан этгээдийн хүн амыг их хэмжээгээр алан хядах байлдах бодлогыг авчээ. Монголын язгууртад баруунш хийсэн дайралтынхаа явцад Дундад Ази, жич зүүн Европод хүнд сүрхий эвдлэгийг хийжээ. Бухара, Самисхан (Самаркандыг хэлж байна – эшлэгч), Ургенч зэрэг хөгжингүй хот балгас бүр алаан талхианд дайрагдсан тул хөдөлмөр хүч цөөрч, тариалан гар үйлдвэр ирмүүн доройтож, энэ орчмын аж ахуй соёлын хөгжил нь ухарсан бөгөөд өргөн олон ард түмэнд хүнд сүрхий аюул гамшгийг тулгажээ. Монголын язгууртад нүүдэлчин амьдралын хоцронгуй арга хэлбэрээс үүсч, хүн алан, хотыг эвдэн, тариаланг атаршуулсан явдал нь нийгмийн дэвшил хөгжлийг саатаасан тэдний тэрслүү чанарыг илрүүлж байна. Зарим хүмүүсийн үзэхээр, Дундад орны дээд хөгжил бүхий соёл аж ахуй нь яг соронзон гүр мэт умардын үндэстнүүдийн анхаарлыг татаж, манай улсын түүхэнд үндэстний харилцааг буй болгожээ. Тиймээс Чингис хаан өмнөш Дундад оронд орсон явдал нь түүхийн зайлшгүй бусдач чанарт шалтгаална. Энэхүү үндэстнүүдийн харьцаа нь мөлжлийн байгуулал доор, зэр зэвсэг ба дайн байлдааны аргаар биелэгддэг юм. Гэтэл Чингис хааны баруунш дайралт нь үүнтэй адилгүй, түүнд ийм түүхийн урьдал байгаагүй. Тиймээс Ази Европыг алсласан Хаант Монгол Улс нь зөвхөн түр цагийн цэрэг дайн ба засаг захиргааны холбоо болох бөгөөд тэр нь дэмий удсангүй сарнин бутарсан биш үү? Зарим хүний үзэхээр, Монголын цэргийн язгууртад сүүлдээ Иран зэрэг боловсон улс оронд зарим талаар төв голч улс төрийг хэрэгжүүлсэн явдал нь эцсийн эцэстээ тэдгээр улсын нэлээд дээд хэмжээний боловсон соёл нь Монголын язгууртадыг хайлуулсанд оршино гэжээ. Бас зарим хүмүүсийн үзэхээр, тухайн үеийн хэвшмэл аж ахуйн байдал доор, дорно өрнийн зам нэвтрэлгийн үйлдлийг ихэсгэж болохгүй. Хэрвээ үйлдвэрлэлийн арга маягийн дотоод

хөгжлөөр үндэс болгохгүй бол онц зарим нээн бүтээлтийн нэвтрэлцэх нь нийгмийг түлхэн урагшлуулах талаар мэдэгдэхүйц үйлдэл гардаггүй юм гэжээ .

1979 онд засвар оруулж дахин хэвлүүлсэн Дундад улсын хятад хэлний бүрэн тайлбарт толь Үгсийн далай гэдэгт:

Чингис хаан (1162-1227 он) бол Юань улсын Тайцзу, нэр Тэмүжин гэдэг. Тэр бол эртний Монголын удирдагч, цэрэг дайны зүтгэлтэн ба улс төрийн зүтгэлтэн болно. Монголын Боржигин овогтны гаралтай. Арван хоёрдугаар зууны сүүлч ба арван гуравдугаар зууны эхээр Монголын нийгмийн үйлдвэрлэл цаашид хөгжиж эл аймгийн хоорондоо аж ахуйн харьцаа холбоо олширсноос монгол үндэстний ард түмэн нэгтгэхийг хүсэн эрмэлзэж байв. Тэр, Монголын язгууртны ашиг сонирхлыг төлөөлж, Монголын эл аймгийг нэгтгээд 1206 онд их хаанаар сонгогдож, Чингис хаан гэж өргөмжлөгдөж, Монголд хаант улсыг байгуулав. Ингээд цэрэг дайн, улс төр, хууль засаг зэрэг дүрэм тогтоолыг тогтоож, үсэг бичгийг эхлэн хэрэглэснээс эл аймгийн хооронд урт хугацаагаар явагдсан дайныг зогсоож, аж ахуйн харилцааг чангатгасан тул Монголын нийгмийн хөгжилд давшсан үйлдлийг үзүүлжээ. Тэр их ор сууснынхаа дараа, цэрэг дайны ажиллагааг өргөн хэмжээгээр өрнүүлэв. 1211 оноос 1215 оны хооронд хоёр удаа Алтан улс өөд өргөн хэмжээгээр дайрч, Хатан голын умард эрэг хүрсэн бөгөөд Чжунду хотыг эзлэн авав. 1219 онд монгол цэрэг нэгдүгээр удаагийн баруунш дайралтыг хийж Хорезм улсыг мөхөөсөн бөгөөд Калка голд Орос Кипчакийн холбоот цэрэгтэй байлдан дийлжээ. Ингээд хил хязгаараа Дундад Азийн орон нутаг ба Оросын өмнөд хэсэг хүртэл өргөтгөсөн бөгөөд эдгээр нутгийг ахмад хөвгүүн Жочи, хоёрдугаар хөвгүүн Чагаадай, гуравдугаар хөвгүүн Өгөөдэй нарт хуваан захируулсан байна. 1226 онд өөрөө цэрэг дайчлан өмнөш Тангудыг довтолж, дараа жилд нь Тангудад өвчнөөр нас барав. Юань улсыг байгуулсан хойно Юань улсын Тайцзу хаанаар нэхэмжлэн өргөмжилжээ гэв.

Наньцзин Их Сургуулийн багш Цю Шо Сэнь “Юань улсын түүхийн тухай яриа” (1980 оны хэвлэл) гэдэг номдоо:

Нөхөр Мао Цзэ Дун Цинь Юань Чунь дуулал, цас гэдэг шүлэгтээ Чингис хааныг юунд Нэгэн үеийн тэнгэрлэг хөвгүүн гэсэн буй? Үүний учир гэвэл, Чингис хаан өөрийн гарамгай чадвараараа Монголын эл аймгийг нэгтгэж, Монгол үндэстний түүхэнд хамгийн алдарт үндэстний баатар болсон бөгөөд тэр бас өмнөш цэрэглэж Тангудыг устган, Алтан улсыг дайлж, бүх Дундад улсыг нэгтгэх үйлсэд хувь нэмрээ оруулсанд оршино .

1206 он (Алтан улсын Тай Хэ-гийн зургадугаар он, Сүн улсын Кай Си-гийн хоёрдугаар он)-д бүх Монголын боол эзэмшигч язгууртан нар Онон мөрний хөвөөнд хуралдай (их хуралдаан) хуралдаж, дөчин дөрвөн настай Тэмүжинийг бүх Монголын их хаанаар санал нэгтэй сонгож, Чингис хаан гэсэн цол өргөмжилжээ. ...

Чингис хаан бүх Монголын хаан болсон явдлаар монгол үндэстний түүх шинэ шат үедээ орсныг тэмдэглэж байна. Гэвч хэдэн зуунаас нааш, Монголын эл аймгууд ерөөс нэгдээгүй бөгөөд тэд нар алан хядалцаж өрсөлдөн тэмцэлдсээр байв. Одоо тэд хүчирхэг чадамгай удирдагч Чингис хааны ноёрхол доор нэгэнтээ бүрэлджээ. Хөлөн буйрын тал нутгаас баруунш Алтайн нуруу хүртэлх өргөн уудам оронд, хэл яриа, угсаа төрөл, соёлын хэмжээ зэрэг талаар тус тус адилгүй байсан эл аймгууд нийлж, нэгэн хамтлаг цогц болон эхэллээ.

Тэрчлэн тэдний хоорондохи соёл аж ахуйн талын харьцаа нэг алхам чангадаж, хамтлаг хэл нь улам улмаар бүрэлдэж, хөдөлмөрч баатар Монгол үндэстний бүрэлдлийн явц ингээд эхлэв. Түүнчлэн агуу их Монгол үндэстэн нь Дундад улсын ба дэлхийн түүхэн тавцан дээр лут их үйлдлээ бадруулж байна.

Чингис хаан бүх Монголын хаан болсон явдал нь бас Монголын түүхэн дэх анхдагч нэгдмэл төр жинхэнээр байгуулагдсаныг тэмдэглэн харуулж байна. Энэ төрийн шинж чанар бол боол эзэмшигч байгууллын төр болно.

Монголын төр байгуулагдсан ба улам улмаар төгөлдөржсөн явдал бол Монголын нийгмийн урагшлалт дахи нэгэн том хэрэг болох бөгөөд тэр нь Монголын эл аймгийн нэгдмэл байдлыг бэхжүүлж, Монголын нийгмийн үйлдвэрлэлийн хөгжилтөд ашигтай байсны зэргэд Монголын хамтлаг цогцын бүрэлдлийг ч ахиулжээ. Хэлэлгээнгүй, энэ төр нь боол эзэмшигч ангийн ашиг сонирхлыг хамгаалах, боол эзэмшигч ангиас Монголын өргөн олон хөдөлмөрчин ард түмэнд явуулсан мөлжил ба дарлалыг баталж, тэрчлэн Монголын боол эзэмшигч ангийн ноёрхлын хүрээг тасраагүй өргөтгөхийн тулд байгуулагдсан юм .

Монголын ноёрхогчдоос эл аймагт явуулж байсан ноёрхол нь маш хэрцгий байв. Чингис хаан өөрийнхөө жаргал цэнгэлийн төлөө, Түмэд аймгаас гучин үзэсгэлэнт эмсийг сонгуулахаар Хорчи-г томилж (бодот явдал нь “Нууц товчоон”-ы 207, 240, 241 дүгээр зүйлүүдэд тэмдэглэлтэй зөрж байхыг анхаараарай! – эшлэгч), Түмэд хүнийг маш их хилэгнүүлж, тэд Хорчи-г барьж авсан тул Чингис хаан аргагүй Хутуга бэхи-ийг томилж дарангуйлуулсан боловч бас баригдав. Ингээд Чингис хаан түүний дотно хань “Дөрвөн хүлэг”-ийнхээ нэг болох Борухулыг томилов. Борухул бас Түмэдэд орсон хойно, Түмэд хүмүүс замыг тосон барьж аваад алжээ. Энэ мэт дараа дараагаар жанжнаа хохируулсан явдалд Чингис хаан машид уурлаж, өөрөө дайлахаар шийдсэн боловч олон жанжин нарын ятгалаар Дөрбэй-г томилж, түмэд хүний эсэргүүцлийг дарангуйлсан бөгөөд түмэд хүнийг гавьяатай хүмүүстээ хуваан өгч боол болгожээ . Чингис хаан өөрийн ноёрхлын хүрээгээ улам өргөтгөж, түүний дүү нар, хөвгүүддээ тус бүр хувь хувилж, баян эрхмийг хамтаар эдлэх-ийн төлөө, залгалдаагаар гадагш цэрэглэж Монголын хилийн гаднахи зэргэлдээ төрүүдийг оруулан авахаар шийдэв. Эдгээр гадагш түрсэн дайн нь маш их дээрмийн чанар ба эвдлэх чанартай бөгөөд Монголын боол эзэмшигч ангийн ховдог чанарыг нь илрүүлэв . Чингис хаан Монголын эл аймгийг нэгтгэсний дараа, өмнөш тасраагүй цэрэг томилж байв. Түүний гол зорилго нь мөн ч хоёр байдаг: Нэг нь: Эд бодосыг дээрэмдэж, Монголын боол эзэмшигч ноёрхогчдын жаргалыг хангах; Нэг нь, Тангуд ба Алтан улсыг мөхөөж, өвөг дээдсийнхээ өшөөг авахын хамт ноёрхлын орноо өргөтгөхөд оршино .

Монголоос Алтан улсыг эсэргүүцсэн нь эхний үедээ үндэстний дарлалыг эсэргүүцсэн шударга дайны чанартай байв .

Чингис хаан нэгдүгээр удаа Алтан улсыг довтолсон дайн нь, Жүрчиний язгууртнуудын үндэсний дарлалыг эсэргүүцсэн дайнаар эхэлж, дээрмийн дайн болон хувираад дуусчээ .

Чингис хаан ба түүний залгамжлагчдын баруунш дайлан дайн нь, 1218 онд Чингис хаан Найманы Хүчүлүг-ийг сөнөөж, баруун Ляо улсыг мөхөөснөөс өмнөх нь улсын дотоодхи үндэстний дайн болно. 1219 онд Чингис хаан биеэр цэрэг дайчилж Хорезмд довтолсноос

эхлэн гадаад улсыг түрэмгийлэн халдсан дайн болно гэжээ.

Арван гуравдугаар зууны дөчөөд онд Персийн түүхч Джувейни түүний зохиосон “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”-дээ:

Бүхнийг тольдогч эзэн тэнгэр Чингис хааныг олноос оройлсон оюун чадвартай, үзэл санааны хурц сэргэлэн, эрх хүчний хязгааргүй талаар дэлхий дахины олон ван нарын манлай болгожээ. Тиймээс түүхийн ном бичигт хэдийгээр эртний аугаа их Хосровын үйлдлэг болон Фараос, Кайса-гийн хуулийн зурвасыг тэмдэглэдэг боловч Чингис хаан харин өөрийн тархиа түшиж байгаад зохион бүтээдэг юм. Тэр бичиг харыг урвуулна гээд тархиа бардаггүй, уламжлал заншлаа журамлана гээд хүчээ шавхдаггүй. Бусад улсыг дайлан дагуулах арга бодлого, дайсан цэргийг устгах ба харьяат нараа дэвшүүлэх арга зэрэг нь бас ч бүр түүний өөрийнх нь сэрж ухсан үр дүн бөгөөд оюун чадварынхи нь болбор болох юм. Үнэнийг хэлэхэд, тэрхүү арга бодлогодоо чадамгай, дайсныг ажихад сахиулс мэт гэдэг алдартай Александр хэрвээ Чингис хааны үед амьд байсан бол, арга сүвээчилж бодлого хэрэглэх талаар Чингис хааны сурагч нь болох бөгөөд хот балгасыг довтлох зүйл бүрийн уран аргын талаар Чингис хааныг үг дуунгүйгээр дагаж хийвэл дээр гэдгээ тэд лав олж мэдэх юм .

Чингис хаан эл үндэстнийг оруулан авахаар зүг бүхэнд томилсон элчийн зарлиг дуу ер айлгаж сүрдүүлэх үгийг хэлдэггүй. Энэ бол эртний догшин эздийн хэрэглэдэг арга болно. Тэд байнгадаа өргөн уудам нутаг дэвсгэр, өнөр олон цэрэг зэвсгээрээ дайснаа айлгадаг. Монгол хүн харин үүнтэй эсрэгээр, хамгийн сүрхий гэсэн нь:

Та нар хэрвээ нугарахгүй, бас орж өгөхгүй бол юу болохыг бид мэдэхгүй, харин тэнгэр мэдэх юм гэж сэрэмжлүүлэв .

... Дэлхий дээрх олонхи хот балгас, улс орон нь эд баялаг, эрх сүр ба байр сууриндаа эрдэж, түүнийг (Чингис – эшлэгч) эсэргүүцэх, өргөл татвараа эс тушаах (Туркестаны хилээс холдахины Сири-ийн Исламын шашинт улс нэн ч ийм билээ) үед Чингис хаан түүнийг эсэргүүцсэн хаад, эзэд ба хотын захирагчдыг түүний гэр бүл, захирагсад, угсаа харьяат ба ард иргэдийнх нь хамт хэлтрүүлэлгүйгээр бүхнийг устгадаг. Тиймээс өчүүхэн ч орхиогүй хэлбэл, анхандаа арван түмэн хүн амтай байсан газар амьд үлдсэн хүн нь зуу хүрэхгүй байв .

Чингис хаан ноёрхохынхоо эхний үе, Монголын эл аймгууд түүнд нэгдэхийн үед тэр, тэдгээр Монгол аймгуудад зөвшөөрөгдөн хэрэгжигдсээр ирсэн хөдхи заншлыг нь үгүйсгэж, дараа нь тэр онолын үзэлтээр үзсэн ч сайшаагууштай хууль дүрмийг тогтоожээ .

Тэдний сайшаагууштай нэгэн овор байдаг: Ёслолыг эрхэмлэдэггүй, зэрэг цолыг хөөцөлддөггүй, эгэл хүмүүс ойртошгүй дээр суудаггүй. Ийм овор бол баян эрхэм хүмүүст байнга харагддаг юм .

Чингис хаан ав авлахыг туйлаар хүндэтгэдэг билээ. Авлах явдал бол цэргийн ноёдын албан тушаал, түүнээс ашиг сургаалыг олох явдал бол байлдагч ба цэрэг хүн бүхний гүйцэтгэвээс зохих үүрэг гэж тэр байнга хэлдэг... гэжээ.

“Марко Поло-гийн аяллын тэмдэглэл” (нэгдүгээр боть, 47 дугаар бүлэг)-д:

Татар хүмүүс шинэ газар нүүснээс хэдий цагийн хожим, бараг 1187 онд нэгэн хүнийг сонгон тэдний эзэн болгожээ (энд Чингис хаан нэгдүгээр удаа Хамаг Монгол Улсын хаанаар өргөмжлөгдсөнийг хэлж байх мэт – эшлэгч). Нэр нь Чингис хаан, түүний бие нь арван хувийн бүрэн чийрэг, билиг ухаан хурц бөгөөд үг өгүүлэлд сайн, нэн ч баатар эрэлхэгээр нэр алдаршжээ. Түүний нийтлэн захирах нь туйлын төв голч бөгөөд эелдэг найрамдуу, ард иргэн нь түүнийг хүндлэн хайрлах нь эзэн бусаар шууд өөрийн эцэг эх мэт санамуй. Үүнээ түүний ариун цагаан, агуу ихэмсэг чанартай алдар нэр нь хол ойрын олон газарт алдаршин дэлгэрсэн тул, тийнхүү аливаа Татарын хүмүүс ямар ажилд хэдий тархан суусан боловч ер цөм түүний захиа зарлалыг дагахыг хүсмүй гэжээ.

Англи улсын зохиолч Уэллс (1866-1946 он) “Дэлхийн түүхийн программ” гэдэг номдоо:

Монголын дайлан дагууллын агуу үйлсийг түүхэнд хамгаас алдартай гэж хэлж болно. Хэдийгээр Александрын дайны гавьяаг маш сүрлэг гэдэг боловч, өргөн хэмжээгээрээ үүнд хол хүрэхгүй юм. Харин хүн төрөлхтний үзэлтийн нөлөөг тархаасан өргөтгөсөн түүний (Чингисийг хэлж буй – эшлэгч) үйлсийг бодтойгоор хэлэхэд хүчиртэй боловч, бараг Александраас Грекийн соёлыг тархаасан лугаа зэрэгцүүлэн өгүүлэх болно. Ази тив ба баруун Европын хоорондох зам нэвтрэлгэ энэ үеэс саадгүй болж дардан зам нээгдсэн тул эл улсын аялагчид Хар хорум хотын ордонд морилон хүрцгээдэг байлаа. Ази Европын хооронд Христосынхон ба Исламынхны байгуулсан халхавч ч энэ үед тэгширсэн тул Ромын шашны хаан (Пап лам)-аас монгол хүнийг уяруулж байгаад Христосын шашныг шүтүүлэх агуу эрмэлзэлтэй байв. Энэ үед Монголчуудын шашин шүтлэг гэвэл балас шүтээн бөө мөргөл болох юм. Ингээд шашны хааны элчид болох Энэтхэгийн Буддын шавь нар, Прис, Итали ба Дундад улс дахи Христостон, Зүүн Ром болон Арменийн худалдаачид нь бүр Арабын албан хаагч ба Прес Энэтхэгийн заяа бодоочинтой Монголын хааны ордонд уулзалдаж байв. Монгол хүн байлдаанд алан хяддаг гэдгийг хэдийнээс чихний улиг болтол сонсч байсан боловч харин түүний эрдэм ухааныг сонирхон хүсэх байдлыг хэлэлцэхийг дэмий олж сонссонгүй. Монгол үндэстнийг хэдийгээр ямар нэгэн нээлт үүдэлттэй гэж хэлэх баримт төгөлдөргүй боловч, мэдлэг ухаан ба арга бодлогыг тархаасан хувьд авч хэлбэл, түүний нөлөө нь дэлхий дахинд зайлшгүй юм. Миний мэдэж байхаар, Чингис хаан болон Хубилайн авир чанарын тухай хэдийгээр олонхи цуурхал гутаалаар хучигдсан үгсийг олж сонсдог бөгөөд мөн эдгээрийн завсраас хянан үзэвч, бас түүний агуу их авирыг нь мэдэж болно. Түүнийг хий хоосноор бардамнагч Александр болон эрс хатуу зоригтой, үсэг бичиг мэддэггүй мөртөө улс төрийн ад чөтгөрийг хөөргөгч хий бишрэлт Чарлеман (Charlemagne – хө.) (эртний Францийн хаан) лугаа адилтгавал, түүний хурц билиг ба бүтээлч чадвар нь ядахдаа тэднээс яасан ч доордохгүй юм гэжээ.

Б.Я.Владимирцов 1922 онд зохиосон “Чингис хаан” гэдэг номдоо:

Чингис хаан өөрийнхөө ашиг сонирхол, хааны угсаа ба алтан ургийнхаа ашиг сонирхлын төлөө ажиллаад ирсэн юм. Тэнэгэр уудам хаант улсаа үр ач нартаа уламжлан өгч, төрийн жолоодох үндэслэл нь болсон “засаг” ба “билиг” гэдгээ үлдээсэн байна. Өргөн уудам нутаг дэвсгэр болон боловсон үндэстнүүдийг дайлан дагуулсан явдал нь Чингис хааны төрөлх үзэлтэд нь ямар ч нөлөө болсонгүй бөгөөд “Эсгий туургатан улс иргэд”-ийг өөрийн ноёрхол доор нэгтгэсэн тэр үеийнхээсээ өчүүхэн ч хувирсангүй байжээ .

Хаант Монгол Улсыг Чингисийн алтан ураг, тухайлбал олон ван нар, ойр төрөл нь ноёрхож байсан бөгөөд бүх Монголын язгууртад, хааны анд нөхөд жич тэдний үр ач нар, шадар хамгаалагчид ба дархад (чөлөөт иргэд) нийлж Хаант Монгол Улсын ноёрхогч анги болсон байна. Энэхүү анги нь тэд нарын ашиг сонирхол адил байсан суурь дээр бүрэлдсэн бөгөөд энэхүү ашиг сонирхлын хэмжээ дотор үргэлж оршин тогтнож чаддаг байна. Нэгэн овогтны хамтын ноёрхлын үзэлт нь хааны хувийн эрх сүрийн үзэлттэй огт зөрөлдөхгүй юм. Учир нь, тэр (Чингис хаан – эшлэгч) бол мөнх тэнгэрийн хүч болон бүх овгийн гишүүдийн хүчинд түшиглэж баймаажин сая энэхүү өндөр сууринд гарч, овог угсаатнынхаа удирдагч болсон байна. Хаант улс нь нэгдэх хэрэгтэй бөгөөд түүний удирдагч нь эрхи биш ганц хаан байх хэрэгтэй .

Чингис хаан насан туршдаа Уйгурын соёл гэгээрлийг биширч байсан бөгөөд Уйгурын сурган хүмүүжил нь монгол үндэстэнд хамгийн тохиромжтой гэж итгэж байв. Энэ бол түүний холыг олж үзэгч агуу их ажиглах чадварынхи нь илрэл мөн. Тэр хэдийгээр хятад болон Исламын шашинт улсын дээд хэмжээний соёл боловсрол, мөн энэхүү соёл боловсролын төлөөлөгч Елюй Чусай, Чан-чунь арш мэт алдарт хүмүүстэй учралдаж байсан боловч Уйгурын соёл гэгээрэл сайн гэсэн түүний үзэлт нь ер хувирч багассангүй. Уйгурын сурган хүмүүжлийг хүртсэн Монголчуудын тоо нь нэлээд өргөжиж олширсон үед дотоод засагтаа харь улсын хүн (эрээн нүдтэн)-ийг хэрэглэхгүй байж болно гэж Чингис хаан үзэж байв. Сурган хүмүүжил (хэрвээ сурган хүмүүжилгүй бол хаант улсын нэгдлийг батлах ба түүний эрх сүрийг эл соёлт боловсон суурьшмал харьяатын дотор баталж огт чадахгүй) ба нүүдлийн амьдрал нь хамтаар урагшилж болно гэж Чингис хаан үзэж байжээ .

Чингис хааны хаант улс нь түүний агуу их үүдэн бүтээгчээ нас барснаас хойш бараг дөчөөд жил оршин тогтносоор байв. ... Чингис хааны ихийг санасан төлөвлөгөө нь ялагдалд учирч, хаант улс нь задарчээ. Түүний цэрэг, улс төрийн авьяас билгийн агуу их чадвараар дэлхийн түүхийн тавцан дээр алхан гарсан монгол үндэстэн нь удаан оршин тогтнож чадсангүй билээ.

Чингис хааны улс төрийн байгуулал дахи буурай газар гэвэл, соёл боловсролыг малжлын амьдрал лугаа уялдуулах гэсэн төлөвлөгөө ба хааны угсаагаа сүйрүүлэлгүй, хаанаар түрүү болгосон хамтын ноёрхлоо цаашид хэрэгжүүлж, хааны ноёрхлоо “Мөнх тэнгэрийн хүч”-ээр илрүүлж, түмэн он боловч үл буруудах “засаг”-ийн сургаалаа журамлуулах гэсэн хүсэлд нь оршино. Иймэрхүү хүсэл нь биелэгдэж чадашгүй гэснийг тэр хоёр нь гэрчилж байна. Учир нь, боловсон ёс ба нүүдлийн байгуулал хоёр хамт оршиж чадахгүй бөгөөд “засаг” нь маш олон хүчин зүйлийг тэсвэрлэх хүчгүй. Энэхүү хүчин зүйл нь хааны угсааны сарнишгүйгээр оршин тогтнохтой нь зөрчилдөж байдагт оршино гэжээ.

Д‘Оссоны “Монголын түүх”-д:

Арван гуравдугаар зууны үед, Азийн их хэсэг болон Европын дорно дахи эл орон нь Татар орны үндэстнүүдийн түрэмгийлэлээр эвдлэгдэн сүйрлээ. Юуны урьд харилцан дайсагналдаж байсан тоо томшгүй үндэстнүүд ба малчин аймгуудын нэгэн захиргааны доор цугларч, элбэг баялаг орон өөд түрэмгийлэн халдаж, ард иргэдийг нь алан, хот балгасыг нь товрог болгожээ. Энэхүү хэрцгий догшин, түйвээгч аймгийг захирч байсан хүн бол Онон, Хэрлэн, Туул мөрний эхээр нүүдэллэн явдаг, Байгал далайгаас зүүн өмнөш өндөр уул

нугадаар нутагладаг ядуу аймгуудын удирдагч болно. Түүний нэр бол Тэмүжин гэдэг. Тэр урьдаар Монголын хаад эзэд, их эрх ольё хэмээн шунахайрагчид лугаа ийн тэмцэлдээний дунд, дайснаа дараа дараагаар дарж, Монгол аймгуудаа дагуулан аваад дахин Татар орны бусад үндэстнийг оруулан авч, хаан ор сууж Чингис хаан хэмээн өргөмжлөгдөв. Татарын эл үндэстэн уул нь Дундад улсын умар дахины Алтан улсад харьяалагдаж байв. Энэ үед Чингис хаан сүрхий олон морьт цэргээ дайчилж, тус улсыг довтлон, Хатан голын хоёр хөвөө хүртэл урагшилж олз ашгийг маш арвин олов. Бас тэндээсээ Дундад Ази өөд түрэмгийлж, хоёр мөрний хоорондохи орон (Дундад Азийн Сыр-Дарья, Аму-Дарья хоёр мөрний хоорондохи орныг хэлж буй – эшлэгч), Хорезм, Перс зэрэг орныг талхидсан байна .

Чингис хаан Персийг талхидсан хойно цэрэг буцан Тангудыг халдаж, ард иргэдийг нь алан хядав. Тангуд бол уул нь Дундад улсын харьяат газар юм. Чингис хаан энд өвчнөөр үхэхдээ дэлхий дахиныг түрэмгийлэхээ биелүүлсүгэй гэж хөвгүүддээ гэрээслэжээ .

Монгол хүний түрэмгийлэл нь Ази тивийн зүс царайг нэгэнт хувиргажээ. Уулын эл их гүрнүүд задрав, эл төрүүд мөхөв, эл үндэстний дотор зарим нь устгагдав. Монгол хүний явсан мөр дээр хот балгас эвдлэгдэн, хүүр үхдэл тал дүүрч, тэрхүү догшин хэрцгий нь хамгийн зэрлэг балмад үндэстнээс ч ахаджээ. Түүний довтолсон газар бүхэнд эр эм хөгшин залууг алж, хот тосгоныг галдан, тариа төмсийг талхиж, хөгжингүй газрыг хувхай хээр болгов. Тэр яагаад ийм балмад хэрцгий буй гэвэл, хилин хорсол ба өсөл өсөхөөс нь болсон биш, учир нь тэр устгагдсан үндэстнүүдийн нэрийг нь таниад дэмий удаагүй байсан билээ. Харин эл улсын түүхийн номд энэ талын тэмдэглэл хараахан адилгүй байхыг үзэхүл, лав нэгэн итгэмжит түүхийн тэмдэглэл нь үнэн байдлаас хэтрүүлсэн явдал байх юм гэжээ.

Японы дорно дахинч Широтори Куракичи (1865-1942 он) 1939 онд нийтлүүлсэн “Монголын эрт ба өдгөөг түүхээс үзсүгэй” гэсэн өгүүлэлдээ:

Чингис хаан бол түүхэнд маш ховор тохиолддог улс төр, цэрэг дайны авьяас билигтэн болно. Хэрвээ түүнийг дайлан дагууллын хэнээтнээр үздэг бол их буруугаар барахгүй туйлын буруу юм. Тухайн үеийн Монголын нийгэмд баян ядуу анги нэгэнтээ буй болж, эцгийн эрхэт овгийн байгуулал улам улмаар задран, феодалын байгуулал өөд шилжиж байв, ялагсад нь байнгадаа эд бодосыг дээрэмдэхээр үл барам, хүмүүсийг нь ч байлдааны олз болгон авч ирдэг билээ. Ялагдсан аймаг бүлгийн хүмүүс нь бусад аймгуудад тархан харьяалагдахаас гадна, тал нутгийн феодал ноёнд очиж дагадаг л байв. Чингис хаан нэг талаар энэхүү хувьсалтын үед буй болсон феодалын байгууллыг төгөлдөржүүлэн, нэг талаар Монголын нийгмийг нэгтгэжээ. Гэвч, түүний захирагдагсадынхаа идэх өмсөхийг чухам яаж хангах буй? гэдэг бол өнөөдөө нэгэн бодтой асуудал байсан юм. Ялалтын улмаар захирагсад нь ч улам олширч, эд бодсын хэрэгцээ ч улам нэмэгддэг тул Монголын үйлдвэрлэлийн хүч нь түүний харьяат нарын амьдралыг батлахад үнэндээ хүчиртэй байсан юм. Чингис баруунш дайлах замдаа Алтай нурууны хавцалд хүрч түүний үнэнч дайчдынхаа хээрийн байрыг тойрон үзэхдээ: Миний байлдагчид амтлаг идээтэй, дулаан хувцастай, тарган агттай бөгөөд адуу мал идээшүүлэх шимлэг бэлчээртэй байхыг л би даатгадаг гэж уярангуйгаар хэллээ гэдэг шиг юм. Түүний хийж байгаа дайн байлдааныхаа нь зорилго юу болохыг үүнээс мэдэж болно. Өмнөд умард төрийн үе түүнчлэн Сүй, Тан улсын үе болтол, умар дахины үндэстнүүд хятад үндэстнийг довтолж байсан боловч, хятад үндэстнийг эрхшээх зорилго байсангүй, зөвхөн эд

бодосыг дээрэмдэх төдий л байв .

Чингис хааны алдар сүр алс холын Европод дуурсч, түүнчлэн Плано Карпини шашны хааны элчээр, Рубрук есдүгээр Луйс (1214-1270 он, Францын Капей-гийн вант төрийн ван - эшлэгч)-гийн элчээр тус тус Монголд томилогдож байсан ба Италийн Марко Поло Юань улсын Хубилай хааны төрд алба хааж арван долоон жил байсан эдгээр явдлуудыг хүмүүс бүр мэдэцгээх юм. Бас Хубилай элч томилж Ромд эчүүлж байсан нь цөм өрнө дорнын их харилцааны хөшиг болох юм гэжээ.

1972 онд Носов гэгчээс эрхлэн найруулж засварлан хэвлүүлсэн “Зөвлөлт холбоот улсын товч түүх” (нэгдүгээр боть)-д:

Монголчууд эртнээс аваад Дундад Азийн тал нутгаар малаа дагаад нүүдэллэн амьдарч байв. Тэд нар нүүдлийн малжлаасаа түрэмгийлэлд шилжсэн явдал нь тэдний нийгмийн байгуулал өөрчлөгдсөнөөс шийдвэрлэгджээ. Арван хоёрдугаар зуунаар, Монголын овгийн байгуулал задарч, анхны үеийн феодалын харьцаа буй болсон байна. Мал сүргийг эзэрхэглэх, бэлчээрийг булаах, байлдаанаас олз олох явдал бол язгууртадын баяжихын чухал ирэлт нь болно. Арван гуравдугаар зууны эхээр, Монголчууд Чингис хаан түрүүтэй нэгэн улсыг байгуулжээ.

Туйлын хэрцгий догшин, итгэл журмыг тэрсэлсэн ноёрхогч Чингис хааны удирдлага доор, Монголчууд Дундад улсын умард өөд түрэмгийлсэн бөгөөд дийлэн дагуулжээ. 1219 онд Монголын дээрмийн бүлэг Дундад Азид илрэв. Тэр үед Дундад Азид хот зээлийн баялаг ба соёл гэгээрлийн бадралаар алдаршсан Хорезм Шах (Арабаар улсын вангаа бас шах гэдэг – эшлэгч) гэгч улс байжээ. Түрэмгийлэгчдийн ширүүн довлол доор, Бухара, Самарканд, Ургенч, Мерв зэрэг Дундад Азийн хотууд хойно хойноосоо мөхлийн хувь заяандаа учирчээ .

1222 оноос 1223 онд, монгол цэрэг Каспийн тэнгисийг тойрон, Иранаар дамжиж гадаад Кавказыг өмнө зүгээс нь түрэмгийлэн халджээ. Цэрэг дайрсан газар, утаа манарсан эвдэрхий балгас энд тэндгүй үлджээ. Тэд бас уул нурууг даван бартаа хавцлыг туулж, умард Кавказын тал нутагт очин тэнд Половец хүн (Кипчак хүнийг оросчууд ингэж нэрлэдэг байна – эшлэгч)-ий эл аймгийг байлдан дийлээд Хар тэнгисийн хөвөө дагуу Оросын хязгаар өөд урагшилжээ. ... 1223 оны 5 сарын 31-ний өдөр Калка голын эхэнд Орос Монголын хоорондохи анх удаагийн байлдаанд Оросын ван гүн нар ажиллагаагаа хамтарч чадсангүй учраас Оросын харьяат цэрэг нь харамсалтайгаар ялагджээ .

Чингис хаан болон түүний цэргийн түрүү нар нь тойрон байлдсаныхаа дараа, их Монголын хаант улсыг байгуулжээ. Монгол хүн цэрэг дайны талаар ялсан шалтгаан гэвэл:

- Тэд нар дотооддоо хямралдаан үүсгээгүй феодалын эхний үед оршиж байсан, бас цэрэг дайны зохион байгуулалт нь ган бат сахилгатай байсанд орших бөгөөд монгол хүнийг эсэргүүцэж байсан нэлээд гүнзгий үндэстнүүд нь нэгэнтээ феодалын боловсронгуй цаг үед ороод байсан ба улс төрийн талаар сарнин бутарч байсанд оршино гэжээ.

Амеркийн Колумбын Их Сургуулийн профессор Хайс нарын зохиосон “Дэлхийн түүх” гэдэг номд:

Чингис хаан нэгэн байлдагчийн хувьд Хүннүгийн Агтила (бараг нийтийн он тооллын 406-453 оны хооронд амьдарч байжээ – эшлэгч) лугаа адил зэрлэг балмад, нэгэн ноёрхогч ба зохион байгуулагчийн хувьд сүүлчийнхээсээ нэн агуу их, түүний дайлан дагуулсан газар нэлээд өргөн уудам, ялалт нь мөн нэлээд олон байлаа. Түүнээс хойшхи хэдэн шууд залгамжлагчдын ноёрхол доор, Монголын хуй салхи улам хол дахинд дэгдэж байв гэжээ.

2 Цинь Ши Хуан бол байлдаант улсын үеийн Цинь улсын төрийг үүдэн байгуулсан эзэн нь болно. Тиймээс “Ши Хуан” гэдэг нь түүний нэр биш, харин “үүсгэгч хаан” гэсэн үг юм. Түүний чухам нэр нь Ин Жэн гэдэг. Тэр нийтийн он тоолоос өмнө 259-210 онд амьдарч байв. Тэр, нийтийн он тоолоос өмнө 230 онд Ци улсыг мөхөөтөл, арван жилийн цагийг хэрэглэж зургаан улс (Чу, Хань, Вэй, Янь, Чжао, Ци)-ыг мөхөөгөөд Дундад улсын түүхэн дэх анхдагч төвд төвлөрүүлэн захирах эрхэт нэгтгэсэн феодалын улсыг байгуулжээ.

3 Сунь У бол Дундад улсын эртний Чунь Цю-гийн үеийн Ци улсын цэргийн эрдэмтэн мөн. Тэр “цэргийн бодлого” арван гурван бүлгийг зохиож, У улсын ванд айлтгасан тул, У улсын жанжин болж, цэрэг захиран Чу улсыг мөхөөв. Тэр “цэргийн явдал бол улсын их хэрэг” гэж үзэж байсан бөгөөд “өөрийг ба бусдыг мэдвээс зуунтаа байлдавч аюулгүй” гэдэг үгийг дурдаж, байдлыг ойлгож, дайсан ба өөрөө, олон цөөн, хүчирхэг буурай, үнэн худал, довтлох хориглох, урагшлах ухрах зэрэг зөрчлийн хоёр талыг тал талаар задлахыг эрхэмлэдэг байжээ. Түүний эдгээр үзэл санаанд нь элбэг дэлбэг борогжуун бодосч үзэл ба хувьсангуй аргын хүчин зүйл илэрч байв. “Сунь-цзы-н цэргийн бодлого” гэдэг Дундад улсын түүхэнд хамгийн эрт буй болсон, хамгийн алдарт зохиолыг тэр зохиожээ.

4 Наполеон (Napoleon, 1769-1821) бол Францын хөрөнгөтөн ангийн улс төрийн зүтгэлтэн ба цэргийн эрдэмтэн мөн бөгөөд Францын нэгдүгээр хаант улсыг гардан байгуулсан хаан мөн.

Молтке (Helmuth Karl Moltke, 1800-1891) бол Германы цэргийн эрдэмтэн мөн. Тэр баруун Европод олон арвин дайн байлдааныг удирдан хийж байсан бөгөөд олон арвин цэрэг дайны зохиолыг бичжээ. 1871-1888 оны хооронд Германы цэргийн ерөнхий захиргаан даргаар ажиллаж байгаад дараа нь Германы улсын батлан хамгаалалтын комиссын түрүүлэгч болов. Түүний цэрэг дайны үзэл санаа нь Герман цэргийн дотор маш их нөлөөтэй байжээ.

Ганнибал (Hannibal) бол нийтийн он тоолоос өмнө 247-183 оны хооронд амьдарч байсан Испанийн Хатайки цэргийн удирдагч байжээ. Он тоолоос өмнө 218 онд тэр зургаан түмэн цэрэг дайчилж Италийг дайлсан хол дахины аян дайныг хийжээ. Үүнийг нь хоёрдугаар удаагийн Буно-гийн дайны эхлэлт гэдэг билээ. Тэр анхандаа Ромын цэргийг ялж байв. Сүүлдээ урт хугацаагаар улсын гадна байлдсан тул, цэргийн хүч нь мохож, Итали цэргийн гэдрэг довтлолтод ялагдаж, Сири-д дутаан очиж, хожим нь бага Азид биеэ хорлон үхжээ.

Хавсраас

Нэг. Чингис хааны үйл ажиллагааны он дараалал

Энэхүү он дарааллыг тус товчоонд баримтласан он сар ба үйл явдлаар баримтлал болгож найруулав. Үйл явдлыг нь цагийн урьд хожидоор байрлуулсан болохоор, тус товчооны бүлгийн дараалалтай бага сага зөрөх юм.

Нийтийн он тооллын 1162 он (хар морин жил):

4 сарын 16-ны өдөр Чингис хаан мэндлэв.

Нэр Тэмүжин.

1163 он (харагчин хонин жил):

Тэмүжин хоёр настай (хий насаар тоолов, доош адил).

1164 он (хөх бичин жил):

Тэмүжин гурван настай байв.

Тэмүжиний их дүү Жочи Хасарыг төрөв.

1165 он (хөхөгчин тахиа жил):

Тэмүжин дөрвөн настай байв.

1166 он (улаан нохой жил):

Тэмүжин таван настай байв.

Тэмүжиний хоёрдугаар дүү Хачигун-ыг төрөв.

1167 он (улаагчин гахай жил):

Тэмүжин зургаан настай байв.

1168 он (шар хулгана жил):

Тэмүжин долоон настай байв.

Тэмүжиний отгон дүү Тэмүгэ Отчигин-ийг төрөв.

1169 он (шарагчин үхэр жил):

Тэмүжин найман настай байв.

Тэмүжиний ганц охин дүү Тэмүлүн гуа-г төрөв.

1170 он (цагаан барс жил):

(1) Тэмүжинийг есөн настай байхад Бөртэ үжинийг сүй тогтжээ.

(2) Есүхэй баатар Татар аймагт хорлогдон нас барав.

1171 он (цагаагчин туулай жил):

Тэмүжин арван настай байв.

Есүхэй баатар нас барснаас аймаг угсаа нь бутарч, Тэмүжиний нэгэн гэр хүчир бэрхшээлд тулгарав.

1172 он (хар луу жил):

Тэмүжин арван нэгэн настай байв.

Тэмүжин Онон мөрний мөсөн дээр Жамуха-тай наадаж байгаад “анд” бололцов.

1173 он (харагчин могой жил):

Тэмүжин арван хоёр настай байв.

Тэмүжин өөр эхтэй дүү Бэгтэрийг харван алав.

1174 он (хөх морин жил):

Тэмүжин арван гурван настай байв.

1175 он (хөхөгчин хонин жил):

Тэмүжин арван дөрвөн настай байв.

1176 он (улаан бичин жил):

Тэмүжин арван таван настай байв.

1177 он (улаагчин тахиа жил):

Тэмүжин арван зургаан настай байв.

(1) Тэмүжин Тайчигудад баригдаж, Сорхан шарын тусламжийг олов.

(2) Тэмүжин найман шарга агтаа дээрэмдүүлж, Боорчу-тай нөхөрлөв.

1178 он (шар нохой жил):

Тэмүжин арван долоон настай байв.

- (1) Тэмүжин Бөртэ үжинтэй хуримлав.
- (2) Бөртэ үжиний шитхүл хар булган дахыг бэлэг болгож, Хэрэйдийн хаан Тоорил (Ван хан)-той холбоолов.
- (3) Бэлгүтэй-г томилж Боорчу-г урин ирж нөхөрлөв.
- (4) Урианхан овогтны Жарчигудай өвгөн хөвгүүн Зэлмэ-ээ дагуулан ирж Тэмүжинд тушаан өгч, Тэмүжин Зэлмэ лүгээ нөхөрлөв.
- (5) Мэргид аймаг гэнэт дайрч Бөртэ үжинийг барьж явав.
- (6) Зэвсэгт хүчнийг эхлэн байгуулав.

1179 он (шарагчин гахай жил):

Тэмүжин арван найман настай байв.

- (1) “Буур хээрийн байлдаан”-аар Мэргидийг ялж, Бөртэ үжинийг буцаан авчрав.
- (2) Бөртэ үжин ахмад хөвгүүн Жочи-г төрөв.
- (3) Тус оны өвлөөс дараа жил болтол, Хурхунаг Жубур-т Жамуха-тай хамт байжээ.

1180 он (цагаан хулгана жил):

Тэмүжин арван есөн настай байв.

1181 он (цагаагчин үхэр жил):

Тэмүжин хорин настай байв.

- (1) Хаврын барагаар Жамуха Тэмүжинээс салан явав.
- (2) Жамуха салан явснаас хойшхи хэдэн жилийн дотор Тэмүжин тал нутгийн язгууртадтай өргөнөөр холбоолов.

1182 он (хар барс жил):

Тэмүжин хорин нэгэн настай байв.

1183 он (харагчин туулай жил):

Тэмүжин хорин хоёр настай байв.

Бөртэ үжин хоёрдугаар хөвгүүн Чагаадайг төрөв.

1184 он (хөх луу жил):

Тэмүжин хорин гурван настай байв.

1185 он (хөхөгчин могой жил):

Тэмүжин хорин дөрвөн настай байв.

1186 он (улаан морин жил):

Тэмүжин хорин таван настай байв.

Бөртэ үжин гуравдугаар хөвгүүн Өгөөдэйг төрөв.

1187 он (улаагчин хонин жил):

Тэмүжин хорин зургаан настай байв.

1188 он (шар бичин жил):

Тэмүжин хорин долоон настай байв.

1189 он (шарагчин тахиа жил):

(1) Тэмүжин хорин найман настайдаа “Хамаг Монгол Улс”-ын хаанаар өргөмжлөгдөж, “Чингис хаан” цолыг олжээ.

(2) Анхны төрийн зохион байгуулалтын суурийг тавив.

1190 он (цагаан нохой жил):

Хаан хорин есөн настай байв.

Жамуха-гийн өдөөсөн “Арван гурван хүрээний байлдаан” явагдав.

1191 он (цагаагчин гахай жил):

Хаан гучин настай байв.

1192 он (хар хулгана жил):

Хаан гучин нэгэн настай байв.

1193 он (харагчин үхэр жил):

Хаан гучин хоёр настай байв.

Бөртэ үжин дөрөвдүгээр хөвгүүн Тулуйг төрөв.

1194 он (хөх барс жил):

Хаан гучин гурван настай байв.

Монголын Хатагин, Салжигуд зэрэг аймгууд Алтан улсын хилд халдав.

1195 он (хөхөгчин туулай жил):

Хаан гучин дөрвөн настай байв.

Алтан улсаас цэрэг томилж Жүйн цэрэг ба Татар цэрэгтэй хамтран Хатагин, Салжигуд зэрэг аймгийн арван дөрвөн хүрээнийг эзлэн авсан бөгөөд Татар аймаг ба Алтан улсын хооронд зөрчил гарав.

1196 он (улаан луу жил):

Хаан гучин таван настай байв.

(1) Алтан улс Татарыг дайлав. Чингис хаан Ван хантай холбоолж, Алтан улсын хүчийг ашиглан, нэгдүгээр удаа Татар аймагтай байлдаж дийлэв.

(2) Хэрэйдийн дотоодод хямралдаан болж, Ван хан дийлэгдэн хар Хятанд дутаав.

1197 он (улаагчин могой жил):

Хаан гучин зургаан настай байв.

(1) Чингис хаан Жүрхин аймгийг дарав.

(2) Жалайрын Мухулай ирж нөхөрлөв.

(3) Ван ханы дүү Жаха Гомбу дагаар ирэв.

1198 он (шар морин жил):

Хаан гучин долоон настай байв.

(1) Намар Ван хан Тангуд газраар гачигдан тэнэсээр буцаж ирэхэд Чингис хаан үнэнчээр туслав.

(2) Чингис хаан Мөрүчэ сэгүл гэдэг газар, Мэргидийн Тогтуга бэхи-г дахин байлдаж дийлэв.

(3) Ван хан Чингис хаантай зөвлөсөнгүйгээр Буур хээрт Мэргидийн үлдэгдлийг довтолж олз

ашгийг ганцаар авав.

1199 он (шарагчин хонин жил):

Хаан гучин найман настай байв.

(1) Чингис хаан Ван хантай хамтран умард Наймантай байлдав.

(2) Өвөл Найманы Көксэгүү Сабрагтай байлдах гэтэл Ван хан байлдааны талбайд Чингисийг орхиж дутаав. Көгсэгүү Сабраг Ван ханыг нэхэж байлдсанд Ван хан дийлэгдэв. Чингис хаан Боорчу, Мухулай нарыг томилж Ван ханыг дэмжив.

(3) Мэргид, Тайчигуд нар Чингисийг халдахаар сүлбээлдэв.

1200 он (цагаан бичин жил):

Хаан гучин есөн настай байв.

(1) Чингис хаан Ван хантай хамтарч, Онон мөрний элсэнд Тайчигудтай байлдав.

(2) Хагагин, Салжигуд зэрэг арван нэгэн аймгийн язгууртад нийлж Буйр нуур орчим Чингис хаантай байлдав. Хаан ихэд ялжээ.

(3) Өвөл Ван хан Чингисээс дахин салж явав.

(4) Өвөл, Цагаан, Дутагуд, Алчи, Алухай дөрвөн Татар Чингисийг довтолсонд, Чингис Далан Нөмөргөст байлдаж, хоёрдугаар удаа Татар аймгийг ялав.

1201 он (цагаагчин тахиа жил):

Хаан дөчин настай байв.

Хонгирад, Ихирэс, Горлос зэрэг аймгууд Жамуха-г “Гүр хан” өргөмжилж, Чингис хааныг довтолов. Хаан Тэниг горхинд байлдаж дийлэв.

1202 он (хар нохой жил):

Хаан дөчин нэгэн настай байв.

(1) Далан Нөмөргөст гуравдугаар удаа Татар аймагтай байлдаж мөхөөв.

(2) Намар өвлийн үесээр “Хүйтэн” гэдэг газар Жамуха нартай дахин байлдаж дийлэв.

(3) “Хүйтний байлдаан”-ы дараа Тайчигудтай байлдаж дарав.

(4) Тайчигудыг дарсан байлдаанд Чингис хаан шархдав, Зэвгэй нөхөрлөв.

(5) Тайчигудыг дарсан байлдааны дараа Сорхан шар нар ирж нийлэв.

1203 он (харагчин гахай жил):

Хаан дөчин хоёр настай байв.

(1) Хавар Жамуха, Ван хан, Нилха Сэнгүм нар хуйвалдаж Чингис хааныг хорлох арга үүсгэв.

(2) Бадай, Хишилиг хоёр адуучин Ван ханы хуйвалдлагыг Чингис хаанд мэдэгдэж туслав.

(3) Ван хантай анх байлдсан “Муу өндөрийн байлдаан”-д хоёр талаараа хохирол олж ухрав.

(4) “Балжуна нуурын тангараг”-ийг байгуулав.

(5) Намар Жэжэгэр өндөрт Ван хантай байлдаж Хэрэйдийг мөхөөв.

1204 он (хөх хулгана жил):

Хаан дөчин гурван настай байв.

(1) Хавар Онгуд аймаг Найманы чимээг хүргэн ирж, Чингис хаантай нэгдэв.

(2) Цэрэг ангийн зохион байгуулалтыг өөрчилж “аравт, зуут, мянгат”-ын дүрмийг тогтоожээ.

(3) 4 сард Наху гунд Наймантай байлдаж мөхөөв.

(4) Уйгур бичгийн хүн Тататунгаа-г олзолж, уйгуржин монгол үсгийг бүх Монголд түгээмэлжүүлсэн бөгөөд тамгыг эхлэн хэрэглэжээ.

(5) Намар өвлийн үеэр эл аймгийн тэрслүү үлдэгдлүүдийг нэхэн байлдав.

1205 он (хөхөгчин үхэр жил):

Хаан дөчин дөрвөн настай байв.

(1) Хавар Чингис хаан өөрийн биеэр умард Найман ба Мэргидийн дахин үлдэгдлийг дарав.

(2) Борухул, Чинбай нар Увас Мэргидийн дахин урвагсдыг дарав.

(3) Алтайн араас их цэрэг буцав.

(4) Тангуд улс Нилха Сэнгүмийг далдалсан учир Тангудыг нэгдүгээр удаа дайлав.

(5) Бүх Монголыг нэгтгэх үйлсийн эцсийн дайсан - Жамуха-г эцэслүүлэв. Монголын эл аймгуудыг бүрэн нэгтгэв.

1206 он (Чингисийн тэргүүн он, улаан барс жил):

Хаан дөчин таван настай байв.

(1) Хаант Монгол Улсыг тунхаглан байгуулж, Чингис хаан их ор суув.

(2) Наян найман төрийн гавьяатныг шагнав.

(3) Цэрэг засаг нэгдсэн дөрвөн түмэн ба ерэн таван мянган жич түмэн хишигтнийг шинээр цэгцлэн байгуулж, Хаант Монгол Улсын төрийг цогцлов.

(4) Их “засаг”-ийг тогтоов.

(5) Харлугийг дайлахаар Хубилай ноёныг, Найманы Хүчүлүг-ийг нэхүүлэхээр Зэв ноёныг тус тус томиллов.

1207 он (Чингисийн 2 дугаар он, улаагчин туулай жил):

Хаан дөчин зургаан настай байв.

(1) Ахмад хөвгүүн Жочи-г томилж, Ойн иргэдийг нэгтгэн авав.

(2) Өргөлийг осолдсон учир Тангуд улсыг хоёрдохи удаа дайлав.

(3) Алтан урагтаа ард иргэдийг хувь хувилав.

1208 он (Чингисийн 3 дугаар он, шар луу жил):

Хаан дөчин долоон настай байв.

Алтан ордондоо саатжээ.

1209 он (Чингисийн 4 дүгээр он, шарагчин могой жил):

Хаан дөчин найман настай байв.

(1) Уйгурын Итүгүд Баржуг Арт Тигин Хар Хятаны тайш Шаокэм гэгчийг алж, Чингис хаанд орж өгөв.

(2) Тангуд улсыг гуравдахи удаа дайлав.

1210 он (Чингисийн 5 дугаар он, цагаан морин жил):

Хаан дөчин есөн настай байв.

(1) Хааны эрхэд халдсан бөө “Дэв тэнгэр”-ийн амийг нь эцэслүүлжээ.

(2) Алтан улсыг дайлах бэлтгэлийг бүх талаар хийв.

1211 он (Чингисийн 6 дугаар он, цагаагчин хонин жил):

Хаан тавин настай байв.

- (1) Хубилай ноён Харлуг-ийг оруулан авч Харлуг-ийн Арслан ханы хамт буцаж ирэв.
- (2) 2 сард хаан биеэр их цэрэг дайчилж, Алтан улсыг гурван замаар дайлав.
- (3) 4 сард зүүн гарын хошууч Зэв ноёны цэрэг Да Шуй Пуань, Фэнли зэрэг сянь-ийг эзлэв.
- (4) Чингис хаан энэ зун Онгуд аймгийн нутагт зусав.
- (5) 7 сард Зэв ноён Ушабуу, У Юай Ин-ийг эзлэн авсан бөгөөд Монголын цэрэг нэгдүгээр удаа Алтан улсын баруун нийслэл Датун хотыг эзлэн авав.
- (6) Чингис хаан өөрөө Чжанчжоу, Фучжоуг довтолж, Цуйбиншань, Хуйхэбао зэрэг газар Алтан улсын жанжин Ваньгинь Чэн Юй-гийн цэргийн гол хүчийг сөнөөж, Сюаньдэ, Дэ Син-ийг эзлэн авав.
- (7) Алтан улсын түшмэл Го Бао Юй зэрэг монгол цэрэгт орж өгөв.
- (8) 9 сард монгол цэрэг Цавчаал боомтыг нэгдүгээр удаа эзлэн авч, Чжунду хотыг шахан хүрэв.
- (9) Монголын баруун гарын цэрэг Юньнэй зэрэг газрыг эзлэв.
- (10) Монголын гол цэрэг Чжунду хотыг нэгдүгээр удаа довтолоод авч чадсангүй ухарч, тус оны өвөл Алтан улсын хил дагуу орноор өвөлжиж цэргээ цэгцлэв.

1212 он (Чингисийн 7 дугаар он, хар бичин жил):

Хаан тавин нэгэн настай байв.

- (1) Хаврын тэргүүн сард Чжунду хот өөд хоёрдохи удаагийн довтоллыг эхлэв.
- (2) Хавар монгол цэрэг Үнэгэн даваан дээр ширүүн байлдаж, Алтан улсын жанжин Хушаху-гийн гучин түмэн цэргийг Хуй Хэ Бао-д бүрэн сөнөөсөн бөгөөд Сюаньдэ-г эзлэн авав.
- (3) Алтан улсын жанжин Шимо мянган, монгол цэрэгт орж өгөв.
- (4) 8 сард Чингис хаан биеэр Алтан улсын баруун нийслэл Датун-ыг дахин довтолж, зэрлэг суманд шархдаж цэрэг ухрав.
- (5) 9 сард монгол цэрэг Дэ Син балгасыг хэдэнтээ байлдаж эзлэв.
- (6) Тус онд Хятанчууд “Зүүн Ляо улс”-ыг байгуулж, Монголд орж өгөв.

1213 он (Чингисийн 8 дугаар он, харагчин тахиа жил):

Хаан тавин хоёр настай байв.

- (1) Хаврын тэргүүн сард Чингис хаан Алтан улсын зүүн нийслэл Ляо Янь-г эзлүүлэхээр Зэв ноёныг томилов.
- (2) 7 сард Чингис хаан биеэр цэрэг дайчилж Дэ Син балгасыг дахин эвдэв.
- (3) 8 сард Гуйчуань голд Алтан улсын мужийн төлөөлөгч Ваньгинь Ган, нийтлэн захирагч Жүхү Гуучи нартай байлдаж ялав.
- (4) Алтан улс Цавчаал боомтоо дахин чанга бэхлэсэн тул Чингис хаан цөөн цэрэг авч нарийн замаар тойрон Цицзингуань боомтыг гэнэт дайран гэтэлж, И чжоу балгасыг эзлэн авав. Зэвийг томилж Нань коу боомтыг эзлэн, Цавчаал боомтыг өмнө хойноос нь хавчин дайрсан тул Цавчаалын сахиул цэрэг буун өгч, боомтыг эзлэн авав.
- (5) Мөн 8 сард, Алтан улсын төрд “Ордны хувьсал” гарч, Хушаху хаанаа хор идүүлэн алж, Ваньгинь Сюань-г Алтан улсын наймдугаар хаанаар өргөмжлөв.
- (6) 10 сард Чингис хаан элч томилж, Алтан улсын бууж өгөхийг шаардав.
- (7) Чжунду-гийн сэргийлэл бат бэх тул монгол цэрэг эзэлж чадсангүй, Чингис хаан цэргээ гурван замаар хувааж, Алтан улсын дотор газар өөд довтлон, Шаньдун, Шаньси, Хэбэй, Ляоси зэрэг газрын ерээд хот балгасыг эзлэв.
- (8) Тус оны өвөл Чингис хаан Чжунду-гийн Шар хээрт буув.

1214 он (Чингисийн 9 дүгээр он, хөх нохой жил):

Хаан тавин гурван настай байв.

- (1) Хаврын тэргүүн сар, Алтан улс эвсэхийг гуйв. Чингис хаан зөвшөөрч, Арачан (Жабар)-г Алтан улсад элчлүүлэв.
- (2) 3 сард эвсэл биелэгдэж, монгол цэрэг ухрав. Чингис хаан энэ зун Загасан нуурт зусав.
- (3) 6 сард Алтан улсын хаан Чжунду хотоо орхиж, өмнөд нийслэл Бяньлян хотдоо нүүж нийслэв.
- (4) 7 сард, Алтан улсыг итгэл алдав гэж монгол цэрэг гуравдахи удаа Чжунду хот өөд довтлов.
- (5) 10 сард Мухулай ноёныг томилон Ляоси-г дайлуулав.

1215 он (Чингисийн 10 дугаар он, хөхөгчин гахай жил):

Хаан тавин дөрвөн настай байв.

- (1) Хавар монгол цэрэг Ляоши-гийн газрыг бүрэн эрхшээн авав.

- (2) Алтан улсын баруун мөрийн дэд юаньшуай Пуча Чигин Монголд бууж өгөв.
- (3) 3 сард Чжунду-г туслахаар ирсэн Алтан хааны цэргийг устгав.
- (4) 5 сард Алтан улсын нийслэл Чжунду хотыг эзлэн авав.
- (5) Бичгийн эрдэмтэн хятан хүн Елюй Чусай-г Чжунду-гаас элсэн хэрэглэж, Чингис хаан биеэр ярилцав.
- (6) 6 сард Монголын цэрэг ухарч Загасан нуурт буув.
- (7) Ойн иргэд бослого гаргав.
- (8) Чингис хаан цэргээ гурав хувааж, Алтан улсыг залгалдаагаар дайлуулав.
- (9) Улсын дотоодын явдлаа шийдвэрлэхийн тулд Чингис хаан Хэрлэнгийн их ордондоо буцав.

1216 он (Чингисийн 11 дүгээр он, улаан хулгана жил):

Хаан тавин таван настай байв.

- (1) Түмэд зэрэг Ойн иргэдийн бослогыг дарангуйлахаар цэрэг томилов.
- (2) Сүбээдэйд төмөр тэрэг өгч, урьд томилсон Тогучарын морьт цэрэгтэй хамтран Мэргидийн үлдэгдлийг нэхүүлэв.
- (3) Найманы Хүчүлүг-ийг устгахаар Зэв ноёныг Хар Хятан өөд томилов.
- (4) Хорезмд элч томилж, арилжааны гэрээ тогтолцжээ.

1217 он (Чингисийн 12 дугаар он, улаагчин үхэр жил):

Хаан тавин зургаан настай байв.

- (1) Дөрбэй догшин Ойн иргэдийн бослогыг дарангуйлав.
- (2) Сүбээдэй баатар Мэргидийн үлдэгдлийг нэхэж Чуй мөрөн хүрч бүрмөсөн устгав.
- (3) 8 сард Мухулай ноёнд Го ван цол, алтан тамга, есөн хөлт цагаан туг өгч, Алтан улсыг дайлах үүргийг хариуцуулав.
- (4) Ухуна түрүүтэй 450 хүнээр бүрэлдсэн арилжааны бригадыг Хорезмд томилов, Отрарын хэрэг явдал үүсэв.

1218 он (Чингисийн 13 дугаар он, шар барс жил):

Хаан тавин долоон настай байв.

- (1) Арилжааны бригад алагдсан тухай Хорезмд элч томилж бас алагдав.
- (2) Зэв ноён Хар Хятаныг мөхөөв.
- (3) Хорезмыг дайлах тухай хуралдай хуралдаж дайны бэлтгэлийг хийв.
- (4) Хавар Тангудыг дөрөвдэх удаа дайлав.
- (5) Гуули улсад дугаасан Хятаны оргодлыг дарахаар арван түмэн цэрэг томилов. Гуули улс ба Монголын харьцаа байгуулагджээ.
- (6) Хааны дүү Отчигин ноён ба гүнж Алага бэхи-гээр төрийн хэргийг захируулахаар тогтов.
- (7) Өгөөдэйг Монголын их хааны залгамжлагчаар тогтоов.
- (8) Зэв, Сүбээдэй, Тогучарыг Монголын их цэргийн хошуучаар томилов.

1219 он (Чингисийн 14 дүгээр он, шарагчин туулай жил):

Хаан тавин найман настай байв.

- (1) 4 сард, Чингис хаан их цэрэг дайчилж Хорезм улсыг дайлаар мордов.
- (2) 5 сард, Найманы нутгаар дайран Эрчис мөрөнд зусав.
- (3) Хорезмыг дайлах хорин түмэн их цэрэг Эрчис мөрөнд цугларав.
- (4) Сүн улсын Бумбын шашны бясалгагч Чан-чунь аршийг залахаар Лю Чжун Лу, Жабар нарыг томилжээ.
- (5) Намар Монголын их цэрэг Эрчис мөрнөөс мордож, 9 сард Отрар хотыг бүслэн авчээ. Дараа нь Чингис хаан цэргээ дөрвөн замаар хувааж, хоёр мөрний хоорондын дайралдааныг өрнүүлэв.
- (6) Чингис хааны захирсан гол цэрэг нь Бухара, Самаркандыг дайлах замд тус оны өвөл Зернук, Нур хотыг оруулан авав.

1220 он (Чингисийн 15 дугаар он, цагаан луу жил):

Хаан тавин есөн настай байв.

- (1) 3 сард Чингис хааны их цэрэг Бухара хотыг эзлэн авав.
- (2) Тус сард Чингис хаан биеэр Хорезмын шинэ нийслэл Самарканд хотыг эзлэв.
- (3) Хорезмын Султан хан Мухаммед Самаркандыг эзлэхээс өмнө дугаасан тул Чингис хаан Зэв, Сүбээдэй, Тогучараар нэхүүлэв.

- (4) Чагаадай, Өгөөдэйн захирсан цэрэг хагас жил залгаагаар байлдаж, тус оны хаврын хугасаар Отрар хотыг эзлэн авчээ.
- (5) Жочи-гийн захирсан хоёрдугаар замын цэрэг болон Алаг, Сүйхэтү, Тахай нарын захирсан нөгөө нэгэн замын цэрэг нь тус тус залгалдаагаар дайралт хийж Ходжент-оос Енджикент хүртэлх Сыхун мөрөн дагуу бүх орныг эзлэв.
- (6) Хавар Чингис хаан өөрөө Хорасан орныг дайлжээ.
- (7) Энэ зун Чингис хаан Нагшабын талд зусав.
- (8) Намар Чингис хаан Термез хотыг эзлэн авав.
- (9) Өвөл Чингис хаан Кангарт, Шуман оронд өвөлжив.
- (10) Зэв, Сүбээдэй нарын цэрэг Азербайджаны төв Тбилиси өөд довтолж, Каспийн тэнгисийн эрэг дагуу Муганы талд өвөлжив.
- (11) Зэв, Сүбээдэй нарын цэрэг өвлийн хүйтэнд Гүржийн хилд гэнэт цөмрөн орж тус газрын цэргийг нь устгажээ.
- (12) 12 сард Мухаммед султан Каспийн тэнгисийн нэгэн бяцхан арал дээр дутаан гарав.
- (13) Өвлийн эхээр Ургенч хотыг дайлсан байлдаан эхэлж, өвөл туж үргэлжлэв.

1221 он (Чингисийн 16 дугаар он, цагаагчин могой жил):

Хаан жаран настай байв.

- (1) 1 сард Хорезмын Султан хан Мухаммед Каспийн тэнгисийн бяцхан арал дээр өвчнөөр үхжээ. Түүний хөвгүүн Джалал-ад-Дин хаан орыг залгамжлав.
- (2) Хавар, Чингис хаан Аму-Дарья мөрний олмоор гаталж, Балх хотыг эзлэн авав.
- (3) Хавар, Джалал-ад-Дин султан Бараан хээрт Монголын хошууч цэргийг дайрч мянган хүн алсан бөгөөд туслахаар очсон Шигихутуху-гийн цэргийг байлдан дийлэв.
- (4) Ургенч хотыг монгол цэрэг ноднин өвлөөс эхэлж зургаан сар байлдаад, тус оны 5 сард эзлэн авчээ.
- (5) Зун, Чингис хааны гол цэрэг Талаханы Носрат Хо цайзыг зургаан сар байлдаад эзлэн авав.
- (6) Зун, хаан Талаханы уулархаг оронд зусав.
- (7) Зун, намрын үеэр Бамиан цайзын байлдаанд Чагаадайн хөвгүүн Мугадуган алагджээ.
- (8) 7 сард Алтан улсын элч ёслолын яамны түшмэл Үгүсүн Жүанда төрийн бичиг барьж,

эвслийг гуйчлахаар Чингис хаантай аян зам зуур барааджээ.

(9) 10 сард Чингис хааны их цэрэг Шин мөрний хөвөөнд Джалал-ад-Дин султантай ширүүн байлдаж дийлэв.

(10) Өвөл, Джалал-ад-Дин султаныг нэхүүлэхээр Бала ноёныг, Индүс Багдадын хоорондохи Ару, Мару, Мадасари зэргийг дайлахаар Дөрбэй догшин нарыг тус тус томилов.

(11) Зэв, Сүбээдэйн цэрэг тус онд Арменийн болон Гүржийн зүүн өмнө хэсэг өөд довтолжээ.

1222 он (Чингисийн 17 дугаар он, хар морин жил):

Хаан жаран нэгэн настай байв.

(1) Тус оны эхээр Тулуйн захирсан цэрэг Хорасан орны олон хотодыг эзлэн авав.

(2) Хавар Чингис хааны гол цэрэг Балх хотыг дахин байлдав.

(3) 4 сарын 5-ны өдөр, Сүн улсын бумбын шашны бясалгагч Чан-чунь арштай анх удаа уулзалт хийв.

(4) Зун, Чингис хаан Бараан хээрт зусав. Эл газар томилсон цэргүүд ирж нийлжээ.

(5) Хорезмын эл хотод дарга томилов.

(6) 8 сард Чингис хаан Чан-чунь арштай хоёрдугаар удаа уулзалт хийв (сүүлд нь хамт буцахдаа бас хэдэн удаа уулзжээ).

(7) Зэв, Сүбээдэйн цэрэг энэ өвөл Кавказын нурууг даван өнгөрч, Асу аймгийн холбоот цэргийг мөхөөн, Кипчакт гүнзгийрэн довтолжээ. Тэд энэ өвөл Кипчакийн төв газар өвөлжжээ.

(8) Монголын их цэрэг энэ өвөл Шин мөрний эх орчим дахи Буя Катур-ын уулд өвөлжив. Цэрэгт хижиг өвчин дэлгэрчээ.

1223 он (Чингисийн 18 дугаар он, харагчин хонин жил):

Хаан жаран хоёр настай байв.

(1) Хаврын эхээр Монголын их цэрэг Энэтхэг, Төвдөөр дайрч Монголдоо буцах хэд хэдэн өдөр явж, уур амьсгал тохиромжгүй тул дахин буцаж уул замаараа Монгол орон өөдөө буцав.

(2) Тус оны 3 сард Чан-чунь арш Чингис хаанаас салж улсдаа буцав.

(3) Мөн энэ 3 сард Го ван Мухулай Шаньси мужийн Вэньси сянь-д өвчнөөр нас барсан тул түүний хөвгүүн Бору-г Дундад Азиас буцааж, орыг нь залгамжлуулав.

(4) 5 сард Зэв, Сүбээдэйн цэрэг Дон мөрний орчим дахи Калка голд Орос Кипчакын холбоот цэргийг бүрэн устгажээ.

(5) Зун, монгол цэрэг буцах замдаа Бараан хээрт зусжээ.

(6) Өвөл, Чингис хаан Самаркандаас зүүнш хорин газар зайтай буув.

(7) Өвөл, Чингис хаан их ав тавив.

(8) Чингис хаан Хар Эрчис гол орчимд буудаллан буухад, Тангуд улсын цэрэг монгол нутгийг Эзнэй голын зүгээс уулгалан халджээ.

(9) Тус оны сүүлчээр Зэв, Сүбээдэйн цэрэг Булгар аймгийг оруулан аваад Жочи-гийн гадаад харьяат болгож, цэрэг буцав.

1224 он (Чингисийн 19 дүгээр он, хөх бичин жил):

Хаан жаран гурван настай байв.

(1) Хавар Чингис хаан цэрэг буцах замдаа Сыхун мөрний баруун эрэг орчимд хаан эцэг хөвгүүд цугларч хуралдай хийв.

(2) 5 сард Мухулайн хүү Бору ван Иньчжоу хотод Тангудын цэргийг байлдан дийлж, Тангудын эзний хөвгүүдийг барьцаа болгохоор тогтоов.

(3) Чингис хаан энэ зун Хулан баш гэдэг газар зусав.

(4) Намар, Монгол орон өөдөө буцан явж байв.

(5) Намар, Тангуд улс ба Алтан улс хоёр эвслийн гэрээ тогтоов.

(6) 10 сард хааны ач хөвгүүн Хубилай, Үлэгү хоёр (Тулуйн хөвгүүн) Эмил голд ирж хааныг угтан бараадав.

(7) Хошууч жанжин Зэв, цэрэг буцах замдаа Ханлины нутагт нас барсан бөгөөд Сүбээдэйн цэрэг хааны их цэрэг лүгээ нийлэлдэв.

(8) Тус оны сүүлч буюу 1225 оны эхээр Эрчис мөрний эх орчмын Буга Сочигай гэдэг газар их хурим хийж, Есөнхэ мэргэн сур харваж 335 алд хол тусгасан учир сүүлд нь нэгэн чулуун хөшөө босгож дурсгав. Энэ бол одоо болтол хадгалагдсаар бүхий “Чингисийн чулууны бичиг” гэдэг дурсгалт зүйл болно.

1225 он (Чингисийн 20 дугаар он, хөхөгчин тахиа жил):

Хаан жаран дөрвөн настай байв.

(1) Хаврын эхээр Чингис хаан Сартуул иргэнийг дайлан дуусч, Туул голын Хар түн дэх

ордондоо буцаж ирэв.

(2) 2 сард, Чингис хаан Тангуд улсад элч томилж, Тангудын эзнээс хөвгүүнээ барьцаа болгон илгээсэнгүй учрыг асуулгав.

(3) Намар, Чингис хаан арван түмэн их цэрэг дайчилж Тангуд улсыг дайлаар мордов.

(4) Тангуд улс хэрэм хотоо бэхэлж, Алтан улсаас цэрэг зэвсгийн тусламж авах хэлэлцээрийг 10 сард байгуулж, дараа сард нь илэрхий зарлажээ.

(5) 11 сард Монголын их цэрэг Түй Онгийн голын хөндийд ирж өвөлжин цэргээ сургуулилав.

(6) Өвөл, Чингис хаан их ав тавьсан бөгөөд мориноосоо унаж бие мариа нь чилээрхэв.

1226 он (Чингисийн 21 дүгээр он, улаан нохой жил):

Хаан жаран таван настай байв.

(1) Хаврын тэргүүн сард Монголын их цэрэг Эзнэй голын зүгээс Тангуд улс өөд довтлон, Хар балгас зэрэг хотыг эзлэн авав.

(2) Зун, Чингис хаан Хуньцуй Шань ууланд зусав.

(3) 7 сард Тангудын эзэн Ли Дэ ван үхэж, түүний ач хөвгүүн Ли Сянь эзний орыг залгамжлав. Тэр харин Тангудын эцсийн нэгэн эзэн нь болжээ.

(4) Намар, Монголын их цэрэг Ганьчжоу, Силянцу, Чулу, Хэлу, Сучжоу зэрэг хот балгасыг эзлэн авч, элс манхыг туулан Хатан голын есөн олом хүрч, Инли зэрэг сянь-ийг эзлэн авав.

(5) 11 сард Чингис хааны их цэрэг Түрэмгий балгасыг байлдан эзлэв.

(6) Өвөл, Монгол цэрэг Тангудын нийслэл Яргай хотыг бүслэн авч тусгай жанжнаар байлдуулав.

1227 он (Чингисийн 22 дугаар он, улаагчин гахай жил):

Хаан жаран зургаан настай байв.

(1) Хаврын тэргүүн сар, хаан Хатан голыг гаталж, Тангудын зэргэлдээ Алтан улсын хот балгасыг довтлов. Урьдаар Цзий Шичжоу-г эзлэн авчээ.

(2) 2 сард Линьтао-г эзлэн авав.

(3) 3 сард Таочжоу, Хэчжоу, Синин сянь зэргийг эзлэн авав.

(4) 4 сард Чингис хаан Лундэ-д хүрэв.

- (5) 5 сард Чингис хаан Тан Цин-ийг Алтан улсад элчээр томилов.
- (6) Илүү 5 сард Чингис хаан Лу Пань Шань ууланд зусав.
- (7) 6 сард Алтан улсаас Ваньгинь Хэчжоу, Уудун аху гэгч хоёр элчийг Лу Пань Шань-д ирүүлж эвсэхийг гуйчлав.
- (8) Мөн 6 сард Чингис хаан Лу Пань Шань-гаас хөдөлж, Циншуй Сянь-ий Сицзян гэдэг газар хүрч буув.
- (9) Чингис хаан Циншуй-д байхад Тангуд улсын элч ирж, нэг сарын хойно бууж өгөхөөр гуйчлав.
- (10) 7 сарын шинийн тавны хар морин өдөр (буюу аргын улирлын 8 сарын 18-ны өдөр), Чингис хаан халуун өвчнөөр хүнд чилээрхэж, тус сарын 12-ны шарагчин үхэр өдөр (буюу аргын улирлын 8 сарын 25-ны өдөр) жаран зургаан настайдаа Циншуй сянь-ий Сицзян-д нас барав.

Хоёр. Чингис хааны дөрвөн ордон ба тайцзи гүнж нар

Чингисийн хатад

Дундад улсын феодал хаадыг “гурван ордон, зургаан хүрээн, далан хоёр татвар хатан”-тай гэж ердийн ярианд хэлэлцдэг. Хэрэг дээрээ адил бусын цаг үед адил бусын төр нь адил бусын дүрэмтэй байжээ. Хань улсын үед хааны хатад татвар ба ордонд үйлчлэгч эмс охидыг арван дөрвөн дэсээр хувааж, хэдэн зуун хүн байлаа гэдэг. Тан улсын үед зургаан товчоо, хорин дөрвөн салаа байгуулж, нийт хоёр зуун дөчөөд хүн байсан бөгөөд “бүр сайн гэрийн охидыг сонгож бүрэлдүүлдэг” гэдэг. Энэхүү урд урдын төрд эмсийн гамшиг болсон явдлыг Мин улсын Тайцзу хаан сургамж болгон, дүрэм сахилгыг байгуулж, урьдаар дотоодын хүмүүжлийг чангатгав (“Мин улсын түүх”, 113 дугаар боть). Ингээд Мин улсын үед зургаан товчоо, нэгэн салааг байгуулсан бөгөөд хатад татвар ба ордны эмс охидын тоог Тан улсын үеийнхээс зуун дөчөөд хүн хассан гэлээ. Татвар хатдыг ч найман байраар тогтоосон байна.

Монголын хаад ч феодал хаадын хувьд ерөнхийдөө ийм байсан. Гэвч түүнд өөрийн үндэстний удамшил ба өвөрмөц онцлогтой билээ.

Эртний монгол хүмүүс олон гэргий авах заншил нийдэм байсныг арван гуравдугаар зууны дунджаар монгол оронд айлчилж байсан элч буюу жуулчдын тэмдэглэлээс мэдэж болно. Тэр үеийн эрэгтэй хүн тэжээж чадах хир дотор хэчнээн олон гэргийг ч авч болдог гэж Плано Карпини, Марко Поло нар тэмдэглэж байв. Хаан язгууртад авч хэлбэл нэн ч ямар хязгаар байх аж.

Чингис хаан эхлэнгүүтээ ордон ба харш балгад гэж байсангүй. Сүүлд Ляо улсын байгууллыг дүрэмлэж, “ордон” гэгч байгууллыг тогтоожээ. Энгийн цагт энэхүү ордонд нь тогтсон хатад татвар нь суудаг бөгөөд аян дайнд явах үед нь хааны зарлиг захиа буулгах улс төрийн төв нь болдог байна. Тиймээс энэхүү ордныхи нь хийц бүтэц нь явах тутам эд эрдэнийн цогцлоосоор гэрэлтэх болжээ.

Чингис хаанд нийт дөрвөн ордон байв.

Нэгдүгээр нь Хэрлэний их ордон болно. Энэ ордныг нь “Лу. Алтан товч”-д “Бөртгэлжин хатны их орд нь Хүрүй орд” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Тайцзу хааны их ордон” гэж, “Юань улсын түүх”-д “Хэрлэнгийн аяны ордон” гэж тус тус адилгүй тэмдэглэжээ.

Энэ ордон нь “Хэрлэний хөдөө арал”-д байсан гэж олонхи түүхчид үзэцгээдэг билээ. Тус ордныг эрхлэгч гол хатан бол Чингис хааны авааль хатан Бөртэ үжин болох нь дамжиггүй. Үүнээс гадна бас зургаан хатан, нэгэн татвар сууж байлаа гэдэг (“Юань улсын түүх, Хатад татварын илтгэл”-д бүр бодтой нэрс нь буй, энд товчлов, дорогш адил).

Бөртэ үжин хатан бол Хонгирад аймгийн Дэй сэцэний охин юм. Тэр цагаагчин могой жилтэй, нийтийн он тооллын 1161 онд төржээ. Чингис хаанаас нэг ах. 1170 онд Чингис Бөртэ үжинтэй анх сүй тогтож, 1178 онд хуримлажээ. Бөртэ үжин Тэмүжинтэй урагласны дараа дэмий удсангүй, Мэргидэд баригдаж эл халыг амссан бөгөөд Есүхэй баатараас хойш

Тэмүжиний аймаг угсаа нь сарниж, айл гэр нь өнчирсөн хүчир бэрх, ядуу зүдүү амьдралыг Тэмүжинтэй хуваалцан эдэлж байв.

Тэр, Тэмүжиний их үйлсийг дэмжихийн төлөө “эхийн шитхүл”-д авчирсан үнэт ховор хар булган дахаа харамгүй гаргаж, Ван ханы дэмжлэгийг олсон юм. Тэмүжин бүх Монголыг нэгтгэх шургуу тэмцлийн дунд, Бөртэ үжин үр хүүхдээ өсгөж, өрх гэрээ додомдохын хамт Чингис хааны мартсаныг нь сануулж, унтсаныг нь сэрүүлж, төрийн их хэрэгт нь зүйтэй сануулга, мэргэн бодлогыг дэвшүүлж байв. Тиймээс Бөртэ үжин хатан бол журамт гэргий, энэрэлт эх төдий биш, харин бас Чингис хааны дайчин үйлсийн хань, дархан төрийн түшээ болж байжээ.

Бөртэ үжин хатнаас Жочи, Чагаадай, Өгөөдэй, Тулуй дөрвөн хөвгүүн ба таван гүнж (энэ таван гүнж гэдэг нь Рашид-ад-Диний тэмдэглэл болно. “Лу. Алтан товч”-д: Алаха бэхи, Илхалдун бэхи, Сэчэйхэн гурван гүнж гэдэг байна. Бодтой нэрс ба эл тэмдэглэлийн байдлыг гүнж хүргэнийг танилцуулсан хэсэгт лавлаарай) төржээ.

Бөртэ үжин хатан чухам хэдийд нас барсан зэрэг түүний хувийн намтар тэмдэглэл хараахан үгүй байсаар. Хожим нь нийтийн он тооллын 1265 он буюу Хубилай сэцэн хааны Чжи Юань-ий хоёрдугаар онд “Богдын түшээ гэгээн ивээлт хатан” цолыг нэхэмжлэн өргөмжилсөн байна.

“Юань улсын түүх, аж ахуйн тэмдэглэл”-д эл ордны жил бүр олох хишиг цалинг тэмдэглэж байдаг. Доор ордон тус бүрт нь дагалдуулан тэмдэглэе.

Их ордны жилийн хишиг: Мөнгө 43 цутгаас (нэг цутгаас нь тав буюу арван лан байдаг), улаан хүрэн гурамсан сиймгий (торгын нэгэн зүйл) 24 толгой, өнгө бүрийн өөтөн ба ёнгор 5.000 жин, зүү 3.000 ширхэг, торго 75 толгой, байнга гаалийн торго 800 толгой. Ёнгор гаалийн тавт(таван өрх бүрээс нэг жин ёнгорын гааль татварладгаас ингэж нэрлэжээ): 1275 онд зургаан түмэн өрх хувьдан өгчээ. 1319 онд хэрэг дээрээ 12.693 өрх байсан бөгөөд нийт 5.207 жин ёнгор хураадаг байжээ. 1281 онд Цзян Нань-ий зоос тушаах гаалийн өрхийг Ганьчжоу Лу-гаас хоёр түмэн өрх (өрх бүр таван цэн тушаадаг) хуваан өгсөн бөгөөд найман зуун цутгаас хураадаг байв.

Хоёрдугаар нь Хулан хатны ордон болно. Энэ ордныг “Лу. Алтан товч”-д “Солонгосын барс орд” гэж, “Юань улсын түүх”-д “хоёрдугаар ордон” гэж, Чжан Чжэнь Пэй-н “Чингис хааны шүүмжлэл шастир”-т ба “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Саарь Хээрийн харилт дахи аяны ордон” гэж тус тус нэрлэж байна. Энэ ордныг эрхэлж байсан хатан бол Хулан хатан болно. Түүнээс гадна бас гурван хатан нэгэн татвар сууж байжээ.

Хулан хатан бол Увас Мэргидийн түрүү Дайр Усун гэгчийн охин юм. 1204 оны намар, Чингис хаан хар талын язгуурт Мэргидийн үлдэгдэлтэй байлдахад Удуйд Мэргидийн түрүү Тогтуга бэхи Худу, Чулуун хоёр хөвгүүнтэйгээ цөөн хүн авч умард Найман өөд дутаасан байна. Харин Мэргидийн өөр нэгэн салбар - Увас Мэргидийн түрүү Дайр Усун өөрийн охин Хулан гэгчээ Чингис хаанд татвар болгон өргөж дагаж өгсөн билээ.

Хулан хатан төрөлх сэцэн сэргэлэн, гуа үзэсгэлэн тул Чингис хааны дотночиллыг олжээ.

Чингис хаан баруунш Сартуул улсыг дайлахад Хулан хатан дагалцан явав.

Хулан хатнаас Хөлгэн гэгч ганц хөвгүүн төрлөө гэдэг тэмдэглэлтэй юм.

Энд тэмдэглүүштэй нэгэн асуудал гэвэл, арван долоо, арван наймдугаар зууны үеийн Монголын сурвалж бичгүүдэд тэмдэглэдэг “Аргасун хуурчийн домог” гэдэгт Хулан хатныг “Солонгосын гүнж” болгож тэмдэглэжээ. Энэ нь түүхт явдалтай нийцэхгүй юм. Энэ тухай Ц.Дамдинсүрэн авгай зүйтэй тайлбар хийжээ. Тэр тэмдэглэхдээ: Энэ домогт үнэн түүхт явдал ч буй. Хойно нэмж зохиосон зүйл ч буй. Үнэн түүхт домог нь аль буй гэвэл Чингист Хулан нэртэй хатан байсан ба тэр хатнаа Чингис их дотночилж үздэг байсан нь үнэн түүхт явдал юм. Харин тэр Хулан хатан бол Солонгосын гүнж биш, Монголын Мэргид аймгийн ноён Дайр Усуны охин байсан. Мэргид бол Солон баргатай ураг төрлийн холбоотой аймаг байсан. Тэгэхлээр энэ Хулан хатны нутаг Солонгос болбол одоогийн Солонгос улс биш, Солон баргын Солонгос мөн. Үүнийг Саган Сэцэн мэдээд “Эрдэнийн товч”-доо: “Солонгос Мэргидийн Дайр Усуны Хулан гуа нэрт охин гэж бичжээ. ...Чингис, Солонгосын нутагт Бух цагаан хааны охиныг хатан болгож аваад өөрийн нутгийг гурван жил орхин мартаж суусан гэдэг бол арван тавдугаар зууны орчмоос Монголд их дэлгэрсэн “Гэсэрийн тууж”-ийн нөлөөгөөр үүссэн домог байж болох юм (“Монголын ардын уран зохиолын түүх”, 147-149 нүүр) гэжээ.

Хоёрдугаар ордны жилийн хишиг: Мөнгө 50 цутгаас, торго 75 толгой, байнга гаалийн торго 1.490 толгой, ёнгор гаалийн тавт: 1257 онд Цинчэн сянь болон Цинчэн сянь-ий 2.900 өрхийг хувьдан өгчээ. 1319 онд хэрэг дээрээ 1.556 өрх байсан бөгөөд нийт 657 жин ёнгор хураадаг байна. 1281 онд Цзяннань-ий зоос тушаах гаалийн өрхийг Ганьжоу Лу-гаас 15.000 өрх хувьдан өгсөн бөгөөд зургаан зуун цутгаас хураадаг байв.

Гуравдугаар нь Есүй хатны ордон болно. Энэ ордныг “Лу. Алтан товч”-д “Шаргачийн орд” гэж, “Биеэр дайлсан тэмдэглэл”-д “Туулын хар түн дэхи ордон” гэж, “Юань улсын түүх”-д “Гуравдугаар ордон” гэж тус тус нэрлэжээ. Бодтой газар нь “одоогийн Зүүн хүрээ орчимд байсан” гэж Чжан Чжэнь Пэй авгай тэмдэглэж байв. Энэ ордныг эрхлэж байсан хатан бол Есүй хатан болно. Түүнээс гадна бас зургаан хатан, гурван татвар сууж байжээ.

Есүй хатан бол Татар аймгийн Их Чэрэнгийн охин, Есүхэн хатны төрсөн эгч нь болно. 1202 онд Чингис хаан Татар аймгийг хамаг эцэс мөхөөсөн хойно, хаан урьдаар Есүй-н охин дүү Есүхэн-ийг өөрийн хатан болгож авчээ. Тэр үед Есүхэн хатан: Миний эгч Есүй надаас дээр, хаан хүнд зохилдох гуа бөлгөө. Гагцхүү саяын будлианд хааш одсоныг мэдэхгүй гэж Чингис хаанаа айлтгасанд: Эгчээ ирвээс чи зайлж сууриа өгөх үү? гэж хаан асуув. Хаан соёрхож, эгчийг минь авчирч уулзуулваас, би эгчдээ даруй зайлья гэж Есүхэн хатан хэлжээ. Ингээд Чингис хаан тунхаг зарлаж, Есүй хатныг ирүүлж ирсэн бөгөөд Есүхэн хатан ч үнэнхүү эгчдээ сууриа тавин өгч өөрөө доод этгээдэд суусан гэлээ.

Есүй хатан мөн сэцэн сэргэлэн, алс холын бодлоготой тул Чингис хааны төрийн их ажиллагаанд нь байнга оролцдог байжээ.

1219 онд Чингис хаан хорин түмэн их цэрэг дайчлан, Дундад Азийн том гүрэн Хорезм улсад цээрлүүлэлтийн дайралдаан хийхээр цэрэглэхийн өмнөх их хуралдай дээр, хаан сууриныг

залгамжлах хүнийг тогтоох тухай чухал дурдлагыг Есүй хатан гаргажээ. Чингис хаан энэхүү дурдлагыг нь хүлээн авч, хааны гуравдугаар тайцзи Өгөөдэйг Чингис хааны их орыг залгамжлагчаар тогтоожээ.

Сүүлд нь 1225 оны намар, Чингис хаан тавдахи удаа Тангуд улсыг дайлахад Есүй хатныг дагуулан явсан бөгөөд хаан мориноосоо унаж чилээрхэн бүхүйд Есүй хатан төрийн их хуралдайг эрхлэн хуралдуулж байв.

Есүй хатнаас Чагур нэрт нэгэн хөвгүүн төрж бага насандаа үгүй болов гэдэг билээ. Гэтэл “Лу. Алтан товч”-д: “Есүй хатнаас төрсөн Жочибай” гэж тэмдэглэж байх бөгөөд Чагурыг Есүхэн хатнаас төрсөн гэжээ.

Гуравдугаар ордны жилийн хишиг: мөнгө 50 цутгаас, торго 75 толгой. Байнга гаалийн торго 682 толгой, ёнгор гаалийн тавт: 1252 онд 318 өрх, 1319 онд хэрэг дээрээ 121 өрх байсан бөгөөд 48 жин ёнгор хураадаг байжээ. Цзяннань-ий зоос тушаах гаалийн өрхийг 1281 онд Ганьжжоу Лу-гаас 21.000 өрх хувьдан өгсөн бөгөөд нийт 840 цутгаас хураадаг байв.

Дөрөвдүгээр нь Есүхэн хатны ордон болно. Энэ ордныг “Лу. Алтан товч”-д “Хамтатгахуйн орд” гэж, “Юань улсын түүх”-д “Дөрөвдүгээр ордон” гэж тэмдэглэж буй. Түүний байсан газар нь Найманы Таян ханы ордон байсан газар, өөрөөр хэлбэл Алтай нурууны ард байжээ. Чан-чунь арш Чингис хаантай бараадахаар явахуйд таарсан ордон нь энэ ордон болох мэт. Түүний тэмдэглэлд энэ газрыг “Эдэр гол” гэж тэмдэглэж байв. Энэ ордныг Есүхэн хатан голлон эрхлэж байснаас гадна бас дөрвөн хатан, долоон татвар сууж байлаа гэж “Юань улсын түүх, хатад татварын илтгэл”-д тэмдэглэж байдаг. Чан-чунь аршийн тэмдэглэлээс үзэхүл, Алтан улсаас авсан Чиго гүнж хатан болон Тангудаас авсан Чагаа гүнж хатан мөн энэ ордонд байсан нь үнэн хэрэг бололтой. Гэтэл тэдний нэр “Хатан татварын илтгэл”-д байдаггүй нь сонирхолтой. Эсхүл өөр нэрээр тэмдэглэсэн буюу орхигдуулсан байж ч мэднэ.

Есүхэн хатны товч байдал нь Есүй хатны хамт дурдсан мэт. “Есүхэн хатнаас төрсөн Карачар, Харагту, Чахур эд гурвуул” гэж “Лу. Алтан товч”-д л тэмдэглэж байдаг билээ.

Дөрөвдүгээр ордны жилийн хишиг: мөнгө 50 цутгаас, торго 75 толгой. Ёнгор гаалийн тавт: 1252 онд Чжэндин зэрэг газрын 283 өрхийг хувьдан өгчээ. 1319 онд хэрэг дээрээ 116 өрх байсан бөгөөд нийт 46 жин ёнгор хураадаг байв.

Дээр дурдсан ордон ба хатан татвар бол “Юань улсын түүх, хатад татварын илтгэл” ба бусад олон сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн зүйл болно. Гэвч бодтой хүмүүсийн нэрийг эл номд хараахан адил бусаар тэмдэглэдэг явдал ч зөндөө буй. Үүнээс гадна, Сорхан шарын охин Хадаан болон Найманы Таян ханы бага эх Гүрбэсү-г бас Чингис хаан хатан болгон авсан хэрэг тэмдэглэл ч байдаг. Гэвч эдгээрийг манай тулгар бичгүүдэд нутлах баримтгүйг тэмдэглүүштэй.

Бас нэгэн лавлууштай зүйл гэвэл, Чингис хааны ордны тоог ч эл номд баахан зөрөөнтэй тэмдэглэдэг байна. Манай баримтласан тэмдэглэл бол “Юань улсын түүх” болно. Рашид-ад-Дин, Д’Оссон нар таван ордонтой гэж, тухайлбал, нэгдүгээрт Бөртэ хатан, хоёрдугаарт Хулан хатан, гуравдугаарт Есүхэн хатан, дөрөвдүгээрт гүнж хатан, тавдугаарт Есүй хатан гэдэг. Бас

нэгэн зүйлийн тэмдэглэл бол Ту Цзи-гийн тэмдэглэл болно. Тэр хэдийгээр дөрвөн ордон гэж үздэг боловч, эл ордны эрхлэгч хатныг адилгүйгээр тэмдэглэжээ. Жишээлбэл, Есүй, Есүхэн хоёрыг гуравдугаар ордонд байрлуулж, дөрөвдүгээр ордныг эрхлэгч хатныг Алтан улсын гүнж хатан гэжээ.

Чингисийн тайцзи нар

Чингис хаанд, авааль хатан Бөртэ үжинээс төрсөн дөрвөн хөвгүүн, татвар хатнаас төрсөн хоёр хөвгүүнтэй нийлээд нийт зургаан хөвгүүнтэй гэж түүх шастирт нэлээд өргөн тэмдэглэдэг байна.

Ахмад хөвгүүн Жочи. Жочи бол Чингис хааны ууган хөвгүүн билээ. Бөртэ үжин сартай байхдаа Мэргидэд баригдаж аюулд дайрагдсан бөгөөд дараа нь 1179 онд Тэмүжин Хэрэйдийн Ван хан, Жадараны Жамуха нартай холбоолж, Буур хээрт Мэргид аймгийг анх удаа дайлж, Бөртэ үжинийг чөлөөлөн авсны дараахан, тус оны намар өвлийн баргаар Жочи-г төржээ.

Жочи хараахан багаасаа эцгээ дагаж шаргуу хатуужилтайгаар тэмцэн, сааргүй дийлж, сааталгүй довтолдог эрэлхэг байлдамгай жанжин болсон бөгөөд Чингис хааны их үйлсэд маш их гавьяа зүтгэлийг бүтээжээ. Тэр хэдийгээр яаруу сагамгай зантай боловч хүн дэмий алдаггүй гэдэг. Олонхи жанжин ноёд нар нь түүний чадварыг биширдэг гэлээ.

Түүний нэгэн насан дахи гол гол явдал гэвэл: Татар аймагтай байлдахад хагасыг нь олзолж, амьдаар тавин явуулжээ. 1207 онд Хаант Монгол Улсын баруун гарын цэргийг захирч ойн иргэнийг нэгтгэн оруулав. 1211 онд Чингис хаан Алтан улсыг дайлахад Чагаадай, Өгөөдэйн хамт баруун замын цэргийг захирч, Юньнэй, Дуншэн, У-вэй, Сочжоу зэрэг орныг байлдан эзэлсэн бөгөөд хоёр жилийн хойно Тайханшань уулаар өмнөш дайралт хийж хорин долоон чжоу-г байлдан авчээ. 1216 онд хаан эцгээ дагалдан умарш буцсан бөгөөд дараа жилд нь Чингис хаан хар Хятаныг дайлахдаа Киргизээс цэрэг элсээд өгсөнгүй тул Жочи-г томилж дайлуулжээ. Киргизийг дарсан хойно, Жочи Хаант Монгол Улсын баруун хилээр сууж байв. Тэр үед Сүбээдэй ноён Мэргидийн үлдэгдлийг нэхэн шүүрдэж, Тогтуга бэхи-гийн гуравдугаар хөвгүүнийг нь барьж аваад Жочи-д хүргэжээ. Энэ үед Жочи түүнээр сур харвуулсанд, түрүү сум нь байг унагаав. Хоёрдугаар сум нь түрүү сумынхаа нүхээр туссан байв. Жочи үүнийг үзээд ихэд баярлаж, түүний эрдмийг нь машид хайрлан, өршөөн хэлтрүүлэх санаатай эцэг хаандаа айлтгасан боловч зөвшөөрлийг олсонгүй гэдэг билээ. 1219 онд хаан эцгээ дагалдаж Сартуул иргэнийг дайлах байлдаанд явжээ.

Чингис хаан Жочи-г хараахан багаас нь хайрладаг юм. Жишээлбэл, хаан орыг залгамжлах хөвгүүнийг тогтоох үед, Чингис хаан юуны урьд Жочи-г дурдсан. Гэвч Чагаадай зөвшөөрөхгүй, хуралдай дээр хэрүүл болсон үед: Жочи-г чингэж хэлж яахин болмуй? Хөвүүдийн минь ахмад Жочи биш үү? Хожим чингэж бүү хэлтүгэй гэж Чингис хаан хэлж байв. Гэвч Чингис хаан бас эндүүгээр Жочи-г муу санасан удаа ч буй.

Бөртэ үжин хатан Жочи-г сартай байхдаа Мэргидэд баригдаад чөлөөлөгдмөгц төрсөн болохоор Чагаадай хүндэлдэггүй мөртөө ер зөрчилдөөнтэй байсан билээ. Энэ нь хаан орыг залгамжлах явдал дээр, сүүлд нь Ургенчийн байлдаан дээр тодорхой илэрч байв.

Ургенчийг дайлан эзэлсэн байлдаанаас хойш Жочи, хаан эцэгтэйгээ өнөд учирсангүй. Учир нь Жочи тэр удаагийн байлдааны дараа Арал, Каспи 2 тэнгисийн хоорондохи хувилсан газраа сахин сууж, Зэв Сүбээдэй хоёрын аян дайныг алсаас дэмжиж байв. Дараа нь Чингис хааны их цэрэг улстаа буцахад Жочи мөн тэндээ үлджээ. Чингис хаан Сыр-Дарья мөрний орчим ирж Жочи-г дуудуулсан боловч Жочи өвчинтэй гээд ирсэнгүй гэлээ. Сүүлд нь бас хэдэнтээ дуудуулаад ирсэнгүй гэдэг. Энэ үе Жочи үнэхээр өвчинтэй байсныг сүүлчийн явдал гэрчилжээ.

Чингис хаан Жочи-г хэдэнтээ дуудуулаад ирсэнгүйд тааламжгүй байв. 1225 оны эхээр Чингис хаан Монгол орондоо буцсан хойно, Жочи-гийн харьяатаас нэгэн хүн ирсэн гэлээ. Хаан түүнээс Жочи-гийн ойрын байдлыг асуусанд, Жочи-гийн бие мариа тун чийрэг, ав тавьж байхыг гарч ирэхээс өмнөхөн бас олж үзлээ гэж тэр хүн хариулжээ. Энэ нь гал дээр тос нэмсэн мэт болж, хаан эцгийнх нь уур хилэнг тэнгэр тулам дэгдээсэн бөгөөд цэрэг зэвсгээр залхаахад ч хүрчээ.

Гэтэл, дэмий удсангүй хайрт хөвгүүн Жочи нь хүний ертөнцөөс өнөд ангижирсан гунигийн мэдээ тэнгэрийн аянга мэт эцгийнх нь чихэнд хүрч ирлээ! Жочи-г ав тавьж байна гэсэн саяын тэр мэдээ худал гэснийг Чингис хаан гэмшиж мэдээд, тэр хүнийг эрээд олсонгүй гэлээ. Энэ үед:

Ган болд зүрхтэй

Газар сайг донсолгогч

Гайхамшиг баатар Чингис ч

Гаслангийн дууныг тавьж

Эндүүрлийн хилэнгээ гэмшиж

Эцэг болсон хүний

Энэрэлийн нулимас

Энгэр дүүрэн унгаажээ.

Жочи дөчин долоон настайдаа 1225 оны эхээр баруун ордонд өвчнөөр нас баржээ. Түүний хувилсан газар бол Каспи, Арал тэнгис хавийн Кипчак орон болно. Сүүлд нь түүний хоёрдугаар хөвгүүн Бат энэ газрыг эзэлж, Кипчак хаант улс гэж байгуулан, 1243 онд Сарайд төвлөжээ.

Хоёрдугаар хөвгүүн Чагаадай. Чагаадай бараг харагчин туулай жил, 1183 онд төрсөн бололтой. Тэр бол эрс шуурхай зоригтой, эрэлхэг байлдамгай жанжин юм. Заримдаа харин хэрцгий догшин занг илрүүлдэг байна. Тэр эцэг хааныхаа их үйлст осолдолгүй зүтгэж байжээ. 1211 онд Чингис хаан Алтан улсыг дайлахад Чагаадай, ах Жочи, дүү Өгөөдэйн хамт баруун замын цэргийг захирч байлдсан бөгөөд 1219 онд Хорезмыг дайлахад Отрар, Ургенч

зэрэг хотыг байлдах хатуу үүргийг биелүүлжээ. Энд дурдууштай нэгэн явдал бол, тус товчооны наймдугаар бүлэгт товч дурдсанчлан, Бамиан цайзын байлдаанд Чагаадайн ахмад хөвгүүн Мугадуган эндэгдсэн билээ. Чингис хаан энэ учрыг сүүлд нь Чагаадайд хэлж өгөхөд нэгэн үлгэртэй гэдэг. Мугадуган алагдсан даруй Энэ учрыг задруулж болохгүй, Мугадуганыг өөр учраар гадагш явав гэж хэл гэж Чингис хаан зарлиг өгчээ. Хэд хоногийн дараа Чагаадай, Өгөөдэй, Тулуй гурав эцэг хаантайгаа нийлэлдэж хамтдаа зоог барьсан гэлээ. Энэ учирт, Чингис хаан хөвгүүдээ зарлиг сонссонгүй гэж уур хилэнт байдлыг гаргаж, ялангуяа Чагааадыг “муухай” ширтэж байсан тул Чагаадай машид эмээж, Үхэвч эцэг хааны зарлигийг үл зөрчинө гэж сөгдөн хэлэв. Энэ ташрамд Чингис хаан саяын үгээ дахин давтан хэлж, Чиний хэлсэн чинь үнэн үү? Чи үгэндээ сууж чадах уу? гэж Чагаадайгаас асуусанд, Үхэвч хэлсэн үгээ буцахгүй гэж Чагаадай хариулсан гэлээ. Энэ үед Чингис хаан чухам үгээ гаргаж, Чиний хөвгүүн Мугадуган чинь нэгэнтээ эндэв. Чи зовж болохгүй гэж хэллээ. Аль нэгэн эцэг бологсдод үүнээс өөр ямар гуниг тохиолдох аж. Чагаадай ч сонсонгуутаа түмэн бээрийн гүн ганганд унасан мэт харангуйтан баларчээ. Гэвч хаан эцгийнхээ зарлигийг санамагц өөрийн биеэ чангалж, багалзуурт тулсан эмгэнэлээ дахин залгин оруулж, нулимс дуслуулсангүйгээр хоолоо идэж бараад гарч явжээ. Гадна гараад сая багтралаа чинээгээрээ илтгэлээ гэдэг билээ. Энэ бол түүний хаан эцэгтээ цаглашгүй шударга гэснийг харуулж байна.

Чагаадай, түүний төрсөн ах Жочи-г гадуурчлах сэтгэл нь ер эргэсэнгүй ч байж мэднэ. Гэвч тэр Өгөөдэйтэй найртай байсан бөгөөд бүх хүчээ өргөн дэмжиж хаан орд суулгажээ. 1230 оноо Өгөөдэй хаан Алтан улсыг дайлахад Чагаадай бүх цэргээ авч дагалдан байлдсан бөгөөд Цзюньжоу-гийн Гурван хайрханы дайралдаанд гавьяа байгуулав гэдэг. 1235 онд Монголын ноёрхогчид хоёрдугаар удаа баруунш дайралт хийхэд, ахмад хөвгүүдийг явуулах сануулгыг Чагаадай дурджээ. Энэ удаагийн дайралдааныг түүхэнд “ахмад хөвгүүдийн дайралт” гэдэг юм.

Өгөөдэй их хааны орыг залгамжласан хойно, Чагаадай эзэн сайдын ёсоор дүүгээ хүндэлж байжээ. Ийм нэгэн үлгэр байдаг сан: Нэгэн өдөр, Өгөөдэй хаан ах Чагаадайтайгаа хоёул архи ууж нэлээд согтуурхсан байдал доор, морь унан зэрэгцэж явж байжээ. Тэр үед Чагаадайн унасан морь Өгөөдэйн мориноос давуулаг болохоор морь уралдая гэж сануулга гаргаж уралдсан бөгөөд Чагаадай түрүүлэв. Гэртээ харьж унтаж байгаад шөнө гэнэт сэрж, “Хаан эзэнтэй дураар морь уралдаж, бас эзний тэргүүнд гарна гэдэг чинь их ёсыг алдав” гэж өөрөө бодож мэдээд, маргаашийнхи нь үүрээр сайд түшмэлээ дагуулж, Өгөөдэй хааны ордны өмнө хүрсэнд, хаан учрыг асуув. “Өчигдөр эзний өмнө ёсыг алдав, өдгөө хүлээхээр тусгайлан ирэв, занчих буюу алахыг эзэн мэдтүгэй!” гэж хэлсэнд, энэхүү ажиллагаанд нь Өгөөдэй хаан маш уярч, зөөлөн хэдэн үгээр зэмлэн өнгөрөөв. Чагаадай, хааны өршөөлд талархан гарч, бас хааны ордны үүдэнд сөгдөж, есөн ес наян нэгэн агтыг өргөж, хааны өршөөлд мөргөн талархсан бөгөөд “Хаан, Чагаадайн үхэх ялыг хэлтрүүлэв” гэж өөр хүмүүсээр өндөр дуугаар хэлүүлсэн гэлээ .

Өгөөдэй хаан ч Чагааадыг ах ёсоор хүндэлж байсан бөгөөд төрийн чухал хэрэг учраа бүр Чагаадайтай зөвлөдөг гэж тэмдэглэж байдаг. 1236 онд Өгөөдэй хааны төрөөс Дундад орны өрх амыг дансалж, ураг төрөл, гавьяатан сайд нартаа хувь хувилахад Чагаадайд Тайюань Фу-гийн харьяат 47.330 өрхийг өгсөн байна. Дараа нь бас Шэньжоу-гийн түмэн өрхийг өгчээ.

Чагаадай, Чингис хааны гардан тогтоосон засгийг маш хянамгай хичээнгүйгээр журамладаг бөгөөд хууль зөрчигсдийг чанга хатуугаар шийтгэдэг гэлээ. Тэрчлэн Чингис хааны сургаалийг эрхэмлэн хүндэтгэгч Ялавачи-гийн хөвгүүн Масхудаар аж ахуйгаа хамааруулжээ. Масхуд баруун орноос гааль гувчуур татварлахдаа голч байсан тул Бухара зэрэг олон хотодыг ихээр сэргээж хүн ам нь өдөр ирэх тутам олширсон гэлээ.

1241 онд Өгөөдэй хаан нас барсан хойно, Чагаадайн дурдлагаар Наймжин хатан Дөрэгэнэ-гээр төрийн хэргийг орлон захируулжээ.

Чагаадай 1242 онд өвчнөөр нас баржээ. Түүний орыг Мугадуганы хоёрдугаар хөвгүүн Хар Үлэгү Наймжин хатны зарлигаар залгамжилжээ.

Чагаадайн хувилсан газар бол Хар Хятаны хуучин нутаг ба баруун Уйгурын нутаг болно. Зах хязгаар нь зүүнш Ил голыг тулан, баруунш Сырдарьяа мөрний эхээс цааш гарч, өмнөш Аму мөрөн хүрч, хойшоо Чуй мөрний саваар Сибирт тулж байв. Чагаадайн хувиар суурилж Чагаадай хаант улсыг байгуулан Алимарт төвлөжээ.

Энд тэмдэглүүштэй нэгэн асуудал гэвэл Чагаадай чухам хэдийд төрснийг олонхи түүх шастирт тэмдэглэл байдаггүй. Миний олж харсан ганц зарим тэмдэглэл гэвэл: 1957 онд Москвад оросчлан хэвлүүлсэн Плано Карпини-гийн “Монголын түүх” (хэрэг дээрээ манай хэлдэг “Плано Карпини-гийн аяллын тэмдэглэл” болно) ба Рубрукын “Дорно дахины гүрнээр зуулчилсан тэмдэглэл” гэдэг номд Н.П.Шастинагийн зүүлгэсэн тайлбарын “68”-д Чагаадайн төрсөн цагийг “1190(?) - 1242(?)” гэж асуулттай тэмдэглэж (тус номын 206 нүүр) байв. Энэ нь хэлэлгээнгүй багтай баримт биш. Өөр нэгэн тэмдэглэл гэвэл, Чжан Чжэнь Пэй-н “Чингис хааны шүүмжлэл шастир” дэх Чингис хааны их үйл хэргийн он дарааллын хүснэгт: Чунь Си-гийн аравдугаар он, харагчин туулай жил, 1183 он, хаан хорин есөн настай байв. Хоёрдугаар хөвгүүн Чагаадай бараг энэ жил төржээ гэж тэмдэглээд, сүүлд нь түүний төрсөн жил сар нь цөм баримтгүй, гагцхүү 1241 онд үхлээ гэдгийг нь мэддэг юм. Жочи Өгөөдэй хоёрын төрсөн жилээр зүйлчилж үзвэл, нийтийн он тооллын 1179 оноос 1184 оны хооронд төрсөн нь лав юм гэж тэмдэглэжээ (тус номын 88 нүүр). Бас 1972 онд Тайвань-д хэвлэгдсэн “Чингис хааны дуулал” гэдэг намтрын он дарааллын хүснэгтэнд “Чунь Си-гийн 11 дүгээр он (хөх луу жил, 1184 он)-д хоёрдугаар хөвгүүн Чагаадай төрөв” гэж тэмдэглэж байна. Энэ нь Чжан Чжэнь Пэй-н тэмдэглэлтэй ойртож байна. Харин Чжан Чжэнь Пэй-н тэмдэглэл ч мөн зүйчлэл төдий болохыг мэдэх хэрэгтэй. Гэвч энэ нь үнэн цагтай нэлээд ойртох тул би ч түр цаг 1183 оноор нь тэмдэглэв. Харин Чагаадайн нас барсан цаг бол 1242 он гэж олонхи тэмдэглэлд бичдэг нь баримттай юм.

Гуравдугаар хөвгүүн Өгөөдэй. Улаан морин жилтэй, 1186 онд төржээ. Тэр хараахан бага наснаасаа хаан эцгээ дагалдан, түүний бүх үйл ажиллагаанд нь үнэнч шударгаар зүтгэж, дотоод гадаадын байлдаанд нь эс оролцсон удаа үгүй бөгөөд эрэлхэг гарамгайгаар байлдаж байв. Ингээд Монголын ноёрхогчдын дотор итгэл хүндийг олсон тул Чингисийг амьд бүхүйд их хааны орыг залгамжлагчаар тогтоожээ.

Чингис хаан амьд байхдаа 1225 онд түүнд хувилж өгсөн газар бол Эрчис мөрний дээд урсгал дагуу орон болон одоогийн Балхаш нуураас зүүнших орон болно. Сүүлдээ Өгөөдэйн үр ач нь Өгөөдэй хаант улс гэж байгуулж, Эмил хот (одоогийн Шинжааны Эмин сянь)-д төвлөж байв.

Өгөөдэй 1229 онд Чингис хааны их орыг залгамжилж, 1241 он болтол арван гурван жил хант Монгол Улсын их хаан суужээ.

Өгөөдэй, Хаант Монгол Улсын хоёрдугаар их хаанаар өргөмжлөгдөөд, 1230 оноос 1234 он болтол Алтан улсыг дайлж (энэ бол Монголоос Алтан улсад чиглүүлсэн гуравдахи удаагийн дайралт болно) хамаг эцэс мөхөөсөн бөгөөд Монголын хоёрдохи удаагийн баруунш дайралтыг мөн Өгөөдэй эрхлэж, 1236 оноос Бат тэргүүтэй хол дахины түрэмгийлэгч их цэрэг (ахмад хөвгүүдийн дайралт)-ийг томилж, Европын дунд хэсэг хүртэл халдуулжээ.

Нөгөө талаар, Өгөөдэй хааны үед Елюй Чусай зэрэг эрдэмтэдийг төрийн чухал тушаалд хэрэглэснээс хууль ёсыг чангатган, гааль гувчуурын дүрмийг байгуулж, Монголын нийгмийн феодалчлалыг цаашид ахиулсан байна. Бас хот балгасыг байгуулж, Хар Хорум хотыг Монголын анхдагч нийслэлээр тогтоосон бөгөөд өртөө замыг байгуулж, усгүй газар худаг малтуулж, удаан жилийн дайн дажины шарх сорвийг эдгэрүүлэх талаар ч ашигтай ажлыг багагүй хийжээ. Ялангуяа “Монголын Нууц товчоон” мэт үндэстний соёлын сацрангүй хөшөө болсон зохиолыг зохион бичүүлсэн явдал бол Өгөөдэй хааны баларшгүй гавьяа гэж үзэж болно.

Өгөөдэй хааны зан чанар бол хаан хүнд маш ховор харагддаг өөрийн буруугаа өөрөө шүүмжилдэг явдал (өөрөө дөрвөн буруутай гэж хэлснийг “Нууц товчоон”-ы 281 дүгээр зүйлд тэмдэглэж буй) болно. Түүний өөрийн хэлсэн ба түүх шастирт өргөн тэмдэглэдгээс үзэхүл, архинд хэтэрхий орсон нь ажил үйл ба амь насанд нь хүртэл нөлөөлсөн нь дамжиггүй юм.

Өгөөдэй хаан 1241 оны 11 сард тавин зургаан настай, аяны ордондоо гэнэт нас баржээ. Сүүлд нь Эрдэмт гэгээн хаан цол өргөмжилж, сүмийн нэрийг Тайцзун гэж цолложээ.

Дөрөвдүгээр хөвгүүн Тулуй. Харагчин үхэр жилтэй, 1198 онд төржээ. Тулуйн төрсөн цагийг “Юань улсын түүх”-ийн тэмдэглэлээр баримтлав. Гэтэл “Нууц товчоон”-ы тэмдэглэлээр үзэхүл төрсөн цаг зэрэг нь нэлээд асуудалтай юм. Тус товчооны гуравдугаар бүлгийн дагалдвар “б”-г лавлаарай. Тулуй бол Бөртэ үжин хатнаас төрсөн отгон хөвгүүн нь болно. Тиймээс түүнийг Монголын заншлаар галын эзэн хөвгүүн гэж үздэг бөгөөд эмэг эх Өгэлүн хатан ба эцэг эх нь бүр түүнийг хайрлаж эрхлүүлдэг гэлээ. Тэр хараахан багаасаа хаан эцгийнхээ захаас салсангүй байв. Аян дайнд нь хүртэл бүр дагалдан явж байжээ. Ингээд тэр олонхидоо Чингис хааны хамт гол замын цэрэгт явдаг байсан юм. Тиймээс хааны цэрэг хэрэглэх арга ухааныг хэнээс ч илүү гүнзгий ойлгосон гэдэг байна.

Тулуй төрөлх талбиу зөөлөн зантай бөгөөд ахас захсаа, ялангуяа их ах Жочи-гоо маш хайрлан хүндэлдэг. Дайн байлдаанд эрэлхэг баатар, цэрэг захирахад арга бодлоготой гэдэг сэн. 1212 онд Алтан улсын Дэ Син балгасыг байлдан эзлэхэд Тулуй болон хүргэн Чихү хоёул хамт хамгийн урьд хотын хэрмийг давж оржээ. Баруунш Хорезмыг дайлахад тэр ганцаар нэгэн салаа цэргийг захирч Аму-Дарья мөрнийг гатлан, Хорасан орныг дайлан дагуулжээ.

1225 онд Чингис хаан хөвүүддээ газар нутгаа хувилахад Тулуйг гал голомт сахигч отгон хөвгүүн гэж Ононы эх болон Хар Хорум орчмын нутгийг түүнд хувилжээ. Энэ газар бол Чингисийн дөрвөн ордон байсан газар юм.

1227 онд, Чингис хаан нас барсан хойно, хааны хөвгүүд, ван нар ба түшмэл жанжин нар хааны шарилыг умарш ар газартаа хүргэж гашуудлын ёслолыг дуусгасан хойно, тэд нар тус тусын газартаа буцжээ. Ингээд шинэ эзнийг сонготол Тулуй төрийн хэргийг захирч байв.

1228 оны намар, хойтон зун (1229 он) их хуралдай хийж шинэ эзнийг сонгох тухай эл газар элч томилж, ван нар, хүргэд, түмний ноёд ба мянганы ноёдод мэдэгджээ. Хойд жилийнх нь их хуралдай дээр төрөл төрөгсөд ба сайд түшмэд нь дөчин өдөр ярилцаад санал нэгдэхгүй байсан гэлээ. Энэ үед Тулуй, Чагаадай хоёр хаан эцгийнхээ гэрээсийг үндэслэж, Өгөөдэйг эрс дэмжин өргөмжлөв. Ингээд тус оны 8 сард Өгөөдэй Монголын их хааны орыг залгамжилсан юм.

Өгөөдэй хаан суусан хойно, 1230 оноос эхлэн Тулуй бүх хүчээрээ Өгөөдэйг дэмжиж, Алтан улс өөд чиглүүлсэн хамаг эцсийн нэгэн дайралдаанд оролцов. Монголын их цэрэг дараа жилийнх нь 2 сард Фэн сянь-ийг эзлэн авсан хойно, “Алтан улсын эзэн Бяньлян-д нүүсэн явдал бол Хатан гол ба Тунгуань боомтоор түшиг болгожээ. Хэрвээ бид урьдаар Баоцзий-д хүрч, Тэндээс Ханьцзян-д хүрэхүйд сар болохгүйгээр хүрч чадна. Үүнийг Танчжоу, Дэнчжоу-д байгаа Алтан улсынхан сонсвол, маньг тэнгэрээс буусан цэрэг хэмээхгүй юу?” гэж Тулуй хаан ахдаа айлтгажээ. Үүнийг Өгөөдэй хаан сонсоод маш баярлаж: Тулуйн арга, жилийгч хааны гэрээс лүгээ нийцэж байх тул өөр арга эрэх хэрэггүй гэж ван, сайд нартаа хэлсэн бөгөөд Тулуйгаар баруун гарын цэргийг ерөнхийлөн захируулж, Фэнсянь-аас мордон Вэйшуй голыг гаталж, бага Тунгуань-д хүрч дахин Сүн улсын хязгаараар өнгөрч, Ханьшуй мөрнийг даган урагшилбал Алтан улсын цэрэг бүх хүчээ өмнөш төвлөрүүлж Тулуйг хориглох нь зайлшгүй, энэ үед Монголын гол замын цэрэг ба зүүн замын цэрэг завшааныг далимдуулан өмнөш Хатан голыг гаталж, Бяньлян хотод гурван замын цэрэг нийлэлдээ гэж шийдвэрлэв. Ингээд Сүн улсын хязгаараар цэрэг өнгөрөх ба хүч хамтран Алтан улсыг мөхөөсүгэй гэж Сүн улсад элч томилжээ. Гэтэл Сүн улсынхан Монголын элчийг барьж алсан байв. Үүнийг Тулуй сонсоод маш их уурлан: Тэд мантай найрамдахаар алс холын Цунлин нурууг давуулан олон удаа элч томилж байсан атал, одоо хэрхэн манай элчийг алах буй? Энэ бол хэлснээ мэлзэж итгэлийг эвдсэн, гэрээгээ тэрсэлж журмыг алдсан, зөвийг орхиж гажууг сэдсэн, өшөөгөө мартаж тэмцлийг үгүйсгэсэн явдал болох тул манай алдарт цэрэг хэрхэн хүлээж болох аж гэж хэлээд Сүн улсын эл хот цайзыг чиглэж, Ханьжун өөд шувт дайрав. Тэрчлэн Сычуань-ийг довтолж, Ланчжоу-гийн өмнөд хэсгийг эзлээд буцжээ. Үүнийг нь Алтан улсынхан сонсч, Туньгуань боомтыг сахин, Хатан голыг сэргийлж байсан цэргээ бүхнийг өмнөш татаж, Ханьцзян мөрний сэргийлэлтээ чангатгав. Дараа нь Тулуйн цэрэг У Дан Шань ууланд Алтан улсын арван түмэн цэргийн жагсаалыг эвдэж, Цзюньчжоу газраар бачим дайрч, Хань Шуй мөрнийг мориор гаталсны дараа, Алтан улсын жанжин Ваньгинь Хада хориод түмэн харьяат цэргээ авч, Дэнчжоу-гаас баруунш хавцал бартаатай газрыг эзлэн бэлтгэж буй гэсэн мэдээг сонсчээ. Энэ үед Тулуйн цэрэг дөрвөн түм хүрэхгүй байв. Энэхүү мэдээг олж, ачаа хөсгөө тэндээ үлдээж, хөнгөн морьт цэргээр довтолов. Алтан улсын хошууч цэрэгтэй Юй Шань ууланд учралдаж байлдав. Монгол цэрэг хуурмагаар хойш ухарч ойд орон, Алтан улсын цэргийг өдөөсөн боловч Алтан улсын цэрэг хөдөлсөнгүй байв. Тэгээд Тулуй гурван мянган шилдэг морьт цэргийг гэзэг цэрэг болгож, бүх цэргээрээ гал бамбай барин шөнө довтолсон бөгөөд өдөржин шөнөжин эмээл авалгүй дайрсан тул Ваньгинь Хада ухарч, Дэнчжоу хотоо сахив. Гурван хоног довтолоод эзэлж чадсангүй хурдан умарш ухрав. Ингээд Хада нар арван түмэн явган, морьт цэрэг авч хойноос нь нэхжээ. Тулуй нэгэн талаар байлдаж, нэгэн талаар

ухран, тэр этгээд нь урагшилбал, энэ этгээд нь ухарч, тэр этгээд нь ухарвал, энэ этгээд нь довглох аргаар гурван сар тэнцэлдсэн байна. Өвөл болон тэнгэр хүйтэрч их цас орсонд Алтан улсын цэрэг нь хөлдөж, зэвсгээ гаргаж чадахгүй болжээ. Энэ үед Тулуй хөнгөн морьт цэргээрээ ширүүн дайралт хийж, Алтан улсын цэргийг гурван хайрханд ихээр сөнөөж, хэдэн арван газар нэхэн байлдсан тул Алтан улсын цэрэг эд хэрэгслээ тал хөдөөгүй орхиж, үлдэгсэд нь сарнин дутаажээ. Ваньгинь Хада Цзюньчжоу өөд дутаасан боловч нэхсэн цэрэгт баригдав. Энэ үед Өгөөдэй хааны гол цэрэг ч байлдааны талбарт хүрэлцэн ирж, “Чамаас өөр хүн дайсныг энэ мэт түргэн сөнөөж үл чадах билээ” гэж Өгөөдэй хаан Тулуйг магтжээ. Гэтэл Тулуй ер бардамнасангүй байж, цэрэг буцаж умарш явав. Цэрэг буцах замд Өгөөдэй хаан хүнд өвдсөн байв. Бөө төлөгчөөр мэргэлүүлсэнд “Гагцхүү ойр төрлийн хүнийг золио болгож өгье хэмээвээс зөвшөөрч өвчнийг хөнгөрүүлж байна. Одоо яахыг зарлиг мэдтүгэй!” гэжээ. “Хаан хөвүүдээс минь дэргэд хэн байна?” гэж Өгөөдэй асуусанд, дэргэд нь байсан Тулуй: Суут Чингис хаан эцэг минь, бидний дээр ах нар, доор дүү нар байтал, хаан ах таныг агт мэт сонгож, иргэ мэт барилж их ороо биед чинь чүчиж (өгч), олон улсыг дээр чинь ачиж одов за. Намайг хаан ахын дэргэд байж, мартсныг нь сануулж, унтсаныг нь сэрүүлж яв хэмээсэн билээ. Одоо хаан ах чамайг алдваас би хэний мартсаныг сануулж, хэний унтсаныг сэрүүлэх буй? Үнэхээр хаан ах муужирваас, олон монгол улс өнчирч, Хятад улс (Алтан улсыг хэлж буй – эшлэгч) баясах болмуй. Хаан ахын оронд би золио больё! (“Нууц товчоон”, 272 дугаар зүйл) гэж хэлсэн тул, “Бөө нар бөөлөн залбирч, адисласан усыг Тулуйд уулгав” гэдэг. Ингээд хоёр, гурван өдрийн дараа, Тулуй зам зууртаа Алаг дэрс гэдэг газар (энэ газар одоогийн Урад хошууны умардахи Алаг худаг магадгүй гэж Ту Цзи тайлбарлажээ) гэнэт нас баржээ. Тэр үе бол хар луу жил, 1232 он болно. Учир иймээс Тулуйн үхсэн явдлыг сүүлчийн хүмүүс сэжиглэх болжээ.

Хаант Монгол Улсын гуравдугаар их хаан Мөнхөөс эхэлж, Монголын их хааны суурийг Тулуйн үр хөвүүд гурван зуун ная гаруй жил (1251 – 1634 он) залгамжлав.

Дээр дурдсан Чингис хааны дөрвөн хөвгүүд бол цөм авааль хатан Бөртэ үжинээс төржээ. Тиймээс феодалын байгууллын ёсоор хаан сууриныг залгамжлах эрхтэй гэдэг билээ. Чингист бас өөр хатдаас нь төрсөн хоёр хөвгүүн байв.

Нэг нь Үрүчи. Тэр бол хааны нэгэн татвараас төрсөн гэдэг. Урьд Алтан улсын баруун нийслэл буюу Юньжун-ыг дайлах байлдаанд багадаа эндэгджээ.

Нөгөө нь Хөлгэн. Тэр бол Хулан хатнаас төрсөн хөвгүүн болно. Чингис хаан түүнийг залган төрлийн хөвүүдтэйгээ адил хайрладаг тул цэргээ хувилахад дөрвөн мянган хүн өглөө гэдэг билээ. Өгөөдэй хааны үед түүнд Хэ Цзянь Фу-гийн иргэдээс хувь хувилж өгсөн бөгөөд 1236 онд Батыг дагалдан баруунш Европ өөд дайлж, дараа жилд нь Оросын Ока голын захад нь Коломна хотыг байлдаж байгаад шархтаж үхлээ гэдэг юм.

Чингисийн гүнж ба хүргэд

Их нь Хожин бэхи. Хожин бэхи бол Бөртэ үжин хатнаас төрсөн эгчмэд охин нь болно. Уулдаа Чингис хааны охин дүү Тэмүлүн гуа-г Ихирэс овогтон Буту хүргэнд богтлосон билээ, Тэмүлүн гуа үхсэн хойно, Хожин бэхи-г Буту-д залган богтолсон байна. Хожин бэхи-г “Юань улсын түүх”-ийн гүнжийн илтгэлд Чан Го гүнжийн байрын хоёрдугаар эгчмэд гүнжээр

ТЭМДЭГЛЭЖЭЭ.

Хоёрдугаар нь Чэчэйхэн гүнж. Бөртэ үжин хатнаас төрсөн хоёрдугаар охин (энд Рашидын тэмдэглэлийг баримтлав). Түүнийг Ойрадын түрүү Хутуга бэхи-гийн хөвгүүн Иналчи-д богтлон өгчээ (зургадугаар бүлгийн дагалдвар “3”-ыг лавлаарай). Чэчэйхэн гүнжийг “Юань улсын түүх”-ийн гүнжийн илтгэлд Янь Ань гүнжийн байрын хоёрдугаар гүнжээр тэмдэглэжээ.

Гуравдугаар нь Алага бэхи. Бөртэ үжин хатнаас төрсөн гуравдугаар охин (“Монгол Татарын тухай бүрэн тэмдэглэл”-д хоёрдугаар гүнж гэжээ). Түүнийг 1207 онд Онгуд аймгийн түрүү Алахуши Дигит Хури-д богтлон өгөхүйд Алахуши нас өтлөв гэж өөрөө хүлээн авсангүй, өөрийн ахмад хөвгүүн Буяншибалд өгсөн байна. Дараа нь 1211 онд Онгудын дотоодод Алахуши-гийн эсрэг этгээд нь хувьсал гаргаж, Алахуши ба Буяншибал эцэг хөвгүүн хоёулыг алсан гэдэг билээ. Ингээд Алага бэхи-г Алахуши-гийн ах Найсуй-гийн хөвгүүн Жинхүй залган авчээ. Дараа нь Жинхүй Онгуд аймгийнхаа морьт цэргийг авч Мухулай ноёны захираан доор Дундад орны байлдаанд явж байгаад эндэгдсэн байна. Тиймээс Алага бэхи гүнж хамгийн сүүлд нь Буяншибалын хөвгүүн Буюуха-д залган гарчээ (тавдугаар бүлгийн дагалдвар “15”-д лавлаарай). 1219 онд Чингис хаан Дундад Азийг дайлах үед Алага бэхи-гээр говийн өмнөх төрийн хэргийг захируулжээ. Түүхэнд “Төр захирагч гүнж” гэдэг даруй энэ хүн болно. Түүнийг “Юань улсын түүх”-ийн гүнжийн илтгэлд Чжао Го гүнжийн байрын нэгдүгээр эгчмэд гүнжээр тэмдэглэжээ.

Дөрөвдүгээр нь Түмэлүн гүнж. Тэр бол Бөртэ үжин хатнаас төрсөн дөрөвдүгээр охин (“Монгол Татарын бүрэн тэмдэглэл”-д Бөртэ үжиний гуравдугаар охиныг А У гэдэг. Үүнийг Хун Цзюнь, Ту Цзи нар “Түмэлүн” мөн гэж үзжээ) нь болно. Түүнийг төрийн нагац Босхар Хонгирадын Алчи ноёны ахмад хөвгүүн Чихү-д богтлон өгсөн байна. “Юань улсын түүх”-ийн гүнжийн илтгэлд Юнь Го гүнжийн байрын нэгдүгээрт тэмдэглэж буй.


Тавдугаар нь Алтулукхан гүнж. Тэр бол Бөртэ үжин хатнаас төрсөн тавдугаар охин (Рашидын тэмдэглэлийг баримтлав) нь болно. Түүнийг Олхунуд Хонгирадын Жабдур сэцэн Тачу-д богтлон өгчээ. “Жабдур сэцэн” гэдэг бол Тачу-гийн цол гэж Ту Цзи авгай магадалжээ. Тачу бол Чингис хааны эх Өгэлүн хатны дүүгийн хөвгүүн юм. “Юань улсын түүх”-ийн гүнжийн илтгэлд - - (нэргүй) гүнжийн байрын нэгдүгээрт: - - гүнж(нэргүй гүнж)-ийг Тачу хүргэнд богтлов гэж тэмдэглэж байдаг. Гэтэл Рашидын номд “Тайцзу” (“Юань улсын түүх, аж ахуйн тэмдэглэл”-д “Тачу” гэжээ. Энд үүнийг нь баримтлав)-д өгсөн гүнж бол “Артаруг” гэжээ. Д’Оссоны түүнийг нь “Артарун” гэж тэмдэглэсэн байна. Энэ бол гүнжийн илтгэл дэх - - гүнж мөн гэж “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д “Дайрхан гүнж”-ийн байрын нэгдүгээрт тэмдэглэжээ. Энэ нь нэлээд баримттай мэт. Үүнээс гадна, Харлугийн Арслан ханд өгсөн Тулай гүнж гэж байдаг (зургадугаар бүлгийн дагалдвар “4”-ийг лавлаарай). Энэ Тулай гүнж чухам аль хатнаас төрсөн тухай хараахан тэмдэглэлгүй байсаар. Бас Уйгурын түрүү Баржуг Арт Тигинд Ал Алтун гүнжийг өгчээ(зургадугаар бүлгийн дагалдвар “6”-г лавлаарай). Гүнжийн илтгэлд Тайцзу-гийн охин гэж, “Ту Цзи-гийн тэмдэглэл”-д Чингис хааны татвараас төрсөн охин гэж тус тус тэмдэглэж байдаг. Гэвч аль хатан, аль татварыг нь дурдсангүй байна.

Гурав.Чингис хааны язгуур төрлийн цадигууд

Тодорхойлол

Гуров. Чингис хааны угсаа төрлийн цадигууд

Цадиг 1. ЧИНГИС ХААНЫ ЯЗГУУР




1. Жажарадай бол Бодончарын барьж авсан эмд гэдсэндээ авч ирсэн хөвгүүн. Тэр бол Жамуха-ын дээдэс, хэрэг дээрээ Жамуха бол Чингистэй нэгэн үеийн хүн. Гэтэл Чингистэй нэгэн үеийн хүн. Гэтэл энд 18 үеэр тэмдэглэж байх тул “Нууц товчоо”-н үе тасарсан нь илт байна.

2. Бодончарын барьж авсан эм Боданчарт ирээд төрсөн хөвгүүн.

3. Боданчарын авааль гэргийгээс төрсөн калган төрөл.

4. Боданчарын татвар эмээс төрсөн хөвгүүн.


Цагиг 2. ХАБУЛ ХААНЫ ҮЕ ЗАЛГАМЖ



Тодорхойлолт: *23-р үе, нэрлэл хэлбэл Чынгис хаанаас доошхи үеийг дахин дугаарлав.

▲ Есүхэй баатарын үе залгамжийг Цагиг 3.-т байрлуулав.

Цадиг 3. Есүхэй баатрын үе залгамж



A


Хачигун



Алчигидай



Хөдөн
Чахула
Хулхур
Дүүлэнэ



Хулачу
Еижири
Мунанса
Буби



Шинэ хөр
Адалимиши

Отчитин



B

Одон
Жибхан
Салахи
Ашидай
Чажилга



Ажуру
Аяхачи
Тачар
Тэмүдэр



Наймадай
Эбүгэн
Уларгидай
Усужай
Чалахай
Бурудай



Бор
Тоғтох
Магухан
Бимбай
Ижи
Бужир

Туличу
Орудай
Байху




Аяхачи
Хабурту
Таши
Хигүгэ




Балтатамер
О
Тоду
Түтөмөр




Нанжа
Урусхан
Хулацай
Янши
Их хонгор
Иду



Ца­диг 4. Чингис хааны үе залгамж (1)







Цадиг 5. ЧИНГИС ХААНЫ ҮЕ ЗАЛГАМЖ (2) -Кибчаг Жочиг хаад

2-р үе

Жочиг




①-⑤ хүртэлх тоо бол сүүлчийнх нь түрүүлчийнхтэйгээ залгаж буйх тэмдэг болно.




Тодорхойлол: (1) Орднос доролш ром тоогоор дугаарласан нь зуун Кипчакийн хаад болно. Түүний 13-р үеийн хан нь Хүлмэгийн хөвлүүн Бүрхэбохи гэгч байжээ. Батвас доролш араан тоогоор дугаарласан нь баруун Кипчакийн хаад болно.


(2) "Монголын үе уламжлал" гэдэг номд Жочийн хойчисыг 16-р үе хүртэл тэмдэглэж байв. Гэтэл 13-р үеэс хойш Кипчакийн хэдийн залгамжлал нь самуурсан тул энд цөм товчлов.

Цагиг 6. ЧИНГИС ХААНЫ ҮЕ ЗАЛГАМЖ (3)
Цагаадай ба Цагаандайн хаан улсын хаад






Тодорхойлолт: Цагаадай хан улсын (21), (24) дугаар хан орыг нь Өгөөдэйн хойч залгамжлалаа гэдэг.





Цадиг 7. ЧИНГИС ХААНЫ ҮЕ ЗАЛГАМЖ (4)

Тулуйн үрс




Цадиг 8. ТУЛУЙН ҮЕ ЗАЛГАМЖ (1)
Хубилай ба Юань улсын хавд





Тодорхойлол: Дорволмин хүрээтэй тоо бол Чиглэсээс эхэлсэн Монголь н их хаадын дугаарлал болно. Хубилайгаас Тогоонтөмөр хүртэл их Юань улсын хаад болно.

Цагиг 9. ТУЛУЙН ҮЕ ЗАЛГАМЖ (2)
Үлэгү ба Ил хааны залгамжлал



Тодорхойлолт: ① Үлэгүд 15 хөвгүүнтэй гэдэг бөгөөд тавинх нь нэр тэмдэглэсэнгүй. Абагаас дорнош дэс дараа нь эл түүхэнд адилгүй байдаг.
 ② 10 дугаар Ил хан Албагай хан бол Үлэгү-гийн дүү Ариг-бахийн хойч гэдэг бөгөөд 13 дугаар Ил хан Түхэлтөмөр гэгч бол Чингисийн дүү Хасарын хойч гэдэг билээ.

Дөрөв. Зүүлт зургуудын тайлбар

Зураг 1: “Тэмүжин анх хуяглаж дайнд мордсон нь”. Өмнөх наамал зураг (ба Чжун Вэнь зурав).

Зураг 2: “Дотор нүүрын зураг”. Хүрээ нь 1240 оноо босгосон арван зүгийн Цзы Вэй Гун ордны хөшөө чулууны хөвөөний монгол үндэстний уламжлалт эвэр угалж. “Чингис хааны товчоон” гэсэн үсгийг зохиолч М.Асар бичив.

Зураг 3: “Чингис хааны эш хөрөг”. Нарийн учрыг хоёрдугаар бүлгийн “Чингис хааны эш хөрөг” гэсэн хэсэгт лавлаарай.

Зураг 4: “Чингис хааны зарлигийн пайз”. Тус пайзыг гуулиар үйлдэж хятад, Хятан хоёр зүйлийн үсгийг нь алтаар шарсан байжээ. Уул пайзыг 1934 оноо тухайн үеийн Жэхэ мужаас олжээ. Хожим нь япон хүний гарт орж, одоо Японы Киото Их Сургуулид хадгалагдаж буй. Энэ пайзын дээр Хятан үсэг байх ба түүнийг олсон газар байцаас үзэхүл, үүнийг Елюй Люгэ-гийн Хятаны бага төр лүгээ харьцах элч нар хэрэглэж байсан бололтой.

Зураг 5: “Монголын хааны төрийн бичиг”. Энэ бол одоо болтол Ватиканы түүхийн эвхмэлд хадгалагдаж бүхий Монголын гуравдугаар их хаан – Гүюг хаанаас Ромын шашны хаанд өгсөн төрийн бичиг болно. Уул бичгийг хорин см өргөн, зуун хорин см урталжин цардмал цаасан дээр сарацин (перс) үсгээр бичсэн бөгөөд хааны тамгыг наасан уулзвар буюу бичгийн сүүлд нь шунхаар дарж байжээ.

Гүюг хааны энэхүү төрийн бичиг Ватиканы эвхмэлийн хөмрөгт байсныг 1920 онд Польшийн эрдэмтэн Кирилл Каралевский анх удаа олж үзээд, гэрэл зургаар буулган авч, Ираны эрдэмтэн Массэ гэгчид өгч судлуулжээ. Пеллио бас шинээр орчуулсан бөгөөд цаашид судалж, уул бичгийг орчуулга ба тайлбарын хамт нийтлүүлжээ. Доор Пеллио-гийн орчуулгыг монголчилж дагалдуулав. Тэр нь:

“Мөнх тэнгэрийн хүчин дор, бүх агуу их ард иргэдийн далайн хааны зарлиг (энэ хэдэн мөр үсгийг түрэгээр бичжээ). Зарлигийг минь, шашны их хаан ухаартугай

Кэрэли хэмээх газар хуралдай хийж ахуйд, та нар элч томилон гуйчлуулав. Гуйчлалыг чинь элчдээс сонсов. Та нар хэрвээ өрийн хэлсэн үгэндээ суух болбоос, шашны их хаан чи биеэр ирж, бид лүгээ учрах хэрэгтэй. Бид та нарт засагт дурдаж бүхий зарлиг бүхнийг сонсгосугай.

Бас, надад угаалын ёсыг хүлээлгэх нь сайн явдал хэмээн та нар хэлэв. Та нар элч томилон гуйчилсан нь сэцэн болой. Гэвч бид танай гуйчлалыг ойлгоогүй болой.

Бас, та нар элч томилж: Та нар бүх Мажар (Хангари) ба Христосын мөргөлтний орныг эзлэв хэмээмү. Би ихэд цочив. Бидэнд авч хэлбээс, энэ нь аль хир буруу аж? хэмээн надад хэлүүлэв. Эдгээр үгийг чинь бид үл ойлгов. Чингис хаан хийгээд хаан миний бие басхүү элч томилон, тэр хоёр орныг тэнгэрийн бошгыг дагатугай хэмээв. Гэвч тэдгээр хүмүүс тэнгэрийн бошгыг эс дагав. Чиний өгүүлж бүхий тэдгээр хүмүүс их чуулган цуглаж, ихэд дээрэнгүй аашилж,

манай элчийг алав. Тиймээс мөнх тэнгэрийн хүчинд тэдгээр орны хүмүүсийг алсан бөгөөд устгасан болой. Харин зарим хүмүүсийг тэнгэрийн бошго ба түүний хүчээр аврав. Энгийн иргэдийг хэрхэн барьж алах ба хорих буй?

Чи өгүүлсэн биш үү: “Би болбоос Христосын мөргөлтөн, би дээд тэнгэрийг хайрламуй, би ... -г жигшмүй”. Гэтэл, дээд тэнгэр чинь ял нүгэл хийсэн агал бас энэрэхүй сэтгэлийг өвөрлөмүй хэмээснийг чи мэдэх үү? Чи ийм үгийг өгүүлсэн бөгөөд дээд тэнгэрээ хэрхэн таних буй?

Наран мандах орноос наран жаргах орон хүртэлхи бүх ертөнцийн тэнгэрийн хүч маньг ивээв. Тэнгэрийн бошгоос гадна, хэн ч дураар үйлдэж үл болмуй. Одоо та нар: “Бид болбоос танай харьяат албат, аливаа эд хөрөнгийг дуртайяа өргөмүй” хэмээн үнэн сэтгэлээсээ хэлэх хэрэгтэй бөгөөд чиний харьяат ван нараа дагуулан, нэг ч хоцролгүйгээр бидэнд бууж өгөх хэрэгтэй. Ийм болбоос бид сая та нарыг эээр дагагч хэмээн өчмүй. Та нар хэрвээ тэнгэрийн бошгыг үл даган, зарлигийг эсэргүүцвээс даруй дайсан хэмээмү.

Дээр дурдсан аливаа зарлигийг та нар эрхбиш ухаартугай. Хэрвээ буруу санаа өвөрлөвөөс хэрхэхийг тэнгэр мэдмүй.

[Хотоны он тооллын] 644 оны 6 сарын сүүл (1246 оны 11 сарын 3-11-ний өдөр)” гэжээ. Плано Карпини-гийн мэдээнээс үзэхүл, тус бичгийг урьдаар монголоор бичиж, дараа нь сарицан үсгээр орчуулсан гэлээ.

Зураг 6: “Их Монгол Улсын далайн их хааны тамга”. Энэ бол 1246 оны 7 сард Монголын гуравдугаар их хаан Гүюг-ээс Европ дахины пап лам – Ромын шашны хаанд өгсөн төрийн бичигт дарж байсан Монголын их хааны тамга болно. Хэрэг дээрээ Чингис хааны тамга юм. Уул тамгын хэмжээ бараг 15.5 x 15.5 сантиметр ам дөрвөлжин тамга байжээ. Бодтой агуулгыг тавдугаар бүлэгт лавлаарай.

Зураг 7: “Чингис хааны хэрэглэж байсан аяга”. Цзинь Юн-гийн мэдээнээс үзэхүл, энэ аягыг одоо Мандалговь орчмын нэгэн сүмд хадгалж байна гэлээ. Гэтэл Мандалговийн бодот байрыг тодолж чадаагүй.

Зураг 8: “Чингис хааны алтан дөрөө”. Цзинь Юн-ий зохиосон “Бүргэд намнагч баатарын намтар” гэсэн романы тайлбарыг үндэслэвэл Тэр (Чингисийг зааж буй – эшлэгч) нас барсны хойно энэ дөрөө нь хүргэнд нь дамжиж, дараа нь хүргэн нь бас үр хөвгүүндээ уламжилсан гэнэ. Гэвч уул эд одоо хаана хадгалагдаж байх тухай тодорхой мэдээ үгүй байсаар.

В. “Чингис хааны авд хэрэглэдэг эмээл” гэсэн уламжлалт яриа бүхий эмээл. Уул эд нь Эзэн хороон дахи “Чингис хааны онгон” –д хадгалж буй.

Зураг 9: “Чингис хаанд унд барьж байгаа зураг”. Чингис хаан бүх насаа дайн байлдаан ба хүчир бэрхшээлийн дунд өнгөрөөжээ. Нэгэн удаагийн байлдаан (энэ нь Балжуна нуурын тангаргийг дүрсэлжээ)-д ус олдохгүй ангаж байхад нь дагагсад нь чийгтэй шаврыг бөс уутанд хийж шахан, усыг нь дусал дуслаар хуримтлуулж, хааныг нэгэн удаа ундласан гэлээ. Энэ зургийг Перс зурагчин зуржээ. Одоо Иран Тегеран дахи хааны номын санд хадгалж буй.

Зураг 10: “Чингисийн чулууны бичиг” буюу “Есөнхэ мэргэний хөшөө” гэж сүүлчийн үед алдаршсан, одоо Ленинград хотод хадгалагдаж бүхий чулуун дурсгал бол энэ билээ. Нарийн учрыг тавдугаар наймдугаар бүлэгт лавлаарай. Зурагт нүүр дэх А бол тус хөшөөний гэрэл зураг, В, С бол түүний хоёр янзын буулгавар нь болно.

Зураг 11: “Төр захирагч гүнжийн тамга”. Энэ бол Чингис хааны гуравдугаар гүнж Алага бэхи төр захирч байхдаа хэрэглэж байсан гуулин тамга болно. Нарийн учрыг тавдугаар бүлэгт лавлаарай. Одоо Өвөр Монголын музейд хадгалж буй.

Зураг 12: “Зарлигийн элчийн тамга”. Нарийн учрыг тавдугаар бүлэгт лавлаарай. Тус тамгыг одоо Өвөр Монголын музейд хадгалж буй.

Зураг 13: “Эртний Монголчуудын дуулга”. Энэ бол Москвагийн Кремль ордны музейд хадгалж бүхий сэргээн үйлдсэн Монголчуудын дуулга болно.

Зураг 14: “Юань улсын их жанжны дуулга”. Энэ бол Юань улсын Хубилай сэцэн хааны үед Японыг түрэмгийлсэн Монголын их жанжны хэрэглэж байсан дуулга болно. Луугийн хуарыг мөнгөөр чимэглэжээ. Энэ дуулгыг одоо Японы “Юань-ий дээрмийн дурсгалын музей” гэдэгт хадгалж буй.

Нэгдүгээр бүлгийн нүүрийн зураг: “Хийморь”. Хийморь бол Монголчуудын мандал хөгжлийг бэлгэдсэн тэмдэг болно. Чингис хаан яг энэ морин жил мэндэлсэн тул Монголчуудын хийморийн бэлгэ шинж нь болжээ. Ердөө морь бол таван хошуу малын манлай болох тул Монголчууд түүгээр мандал хөгжлийнхөө сүлд тэмдэг болгосон нь зүйтэй юм.

Зураг 15: “Монгол аймгуудын нутаг байрын тойм зураг”. Тус зургийг “Дундад улсын түүхэн газрын зураг”-ийг үндэслэж, бүдүүвчлэн зурав.

Зураг 16: “Чингис хааны төрсөн газрыг олсон тухай мэдээлэл”. Энэ бол 1958 оны 4 сарын 7-ны өдрийн “Вэнь Хуй Бао сонин”-ы дөрөвдүгээр нүүрт нийтэлсэн Синхуа хорооны мэдээ болно.

Зураг 17: “Судрын чуулган-ы нүүрийн зураг”. Тус ном бол Монголын түүхийн тулгар бичгийн нэгээр тооцогдож дэлхий дахинд алдаршжээ.

Зураг 18: “Монголын Нууц товчоон-ы эхний нэгэн хуудас”. Тус ном мөн Монголын түүхийн тулгар бичгийн нэгээр тооцогдсоноор үл барам, Монголын соёлын мөнх хөшөө болон сүндэрлэжээ.

Хоёрдугаар бүлгийн нүүрийн зураг: “Монголын хааны хам тэрэг”. Энэ бол арван есдүгээр зууны үеийн зураг болох бөгөөд Юл-ийн орчуулсан “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-ийн англи хэвлэлд нийтлэгдсэн байв. Хам тэргэнд хорин хоёр үхэр хөлжээ. Хам тэрэгний тухай “Хар Татарын тухай хэргийн товч” зэрэг номд бүр тодорхой тэмдэглэлтэй юм. Тиймээс энэ зураг нь түүхэн тэмдэглэлүүдтэй нийцэж байхыг нутлах хэрэгтэй.

Зураг 19: “Нань Сюнь Дянь харшийн хадгаламж хөрөг болон түүний хувирлууд”. Зурагт нүүр дэх А бол Тайвань-д хадгалж бүхий ордны зураг. В бол Японд дамжигдаж бүхий хуулбар. С бол ордны хөргөөс нэлээд хувирсан нэгэн дам хуулбар (Үүнийг “Өвөр Монгол” зурагт сэтгүүлд нийтэлж байв) болно.

Зураг 20: “Их мэргэн Чингис хаан” гэдэг зурмал хөрөг. Энэ хөргийг арван есдүгээр зууны үед нэгэн Франц зурагчин зурлаа гэдэг билээ. Уул зургийг Өвөр Монголын Зуу аймаг дахи “Чингис хааны онгон”-д хадгалж байв. “Соёлын хувьсгал” (1966-1976)-ын дунд үрэгджээ. Энэхүү гэрэл зургийг тус зууны хориод онд Дундад улсын газарзүйн ухааны судлах хурлын дарга Чжан Юй Си (Чжан Сян Вэнь) авгай “Чингис хааны онгон”-оос сүүдэрлэж, тус хурлын сэтгүүл дээр нийтэлсэн байна.

Зураг 21: “Хайр найргүй байлдагч”. Энэ зургийг Роберт Валлаши-гийн найруулсан “Хүн төрөлхтөний агуу их цаг үе” гэдэг цуврал бичгийн нэг “Оросын мандалт” гэсэн номд нийтэлж байв. Уул тайлбар нь: “Хайр найргүй байлдагч Чингис хаан, түүний ялагдашгүй их цэргээ Дундад Азиас томилон, 1223 онд Оросын нэгэн салаа цэргийг бут ниргэсэн байв. Тэр нэгэн талаар дэлхийг дайлан дагуулахыг зорьж, нөгөө талаар эрдэм мэдлэг, энх тайван ба үнэн шударгыг уламжлахыг зорьж байв. Тэгээд Оросын их хаалгыг тэр нээсэн юм” гэжээ.

Зураг 22: “Кап хоршооны хөрөг”. Энэ хөргийг Америкийн Хайс нарын зохиосон “Дэлхийн түүх”-ийн дунд дэвтэрт “Кап хоршооны зураг” гэж нэрлэж байв. Цзин Цзай-н зохиосон “Чингис хаан” (Тайбэй-н хэвлэл) гэдэг товхимолд Европ хүний зурсан хөрөг гэж тайлж байв.

Зураг 23: “Балгадын сүмийн хөрөг”. Энэхүү “Юань улсын Чингис хааны хөрөг”-ийг Халхын Цэцэн хаан аймгийн Балгадын сүмийн хэрэм дээр зурж бичжээ. Зураг дээрх хувцас, эдлэл зэргээс үзэхүл, Чин улсын үеийн зураг бололтой. Энэ харин Балгадын сүмийн түүхтэй холбогдох магадгүй. Уул зургийг 1912 оноос эрхлэсэн “Баруун хойдхийн сэтгүүл”-ийн анхдах оны нэгдүгээр хугацаанд нийтлэв.

Зураг 24: “Юньнань Монголчуудын сүмийн хөрөг”. Энэ бол Юньнань мужийн Дунхай сянь-ий шинэ монгол их бригадын Монголчуудын сүмд асан Чингис (дундахи), Өгөөдэй (зүүндэх), Хубилай гурван хааны хөрөг болно. Тус зургийг “Алтан гандир” сэтгүүлийн найруулагч нөхөр М.Хасбагана сүүдэрлэсэн бөгөөд тус сэтгүүлийн 1983 оны дөрөвдүгээр хугацаанд нийтлүүлэв.

Зураг 25: А: “Өвөр Монголын музейн шуумал хөрөг”. Энэ хөргийг 1977 онд тус музейн дарга Үндэс шууж, гуулиар цутгажээ. Адил нэгэн цутгамалыг Эзэн хорооны “Чингис хааны онгон”-ы гол цомцогт тавьж буй.

В: “Зүүх хөрөг”. Үүнийг 1982 онд Бээжингийн засал чимгийн үйлдвэрт үйлдүүлж, Хөх хотын засал урлалын газраас тархаажээ. Тэр нь 4.5 х 3.5 см-ийн өндгөн хэлбэртэй, хүзүүнд зүүх хөрөг болно. Гуулиар үйлдэж мөнгөлжээ.

Зураг 26: А: “Чингисийн онгоны шуумал хөрөг”. Энэ бол “Чингис хааны онгон”-ы гол танхимд 1980 онд шуусан хөрөг болно.

В: “Чингис хааны одоо үеийн зурмал хөрөг”. Энэ хөргийг Япончууд зурж, 1984 оны 11 дүгээр хугацааны “Удирдагчид” гэсэн тусгай хэвлэлд нийтэлжээ.

Зураг 27 А: “Будаггүй зурмал хөрөг”. Энэ хөргийг Цю Шо Синь-ий зохиосон “Юань улсын түүхийн яриа” гэдэг номд хавсаргуулсан байв. Энэ бол таталгын зургийн аргаар зурсан хөрөг болно. Гэтэл энэ хөрөг нь Чингис хааны хөргөөс нэлээд зайдаж, Хубилай хааны хөрөг лүгээ ойр болсон мэт.

В. “Мусульманчуудын зурсан хөрөг”. Энэ хөргийг 1982 оны 8 сард Тайбэй-д хэвлүүлсэн “Чингис хаан” (Цзин Цзай зохиожээ) гэдэг товхимолд хавсаргав.

С. “Мүнлэй-гийн зурмал хөрөг”. Энэ хөргийг Мүнлэй гэгч орчимхон зурж, Өвөр Монголын Бугат хотын Бадгар сүмээс тархаажээ (уул зураг өнгөтэй). Энэ зураг бас Чингис хааны эш хөргөөс нэлээд зайдсан бөгөөд хувцас эдлэл нь ч Юань улсын үеийнхээс зөрөөтэй болжээ.

Зураг 28: А: “Өгэлүн эх хөвгүүдээ сургаж байгаа зураг”. Тус зургийг 1981 онд Чэн Бан зурж, 1981 оны 11 дүгээр хугацааны “Үнэр цэцэг” сэтгүүлийн гадар нүүрт Бүлгэмдвээс хүч нь Их - Юань улсын мандсан төрийн хөх судар дахи Өгэлүн хатны сургаалийг тэмдэглэв гэсэн гарчигаар нийтэлжээ.

В. “Чингисийн найман шарга”. Энэ зургийг Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны уран зургийн найруулагч нөхөр Намсрай зурж, Өвөр Монголын цэргийн тойрог нь нийтэлжээ.

Гуравдугаар бүлгийн нүүрийн зураг: “Есүхэй баатарын дайчин сүлд”.

Зураг 29: “Буур хээрийн байлдаан”-ы зураг.

Дөрөвдүгээр бүлгийн нүүрийн зураг: “Чингис хааны цэргийн хүрээ”. Тус зургийн тайлбарыг зураг 32-т лавлаарай.

Зураг 30: “Морио унавал байлдагч”. Энэ бол арван долдугаар зууны үеийн хятад зураг гэж Рубрукскийн “Дорно дахины гүрнүүдээр зуучилсан тэмдэглэл” гэдэг номын оросчлогч мэдээлж байв.

Зураг 31: “Чингис хаан дайснаа дарж бүхий зураг”. Энэ зургийг перс зурагчин зуржээ. Одоо Иран улсын Тегеран дахи хааны номын санд хадгалагдаж буй. Зураг дээр улбар улаан хувцас өмсч, жад барьсан морьтон бол Чингис хаан болно. Түүний өмнө нь төмөр манчуурга далайж, дайсныг цохиж байгаа хүн бол Зэв болно.

Зураг 32: “Чингис хааны цэргийн хүрээ”. Энэ зургийг Монголчууд өөрөө зурж, тус зууны хориод онд Бээжингийн Монгол Бичгийн Хорооноо хэвлүүлсэн “Богд Чингис хааны цадиг” (хэрэг дээрээ “Хураангуй Алтан товч” болно)-т анх нийтлүүлсэн бөгөөд Кобаяши Такаширогийн “Чингис хаан” гэдэг товхимолд дам нийтлэв.

Зураг 33: “Монгол цэргийн аяны эгнээ”. Энэ зургийг Перс зурагчин зуржээ. Зургаас үзэхүл, Монгол цэргийн аяны эгнээ нь дэс дэглэмтэй бөгөөд чанга нарийн зохион байгуулалттай

байна. Морь бүрийн аманд уут зүүлгэжээ. Энэ нь аян замыг саатаахгүй мөртөө аяны журмыг баталж чаддаг юм. Энэ бүр түүхэн тэмдэглэлтэй тохирч байна.

Зураг 34: “Байлдаж бүхий Монголын морьт байлдагч”. Энэ зургийг анх Рашид-ад-Диний номд хавсаргаж байжээ. Сүүлчийн үед Юй баяны ном ба “Дундад улсын нэвтэрхий түүх” зэрэг номд хавсаргажээ.

Зураг 35: “Арван дөрөвдүгээр зууны үеийн Монголын морьт байлдагч”. Тус зургийг Роберт Валлашийн найруулсан “Хүн төрөлхтөний агуу их цаг үе” гэдэг цуврал бичгийн нэг “Оросын мандалт” гэсэн номд: “Тус зураг бол арван дөрөвдүгээр зууны үеийн Дундад улсын зураг” гэж тэмдэглэжээ.

Зураг 36: “Юань улсын үеийн монгол цэргийн хэрэглэж байсан хөнгөн нум сум”. Уул эдийг одоо Японы “Хакүсаки ордон”-д хадгалж буй.

Зураг 37: “Монголын морьт цэргийн хөнгөн сэлэм”. Уул эдийг долоон зуун жилийн өмнө, Монголын довтлогчид Японы Кюшю-г довтлох үед далайд тунаасан онгоцноос олжээ.

Зураг 38: “Монгол цэргийн их буу” – “чөдөр оньс”. Уул зургийг “Дундад Ази ба Монголоор аялсан тэмдэглэл” (япон хэвлэл)-д нийтэлж байв. Түүний доорхи хэсгийг нь Плано Карпинийн “Монголын түүх” ба Рубрукын “Дорно дахины гүрнүүдээр зуучилсан тэмдэглэл” (орос хэвлэл)гэдэг номд нийтэлж байсан бөгөөд зураг нь ялимгүй зөрөөтэй байв. Сүүлчийн номд: “Монголын харвах машин” (перс зурагчин зуржээ, Рашид-ад-Диний “Судрын чуулган”-аас буулгав) гэж тэмдэглэж байлаа.

Зураг 39: “Чулуун бөмбөг”. Энд бол эртний монгол цэргийн “чөдөр оньс” гэгч их харвуулаар харваж, хот барилгыг эвддэг зэвсэг болно. Уул эдийг Япон далайд тунаасан монгол цэргийн онгоцноос олжээ.

Зураг 40: “Тэсрэгч бөмбөг”. Энэ бол дариар дэлбэрүүлэх туйлын хүчтэй зэвсэг болно. Хятад хэлэнд “Тэнгэрийг донсолгогч мина” гэж нэрлэдэг. Уул эдийг одоо Японы Сэода Их Сургуулийн музейд хадгалж буй.

Зураг 41: “Юань улсын үеийн монгол цэргийн хуяг дуулга”. Уул эдийг одоо Япон дахи “Юань-ий дээрмийн дурсгалын музуй”-д хадгалж буй

Зураг 42: “Юань улсын үеийн монгол цэргийн хэрэглэж байсан дөрөө”. Доорхи нь одоо үеийн дөрөө. Уул эд нь одоо Японд хадгалагдаж буй.

Зураг 43: “Арван гурван хүрээний байлдаан”-ы зураг.

Зураг 44: “Хүйтний байлдаан”-ы зураг.

Зураг 45: “Муу өндөр ба Жэжэгэр өндөрийн байлдаан”-ы зураг.

Зураг 46: “Онгуд аймгийн несторианчуудын загалмайт хөшөө чулуу”. Энэ хөшөө бол Онгуд аймгийн төв Зуу вангийн хотод байжээ. Монголын зарим аймаг – Онгуд, Найман, Хэрэйд

зэрэг уулдаа Христосын шашны несториан бүлгийг шүтэж байсныг энэхүү археологийн баримт нэн багтай гэрчилж байх бөгөөд тэр нь монгол үсэг бичгийн түүхнээ холбогдох чухал дурсгал болно. Ийм дурсгалт зүйл тус газар олон байсныгдотоод гадаадын эрдэмтэд нүдээрээ үзэж маш олон тэмдэглэл ба судалгааны өгүүлэл зэргийг бичжээ. Харамсалтай нь эдгээр хөшөө чулууны олонхи нь “Соёлын хувьсгал”-ын дунд үрэгджээ.

Зураг 47: “Наху гуны байлдаан”-ы зураг.

Тавдугаар бүлгийн нүүрийн зураг: “Монголын хааны шар ордон”. Тус зургийг “Плано Карпинийн аяллын тэмдэглэл” (оросчилго)-д хавсаргаж байсан бөгөөд арван наймдугаар зууны үед Францын зурагчин зурсан гэж тэмдэглэж байв.

Зураг 48: “Чингис хаан хаан ордоо саатаж бүхий зураг”. Хааны баруун талд сууж байгаа хүн бол Бөртэ үжин хатан, хааны өмнө нь сөгдөж байгаа хоёр хүн бол Жочи, Өгөөдэй бололтой гэж Кобаяши Такаширо авгай тэмдэглэжээ. Гэтэл Рубрукийн номын оросчилгод: “Өгөөдэй хаан анх удаа хаан суусан байдал – арван дөрөвдүгээр зууны перс зурагчны зурсан бодот зураг” гэж Шастина тэмдэглэж байв. Зургийн байдлаас үзэхүл, Чингисийн зураг гэсэн нь зүйтэй мэт.

Зураг 49: “Өгөөдэй хаанаас Чингисийн их засаг-ийг уламжилж бүхий зураг”. Кобаяши Такаширо-гийн орчуулсан “Монголын Нууц товчоон”-оос дам эшлэв.

Зураг 50: “Амудулла вангийн зарлигийн пайз”. Энэхүү мөнгөн пайз (бас гэрэгэ гэж нэрлэдэг)-ыг 1845 оноо Днепр мөрний хөвөөнөөс олжээ. Энэ бол цул уйгуржин монгол үсгээр сийлсэн, одоо хүртэл олдоод байх пайзын цорын ганц жишээ болно. Нарийн учрыг тавдугаар бүлэгт лавлаарай.

Зураг 51: “Зальхайг сэргийлэх зарлигийн пайз”. Тус пайзыг гуулиар үйлджээ. Нүүрийн талд нь хятад үсэг, ар талд нь перс, дөрвөлжин монгол, уйгуржин монгол гурван зүйлийн үсэг буй. Дөрвөлжин ба уйгуржин монгол үсгийн агуулга нь “Зар тунхаг мууг сэрэгдэх” гэсэн үг болох мэт. Энэ пайз нь 1925 оны баргаар Бээжинд дамжигдаж байжээ. Сүүлдээ Зөвлөлт Холбоот Улсад шилжлээ.

Зураг 52: “Урталжин хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз”. Тус пайзыг 1846 онд Оросын Ениссей чжоу-гийн Минусинск гэдэг газраас олжээ. Тус пайзыг мөнгөөр үйлдэж, хоёр талд нь монгол дөрвөлжин үсгийг сийлээд алтаар шаржээ. Нүүрийн талд нь гурван мөр үсэгтэй:

(1) Тэнгэрийн хүчин дор.

(2) мөнх

(3) хаан нэр хутугтай.

Хоёрдугаар мөрийн “мөнх” гэсэн ганц үсэг нь нэгдүгээр мөрийн дээр орж, “Мөнх тэнгэр” гэсэн үг болох ёстой. Эртний үед зориуд ингэж бичдэг гэж Н.Поппе тэмдэглэж байв. Тус

пайзын ар талд нь нүүр талын агуулгыг үргэлжлүүлсэн хоёр мөр үсэг буй:

(1) болтугай хэн үл бү

(2) ширэх алах үхэх.

Нэгдүгээр мөрийн эцсийн “вь” болон хоёрдугаар мөрийн эхний “si-re-кь” гэсэн нь “бүширэхү” гэсэн нэгэн үсгийг салган бичжээ. Уул пайзыг Н.Поппегийн зохиосон “Дөрвөлжин үсэг” гэдэг номд нийтэлж байсан бөгөөд “Марко Поло-гийн аяллын тэмдэглэл”-д түүний хуулбарыг ашиглажээ.

Зураг 53: “Дугариг хэлбэртэй дөрвөлжин үсгийн зарлигийн пайз”. Гэрэл зураг А-г бол тус зууны жараад онд Төвдөөс олж, одоо Ганьсу мужийн музейд хадгалж буй. Ийм хэлбэрийн пайз Дундад улсад олдсон нь ганц энэ л болно. Гэрэл зураг В бол Оросын Томск чжоу-гаас арван есдүгээр зууны үед олджээ. 1881 онд Позднеев Оросын Шинжлэх Ухааны хүрээлэнгийн сонин дээр анх нийтлүүлсэн байв. Манай мэдэж байхаар энэ хэлбэрийн пайз дэлхийд мөн энэ хоёрхон олдоод байна. Хоёр зүйлийн пайзыг бүр төмрөөр үйлдэж, мөнгөн үсэг суулгажээ. Энэ хоёр пайз бол Юань улсын үед зарлигийн элчийн хэрэглэдэг пайз болно. Хоёр пайзын дөрвөлжин үсэг нь: “Мөнх тэнгэрийн хүчин дор хааны зарлиг хэн эс бүширвээс аладтугай” гэсэн үг болно.

Зураг 54: “Зуу вангийн хотын чулуун арслан”. Энэ бол Чингисийн охин Алага бэхи-гийн сууж байсан Зуу вангийн хотод хадгалагдсан чухал дурсгал болох бөгөөд Монгол үндэстний гар урлалын хөгжил бадралыг тусгасан бүтээл болно. Түүний хэв дүр, ялангуяа сүүл нь Мин, Чин улсын үеийн сийлбэртэй таарахгүй юм. Энэхүү Чингис хаан лугаа холбогдсон чухал дурсгалт зүйлийг өнөд хамгаалан хадгалахын тулд 1983 онд Өвөр Монголын цэргийн тойргийн комиссар, Юншээбү овогтон Юнь И Ли нөхөр эрхлэн шилжүүлж, Эзэн хороон дахи “Чингис хааны онгон”-ы хүрээнд байрлуулжээ.

Зураг 55: “Монгол барилгачдын уран бүтээл”. Эдгээр хагархай ваарнууд бол Чингис хааны хүргэний нутаг Зуу вангийн хотын туурайд үлдэж байсан байшингийн чимэг болно. Үүнийг “Зөвлөлтийн эртний судалгаа” сэтгүүлийн 1959 оны гуравдугаар хугацаанд нийтлэгдсэн “Дундад улсын байшин ваарын түүхийн тухай товч үнэлэх нь” гэсэн өгүүлэлд дурдсан Хятаны хот Дэнжэлэгэ-ийн үлдэгдэл ваар чимэг болон Өгөөдэй хааны нийслэл Хар Хорумын ваар чимэгтэй адилтгаж үзэхүл, нэг л газрын эд гэж хэлж болмоор байна. Үүнээс Монголын хот барилгын орд удаан түүхэн уламжлалтайг мэдэж болно.

Зураг 56: “Онгоцон тээрэм” (нэрийг зохиогчоос тохируулав). Энэ бол Онгуд аймгийн монгол тариачдын хэрэглэж байсан үндэстний онцлог бүхий тарианы багаж хэрэгсэл болно. Дугариг хэлбэртэй онгоцон хүрээний диаметр нь 4.6 метр, бул чулууны диаметр нь 1.27 метр, тэнхлэгийн нүх нь 0.29 метр хэмжээтэй (үүнээс том хэмжээнийх бас буй, баахан бүрэн бус болжээ). Үүнээс үзэхүл, арван гуравдугаар зууны үед тариалан аж ахуйг эрхэлж байсан Монголчуудын үйлдвэрлэлийн хүч нэлээд өндөр хэмжээнд хүрснийг мэдэж болно. Ийм дурсгалын зүйл одоо Өвөр Монголд цөөн бус хадгалагдаж буй. Энэ бол Өвөр Монголын дархан Муумянган хошууны Цагаан давааны Шар хад гэсэн газар байх нэгэн “Онгоцон тээрэм” болно.

Зураг 57: “Арван зүгийн их Цзи Вэй гүн ордон дахи зарлигийн хөшөө”. Тус хөшөөг 1240 он (Өгөөдэй хааны үе)-д босгожээ. Одоо болтол Хэнань мужийн Цзий Юань-ий сянь-д хадгалж буй. Тус хөшөө бол арван нэгэн мөр хятад үсэг, гурван мөр уйгуржин монгол үсгээр бүрэлджээ. Гэтэл хятад монгол хоёрынхи нь агуулга бүр адилгүй юм. Хөшөөний хятад үсэг нь (босоо бичлэгийн журмаар баруун мөрөөс байрлуулжээ):

(1) 皇帝圣旨里依旧行
(2) 东宫事
(3) 也可合敦大皇后懿旨并
(4) 妃子懿旨道与平阳府路达鲁
(5) 花赤管民官据沁州管民官杜丰
(6) 雕造道藏经并修盖等事可充
(7) 提领大使勾当者你不得功夫时节
(8) 你的娘子充提领勾当者兼不以
(9) 是何头下官员人等无得骚扰
(10) 如违要罪过者准此
(11) 庚子年三月十七日

皇帝之宝

Зүүн тал дахи гурван мөр уйгуржин монгол үсгийг:

“(1) энэ миний үг бус булхаг – сан хүн

(2) их ... ? ... алдаг - шүтү болтугай [...] энэ

(3) бичиг хулгана жил” гэж Америкийн Харвард Их Сургуулийн нэгэн өгүүлэлд тэмдэглэжээ.

Энд хятад бичээсийг нь сийрүүлэхдээ хэвлэлийн дүрмийг бодож, хятад үсгийн олон зурагт тигийг одоогийн товчилсон тиг болгов.

Зураг 58: “Шагимунийн хүрээлэнгийн хөшөө тэмдэглэл”. Үүнийг бас “Мөнх хааны гэрэлт хөшөө” гэдэг билээ. Энэ хөшөөг 1953 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн орон нутгийг судлах эрдэм шинжилгээний экспедицийнхэн Хөвсгөл аймгийн Ар булаг сумын гуравдугаар багийн нутаг Дэлгэр ханы өвөр, Дэлгэр мөрний хойд

хөвөө дэх Алтан гадас гэдэг бяцхан хадан уулын хойгуурхнаас олжээ. Энэ хөшөө одоо Улаанбаатар хот дахи Монгол улсын Төв музейд хадгалагдаж буй.

Энэ хөшөө чулууг 144 см өндөр, 78 см өргөн, 20 см зузаан хөх бор өнгөтэй засмал занаржсан туйпуу чулуугаар үйлдэж, хөшөөний манлай дээр нь “Шагимунийн хүрээлэнгийн хөшөө тэмдэглэл” гэсэн таван хятад үсгээр хөшөөг нэрлэжээ. Хөшөөний гол биед зүүн мөрөөс гурван мөр уйгуржин монгол үсгийг, баруун мөрөөс арван хоёр мөр хятад үсгийг тус тус сийлж буй. Хөшөөний хөвөө дэх эвэр угалзан хээ нь “Цзы Вэй гүн ордны хөшөө”-тэй адил юм.

Тус хөшөөний тухай 1956 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн орон нутгийг судлах эрдэм шинжилгээний экспедицийн гишүүн Намнандорж “Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай” гэсэн гарчгаар анх нэгэн эрдэм шинжилгээний өгүүллийг нийтлүүлжээ. Дараа нь Ц.Дамдинсүрэн (1957 он “Монголын уран зохиолын түүх”), Юншээбү-гийн Ринчин (1959 он “Дундад Ази” сэтгүүл), Н.Поппе (1961 он “Дундад Ази” сэтгүүл) нар тус тус өгүүлэл нийтлүүлж, тус хөшөөний тухай цаашид судалцаж байна.

Тус хөшөөний уйгуржин монгол бичгийг Намнандорж авгай анх удаа:

“(1) Уругун уругугар хэдэн хэдэн үест (2) Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж барс түгэ босгуулж (3) хөндлөн энэ дабаригт (учралт)буян хүртүгэй” (“Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1957 оны аравдугаар хугацаанаас дам эшлэв) гэж уншсан бөгөөд нэгдүгээр, хоёрдугаар мөрийн гол агуулгыг “Ургийн ургаар хэдэн хэдэн үедээ Мөнх хаан түмэн түмэн насалтугай...” гэж тайлбарлажээ. Гуравдугаар мөрийн сүүлчийн хоёр үсгийг “барс түгэ” буюу “бара түгэ” гэж хоёр янзаар уншсан бөгөөд “түгэ” гэсэн үгийг “Хөх судар”-аар эшилж “түүх” гэсэн үг ч байж болно гэж жишжээ.

Сүүлчийн судалгаа, ялангуяа Н.Поппегийн судлал нь монгол бичээсийг нь унших талаар нэлээд гүнзгийрсэн мэт. Түүний үзэлтээр бол, энэ гурван мөр үсгийн зөв унших арга нь, уулын хоёрдугаар мөрийг нэгдүгээрээр, нэгдүгээр мөрийг хоёрдугаараар тонгоруулж уншвал таарна гэжээ. Үүнээ Юань улсын үеийн зарим пайзын бичээсээр нуталжээ.

Түүний уншсан нь:

“(1) Мөнх хаан түмэн түмэн насалтугай хэмээж барс түгэ босгуул[в]

(2) Ургийн ургаар хэдэн хэдэн үестээ

(3) хүртэл энэ дабарихуны буян хүртүгэй” гэжээ. Поппегийн энэ уншсаныг ерөнхийдөө нэлээд оновчтой гэж үзэж болно. Гагцхүү гуравдугаар мөрийн гуравдугаар үсгийг “dabarigunu” гэсэн нь арай хангамжгүй мэт. Харин “dabarigtu” гэвэл зүйтэй шиг байна. Тус хөшөөний хятад үсэг нь нийт 263, үүний дотор 207 үсэг нь бүтэн, 5 үсэг нь хагас эвдэрхий, 51 үсэг нь бүрмөсөн эвдэрсэн гэлээ (энэ бол Намнандорж авгайн бүртгэл болно). Тус хөшөөний гэрэл зургийг нарийн ажиглаж, уншин таньсан үсэг доорхи мэт (хятад үсгийг хэрэглэв) голт бичгийн журмаар баруун мөрөөс байрлуулсан бөгөөд зурлага товчилсон

- (1) ……国外刺随营居奉
- (2) □附马八立托公主悉基投丹悃者切念生居浊世幸遇
- (3) □君爰处爰居长安长乐赖
- (4) 天地复载之德叨…
- (5) 国王水土之恩中心藏之追酬罔及今者八立托广兴喜舍之心办财立像重发
- (6) □提之意建寺□僧上报□□广搏之洪麻别糞…
- (7) 今□皇帝毳寿无疆国泰民安□□法轮常转次糞…
- (8) 在堂公主福寿增延进去时中吉祥如意再乞自身吉庆四时歌庆贺之欢后嗣
- (9) 称心□□请佛应心中之愿四恩□报三友遍资□□法界有情俱登
- (10) 彼岸…护□□兴…
- (11) 一草招愆多生好结良因早成…二…
- (12) 丁巳季夏中旬后五日奉佛附马八立托公主一悉基立记

Дээрх гэрэл зургийн сийрүүлэлтээр бүртгэвэл, таньж болмоор үсэг 210, хөшөөний нэр “син, чжа, юань, бэй, цзи” гэсэн таван үсгийг бодвол нийт 215 байх мэт.

Тус хөшөөний босгогдсон цаг бол нийтийн он тооллын 1257 он (Мөнх хааны долдугаар он, улаагчин могой жил) болохыг эл судалгааны дүнд санал нэгтгэйгээр үзэцгээж байна. Гэтэл, ямар хүн босгосон тухай харин янз бүрээр жишицгээж буй. Би үзэхүл, хөшөө чулууны тэмдэглэл нь энэ асуудлыг хангамжтай хариулж чадах боломж бүр буй. Тухайлбал “хүргэн Барс түгэ”, “гүнж Исихэ” бол энэ хөшөөг босгосон эзэн хүн болох нь дамжиггүй билээ. Энэ “Барс түгэ” бол монгол бичээст нь тэмдэглэж бүхий “Бар түгэ буюу Барс түгэ” болох нь ч тодорхой байна. Үүнийг “Барс түгэ” гэж уншиж үл болох мэт. Ийм нэр эртний Монголчуудад зөндөө байдаг. Жишээлбэл, Түгэ, Төгэ маха, Есөнтэгэ гэх мэт.

Бас нэгэн зангилааны чанартай асуудал бол “Барс түгэ” хүргэн чухам аль аймгийн хүн гэсэн асуудал болно. Энэ асуудлыг өгүүлэл нийтлэгсэд арай хангамжтай хариулаагүй мэт. Ялангуяа Намнандорж авгайн өгүүлэлд дурдсан “Улсын Их Сургуулийн хятад хэлний багш профессор Люй Юань Мин” гэгч “Юань улсын түүх”-ээр эшилж, 1257 онд Мөнх хааны говийн өмнөд орныг туулж, Юй Лун Чжан гэдэг газар ирэхэд Хубилай болон ван нар Ариг бөх, Ба Ли Ту, Цомхор, Өргөндаши, Ширги нар угтав гэсэн тэмдэглэл дэх “Ба-ли-ту” бол энэхүү хөшөөнд тэмдэглэгдсэн хүргэн “Ба-ли-ту” мөн гэжээ. Үүнийг хэн үзэвч зохисгүй юм. Учир нь, “Юань улсын түүх”-ийн тэрхүү тэмдэглэлд “ван нар” гэж тов тодорхой бичиж байтал хэрхэн “хүргэн” болох буй? “Ван нар” бол хааны төрлийнхэн болох бөгөөд “хүргэн” бол харь овогтон болох нь харин энгийн мэдлэг билээ. Тэр үед, Монголын хааны угсаа лугаа худ ургийн харьцаатай байсан монгол хэлтэн аймгууд гэвэл: Хонгирад, Ихирэс, Онгуд, Ойрад зэрэг байв. Харь хэлтэн аймгуудаас Уйгур, Харлуг зэрэг байв. Чингэвэл “Барс түгэ” хүргэн яриангүй эдгээр аймгуудын нэгэнд нь харьяалагдах ёстой. Тиймээс бас л хөшөөний тэмдэглэлийг нарийн хянаж үзэхүл, энэ асуудлыг мөн хариулж болох мэт. Тухайлбал, тус хөшөөний хятад бичээсийнх нь нэгдүгээр мөрд: “Го-вай-ла-суй-ин-чжу-фэн” гэсэн хятад үсэг буй. Үүнийг Намнандорж авгайн хавсрагч нар “Улсын гадна...” гэж орчуулж байв. Би үзэхүл “го” гэсний дээр үсэг гээгдэж байх тул тэр “го” гэсэн тал үсэг нь дээрх үсэгтэйгээ нийлж “х х улс” гэсэн утгатай үг байсан байж мэднэ. Тийм бол “вай-ла” гэсэн нь ойн иргэний нэгэн болох “Ойрад” аймгийг заасан нь баримттай юм. Ойрадыг хятадаар “вэ-и-ла-ти” (“Нууц товчоон”-д), “вэ-ла” (“Биеэр дайлсан тэмдэглэл”-д), “вай-ла” (“Юань улсын түүх”-д) гэж дээр үед галиглаж байсан бөгөөд хожим нь “ва-ла” (Мин улсын үед), “ва-ла-тэ” (“Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”-д) гэж янз янзаар галигладаг байна. Тэр үед Ойрадын түрүү Хутуга бэхи хэрхэн орж өгсөн ба түүний хоёр хөвгүүнд Чингисийн охин болон Жочи-гийн охиныг өгч тэдэн лүгээ худ ураг бололцсон тухай би тус товчооны зургадугаар бүлэгт нарийн тэмдэглэсэн билээ. Ингээд үзвэл, энэ “Барс түгэ” гэгч Хутуга бэхи-гийн гуравдугаар үеийн үр хойч нь болох мэт.

Зураг 59: “Монголын Нууц товчоон-ы шинэ хэвлэлүүд”. Чөлөөлөгдсөнөөс нааш Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хорооноос “Монголын Нууц товчоон”-ыг адил бус хэрэгцээнд тохируулан дөрвөн зүйлээр хэвлүүлжээ.

Зургадугаар бүлгийн нүүрийн зураг: “Хаант Монгол Улсын бэхжил”.

Зураг 60: “Хаан амгалан, ард тайван, ан элбэг”

А “Чингис хаан ордондоо буцаж ирэн саатаж байгаа зураг”. Энэ бол персийн зурагчны зурсан зураг болно. Кобаяши Такаширо-гийн орчуулсан “Монголын Нууц товчоон”-оос дам эшлэв.

В “Ард тайван”. Энэ бол монгол үндэстний тайван амьдралыг тусгасан, арван дөрөвдүгээр зууны үед перс зурагчны зурсан зураг болно.

Одоо Их Британийн музейд хадгалж буй.

С “Ан элбэг”. Энэхүү Монголчуудын ангийн зургийг Туркийн зурагчин зуржээ. Одоо Стамбул хотын Топкапы Сарай гэгч музейд хадгалж буй.

Зураг 61: “Жочи-гийн цэрэг Ойн иргэдийг дайлсан зураг”.

Зураг 62: “Зэв, Сүбээдэй баруунш шүүрдэлт хийсэн зураг”.

Зураг 63: “Хар Хятаны газрын зураг”.

Зураг 64: “Бөө удганы дүр”. Бөө мөргөл бол эртний Монголчуудын балас шашин болно. “Удган” гэж эм бөө хэлдэг.

Зураг 65: “Монголын хааны аяны бараа”. Энэ бол 1315 онд Перс зурагчны зурсан бодот зураг болно. Плано Карпини-гийн “Монголын түүх” гэсэн жуулчлалын тэмдэглэлээс дам эшлэв.

Долдугаар бүлгийн нүүрийн зураг: “Урт цагаан хэрэм”.

Зураг 66: “Тангуд улсын газрын зураг”.

Зураг 67: “Тангуд улсын үсэг”. Энэ бол Өвөр Монголын Эзнээ хошууны Хар хот (Тангуд улсын Чал хот)-оос Оросын Козиров түрүүтэй жуулчлалын бригад 1908 оноо малтаж авчирсан Тангудын чухал дурсгалын нэгэн зүйл болно.

Зураг 68: “Чингис хаан нэгдүгээр удаа Тангудыг дайлсан зураг”.

Зураг 69: “Алтан улсын газрын зураг”.

Зураг 70: “Чингис хаан 1-р удаа Чжунду-г дайлсан зураг”.

Зураг 71: “Чингис хаан 2-р удаа Чжунду-г дайлсан зураг”.

Зураг 72: “Чингис хаан 3-р удаа Чжунду-г дайлсан зураг”

.

Зураг 73: “Хятан бага үсгийн хөшөө”.

Зураг 74: “Чингис хаан Алтан улсад байлдаж байгаа зураг”. Энэ зургийг перс зурагчин

зуржээ. Одоо Их Британийн музейд хадгалж буй. Бүх зургийг нь “Дундад Ази ба Монголоор аялсан тэмдэглэл”-д, гол хэсгийг нь Цзинь Юн “Бүргэд намнагч баатрын намтар” гэдэг романд тус тус нийтлэв.

Зураг 75: “Алтан улсын үеэс одоо болтол ургаж байгаа нарс мод”. Энэ бол одоогийн Бээжин хотын Бэй Хай цэцэрлэгийн өмнө үүдэнд бүхий Гуань Чэн гэгч Юань улсын барилгын дээр сэхүйж байгаа нарс мод болно.

Наймдугаар бүлгийн зураг. “Чингисийн чулууны бичиг”.

Зураг 76: “Самарканд дахи Төмөрийн сүм”. Энэ бол Исламын мөргөлтний дуган болно. Үүнийг арван тавдугаар зууны үед байгуулж, 1948-1949 оны хооронд сэлбэн заслаа гэдэг билээ. Зургийг Кобаяши-гийн номоос дам эшлэв.

Зураг 77: “Хорезм улс ба Чингис хаан баруунш дайлсан тойм зураг”.

Зураг 78: “Зэв, Сүбээдэй Оросын Кипчак өөд довтолсон зураг”.

Зураг 79: “Чингис хаан Хорезмд байлдаж байгаа зураг”. Энэ бол Рашид-ад-Диний номд хавсаргасан, перс зурагчны зурсан зураг болно.

Зураг 80: “Чингис хаан сургаал тавьж бүхий зураг”. 1220 оны 3 сард Чингис хаан Бухара хотыг эзлэн авч, Мусульманчуудын ёслолын дуган Махсура-гийн индэрийг хэдэн шат даван гарч, тэндэх язгууртад ба худалдаачдад яриа тавьжээ (Нарийн учрыг наймдугаар бүлэгт лавлаарай). Эртний перс зурагчны зурсан зураг нь энэхүү түүхэн хэргийг гойд сайхан тусгаж чаджээ.

Зураг 81: “Чан-чунь арш Цю Чу Цзи-гийн хөргүүд:

А: “Чан-чунь арш энгийн хувцас өмсч зам явж бүхий зураг”. Уул зураг нь будагтай, Чин улсын үед зуржээ. Бай Юнь Гуань-д хадгалж буй.

В: “Чан-чунь арш хувхай модыг эдгээсэн зураг”. Уул зургийг Сүн улсын үеийн “Аршидын бүх намтар” гэдэг номд хавсаргаж байжээ. Одоо сүмийнх нь үүдэнд ийм нэгэн хөшөө буй.

С: “Чан-чунь аршийн өтөл насны шуумал хөрөг зураг”. Энэ хөргийг Бай Юнь Гуань-ий “Дээдийн харш”-д тахиж буй. Түүнийг Мин улсын үед нэгэн балба шуумалчин шуув гэдэг.

Д: “Чан-чунь аршийн идэр насны шуумал хөрөг”. Энэ хөргийг Бай Юнь Гуань долоон аршийн харшид тахиж буй.

Зураг 82: “Чан-чунь арш баруунш зорчсон аяны шугам”.

Зураг 83: “Бай Юнь Гуань сүм”. Энэ бол Бээжин хот дахи бумбын сүм болно. Чан-чунь арш Дундад Азид Чингис хаантай бараадаж ирээд энд сууж байсан бөгөөд 1227 онд энд нас баржээ. Ингээд Бай Юнь Гуань нь тэр үеэс нааш бумбын шашны төв нь болов. Одоо Дундад улсын бумбын шашны зөвлөл энд ажиллаж буй. Энэ бол Бай Юнь Гуань сүмийн гол үүд

болно.

Зураг 84: “Бумбын шашны дээд Цю Чу Цзи-гийн харш”. Энэ бол Чан-чунь аршийн тухай хөшөө ба түүнийг оршуулсан газар нь байгуулсан “Дээдийн харш”-ийн гадар үзэмж болно.

Зураг 85: “Гуулин морь”. Энэ бол Бай Юнь Гуань сүмийн Дундад харш - долоон аршидын харшийн үүд дэх Чин улсын үед үйлдсэн монгол хэлбэрт гуулин морь болно.

Зураг 86: “Чингис хааны зарлигийн сийлээс – А, В”. Энэ бол Шаньдун мужийн Лао Шань-д бүхий Чингис хаанаас Чан-чунь аршид өгсөн зарлигийн бичгийн сийлээс болно. Тэр нь сийлэгдээд долоон зуу гаруй жил болжээ.

Зураг 87: “Чингис хааны шударга залгамжлагч - Өгөөдэй хаан”. Энэ бол Бээжингийн хааны музейн Нань Сюнь Дянь харшийн хадгаламж болно.

Есдүгээр бүлгийн нүүрийн зураг: “Чингис хааны онгоны гадар үзэмж”.

Зураг 88: “Чингис хаан хамаг эцэс Тангудыг дайлсан зураг”.

Зураг 89: “Шинэ хуучин хоёр үеийн Чингис хааны онгон”. Баруун талын зураг бол 1923 онд Өвөр Монголын Их Зуугийн чуулганы Далан хошууны Вангийн зууд байсан “Чингисийн онгон”-ы гадар байдал болно. Зүүн талын зураг бол 1955 онд Ардын Засгийн Ордноос Их зуу аймгийн Эзэн Хороо хошуунд байгуулсан “Чингис хааны онгон”-ы гадар үзэмж болно.

Зураг 90: “Шинэ хуучин хоёр үеийн цомцог”. Дээрх зураг бол тус зууны хориод оны үеийн Чингисийн онгоны тахилгын цомцог болно. Доорхи зураг бол 1955 онд байгуулсан шинэ онгоны ар танхим дахи хөх хөлтөргөтэй шар торгон цомцог болно. Дундахи нь Чингис хаан болон Бөртэ үжиний тахилгын цомцог гэдэг.

Зураг 91: “Шар хасаг”. Дээрх зураг бол чөлөөлөгдөхөөс өмнөх Чингисийн онгоны дотор хүрээ ба онгоны шар хасаг (онгоныг нүүлгэх тэрэг)болно. Доорхи зураг, одоо уул тэрэгний хоёрхон бул үлдэж, шинэ онгоны хүрээнд тавьж буй.

Зураг 92: “Чингисийн сүлд”. “Сүлд” гэдэг бол эртний Монголчуудын цэргийн туг нь юм. Чингис хааны “Хар сүлд”-ийг урьд гурван зуун хээр азарганы унаган дэлээр үйлддэг гэлээ. Чингис хааны сүлдийг анхдаа сүлдийн хороо гэж тусгай байгуулан тахиж байжээ (зураг А); одоо шинэ онгоны баруун тэнхимд тусгай тахиж байна. Тэрхүү тойрсон бага сүлдийг “элч сүлд” гэдэг (зураг В) байна. Зураг С бол чөлөөлөгдөхөөс өмнө сүлдийн тахилгыг явуулж байгаа байдал.

Зураг 93: “Гол танхим”. Энэ бол одоохи “Чингис хааны онгон”-ы гол танхим болно. 1980 онд “Чингис хааны онгон”-ыг сэргээн засах үед Чингис хааны хуяг дуулгатай том шуумал хөргийг энэ танхимд босгожээ.

Танхимийн хоёр хонгилын хэрэм дээр нь бас ханын зургийг зуржээ. Харамсалтай нь энэ шуумал хөрөг нь Чингис хааны эш хөрөгтэй нэлээд зөрөөнтэй болсон бөгөөд хуяг дуулга нь ч

тухайн үеийн эдлэлтэй баахан зөрөөтэй болжээ.

Зураг 94: “Чингис хаан ба Бөртэ үжиний шарилын авдар”. Энэ бол одоохи “Чингис хааны онгон”-ы ар тэнхмийн гол цомцогт тахиж бүхий “Чингис хаан ба Бөртэ үжиний шарилын авдар” болно. Чин улсын үед үйлдсэн авдрыг нь “соёлын хувьсгал”-ын дунд үрэн сүйтгэжээ. Энэ бол 1980 онд уул зургийг үндэслэн дахин сэргээн үйлдсэн зүйл болно. Түүний өмнөх шуумал хөрөг бол Өвөр Монголын музейн шуумалын хуулбар цутгаас болно. Нарийн учрыг есдүгээр бүлэгт лавлаарай.

Зураг 95: “Хулан хатны шарилын авдар”. Энэ бол баруун цомцогт тахиж бүхий авдар болно. Үүнийг “Хулан хатны шарилын авдар” гэж дархад тайлж байв. Одоогийн энэ авдрыг мөн 1980 онд шинээр үйлджээ. Гэтэл найман цагаан гэрт Хулан хатны байр байсан тэмдэглэл хараахан үгүй байна.

Зураг 96: “Эш хатны шарилын авдар”. Ар тэнхмийн зүүн цомцогт тахиж бүхий авдар болно. Дархадын хэлэхээр, энэ бол “Эш хатан Гүрбэлжи гуагийн шарилын авдар” болох юм байна. “Өвөр Монгол” зурагт сэтгүүл дээр “Есүй хатан” гэжээ. Харин “Эш хатан” гэдэг бол Чингисийн бага хөвгүүн Тулуйн хатан Сорхагтани-гийн цол болно. “Эш” гэсэн нь эш баримтын “эш” биш, харин түрэг хэлний “бэр” гэсэн утгатай үг юм. Нэн ч Гүрбэлжи гуа бол Чингисийн хатан огт биш юм.

Зураг 97: “Тахилгын хэрэгсэл”.

А: “Жолоон эмээл”. Одоо Чингисийн онгонд “Жолоон эмээл” гэдэг гурван эмээл буй. Түүнийг “Байлдаанд хэрэглэх эмээл”, “Энгийн үед хэрэглэх эмээл” ба “Авд хэрэглэх эмээл” (“Морьт үндэстний дурсгалт зүйл”) гэж нэрлэжээ. Эдгээр эмээлүүдийг Лигдэн хааны үеэс уламжилж ирлээ гэдэг яриа байхын хамт бас долдугаар дүрийн Банчин эрдэнэ өргөв гэж 1959 онд нэгэн өвгөн дархан танилцуулж байв.

В: Данх

С: “Цомцогийн түлхүүрийн хайрцаг”.

Тус хайрцгийн дээр: “Тайш Рэнчинноров тайш Эрхбаатар нар их гаиниту түлхүүрийн хайрцаг тунган өргөв” гэсэн монгол үсэг сийлж буй. Хайрцгийн зүүн талд тавьж байх нь тахилгад хэрэглэх бумба болно.

Д: “Тахилгын суулга”. Энэ суулгыг сүлдийн танхимд тавьж буй. Энэ хоёр мөнгөлсөн суулга бол мөн тахилгын хэрэгсэл байрлах бөгөөд одоо үлдэж бүхий зүйлсийн дотор нэлээд эртний эд болно.

Зураг 98: “Эзэн хорооны овоо”. Энэ бол Чингисийн онгоны зүүн өмнө довын дээрх овоо болно. Овоо бол эртний Монголчуудын балас шүтээн бөө мөргөлтэй холбогдсон нэгэн зүйлийн өвөрмөц зан заншил билээ. Энэ нь урт удаан түүхтэйгээр барахгүй, маш өргөн дэлгэрч байсан заншил юм. Энэ заншил нь цаг үеийн хөгжлийг дагалдан, сүүл сүүлдээ Монголчуудын нэгэн зүйлийн найр наадмын хэлбэр болжээ. Үүнийг ойрын жилүүдэд бас

сэргээн явуулж байна.

Зураг 99: “Чингис хаан ба Чан-чунь арш”. Энэ бол перс зурагчны зурсан Чингис хаан ба Чан-чунь арш хоёрын энх тайвныг хэлэлцэж байгаа зураг болно.

Аравдугаар бүлгийн нүүрийн зураг: “Хиюуд ястаны сүлд”.

Зураг 100: “Чингис хааны үеийн Монголын газрын зураг”.

Энэ бол тус товчооны арын наамал зураг болно. Түүнийг “Дундад улсын түүхэн газрын зураг” зэрэг тулгар зургуудыг үндэслэж бүдүүвчлэн зуржээ.

Тав. Ашиглаж лавласан номын данс

1 “Монголын нууц товчоон”

(1) Ц.Дамдинсүрэн; Орчин үеийн монгол хэлээр буулгасан хэвлэл, 1957 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

(2) Элдэндэй, Оюундалай; харгуулан зассан хятад галигын уул хуулбар, 1980 оны 9 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

(3) Баяр; Хятад, уйгуржин, латин галиг ба монголоор буулгасан шинэ хэвлэл, 1980 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

(4) Се Цзай Шань; Ц.Дамдинсүрэнгийн буулгаварыг орчин үеийн хятад хэлээр орчуулсан хэвлэл, 1957 оны 3 сарын Чжунхуа бичгийн хорооны хоёрдахи хэвлэл.

(5) Яо Цун У; Загчисэцэн: “Шинээр хятадчилж, тайлбарласан Монголын нууц товчоон”, 1960-1961 онд Тайвань-д хэвлүүлсэн “Зохиол түүх гүн ухаан сэтгүүл”-ийн 9-12 дугаар хугацаанд нийтлүүлжээ.

(6) Дорнотив: “Шинээр орчуулж товч тайлбарласан Монголын нууц товчоон”, 1979 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

(7) Накаичиё: “Чингис хааны үнэн тэмдэглэл” (“Монголын нууц товчоон”-ыг ингэж нэрлэжээ), энэ бол япон хэлээр тулган орчуулж, тайлбар дагалдуулан анх удаа 1906 онд хэвлүүлсэн бөгөөд 1934 онд Чжан Хун гэгч дахин хятадаар тулган орчуулж “Го Сюай Лунь Хэн” сэтгүүл дээр нийтэлсэн хэвлэл болно.

(8) Кобаяши Такаширо: япон орчуулга, 1940 оны 2 сард Шен Хо Шэ хороо хэвлүүлжээ.

2. Рашид-ад-Дин: “Судрын чуулган”

О.Н.Смирнова орчуулж, 1952 онд Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн нэгдүгээр ботийн хоёрдугаар дэвтэр.

3. “Чингис хааны цэрэг дайны түүх”

(1) 1926 онд Цинхуа Их Сургуулийн Судалгааны Хүрээлэнгээс хэвлүүлсэн “Харгуулан тайлбарласан дөрвөн зүйлийн монголын түүхийн материал”.

(2) Б.Баганын монголчлого: “Богд баатарын биеэр дайлсан тэмдэглэл”, 1979 он, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

4. Хун Цзюнь: “Юань улсын түүхийн нөхвөр орчуулга”, Бадаргуулт төрийн 23 он (1897 он)-ы модон бар.

5. Джувейни: “Дэлхийг дайлан дагуулагчдын түүх”, 1980 оны 5 сар, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны хэвлэл.

6. Сун Лянь нар: “Юань улсын түүх”, 1976 он, Чжунхуа бичгийн товчооны шинэ хэвлэл.

7. Шао Юань Пин: “Юань улсын түүхийн зүйл хуваасан шастир”, Тэнгэр Тэтгэгчийн 60 он (1795)-ы модон бар.

8. Ту Цзи: “Монголын түүхэн тэмдэглэл”, 1958 онд эртний номын хэвлэлийн хорооноос гэрэл зургаар хэвлүүлсэн 1934 оны модон бар.

9. Кэ Шао Мин: “Юань улсын шинэ түүх”, 1935 онд Шанхайн Каймин бичгийн хороо хэвлүүлжээ.

10. Вэй Юань: “Шинэ найруулсан Юань улсын түүх”, 1936 онд Шанхайн Дагуан бичгийн товчоо хэвлүүлжээ.

11. Лувсанданзан: “Алтан товч”, 1937 оны Улаанбаатарын хэвлэл.

12. Лю Цзинь Со: “Хаадын үндсэн хураангуй алтан товч”, тулган харьцуулж тайлбарласан хэвлэл, 1980 онд Өвөр

Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

13. “Богд Чингис хааны цадиг”, 1925 он, Бээжингийн Монгол Бичгийн Хорооны хорголжин бар.

14. Саган сэцэн: “Хаадын үндэсний эрдэнийн товч”

(1) 1962 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо гэрэл зургаар хэвлүүлсэн сударчилсан хэвлэл.

(2) 1980 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн тулган харгуулсан шинэ хэвлэл.

(3) Шэнь Цзэн Чжи, Чжан Эр Тянь: “Эрдэнийн товч”-ийн тайлбарлан зурагласан хятадчилга, 1933 оны хэвлэл.

(4) Дорнотив: “Шинээр орчуулж харгуулан тайлбарласан Хаадын үндэсний эрдэнийн товч”, 1980 он, Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооны хятад хэвлэл.

15. Гомбожав: “Гангын урсгал”, Чойжийн тулган харьцуулж тайлбарласан хэвлэл, 1981 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлэв.

16. Н.П.Шастина: “Арван долдугаар зууны монголын он дараалсан түүх, ”Шар тууж”, 1957 онд Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэвлэлийн Хорооноос Москва-Ленинград хэвлүүлсэн орос хэвлэл.

17. “Далай ламын номлосон залуусын хурим хэмээх хаад ноёдын уг түүх энэ болой”, Улаанбаатар, Монгол улсын номын сангийн хадгалалт, гэрэл зураг.
18. “Асрагч нэртийн түүх”, 1677 онд Ар Монголын Эрдэнэ зуу хийдэд зохиогдсон гар бичмэл, 1959 оноо Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн тосон барын хэвлэлээс буулгасан хуулбар.
19. Тогтох: “Алтан улсын түүх”, 1957 он, Чжунхуа бичгийн товчооны шинэ хэвлэл.
20. Ли Ю Тан: “Алтан улсын түүхийн гол гол явдлын эх адаг”, 1980 он, Чжунхуа бичгийн товчооны шинэ хэвлэл.
21. Чжан Тин Юй нар: “Мин улсын түүх”, 1974 он, Чжунхуа бичгийн товчооны шинэ хэвлэл.
22. Тада-Сабуроу: “Чингис хаан”, Бадаргуулт төрийн 29 он (1903), Ту Сяо Куань орчуулж, Шанхайн Цзо Синь Шэ бичгийн хороо хэвлүүлжээ.
23. Фэн Чэн Цзюнь: “Чингис хааны намтар”, 1934 оны 4 сард Шан У бичиг хэвлэх газар хэвлүүлжээ.
24. Чжан Чжэнь Пэй: “Чингис хааны шүүмжлэл шастир”, 1943 онд Чжунхуа бичгийн товчоо хэвлүүлжээ.
25. Булрин: “Чингис хаан”, 1945 оны 2 сар, Шэнь Ин орчуулж, Гомиьндан-ий төвийн сургуулилах хорооноос хэвлүүлжээ.
26. Б.Я.Владимирцов: “Чингис хаан”, 1950 оны 1 сард Юй Юань Ань хятадчилж, Шанхайн “Цзюй Лунь” хэвлэлийн хорооноос хэвлүүлжээ(уул зохиол нь 1922 онд зохиогдсон бөгөөд Берлин-Петроград-Москвад хэвлэгджээ, 1981 оны 7 сард япон хэлээс дам монголчилж, Хайларт хэвлэгджээ).
27. Чжоу Цин Цзий: “Чингис хаан”, 1955 оны 9 сард Шанхайн “Шинэ мэдлэг” хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
28. Юй Юань Ань: “Чингис хааны намтар”, 1955 оны 12 сард Шанхайн Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
29. Ши Вэй: “Чингис хаан”, 1985 оны 5 сард Сянгань Чжунхуа бичгийн товчоо хэвлүүлжээ.
30. Ли Цзэ Фэнь: “Чингис хааны шинэ намтар”, 1970 онд Тайвань-ий Чжунхуа бичгийн товчоо хэвлүүлжээ.
31. Дин Сян Бинь: “Чингис хааны дуулал”, 1973 оны 6 сард Тайвань-ий “Вэй Синь” бичгийн товчоо хэвлүүлжээ.
32. Цзя Нянь Хуа найруулах комисс: “Чингис хаан”, 1981 оны 1 сард Тайваны Цзя Нянь Хуа соёл хэвлэлийн үйлсийн компани хэвлүүлжээ.

33. Хань Жу Лин: “Чингис хаан”, 1982 оны 6 сард Цзянсу-гийн Ардын Хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
34. Цзин Цзай: “Чингис хаан”, 1982 оны 8 сард Тайвань-ий алдарт хүний хэвлэлийн ажлын хувь нийлүүлсэн компани хэвлүүлжээ.
35. Сакаи Шигэйтика: “Чингис хаан”, 1915 он, Токиогийн “Бо Вэнь Гуань” бичгийн хорооны япон хэвлэл.
36. Окусаки Широү: “Чингис хаан”, 1940 он, Токиогийн “Синь Чао” бичгийн хорооны япон хэвлэл.
37. Березин: “Чингис хаан”
- (1) Хаманака Хидайта-гийн япончилго, 1940 онд Токиогийн “Фу Шань Фан” бичгийн хороо хэвлүүлжээ.
- (2) Эймурашики-гийн япончилго, “Их удирдагч Чингис хааны нууц” гэсэн нэрээр 1982 онд “Сообуншия” бичгийн хороо хэвлүүлжээ.
38. Осаки Широ: “Чингис хаан”, 1941 онд Токиогийн “Синь Чао Шэ” бичгийн хороо хэвлүүлжээ.
39. Лю Тянь Цюань: “Чингис хааны тухай яриа” (Идэр насны Тэмүжин), 1942 онд Токиогийн “Да Гуань Тан” бичгийн хороо хэвлүүлжээ.
40. Үмэймото Сетайзоо: “Чингис хаан”, 1943 онд Мүгдэний “Ту Фэн” бичгийн гэр хэвлүүлжээ.
41. Үмэймото Сетайзоо: “Чингис хаан” (1-3 боть, гурван дэвтэр), 1944 онд Чанчунь хотод “Манжийн өдрийн сонин”-ы хороо хэвлүүлжээ.
42. Ооба Яхаи: “Чингис хааны бүрэн намтар”, 1944 онд Токио-гийн “Гао Шань” бичгийн хүрээлэн хэвлүүлжээ.
43. Казифүжи Такэки: “Чингис хаан – тал нутаг дахи дэлхийн хаант улс”, 1972 онд Токиогийн “Цин Шуй” бичгийн хүрээлэн хэвлүүлжээ.
44. Кобаяши Такаширо: “Чингис хаан”, 1979 оны 4 сард Токиогийн “Янь Бо” номын дэлгүүр хэвлүүлжээ.
45. Чёоко Ротаиро: “Чингис хааны байлдааны түүх”, 1939 онд Токиогийн “Дайны соёлыг судлах газар” хэвлүүлжээ.
46. “Богд Чингис хааны байлдааны бичиг”, 1943 онд Чуулалт хаалга хотод монгол хорголжин бараар хэвлүүлжээ.

47. Өвөр Монголын Нийгмийн Судалгааны Нийгэмлэг: “Чингис хааны мэндэлсэн 800 жилийг дурсгах тухай монгол түүхийн эрдэм шинжилгээний ярилцах хурлын түүвэр”, 1962 оны 10 сард Өвөр Монголын Түүхийн Судалгааны Нийгэмлэгээс Хөх хотод хэвлүүлжээ.
48. Хураангуй мэдээ: “Чингис хааны мэндэлсэн 800 жилийг дурсгах тухай Монгол түүхийн эрдэм шинжилгээний ярилцаан”, 1962 оны “Түүхийн судлал” сэтгүүлийн 4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
49. Өвөр Монголын түүхийн судалгааны нийгэмлэг: “Чингис хааныг үнэлэх тухай ярилцаан дээр тавьсан яриануудын эмхэтгэл”, 1964 оны 5 сард Өвөр Монголын түүхийн судалгааны нийгэмлэгээс Хөх хотод хэвлүүлжээ.
50. “Чингис богдын дурсгалын түүвэр”, 1925 онд Бээжингийн Монгол Бичгийн Хороо хэвлүүлжээ.
51. “Чингис хааны сургаалын түүвэр”, Чингис хааны сүм байгуулах гишүүдийн хурлын тайлгын явдлыг бэлтгэн шийдвэрлэх хорооны харьяат найруулан зохиох хэлтэс найруулан хэвлүүлжээ.
52. Осаки Широ: “Чингис хааныг ярих нь”, 1943 онд Токиогийн “Се Чэн Шэ” бичгийн хороо хэвлүүлжээ.
53. Оохама Кийчиро: “Чингис хаан хийгээд Азийн үндэстэн”, 1933 онд Токиогийн “Ий Тэн Шу Линь” бичгийн хороо хэвлүүлжээ.
54. “Чингис хаан хийгээд барс”, Монголын соёлыг судлах газраас найруулж, “Хөх” (одоогийн Хөх хот)-д тосон дармалаар хэвлүүлжээ.
55. Чэнь Юй Цзя: “Чингисийн онгоныг шилжүүлсэн тэмдэглэл”, Иргэн улсын 31 он (1942 он)-ы хэвлэл (Өвөр Монголын номын сангийн хуулбар).
56. Хань Чан Лу: “Урьд Монголын гол гол түүхэн явдлын эх адаг”, Бадаргуулт төрийн 31 он (1905 он)-д Шанхайн “Чунь Цзий” бичгийн хороо хэвлүүлжээ.
57. Хань Чан Лу: “Хойд Монголын гол гол түүхэн явдлын эх адаг”, Бадаргуулт төрийн 31 он (1905 он)-д Шанхайн “Чунь Цзий” бичгийн хороо хэвлүүлжээ.
58. “Ши Чжун” бичгийн товчоо: “Азийн гурван баатар (Төмөр, Чингис хаан, Хитайюши)”, Бадаргуулт төрийн 29 он (1903 он)-д Шанхайн “Ши Чжун” бичгийн товчоо хэвлүүлжээ.
59. Д‘Оссон: “Монголын түүх”, Иргэн улсын 25 он (1936 он)д Фэн Чэн Цзюнь орчуулж, Шан У бичиг хэрэглэх газар хэвлүүлжээ.
60. Бархаусэн (Barkhausen): “Чингис хааны Хаант улсын түүх”, 1940 онд Линь Мэн Гун хятадчилж, Чжунхуа бичгийн товчооны хэмжээт хятадчилгатай Компани хэвлүүлжээ.
61. Цзэн Вэнь У: “Монголын баруунш дайралтын агуу амжилт”, “Дундад улсаас баруун орныг

үе улиран эзэгнэсэн түүх”-ийн нэгэн бүлэг(“Дундад улсын шинэ өгүүлэл” сэтгүүлийн 7, 8 дугаар хугацаанд лавлаарай).

62. Тогтох: “Өвөр Монголын түүхэн хөгжлийн тойм байдал”, 1957 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хятадаар хэвлүүлжээ.

63. Юй Баян: “Өвөр Монголын түүхийн найруулал”, 1958 онд Шанхайн Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

64. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн болон Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгээс хамтран найруулсан: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх”, 1956 оны 9 сард Үндэстний Хэвлэлийн Хороо Бээжинд хэвлүүлжээ.

65. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн Хүрээлэн: “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Түүх” (гурван боть), 1966-1969 онд Улаанбаатарт хэвлэгджээ.

66. Гао Юай Тянь: “Монголын түүхийн программ”, 1972 оны 8 сард Тайвань-ий Чжунхуа-ны бичгийн товчооны хувь нийлүүлсэн хэмжээт харьцуулгатай компани хэвлүүлжээ.

67. Рашпунцаг: “Дай Юань улсын болор эрих”, Өвөр Монголын Хэл Утга Зохиол Түүх Судлах Газрын номын сангийн гар бичмэл.

68. Цю Шу Сэнь: “Юань улсын түүхийн тухай яриа”, 1981 оны 11 сард Дундад улсын Залуучуудын хэвлэлийн хороо хэвлүүлжээ.

69. Д.Хүүхэнбаатар: “Монголын элчин харьцаа”, 1964 онд Монгол Улсын Хэвлэлийн Хэрэг Эрхлэх Хороо Улаанбаатарт хэвлүүлжээ.

70. Бээжин цэргийн тойрог: “Манай улсын умард оронд болж өнгөрсөн дайралдааны жишээнүүд”, 1973 оны 12 сарын дотоод хэвлэл.

71. Чжан Му: “Монголын нүүдэлчдийн тэмдэглэл”, Иргэн улсын 27 он (1938 он) Шан У бичиг хэвлэх газар Чан Ша хотод хэвлүүлжээ.

72. Айками Намио нар: “Монголын өндөрлөгөөр тойрсон тэмдэглэл”, 1941 онд “Чжигуань” бичгийн хүрээлэн хэвлүүлжээ.

73. Чжоу Цин Шу: “Онгуд аймгийн тухай этхэтгэл”, 1-5 дугаар, Чжунхуа бичгийн товчооноос 1980 оны 6 сараас 1982 оны 7 сард хэвлүүлсэн “Вэнь Ши” сэтгүүлийн 9-12, 14 дүгээр хугацаанд нийтлэгджээ.

74. Чжу Цзя Цзий, Яо Цзий Ань: “Монгол үндэстний баатар Бат”, 1936 оны 7 сард “Чжэн Чжон” бичгийн товчоо хэвлүүлжээ.

75. Ц.Дамдинсүрэн: “Монголын ардын уран зохиолын түүх”, 1957 оны 4 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.

76. Мансан: “Монголын ардын уран зохиолын түүх”, 1980 оны 8 сард Өвөр Монголын Сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
77. “Аргасун хуурчийн домог”, 1979 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршив” гэдэг номд нийтлэгджээ.
78. “Чингисийн их өчиг”, 1979 онд Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн “Монголын уран зохиолын дээж зуун билиг оршвой” гэдэг номд нийтлэгджээ.
79. Элдэндэй, Оюундалай, Асралт: “Монголын нууц товчооны үгсийн тайлбар”, 1980 оны 2 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
80. Козин: “Монголын нууц товчооны үгсийн тайлбар”, 1941 онд Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
81. Ши Ши Цзэ: “Юань улсын нууц товчооны газар усны нэрсийн магадлалт”, 1978 оны 3 сард Тай-бэй хотын “Гуань Вэнь” бичгийн товчооны хэмжээт хариуцлагатай компани гэрэл зургаар хэвлүүлжээ.
82. Ван Инь Хоу: “Юань улсын үе улирлын хаан Хуан-хэү-ийн хөрөг”, 1924 оны 9 сард Бээжингийн Монгол Бичгийн Хороо хэвлүүлжээ.
83. Өвөр Монголын Түүхийн Судалгааны Нийгэмлэг: “Хаадын үндэсний эрдэнийн товч бичигдсэн 300 жилийн ойг дурсах хурлын бичиг материалын эмхэтгэл”, 1963 оны 5 сард Хөх хотод дотоодын материалаар хэвлэгджээ.
84. Цай Мэй Бяо, Чжоу Цин Шу, Чжу Жуй Си, Дин Вэй Чжи, Ван Чжунь нар: “Дундад улсын ерөнхий түүх”, 6 дугаар дэвтэр, 1979 оны 1 сард Ардын Хэвлэлийн Хороо Бээжинд хэвлүүлжээ.
85. Елюй Чжу: “Шуан Си Цзуй Инь Цзий-гийн хуулбар”, 6 дугаар боть, Бээжин номын сангийн хуулбар хадаглалт.
86. “Зарлигаар тогтоосон гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”, Бадаргуулт төрийн 34 он (1908 он)-д хэвлэгдсэн дэвтэр.
87. (Зарлигаар тогтоосон) “Монгол Хотон аймгийн ван гүнгийн илтгэл шастир”, Тэнгэр тэтгэгчийн 44 он (1779 он)-ы найруулал.
88. “Их Чин улсын нэгтгэсэн ойллогын бичиг”, Төр гэрэлтийн үед бичигдсэн гуравдугаар найруулал.
89. “Суй Юань мужийн ерөнхий тэмдэглэлийн эх”, 1-8 дугаар боть, Өвөр Монголын номын сангийн хадгалалт.
90. “Цзянь Янь-аас наашхи чухал хэргийн он дараалсан тэмдэглэл”, 96, 133, 148, 155, 156 эл боть, Ван Го Вэйн “Гуань Тан Цзий Линь” гэдэг номын 15 дугаар ботид үз.

91. Дин Цянь: “Баруун Ляо улс байгуулагдсан эх адаг”, “Го Цуй Сюань Бао” сэтгүүлийн хорооноос найруулсан эртний судлалын хоёрдугаар эмхэтгэл.
92. Чжан Цзянь: “Тангудын түүхийн гол гол явдлын эх адаг”, Бадаргуулт төрийн 29 он (1903 он)-ы “Вэнь Шэн Цзюй” бичгийн товчооны модон бар.
93. Ж.Түчи: “Төвдийн дундад зууны түүх”, 1980 оны 7 сард Дундад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Үндэстэн судлах газар хэвлүүлжээ.
94. Цай Мэй Бяо: “Юань улсын үеийн ярианы хэлээр сийлэгдсэн хөшөө чулууны түүвэр”, 1955 оны 2 сард Шинжлэх Ухааны Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
95. Е Цзи Ци: “Цао Му Цзи бичиг”, 1959 оны 5 сард Шанхайн Чжунхуа бичгийн товчоо хэвлүүлжээ.
96. Гао Вэнь Дэ: “Монголын боол эзэмшигч байгууллын судлал”, 1980 оны 3 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хятадаар хэвлүүлжээ.
97. Тао Цзун И: “Чо Гэн Лу бичиг”, 1959 оны 2 сард Чжунхуа бичгийн товчооноос хэвлүүлсэн шинэ хэвлэл.
98. Б.Я.Владимирцов: “Монголчуудын нийгмийн байгууллын түүх”, 1980 онд Үндэстний Хэвлэлийн Хорооноос монголчлон хэвлүүлжээ.
99. Лю Цзинь Со: “Арван гурав – арван долдугаар зууны монголын түүх бичлэг”, 1979 оны 4 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
100. Чжоу И Лян, У Юй Цинь: “Дэлхийн ерөнхий түүх” (дундад эртний хэсэг), 1962 оны 9 сард Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
101. Ж.Х.Хайс, Муун, В.Вейланд нар: “Дэлхийн түүх”, 1941 онд Нью-Йорк Макмиллан компани хэвлүүлжээ.
102. В.Х.Лиддел, Харт: “Дэлхийн хоёрдугаар их дайны түүх”, 1980 оны 1 сард Шанхайн орчуулгын хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
103. К.В.Базилевич: “Монголоос ноёрхож байсан үеийн Оросын товч түүх”, 1959 оны 12 сард Хуан Цзюй Син, Яо Цзя Цзий-н хятадчилгыг Шинжлэх Ухааны Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
104. Носов: “Зөвлөлт холбоот улсын товч түүх”, нэгдүгээр боть, 1972 онд Зөвлөлтийн Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэвлэлийн Хорооны Ленинград дахи салбар хорооноос хэвлүүлжээ. Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн Хэвлэлийн Хорооны Ленинград дахи салбар хорооноос хэвлүүлжээ.
105. Роберт, Валлаши: “Оросын мандалт” - “Хүн төрөлхтөний агуу их цаг үе” цуврал бичгийн нэг, Нью-Йорк-ын “Цаг үе” компани хэвлүүлжээ.

106. “Монголын дайралтын дараахи 700 жил – Японыг довтолсон нууцыг далайн доороос сэргээсэн нь”, Чжао Хэ-гийн 56 он (1981 он)-ы 11 сард Радио нэвтрүүлгийн систем хэвлүүлжээ.
107. Ц.Шагдарсүрэн: “Монгол үсэг зүй”, 1981 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл Зохиолын Хүрээлэн Улаанбаатарт хэвлүүлжээ.
108. Ли Чжи Чан: “Чан-чунь аршийн баруунш зорчсон тэмдэглэл”, 1926 онд Цин Хуа Их Сургуулийн Судалгааны Хүрээлэнгээс хэвлүүлсэн “Харгуулан тайлбарласан дөрвөн зүйлийн монгол түүхийн материал” гэдэг дэвтрийн хоёрдугаар боть.
109. Елюй Чу-сай: “Баруунш зорчсон тэмдэглэл”, 1981 оны 10 сард Чжунхуа бичгийн товчооноос “Харь орны тэмдэглэл” гэдэгтэй хамтруулан хэвлүүлжээ.
110. Чжао Хун: “Монгол татарын тухай бүрэн тэмдэглэл”
- (1) 1926 онд Цинхуа Их Сургуулийн Судалгааны Хүрээлэнгийн хэвлүүлсэн “Харгуулан тайлбарласан дөрвөн зүйлийн монгол түүхийн материал” гэдэг дэвтрийн 3-р боть.
- (2) 1979 онд Хар мөрөн мужийн ардын хэвлэлийн хорооноос Мөнхзаяагийн монголчилгыг “Хар татарын тухай хэргийн товч” гэдэгтэй хамтруулан хэвлүүлжээ.
111. Пэн Да Я, Сюй Тин: “Хар татарын тухай хэргийн товч” (хэвлэл нь 110-тай адил).
112. Лю Ци: “Үгүсүн Жүанда-гийн умарш элчилсэн тэмдэглэл”, “Дундад улс ба Өрнө дахины зам нэвтэрлэгийн түүхэн материал”-ын тавдугаар дэвтэрт нийтлэгджээ.
113. Плано Карпини: “Монгол түүх” (ердөө “Плано Карпинийн аялалын тэмдэглэл” буюу “Монголд элчилсэн тэмдэглэл” гэдэг). Н.П.Шастинагийн оросчилго, 1957 онд Зөвлөлтийн Газарзүйн ном бичгийн улсын хэвлэлээс Москвад хэвлүүлжээ.
114. Марко Поло: “Марко Пологийн аяллын тэмдэглэл”, 1978 онд Гириний Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
115. Дундад улсын түүхэн газрын зургийг найруулан эмхэтгэх дугуйлан: “Дундад улсын түүхэн газрын зургийн нийлбэр”, 6 дугаар дэвтэр, 1975 онд Дундад улсын Газрын зургийн шинжилгээний нийгэмлэг хэвлүүлжээ.
116. “Бүгд Найрамдах Дундад Ард Улсын газрын зургийн нийлбэр”, 1958 онд Газрын Зургийн Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
117. “Дэлхийн газрын зургийн нийлбэр”, 1958 оны 11 сард Газрын зургийн хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
118. Ай-лунь, Ф.Цю: “Оросын түүхэн газрын зургийн тайлбар”, 1980 онд Шан У бичиг хэвлэх газар хэвлүүлжээ.

119. Гунгаадаш: “Монголын аж ахуйн газар зүй”, 1977 онд Ляонин-гийн ардын хэвлэлийн хороо хэвлүүлжээ.
120. Бээжингийн Монгол Бичгийн Хороо: “Монгол утгын зүйл хуваасан толь бичиг”, 1956 оны 4 сард Үндэстний Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
121. Шу Синь Чэн нар эрхлэн найруулсан: “Үгсийн далай”, 1937 оны 8 сард Чжунхуа бичгийн товчооны хэмжээт хариуцлагатай компани хэвлүүлжээ.
122. “Үгсийн далай”-г найруулах комисс: “Үгсийн далай”, 1979 оны 9 сард Шанхайн Толь Бичгийн Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
123. Я.Цэвэл, “Монгол хэлний товч тайлбар толь”, 1966 оны 1 сард Улаанбаатарт Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн компани хэвлүүлжээ.
124. Сюай Цюань Цзэн: “Чингис хааны тухай лавлалт материалыг товч өгүүлэх нь”, “Дундад улсын шинэ өгүүлэл” сэтгүүлийн 3 дугаар ботийн 2 дугаар хугацаанд нийтлэгджээ.
125. Иринчин, “Дундад улсын умар дахины угсаатнууд болон Монголчуудын угсаа язгуур”, “Өвөр Монголын Их Сургууль” Эрдэм Шинжилгээний Сэтгүүлийн 1979 оны 3-4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
126. Ван Цун У: “Өгэлүн” (арван гуравдугаар зууны үеийн нэгэн монгол эмэгтэй баатар), 1936 онд хэвлэгдсэн “Олон түмний мэдлэг” сэтгүүлийн 1 дүгээр ботийн 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.
127. Яо Цун У: “Алун гуа эх сум хугалж хөвгүүдээ сургаснаас Өгэлүн хатан Чингис хааныг сурган цээрлүүснийг өгүүлэх нь” – 1961 оны 1 сарын 15-нд хэвлэгдсэн Тайвань-ий “Их хуурай сэтгүүл”-ийн 22 дугаар ботийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
128. Дун Тан: “Чингис хааны зурмал хөргийн гаргалгаа”, “Вэнь У” сэтгүүлийн 1962 оны 10 дугаар хугацаанд нийтлэгджээ.
129. Шао Сюнь Чжэн: “Чингис хааны төрсөн оны тухай”, “Түүхийн судлал” сэтгүүлийн 1962 оны 2 дугаар хугацаанд нийтлэгджээ.
130. Чжоу Цин Шоу: “Чингис хааны төрсөн цагийн тухай магадлалт”, 1962 оны 10 сард хэвлэгдсэн “Вэнь Ши” сэтгүүлийн нэгдүгээр эмхэтгэлд нийтлэгджээ.
131. Синьхуа хорооны мэдээ: “Зөвлөлтийн нэгэн шинжилгээний бригад Чингис хааны мэндэлсэн газрыг олжээ”, 1958 оны 4 сарын 7-ний өдрийн “Вэнь Хуй Бао сонин”-д нийтлэгджээ.
132. О.Чимэд, О.Жамьян нар: “Дэлүүн Болдогийг сурвалжилсан нь” (1928 онд), “Монгол түүх хэл бичиг” сэтгүүлийн 1958 оны 6 дугаар хугацаанд нийтлэгджээ.
133. Ли Бин: “Агуу их Чингис хаан”, 1935 онд хэвлэгдсэн “Шинэ Монгол” сэтгүүлийн 1

дүгээр ботийн хугацаанд нийтлэгджээ.

134. Чжань Ди Цун: “Ази Европыг дайлан дагуулсан Чингис хаан”, 1934 оны 11 сард хэвлэгдсэн “Хөлс, цус сарын сэтгүүл”-ийн 4 дүгээр ботийн хоёрдугаарт нийтлэгджээ.
135. Хань Жу Линь: “Чингис хааны тухай”, “Түүхийн судлал” сэтгүүлийн 1962 оны 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.
136. Чжоу Лян Шао: “Чингис хааны тухай”, “Түүхийн судлал” сэтгүүлийн 1962 оны 4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
137. “Чингис хааны товч явдал”, 1935 оны 4 сард хэвлэгдсэн “Чи Бянь” сэтгүүлийн 3 дугаар ботийн 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.
138. Бүрэн: “Чингис хааны товч явдал”, 1981 оны 6 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хятадаар хэвлүүлсэн “Дундад улсын монгол түүхийн судалгааны нийгэмлэгийн өгүүллийн түүвэр” (1980 оных) -т нийтлэгджээ.
139. Чжао Бин Кунь, Ли Гуй Чжи: “Чингис хааныг туршин өгүүлэх нь”, (хэвлэл нь 138-тай адил).
140. Шэнь Цзюнь: “Монголын баатар Чингис хааны дайны амжилт”, 1939 оны 7 сард хэвлэгдсэн “Сянь Ши” сэтгүүлийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
141. Өлзий: “Чингис хааны тухай туршин өгүүлэх нь”, 1981 онд хэвлэгдсэн “Өвөр Монголын Үндэстний Багшийн Дээд Сургууль” сэтгүүлийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
142. И.М.Майский: “Чингис хаан”, Зөвлөл Холбоот Улсын “Түүхийн асуудал” Сэтгүүлийн 1952 оны 5 дугаар хугацаанд нийтлэгджээ.
143. Юань Го Фан: “Юань улсын Тай-цзу Балжуна голын усыг ууж тангарагласан тухай товч магадлалт”, 1959 оны 12 сард хэвлэгдсэн Тайвань-ий “Их хуурай сэтгүүл”-д нийтлэгджээ.
144. Линь Чжань Ао: “Чингис хаан хийгээд Жамуха”, 1936 оны 11 сард хэвлэгдсэн “Шибэй Лунь Хэн” сэтгүүлийн 4-8 дугаар хугацаанд нийтлэгджээ.
145. Ц.Хишигтогтох: “Чингис хаан хийгээд Жамуха сэцэн”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүлийн 1982 оны 4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
146. Хонда Санаинобу: “Чингис хааны мянгат”, 1953 оны 8 сард Токио-д хэвлэгдсэн “Түүхийн ухааны сэтгүүл”-ийн 62 дугаар эмхтгэлийн наймдугаарт нийтлэгджээ.
147. Хонда Санаинобу: “Чингис хааны арван гурван хүрээний тухай”, 1952 оны 3 сард Токиод хэвлэгдсэн “Дорно дахин” сэтгүүлийн 4 дүгээр эмхэтгэлд нийтлэгджээ.
148. Хань Жу Линь: “Чингис хааны арван гурван хүрээний тухай магадлалт”, 1982 оны 11 сард Шанхайн ардын хэвлэлийн хорооноос хэвлүүлсэн “Цюн Лу Цзий” гэгч зохиогчийн

түүвэрт нийтлэгджээ.

149. Жагар: “Чингис хааны сүлд тугийн тухай”, “Өвөр Монголын Багшийн Дээд Сургуулийн Эрдэм Шинжилгээний Сэтгүүл” (монгол хэвлэл)-ийн 1981 оны 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.

150. Ерөнхий мэдээ: “Өвөр Монголын түүхийн судалгааны нийгэмлэгээс Чингис хааны мэндэлсэн 800 жилийн ойг дурсах тухай монгол түүхийн эрдэм шинжилгээний хурлыг хуралдуулав”, “Түүхийн судлал” сэтгүүлийн 1962 оны 4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.

151. Цзя Цзин Янь, Хун Цзюнь: “Чингис хааны түүхэнд холбогдох хэдэн асуудлын тухай”, (хэвлэл нь 138-тай адил).

152. Ян Чжи Мэй: “Чингис хааны түүхэн байр суурь”, 1954 оны 10 сард хэвлэгдсэн “Түүхийн Сургах Ухаан” сэтгүүлийн 46 дугаар хугацаанд нийтлэгджээ.

153. Дэлгэр: “Чингис хаан бол түүхийн зохицонгуй нөхцөл доор буй болсон агуу их хүн мөн”, 1980 оны 9 сарын 17-ний өдрийн “Өвөр Монголын өдрийн сонин” (хятад хэвлэл)-д нийтлэгджээ.

154. Бүрэн, Лю Цзинь Со: “Чингис хааны түрүү хагас насны үйл ажиллагааг нь товч үнэлэх нь”, 1981 оны 9 сард Дундад Улсын Нийгмийн Шинжлэх Ухааны Хэвлэлийн Хорооноос хэвлэгдсэн “Монгол үндэстний түүхэн хүмүүсийн тухай өгүүллийн түүвэр”-т нийтлэгджээ.

155. Чжао Юн Чунь: “Чингис хаан Монголыг нэгтгэсэн шалтгааны тухай өгүүлэх нь”, (хэвлэл нь 138-тай адил).

156. Чэнь Го Гань: “Чингис хаан Монголыг нэгтгэсэн түүхэн гавьяа”, (хэвлэл нь 137-той адил).

157. Яо Цзун У: “Юань улсын хуучин түүх, Тайцзу-гийн шастир дахи багалзуур (идэх) хийгээд түүнээс үүссэн Ван хан болон Чингис хааны хоорондохи шийдвэрлэх дайны тухай өгүүлэх нь”, 1960 онд Тайбэй-д хэвлэгдсэн “Зохиол, түүх, гүн ухаан сэтгүүл”-ийн 10 дугаар хугацаанд нийтлэгджээ.

158. Шу Чжэнь Бан: “Чингис хааны өмнөш явуулсан дайралтын мөн чанар ба үйлдэл”, (хэвлэл нь 138-тай адил).

159. Шу Чжэнь Бан: “Чингис хааны өмнөш Алтан улсыг дайлсан явдлын түүхэн дээрхи давшсан үйлдэл”, 1980 оны 9 сарын 17-ны өдрийн “Өвөр Монголын Өдрийн Сонин” (хятад хэвлэл)-д нийтлэгджээ.

160. Баяр: “Алтан улсын үндэстний харьцаа ба Чингис хаанаас Алтан улст хэрэглэсэн байлдах бодлого”, “Өвөр Монголын Багшийн Дээд Сургуулийн Эрдэм Шинжилгээний Сэтгүүл” (хятад хэвлэл)-ийн 1981 оны 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.

161. Чжэнь Цзинь: “Чингис хааны баруунш дайралтыг зөвөөр үнэлэх хэрэгтэй”, (хэвлэл нь

159-тэй адил).

162. Яо Цун У: “Чингис хаан Цю Чу Цзий-ийг итгэсэн явдал ба энэ явдал нь Дундад орны уламжлалт соёлыг эсэнэхүүн хамгаалсан хувь нэмэр”, 1966 оны 8 сард Тайбэй хотод хэвлүүлсэн “Соёл, түүх, гүн ухаан сэтгүүл”-ийн 15 дугаар хугацаанд нийтлэгджээ.

163. Алтан-Очир: “Чингис хаан монгол үндэстний түүхнээ үзүүлсэн үйлдлийг туршин өгүүлэх нь”, “Өвөр Монголын Багшийн Дээд Сургуулийн Эрдэм Шинжилгээний Сэтгүүл” (монгол хэвлэл)-ийн 1981 оны 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.

164. Б.Т.Пешотов: “Чингис хааны баруунш түрэмгийлсэн ба түрэмгийллийг эсэргүүцсэн ард түмний баатар тэмцэл”, “Түүхийн сургах ухааны асуудал” сэтгүүлийн 1958 оны 4 дүгээр хугацаанд Чэнь Дэ Чжи хятадчилан нийтлүүлжээ.

165. “Шинэ колончлолын өмөглөгч”, Зөвлөлтийн эв хамт намын төв хорооны ил зохиолын тухай шүүмж дөрөв, 1963 оны 10 сарын 12-ны өдрийн “Ардын өдрийн сонин”, “Улаан туг” сэтгүүлийн найруулах хэлтсийн өгүүлэл.

166. Лу Сюнь: “Энэ тэр номыг шүүж байгаад”, “Лу Сюнь-ий бүрэн зохиол”, 1958 оны хэвлэлийн 6 дугаар ботид нийтлэгджээ.

167. Цю Шу Сэнь: “Чингис хааныг үнэлэх тухай хэдэн асуудал”, 1979 оны 9 сард Дундад Улсын Монгол Түүхийн Судалгааны Нийгэмлэгээс найруулан хэвлүүлсэн “Дундад Улсын Монгол Түүхийн Судалгааны Нийгэмлэгийг байгуулсан их хурлын дурсгалын түүвэр”-т нийтлэгджээ.

168. Шу Чжэнь Бан: “Чингис хаан цолын тухай магадлалт”, (хэвлэл нь 167-той адил).

169. Тао Я Минь: “Монголын баруунш дайлсан цэргийн сүр хүрсэн газар”, 1913 оны 8 сард хэвлэгдсэн “Газар зүйн ухааны сэтгүүл”-ийн 4 дүгээр ботийн 8, 9 дүгээр хугацаанд нийтлэгджээ.

170. Ли Юн Линь: “Арван гуравдугаар зууны өмнө хагас хугацаан дахи Монгол Солонгосын харьцаа”, “Юй гүн хагас сарын сэтгүүл”-ийн 7 дугаар ботийн 5 дугаар хугацаанд нийтлэгджээ.

171. Сунь Го Дун: “Юань улсаас дундад улс ба өрнөдахины соёлын солилцоонд үзүүлсэн хувь нэмрийг товч өгүүлэх нь”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүл (хятад хэвлэл)-ийн 1980 оны 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.

172. Яо Цун У: “Монголын нууц товчоонд дурдсан хаан сонгох ба тайж өргөмжлөх тухай өгүүлэх нь”, 1964 оны 12 сард Тайбэйд хэвлэгдсэн “Зохиол түүх гүн ухаан сэтгүүл”-ийн 13 дугаар хугацаанд нийтлэгджээ.

173. Лю Цзинь Со: “Эртний Монгол ба Хаант Монгол Улс байгуулагдсан нь”, 1978 онд хэвлэгдсэн “Монгол түүхийн өгүүлэлийн эх бичиг”-ийн хоёрдугаарт нийтлэгджээ.

174. Вэн Ду Цзянь: “Монгол ба Юань улсын үе дэх хуулийн эмхэтгэл”, 1948 онд хэвлэгдсэн “Яньцзин-ий Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүлийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
175. Бао-сян: “Мөн Монголын үсэг бичгийн түүхийн тухай товч өгүүлсүгэй”, “Монгол хэл, утга зохиол” сэтгүүлийн 1981 оны 2 дугаар хугацаанд нийтлэгджээ.
176. Яо Цун У: “Чингис хааны үеийн бөөгийн шашин”, 1937 онд хэвлэгдсэн “Түүхийн оролдлого сэтгүүл”-ийн 1 дүгээр ботийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
177. Юань Го Фан: “Арван гуравдугаар зууны үеийн монгол байлдагчдын зэвсэг тоноглол”, 1969 онд хэвлэгдсэн “Их хуурай сэтгүүл”-ийн 38 дугаар ботийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
178. Ван Лу: “Монголын хант улс болон түүний эхэн үе дэх монгол үндэстний мал аж ахуй”, (хэвлэл нь 173-тай адил).
179. Хун Юн Бинь: “Онгуд гэдэг үгийн гарлын тухай магадлалт”, (хэвлэл нь 172-той адил).
180. Мэн Гуан Яо: “Ляо улсын үеийн Үгүдилей аймгийн тухай гуравдахи зөвлөгөө - Үгүдилей салбарууд болон холбогдол бүхий нэрсийн ялгал”, 1980 оны 4 сард хэвлэгдсэн “Монгол түүхийн өгүүллийн эх бичиг”-ийн гуравдугаарт нийтлэгджээ.
181. Хань Жу Линь: “Тангуд үндэстний нэр болон Тангуд вангийн цолын тухай”, (хэвлэл нь 148-тай адил).
182. Чжан Юй Чэн: “Елюй Чу-сай”, 1981 оны 6 сарын 16-ны өдрийн “Өвөр Монголын Өдрийн сонин” (хятад хэвлэл)-д нийтлэгджээ.
183. Паул Пелио: “Марко Пологийн аялалын тэмдэглэлийн тайлбар” (Чингис хааны түүхэнд холбогдох зүйлүүд), 1959 онд Парист хэвлэгджээ.
184. Ши Нянь Чан: “Бурхан багшийн үе улирлын ерөнхий тэмдэглэл”, 31 дүгээр боть.
185. У.Сүртэй: “Юань улсын үеийн умардахины цөөн тоот үндэстний зурагчдын тухай товч өгүүлэх нь”, 1981 оны 12 сарын 10-ны өдрийн “Өвөр Монголын өдрийн сонин”-д нийтлэгджээ.
186. Сюй Чжан Цзян: “Чин улсын үед Өвөр Монголд байгуулсан Мулан Хуйхан” 1962 оны 7 сарын 5-ны өдрийн “Өвөр Монголын Өдрийн Сонин” (хятад хэвлэл)-д нийтлэгджээ.
187. Х.Пэрлээ: “Монголын нууц товчоон-ы газар усны нэрийн тухай урьдчилсэн мэдээ”, “Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1957 оны 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
188. Ван Жу Тан: “Чан-чунь аршийн Баруунш зорчсон тэмдэглэл дэх газар усны нэрсийн тайлбар”, 1941-1942 онуудад хэвлэгдсэн “Го Сюай Цзун Кань” сэтгүүлийн 4, 5, 7 дугаар хугацаанд нийтлэгджээ.

189. Элдэндэй: “Хөлөн буйр аймгийн доторхизарим монгол түүхэн газрын нэрсийн тухай магадлалт”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүлийн 1980 оны 2 дугаар хугацаанд нийтлэгджээ.
190. Ц.Хасдорж: “Монгол гэдэг нэрийн тухай”, “Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1980 оны 5 дугаар хугацаанд нийтлэгджээ.
191. Дин Сюай Юнь: “Төр захирагч гүнжийн гуулин тамга”, (хэвлэл нь 167-той адил).
192. Дин Чань Бо: “Юань улсын үеийн барс толгойт пайзын тухай магадлалт”, “Дундадын зохиол түүхийн өгүүллийн цуврал”-ын дөрөвдүгээр эмхэтгэлд нийтлэгджээ.
193. Су Цзий Цин: “Барс толгойт алтан пайз болон арслан толгойт алтан пайз”, (хэвлэл нь 167-той адил).
194. Хао Су Минь: “Төвдөөс олдсон дөрвөлжин үсгийн дүгрэг пайзын тухай”, “Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1981 оны 2 дугаар хугацаанд нийтлэгджээ.
195. Х.Пэрлээ: “Мөнх хааны гэрэлт хөшөө ба ордыг олж судалсан тухай”, 1956 оны Монгол улсын хэвлэл, Улаанбаатарт хэвлэгджээ.
196. О.Намнандорж: “Мөнх хааны хөшөө ба ордыг олж судалсан тухай”, “Монгол хэл бичиг” сэтгүүлийн 1957 оны 10 дугаар хугацаанд нийтлэгджээ.
197. Чжэ Гун: “Монголын онгоны нууц ба Чингис хааныг богд хэмээсэн нь”, 1935 оны 7 сард хэвлэгдсэн “Шинэ Монгол” сэтгүүлийн 4 дүгээр ботийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
198. Чжан Сян Вэнь: “Чингис хааны онгоныг олсон нь”, 1915 оны хэвлэгдсэн “Газарзүйн сэтгүүл”-ийн 6 дахи жилийн 3 дугаар хугацаанд нийтлэгджээ.
199. Чжан Сян Вэнь: “Чингис хааны онгоны тухай зөвлөгөө”, 1915 оны 12 сард хэвлэгдсэн “Их Дундад” сэтгүүлийн 1 дүгээр ботийн 12 дугаар хугацаанд нийтлэгджээ.
200. Ту Цзи: “Чингис хааны онгоны тухай зөвлөх бичиг”, 1917 онд хэвлэгдсэн “Газарзүйн сэтгүүл”-ийн 8 дахи жилийн 7, 8 дугаар хугацаанд нийтлэгджээ.
201. Чжан Сян Вэнь: “Чингис хааны онгоны тухай Ту Цзин Шань (Ту Цзи авгайн өөр нэр - эшлэгч)-ы маргааны бичгийг дахин хариулах нь”, (хэвлэл нь 198 дэхи сэтгүүлийн 8, 9 дүгээр хугацаа).
202. Чжан Сян Вэнь: “Чингис хааны онгоны хөндлөн баримт”, (хэвлэл нь 199 дэхи сэтгүүлийн 10 дугаар хугацаа).
203. Сюй Дун: “Чингис хааны онгоны тухай зөвлөлдөөнийг тайлбарлан тодорхойлох нь”, 1923 оны 7 сард хэвлэгдсэн “Зүүн хойд орны соёлын сарын сэтгүүл”-ийн 2 дугаар ботийн 7 дугаар хугацаанд нийтлэгджээ.

204. Фан Шао Гун: “1939 онд Чингисийн онгоныг шилжүүлсэн шалтгааны тухай ярих нь”, “Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухаан” сэтгүүлийн 1980 оны 4 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
205. Вэнь Шань Чжэнь: “Чингис хааны онгоны тухай товч тэмдэглэх нь”, 1980 оны 10 сарын 14-ний өдрийн “Өвөр Монголын Өдрийн Сонин” (хятад хэвлэл)-д нийтлэгджээ.
206. “Чингис хааны онгоноор тойрсон бэлэг” (гэрэл зураг), “Шэнь Бао сонины сарын сэтгүүл”-ийн 4 дүгээр боть, 6 дугаар хугацаанд нийтлэгджээ.
207. “Чингис хаан ба түүний сүлдийг тахиж байгаа нь” (гэрэл зураг), “Шинэ Ази” сэтгүүлийн 2 дугаар ботийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
208. “Цэцэн хан аймгийн Балгадын сүм дэх Чингисийн хөрөг”, “Баруун хойд орон сэтгүүл”-ийн анхдах жилийн 1 дүгээр хугацаанд нийтлэгджээ.
209. Инжаннаш: “Хөх судар” (роман), 1979 оны 12 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хорооноос хэвлүүлсэн хоёрдугаар хэвлэл.
210. Цзинь Юн: “Бүргэд намнаач баатарын намтар” (роман), 1980 оны 10 сард Сянган-ы Цзянь Мин бичгийн хорооноос хэвлүүлсэн дөрөвдэх хэвлэл.
211. В.Янчевицки: “Чингис хаан” (роман), 1981 оны 1 сард Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо хэвлүүлжээ.
212. “Ардын өдрийн сонин”-ы тусгай урьсан шүүмжлэгчийн өгүүлэл: “Эх оронч үзэл бол нийгэм журмыг байгуулах оюун санааны аварга хүч мөн”, 1981 оны 3 сарын 19-ний өдрийн “Ардын өдрийн сонин”-д нийтлэгджээ.

Төгсгөлийн үг

Энэхүү “Чингис хааны товчоон” хэмээгч зохиолынхоо анх эхийг би 1981 оны 9 сарын 3-наас 1982 оны 10 сарын 3 болтол бичиж дуусгажээ. Хоёрдохи засалтыг 1982 оны 12 сарын 29-аас 1983 оны 3 сарын 18 болтол нэлээд их хэмжээгээр боловсруулав. Гуравдахи засалтыг 1983 оны 8 сарын 30-аас 10 сарын 7 болтол 253 дугаар эмнэлгийн өвчтөний ор дээр засаж дууссан бөгөөд түүнээс хойно мэргэжлийн чанартай засалтыг хэдэн удаа гүйцэтгэв. Би зохиолоо эхэлж бичихээс аваад: нэгд, түүхийн үнэнийг баллах ба худал хэлэхийг цээрлэе; хоёрт, зохиолынхоо хуудсыг “хараал зүхэл”-ийн түүвэр бүү болгоё; гуравт, аливаа манай үйлсийн төлөө зүтгэгсэдийн нэр хүндийг аль болохоор тэмдэглэж үлдээе гэж эрхэмлэн зорьж байв. Үүнээ журамлаж чадсан эсэхийг уншигчид л тунгаан таслах байлгүй!

Хуудас бүрт нь хөлсөө дусалгаж, үг бүрт нь эсээ шингээсэн энэхүү өчүүхэн хөдөлмөрийн болбор (болсон үр – хө.) юугаа өргөн олон уншигчиддаа ариун цагаан сэтгэлийн бэлэг болгон өргөсүгэй. Бэх, бэрхийн шүлтээр эвлүүлэн бүтээсэн миний энэ зохиол эрхэм уншигчдыг аль нэгэн талаар сонирхуулдаг бол, тэр бүхэн цөм монгол үндэстний ард түмэн болон өвөг дээдийн минь агуу их үйл хэрэг болох бөгөөд намайг дэмжиж тусалсан халуун сэтгэлт нөхдийн минь ач гавьяа болно.

Өчүүхэн зохиол минь өргөн олон уншигчидтайгаа золгох ташрамд, тус зохиолд ашигласан зохиол бүтээлийг бүтээсэн эрт өдгөө, дотоод гадаадын нэр дурдсан ба эс дурдсан тэдгээр багш эрдэмтнийг бишрэн бахдаж, чин сэтгэлийн талархлаа дэвшүүлэе.

Тус зохиолын материалыг бэлтгэх явцад төвийн Үндэстний Дээд Сургуулийн ахлах багш Хишигтогтох, төвийн үндэстний орчуулах товчооны Хатуузориг, Бээжингийн номын сангийн дорно дахины салааны Оюун зэрэг үй олон нөхөд дотноор халамжилсныг тэмдэглүүшгэй.

Тус товчоонд хавсаргасан гэрэл зургийн олонхийг ба дурсгалт зүйлсийн гэрэл зургийг Өвөр Монголын цэргийн тойрогийн найруулах орчуулах газрын найруулагч нөхөр Булаг, зохиогчийн туурвилтыг хангамжтай сайхан биелүүлж чадав. Тус номын хэвлэлийн харгуулалтын их хэмжээний ажлыг Бээжинд гүйцэтгэх явцад Хишигтогтох нөхөр ховор нандин цагаа харамгүй зарцуулсныг онц дурдууштай. Бас удаан жил хамт ажилласан миний сайн найз зохиолч М.Асар намайг ямагт зоригжуулж байдгаар барахгүй бичгийн нэр “Чингис хааны товчоон” гэсэн урламал үсгийг бичиж дурсгал болгов.

Монгол түүхийн алдарт эрдэмтэн Лю Цзинь Со нөхөр эх бичгийг минь нэвт уншиж, маш өндөр үнэлэлт өгсний хамт оршил бичиж өгөв. Нэг хүн нэг насандаа өдий төдий ажил явдлыг хийх нь энгийн хэрэг боловч, харин нэг хоёр зүйлийн үйлсийг бүтээнэ гэдэг нь тийм хялбар биш юм. Заримдаа насаараа зүтгээд үл барах нь ч зөндөө буй. Бүтсэнгүй ч нугаршгүй дахин “цэрэглэгч”-ийн цог зориг нь тэдгээр хялбархан “бүтэгсэд”-ээс нэн эрхэм биш үү? Энэ бол хэнд ч тохиолдож болох учрал байлгүй. Миний энэ насны бүтэмж буюу олсон нь алдсанаасаа илүү л гэж үздэг бол хий хоосон хүслээ орхисон явдал л болж байсан сан. Аливаа нугарал бэрхшээлд учрагсад урагшлах замаа олж, ялалтын оргил өөд давшихыг чин сэтгэлээсээ ерөөсүгэй! Аливаа бүтэгсэд ч бүдрэлээ бүү мартаарай!

1985 оны 7 сар - 1986 оны 6 сар (Хөх хот, Бээжин)

38 Пусянь Ваньну-г “Чингис хааны шүүмжлэл шастир”-т: “Ваньгинь Ваньну” гэж тэмдэглэжээ. Би “Юань улсын түүх”-ийг баримтлав. Түүний дээдсийн тухай тодорхой тэмдэглэлгүй. Тэр Ляодун-гийн тохинуулагч зарлигийн элч байхдаа Алтан улсын нийслэл Чжунду хот Монголд эзлэгдсэн үед зүүн нийслэл Ляо-ян хотыг эзлэн аваад “Да Чжэн” гэгч төрийг байгуулж, дэмий удсангүй Люгэ нарт ялагдаж, 1216 оны өвөл Чингис хаанд бууж өгсөн бөгөөд өөрийн хөвгүүн Тэхэ гэгчийг хааны дэргэд үйлчлүүлжээ. Дараа нь дэмий удсангүй Ляодун-гийн мужийн төлөөлөгч зүүн мөрийн түшмэл Елюй Нэрхэ (Елюй Ахай-н хөвгүүн)-г алж, арваад түмэн хүн авч далайн арал өөд дутаан зугтжээ. Сүүлд нь Жүрчиний эх газар – Хуньтунцзян мөрнөөс өмнөш, Гуули улсаас хойшхи Ляодун-гийн газрыг залгалдаагаар эзэлж, өөрөө “Зүүн Ся улс” гэж нэрлээд арав есөн жил болсон байна.

39 Хуньтунцзян мөрөн гэдэг бол Хармөрөн, Сунгари мөрөн Гирин мужийн Тунцзян сянь-ы хойно хүрч нилээд дорогш урссан хэсгийн нэр нь болно. Энэхүү ухагдахуун бол орчин үеийн газар Жүрчидийн хэллэг болно. Гэтэл “Ляо улсын түүх”-д “Яцзи голын өөрчилсөн нэр” гэж, “Алтан улсын түүх”-д “Хар мөрний нэр” гэж, бас зарим материал (“Үгсийн далай”-н 1931 оны хэвлэл лавлаарай)-д “Сунгари мөрний эх”, “Ялу мөрний эх”, “Хурха гол”, “Эртний Сумо гол, одоогийн Сунгари мөрөн” гэж тус тус адилгүй тэмдэглэж байдаг.

* “Харгуна хан” гэдэг бол одоогийн Далан хар уул болно. “Эрдэнийн товч”-д “Хар хуна” гэж бичдэг. “Гун” гэдэг бол асга хад гэсэн эртний монгол үг болно. Жишээлбэл: Эргүнэ гун, Жоргал гун, Наху гун, Хулдагар гун, Сариг гун гэж “Нууц товчоон” зэрэг тулгар бичигт олон харагддаг билээ.

* Бусад дэвтэрт “Бурхад” гэдэг.

* “Төгс хүрүгэлэгсэн” гэснийг “заяат” гэж Ц.Дамдинсүрэн тайлбарлажээ.

* “Урнаа” гэснийг “удирдан” гэж Ц.Дамдинсүрэн тайлбарлажээ.

Дээр нь гэсэн тамга сийлж буй

Table of Contents

[Долдугаар бүлэг](#)

[Чингис хаан өмнөш дайлсан нь](#)

[Наймдугаар бүлэг](#)

[Чингис хаан баруунш дайлсан нь](#)

[Есдүгээр бүлэг](#)

[Тангуд улсыг мөхөөсөн ба Чингис хаан нас барсан нь](#)

[Аравдугаар бүлэг](#)

[Тэнгэрлэг богд Чингис хаан](#)

[Хавсраас](#)

[Нэг. Чингис хааны үйл ажиллагааны он дараалал](#)

[Хоёр. Чингис хааны дөрвөн ордон ба тайцзи гүнж нар](#)

[Гурав. Чингис хааны язгуур төрлийн цадигууд](#)

[Дөрөв. Зүүлт зургуудын тайлбар](#)

[Тав. Ашиглаж лавласан номын данс](#)

[Төгсгөлийн үг](#)